UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS,
MONGOLIA

LAW ENFORCEMENT

THEORETICAL AND METHODOLOGICAL
QUARTERLY JOURNAL

2022
№01 (28)

Ulaanbaatar

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ

Сэтгүүлийн эрхлэгч:
Зоригт О. Эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Орлогч дарга:
Гантулга С. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Нарийн бичгийн дарга:
Бямбажаргал Б. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хэвлэл редакцын хэлтсийн дарга бөгөөд ахлах редактор, цагдаагийн дэд хурандаа

Гишүүд:

Мөнхзаяа Б. Сургалтын бодлого, төлөвлөлтийн газрын дарга, хурандаа

Азбаяр Ц. Удирдлагын академийн захирал, цагдаагийн хурандаа

Лхагвасүрэн Б. Ахисан шатны боловсролын сургуулийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Хишигтогтох Б. Цагдаагийн сургуулийн захирал, доктор, цагдаагийн хурандаа

Ганбаатар Д. Хилийн албаны сургуулийн захирал бөгөөд хилийн 0345 дугаар ангийн захирагч, бригадын генерал

Ууганбаяр П. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн захирал, хурандаа

Батсайхан Н. Онцгой байдлын сургуулийн захирал, доктор, дэд профессор, дэд хурандаа

Болдбаатар Ч. Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн захирал, цагдаагийн хурандаа

Ганбаатар Г. Ахлагчийн сургуулийн захирал, доктор, цагдаагийн хурандаа

Гантулга Ц. Шинжлэн магадлахуйн институтын захирал, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Чулуунбат Ш. Гадаад хэлний институтын захирал, доктор, дэд профессор, хурандаа

Мөнхдорж Б. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа судлалын хүрээлэнгийн захирал, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Сайнтөр Ч. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн захирал, доктор, бригадын генерал

Алтангэрэл Б. Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрхлэгч, доктор, дэд профессор, хурандаа

JOURNAL EDITORIAL BOARD

Editor of the journal:
Zorigt O, Vice president for Research Affairs, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Police Colonel.

First Secretary:
Gantulga S, Director, Integrated Research Institute, University of Internal Affairs, Ph.D. Associate professor, Police Lieutenant Colonel.

Secretary:
Byambajargal B, Head of the Press and Editorial Department, Senior Editor, Integrated Research Institute, University of Internal Affairs, Police Lieutenant Colonel

Members:

Munkzaya B, Head of Training Policy and Coordination Department, University of Internal Affairs, Colonel

Azbayar Ts, Director, Executive Management Academy, University of Internal Affairs, Police Colonel

Lkhagvasuren B, Director, Post-Graduate College, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Police Lieutenant Colonel

Khishigtogtokh B, Director, Police College, University of Internal Affairs, Ph.D., Police Colonel

Ganbaatar D, Director, Border Services College and Commander of the Unit 0345, University of Internal Affairs, Brigadier General

Uuganbayar P, Director, Court Order Decision Enforcement College, University of Internal Affairs, Colonel

Batsaikhan N. Director of Emergency Management School, Ph.D, Associate Professor, Lieutenant Colonel

Boldbaatar Ch, Director, Law and Social Sciences College, University of Internal Affairs, Police Colonel

Ganbaatar G, Director, Non-Commissioned Officer's School, University of Internal Affairs, Ph.D., Police Colonel

Gantulga Ts, Director, Forensic Science Institute, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Police Colonel

Chuluunbat Sh, Director, Foreign Language Institute, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Colonel

Munkhdorj B, Director, Institute of Criminology and Police Research, Integrated Research Institute, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Police Lieutenant Colonel

Saintur Ch, Director, Institute of Border Security Research, Integrated Research Institute, University of Internal Affairs, Ph.D., Brigadier General

Altangerel B, Head of Court Order Decision Enforcement Center, Integrated Research Institute, University of Internal Affairs, and Ph.D., associated Professor, Colonel

Одбаатар Б. Удирдлагын академийнЦагдаагийн удирдлага, стратегийн профессорын багийнпрофессор, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Odbaatar.B. Professor, Professor's Team of Police Strategy Management, Executive Management Academy, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Police Colonel

Лхагварагчаа Б. Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, цагдаагийн ахмад

Lkhagvaragchaa B, Head of Criminal Investigation Department, University of Internal Affairs, Ph.D., Police Captain

Галбадрах Б. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, хошууч

Galbadrakh B, Head of Social Work and Psychology Department, Court Order Decision Enforcement College, University of Internal Affairs, Ph.D., Major

Мягмаржав Х. Онцгой байдлын сургуулийн Эдийн засаг нөөцийн удирдлагын тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, хурандаа

Myagmarjav Kh, Head of Economics and Resource Management Department, Emergency Management College, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Colonel

Энхтүвшин Б. Онцгой байдлын сургуулийн Гал түймэртэй тэмцэх албаны тэнхимийн дэд профессор, доктор, дэд хурандаа

Enkhtuvshin B, Associate Professor in the Department of Emergency Management, University of Internal Affairs, Ph.D., Colonel

Мөнхзул Н. Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Munkhzul N, Head of Public Law Department, Law and Social Science College, University of Internal Affairs, Ph.D., Associate Professor, Police Lieutenant Colonel

Цолмон Б. Шинжлэн магадлахуйн институтын Криминалистикийн шинжилгээний тэнхимийн эрхлэгч, доктор, дэд профессор, цагдаагийн хурандаа

Tsolmon B, Head of Forensic Investigation Department, Forensic Science Institute, Ph.D., Associate Professor, Police Colonel

ГАРЧИГ–TITLE

ХУУЛЬ САХИУЛАХУЙН УДИРДЛАГА
LAW ENFORCEMENT MANAGEMENT

БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

THE ANALYSIS OF CURRENT ORGSNIZATIONAL CONTROL ISSUES

Б.Эрдэнэдалай
ДХИС-ийн Хууль сахиулах удирдлага хөтөлбөрийн докторант, цагдаагийн хошууч
Erdenedalai B.
Ph.D Student of Law Enforce management programme at University of Internal Affairs, Mongolia
Ц.Баясгалан
ДХИС-ийн Удирдлагын Академийн Удирдахуйн ухааны профессорын багийн ахлах багш, доктор (Ph.D), дэд профессор, ахлах дэслэгч
Bayasgalan.Ts
Ph.D, asisstant professor, A senior lecturer at team of management for the Executive Leadership Academy of the University of Internal Affairs, Mongolia. 10

МАНЛАЙЛЛЫН НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА: ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЖИШЭЭН ДЭЭР

THE STUDY OF IMPACTS ON LEADERSHIP: THE CASE OF BORDER PROTECTION AGENCY

Ц.Одонгэрэл
ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн ар тал, эдийн засгийн тэнхимийн эрхлэгч, докторант, дэд хурандаа
Odongerel.Ts
Head of rear and economics department of Border Service College at University of Internal Affairs, Mongolia, Lieutenant Colonel 22

ГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ
CRIMINOLOGY

МОНГОЛ УЛСАД ГАРЧ БАЙГАА ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS ON THE TRAFFIC ACCIDENT AND TRAFFIC BREACH THAT OCCUR IN MONGOLIA 28

Г.Ариунгэрэл
ДХИС-ийн магистрант, цагдаагийн хошууч
G.Ariungerel
Major, Master student of UIA

"НЭГ БҮС, НЭГ ЗАМ" САНААЧИЛГЫН ХЭРЭГЖИЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

"НЭГ БҮС, НЭГ ЗАМ" САНААЧИЛГЫН ХЭРЭГЖИЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б.Эрдэнэчимэг
БХЭШХ-ийн төвийн дарга, доктор, профессор, хурандаа
Б.Эрдэнэчимэг
БХЭШХ-ийн төвийн дарга, доктор, профессор, хурандаа
Д.Гантуяа.
ДХИС-ийн АШБС-ийн ЭЗАБ-ын магистрант, хошууч
Д.Гантуяа.
ДХИС-ийн АШБС-ийн ЭЗАБ-ын магистрант, хошууч 40

ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ

CONDITIONS AND PREVENTION OF THE CRIME OF MURDER

З.Амартүвшин
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Z.Amartuvshin
Master of the University of Internal Affairs 54

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

VALIDATION OF CHILD SEXUAL ABUSE IN SOME FOREIGN COUNTRIES' CRIMINAL LAW AND ITS COMPARATIVE ANALYSES

62

Б.Батбаяр
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн дэслэгч
B.Batbayar
University of Internal Affairs, postgraduate student, police lieutenant

АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ГЭРЧИЙГ ГҮЙЦЭТГЭХ АЖЛААР ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

LEGAL REGULATION FOR PROTECTION OF WITNESSES OF CORRUPTION CRIMES

69

Б.Батхуяг
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн дэслэгч
Batkhuyag.B
University of Internal Affairs, Post-graduate student, Police lieutenant

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНД ХАЛДАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES IN THE CRIMINAL LAW THAT VIOLATION ON FREEDOM OF EXPRESSION AND THE PRESS

Э.Өнөболд
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр Гүйцэтгэлийн албаны сургуулийн Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах багш, хууль зүйн магистр, ахмад
Unubold.E
Senior lecturer, Department of Warding and Intelligence, the School of Court Decision Execution, University of Internal affairs, Master in law, and Captain;
Э.Цэрэнханд
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хууль зүйн магистр, ахмад
Tserenkhand.E
Lecturer, Department of Decision execution, the School of Court Decision Execution, University of Internal affairs, Master in law, and Captain

78

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЗАРИМ ШАЛТГААН НӨХЦӨЛ

SOME CAUSES AND CONDITIONS OF CYBERCRIME

92

Т.Туяа
Цагдаагийн сургуулийн сургалтын арга зүйч, цагдаагийн дэд хурандаа
T.Tuya
Training methodologist of Police school, police lieutenant colonel

АЮУЛГҮЙ БАЙДАЛ СУДЛАЛ
SECURITY STUDIES

ТЕРРОРИЗМЫН ТУХАЙ НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ БА ЭРДЭМТЭН СУДЛААЧДЫН ҮЗЭЛ САНАА

DEFINITIONS OF THE TERRORISM AND DIFFERENT PERSPECTIVES OF SCHOLARSHIPS

96

Б.Баянмөнх
ДХИС-ийн ЦС-ийн ЦЭЗТ-ийн дэд профессор, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
B. Bayanmunkh
Associate Professor at the Department of Police Law, University of Internal Affairs Doctor of Law (Ph. D), Police Lieutenant Colonel

ЦАГДАА СУДЛАЛ
POLICE STUDIES

ДОТООДЫН ЦЭРГИЙН "ХАРУУЛЧИН" МЭРГЭЖЛИЙН ҮҮРЭГ, АЖИЛБАРТ ХИЙСЭН ДАКУМ ШИНЖИЛГЭЭ

DACUM OF INTERNAL TROOPS "GUARD" DOCUMENT ANALYSIS AND CONCLUSIONS

107

Б.Батцоож.
ДХИС-ийн Ахлагчийн сургуулийн Цагдаагийн албаны тэнхимийн багш, хошууч
B. Battsooj.
Major, teacher of internal troops work department

ЗАМЫН ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДААС ГАРГАЖ БУЙ САХИЛГЫН ЗӨРЧИЛ БА НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ

FACTORS THAT CAUSE DISCIPLINARY VIOLATIONS OF TRAFFIC POLICE OFFICERS

119

Д.Бат-Эрдэнэ
Цагдаа судлалын магистрант, Цагдаагийн хошууч
Bat Erdene.D
Major police, Student of the Police Studies

ЭРГҮҮЛИЙН ЦАГДААГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

SEVERAL ISSUES RELATED TO THE LEGAL REGULATION OF PATROLMEN WORK

131

Ц.Мягмарсүрэн
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахлагч
Ts. Myagmarsuren
Police Sergeant, Graduate Student of the University of Internal Affairs

ХИЛ СУДЛАЛ
LIMNOLOGY

ХИЛИЙН ЦЭРГИЙН АЛБАНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ХИЛИЙН ЦЭРГИЙН АЛБАНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

143

В.Пүрэвбаасан
ДХИС-ийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага стратегийн профессорын багийн дэд профессор, доктор (Ph.D), хурандаа
В.Пүрэвбаасан
ДХИС-ийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага стратегийн профессорын багийн дэд профессор, доктор (Ph.D), хурандаа

ГАМШИГ СУДЛАЛ
DISASTER STUDIES

СЭТГЭЛ ХАНАМЖИД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ: /ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ЖИШЭЭГЭЭР/

THE ANALYSIS OF IMPACTS ON SATISFACTION: THE CASE OF EMERGENCY MANAGEMENT AGENCY ON TUW PROVINCE

152

Б.Ганзагас
ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гамшиг судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан-багш, ахлах дэслэгч
Г.Хатанбаатар
ДХИС-ийн Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн ахлах багш, хошууч
Ganzagas.B
Researcher, Disaster Studies Center, Integrated Scientific Research Institute, University of Internal Affairs, Mongolia. Senior Lieutenant
Khatanbaatar.G
A Senior Lecturer at department of Disaster protection agency of Emergency Management School at University of Internal Affairs, Mongolia, Major

ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДАЛ, БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТОД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF DISASTER PREPAREDNESS AND EMERGENCY PREPAREDNESS DEGREE

158

Б.Амарбаяр
Дотоод хэргийн их сургуулийн "Гамшиг судлал"-ын магистрант, ахлах дэслэгч
Amarbayar.B
Master of Disaster Manajment, University of Internal Affairs

ГОЛ УСНЫ АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ,ЭРГИЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ

PREVENTING RIVER HAZARDS AND OPPORTUNITIES TO IMPROVE PROTECTION

Б.Батдэлгэр
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Batdelger.B
University of internal affairs master Senior Lieutenant

162

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛ БА ИРГЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

FIRE DANGER AND CIVIL SAFETY IN BUILDINGS

Б.Гантөмөр
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Gantumur.B
University of internal affairs master Senior Lieutenant

171

НИЙСЛЭЛИЙН ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИУДЫН БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ХАНГАЛТАД ХИЙСЭН СУДАЛГАА

THE ANALYSIS OF SUPPLY EQUIPMENT FOR FIRE FIGHTING AND RESCUE IN CAPITAL CITY

Г.Золжавхлан
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Zoljavkhlan.G
University of internal affairs master Senior Lieutenant

182

АВРАГЧДЫН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

INTERNATIONAL EXPERIENCE IN LIFEGUARD TRAINING

Н.Төгсбаяр
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Tugsbayar.N
University of internal affairs master Senior Lieutenant

189

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАХ НЬ

COOPERATING DISASTER RISK REDUCTION ACTIVITIES WITH DEVELOPMENT POLICY

Г.Гаваадамба
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахмад
Gavaadamba.G
University of internal affairs master captain

198

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ГАЛ ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМ

THE WAYS FOR REDUCING THE RISK OF FIRE PERCHANCE IN CONSTRUCTION SECTOR

Э.Ууганбаяр
ДХИС-ийн Удирдлагын академийн Онцгой байдлын удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, хошууч
Uuganbayar E
Assiociate professor at team of Emergency Management and strategy of Executive Leadership Academy at University of Internal Affairs, Mongolia.
Э.Энхбаяр
ДХИС-ийн Ахлагчийн сургуулийн Онцгой байдлын албаны тэнхимийн багш, хошууч
Enkhbayar E
Lecturer at department of Emergency Management of Non-comissioned Officer's School at University of Internal Affairs, Mongolia

203

ЦАГ УУРЫН ТАНДАН СУДАЛГААГ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНД АШИГЛАХАД ТУЛГАРЧ БУЙ СААД БЭРХШЭЭЛ

OBSTACLES TO USING SPATIAL WEATHER FORECASTING IN HUMANITARIAN EARLY ACTION

211

Ч.Нямхүү
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Nyamkhuu.Ch
University of internal affairs master

ХУУЛЬ САХИУЛАХУЙН ИННОВАЦИ
LAW ENFORCEMENT INNOVATION

ИННОВАЦИЙГ ЦАГДААГИЙН АЛБАНД АШИГЛАХ ЗАРИМ БОЛОМЖ

USE INNOVATION IN POLICE OPPORTUNITY

220

Б.Бямбасүрэн
Магистрант, ТЗЦГ-ын чиглэлийн ахлах ажилтан, цагдаагийн хошууч
B.Byambasuren
Senior Officer of the General Administration, police major

ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ
LAW ENFORCEMENT EDUCATION STUDIES

АЖИЛ ОЛГОГЧДООР ТӨГСӨГЧИЙГ ҮНЭЛҮҮЛСЭН СУДАЛГАА: ДХИС-ИЙН УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ЖИШЭЭН ДЭЭР

THE STUDY OF EVALUATION ON GRADUATES BY EMPLOYERS: THE CASE OF EXECUTIVE LEADERSHIP ACADEMY AT UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS, MONGOLIA

Д.Сундуйсүрэн
ДХИС-ийн УА-ийн Удирдахуйн ухааны профессорын профессор, доктор цагдаагийн хурандаа
Sunduisuren.D Ph.D,
Professor of Management team of management for the Executive Leadership Academy of the University of Internal Affairs, Mongolia, police colonel.
Ц.Амгаланбаяр
ДХИС-ийн УА-ийн Удирдахуйн ухааны профессорын дэд профессор, доктор, бригадын генерал
Amgalanbayar.Ts
Ph.D, Sub professor of management team of Executive Leadership Academy of the University of Internal Affairs, Mongolia, brigade general
Ц.Баясгалан
ДХИС-ийн УА-ийн Удирдахуйн ухааны профессорын багийн ахлах багш, доктор, дэд профессор, ахлах дэслэгч
Bayasgalan.Ts
Ph.D, A Senior lecturer of management team of Executive Leadership Academy of the University of Internal Affairs, Mongolia, senior Lieutenant

229

ОСОБЕННОСТИ ПРОФЕССИОНАЛЬНО-ОРИЕНТИРОВАННОГО ОБУЧЕНИЯ ИНОСТРАННОМУ ЯЗЫКУ СОТРУДНИКОВ ПОЛИЦИИ

PECULIARITIES OF PROFESSIONALLY ORIENTED FOREIGN LANGUAGE TRAINING OF POLICE OFFICERS

236

Нестерова Валерия Евгеньевна
Старший преподаватель кафедры иностранных языков Уральского юридического института МВД России
Nesterova Valeria Evgenevna
Senior lecturer of the Department of the foreign languages of the Ural Law Institute of the Ministry of the Interior of the Russian Federation

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ
LEGAL ISSUES

ШҮҮГЧ ХАРААТ БУС БАЙЖ, ГАГЦХҮҮ ХУУЛЬД ЗАХИРАГДАХ ЗАРЧМЫН ШИНЭ СОРИЛТ

JUDGES ARE INDEPENDENT AND ONLY PRINCIPLE OF THE LAW NEW CHALLENGE

М.Долгорсүрэн
ШУА-ийн Философийн хүрээлэн Улс төр, эрх зүйн салбарын ЭШДэА, хууль зүйн магистр, хуульч, өмгөөлөгч
M.Dolgorsuren Mongolian
Academy of Sciences Institute of Philosophy Department of legal and Political studies Researcher, Master of Law (LL.M), advocate
242

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГАА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ

ECONOMIC GUARANTEES FOR PUBLIC SECTOR SPECIAL OFFICIALS, COMPARITIVE ANALYZES OF LEGAL REGULATIONS
251

Д.Наранбаатар
Цагдаа судлалын магистрант, цагдаагийн ахмад
D.Naranbaatar
Graduate student of policing studies, police captain

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ПРОЦЕССИЙН ЭРХ ЗҮЙН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

CHALLENGE IN FOCUS: MONGOLIAN CONSTITUTIONAL PROCEDURAL LAW

С.Оюунчимэг
ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хошууч
Oyunchimeg.S
Senior lecturer, department of civil law, Law and Social Science Institute, the University of Internal Affairs, Mongolia, major
267

ЦАХИМ ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES TO IMPROVE THE LEGAL REGULATION OF E-COMMERCE
277

М.Өлзий-Очир
ДХИС-ийн магистрант
Ulzii-Ochir.M
Postgraduate of University of internal affairs, Mongolia

НУТГИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ХЭВ МАЯГИЙГ ХАРЬЦУУЛАХ НЬ

LOCAL GOVERNMENT SYSTEM TYPES COMPARE

Ц.Түвшинбаяр
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн магистрант, цагдаагийн дэд ахлагч
Tuwshinbayar.Ts
Graduate student of the School of Law and Social Sciences of the University of Internal Affairs, Deputy Chief of Police
281

БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ

THE ANALYSIS OF CURRENT ORGSNIZATIONAL CONTROL ISSUES

Б.Эрдэнэдалай
ДХИС-ийн Хууль сахиулах удирдлага хөтөлбөрийн докторант, цагдаагийн хошууч
Erdenedalai B.
Ph.D Student of Law Enforce management programme at University of Internal Affairs, Mongolia
Ц.Баясгалан
ДХИС-ийн Удирдлагын Академийн Удирдахуйн ухааны профессорын багийн ахлах багш, доктор (Ph.D), дэд профессор, ахлах дэслэгч
Bayasgalan.Ts
Ph.D, asisstant professor, A senior lecturer at team of management for the Executive Leadership Academy of the University of Internal Affairs, Mongolia.

Хураангуй: Байгууллагын үйл ажиллагаа, хяналтыг судлахад тухайн байгууллагад ажиллаж байгаа алба хаагчдын оролцоо чухал үүрэг гүйцэтгэдэг. Байгууллагын гадаад дотоод орчинг алба хаагчдаар үнэлүүлэн нэгтгэх зорилгоор менежментийн хяналттай уялдуулан судлахыг зорьсон. Судалгааны ажлынхаа байгууллагын үйл ажиллагааны хяналтын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлохын тулд PESTLE (P-Political/улс төр, E-Economic/эдийн засаг, S- Social/нийгэм, T-Technological/технологи, L-эрх зүй/Legal орчин) шинжилгээ хийх арга зүйгээр судалгааны асуумжийг боловсруулан судаллаа.

Судалгаанд оролцогчид нь тухайн байгууллагын үндсэн алба хаагчид байгаа нь байгууллагын үйл ажиллагааг шууд болон шууд бусаар үнэлэх, бодит байдлыг харьцуулах бүрэн боломж нээлттэй байгаа нь судалгааг бодит болгох шаардлагад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны талаар нэгдсэн ойлголтыг нэгтгэхэд дөхөм үзүүлсэн.

Түлхүүр үг: байгууллага, хяналт, PESTLE

Abstract: Our study aims to define the external and internal environment of the organization in accordance with the management control in order to evaluate and integrate it by the employees.

There are plays an important role in the study of the organizational operations and controls to involvement of employees in the organization. We determine the current state of control over the activities of the research organization, the research questionnaire was developed using PESTLE (P-Political, E-Economic, S-Social, T-Technological, L-legal) analysis methodology.

This survey's respondents are participated key employees of the organization such as to evaluate direct and indirect of the organization's activities, to facilitate a common understanding of the organization's operations and the fact that it is possible to compare the realities is open to the need to make the research realistic.

Keywords: organization, control, PESTLE

Танилцуулга Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт, "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт менежментийн хяналтыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

- Төрийн үйлчилгээний чанарын стандарт бий болж, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшсөн байна;

- Төрийн үйлчилгээний төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үр дүнгийн хяналт сайжирсан байна ... зэрэг нь үндэслэл болж байна.

Байгууллага, байгууллагын үйл ажиллагааны онол, арга зүй Монгол Улсын Байгууллагын нууцын тухай хуулийн гуравдугаар зүйлийн нэгдүгээр зүйлд "байгууллага" гэж тодорхой чиг үүрэг, бүрэн эрх бүхий хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийг хэлнэ[1].

Кембреджийн толь бичигт, байгууллагын үндсэн ойлголтыг "Хамтарсан зорилгоор зохион байгуулалттай хамтран ажилладаг хүмүүсийг байгууллага гэнэ, Үйл ажиллагаа эсвэл арга хэмжээний төлөвлөлт, Ямар нэг зүйлийг хийх эсвэл зохион байгуулах арга" гэж тайлбарласан (Cambridge, 2013)

Байгууллага гэдэг нь бүтээх, босгох гэсэн утгатай латин үгний бүтээвэр, менежментийн ухааны обьект нь байгууллага, түүний удирдлагын тухай ойлголт болно[2].

Байгууллагын үндсэн тодорхойлолтын талаар олон эрдэмтэд өөрийн байр суурийг илэрхийлсэн. Үүнд:

Байгууллага гэдэг нь хувь хүмүүсийн бүлэг бүрт хийх ёстой ажлыг нь гүйцэтгэхэд шаардагдах байгууламжтай нэгтгэх үйл явц бөгөөд ингэснээр гүйцэтгэсэн үүрэг нь боломжтой хүчин чармайлтыг үр дүнтэй, системтэй, эерэг, уялдаа холбоотой хэрэгжүүлэхэд хамгийн сайн сувгуудаар хангаж өгдөг. Байгууллага нь янз бүрийн хүмүүсийн үүргийг хуваах нөөцийг үр ашигтай ашиглахад тусалдаг (Thompson, 2003).

Честар Ирванг Бернард 1938 онд туурвисан "Гүйцэтгэх ажиллагааны чиг үүрэг" номонд байгууллагын онол, байгууллагын гүйцэтгэх захирлын чиг үүргийн талаар дурдсан (Haruki, 1991).

Байгууллагын асуудлыг шинжлэх ухааны түвшинд хөгжүүлсэн хүн бол Америкийн нэртэй эрдэмтэн Питэр Фэрдинанд Драйкэр (1909-2005) Менежментийн гурван үндсэн чиг үүргийг дараах байдлаар дурдсан. Үүнд:

1. Байгууллагын зорилго, эрхэм зорилгын биелэлт
2. Ажлыг бүтээмжтэй болгож, ажилчдыг амжилтад хүргэх
3. Нийгмийн хариуцлагын үр дүнтэй удирдлага

Зорилгод тулгуурласан менежмент нь дээд болон доод албан тушаалтнууд хамтын зорилгоо тодорхойлж, бүгд хүрэх ёстой үр дүнгээ гаргаж, хувь хүн бүрийн оруулсан хувь нэмрийг үнэлэх үйл явцаар хэмжигддэг. Тэрээр "Байгууллага нь зөв юм хийхийг үр дүн, юмыг зөв хийхийг үр ашиг" гэнэ. Өөрөөр хэлбэл, үр дүн, үр ашиг гэдэг нь үйлдвэрлэх бүтээгдэхүүн, үзүүлэх үйлчилгээгээ оновчтой сонгож, тэдгээрийг зөв аргаар үйлдвэрлэж гүйцэтгэнэ гэсэн үг гэж тайлбарласан (Drucker, 2011).

Байгууллагын хяналт бол түүний үйл ажиллагааг төлөвлөгөө, зорилго болон үзүүлэлтүүдийн урьдчилан тооцож тогтоосон стандартад дэс дараатай нийцүүлэн тохируулах үйл явц. Хяналт гэдэг бол тавьсан зорилтуудаа хүрэх явдлыг байгууллагын зүгээс хангах үйл явц (Дорж.Т., 2018).

Нийгмийн шинжлэх ухааны салбарт байгууллагын хяналт,

[1] Төрийн мэдээлэл, УБ.,1995. №07

[2] Отгонбаяр Н, "Менежментийн үүсэл хөгжил" лекц, Улаанбаатар хот, 2015, 2 дугаар тал

хяналтын уялдаа холбоог судалсан гадаад орны эрдэмтэн судлаачдаас Сирияама Канти, Херат, Цэнг Яанг, Сандро Курчнер, Даниел Баллестрос Орозсо нарыг зүй ёсоор нэрлэж болно. Үүнд:

Менежментийн хяналтын судалгааны хүрээ сэдэвт ажлаараа, байгууллагын бүтэц, байгууллагын стратеги, байгууллагын соёл, менежментийн мэдээллийн системийн хамаарлыг судалсан (Herath, 2007).

Менежментийн хяналтын талаарх туршлагад үндэслэсэн судалгаа сэдэвт ажлаараа, удирдлагын хяналтын тогтолцооны хамгийн анхны судалгааг 1965 онд хэвлүүлсэн Антоннигийн бүтээлийг дурдаж, тэр цагаас хойш удирдлагын хяналт хөгжиж ирсэнг чухалчилсан (Kьrschner, 2013).

Хяналтын талаар нийгмийн шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулсан эрдэмтдээс, Америкийн социологич, Травис Юарнэр Хирши (1935-2017), нийгмийн хяналтын онолын хувилбар, гэмт хэргийн нийгмийн хяналтын онолын орчин үеийн хувилбарыг боловсруулан үзэл баримтлалаа дэвшүүлсэн (McClelland, 2020).

Судалгааны боловсруулалт, үр дүн Хар тамхитай тэмцэх байгууллагын үйл ажиллагааны хяналтыг шинжлэн сайжруулахад нөлөөлж болох гадаад додоод орчны хүчин зүйлийг матрицлан тооцож дүгнэлтээ гаргахаар энэхүү шинжилгээг хийхдээ тухайн байгууллагын гадаад дотоод орчинд нөлөөлөх хүчин зүйлийг тухайн байгууллагын онцлогоос хамааруулан алба хаагчдаар байгууллагын хяналтын орчинг үнэлүүлэх судалгааг эхэлж авсан.

Цахимаар авах судалгаа: Цар тахал дэлхийг хамарсан сүүлийн хоёр жилийн хугацаанд нийгмийн тулгамдсан асуудлыг судлахад цахим судалгааг хэрэглэх явдал ихээхэн нэмэгдэж байна. Тоон болон чанарын судалгааг цахимаар авах, судалгааг боловсруулах, ашиглах өргөн боломжийг судлаачдад олгож байна. Судалгааны бүх аргын нэгэн адил цахим судалгаа нь давуу болон сул талтай. Энэ арга нь судалгааны зарим төслүүдэд амжилттай хэрэглэгдэн мэдээлэл цуглуулахад нь энгийн асуулгын аргад хэрэглэдэг боловсруулалтын үйл явцыг дагадаг. Оролцогчийн хувьд асуулгыг холбоосоор орж, энгийн асуулгад хариулдагтай нэгэн адилаар хариулна. Гагцхүү энгийн асуулгад гараар бичин хариулдаг бол цахим асуулгад оролцогч нь компьютер, ухаалаг утас, таблет зэргийг ашиглан судалгаанд оролцдог нь давуу талтай. Сю ба Риттер (2012), цахим судалгааг хийхэд тохиромжтой нөхцөл байдлыг тодорхойлохдоо хязгааргүй орон зай ба газарзүйн байршлын хувьд янз бүрийн түүвэртэй байх тохиолдолд асар их ашигтай гэж өгүүлсэн байдаг.

Судалгааг Ковид 19 цар тахлын нөхцөл байдлын хорио дэглэмтэй үеэс хамаарч цахим (Google form)-аар авч судалгаанд нийт 53 оролцогч хамрагдсан (Хавсралт 1.).

Зураг 1. Алба хаагчдын ажилласан жил (n:53)



Тайлбар: Судалгааны ажлын үр дүн

Судалгаанд оролцсон алба хаагчид 100 хувь төрийн тусгай албан тушаалтай, ажилласан жилийн хувьд, 1-3 жил ажилласан 8 алба хаагч, 3.1-8 жил ажилласан 7 алба хаагч, 5.1-7 жил ажилласан 6 алба хаагч, 7.1-9 жил ажилласан 6 алба хаагч, 9.1-12 жил ажилласан 10 алба хаагч, 12.1-15 жил ажилласан 9 алба хаагч, 15.1-18 жил ажилласан 1 алба хаагч, 18.1-20 жил ажилласан 5 алба хаагч, 20-оос дээш ажилласан 1 алба хаагч тус тус хамрагдсан (Зураг 1).

Зураг 2. Оролцогчдын алба, хэлтсийн ангилал (n:53)

Үзүүлэлт	Давтамж	Хувь	Хүчинтэй хувь	Хуримтлагдсан хувь
Захиргааны удирдлагын хэлтэс	**5**	9.4	9.4	9.4
Мөрдөн шалгах хэлтэс	**9**	17.0	17.0	26.4
Тандалт судалгааны дүн шинжилгээний тасаг	**4**	7.5	7.5	34.0
Урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааны хэлтэс	**6**	11.3	11.3	45.3
Эрүүгийн цагдаагийн хэлтэс	**29**	54.7	54.7	100.0
НИЙТ	53	100.0	100.0	

Тайлбар: Судалгааны ажлын үр дүн

Хар тамхитай тэмцэх байгууллагын алба хаагчдаас авсан судалгааны үр дүнгээс харахад, Захиргааны удирдлагын газарт 1-3 жил ажилласан 5 алба хаагч; Мөрдөн байцаах хэлтэст 1-3 жил ажилласан 3 алба хаагч, 12.1-15 жил ажилласан 6 алба хаагч; Тандалт судалгааны дүн шинжилгээний тасагт 12.1-15 жил ажилласан 3 алба хаагч, 15.1-18 жил ажилласан 1 алба хаагч; Урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааны хэлтэст 18.1-20 жил ажилласан 5 алба хаагч, 20-оос дээш жил ажилласан 1 алба хаагч; Эрүүгийн цагдаагийн хэлтэст 3.1-5 жил ажилласан 7 алба хаагч; 5.1-7 жил ажилласан 6 алба хаагч; 7.1-9 жил ажилласан 6 алба хаагч; 9.1-12 жил ажилласан 10 алба хаагч хамрагдсан байна (Зураг 2.).

Зураг 3. Улс төрийн хүчин зүйлийн үнэлгээ (n:53)

Үзүүлэлт	Үйл ажиллагаа тогтвортой байдал		Удирдах газрын гаргаж буй шийдвэр		Алба хаагчийг чадавхжуулах хөтөлбөр		Дотоод шилжилт хөдөлгөөн		Албан томилгоо	
Давуу тал	**30**	56.6%	**28**	52.8%	14	26.4%	8	15.1%	15	28.3%

Сул тал	6	11.3%	**11**	20.8%	**19**	35.8%	**24**	45.3%	**16**	30.2%
Боломж	**13**	24.5%	8	15.1%	**16**	30.2%	**15**	28.3%	**16**	30.2%
Аюул занал	1	1.9%	5	9.4%	1	1.9%	4	7.5%	6	11.3%
Мэдэхгүй	3	5.7%	1	1.9%	3	5.7%	2	3.8%	0	0
НИЙТ	**53**		**53**		**53**		**53**		**53**	

Тайлбар: Судалгааны ажлын үр дүн

Хар тамхитай тэмцэх байгууллагын улс төрийн хүчин зүйлийн дотоод давуу сул тал, гадаад боломж, аюул заналыг тодорхойлохоор, олон улсын судлаачдын судалгааны ажилдаа тухайн байгууллагын үйл ажиллагаа, хяналтын систем улс төрөөс хамааралтай эсэхийг шалган судалж хэрэглэсэн асуумжаас түүвэрлэн авч ашигласан. Үйл ажиллагаа тогтвортой байдал, удирдах газрын гаргаж буй шийдвэр, албан хаагчийг чадавхжуулах хөтөлбөр, дотоод шилжилт хөдөлгөөн, албан томилгоо асуултуудад өгсөн үнэлгээг давуу болон сул тал, боломж болон аюул занал, хариулах боломжгүй хувилбараар нэгтгэн тоо болон хувийн харьцуулалтаар харууллаа (Зураг 3.).

Зураг 4. Хүчин зүйлийн хамаарал (n:53)

ҮЗҮҮЛЭЛТ	Албан тушаал	[a]	[p1]	[p2]	[p3]	[p4]	[p5]
Албан тушаал	**1.000**						
Ажилласан жил **[a]**	0.127	**1.000**					
Үйл ажиллагааны тогтвортой байдал **[p1]**	.595**	0.053	**1.000**				
Удирдах газрын гаргасан шийдвэр **[p2]**	.623**	0.035	**.937****	**1.000**			
Алба хаагчийг чадавхжуулах хөтөлбөр **[p3]**	.767**	0.179	.913**	.866**	**1.000**		
Дотоод шилжилт хөдөлгөөн **[p4]**	.718**	0.267	.877**	**.873****	**.902****	**1.000**	
Албан томилолгоо **[p5]**	**.837****	0.12	.705**	.741**	.746**	**.714***	**1.000**
ТОО	**53**	**53**	**53**	**53**	**53**	**53**	**53**

*Тайлбар: Судалгааны ажлын үр дүн ** Хамаарал 0.01 түвшинд ач холбогдолтой*

Статистик боловсруулалтыг SPSS-25.0 программ ашиглан Пеарсоны хүчин зүйлийн хамаарлын шинжилгээгээр хар тамхитай тэмцэх байгууллагын үйл ажиллагааны хяналтад нөлөөлөх магадлал бүхий улс төрийн хүчин зүйлийг илэрхийлэх таван асуултыг ажилласан жил, албан тушаалтай хамааруулан судалсан. Ийнхүү шинжлэхэд, албан тушаал албан томилгоо 0.837**, албан тушаал удирдах газрын шийдвэртэй 0.937**, удирдах газрын гаргах шийдвэр алба хаагчдыг чадавхжуулах хөтөлбөртэй 0.873**, алба хаагчийн чадавхжуулах хөтөлбөр дотоод шилжилт хөдөлгөөнтэй 0.902** хамгийн их хамааралтай байна. Шинжилгээний үр дүнгээс албан томилгоо, удирдах газрын гаргаж буй шийдвэр нь алба

хаагчдыг чадавхжуулах хөтөлбөр, дотоод шилжилт хөдөлгөөн ихээхэн хамаардаг гэсэн дүгнэлт өгөх боломжтой (Зураг 4.).

Зураг 4. Эдийн засгийн хүчин зүйлийн үнэлгээ (n:53)

Үзүүлэлт	Төсвөөс авдаг санхүүжилт		Улсын төсвөөс гадуур санхүүжилт		Цол, тусгай албаны нэмэгдэл		Хамтын ажиллагаанд төсвөөс мөнгө хуваарилах байдал		Удаан жил ажилласны нэмэгдэл	
Давуу тал	33	62.3%	24	45.3%	38	71.7%	20	37.7%	32	60.4%
Сул тал	9	17.0%	17	32.1%	5	9.4%	17	32.1%	5	9.4%
Боломж	7	13.2%	4	7.5%	9	17.0%	9	17.0%	15	28.3%
Аюул занал	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мэдэхгүй	4	7.%5	8	15.1%	1	1.9%	7	13.2%	1	1.9%
НИЙТ	**53**		**53**		**53**		**53**		**53**	

Тайлбар: Судалгааны ажлын үр дүн

Алба хаагчдаас авсан судалгаанд, байгууллагын төлөв байдал, хяналтад нөлөөлөх эдийн засгийн хүчин зүйлийг шинжлэхэд, төсвөөс авдаг санхүүжилт, цол, тусгай албаны нэмэгдэл, удаан жил ажилласны нэмэгдэл нь давуу тал; улсын төсвөөс авах санхүүжилт сул тал; төсвөөс авдаг санхүүжилт, улсын төсвөөс гадуур санхүүжилт цол, тусгай албаны нэмэгдэл, хамтын ажиллагаанд төсвөөс мөнгө хуваарилах байдал, удаан жил ажилласны нэмэгдэл бүгд боломж гэдгийг алба хаагчид тодорхойлсон үр дүнтэй байна (Зураг 4.).

Зураг 5. Ажилласан жил, албан тушаал ба эдийн засгийн хүчин зүйлийн хамаарал (n:53)

ҮЗҮҮЛЭЛТ	Албан тушаал	[a]	[e1]	[e2]	[e3]	[e4]	[e5]
Албан тушаал	**1.000**						
Ажилласан жил **[a]**	.127	**1.000**					
Төсвөөс авдаг санхүүжилт **[e1]**	.537**	.105	**1.000**				
Улсын төсвөөс гадуур санхүүжилт **[e2]**	.619**	.019	.913**	**1.000**			
Цол, тусгай албаны нэмэгдэл **[e3]**	.445**	.149	**.908****	.883**	**1.000**		
Хамтын ажиллагаанд төсвөөс мөнгө хуваарилах байдал **[e4]**	680**	109	**901****	**942****	**864***	**.000**	
Удаан жил ажилласны нэмэгдэл **[e5]**	584**	.016	670**	610**	549**	636**	**1 .000**
ТОО	**53**	**53**	**53**	**53**	**53**	**53**	**53**

Албан тушаал, ажилласан жил нь эдийн засгийн хүчин зүйлтэй хэрхэн хамааралтай байгааг шалгахад, улсын төсвөөс авах санхүүжилтийг цол, тусгай

албаны нэмэгдэлтэй 0.908**; төсвөөс авдаг санхүүжилт нь хамтын ажиллагаанд төсвөөс мөнгө хуваарилах байдалтай 0.901**; улсын төсвөөс гадуур санхүүжилт олох байдал нь хамтын ажиллагаанд төсвөөс мөнгө хуваарилах байдалтай 0.942**; цол тусгай албаны нэмэгдэл нь хамтын ажиллагаанд төсвөөс олгосон мөнгөн хуваарилах байдалтай 0.864** тус тус хамаарал өндөртэй үр дүн гарсан. Ажилласан жил болон удаан жил ажилласны нэмэгдэл авдаг байдал хамаарал бага ба -0.016 байгаа нь хар тамхитай тэмцэх байгууллагад ажиллаж байгаа алба хаагчдын ажилласан жил харьцангуй бага байгааг илтгэсэн. Энэ шинжилгээний үр дүнгээс, тухайн байгууллага нь төсвөөс санхүүждэг тул төсвөөс олгож байгаа санхүүжилт нь цол, тусгай албаны нэмэгдэл, хамтын ажиллагаанд шууд зарцуулагддаг гэсэн дүгнэлтийг өгөх боломжтой (Зураг 5.).

Зураг 6. Нийгмийн хүчин зүйлийн үнэлгээ (n:53)

Үзүүлэлт	Аюулгүй байдал		Гадаад хамтын ажиллагаа		Туршлагатай, багийн үйл ажиллагаа		Мэргэшүүлэх сургалтад хамрагдалт		Мэргэжлийн ур чадвар	
Давуу тал	26	49.1 %	26	49.1 %	35	66.0 %	26	49.1 %	31	58.5 %
Сул тал	18	34.0 %	10	18.9 %	8	15.1 %	11	20.8 %	6	11.3 %
Боломж	8	15.1 %	16	30.2 %	10	18.9 %	16	30.2 %	16	30.2 %
Аюул занал	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мэдэхгүй	1	1.9%	1	1.9%	0	0	0	0	0	0
НИЙТ	**53**		**53**		**53**		**53**		**53**	

Тайлбар: Судалгааны ажлын үр дүн

Алба хаагчдаас авсан судалгаанд, байгууллагын төлөв байдал, хяналтад нөлөөлөх нийгмийн хүчин зүйлийг шинжлэхэд, аюулгүй байдал, байгууллагын үйл ажиллагааны гадаад хамтын ажиллагаа, туршлагатай, багийн үйл ажиллагаа, мэргэшүүлэх сургалтад хамрагдалт, мэргэжлийн ур чадвар нь давуу тал, боломж болсон байна (Зураг 6.).

Зураг 7. Ажилласан жил, албан тушаал ба нийгмийн хүчин зүйлийн хамаарал (n:53)

Үзүүлэлт	Албан тушаал	**[a]**	**[s1]**	**[s2]**	**[s3]**	**[s4]**	**[s5]**
Албан тушаал	**1.000**						
Ажилласан жил **[a]**	.127	**1.000**					
Аюулгүй байдал **[s1]**	.662**	-.036	**1.000**				
Гадаад хамтын ажиллагаа **[s2]**	.704**	-.047	**.840****	**1.000**			
Туршлагатай, багийн үйл ажиллагаа **[s3]**	.527**	-.025	.444**	.728**	**1.000**		
Мэргэшүүлэх сургалтад хамрагдалт **[s4]**	**.736****	-.124	.664**	**.841****	**.830****	**1.000**	
Мэргэжлийн ур чадвар **[s5]**	.630**	-.119	.510**	.714**	**.794****	**.825****	**1.000**
ТОО	**53**	**53**	**53**	**53**	**53**	**53**	**53**

*Тайлбар: Судалгааны ажлын үр дүн ** Хамаарал 0.01 түвшинд ач холбогдолтой*

Албан тушаал, ажилласан жил нь нийгмийн хүчин зүйлтэй хэрхэн хамааралтай байгааг шалгахад, албан тушаалын ангиллаар мэргэшүүлэх сургалтад хамрагдах хамаарал 0.736**; аюулгүй байдал нь гадаад хамтын ажиллагаатай 0.540**; гадаад хамтын ажиллагаа ба мэргэшүүлэх сургалтад хамрагддаг байдал нь 0.841**; туршлагатай багийн үйл ажиллагаа нь мэргэшүүлэх сургалтад хамрагдах хамаарал 0.830**; гадаад хамтын ажиллагаа нь мэргэжлийн ур чадвартай 0.794**, мэргэшүүлэх сургалт мэргэжлийн ур чадварын хоорондын хамаарал 0.825** тус тус өндөр хамааралтай байна. Харин ажилласан жил аюулгүй байдал, байгууллагын үйл ажиллагааны гадаад хамтын ажиллагаа, туршлагатай, багийн үйл ажиллагаа, мэргэшүүлэх сургалтад хамрагдалт, мэргэжлийн ур чадвартай хамаарал бага -0.036-0.119 хооронд байгаа нь тусгай чиг үүргийн алба хаагчдад ажилласан жилийн ялгаа бага байгааг илтгэсэн. Энэ шинжилгээний үр дүнгээс, тухайн байгууллага нь туршлагатай, ур чадвартай алба хаагчидтай, гадаад хамтын ажиллагаа сайн, мэргэшүүлэх сургалтад хамрагддаг гэсэн дүгнэлтийг өгөх боломжтой (Зураг 7.).

Зураг 8. Технологийн хүчин зүйлийн үнэлгээ (n:53)

Үзүүлэлт	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал		Санал, хүсэлт, өргөдөл, шийдвэрлэлт		Цахим сургалт, уулзалтын боломж		Сүлжээний хамгаалалт		Мэдээлэл алдагдах эрсдэл	
Давуу тал	**23**	43.4 %	**32**	60.4 %	**36**	67.9 %	**19**	35.8 %	**10**	18.9 %
Сул тал	**17**	32.1 %	**11**	20.8 %	7	13.2 %	**17**	32.1 %	**27**	50.9 %
Боломж	9	17.0 %	9	17.0 %	**9**	18.9 %	10	18.9 %	8	15.1 %
Аюул занал	4	7.5%	0	0	0	0	4	7.5%	8	15.1 %
Мэдэхгүй	0	0	1	1.9%	0	0	3	5.7%	0	0
НИЙТ	**53**		**53**		**53**		**53**		**53**	

Тайлбар: Судалгааны ажлын үр дүн

Алба хаагчдаас авсан судалгаанд, байгууллагын үйл ажиллагааны хяналтад технологийн хүчин зүйлийг шинжлэхэд, мэдээллийн ил тод, нээлттэй байдал; санал, хүсэлт, өргөдөл, шийдвэрлэлт цахим сургалт, уулзалтын боломж сүлжээний хамгаалалт нь давуу тал болсон ч мэдээллийн ил тод байдлыг сул тал гэж дүгнэхээр хариулттай үр дүн гарсан. Сүлжээний хамгаалалт сайн байгааг боломж үзүүлэлт илтгэж байна (Зураг 8.).

Зураг 9. Ажилласан жил, албан тушаал ба технологийн хүчин зүйлийн хамаарал (n:53)

Үзүүлэлт	Албан тушаал	**[a]**	**[t1]**	**[t2]**	**[t3]**	**[t4]**	**[t5]**
Албан тушаал	**1.000**						
Ажилласан жил **[a]**	.127	**1.000**					

Мэдээллийн ил тод, нээлттэй байдал **[t1]**	.713**	.003	**1.000**				
Санал, хүсэлт, өргөдөл, шийдвэрлэлт **[t2]**	.549*	.090	.663*	**1.000**			
Цахим сургалт, уулзалтын боломж **[t3]**	.507*	.074	.632*	.604*	**1.000**		
Сүлжээний хамгаалалт **[t4]**	.730*	.119	**.828****	**.876****	.679**	**1.000**	
Мэдээлэл алдагдах эрсдэл **[t5]**	.666*	.306*	**.867****	.638**	**.659****	**.767****	**1.000**
ТОО	**53**	**53**	**53**	**53**	**53**	**53**	**53**

*Тайлбар: Судалгааны ажлын үр дүн ** Хамаарал 0.01 түвшинд ач холбогдолтой*

Албан тушаал, ажилласан жил технологийн хүчин зүйлтэй хэрхэн хамаарахыг шинжлэхэд, мэдээллийн ил тод, нээлттэй байдал нь сүлжээний хамгаалалттай 0.828**; мэдээлэл алдагдах байдалтай 0.867**; санал хүсэлт, өргөдөл, шийдвэрлэлт нь сүлжээний хамгаалалттай 0.876**, цахим сургалт, уулзалт нь мэдээлэл алдагдах эрсдэлтэй 0.659**, сүлжээний хамгаалалт нь мэдээлэл алдагдах эрсдэлтэй 0.767** тус тус өндөр хамааралтай байна. Эндээс мэдээллийн ил тод хэдий чинээ их байна тэр хэмжээгээр мэдээлэл алдагдах боломж их, цахим сургалт уулзалтыг зохион байгуулснаар алба хаагчидтай холбоотой мэдээлэл алдагдах эрсдэл өндөр байна гэж дүгнэж байна. Мөн өмнөх асуулттай харьцуулахад ажилласан жил нь мэдээллийн ил тод байдал, нээлттэй байдал; санал, хүсэлт, өргөдөл, шийдвэрлэлт цахим сургалт, уулзалтын боломж сүлжээний хамгаалалт; мэдээлэл алдагдах эрсдэлтэй 0.003-0.306* хүртэл хамааралтай байгаа нь технологийн хүчин зүйл бүх алба хаагчдад хүртээмжтэй байдаг гэх дүгнэлтэд хүргэж байна (Зураг 9).

Зураг 10. Хууль эрх зүйн хүчин зүйлийн үнэлгээ (n:53)

Үзүүлэлт	Эрх зүйн орчин бүрдсэн байдал		Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийг хэрэгжилт		Урамшууллын эрх зүйн хүрээний хэрэгжилт		Шагнал урамшууллын бодлого, тогтолцоо		Хуулийн нэршил, нэр томьёоны хэрэгжилт	
Давуу тал	**24**	45.3 %	**24**	45.3 %	**27**	50.9 %	**19**	35.8%	**24**	45.3%
Сул тал	10	18.9 %	**14**	26.4 %	10	18.9 %	**18**	34.0%	**20**	37.7%
Боломж	**16**	30.2 %	12	22.6 %	**14**	26.4 %	13	24.5%	8	15.1%
Аюул занал	2	3.8%	1	1.9%	1	1.9%	1	1.9%	1	1.9%
Мэдэхгүй	1	1.9%	2	3.8%	1	1.9%	2	3.8%	0	0
НИЙТ	**53**		**53**		**53**		**53**		**53**	

Тайлбар: Судалгааны ажлын үр дүн

Алба хаагчдаас авсан судалгаанд, байгууллагын үйл ажиллагааны хяналтад хууль эрх зүйн хүчин зүйлийг шинжлэхэд, эрх зүйн орчин бүрдсэн байдал, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, урамшууллын эрх зүйн хэрэгжилт, шагнал урамшууллын

бодлого, тогтолцоо, хуулийн нэршил, нэр томьёоны хэрэгжилт нь давуу тал болсныг илтгэж байна. Энэ нь цагдаагийн байгууллагын онцлог, тусгай чиг үүргийн агентлаг тул хууль эрх зүйн бодлогын үйл ажиллагаа хэрэгждэг нь харагдаж байна (Зураг 10.).

Зураг 11. Ажилласан жил, албан тушаал ба хууль эрх зүйн хүчин зүйлийн хамаарал (n:53)

ҮЗҮҮЛЭЛТ	Албан тушаал	[a]	[L1]	[L2]	[L3]	[L4]	[L5]
Албан тушаал	**1.000**						
Ажилласан жил **[a]**	.127	**1.000**					
Эрх зүйн орчин бүрдсэн байдал **[L1]**	.747**	-.088	**1.000**				
Гадаад, дотоод төсөл, хөтөлбөрийг хэрэгжилт **[L2]**	.699**	-.049	**.958****	**1.000**			
Урамшуллын эрх зүйн хүрээний хэрэгжилт **[L3]**	.671**	-.010	**.927****	**.949****	**1.000**		
Шагнал урамшуллын бодлого, тогтолцоо **[L4]**	**.748****	.114	**.921****	**.953****	**.924****	**1.000**	
Хуулийн нэршил, нэр томьёоны хэрэгжилт **[L5]**	.744**	-.096	**.926****	**.925****	**.869****	**.875****	**1.000**
НИЙТ	**53**	**53**	**53**	**53**	**53**	**53**	**53**

*Тайлбар: Судалгааны ажлын үр дүн ** Хамаарал 0.01 түвшинд ач холбогдолтой*

Албан тушаал, ажилласан жил технологийн хүчин зүйлтэй хэрхэн хамаарахыг шинжлэхэд, албан тушаал шагнал урамшуллын бодлого 0.748**, гадаад, дотоодын төсөл, нь урамшуллын эрх зүйн хэрэгжилттэй 0.949**, гадаад, дотоодын төсөл нь шагнал, урамшуллын бодлого тогтолцоотой 0.953**, хуулийн нэршил, нэр томьёотой 0.925**, урамшуллын эрх зүйн хүрээний хэрэгжилт нь шагнал урамшуллын бодлого, хэрэгжилттэй 0.924**, хуулийн нэршил, нэр томьёотой 0.869**, шагнал урамшуллын бодлого, хэрэгжилт нь хуулийн нэршил, нэр томьёотой 0.875** тус тус өндөр хамааралтай үр дүнтэй байгаа нь гадаадын төсөл хөтөлбөр хэрэгждэг, хөтөлбөрийн хэрэгжилтээс урамшуулал, шагналын бодлого хэрэгждэг гэдгийг харуулж байна (Зураг 11.).

Дүгнэлт

Байгууллагын хяналтын өнөөгийн төлөв байдлыг олон улсын судлаачдын судалгааны ажлуудаас түүвэрлэн судлахад, хөндлөнгийн хяналт, үнэлгээ, тухайн нэгжийн алба хаагчдын хяналт үнэлгээ гэсэн үндсэн хоёр сонголт нь хамгийн түгээмэл хэрэглэгддэг аргачлалд тооцогддог. Иймээс байгууллагын бодлого, эдийн засаг, нийгэм, технологи, хууль эрх зүйн үзүүлэлтийг байгууллагынхаа үйл ажиллагаатай шууд холбон үнэлэх үнэлэмж нь зөвхөн тухайн байгууллагаа сайн мэддэг алба хаагчдын хувьд бодит шалгуурт нийцсэн үнэлгээ өгөх нээлттэй боломж байсан. Судалгааны обьектын тухайд албан тушаал дэвшүүлж буй байдал, удирдах албан тушаалтны шийдвэр зэрэг нь алба хаагч нарыг урамшуулах, чадавхжуулах, үйл ажиллагаагаа бэхжүүлэх чиглэлд түлхүү анхаардаг. Алба хаагч нар нь байгууллагын аюулгүй байдал, гадаад хамтын ажиллагаа, хуримтлуулсан туршлага, мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх мэргэшүүлэх сургалтанд үе

шаттай хамрагдуулдаг зэргийг тухайн байгууллагын давуу тал гэж тодорхойлсон нь байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Алба хаагч нарын олонх нь хариуцсан чиглэлд үр дүнтэй ажиллах ажлын дадлага туршлага, ажилласан жилийн ялгаа багатай байгаа нь богино хугацаанд дээр дурьдсан ажил, арга хэмжээний хүрээнд ур чадвар өсөн нэмэгдэх боломжтой, албандаа итгэх дотоод итгэл үнэмшил өндөр байгааг харуулж байна.

Алба хаагч нар сүлжээний хамгаалалт, технологийн хүчин зүйл хүртээмжтэй хэдий ч мэдээлэл алдагдах эрсдэл, ил тод байдал нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд сөрөг үр дагавар учруулах эрсдэл гэж тодорхойлсон нь байгууллагын зүгээс анхаарал тавьж, шийдвэрлэх асуудлын нэг болж байна.

Бидний судалгаа нь төрийн чиг үүргийн хэрэгжүүлэгч зөвхөн нэг нэгжийн алба хаагчдыг хамруулан авсанаараа онцлог хэдий ч цаашид бусад агентлагтай харьцуулалт хийж болох суурь судалгааны баримтжуулсан мэдээлэл болсноороо ач холбогдолтой гэж үзэж байна.

Ном зүй

A.Allen, L. (1958). *Management and Organziation.* McGraw-Hill: McGraw-Hill, 1958.

Autores, V. (2013). *Oxford Learner's dictionary of American English, third edition.* Oxford: Oxford University Publisher .

Azemi, F. (2019). National Strategy Against Narcotics, Drug Control Policy, and Law Enforcement Experiences in Kosovo. *Dissertations and Dcotoral Studies*, 38-42.

Brook, K. K. (2010). Drug Courts and the Treatment of Addiction:Therapeutic Jurisprudence and Neoliberal Governance. *Doctoral dissertation*, 12-18.

Cambridge. (2013). *Cambridge Advanced Learner's dictionary.* London: Cambridge University Press.

Drucker, P. F. (2011). *Technology, Management, and Society.* Boston Massachusetts: Harvard

Koontz, H. a. (2005). *Management: A Systems and Contingency Analysis of Managerial Functions.* New York.: McGraw-Hill Book Company.

Kьrschner, S. (2013). Empirical research on management control. *Doctoral dissertation*, 16-18.

McClelland, K. (2020). Social structure and control. *Science Direct*, 229-235.

Nanto, D. K. (2011). *Economics and National Security: Issues and Implications for U.S. Policy.* Washington: Congressional Research Service.

O'Donnell., H. K. (1959). *Principles of Management. An Analysis of Managerial Functions.* London, New York, Toronto: McGraw-Hill Book Company.

Okpora, M. (2015). Henry Fayol's 14 Principles of Management: Implications for Libraries and Information Centres. *Journal of Information Science Theory and Practice*, 58-65.

Pasupathi, M. (2015). *Emotion and aging:Experience and control.* California: Psychology and Aging.

Pearson. (2015). *Longman dictionary of Contemporary English sixth edition.* Los Angelos: Pearson Education.

Schwabel, J. (2007). *Command, Control, Coordination, and Cooperation during Defense Command, Control,*

Coordination, and Cooperation during Defense. Philadelphia: U.S. Army War College,Carlisle Barracks,Carlisle.

Д.Цэндсүрэн. (2015). Гаалийн хяналтын эрсдэлүүд, тэдгээрийг бууруулах зарим арга зам. *Докторын диссертац, Монгол Улсын Их Сургууль. Бизнесийн Сургууль*, 25-29.

Т.Дорж. (2018). *Менежмент.* Улаанбаатар хот: Эдмон пресс.

ЦЕГ. (2019). Хар тамхитай тэмцэх газрын тайлан. *Хар тамхитай тэмцэх газрын тайлан, нөхцөл байдлын мэдээ*, 30.

Я.Шуурав. (2020). *Менежментийн шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь бичиг.* Улаанбаатар хот.

실박진. (2015). 마약류 중독자에 대한 치료현황 및 대책에 대한 연구. *Chung-Ang Journal of Legal Studies*, 201-236.

전경수. (2004). Хар тамхи, мансууруулах бодис хэрэглэгчдэд зориулсан анагаах ухааны эмчилгээний аргын тухай. *weekly.khan.co.kr*, 221-223.

Хавсралт

Байгууллагын орчны төлөв байдлын судалгаа ХТТБ-ын алба хаагчдын судалгаа (N:53)



Тайлбар: Судалгааны ажлын баримтжуулсан мэдээлэл

МАНЛАЙЛЛЫН НӨЛӨӨЛЛИЙН СУДАЛГАА: ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ЖИШЭЭН ДЭЭР

THE STUDY OF IMPACTS ON LEADERSHIP: THE CASE OF BORDER PROTECTION AGENCY

Ц.Одонгэрэл
ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн ар тал, эдийн засгийн тэнхимийн эрхлэгч, докторант, дэд хурандаа
Odongerel.Ts
Head of rear and economics department of Border Service College at University of Internal Affairs, Mongolia, Lieutenant Colonel

Хураангуй: Хил хамгаалах байгууллагаас 2022 онд дэвшүүлсэн “Дархан хилийн албанд итгэл дүүрэн, сэтгэл хангалуун хилчин” зорилт, “Офицерын манлайллын жил” – ийн хүрээнд бие бүрэлдэхүүний албаны ур чадвар, ёс зүй, сахилга хариуцлагыг бэхжүүлэх аяны хүрээнд хил хамгаалах байгууллагын албан хаагчдаас манлайллын нөлөөллийн судалгааг авахыг зорьсон. Манлайлалд нөлөөлж байгаа хүчин зүйлийн нөлөөлөл, ач холбогдол, үнэлгээгээр нь олон эрдэмтэд үзэл браимтлалаа илэрхийлэн, үнэлэн харьцуулан судалдаг. Энэ судалгааны ажил нь манлайлалд нөлөөлж байгаа хүчин зүйлийн найдвартай байдал, дундаж утга, замын шинжилгээнйи үр дүнг тооцон шинжилж харьцуулсан.

Abstract: This study was conducted that “Border Guard Confidence and Satisfaction Border Guard” goal set by the Border Guard Service in 2022 and the “Year of Officer Leadership” campaign to strengthen the skills, ethics and discipline of personnel. There are many scholars compared and contrasted their conceptual framework on impacts, factors for influencing leadership. This study analyzes and compares the reliability of the factors influencing leadership, the mean values, and the results of the path analysis.

Түлхүүр үг: ур чадвар, ажлын туршлага, харилцаа, хандлага, манлайлал
Keywords: skills, work experience, communication, attitudes, leadership

Манлайлал, манлайллын тухай онол арга зүй

Манлайлал ба менежмент нь хоорондоо ялгаатай боловч нэг нэгийгээ нөхдөг хоёр өөр үйлдлийн систем бөгөөд тус бүрдээ өөрийн үүрэг, үйл ажиллагаатай байдаг.

Манлайлал нь хүмүүсийн үнэт зүйлс, зан төлөв болон хандлагад нөлөөлж өөрчлөлт шинэчлэлийг удирдан зааварлаж нэг ойлголтод хүргэх ур чадваруудын нэгдэл бөгөөд байгууллагын бүх түвшинд байвал илүү үр дүнтэй. Байгууллагад манлайлагч гэсэн тусдаа албан тушаал байдаггүй. Харин менежмент нь менежер, захирал, гүйцэтгэх захирал зэрэг тодорхой албан тушаалуудаар дамжуулан ажлыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, хянах, асуудлыг шийдвэрлэх арга ажиллагаа байдаг.

Менежментийн онолын нэрт төлөөлөгч П.Дракер 1999 онд “XX зууны менежментийн сорилтууд” хэмээх алдартай номоо бичин өнгөрсөн зууны менежментийн хоцрогдолд ороод буй асуудлыг нэрлэн, улмаар шинэ зууны менежментийн найман хандлагыг тодорхойлсны дотор “Хүмүүсийг удирдах гэхээс илүү тэдний давуу тал, мэдлэгийг үр бүтээлтэй болгохын тулд манлайлах хэрэгтэй” гэсэн байдаг.

Манлайллын онол 19 дүгээр зууны төгсгөл, 20 дугаар зууны эхэн үеэс эрчимтэй хөгжжээ. “Агуу хүн’’-ий зан чанарын зэрэг эхэн үеийн онолууд нь сайн манлайлагчийн нийтлэг шинж чанар, манлайлагч хүнийг бусдаас ялгаруулдаг зан чанарын тухай эрэл хайгуул хийж байсан бол цаашид манлайллыг удирдлагын арга барилтай холбон авч үздэг зан үйлийн онол, удирдагч нөхцөл байдалдаа тохируулан манлайллын өөр өөр аргыг хэрэглэх тухай нөхцөл байдлын онолын урсгалууд хөгжсөн.

Менежментийн шинжлэх ухаанд манлайллын талаар судлахдаа ур чадвар, харилцаа, хандлага, ажлын туршлага, гадаад хэлний мэдлэгийг удирдах ажилтны манлайлалд хэрхэн нөлөөлөхийг судлахаар таамаглал дэвшүүлж загвар санал болголоо.

Загвар 1. Манлайлалд нөлөөлөх хүчин зүйлс

Тайлбар: Судлаачийн санал болгож буй загвар

Т1: Удирдах ажилтны ажлын туршлага манлайлалд нөлөөлнө.

Т2: Удирдах ажилтны мэргэжлийн мэдлэг манлайлалд нөлөөлнө.

Т3: Удирдах ажилтны мэргэжлийн ур чадвар манлайлалд нөлөөлнө.

Т4: Удирдах ажилтны харилцаа хандлага манлайлалд нөлөөлнө.

Т5: Удирдах ажилтны гадаад хэлний ур чадвар манлайлалд нөлөөлнө.

Судалгааны арга зүй, үр дүн:

Судалгааг онолд үндэслэн дэвшүүлсэн таамаглалаа батлах зорилгоор чанарын судалгааны арга зүйгээр өгөгдөлд боловсруулалт хийсэн. Судалгааг 2022 оны 2 дугаар сарын 07-ны өдрөөс 2022 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн хооронд цахимаар авсан. Судалгаанд хил хамгаалах байгууллагын нийт 168 удирдах албан хаагчид хамрагдсан ба агшингийн судалгааны боловсруулалтыг хувьсагч бүрийг кодлосон.

Хүснэгт 1. Хэмжил зүйн шинжилгээний үр дүн

хувьсагч	кодлол	Хүчин зүйлийн шинжилгээ	Кронбах альфа	Нийлмэл найдвартай байдал	Дундаж утга
Ажлын туршлага	exp-1	0.886	0.916	0.936	0.710
	exp-2	0.854			
	exp-3	0.706			
	exp-4	0.771			
	exp-5	0.894			
	exp-6	0.925			
Мэргэжлийн мэдлэг	know-1	0.726	0.882	0.908	0.588
	know-2	0.668			
	know-3	0.672			
	know-4	0.849			
	know-5	0.822			
	know-6	0.824			
	know-7	0.785			
Мэргэжлийн ур чадвар	prof sk-1	0.768	0.818	0.864	0.478
	prof sk-2	0.745			
	prof sk-3	0.672			
	prof sk-4	0.562			
	prof sk-5	0.677			
	prof sk-6	0.767			
	prof sk-7	0.625			
Харилцаа хандлага	att-1	0.657	0.842	0.879	0.515
	att-2	0.751			
	att-3	0.526			
	att-4	0.686			
	att-5	0.620			
	att-6	0.849			
	att-7	0.869			
Гадаад хэлний ур чадвар	lan sk-1	0.824	0.843	0.927	0.590
	lan sk-2	0.901			
	lan sk-3	0.860			
	lan sk-4	0.912			
	lan sk-5	0.914			
	lan sk-6	0.327			
	lan sk-7	-0.244			
МАНЛАЙЛАЛ	LEAD-1	0.604	0.910	0.879	0.515
	LEAD-2	0.787			
	LEAD-3	0.844			
	LEAD-4	0.792			
	LEAD-5	0.841			
	LEAD-6	0.845			
	LEAD-7	0.842			
	LEAD-8	0.649			
	LEAD-9	0.659			

Тайлбар: exp-ажлын туршлага, know – мэргэжлийн мэдлэг, prof sk-мэргэжлийн ур чадвар, att-харилцаа, хандлага, lan sk-гадаад хэлний ур чадвар, LEAD-манлайлал

Загвар 2. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн



Тайлбар: exp-ажлын туршлага, know – мэргэжлийн мэдлэг, prof sk-мэргэжлийн ур чадвар, att-харилцаа, хандлага, lan sk-гадаад хэлний ур чадвар, LEAD-манлайлал

Дээрх хэмжил зүйн шинжилгээний үр дүнгээс, ажлын туршлагын зургаан далд хувьсагчийн утга 0.706-0.925, мэргэжлийн мэдлэгийн долоон далд хувьсагч 0.668-0.849, мэргэжлийн ур чадварын долоон далд хувьсагч 0.562-0.768, харилцаа хандлагын долоон далд хувьсагч 0.526-0.869, гадаад хэлний ур чадварын долоон далд хувьсагч -0.244-0.914, манлайллын есөн далд хувьсагч 0.604-0.844 хооронд тус тус хэлбэлзсэн үр дүнтэй байна.

Хэмжил зүйн шинжилгээний нийлмэл найдвартай байдлын хувьд, ажлын туршлага 0.936, мэргэжлийн мэдлэг 0.893, мэргэжлийн ур чадвар 0.835, харилцаа хандлага 0.868, гадаад хэлний ур чадвар 0.918, манлайлал 0.918 үр дүнтэй ба бүх утга 0.7 нэгжээс өндөр гарч найдвартай байгааг илэрхийллээ.

Найдвартай байдлын итгэлцүүр Кронбах альфа утгын хувьд, ажлын туршлага 0.916, мэргэжлийн мэдлэг 0.882, мэргэжлийн ур чадвар 0.818, харилцаа хандлага 0.842, гадаад хэлний ур чадвар 0.843, манлайлал 0.910 үр дүнтэй ба бүх утга 0.7 нэгжээс өндөр гарч найдвартай байгааг илэрхийллээ.

Дундаж утгын үнэ цэнийн хувьд, ажлын туршлага 0.710, мэргэжлийн мэдлэг 0.588, харилцаа хандлага 0.515, гадаад хэлний ур чадвар 0.581, манлайлал 0.590 үр дүнтэй байгаа нь

0.5 нэгжээс их байж дундаж утга сайн байгааг илэрхийлсэн бол мэргэжлийн ур чадвар 0.478 гарч энэ хувьсагчийн хувьд цаашид анхаарах хэрэгтэйг илэрхийллээ.

Хүснэгт 2. Замын шинжилгээний ур дүн

Таамаглал	Стандарт хазайлт	Т статистик утга	П үнэ цэнэ	Ур дүн
exp → LEAD	0.099	4.535	0.000	батлагдсан
know → LEAD	0.089	4.709	0.000	батлагдсан
prof sk → LEAD	0.096	2.056	0.000	батлагдсан
att → LEAD	0.071	0.476	0.634	батлагдаагүй
lan sk → LEAD	0.085	1.702	0.089	батлагдаагүй

Тайлбар: exp-ажлын туршлага, know – мэргэжлийн мэдлэг, prof sk-мэргэжлийн ур чадвар, att-харилцаа, хандлага, lan sk-гадаад хэлний ур чадвар, LEAD-манлайлал

Судалгааны ажлаараа, таамаглал батлахаар замын шинжилгээг стандарт хазайлт, Т статистик утга, П үнэ цэнээр шинжилсэн. Ажлын туршлага, мэргэжлийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар энэхүү судалгаанд манлайлалд эерэгээр нөлөөлж таамаглал батлагдлаа. Харин харилцаа хандлага, гадаад хэлний ур чадвар манлайлалд хараахан эерэг нөлөө үзүүлж чадахгүйгээр таамаглал батлагдсангүй /Хавсралтаас баримтжуулсан мэдээлэл тулгана уу/.

Дүгнэлт

Судалгааг хил хамгаалах байгууллагын алба хаагчдаас манлайлалд нөлөөлөх хүчин зүйлийн хамаарлыг чанарын судалгаагаар судлан боловсруулалт хийсэн нь өмнөх судлаачдын судалгааны арга зүйгээс өвөрмөц байсан гэж дүгнэх боломжтой.

Судалгааны ур дүн боловсруулалтын замын шинжилгээнээс гурван таамаглал батлагдсан нь сайн ур дүн хэдий ч хоёр таамаглал батлагдаагүй учир шалтгааныг ахин судлах шаардлагатай.

Энэ судалгааны ажлыг онолын хувьд илүүтэй дэлгэрүүлэн судалж, олон улсын ижил төстэй судалгааны ажлын боловсруулалт ур дүнтэй харьцуулж дараа дараагийн харьцуулсан судалгаа хийх, өндөр зэрэглэлээр шүүн тунгаагддаг сэтгүүлд хэвлүүлэх судалгааны ажлын суурь судалгаа болгон ашиглана гэж төлөвлөж байна.

Хавсралт

20220306 LEADERSHIP Od.txt | *20220306 Lead Ts.Od.splsm | PLS Algorithm (Run No. 3)

Construct Reliability and Validity

Matrix | Cronbach's Alpha | rho_A | Composite Reliability | Average Variance Extracted (AVE)

	Cronbach's Al...	rho_A	Composite Rel...	Average Varian...
Communication and attitude	0.842	0.868	0.879	0.515
LEADERSHIP	0.910	0.918	0.927	0.590
Language skills	0.843	0.879	0.873	0.581
Professional knowledge	0.882	0.893	0.908	0.588
Professional skills	0.818	0.835	0.864	0.478
Work experience	0.916	0.920	0.936	0.710

20220306 LEADERSHIP Od.txt | *20220306 Lead Ts.Od.splsm | PLS Algorithm (Run No. 3) | Bootstrapping (Run No. 2)

Total Effects

Mean, STDEV, T-Values, P-Values | Confidence Intervals | Confidence Intervals Bias Corrected | Samples

	Original Sampl...	Sample Mean (...	Standard Devia...	T Statistics (|O/...	P Values
Communication and attitude -> LEADERSHIP	0.034	0.062	0.071	0.476	0.634
Language skills -> LEADERSHIP	-0.144	-0.116	0.085	1.702	0.089
Professional knowledge -> LEADERSHIP	0.419	0.401	0.089	4.709	0.000
Professional skills -> LEADERSHIP	0.196	0.200	0.096	2.056	0.040
Work experience -> LEADERSHIP	0.448	0.434	0.099	4.535	0.000

Ном зүй:

1. Г. Цэрэн “Байгууллагын зан төлөв” 2014 он, УБ хот,
2. Ц.Цэцэгмаа “Хүний нөөцийн менежмент” онол, практик, жишээ 2009 он, УБ хот,
3. М.Нармандах, Б. Довчинбалжир, Л. Санжрагчаа “Хүний нөөцийн ажилтны гарын авлага” 2011 он, УБ хот,
4. П.Наранцэцэг “Хүний нөөцийн менежмент ” 2014 он, УБ хот,
5. Н.Цэнд, Г.Батхүрэл, Я.Шуурав, Х,Пүрэвдавга, Ц.Цэцэгмаа, Н.О.Лизунов, Л.Цэрэнчимэд, Д.Оюунчимэг “Менежмент” сурах бичиг 2013 он, УБ хот,
6. Х.Пүрэвдавга, Г. Батхүрэл “Хүний нөөцийн менежмент” сурах бичиг 2015 он, УБ хот,
7. И.Батхишиг “Мотивацийг ашиглан хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх боломж, арга зам” 2013 он, УБ хот,
8. Б.Батжаргал “Бүтээмж ба цалин” 2008 он, УБ хот,
9. Д.Болормаа, Т.Оюунгэрэл“Хүний нөөцийн удирдлага”сурах бичиг, 2008 он, УБ хот,

Илтгэл өгүүлэл:

1. ANAO. 2004. Performance Management in the Australia Public Service. Canberra, Australia: Australian National Audit Office
2. Aucoin & Heintzman. 2000. *The* Dialectics of Accountability for Performance in Public Management Reform, *International Review of Administrative Sciences*. Vol. 66. p. 45
3. Bratton, J. & Gold, J. (2007). *Human resource management: Theory and practice (4th ed.).* New York: Palgrave Macmillan
4. Bruijin, H. (2002). Performance measurement in public sector: strategies to cope with the risk of the performance measurement. The International Journal of Public Sector Management. Vol. 15, No. 6;
5. Tanzania College. *International Journal of Emerging Market Vol. 2, No. 1, pp. 69 – 83*
6. Fenwick, M. & De Cieri, H. (2001). Performance management: Linking strategy and human resources. *Working Paper Vol.10, No. 1;* Monash University, Faculty of Business and Economy
7. Harper, S. & Vilnikas, T. 2007. Determining the Impact of an Organization’s Performance Management System, *Asia pacific Journal of Human Resources.* Retrieved 20 August 2007 from

МОНГОЛ УЛСАД ГАРЧ БАЙГАА ЗАМ ТЭЭВРИЙН ОСОЛ, ЗӨРЧИЛ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS ON THE TRAFFIC ACCIDENT AND TRAFFIC BREACH THAT OCCUR IN MONGOLIA

Г.Ариунгэрэл
ДХИС-ийн магистрант, цагдаагийн хошууч
G.Ariungerel
Major, Master student of UIA

Хураангуй: Хүний аюулгүй байдалд нөлөөлөх аюул заналын эх үүсвэр нь анхандаа байгалийн, араатан амьтны гаралтай байж, яваандаа хүний хүчин зүйлээс гаралтай эх үүсвэр бүхий аюул хамгийн ноцтой үр дагаврыг бий болгож ирсэн. Энэ нь дайн, зэвсэгт түрэмгийлэл, терроризм, гэмт халдлага, хүчирхийллээс эхлээд өвчин тахал, агаарын бохирдол, осол гэмтэл гэх зэрэг төрөл бүрийн шалтгаантай. Энэхүү өгүүлэлд Монгол Улсад гарч байгаа зам тээврийн осол, зөрчил, түүний шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар товч авч үзлээ.

Abstract: Sources of threats to human security initially had a natural and animal origin, and over time, anthropogenic threats. It can range from war, armed aggression, terrorism, crime and violence to disease, air pollution and injury. This article provides a brief overview of road traffic accidents in Mongolia, their causes and factors.

Түлхүүр үг: Зам, тээвэр, замын хөдөлгөөний аюулгүй байдал, хүн, байгууламж, осол аваар, автомашин

Keywords: Roads, transport, traffic safety, people, objects, accidents, cars

Удиртгал: 1896 оны 8-р сарын 17-нд Лондон хотод дэлхийн анхны авто осол бүртгэгдэж тэр жилдээ хоёр хүн зам тээврийн ослоор нас барсан байна. Ийнхүү автомашин гэх чамин зүйлийг “Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” гэх хар сүүдэр дагах болжээ.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаагаар жил бүр 1.2 сая хүн зам тээврийн ослоор нас барж, 50 сая хүн хөгжлийн бэрхшээлтэй болох төлөвтэй байна гэсэн үр дүн гарсан байна.[1]

Зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан хүмүүсийн 92.6 хувь нь 24 цагийн дотор, 7.1 хувь нь 30 хоногт, 0.3 хувь нь 30-аас дээш хоногт нас барсан байна. Амь насаа алдсан хүмүүсийн зөвхөн 8.4 хувь нь эмнэлгийн анхны тусламж авсан байна. Эмнэлгийн анхны тусламж авч чадаагүй тохиолдол өндөр байгаа нь орон нутгийн замд төв, суурин газраас алслагдсан замуудад хүний амь нас хохирсон осол бүртгэгдсэнтэй холбоотой юм.

"Зам тээврийн ослоор хохирогсдод хүндэтгэл үзүүлэх дэлхий нийтийн өдөр"-ийг жил бүрийн 11 дүгээр сарын 3 дахь 7 хоногт дэлхий нийтээрээ тэмдэглэн өнгөрүүлж хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай. Уг өдрийг анх 1993 онд Английн Вант улсад тэмдэглэсэн ба үүнээс хойш улс орнууд уг арга хэмжээг авто ослоор амь үрэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх, сэтгэл санааны болон бусад хохирол

[1] Зам тээврийн ослын өнөөгийн байдал. Уб. 2018. 9 дэх тал

амсаж суугаа тэдний ар гэр, ойр дотныхонд гашуудал илэрхийлэх, сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх өдөр болгон тэмдэглэж байхаар Нэгдсэн үндэстний байгууллагын Ерөнхий ассамблейгаас шийдвэрлэсэн байна[2].

Сэдвийн хамрах хүрээ: Энэхүү өгүүлэлд зөвхөн сүүлийн жилүүдэд Монгол Улсад гарсан зам тээврийн осол, түүний шалтгаан нөхцөл, нөлөөлсөн хүчин зүйлийн талаар товч авч үзсэн болно.

Үндсэн хэсэг. Хүн төрөлхтний түүхэнд аливаа улс, үндэстний сайн сайхан амьдралын төлөөх тэмцлийн туйлын зорилго нь хүн амынхаа амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлэх явдал байж ирсэн. Ийм ч учраас хүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учруулах аливаа эрсдлээс ангид байх нөхцлийг бүрдүүлэх нь төрийн анхдагч үүрэг болохын зэрэгцээ энэхүү үүргээ хэрхэн хариуцлагатай биелүүлэх нь тухайн төрт улсын оршин тогтнохуйн үндсэн нөхцөл болдог. Энэ үүднээс авч үзвэл хүний аюулгүй байдлыг хангах асуудал нь төрийн шийдвэрлэвэл зохих хамгийн үндсэн асуудал юм.

Зам тээврийн осол гэж Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.6-д заасан зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч, гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг ойлгоно.[3]

Дэлхий дахинд осол гэмтлийн улмаас жил бүр 5.8 сая хүн амь насаа алдаж, 600 гаруй сая хүн бэртэж гэмтэж, хөгжлийн бэрхшээлтэй болж, 700 тэрбум ам.долларын хохирол учирч байгаа бол үүнээс зам тээврийн ослын улмаас 1.25 сая гаруй хүн амь насаа алдаж 50 гаруй сая хүн бэртэж гэмтэж 65 тэрбум ам.долларын хохирол учруулж байгаа нь хүн амын нас баралтын гурав дахь гол шалтгаан болж байгаа тухай дэлхийн Эрүүл мэндийн байгууллагаас онцлон тэмдэглэсэн нь дэлхий нийтээрээ зам тээврийн ослыг “Тахал”-тай адилтган үзэж байна.

Зам тээврийн осол хүний хүсэл зоригоос шууд хамаарах урьдчилан сэргийлэх боломжтой шалтгаан болохыг нотолж, энэ төрлийн осол, гэмтлээс хүний амь нас хохирох явдлыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх явдалд дэлхий нийтийн анхаарлыг хандуулахын тулд Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн 2010 оны 64/255 дугаар тогтоолоор “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах хөтөлбөр”-ийг баталж, 2011-2020 оныг “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах арван жил” болгон зарласан.

Түүнчлэн Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2015 оны 70/1 дугаар тогтоолоор баталсан “2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилго”-ын гуравдугаар зорилгын хүрээнд “2020 он гэхэд зам тээврийн ослын улмаас нас барсан, гэмтсэн хүний тоог хоёр дахин бууруулах”[4] явдлыг зорилт болгон тодорхойлжээ.

Монгол Улс Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний

[2] https://www.trends.mn/n/7382

[3] Төрийн мэдээлэл. 2015. №28. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль.

[4] https://digitallibrary.un.org/record/684031?ln=en

хөтөлбөрийг 1993-2008 онд 3 удаа батлан, үйл ажиллагааны төлөвлөгөөг 95-98%-тай хэрэгжүүлсэн гэж дүгнэсэн боловч замын хөдөлгөөний аюулгүй байдал төдийлөн сайжраагүй[5] талаар Зам тээврийн хөгжлийн яамнаас мэдээлэл хийсэн.

"Монгол Улсын Үндсэн хууль"[6]-д ардчилсан эрх зүйт төрийн үндэс суурийг тогтоон бэхжүүлж, Монгол Улсын иргэд амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй байхаар зааж, бүх талын баталгааг хуульчилж өгсөн билээ.

"Цагдаагийн албаны тухай хууль"-ийн "нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг" 11.1.3-д "замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах", "Захиргааны хяналтын үүрэг"-ийн 13.1.3-т "зам тээврийн осол, түүнээс учирсан хохирол, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн жолооч болон зөрчлийн тоо бүртгэл хөтлөх"[7] талаар цагдаагийн байгууллагын чиг үүрэгт заасан.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль нь замын хөдөлгөөний зохион байгуулалт, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төрийн бодлогыг шинэ төвшинд хүргэж, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, осол, хэрэг, зөрчлийн тоог бууруулах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үзэл баримтлалыг тодорхойлж, эдгээр харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэхэд чиглэсэн. Уг хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Замын хөдөлгөөнийг зохион байгуулах болон түүний төсөл, бүдүүвчийг гүйцэтгэхэд холбогдох хууль тогтоомж, техникийн норм, дүрэм, стандарт, Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг мөрдлөг болгон шинжлэх ухааны үндэслэл, тооцоо, судалгаа, дэвшилтэт технологи, техник хэрэгсэл, инженерийн оновчтой шийдлийг иж бүрэн ашиглана", 19 дүгээр зүйлийн 19.4-т заасан "Зам, замын байгууламжийг төлөвлөх, барих, өргөтгөх, засварлах ажлыг замын хөдөлгөөний аюулгүй байдлын холбогдох шаардлагад нийцүүлэх үүргийг авто замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хариуцна"[8] гэсэн заалтуудын хэрэгжилтийн хяналтыг сайжруулах нь осол, зөрчлийг бууруулахад ач холбогдолтой юм.

Манай орны нийгэм, эдийн засаг хурдацтайгаар хөгжиж байгаагийн зэрэгцээ амьдралын хэрэгцээ шаардлага улам ихээр өсөн нэмэгдэх боллоо. Үүний илрэл нь иргэдийн худалдан авалт дээшилж, Монгол улсад гадаадын орнуудаас импортоор орж ирж байгаа автомашины тоо өсч, жолооч мэргэжил биш болж хүн бүр жолооч байх эрмэлзлэлтэй, шаардлагатай болжээ.Үүнийгээ дагаад нийслэл хот болон орон нутгийн замын хөдөлгөөн ихсэж зам тээврийн осол хэрэг ихээхэн гарч, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ихээхэн хохирол учруулах сөрөг үр дагавар бий болгож байна.

Зам тээврийн осол нь хүн, тээврийн хэрэгсэл, зам орчин гэсэн гурван үндсэн хүчин зүйлээс хамаардаг. Иймд зам

[5] http://mrtd.gov.mn/single/208
[6] Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль
[7] Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль
[8] Төрийн мэдээлэл. 2015. №28. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль.

тээврийн осол, зөрчлийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх аливаа үйл ажиллагаа нь дээрх хүчин зүйлсийн талаарх нотолгоонд тулгуурласан байх ёстой.

Монгол Улсын нийт иргэд замын хөдөлгөөнд /явган зорчигч/ явганаар болон тээврийн хэрэгслээр зорчин замын хөдөлгөөнд оролцдог тул энэ асуудал хүн бүрт хамааралтай асуудал юм.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал, зам тээврийн ослын нөхцөл байдал сайнгүй байгаа нь холбогдох статистик үзүүлэлтээс тодорхой харагдаж байна. Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2020 онд зам тээврийн ослын дуудлага мэдээлэл 21768 бүртгэн шалгасны 89.4 хувь нь эд материалын хохиролтой ослын дуудлага, 10.6 хувь нь хүн гэмтсэн /хүний амь нас, эрүүл мэнд хохирсон/ зам тээврийн осол бүртгэгдсэн байна.

Зам тээврийн осол үйлдэгдсэн хэлбэрээр нь авч үзэхэд 1454 буюу 44.7 хувь нь мөргөлдөх, 888 буюу 27.3 хувь нь онхолдох, 323 буюу 9.9 хувь нь явган хүн дайрсан ослууд байна. Орон нутагт үйлдэгдсэн 3255 ослын Дорнод аймагт 202, Хэнтий аймагт 300, Сүхбаатар аймагт 142 буюу зүүн бүсийн автозамд 644 буюу 20 орчим хувь нь үйлдэгдсэн бусад аймгуудаас өндөр үзүүлэлттэй байна.Улсын хэмжээнд 21768 зам тээврийн осол бүртгэгдсэнээс орон нутагт 3255 бүртгэгдсэн байна, орон нутагт үйлдэгдсэн зам тээврийн ослын 3122 буюу 95.9 хувь нь жолоочийн буруугаас, 115 буюу 3.5 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдлээс, 18 буюу 0.6 хувь нь замын нөхцлөөс шалтгаалж бүртгэгджээ. Зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг жолоочийн буруутай үйлдэл, явган зорчигчийн буруутай үйлдэл, замын нөхцөл байдал, техникийн гэмтлийн улмаас гарсан осол хэмээн бүлэглэн авч үзэж байна.

Гэтэл өнөөдөр манай улсын хувьд орон нутгийн автозамд замын хальтаргаа гулгаа, эвдрэл гэмтэл, тэмдэг тэмдэглэл, аюулгүй зурвас, зорчих хэсэг болон жолоочийн хөдөлмөр амралтын горимын зохицуулалт зөрчигдсөнөөс шалтгаалсан зам тээврийн осол цөөнгүй гарч байгаа хэдий ч замын нөхцөл буюу авто зам, түүний төлөвлөлт, ашиглалт, арчлалтаас хамаарсан ослын шалтгааныг бүрэн тогтоож чадахгүй байна. Монгол Улсад 2020 онд гарсан зам тээврийн ослыг аймаг тус бүрээр нь графикт оруулан харуулбал:

График №1



Дээрх статастик судалгаанд үндэслэн орон нутгийн автозамд үйлдэгдэж буй зам тээврийн осолд нөлөөлж буй хүчин зүйл, тулгамдсан асуудлыг дагнан судлах, урьдчилан сэргийлэх ажлыг онолын гаргалгаанд суурилж, оновчтой зохион байгуулах, эрх зүйн зохицуулалтын хийдэл, уялдаа холбоог сайжруулах, давхардлыг арилгах, практик үйл ажиллагааг боловсронгуй болгох зэрэг шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Монгол Улсад чанартай, хүртээмжтэй авто замын сүлжээг бий болгохоор сүүлийн жилүүдэд гадаадын зээл, тусламж, улсын төсөв, төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажлууд эрчимтэй явуулснаар Монгол Улсын авто замын сүлжээ нь олон улс, улс, нийслэл, орон нутаг, тусгай зориулалт, аж ахуйн нэгж байгууллагын дотоодын авто зам гэж ангилагддаг бөгөөд нийтдээ 112 414.2 км авто замаас бүрддэг[9].

Нийт авто замын сүлжээнээс 4 282.3 км авто зам нь олон улсын, 14 918.7 км нь улсын чанартай, 96125,3 км нь орон нутгийн чанартай авто замд хамаарч байна. Улсын чанартай авто замын 7469 км нь хатуу хучилттай, 6314,1 км нь ердийн хөрсөн, 923,56 км нь хайрган хучилттай, 211,9 км нь сайжруулсан хөрсөн авто зам байна. Тусгай зориулалтын буюу уул уурхайн тээвэрлэлтийн зориулалт бүхий 872.7 км авто зам ашиглагдаж байна.

Монгол Улс нь Азийн авто замын сүлжээ /АН-3, АН-4, АН-32, АН-35/, Төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа (CAREC) /4a, 4b, 4c/, Их түмэн гол санаачилга (GTI) /1a, 1b/ зэрэг олон улсын авто замын сүлжээнд нэгдэн орсон бөгөөд ОХУ, БНХАУ, Монгол Улс хооронд эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт 2 чиглэлд авто замын коридорыг хөгжүүлэх зорилт тусгагдсан[10].

Зураг №1

[9] https://mrtd.gov.mn/t/53. Зам тээврийн хөгжлийн яам.

[10] ТХХТ-ийн төслүүдийн онолын болон практик асуудлууд. (n.d.). Libĕna Tetrevova, Vadyba Management.

Монгол Улсын жолоочийн бүртгэлийн санд 1.335.000 жолооч бүртгэлтэй, 2020 онд шинээр 34371 жолооч нэмэгджээ. Нийт жолоочийн 36,9 хувь нь эмэгтэй, 63,1 хувь нь эрэгтэй жолооч байна. Сүүлийн 10 жилийн үзүүлэлтээс харахад жилд дунджаар 6000 гаруй жолооч шинээр бэлтгэгдэн тээврийн хэрэгсэл жолоодох эрх авсан байна.

Тэгвэл Монгол Улсын тээврийн хэрэгслийн бүртгэлийн санд 2020 оны байдлаар 1013786 автомашин,1137208 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн ба өмнөх оноос 94180 тээврийн хэрэгсэл буюу 9,1 хувиар өссөн байна. Үүнээс 715678 буюу 62,9 хувийг суудлын автомашин, 211142 буюу 18,6 хувийг ачааны автомашин, 67796 буюу 6,0 хувийг мотоцикл, 36098 буюу 3,2 хувийг том, бага оврын автобус, 40620 буюу 3,6 хувийг чиргүүл, 15006 буюу 1,3 хувийг механизм тус тус эзэлж байна.

Нийт тээврийн хэрэгслийн 572432 буюу 56,5 хувь нь Улаанбаатар хотод бүртгэлтэй, 441354 буюу 43,5 хувь нь орон нутагт бүртгэлтэй, 828273 буюу 72,8 хувь нь 10-аас дээш жил, 211525 буюу 18,6 хувь нь 7-9 жил, 45242 буюу 4.0 хувь нь 4-6 жил, 52168 буюу 4,6 хувь нь 0-3 жилийн насжилттай байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлдөг хүчин зүйлүүдээс тээврийн хэрэгслийн насжилт, жолооны хүрдний байрлал чухал нөлөөтэй бөгөөд Монгол Улсын хэмжээнд энэ үзүүлэлт анхаарал татах үзүүлэлт болоод байна. 2020 онд нийт бүртгэлтэй автомашины 436942 буюу 34,8 хувь нь зүүн талдаа жолооны хүрдтэй, 576844 буюу 65,2 хувь нь баруун талдаа жолооны хүрдтэй байна.

Өмнөх оноос зүүн талдаа жолооны хүрдтэй автомашин 5,6 хувиар, баруун талдаа жолооны хүрдтэй автомашин 10,8 хувиар тус тус өссөн байна[11].

График №2

Замын хөдөлгөөний аюулгүй байдал, орон нутгийн автозамд үйлдэгдсэн зам тээврийн осол, зөрчлийн нөхцөл байдлыг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойшхи дөрвөн жилийн хугацаанд Үндэсний статистикийн хороо, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, болон бусад

[11] Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт 2020. Тээврийн цагдаагийн алба, УБ. 2021

байгууллагаас тооцсон статистик баримт мэдээлэлд тулгуурлан ослын түвшин, хөдөлгөөн, бүтэц гэсэн үндсэн гурван үзүүлэлтээр илэрхийлж, өөрчлөлтийн төлөвийг тодорхойлон авч үзлээ.

Дурьдсан хугацаанд бүртгэгдсэн зам тээврийн ослын тоон үзүүлэлтийг авч үзвэл зам тээврийн ослын түвшин тогтвортой буурч, тухайлбал: 2020 онд бүртгэгдсэн ослын тоог 2017 оны суурь түвшинтэй харьцуулбал, улсын хэмжээнд 14823 нэгжээр буюу 40.5 хувь, орон нутагт 664 нэгжээр буюу 16,8 хувиар тус тус буурсан байна. Үүнийг графикаар үзүүлбэл:

График №3



Орон нутгийн хувьд бүсчлэлээр авч 2017 оны суурь түвшинтэй харьцуулахад /хавсралт-2/үзвэл: Баруун бүсэд 133 нэгжээр буюу 21,6 хувиар, Төвийн бүсэд 206 нэгжээр буюу 17,6 хувиар, Хангайн бүсэд 1690 нэгжээр буюу 75,9 хувиар, Говийн бүсэд 4 нэгжээр буюу 0,8 хувиар тус тус буурчээ. Харин Зүүн бүсийн хувьд 49 нэгжээр буюу 5,8 хувь буурсан боловч 2020 оны түвшин өмнөх оныхоос өсөлттэй бүртгэгджээ.

График №4



Олон улсын хэмжээнд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг илэрхийлэх хамгийн чухал үзүүлэлт нь уг ослын улмаас нас барсан хүний тооны өөрчлөлт гэж үзэж байна.

Орон нутгийн автозамд 2020 онд бүртгэгдсэн зам тээврийн ослын тоо

2017 оны суурь түвшинтэй харьцуулж үзвэл:

График №5

Улсын хэмжээнд 2020 онд бүртгэгдсэн нийт зам тээврийн ослын 21768 буюу 85,0 хувь нь нийслэлд, орон нутагт 15,0 хувь нь бүртгэгдсэн бол, зам тээврийн ослын улмаас нас барсан хүний 25,8 хувь нь нийслэлд, 74,2 хувь нь орон нутагт амь насаа алдсан байна.

Зам тээврийн ослын бүтцийг үйлдэгдсэн хэлбэрийнх нь хувьд авч үзвэл:

Ослын хэлбэр	2017		2018		2019		2020	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Мөргөлдөх	32214	88.1	25176	85.4	20764	80.4	1454	44.7
Үл хөдлөх зүйл мөргөх	670	1.8	648	2.2	986	3.8	239	7.3
Онхолдох	850	2.3	805	2.7	1071	4.1	888	27,3
Мал амьтан дайрах	155	0.4	93	0.3	162	0.6	159	4,9
Зорчигч унагах	34	0.1	16	0.1	75	0.2	33	1,0

Зам тээврийн осол гарсан хэлбэрийн хувьд сүүлийн 4 жилийн өөрчлөлтийг харвал тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх осол жил дараалан буурсан ч нийт ослын дийлэнх олонхи хувийг эзэлсэн хэвээр байна.

Зам тээврийн осол нь олон нийтэд ил үйлдэгддэг, иргэдэд орчны аюулгүй байдалдаа санаа зовох мэдрэмж, эргэлзээ төрүүлж нийтийн амгалан тайван байдалд маш их сөрөг нөлөө үзүүлж байдаг нийгмийн үзэгдэл боловч осол гарахад нөлөөлдөг хүчин зүйл нь тодорхой, хүнээс шалтгаалах асуудал тул түүнээс урьдчилан сэргийлэх боломжтой гэж олон улсад үздэг.

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/ Х.Доржпалам нь зам тээврийн хэрэг, ослын шалтгааныг тээврийн хэрэгслийн жолооч замын хөдөлгөөний журам зөрчсөн үйлдэл, хөдөлгөөнд оролцогч бусад зорчигчдын буруутай үйлдэл, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалд сөрөг хүчин зүйлүүдийн нөлөөлөл /зам засварын ажлыг гэрэлтүүлэггүй буюу хаалтгүй

хийх г.м/, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зөрчих гэмт хэргийн хохирлыг ихэсгэхэд нөлөөлөх хүчин зүйлүүд /хохирогчид эмнэлгийн тусламж үзүүлээгүй буюу буруу эмчлэх г.м/, техникийн боловсронгуй бусаас аюулын эх сурвалжийг ихэсгэх /тахир гол хугарах, хүрдний таяг мултрах ..г.м/ зэрэг байдлуудын үр дүн[12] гэж ангилан үзжээ.

Харин магистр Т.Төгсмаа нь зам тээврийн гэмт хэргийн шалтгааныг обьектив, субьектив гэж 2 ангилж обьектив шалтгааныг авто замын тааламжгүй байдлаас болон техникийн гэмтлээс үүдэлтэй, субьектив шалтгааныг жолоочийн буруутай үйлдэл, явган болон тээврийн хэрэгсэлтэйгээр хөдөлгөөнд оролцогч бусад хүмүүсийн буруутай үйлдлээс[13] гэж ангилан авч үзсэн байна.

Орон нутгийн автозамд үйлдэгдэж буй зам тээврийн ослын шалтгааныг жолоочийн буруутай үйлдэл, техникийн гэмтэл, замын нөхцөл гэсэн 3 үндсэн хүчин зүйлсээс хамаарах байдлаар нь ангилан үзэж байна.

Сүүлийн 4 жилийн статистикийг харьцуулан үзвэл нийт бүртгэгдсэн ослын тоон үзүүлэлт буурсан боловч нийт осолд эзлэх хувийн жингийн хувьд өөрчлөлт бага буюу жолоочийн буруутай үйлдлээс шалтгаалах осол 97,5-97,9 хувь, замын нөхцлөөс шалтгаалах осол 0,2-0,1 байгаа нь зам тээврийн ослын шалтгаанд бодитой өөрчлөлт гараагүйг харуулж байна.

Хүснэгт №1

Он	2017	2018	2019	2020
Жолоочийн буруутай үйлдэл	35679	28794	24741	21196
	97,5	97,7	97,9	97,4
Замын нөхцөл	44	48	31	18
	0,1	0,2	0,1	0,2

Жолоочийн буруутай үйлдэлд замын хөдөлгөөний аюулгүй байдлын хууль, дүрэм, журам зөрчсөн, хөдөлгөөнд оролцох соёл, дадал эзэмшээгүй, сахилга хариуцлагагүй үйлдлүүд багтаж байгаагаас шалтгаалан амь насаа алдах, гэмтэл бэртэл авч хохирч байна. Тухайлбал: орон нутгийн автозамд үйлдэгдсэн ослын хувьд жолооч нар эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, зогсоох арга хэмжээ аваагүй, хурд хэтрүүлсэн, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зэрэг шалтгаан голлосон байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдал, шуурхай байх үндсэн нөхцлийн нэг нь зам, замын дэд бүтэц байдаг. Замын эвдрэл, гэмтэл нь Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад сөрөг нөлөө үзүүлж, зам тээврийн осол хэрэг гарах шалтгаан нөхцлийн нэг болдог байна.

[12] Х.Доржпалам. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэргтэй тэмцэх ЭЭЗ, криминологийн асуудал. УБ.2000. 84 тал.

[13] Т.Төгсмаа. “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн орчин үеийн шалтгаан, нөхцөл” сэдэвт магистрын зэрэг горилсон бүтээл. УБ.,2009. 38 дахь тал

Замын нөхцлөөс шалтгаалан гарсан осолд техникийн гэмтэл, замын гэрэл, зам орчны нөхцлийг багтаан авч үзэж байгаа ч авто зам, замын байгууламж хариуцсан байгууллагад ослын акт тавигдаж арга хэмжээ тооцсон байдал хангалтгүй, замын нөхцлөөс гарсан ослын үзүүлэлт бага хэвээр байна.

Өнөөг хүртэл замын эвдрэл гэмтэл, онгорхой нүх, овоолсон шороо, зузаан мөстсөн замын хэсэг, замын бусад хангалтгүй нөхцлийг тойрох гэсэн автомашины жолооч хөдөлгөөний чиглэлээ гэнэт өөрчлөх, тойрч эсрэг урсгалд орсноос гарсан ослын тохиолдлын бурууг жолоочид хүлээлгэх байдлаар хариуцлага тооцож байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас улс орнуудын замын хөдөлгөөний аюулгүй байдлын түвшинг тогтооход харгалзах гол үзүүлэлт нь 100,000 хүн амд ногдох нас баралтын түвшин байдаг. Монгол Улсын хувьд энэ үзүүлэлт нь 2020 оны байдлаар 13 байгаа нь өмнөх оны үеэс буурсан байна.

ДЭМБ-аас гаргасан “Дэлхийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын тайлан 2018”[14] дурдсанаар дэлхийн дундаж 18,2, манай улс бүсчлэлд нь хамаарч байгаа Ази-номхон далайн бүсийн дундаж 16,9 байна.

Дэлхийн улс орнууд зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг тогтооход системийн шинжилгээний аргуудыг өргөнөөр ашиглах болсон бөгөөд “Хүн-Зам /орчин/-Тээврийн хэрэгсэл” гэсэн гурван хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзахыг зөвлөж байна. Германы эрдэмтдийн судалж тогтоосноор зам тээврийн ослын нэг сөрөг хүчин зүйл болоод байгаа замын нөлөөлөл 31 хувь буюу түүнээс дээш, Оросын эрдэмтэн А.П.Матросов[15] зам тээврийн ослын шалтгаан нөхцлийг нарийвчлан тогтоох зорилгоор 1971 онд хийсэн судалгаагаар замын нөхцөл нь гарсан ослын 70 хувьд нь ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлсэн гэж үзсэн бол Шведийн судлаач Хелена Стигсон нар[16] энэ нөлөөллийг ойролцоогоор 63 хувь гэж дүгнэжээ. Тэд үзэхдээ зам тээврийн осол нь 100 хувь хүний хүчин зүйлээс хамаарахгүй.

Энэ нөлөөлөл нь хамгийн ихдээ 50 хүртэл хувь байх тул хүнтэй ажилласнаар ослыг мөн төдий хувиар бууруулах боломжтой. Асуудлын нөгөө тал нь замын болон техникийн хүчин зүйл бөгөөд замын стандарт нөхцлийг сайжруулж, тээврийн хэрэгслийн стандарт үзүүлэлтийг чанд баримтлах явдал мөн. Ингэж асуудлыг тогтолцооны түвшинд, хамаарах хүчин зүйлсийн уялдаа холбоог харгалзан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлснээр 2030 он гэхэд Тогтвортой хөгжлийн гуравдугаар зорилгын хүрээнд “Зам тээврийн ослын улмаас нас барсан, гэмтсэн хүний тоог хоёр дахин бууруулах” зорилтыг хангах боломжтой гэж үзжээ.

Манай орны хувьд статистик үзүүлэлтээр 0.1-0,2 хувь байгаа нь цаашид зам тээврийн осолд нөлөөлсөн хүчин зүйлийг бүрэн тогтоох чиглэлээр холбогдох мэргэжлийн алба хаагчдын

[14] https://www.who.int/publications-detail/global-status-report-on-road-safety-2018

[15] Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном 2018. Зам тээвэр, хөгжлийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам. УБ., 2019. 66-67 дахь тал.

[16] Helena Stigson, Maria Krafft & Claes Tingvall. Use of Fatal Real-Life Crashes to Analyze a Safe Road Transport System Model, Including the Road User, the Vehicle, and the Road. Traffic Injury Prevention, 9:5, 2008. page 463- 471, DOI: 10.1080/15389580802335240

мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх шаардлагатайг илэрхийлж байна. Судалгаанаас үзэхэд орон нутгийн замд бүртгэдсэн осолд жолооч, зорчигч амь насаа алдаж байгаа бол нийслэлд бүртгэгдсэн ослын улмаас явган зорчигчийн амь нас их хохирч байна.

Ослын ихэнх шалтгаан хүний буруутай ажиллагаанаас үүсч байна. Замын хөдөлгөөнд оролцогчдын дийлэнх нь ерөнхий болон аюулгүй байдлын дүрмүүдийг сайтар мэддэг ч анхаарал болгоомжгүй байдал, үл тоох хандлага нь осол үүсэх гол шалтгаан болдог байна.

Тээврийн цагдаагийн алба, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас хийсэн судалгаагаар өнгөрсөн жилүүдэд үйлдэгдсэн зам тээврийн ослын 84.9 хувь нь жолоочийн буруутай үйлдэл, 14.4 хувь нь явган зорчигчийн буруутай үйлдэл, 0.7 хувь нь замын нөхцөл байдлаас шалтгаалсан гэсэн судалгаа гарсан байна.

Ослууд нь хурд хэтрүүлэх, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, жолоочийн анхаарал сарних, гэрэл зөрчих, хамгаалалтын бүс, дуулга, хүүхдийн суудал гэх мэт аюулгүйн тоноглолоос зайлсхийх, гүйцэж түрүүлэх үйлдлийг буруу хийх, эгнээ байраа буруу эзлэх гэх мэт шалтгаанаас үүссэн байна.

Дүгнэлт. Олон улсын судалгааны байгууллагуудаас зам тээврийн ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө хохирч, эрсдэлд орж байгаа гол шалтгааны нэг нь “тээврийн хэрэгслийн хурд” хэтрүүлэлтээс болж байнаа гэж тогтоосон. Амьдралын өртөг өндөртэй орнуудад зам тээврийн ослоос шалтгаалсан үхэл 30 орчим хувийг эзэлж байхад бага буюу дунд түвшний орнуудад зам тээврийн ослын 50 орчим хувь нь хурд хэтрүүлснээс шалтгаалан үйлдэгдэж байна.[17] Хурд хэтрүүлэлт бол аминд тулсан ажил гарсан гэж шалтгалах төдий асуудал биш юм. Энэ бол хувь хүн, жолоочийн ухамсар, хариуцлага, хандлагын асуудал юм.

Жил ирэх тусам буурч буй сайн үзүүлэлт гарч байгаа нь жолоочдын хариуцлагатай байдалтай шууд холбоотой юм байна. Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулсан зам тээврийн осол эндэгдэлтэй холбоотой “Яараад яахав дээ” гэх мэт олон нийтийг уриалсан хөдөлгөөнүүд үр дүнгээ үзүүлсэн нь жолоочийн хариуцлагатай холбон үзэж болохоор байна.

Манай улсад замын эвдрэл гэмтэл, нүх, овоолсон шороо, мөстсөн хэсэг замын бусад хангалтгүй нөхцөлийг тойрч гарах гэсэн жолооч хөдөлгөөний гэнэт өөрчлөх, тойрч гарах эсрэг ургалд орох, зэрэг үйлдлийн буруу жолооч эсвэл бусад зорчигч нарт хариуцуулж байна. Энэ нь замын нөхцөлөөс болж бий болсон ослын тоог буруу гаргаж өгөх хариуцлагыг буруу хүлээлгэхэд хүргэж байгаа юм. Иймд замын засвар арчлалтыг хариуцсан байгуулага нь үйл ажиллагаагаа сайжруулах ёстой.

Санал. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах саналыг гаргаж байна. Үүнд:

Автомашины жолооч нарт жилд 1-ээс доошгүй удаа богино хугацаатай давтан сургалтад хамруулж, хурдаа тохируулж явах, хамгаалах бүс хэрэглэх, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, баталгаатай зам

[17] http://uridchilan-sergiileh.police.gov.mn

гүүрээр зорчих, бага насны хүүхэддээ тавих анхаарлаа нэмэгдүүлэх ач холбогдлын талаар хичээл үздэг болох;

Хөдөө, орон нутгийн замд замын хөдөлгөөнд оролцож байгаа тээврийн хэрэгслийн хурдны хязгаарт хяналт тавих хяналтын камерыг олноор байршуулж, бүсийн хяналтын дэд төвүүдийг байгуулах;

“Яараад яахав дээ” гэх мэт олон нийтийг уриалсан хөдөлгөөнүүдийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээгээр дамжуулан идэвхитэй өрнүүлэх;

Замын нөхцөл осол гарахад нөлөөлж байгааг анхаарч замыг шинээр барьж байгуулах, засварлахдаа технологийн шаардлагыг чанга мөрдөж иж бүрнээр шийдвэрлэж байх эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Ашигласан материал

1. Х.Доржпалам. Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих гэмт хэрэгтэй тэмцэх ЭЭЗ, криминологийн асуудал. УБ.2000.
2. Т.Төгсмаа. “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн орчин үеийн шалтгаан, нөхцөл” сэдэвт магистрын зэрэг горилсон бүтээл. УБ.,2009.
3. Зам тээврийн ослын өнөөгийн байдал. Уб. 2018.
4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын цагаан ном-2018. УБ., 2019.
5. Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлт 2020. Тээврийн цагдаагийн алба, УБ. 2021

Цахим эх сурвалж:

6. https://digitallibrary.un.org
7. http://mrtd.gov.mn
8. https://www.who.int/
9. http://uridchilan-sergiileh.police.gov.mn
10. https://www.trends.mn
11. publications-detail/global-status-report-on-road-safety-2018

Сэтгүүл:

12. Төрийн мэдээлэл. 1992. №1.
13. Төрийн мэдээлэл. 2017. №8.
14. Төрийн мэдээлэл. 2015. №28.

Гадаад эх сурвалж

15. Libĕna Tetrevova, Vadyba Management.
16. Helena Stigson, Maria Krafft & Claes Tingvall. Use of Fatal Real-Life Crashes to Analyze a Safe Road Transport System Model, Including the Road User, the Vehicle, and the Road. Traffic Injury Prevention, 9:5, 2008.

“НЭГ БҮС, НЭГ ЗАМ” САНААЧИЛГЫН ХЭРЭГЖИЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б.Эрдэнэчимэг
БХЭШХ-ийн төвийн дарга, доктор, профессор, хурандаа
Д.Гантуяа.
ДХИС-ийн АШБС-ийн ЭЗАБ-ын магистрант, хошууч

Abstract: China`s current leader came up with the idea of implementing a project, a modern version of the ancient Silk Road, whose specific function is to link countries of the world by the different types of infrastructure. Emerging as a feature of China`s so-called peaceful development, the Belt and Road Initiative (BRI) is a manifestation of its aspiration for connecting itself to the countries of the great Afro-Eurasian landmass by railroads, highways, shipping routes and communication networks. Xi Jinping first proposed a plan for building land infrastructure connectivity, named “Silk Road Economic Belt,” and sea routes, named the “21st Century Maritime Silk Road” in 2013. This project, later named the Belt and Road Initiative, today includes more than 100 countries. This study examines the fulfilment of the BRI and the impact of the Covid-19 situation on its implementation.

Key words: the Belt and road, China, the covid impact, infrastructure projects, investment, cooperation.

Түлхүүр үг: Бүс ба зам, Хятад, Ковид-19-ын нөлөө, дэд бүтцийн төслүүд, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа.

БНХАУ-ын “Нэг бүс, нэг зам” санаачилга нь Торгоны замын эдийн засгийн бүс, 21 дүгээр зууны далайн торгоны замын бүсэд хамаарах хөгжлийн стратеги бөгөөд уг санаачилгад багтсан улсуудын эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, аливаа нөөц баялгийг чөлөөтэй нэвтрүүлэх зорилготой юм.

Хятадын одоогийн удирдагч Си Зинпин эртний торгоны замын орчин үеийн хувилбар болох төслийг хэрэгжүүлэх санааг дэвшүүлж, дэлхийн улс орнуудыг янз бүрийн дэд бүтцээр холбох зорилготой Хятадын энх тайвны хөгжлийн нэгэн онцлог болж гарч ирсэн "Бүс ба Зам" санаачилга нь Афро-Евразийн агуу хуурай газрын улс орнуудтай төмөр зам, хурдны зам, тээврийн зам, харилцаа холбоогоор өөрийн улсаа холбох хүсэл эрмэлзлийн нэг илрэл юм. Си Зинпин анх 2013 онд "Торгоны замын эдийн засгийн бүс" нэртэй хуурай газрын дэд бүтцийн холболт, далайн замыг "21 дүгээр зууны далайн торгоны зам" гэж нэрлэсэн төлөвлөгөөг санал болгосон. Хожим нь "Бүс ба Зам санаачилга" гэж нэрлэгдсэн энэхүү төсөл өнөөдөр 100 гаруй улсыг багтааж байна. Энэхүү судалгаа нь “Нэг бүс ба нэг зам” санаачилгын биелэлт, Ковид-19 нөхцөл байдлын хэрэгжилтэд үзүүлэх нөлөөллийг судалсан болно.

Өнөөдрийн нөхцөл байдалд “Нэг бүс нэг зам”-ын бүтээн байгуулалт нь олон чухал боломжуудтай бий болгож байна. “Нэг бүс нэг зам”-ын олон улс дахь нөлөө ба хамтын ажиллагааг өөртөө татах хүч нь тасралтгүй эрчимжсээр байна. Талуудын хөгжлийн стратеги, хөгжлийн төлөвлөгөөний уялдаа холбоо өдөр ирэх тусам нягтарч байна. Дэд бүтцээр харилцан холбогдох, үйлдвэрлэлийн хөрөнгө оруулалт зэрэг салбарын хөгжлийн хэрэгцээ шаардлага нь олон улсын

хамтын ажиллагааны өргөн боломжийг бий болгож байгаа юм. БНХАУ нь өөрчлөлт нээлттэй бодлогыг тууштай хэрэгжүүлэх бөгөөд эдийн засгийн хөгжлийн ирээдүйтэй, гадаад улс орнуудтай хөгжүүлэх хамтын ажиллагаа ч гэсэн асар их орон зайтай гэдэгт эргэлзэхгүй байна. “Нэг бүс нэг зам” нь улам хөгжих тусмаа улам өндөр чанартай байж бүх улс орнуудын эдийн засгийн хөгжилд илүү өргөн боломжийг олгоно гэдэгт итгэлтэй байна.

“Нэг бүс, Нэг зам” санаачилгын тухай

БНХАУ-ын дарга Си Зинпин “2013 оны 9 дүгээр сард Төв Азийн орнуудад айлчлах үеэрээ “Торгоны замын эдийн засгийн бүс” байгуулах, мөн оны 10 дугаар сард Зүүн өмнөд Азийн орнуудад айлчлах үеэрээ “XXI зууны далайн торгоны зам” байгуулах санаачилгыг тус тус дэвшүүлсэн байдаг.

Зураг.1 Нэг бүс, нэг зам санаачилгад нэгдсэн улс орон



Эх сурвалж: Shanghai, Green Finance & Development Center, 2022

Эдүгээ Ази, Европ, Африкийн эх газар болон тэдгээрийн эргэн тойрны далай тэнгисийг дэд бүтцээр харилцан холбох зорилготой тус санаачилгад дэлхийн 145 орон хамрагдаж, БНХАУ-тай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, хамтран ажиллаж байна.[1]

Тус санаачилгын хүрээнд 41 нефть, байгалийн хий дамжуулах хоолой, 201 зам, гүүр, төмөр зам, 199 эрчим хүчний байгууламж (цөмийн, байгалийн хийн, нүүрсний, сэргээгдэх эрчим хүчний) байгуулахаар төлөвлөж буй аж.[2]

“Нэг бүс, Нэг зам” санаачилгын хүрээнд 2013 оноос хойш БНХАУ

1“ Nedopil, Christoph (2022): “Countries of the Belt and Road Initiative”; Shanghai, Green Finance & Development Center, FISF Fudan University, www.greenfdc.org

2 The world, built by China https://www.nytimes.com/interactive/2018/11/18/world/asia/world-built-by-china.html

дараах 5 чиглэлээр дэлхийн улс орнуудтай хамтын ажиллагаа өрнүүлж байна. Үүнд:

1. Бодлогын зохицуулалт: Улс орнуудын засгийн газар хоорондын хамтын ажиллагаа, засгийн газруудын түвшний макро бодлогын уялдаа, харилцааны механизмыг сайжруулах;

2. Дэд бүтцийн холболт: Дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлт, техникийн стандартчилалын тогтолцоог харилцан уялдуулах;

3. Саадгүй худалдаа: Хөрөнгө оруулалт, худалдааны саадыг бууруулах, бүс нутгийн эдийн засгийн интеграцийг дэмжих;

4. Санхүүгийн интеграци: Санхүү, мөнгөний бодлогыг уялдуулах чиглэлээр хамтран ажиллах;

5. Хүмүүс хоорондын харилцаа: Соёл боловсролын солилцоо, хэвлэл мэдээлэлийн хамтын ажиллагаа зэрэг болно.

“Нэг бүс, Нэг зам”-ын дагуух улс орнууд эдийн засгийн хөгжлийн стратеги болон бодлогоо уялдуулах, бүс нутгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх төлөвлөгөө, арга хэмжээг хамтарч боловсруулах, хамтын ажиллагааны явцад үүсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх, бодит хамтын ажиллагаа болон томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх байдлаар бэхжүүлнэ гэж томьёолж байна. Уг санаачилгад оролцож буй улс орнууд дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлт, техникийн стандартын системийн уялдаагаа бэхжүүлж, олон улсын тээврийн гол магистраль шугамыг байгуулахад түлхэц үзүүлж, Ази тивийг бүхэлд нь, Ази, Европ, Африкийг холбосон дэд бүтцийн сүлжээг үе шаттайгаар байгуулахаар төлөвлөж байна.

Зам тээврийн дэд бүтцийг бүтээн байгуулах тухайд “гол гарц, уулзвар, томоохон төслүүдэд анхаарал хандуулж, холбогдоогүй байгаа замын хэсгүүдийг холбох, түгжрэл үүсгэж буй хэсгүүдийг сайжруулахад тэргүүлэх ач холбогдол өгөхийн зэрэгцээ замын аюулгүй байдлыг хангах болон замын удирдлагын байгууламж, тоног төхөөрөмжийг сайжруулж, замын сүлжээний түвшинг дээшлүүлнэ гэж тодорхойлж буй. Олон улсын тээврийг хөнгөвчлөх үүднээс бүх замын турш дахь тээврийн зохицуулалтын нэгдсэн механизмыг байгуулж, олон улсын гаалийн бүртгэл, сэлгэн ачилт, холимог тээврийн холбоосыг бэхжүүлж, зохистой, нэг стандартын тээврийн дүрэм журмыг аажмаар бий болгох ажээ. Боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтыг урагшлуулж, эх газар-далайн холимог тээврийн саадгүй гарцыг барьж, далайн боомтын хамтын ажиллагааг бэхжүүлж, далайн тээврийн маршрут, аяллын тоог нэмэгдүүлж, далайн тээврийн мэдээлэлжүүлэлтийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхийг зорьж байна.

Үүний зэрэгцээ иргэний агаарын тээврийн бүх талын хамтын ажиллагааг өргөжүүлж, агаарын тээврийн дэд бүтцийн түвшинг дээшлүүлэх аж. Түүнчлэн эрчим хүчний дэд бүтцээр харилцан холбогдох хамтын ажиллагааг бэхжүүлж, газрын тос болон байгалийн хий дамжуулах хоолой зэрэг тээврийн замын аюулгүй байдлыг хамтран хамгаалж, хил дамнасан цахилгаан эрчим хүч болон цахилгаан дамжуулах шугамын бүтээн байгуулалтыг урагшлуулж, бүс нутгийн цахилгаан сүлжээг шинэчлэх хамтын ажиллагааг идэвхтэй явуулах юм. Хил

дамнасан шилэн кабель зэрэг харилцаа холбооны үндсэн сүлжээг байгуулах бүтээн байгуулалтыг хамтран урагшлуулж, олон улсын харилцаа холбоог сайжруулж, мэдээллийн "Торгоны зам"-ыг байгуулахыг зорьж байна.

Си Зинпин "Нэг бүс, Нэг зам" санаачилгыг анх дэвшүүлэхэд "бүс" буюу эх газар "зам" буюу" далай тэнгисийг төмөр зам, авто зам, усан замаар холбоно хэмээн тайлбарласан бол өдгөө цахим ертөнц, цахилгаан сүлжээ, улмаар Умард туйлаас эхлээд огторгуйн уудамд хүртэл өргөжин тэлж байна. Хятадын "Сансрын торгоны зам", "туйлын торгоны зам", "дижитал торгоны зам" зэрэг олон нийтийн анхаарлыг татсан нэр томъёо итгэхэд бэрх сонсогдох ч хэдийнээ ажил хэрэг болоод байна. "Нэг бүс, Нэг зам"-ын сансрын мэдээллийн коридор байгуулахаар төлөвлөж Зүүн Өмнөд Азийн орнуудыг Хятадын 200 гаруй хиймэл дагуулын тусламжтайгаар харилцан мэдээлэл солилцох механизмд нэгдэхийг уриалж улмаар ирээдүйд АСЕАН-ийн орнуудын худалдааны сансрын хөлгүүд "Сансрын торгоны зам"-аар нислэг үйлдэх боломжтой болно гэв.[3] Мөн Зүүн Өмнөд Азид "Дижитал торгоны зам"-ын дэд бүтцийн бүтээн байгуулалт эрчимтэй хөгжиж Хуавэй компани шумбагч кабелийн систем буюу усан доогуурх хэдэн арван кабелийн систем барьж, улмаар 5G сүлжээг нэвтрүүлээд байна[4].

БНХАУ 2018 оны 1 дүгээр сард "Умард туйлын талаар баримтлах бодлого"-ыг танилцуулж, "Туйлын торгоны зам" байгуулахыг зорьж буйгаа мэдэгдэв [5]. Дэлхийн дулаарлын нөлөөгөөр туйлын мөс хайлж буй явдал Умард туйл ирээдүйн худалдааны гол усан замын нэг болох боломжийг бий болгож байна.

"Нэг бүс, нэг зам" санаачилгын хүрээнд 6 эдийн засгийн коридор байгуулахаар төлөвлөсөн байдаг. Үүнд:

1. "Евразийн газрын шинэ гүүр" эдийн засгийн коридор
2. Хятад-Монгол-Оросын эдийн засгийн коридор
3. Хятад-Төв Ази-Баруун Африкийн эдийн засгийн коридор
4. Хятад-Энэтхэг Хятадын хойгийн эдийн засгийн коридор
5. Хятад-Пакистаны эдийн засгийн коридор
6. Бангладеш-Хятад-Энэтхэг-Мьянмар эдийн засгийн коридор

"Евразийн газрын шинэ гүүр" эдийн засгийн коридор"

"Евразийн газрын шинэ гүүр" эдийн засгийн коридор бол Хятадын Жиансу мужийн Лианюнганаас Шинжианы Алшаа аймгаар дамжиж Голландын Роттердамд хүрэх төмөр замын сүлжээ юм. Энэхүү шинэ гүүр Евразийн төмөр замын сүлжээ Хятадын нутагт Дорноос Өрнө чиглэлд Ланжоу-Лианюнган төмөр зам болон Ланжоу-Шинжиан төмөр замаар явсаар Хятадын нутгаас гарч Казакстан, Орос, Беларус, Польшийн нутгаар өртөөлөн Европын хэд хэд эргийн боомтод хүрч

[3] Belt and Road Space information corridor, China daily, 23,09,2018 http://www.chinadaily.com.cn/a/201809/13/WS5b99b2c5a31033b4f4655bde.html

[4] China`s digital silk road and Southeast Asia, February 15, 2019 https://www.csis.org/analysis/chinas-digital-silk-road-and-southeast-asia

[5]China's Arctic PolicyThe State Council Information Office of the People's Republic of China, January 2018 https://eng.yidaiyilu.gov.cn/zchj/qwfb/46076.htm

очно. “Евразийн газрын шинэ гүүр” төслийг санхүүжүүлснээр БНХАУ Чонкиноос ХБНГУ-ын Дюссбург хүртэлх орон зайд олон улсын ачаа тээврийн замыг нээсэн бөгөөд Үханаас Болгарын Мелник, Чехийн Пардубис хүртэл ачаа тээврийн шууд галт, Чендугаас Польшийн Лоз, Германы Хамбург хүрэх төмөр замыг тавьсан.

Зураг 2. Эдийн засгийн коридор



Эх сурвалж: HKTDC research

Хятад-Монгол-Оросын эдийн засгийн корридор

Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын Дээд хэмжээний уулзалтын үеэр 2014 онд Душанбед гурван улсын тэргүүнүүд анх удаа уулзаж, Хятад-Орос, Монгол-Хятад, Монгол-Орос гэсэн хоёр талт хэлэлцээр дээр үндэслэж, Монгол-Орос-Хятадын гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх хэлэлцээрт гарын үсэг зурсан. Уг уулзалтын гурван талт хамтын ажиллагааны зарчим, чиглэл, хамтран ажиллах салбарыг тодорхойлсон болно. Хэлэлцээрээр гурван улсын төрийн тэргүүнүүд Хятадын “Торгоны зам” эдийн засгийн бүслүүр, Оросын “Евразийн газрын гүүр”, Монголын “талын зам” хөтөлбөрүүдийг харилцан уялдуулахаар тохиролцсон юм. Гурван улсын Төрийн тэргүүнүүд 2015 оны 7 дугаар сард Оросын Уфа хотод хоёр дахь удаагаа уулзаж, “Орос-Монгол-Хятадын гурван талт хамтын ажиллагааны дунд хугацааны замын зураглал”-ыг албан ёсоор баталгаажуулсан байна. “Монгол-Хятад-Оросын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-т 2016 оны 6 дугаар сард гарын үсэг зурсан явдал “Нэг бүс, Нэг зам”-ын хүрээнд байгуулсан анхны олон талт хамтын ажиллагааны хөтөлбөр болсон байна. “Хөгжлийн зам” хөтөлбөр болон “Нэг бүс, нэг зам” санаачилгыг уялдуулах тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийг

2017 оны 05 дугаар сарын 11-ний өдөр байгуулжээ.

Хятад –Төв Ази-Баруун-Азийн эдийн засгийн коридор

Хятад–Төв-Ази-Баруун-Азийн эдийн засгийн коридор Шинжианаас Алшаагийн нутгаар дамжиж Төв болон Баруун Азийн төмөр замын сүлжээнд нийлж, цааш Газар дундын тэнгисийн эрэг, Арабын хойгт хүрдэг. Уг корридор Казакстан, Кыргызстан, Тажикстан, Узбекстан, Туркменстан зэрэг Төв Азийн 5 орон мөн Баруун Азийн Иран, Турк улсыг тус тус хамардаг.

Хятад-Энэтхэг Хятад хойгийн эдийн засгийн корридор

Банкогк хотноо 2014 оны 12 дугаар сард зохион байгуулсан Их Меконг мөрний дэд бүсийн эдийн засгийн хамтын ажиллагааны уулзалтын үеэр Хятадын ерөнхий сайд Ли Кечиан Хятад улс болон Энэтхэг Хятадын Хойгийн улс орнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх 3 саналыг дэвшүүлсэн. Үүнд:

- Тээврийн сүлжээг өргөжүүлэх ажлыг хамтран төлөвлөж, барих,
- Хандив тусламжийн чиглэлээр хамтрах шинэ хэлбэрийг бий болгох,
- Нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих санал багтдаг.

Өдгөө Меконг мөрний дагуух орнуудыг холбосон хил дамнасан 9 хурдны зам барих ажил явж байна. Дээр дурьдсан чиглэлийн хүрээнд нэлээд олон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр хэрэгжээд байна. Тухайлбал, Гуанши муж "Нөхөрлөлийн хаалга", Хятад Вьетнамын хил дээрх Доншин хүрэх авто замыг барьж ашиглалтад өгсөн. Мөн Наннинаас Ханой хүрэх олон улсын төмөр замын сүлжээ мөн Зүүн Өмнөд Азийн хэд хэдэн орнуудад хүрэх агаарын замыг нээжээ.

Хятад –Пакистаны эдийн засгийн корридор

Хятадын Ерөнхий сайд Ли Кечиан 2013 оны 5 дугаар сард Пакистанд айлчлах үеэрээ анх Хятад–Пакистаны эдийн засгийн корридорыг байгуулах санал дэвшүүлсэн. Өдгөө хоёр орны засгийн газар авто зам, төмөр зам, газрын тос, байгалийн хийн хоолой болон Шинжианы Кашгараас Пакистаны Гвадар хүрсэн шилэн кабелийн сүлжээ зэргийг байгуулах урт хугацааны төлөвлөгөөг боловсруулж ажилласан. Улмаар 2015 оны Дөрөвдүгээр сард Исламбадад хоёр тал тунхаглал гаргаж энэхүү 2 дугаар шатанд Каракорумын авто замыг шинэчлэх, Гвадор боомтын баруун тохой дахь авто зам, шинэ олон улсын нисэх онгоцны буудал, Карачигаас Лахор хүрэх хурдны зам, Лахорын метро, Хайер-Руба эдийн засгийн бүс, Хятад-Пакистаны шилэн кабелийн сүлжээ байгуулах төслийн ажлыг урагшлуулах чиглэлээр идэвхтэй хамтран ажиллахаа мэдэгдсэн юм.

Бангладеш-Хятад-Энэтхэг-Мьянмарын эдийн засгийн корридор

Хятадын Ерөнхий сайд Ли Кечиан 2013 оны тавдугаар сард Энэтхэгт айлчлах үеэрээ хоёр тал Бангладеш-Хятад-Энэтхэг-Мьянмарын эдийн засгийн корридор байгуулах санал дэвшүүлсэн юм. Ингээд 2013 оны 12 дугаар сард Бангладеш-Хятад-Энэтхэг-Мьянмарын эдийн засгийн корридор байгуулах ажлын хэсэг анхны уулзалтаа хийж хамтын ажиллагааны механизм, тэргүүлэх чиглэлүүдийг хэлэлцэж тодорхойлсон байна. Тус уулзалтаар 4 орны төлөөлөгчид тохиролцон зам тээврийн дэд бүтэц, хөрөнгө оруулалт, худалдааны эргэлт болон иргэд хоорондын харилцаа

харилцааг сайжруулах чиглэлээр хамтран ажиллахаар болсон.

“Нэг бүс, нэг зам” санаачилгын хэрэгжилт, өнөөгийн байдал

“Нэг бүс, Нэг зам” санаачилгын хүрээнд БНХАУ 2021 онд 59.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны гэрээнд зарцуулсан ба үүнээс 13,9 тэрбумын ам.долларын хөрөнгө оруулалт хийж, 45,6 тэрбумын ам.долларын хамтын ажиллагааны гэрээ байгуулжээ. Ковид-19-ийн өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад Хятадын “Нэг бүс, Нэг зам” дахь санхүүжилт 53 тэрбум ам.долларраар (48 хувь орчим) буурчээ.[6]



Эх сурвалж: Эх сурвалж: GFDC 2022

Ковид-19 цар тахлын нөхцөл байдал үүссэнээр “Нэг бүс,Нэг зам”-ын хөрөнгө оруулалт 2013 онд тус санаачилга эхэлснээс хойш анх удаа хамгийн доод түвшинд хүртлээ буурсан байна.

“Нэг бүс, Нэг зам”-ын санаачилга дахь улс орнуудын оролцоог бүс нутгаар харьцуулж үзэхэд 2021 оны байдлаар Азийн улс орнууд хөрөнгө оруулалтын хамгийн их буюу 35 орчим хувийг эзлэж байна.[7] Африк, Ойрхи Дорнодын орнуудын оролцоо хамгийн эрчимтэй нэмэгдсэн буюу 2020 онд 8 хувь байсан бол 2021 онд 38 хувьд хүрч болж өсчээ. Европын орнууд дахь “Нэг бүс, Нэг зам”-ын хөрөнгө оруулалт 2020 оны эхний зургаан сартай харьцуулахад 84 хувиаар буурчээ.

[6] Nedopil, Christoph (2022): “Countries of the Belt and Road Initiative”; Shanghai, Green Finance & Development Center, FISF Fudan University, www.greenfdc.org , 5.

[7] Мөн тэнд

График. 2. Нэг бүс, нэг зам санаачилгад оролцогчид бүс нутгаар



Эх сурвалж: GFDC 2022

Дэд бүтцийн бүтээн байгуулалтад хамгийн их санхүүжилт хийгдэж буй улс орнуудад Иракт 10,5 тэрбум ам.доллар Сербид 6,8 тэрбум ам.доллар, Сингапурт 2,4 тэрбум ам.доллар тус тус багтжээ. [8] "Нэг бүс, Нэг зам"-ын санаачилгын хүрээнд гол тоглогчдоор Хятадын төрийн өмчит болон Бояа Капитал, Алибаба, Жинко Солах зэрэг хувийн өмчит компаниуд багтаж байна. Харин Фовер Чайна, Чайна коммуникэйшн констракшн, Синопек зэрэг компани дэд бүтэцийн бүтээн байгуулалтад голлон оролцож буй. Хилийн чанад дахь дэд бүтэцийн бүтээн байгуулалтад Хятадын төрийн өмчит компаниуд тэргүүлэх үүрэгтэй оролцож байна.

Хүснэгт 1.

"Нэг бүс, Нэг зам"-ын гол хөрөнгө оруулагч Хятадын компани. 2021 он

Хөрөнгө оруулагч компани	Нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь
Zijing mining	17,2%
Boyu Capital, Hillhouse Capital	16%
China National Off-shore Oil (CNOOC)	12.2%
Tsingshan Holding	11,7%
China Three Gorges	11,2%
China Railway Construction	9,9%
Alibaba	9,4%
China Communications Construction	6,2%
Jinko solar	6,2%

Эх сурвалж: Green Finance & Development Center, FISF Fudan University, 2022.

Дэд бүтцийн бүтээн байгуулалтын хэрэгжилт

Төмөр зам

"Нэг бүс, Нэг зам" санаачилгын хүрээнд 2021 оны байдлаар Зүүн Азид төмөр зам байгуулах ажил эрчимтэй өрнөж, Хятадаас Тайланд, Малайзаар дамжаад Сингапур хүрэх Кунмин-Сингапурын төмөр замын ажлыг үргэлжлүүлж байна. Мөн 2021 оны эцсээр Хятад-Лаосын төмөр замыг ашиглалтад өгсөн байна. Уг төмөр зам Хятадын зүүн өмнөд Юнань мужийн Кунмин хотоос Лаосын нутгаар 422

[8] Nedopil, Christoph (2022): "Countries of the Belt and Road Initiative"; Shanghai, Green Finance & Development Center, FISF Fudan University, www.greenfdc.org,10.

километрийг туулж, нийслэл Вьентьян хүрэх нийт 1035 км үргэлжилдэг.[9] Энэхүү төмөр замыг барих ажил 6 тэрбум гаруй ам.долларын өртөгтэй ба түүний 70 хувийг Хятадын санхүүгийн байгууллагуудаас зээл олгож байна.

Зураг 3. Хятад-Лаосын төмөр зам

Эх сурвалж: "Хятад-Лаосын төмөр зам," Шинхуа 2021

Хятад улс мөн Индонезийн Жакарта, Бандунгийг холбосон 6 тэрбум гаруй ам.долларын өртөгтэй 142 км өндөр хурдны төмөр зам барьж байна.[10]

Африк тивд "Нэг бүс, Нэг зам" санаачилгын хүрээнд хэд хэдэн төмөр замын бүтээн байгуулалтын ажил өрнөж буй. Танзани улсад 1,32 тэрбум ам.долларын төсөл болох Викторианууурын боомтын Мванза хотыг Дар эс Салаам боомттой холбох 341 км төмөр барихаар болжээ.[11]

"Нэг бүс, Нэг зам" санаачилгын Европ дахь хамгийн анхны дэд бүтэцийн бүтээн байгуулалт болох Будапешт-Сербийн нийслэл хотыг холбосон 350 км төмөр замын ажил 2021 онд эхэлжээ.[12]

Хүснэгт 2.

2021 онд "Нэг бүс, Нэг зам"-ын дэд бүтэцийн бүтээн байгуулалтад хөрөнгө оруулж буй Хятадын томоохон компани

Хөрөнгө оруулагч компани	Нийт хөрөнгө оруулалтад эзлэх хувь
Power Construction Corp. (Power China)	23,8%
China Communications Construction	16,5%
China Petroleum and Chemical (SINOPEC)	9.2%
China International Trust and Investment	9.0%
China Railway Construction	8,6%
China State Construction Engineering	7,3%
China Energy Engineering	6,1%

9"China-Laos Railway opens, putting Laos on track from landlocked to land-linked," http://www.news.cn/english/2021-12/04/c_1310350562.htm

10 "Jakarta-Bandung high-speed railway 64% complete," https://www.globalconstructionreview.com /jakarta-bandung -high-speed-railway-64-complete/

11 "Two Chinese firms to build $1.32 billion Tanzanian rail line," https://www.reuters.com/article /uk-tanzania-railway-idUSKBN29C20X

12 "Construction begins on Budapest to Belgrade railway," https://newseu.cgtn.com/news/2021-10-15/Construction-begins-on-Budapest-to-Belgrade-railway-14nTeKukkCY/index.html

China Railway Engineering	4,3%
Sinosteel	2,6%
Shandong Gaosu, China Communications Construction	2,6%
China Energy Engineering, China Minmetals	2,2%
China Petroleum Corp. (CNPC)	2,2%
China National Machinery Industry (SINOMACH)	2,1%
China Minmetals	1,9%
China National Building Material	1,4%

Эх сурвалж: Green Finance & Development Center, FISF Fudan University, 2022.

Боомтууд

Ази, Африк, Европ тивийн улс орнуудыг далай тэнгисээр холбох "Далайн торгоны зам" төсөл хэрэгжиж эхэлснээр геостратегийн ач холбогдол бүхий суваг, хоолой зэрэг газар, тэдгээрийн ойролцоох боомтуудад бүтээн байгуулалт өрнүүлж, дэд бүтцийг хөгжүүлж байна. Сүүлийн жилүүдэд Хятадын төрийн өмчит болон төрийн хувь эзэмшдэг компаниуд Ази, Африк, Ойрхи Дорнод, Европт стратегийн чухал ач холбогдол бүхий далай, тэнгисийн боомтуудыг урт хугацаагаар түрээслэж, боомтын дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд идэвхийлэн оролцож эхэлжээ. Тухайлбал, Чайна Мерчант Порт компани Шри-Ланкын Коломбо, Хамбантотогийн боомтууд, Улаан тэнгисийн орц, гарц дээрх Жибутигийн боомтууд, Нигерийн Лагостине зэргийг оролцуулаад "Нэг бүс, Нэг зам"-ын дагуу дэлхийн 19 оронд 49 боомт эзэмшиж 2 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн бол КОСКО шиппинг групп Абу Дабигийн боомт, Бельгийн Антверп, Зийбружегийн боомтууд, Роттердамын боомт, Испанийн Валенсиагийн боомт зэргийг оролцуулаад "Нэг үс, Нэг зам"-ын дагуух 11 боомт, нийт 20 боомтод хөрөнгө оруулалт хийжээ.[13] Шанхай-Хонг Конг Групп Израилын Хайфагийн шинэ боомтын терминалыг 2021 оноос эхэлж 25 жил ажиллуулах эрхийг 2015 онд тендерт ялж авав.[14]

Хүснэгт 3.

2013 оноос хойш Өмнөд Хятадын тэнгис, Энэтхэгийн далайд Хятадын эзэмшиж буй боомт

Он	Бүс нутаг	Улс	Боомт	Түрээслүүлсэн хугацаа
2015	Энэтхэгийн далай	Пакистан	Гвадар	40
2015	Энэтхэгийн далай	Мьянмар	Кяукпю	50
2015	Өмнөд Хятадын тэнгис	Малайз	Куантан	60
2016	Энэтхэгийн далай	Жибути	Обок	10
2016	Өмнөд Хятадын тэнгис	Малайз	Мелака гарц	99
2017	Энэтхэгийн далай	Шри-ланка	Хамбантота	99
2017	Өмнөд Хятадын тэнгис	Бруней	Муара	60
2017	Энэтхэгийн далай	Малдив	Фэйдхо Финолху	50

Эх сурвалж: Стоколмын Олон улсын Энх тайвны судалгааны хүрээлэн, 2019

[13] 以港口为战略支点书写 21 世纪海上丝绸之路建设新篇章
https://www.sohu.com/a/242651424_784079

[14] мөн тэнд

“Нэг бүс, Нэг зам” санаачилгын хүрээнд 2021 онд хилийн чанадын боомтуудад нийт 3.1 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ. Тухайлбал, Саудын Арабын Жедда, Тайландын боомтод хөрөнгө оруулалт хийж, Бүгд Найрамдах Ардчилсан Конг улсын Калеми боомтыг шинэчлэн засварлав.[15] Хорват дахь хамгийн том Риека боомтыг Хятадын 3 том компанийн консерциумд хүлээлгэн өгөхөөр болсон ч 2021 оны эхээр цуцлагдав.[16]

Бусад

Өнгөрсөн онд Тайланд, Серби, Кени зэрэг хэд хэдэн оронд авто замын бүтээн байгуулалт явжээ. Мөн Агаарын тээвэртэй холбогдолтой хэд хэдэн дэд бүтцийн ажил хийгдсэнээс хамгийн онцлох нь Иракийн Нассарияа Олон улсын нисэх буудал юм.[17]

“Нэг бүс, нэг зам” санаачилгын хэрэгжилтэнд Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын үзүүлсэн нөлөө

2020 оны эхэн үеэр 3.9 их наяд ам.долларын өртөгтэй “Нэг бүс, нэг зам” санаачилгын 2,951 төсөл хэрэгжихээр төлөвлөж байсан боловч цар тахлын улмаас хөл хорио тогтож, хил гааль онцгой дэглэмд шилжсэний улмаас дэд бүтцийн бүтээн байгуулалтын явц зогсоход хүрчээ.[18]

Хятадын Гадаад хэргийн сайд 2020 оны 6 дугаар сард Ковид-19 цар тахал бүс замын төслүүдийн 20 хувьд “ноцтой нөлөөлсөн”, 40 хувьд “сөргөөр нөлөөлсөн” ба 30-40 хувьд “ямар нэг байдлаар нөлөөлсөн” гэжээ.[19] Хил хаагдсны улмаас Хятад ажилчид, барилгын материал урсгал зогссоноор Пакистан, Камбожи, Индонез болон бусад улс дахь дэд бүтцийн төслүүд удааширч, түр зогсов. Хятадын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны хэвлэлийн төлөөлөгч, төслийн хяналт хариуцсан мэргэжилтэн Мэн Вэй 2020 оны 1 дүгээр сард “Нэг бүс, нэг зам” санаачилгыг цаашид үргэлжлүүлэх хэрэгтэй байгааг онцолж улмаар ирээдүйн шинэ алсын хараа бүхий “Ногоон торгоны зам”, “Эрүүл мэндийн торгоны зам,” “Дижитал торгоны зам” гэх 3 талбарыг чухалчилсан төлөвлөгөөг зурагласан байна.[20]

Ногоон торгоны зам

Цар тахлын улмаас олон улсын эдийн засаг тогвортой байдлыг чухалчлах болсон. “Нэг бүс, нэг зам” санаачилга илүү тогтвортой хөгжлийн төслүүдэд анхаарал хандуулж буй. Хятад улс 2020 оны 9 дүгээр сард 2060 он гэхэд хүлэмжийн хийн ялгаралуултгүй орон болохыг зорьж буйгаа зарласан.[21] Бээжингийн төв их сургуулийн Олон улсын Ногоон Санхүүгийн Институтиэс гаргасан судалгаагаар 2020 оны Хятадын эрчим хүчний дэд бүтцийн хөрөнгө

[15] Nedopil, Christoph (January 2022): “China Belt and Road Initiative (BRI) Investment Report 2021”, Green Finance & Development Center, FISF Fudan University, Shanghai, 16.

16 “Rijeka Port Chinese Investment Stopped Owing to EU, US Pressure,” https://www.total-croatia-news.com/business/49331-rijeka-port-chinese-investment

17 “China to Rehabilitate the Nassiriyah International Airport,” https://www.iraq-businessnews.com /2021/06/09/china-to-rehabilitate-the-nassiriyah-international-airport/

18 Has Covid-19 prompted the Belt and Road Initiative to go green? https://oxfordbusinessgroup.com/news/has-covid-19-prompted-belt-and-road-initiative-go-green

[19] “The Belt and Road Initiative 2021 Survey – The impact of Covid-19 on the BRI,” https://www.centralbanking.com /central-banks/economics/7835241 /the-belt-and-road-initiative-2021-survey-the-impact-of-covid-19-on-the-bri

[20] As Covid-19 prompted the Belt and Road Initiative to go green? https://oxfordbusinessgroup.com /news/has-covid-19-prompted-belt-and-road-initiative -go-green

[21] Мөн тэнд

оруулалтын 57 хувийг сэргээгдэх эрчим хүч бүрдүүлж байгаа бөгөөд 2019 оныхоос 38 хувиар өссөн гэжээ.[22] Цэвэр ногоон эрчим хүчинд анхаарал хандуулах болсон явдал "Нэг бүс, нэг зам"-ын ирээдүйг тодорхойлж байна. Цар тахал эхэлснээс хойш тус санаачилгын эрчим хүчний хөрөнгө оруулалтын ихэнх хувийг сэргээгдэх эрчим хүч эзэлж байна. Дэлхийн улс орнууд тогтвортой хөгжил, ногоон эрчим хүчийг эрэлхийлсэн улс орнууд "Нэг бүс, нэг зам"-д нэгдэж буй.

Эрүүл мэндийн торгоны зам

Ковид-19 цар тахал гарч үүнтэй зэрэгцэн их гүрнүүдийн өрсөлдөөн ширүүсч, "Нэг бүс, Нэг зам" санаачилга саатаж, коронавируст халдварыг эрт шийдвэрлэж чадаагүйн улмаас олон улсад Хятадын нэр хүнд хүнд унах зэргээр олон сорилттой тулгарч буй энэ үед Бээжингийн зүгээс "Эрүүл мэндийн дипломат ажиллагаа"-аар дамжуулж Хятадын талаар эерэг имиж бүрдүүлэхийг зорьжээ. Цар тахлын үеэр "Эрүүл мэндийн торгоны зам"-ыг "Дижитал торгоны зам"-тай хоршуулж, олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны "гол тавцан" гэж нэрлэх "Нэг бүс, Нэг зам" гурав дахь шинэ үеийг эхлүүлжээ.[23] Ковид-19 цар тахлын улмаас дэлхийн улс орнуудад, тэр дундаа хөгжиж буй орнуудад эрүүл мэндийн дэд бүтцээ сайжруулах зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэн юм. Эрүүл мэндийн торгоны замаар дамжуулж Хятад улс хилийн чанад дахь эрүүл мэндийн тусламжийн системээ шинэчлэх, бүс нутгийн болон глобал эрүүл мэндийн засаглалд нөлөөгөө ихэсгэх, "Нэг бүс, нэг зам"-ын хөрөнгө оруулалтыг нийтийн эрүүл мэндэд чиглүүлэх, эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлчилгээ,эмнэлгийн бараа материалын хангалтад Хятадын оролцоог нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллаж байна .[24]

Дижитал торгоны зам

Ковид-19 цар тахлын улмаас дэлхий ертөнц виртуал орчин руу түрэн орж Хятад улсын "Нэг бүс, Нэг зам" санаачилга дижитал технологийн инновацруу анхаарал хандуулах болов.

Зураг 4. Дижитал торгоны зам



Эх сурвалж: MERICS 2019

[22] Мөн тэнд

[23] State Council white paper on "China's International Development Cooperation in the New Era," see China Daily, January 11, 2021, https://global.chinadaily.com.cn/a/202101/11/WS5ffb954aa31024ad0baa19e3.html.

[24] Ngeow Chow-Bing "COVID-19, Belt and Road Initiative and the Health Silk Road: Implications for Southeast Asia," http://library.fes.de/pdf-files/bueros/indonesien/16537.pdf

Дижитал торгоны замыг “Нэг бүс, Нэг зам” санаачилгын хүрээнд 2015 онд анх эхлүүлсэн ба төслийн эхэн үед дижитал дэд бүтэц, сансрын технологийн үйлдвэрлэлтэй холбоотой төслүүдийг голчлон хэрэгжүүлж, цахим худалдаа, хяналт ажиглалтын систем, “ухаалаг хот”, дижитал төлбөр тооцоо зэрэг хэлбэрээр төрөлжиж буй. Хятад улс “Үндэсний Мэдээлэлжилтийн стратеги 2016-2020” баримт бичигт технологийн голлох компаниудыг (Алибаба, Тенсент, Байду г.м) дижитал торгоны замыг дэмжин ажиллаж, цахим худалдааны ертөнцөд манлайлан оролцохыг уриалсан байдаг.[25]

Дүгнэлт

Ази, Европ, Африкийн эх газар болон эргэн тойрны далай тэнгисийг дэд бүтцээр харилцан холбох зорилготой “Нэг бүс, Нэг зам” санаачилгад дэлхийн 140 гаруй орон хамрагдаж буй. Си Зинпин “Нэг бүс, Нэг зам”-ыг анх санаачилахдаа “бүс” буюу эх газар “зам” буюу” далай тэнгисийг төмөр зам, авто зам, усан замаар холбохоор төлөвлөж байсан бол өдгөө туйлын торгоны зам, сансрын торгоны зам зэргээр орон зай, хэлбэр агуулгын хувьд өргөжин тэлж байна. “Нэг бүс, Нэг зам” санаачилга дахь улс орнуудын оролцоог бүс нутгаар нь харьцуулж үзэхэд Азийн улс орнууд хөрөнгө оруулалтаараа тэргүүлж буй бол Африк, Ойрхи Дорнодын орнуудын оролцоо хамгийн эрчимтэй нэмэгдсэн буюу 2020 оныхоос 30 хувиар нэмэгджээ. Европын орнууд дахь “Нэг бүс, Нэг зам”-ын хөрөнгө оруулалт нилээдгүй буурчээ.

Дэлхий дахинд Ковид-19 цар тахлын халдвар тархаж 2013 оноос эхэлж тогтвортой өсөлттэй явагдсан “Нэг бүс, нэг зам”-ын хөрөнгө оруулалт, дэд бүтцийн бүтээн байгуулалтад олон бэрхшээл тулгарав. Цар тахлын улмаас 2020 оны эхэн үеэр “Нэг бүс, нэг зам” санаачилгын 2,000 гаруй төлөвлөгдсөн төсөл хойшлогдож, хөл хорио тогтоож, хил гааль хаагдсаны улмаас дэд бүтцийн бүтээн байгуулалтын явц зогсоход хүрсэн. Цар тахлын үеэр тус санаачилагын хэрэгжилтийн тасралтгүй байдлыг хангахын тулд Хөгжил Шинэтгэлийн Хорооноос “Нэг бүс, нэг зам”-ын замын зураглалыг шинэчилэв. Улмаар тогтвортой хөгжлийг дэмжсэн “Ногоон торгоны зам”, цар тахлын үеийн эрүүл мэндийн салбарын дэд бүтцийн хөрөнгө оруулалт, гадаад дахь эрүүл мэндийн тусламжийн ажиллагаагаар дамжуулан харилцан итгэлцэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх “Эрүүл мэндийн торгоны зам”, ковид-19-ын нөлөөгөөр цахимжиж буй нөхцөлд дижитал худалдаа, харилцаа холбоог дэмжих “Дижитал торгоны зам” зэргээр хямралын үеийн стратеги амжилттай хэрэгжүүлж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. “Nedopil, Christoph (2022): “Countries of the Belt and Road Initiative”; Shanghai, Green Finance & Development Center, FISF Fudan University, www.greenfdc.org

2. The world, built by China https://www.nytimes.com/interactive/2018/11/18/world/asia/world-built-by-china.html

3. Belt and Road Space information corridor, China daily,

[25] As Covid-19 prompted the Belt and Road Initiative to go green? https://oxfordbusinessgroup.com/news/has-covid-19-prompted-belt-and-road-initiative-go-green

23,09,2018 http://www.chinadaily.com.cn/a/201809/13/WS5b99b2c5a31033b4f4655bde.html

4. China`s digital silk road and Southeast Asia, February 15, 2019 https://www.csis.org/analysis/chinas-digital-silk-road-and-southeast-asia

5. China's Arctic PolicyThe State Council Information Office of the People's Republic of China, January 2018 https://eng.yidaiyilu.gov.cn/zchj/qwfb/46076.htm

6. http://www.sdpc.gov.cn/xwzx/xwfb/201609/t20160913_818347.html

7. https://www.yidaiyilu.gov.cn/xwzx/gnxw/43662.htm

8. "China-Laos Railway opens, putting Laos on track from landlocked to land-linked," http://www.news.cn/english/2021-12/04/c_1310350562.htm

9. 1 "Jakarta-Bandung high-speed railway 64% complete," https://www.globalconstructionreview.com/jakarta-bandung-high-speed-railway-64-complete/

10."Two Chinese firms to build ам.доллар1.32 billion Tanzanian rail line," https://www.reuters.com/article/uk-tanzania-railway-idUSKBN29C20X

11."Construction begins on Budapest to Belgrade railway," https://newseu.cgtn.com/news/2021-10-15/Construction-begins-on-Budapest-to-Belgrade-railway-14nTeKukkCY/index.html

12.以港口为战略支点书写 21 世纪海上丝绸之路建设新篇章 https://www.sohu.com/a/242651424_784079

13."Rijeka Port Chinese Investment Stopped Owing to EU, US Pressure," https://www.total-croatia-news.com/business/49331-rijeka-port-chinese-investment

14."China to Rehabilitate the Nassiriyah International Airport," https://www.iraq-businessnews.com/2021/06/09/china-to-rehabilitate-the-nassiriyah-international-airport/

15.Has Covid-19 prompted the Belt and Road Initiative to go green? https://oxfordbusinessgroup.com/news/has-covid-19-prompted-belt-and-road-initiative-go-green

16."The Belt and Road Initiative 2021 Survey – The impact of Covid-19 on the BRI," https://www.centralbanking.com/central-banks/economics/7835241/the-belt-and-road-initiative-2021-survey-the-impact-of-covid-19-on-the-bri

17.As Covid-19 prompted the Belt and Road Initiative to go green? https://oxfordbusinessgroup.com/news/has-covid-19-prompted-belt-and-road-initiative-go-green

18.State Council white paper on "China's International Development Cooperation in the New Era," see China Daily, January 11, 2021, https://global.chinadaily.com.cn/a/202101/11/WS5ffb954aa31024ad0baa19e3.html.

19.Ngeow Chow-Bing "COVID-19, Belt and Road Initiative and the Health Silk Road:Implications for Southeast Asia," http://library.fes.de/pdf-files/bueros/indonesien/16537.pdf

ХҮНИЙГ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ШАЛТГААН НӨХЦӨЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ

CONDITIONS AND PREVENTION OF THE CRIME OF MURDER

З.Амартүвшин
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Z.Amartuvshin
Master of the University of Internal Affairs

Хураангуй: Хүнийг алах гэмт хэрэг нь ганц удаа заяасан алтан амийг нь бусниулдаг бөгөөд эл хохирлыг ямар нэг байдлаар сэргээх, нөхөн барагдуулах боломж байдаггүй учир хамгийн хүнд гэмт хэрэг болдог бөгөөд бусдыг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг алсан бол бүх насаар нь хорих ялыг хэрэглэх боломжтой. Энэхүү өгүүлэлд хүний алах гэмт хэргийн тухай ойлголт, түүхэн уламжлал, шалтгаан нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээг санал болгосон.

Abstract: The crime of murder is the most serious crime because it destroys a once-in-a-lifetime life, and there is no possibility of repairing or compensating for it in any way. This article suggests measures to improve the understanding of the crime of murder, historical traditions, causes, ways to prevent it, and the legal environment.

Түлхүүр үгс: Хүний амь нас, эрүүл мэнд, гэмт хэрэг, шалтгаан нөхцөл.
Keywords: Human life, health, crime and causes.

Хүнийг алах гэмт хэргийн ойлголт, шинж

Хүн алах: /murder, killing/ нь бие хүний эсрэг үйлдэгддэг хамгийн хүнд гэмт хэрэг- хүний амь насыг санаатайгаар хагацуулах үйлдэл мөн. [1]

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт “ хүн амьд явах эрхтэй” гэж заасан бөгөөд[2] Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3-р зүйлд “ Хүн бүр амьд явах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй [3] гэж заасан байдаг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 8 дугаар зүйлд “Амьдрах эрх бол хүний салшгүй эрх” мөн. Энэ эрхийг хуулиар хамгаалж хэний ч амийг дур мэдэн бүрэлгэж болохгүй юм. Монгол Улсын Үндсэн хуулийн 19-р зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлж, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх” талаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үүднээс хүний амьд явах эрхийг Эрүүгийн хуулиараа хамгаалсан юм.

Хүнийг алах гэмт хэрэг нь ганц удаа заяасан алтан амийг нь бусниулдаг бөгөөд эл хохирлыг ямар нэг байдлаар сэргээх, нөхөн барагдуулах боломж байдаггүй учир хамгийн хүнд гэмт хэрэг болдог бөгөөд бусдыг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг алсан бол бүх насаар нь хорих ялыг хэрэглэх боломжтой. Хэл зүйн хувьд **Алах гэдэг үгийг** авч үзвэл хүний санаатай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон байхыг ойлгоно.[4]

[1] Ж. Хурцгэрэл “Криминалистик-2”УБ.,2004он.,309 дах тал
[2] Монгол Улсын Үндсэн хууль. УБ хот., 1992 он. 16.13-р зүйл
[3] Хүний эрхийн түгээмэл тунхаглал. 1946 он. 5-р зүйл
[4] Б.Батцэрэн, Э.Амарбат. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулага /сургагч багш нарт

Хүнийг алах гэмт хэргийн шинж:

Обьект: Иргэдийн амь насны аюулгүй байдлыг хангаж байгаа хүний амьд явах эрх байна. Эрүүгийн эрх зүйн хамгаалалтад хүний нас, бие махбодийн болон ёс суртахууны шинж чанараас үл шалтгаалан түүний төрсөн цагаас үхэх хүртэл ямар ч хүний амьдрах, амьд явах эрх хамаарна. Хүний амьдрал нь бие махбодийн хувьд төрсөнөөс эхэлсэнд тооцогдох учраас төрөх үйл явц эхлэхээс өмнө үр хөврөл устгах нь хүнийг алах гэмт хэргийн шинж болохгүй.[5]

Обьектив тал: Үйлдэл, эс үйлдэхүй хийх замаар бусад хүний амь насыг бусниулсан байна. Бусдын амь нас хохирсон үеэс гэмт хэрэг төгсдөг материаллаг бүрэлдэхүүнтэй. [6]

Хүнийг алах нь гол төлөв **идэвхтэй үйлдлээр хэрэгждэг бөгөөд** алахдаа гар, хөлөөрөө зодох болон элдэв багаж, зэвсэг хэрэглэж буудах, хутгалах, цохих, хор өгөх, өндөр юман дээрээс түлхэж нисгэх, автын осолд оруулах зэрэг маш олон аргуудыг хэрэглэдэг. **Эс үйлдэхүйгээр хүнийг алах нь** гол төлөв субьект хохирогчийг асран хамгаалах, амь насыг аврах үүргийг хүлээсэн хэр нь хохирогчийн үхлийг хүсэж, тэр хүслээ гүйцэлдүүлэхийн тулд түүнийг асарч тэтгэхгүй байх, амь насанд аюултай байдалд орхих, тийм байдалд зориуд оруулах замаар үхэлд хүргэх байдлаар илэрдэг байна.

Хүнийг алах гэмт хэргийн бүрэлдэхүүний обьектив талд хамаарах **шалтгаант холбоо нь шууд ба шууд бус** гэсэн хоёр төрөлтэй байна. Эрдэмтэд хүнийг алах гэмт хэргийн шалтгаант холбоо нь ихэвчлэн шууд байдаг гэж үздэг.[7]Тухайлбал: хохирогчийн хоолойг хэрчсэн, зүрх, тархинд буудаж алсан тохиолдолд эдгээр үйлдэл нь хохирогч амиа алдах шууд шалтгаан болно. Хүнийг алах шууд бус шалтгаант холбоонд хүн осгох бүрэн магадлалтай хүйтэн байхад хүнийг ухаан алдтал нь зодож орхисон, тусламж үзүүлэхгүй орхисон гэх мэт үйлдлүүдээр тайлбарлаж болох юм.

Субьектив тал: Гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгднэ. Хүнийг алах гэмт хэргийн субьектив тал нь шууд ба шууд бус санаатай хэлбэрээр үйлдэгднэ. Гадаад орнуудын эрүүгийн эрх зүйд энэ төрлийн гэмт хэрэг нь шууд болон шууд бус санаагаар үйлдэгддэг. Герман улсын эрүүгийн хуулийн 15-р зүйлд **шууд санаа гэдэг нь** гэмт үйлийн субьект тодорхой бодолтой байсан бол шууд санаа гэж үзнэ. Өөрөөр хэлбэл түүний хүсэл зориг тодорхой зорилгод чиглэгдсэн байвал түүнийг шууд санаагаар үйлдэгдсэнд тооцно. [8] Харин шууд бус санаа нь гэмт хэргийн субьект хууль зөрчих боломжийг төсөөлөн, зарим тохиолдолд учирч болох үр дагаврыг хүсээгүй хэрнээ зөвшөөрдөг хэлбэрийг хэлдэг. Харин **Монгол Улсын хуульч эрдэмтэд** шууд болон шууд бус санааг дараах байдлаар тодорхойлсон. **Шууд санаа нь** гэмт хэрэг үйлдэж байгаа этгээд хохирогч алах боломжтойг буюу зайлшгүйг урьдчилан мэдэж байгаа хэр нь энэ хор уршгийг хүсэж бий болгодогыг хэлнэ. Харин **шууд бус санаа нь** субьект

зориулсан гарын авлага/. УБ хот., 2017 он. 99 дэхь тал

[5] Мөн номны 250 дахь тал

[6] С.Жанжан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. УБ хот., 2012 он. 240 дэхь тал

[7] В.Н. Кудрявцев. Общая теория квалификация преступлений. 1999. С.146

[8] Gropp W. Notwehr gegen Unterlassen. Goltdammers Archiv fuer Strafreht. 1991. S.300

хүний амь насанд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг хийж байгаагаа ухамсарлан ойлгож, хохирогчийн амь хохирч болох боломжийг урьдчилан мэдсэн, тэр хор уршгийг хүсээгүй боловч зориуд бий болгосон байхыг хэлнэ.

Субьект: Хэрэг хариуцах чадвартай 14 насанд хүрсэн Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн байна.

Хүнийг алах гэмт хэрэг нь ганц удаа заяасан алтан амийг нь бусниулдаг бөгөөд эл хохирлыг ямар нэг байдлаар сэргээх, нөхөн барагдуулах боломж байдаггүй учир хамгийн хүнд гэмт хэрэг болдог бөгөөд бусдыг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг алсан бол бүх насаар нь хорих ялыг хэрэглэх боломжтой. Хэл зүйн хувьд **Алах гэдэг үгийг** авч үзвэл хүний санаатай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний амь нас, эрүүл мэнд хохирсон[9] байхыг ойлгоно.

1.2.Хүнийг алах гэмт хэргийн өнөөгийн байдал

Хүснэгт:1



Хүнийг алах гэмт хэрэг нь 2015 онд 204, 2016 онд 174, 2017 онд 189, 2018 онд 192, 2019 онд 197 гэмт хэрэг бүртгэгдсэн байна[10]. Үүнээс үзвэл хүнийг алах гэмт хэрэг нь хамгийн их үйлдэгдэж байсан он 2015 онд 204 хэрэг үйлдэгдэж байсан бөгөөд энэ нь 2019 онтой харьцуулахад 7 хэргээр их байгаа юм. Мөн хүнийг алах гэмт хэрэг 2016 оноос хойш жил бүр өсөх хандлагатай харагдаж байна.

Хүнийг алах гэмт хэрэг үйлдэж байгаа хүний насны ангиллын хувьд авч үзвэл 2015 онд 18-24 насны 20.7%, 2016 онд 25-29 насны 26.6%, 2017 онд 30-34 насны 25.6% , 2018 онд 25-29 насны 20.5%, 2019 онд 25-29 насны 24.6%, насны хүмүүс энэ төрлийн гэмт хэргийг хамгийн их үйлдсэн байна. Үүнээс үзвэл "Хүнийг алах" гэмт хэргийг 18-34 насны залуучууд их үйлдсэн.

Хүнийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн цагийн хувьд авч үзвэл 2015 онд 22-06 цагт 56.3%, 2016 онд 22-06 цагт 48.3%, 2017 онд 22-06 цагт 44.8%, 2018 онд 22-06 цагт 49.5%, 2019 онд 22-06 цагт 44.2%, тус тус хамгийн их үйлдэгдсэн байна. Үүнээс үзвэл хүнийг алах гэмт хэрэг нь 22-06 цагт хамгийн ихээр үйлдэгддэг болох нь харагдаж

[9] Б.Батцэрэн, Э.Амарбат. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулага /сургагч багш нарт зориулсан гарын авлага/. УБ хот., 2017 он. 99 дэхь тал

[10] http://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NSO_2300_036V2&CR005_select_all=0&CR005SingleSelect=_1211&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2019_2018_2017_2016_2015&viewtype=linechart

байна. Тиймээс энэ цагуудад эргүүл, хяналтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай.

Хүнийг алах гэмт хэрэг үйлдэж буй хүмүүсийн нийгмийн байдлын хувьд авч үзвэл 2017 онд ажилгүй 54.3%, 2018 онд ажилгүй-53.4, 2019 онд ажилгүй 51.5- ажилгүй хүмүүс хамгийн их үйлдэгдсэн байна. Үүнээс үзвэл хүнийг алах гэмт хэргийг эрхэлсэн тодорхой ажилгүй хүмүүс ихээр үйлдэгддэг болох нь ажиглагдсан.

Хүнийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн аргын хувьд авч үзвэл 2015 онд согтуугаар 58.0%, 2016 онд согтуугаар 69.5%, 2017 онд согтуугаар 53.6%, 2018 онд согтуугаар 66.4%, 2019 онд согтуугаар 70.4% нь тус тус гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгдсэн. Үүнээс үзвэл хүнийг алах гэмт хэрэг үйлдэж буй хүн нь дийлэнх тохиолдолд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ энэ төрлийн гэмт хэргийг үйлддэг болохыг харуулж байна.

Хүнийг алах гэмт хэрэг үйлдэгдсэн газрын хувьд 2015 онд гэр орон сууцанд 59.9%, 2016 онд 59.7%, 2017 онд гэр орон сууцанд 66.6%, 2018 онд гэр орон сууцанд 67.0%, 2019 онд 116 хэрэг нь гэр орон сууцанд хамгийн ихээр үйлдэгдсэн[11].

Энэ бүгдээс авч үзвэл хүнийг алах гэмт хэргийг 18-34 насны хүмүүс хамгийн ихээр үйлддэг. Мөн гэмт хэрэг үйлдэж буй цаг нь 22-06, нийгмийн байдлын хувьд эрхэлсэн тодорхой ажилгүй, гэмт хэрэг үйлдэх үедээ согтуугаар үйлддэг, газрын хувьд ихэнх тохиолдолд ахуйн шинжтэй гэр орон сууцанд, боловсролын хувьд суурь болон бүрэн дунд боловсролтой хүмүүс энэ төрлийн гэмт хэрэг үйлддэг болохыг судалгааны үр дүнгээс дүгнэж байна.

Хүнийг алах гэмт хэргийн шалтгаан нөхцөл:

1.Гэр бүлийн буруу хүмүүжил: Энэ нь байнгын хэрүүл маргаан, бие биедээ үл итгэлцэн, үл ойлголцох байдал, үзэл бодлын зөрчилдөөн, аль нэгэн гишүүний буюу гэр бүлээрээ байнга архидан согтуурдаг байдал, хүүхэдтэйгээ хатуу ширүүн харьцаж, байнга зодож тарчлаах, гэм буруутай үйлдэлдээ шүүмжлэлтэй хандах, өөртөө үнэлэлт дүгнэлт өгөх чадваргүй болж, орчны муу нөлөөнд автан, хэрцгий догшин ааш авир суудаг байна.

2.Гэмт этгээдийн нийгэмд харш зан төлөвийн илрэл болох түргэн уур, омголон зан, бардамнал, атаархал, хардалт, өсөрхөх зан байдлаас болж

3. Аж байдлаас үүдэлтэй зөрчил маргаан, хохирогч гэмт этгээд хоёрын хувийн ашиг сонирхол зөрчилдөхөөс хэрүүл маргаан хурцдан, удтал үргэлжилсэн.

4. Хүнийг алах гэмт хэргийн хамгийн идэвхтэй нөлөө үзүүлдэг хүчин зүйл бол шунахайрах явдал юм. Ажил хөдөлмөр эрхлэхгүйгээр амар хялбар аргаар эд хөрөнгө, мөнгө, үнэт зүйлсийг олж авах, баяжих гэсэн хүсэл эрмэлзлэл.

5.Гэмт этгээдийн нийгэмд харш зан төлөвийг сэдрээдэг зүйл бол архи согтууруулах ундааг хэтрүүлэн хэрэглэх.

[11]Монгол Улс дахь 2015 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ. 2016 он

-Монгол Улс дахь 2016 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ. 2017 он.

-2015-2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт 2020 он.

-Монгол Улс дахь 2017 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ. 2018 он

-Монгол Улс дахь 2018 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ. 2019 он

Хүнийг алах гэмт хэргийн урьдчилан сэргийлэх арга зам

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил гэдэг нь гэмт хэргийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг гарч байгаа шалтгаан нөхцөлийг тогтоох, арилгах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээ мөн” [12] гэж тодорхойлсон байна. Энэ ажил нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, олон нийтийн хүчинд түшиглэх, иргэд оршин суугаа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд энэ талаар зохион байгуулж байгаа ажилд оролцох, аж ахуйн нэгж, байгууллага дотооддоо болон үйл ажиллагааныхаа хүрээнд гэмт хэрэг гарах шалтгаан нөхцөлийг арилгах ажлыг хариуцан зохион байгуулах зарчимд тулгуурлана. Хүнийг алах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил дор дурдсан төрөлтэй байна.

1. Ерөнхий арга хэмжээ
2. Тусгай арга хэмжээ
3. Нэг бүрчилсэн арга хэмжээ

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн эдийн засаг, улс төр, эрх зүй, ёс суртахуун, хүмүүжлийн болон зохион байгуулалтын шинж чанартай нийтлэг арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ерөнхий арга хэмжээ гэнэ.

Тодорхой төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгахад чиглэсэн арга хэмжээг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тусгай арга хэмжээ гэнэ.

Тодорхой этгээд гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор түүний зан үйл, ёс суртахуунд нөлөөлөх, түүнээс гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн цогц арга хэмжээг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээ гэнэ.[13] Хүнийг алах гэмт хэргээс нэг бүрчлэн урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.Гэр бүлийн хүрээнд гарч байгаа тааламжгүй нөлөөллийг арилгах, багасгах, зөөлрүүлэх. Ингэснээр гэмт хэрэг үйлдэж болзошгүй хүмүүсийн нийгэмд харш үзэл бодол, дадал заншил даамжирхаас сэргийлнэ.

2. Хүнийг алах гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэж, завдаж байгаа, заналхийлж байгаа мэдээлэл авмагц түүнийг таслан зогсоох, хойшлуулшгүй яаралтай арга хэмжээ авах

3. Хорих байгууллагаас суллагдсан, ялангуяа энэ төрлийн болон хүч хэрэглэсэн сэдэлттэй гэмт хэрэгт ял шийтгүүлээд суллагдсан хүмүүст хяналт тавьж, үр нөлөөтэй ажил зохиох гэх мэт зүйлсийг хийж чадвал гэмт хэргээс урьдчилан сэргийлж чадна.

Дүгнэлт

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэргүүд дотроос хүнийг алах, гэмт хэрэг нь нийгэм болон хувь хүнд учруулж буй хор уршигаараа ихээхэн аюултай хэрэгт тооцогддог байна. Хүний амь насыг санаатай буюу болгоомжгүйгээр хохироохыг хүнийг алах гэмт хэрэг гэдэг. Хүнийг алах гэмт хэргийг Их засаг хуулиас өнөөг хүртэл эрүүгийн хууль тогтоомжоороо

[12] Л.Билгээ “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн ажлын арга зүй”, УБ., 2005 он. 23 дах тал.

[13] Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль. УБ. 2019 он., 9 дүгээр зүйл

хуульчилж ирсэн. Тухайлбал Их засаг хуулийн 35-р зүйлд: Хүнийг алсаныг алмой эсхүл торгож болмой гэж заасан бөгөөд энэ нь анхны эрх зүйн зохицуулалт болсон юм.

Хүнийг алах гэмт хэрэг нь ганц удаа заяасан алтан амийг нь бусниулдаг бөгөөд эл хохирлыг ямар нэг байдлаар сэргээх, нөхөн барагдуулах боломж байдаггүй учир хамгийн хүнд гэмт хэрэг болдог бөгөөд бусдыг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хүнийг алсан бол бүх насаар нь хорих ял шийтгэхээр хуульчилсан байна.

Хүнийг алах гэмт хэрэг гарч байгаа нийтлэг шалтгаан нөхцөл нь гэр бүлийн буруу хүмүүжил байдаг бөгөөд энэ нь байнгын хэрүүл маргаан, бие биедээ үл итгэлцэн, үл ойлголцох байдал, үзэл бодлын зөрчилдөөн, аль нэгэн гишүүний буюу гэр бүлээрээ байнга архидан согтуурдаг байдал, хүүхэдтэйгээ хатуу ширүүн харьцаж, байнга зодож тарчлаах, гэм буруутай үйлдэлдээ шүүмжлэлтэй хандах, өөртөө үнэлэлт дүгнэлт өгөх чадваргүй болж, орчны муу нөлөөнд автан, хэрцгий догшин ааш авир суудаг байна. Мөн гэмт этгээдийн нийгэмд харш зан төлөвийн илрэл болох түргэн уур, омголон зан, бардамнал, атаархал, хардалт, өсөрхөх зан байдлаас болдог бас аж байдлаас үүдэлтэй зөрчил маргаан, хохирогч гэмт этгээд хоёрын хувийн ашиг сонирхол зөрчилдөхөөс хэрүүл маргаан хурцдан, удтал үргэлжилсэн зэрэг шалтгаанаас үүдэн энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх шалтгаан болж байна.

Монгол Улсад хүнийг алах гэмт хэрэгтэй тэмцэхдээ гадаад орны тэргүүн туршлагаас судалж өөрийн орондоо нэвтрүүлэх шаардлагатай байна. Тухайлбал АНУ-д хэрэглэгддэг Criminal profiling аргачлал нь сэжигтэн, хохирогч, гэрч зэргээр тухайн гэмт хэрэгт холбогдол бүхий хүмүүс болон хэргийн газраас олдсон, эд мөрийн баримтаар хураагдсан, нууц үзлэгээр илэрсэн гэх мэт баримт мэдээллийг нэгтгэж дүн шинжилгээ хийхэд чиглэдэг байна. Тиймээс энэхүү аргачлалыг манай улсын цагдаагийн мөрдөн шалгах ажиллагааны практикт нэвтрүүлснээр хүнийг алах гэмт хэрэг үйлдэж буй этгээдийн үйлдлийн арга, бусад мэдээллээр илрүүлэх ажилд ахиц дэвшил гарна гэж үзэж байна.

Хүнийг алах гэмт хэргийг 18-34 насны хүмүүс хамгийн ихээр үйлддэг. Мөн гэмт хэрэг үйлдэж буй цаг нь 22-06, нийгмийн байдлын хувьд эрхэлсэн тодорхой ажилгүй, гэмт хэрэг үйлдэх үедээ согтуугаар үйлддэг, газрын хувьд ихэнх тохиолдолд ахуйн шинжтэй гэр орон сууцанд, боловсролын хувьд суурь болон бүрэн дунд боловсролтой хүмүүс энэ төрлийн гэмт хэрэг үйлддэг болохыг судалгааны үр дүнгээс дүгнэж байна.

Улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 1.1 хувийг эзэлж байгаа хүнийг алах гэмт хэргийг ажилгүй, 18-34 насны иргэд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ үйлдэж байгаад анхаарал хандуулж энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж болзошгүй нийгмийн бүлэгт чиглүүлсэн ажлыг эрчимжүүлэх шаардлагатай. Өнөөгийн байдлаар хүнийг алах дийлэнх гэмт хэрэг ахуйн хүрээнд үйлдэгдсэн байгаа нь түүний илрүүлэлтэд эерэг нөлөөлсөн байна. Гэвч цаашдаа энэ төрлийн гэмт хэргийн үйлдлийн арга, хэлбэр зохион байгуулалтын шинжтэй болох тусам цагдаагийн байгууллагаас илүү эрчимтэй үйл ажиллагаа явуулахгүй бол илрүүлэлт буурч болзошгүй байна.

Энэ бүгдээс авч үзвэл хүнийг алах гэмт хэргийг 18-34 насны хүмүүс хамгийн ихээр үйлддэг. Мөн гэмт хэрэг үйлдэж буй цаг нь 22-06, нийгмийн байдлын хувьд эрхэлсэн тодорхой ажилгүй, гэмт хэрэг үйлдэх үедээ согтуугаар үйлддэг, газрын хувьд ихэнх тохиолдолд ахуйн шинжтэй гэр орон сууцанд, боловсролын хувьд суурь болон бүрэн дунд боловсролтой хүмүүс энэ төрлийн гэмт хэрэг үйлддэг болохыг судалгааны үр дүнгээс дүгнэж байна.

Дэвшүүлсэн санал

1. Цагдаагийн Ерөнхий газраас сэжигтэн, хохирогч, гэрч зэрэг тухайн гэмт хэрэгт холбогдол бүхий хүмүүс болон хэргийн газраас олдсон, эд мөрийн баримтаар хураагдсан, нууц үзлэгээр илэрсэн гэх мэт баримт мэдээллийг нэгтгэж дүн шинжилгээ хийхэд чиглэгдсэн аргачлалыг шинээр нэвтрүүлэх. Учир нь Цагдаагийн Албаны тухай хуулийн 14-р зүйл “Цагдаагийн төв байгууллагын үүрэг”-ийн 14.2.2 дахь хэсэгт “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах аргачлал, бодлого боловсруулж хэрэгжүүлэх”... үүрэгтэй хэмээн заасан байдаг. Тиймээс энэхүү үүрэг ээ хэрэгжүүлж нэгдсэн аргачлалтай болох шаардлагатай байна. Гэрч, хохирогчийн мэдүүлэг, үзлэгийн тэмдэглэл, дүрс, дууны бичлэг зэрэг гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад цугларсан эд мөрийн баримт мэдээлэлд дүн шинжилгээ хийснээр тухайн хэргийг үйлдсэн хүний талаарх төсөөллийг бий болгож, энэ талаарх мэдээллийг алба хаагчид харилцан солилцох зарчмаар явагддаг. Сэжигтний талаарх тодорхойлолтонд дараах зүйлсийг тусгах

- Сэтгэл зүйн байдал, нас, хүйс,
- Зан байдал, оршин суугаа газар орны болон гэмт хэргийг үйлдэхдээ урьдчилан бэлтгэсэн эсэх зэрэг нөхцөл байдлуудыг тусгах хэрэгтэй.

2. Гэмт хэргийг индекс болон индекс бус гэмт хэрэг гэж 2 ангилан бүртгэж, улмаар гэмт хэрэгтэй тэмцэх стратеги, төсөвөө тодорхойлох. Индекс гэмт хэрэгт нь түгээмэл үйлдэгддэг хүнийг алах, бие махбодид хохирол учруулах, хулгайлах, дээрэмдэх, хүчиндэх, эд хөрөнгө устгах гэх мэт гэмт хэргүүдийг хамааруулах. Харин индекс бус гэмт хэрэг гэдэгт түгээмэл биш боловч нийгмийн хор аюул ихтэй бусад төрлийн гэмт хэрэг хэргүүд тухайлбал хүн амын эрүүл мэнд, байгаль орны эсрэг гэмт хэргүүд гэх мэт 2 хуваж гэмт хэрэгтэй тэмцэх стратеги ээ зөв тодорхойлж чадах болно. Энэхүү аргачлалыг хэрэгжүүлснээр түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн гаралтыг бууруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулж чадна.

3. Мөрдөн байцаалтын явцад нотлох баримтыг шинжлэн судлах төрөлжсөн лаборатори /ялангуяа ДНК/-тай болох. Хүнийг алах гэмт хэргийн нотлох баримтыг судлан шинжлэх техник, технологи шаардлагын түвшинд хүрэхгүй, мэдүүлэгт суурилсан мөрдөх ажиллагаа зонхилж байгаа нь хэргийн илрүүлэлт, мөрдөн байцаалтын чанар, үр дүнд шууд нөлөөлж байна. Иймд эд мөрийн баримт, шинжилгээний төрөлжсөн лаборати байгуулах. Учир нь Цагдаагийн Албаны тухай хуулийн 6-р зүйл “Цагдаагийн байгууллагын тогтолцоо”-н 6.6 дахь хэсэгт Цагдаагийн байгууллага өөрийн харьяандаа чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэшсэн нэгж....лаборатори...-тай байж болно хэмээн заасан байдаг.

Тиймээс эд мөрийн баримт, шинжилгээний лаборатори байгуулах саналыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд тавьж шийдвэрлүүлэх. Төрөлжсөн лаборатори байгуулсанаар хүнийг алах гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цаг хугацаа алдахгүйгээр баривчлахад ач холбогдолтой юм.

4.Хүний амь нас хохирсон хэргийн газарт ажиллаж байгаа алба хаагчдад техник, хувцас хэрэгсэлийн хүртээмжийг нэмэгдүүлэх.

Ашигласан материалын жагсаалт:

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он
2. Сайшаал. Чингис хааны товчоон. Хөх хот., 1987 он
3. С.Жалан- Аажав. Халх журам . УБ хот., 1995 он
4. Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойших эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил. УБ . 1998 он
5. Б. Баярсайхан, С.Жанцан нар. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал (1911-2009). УБ., 2011 он
6. Эрүүгийн хууль шинэчилсэн найруулга.УБ. 2015 он.,
7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль. УБ. 1997 он
8. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль. УБ. 2016 он
9. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ. 2013 он
10.Б.Батцэрэн, Э.Амарбат. Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулага /сургагч багш нарт зориулсан гарын авлага/. УБ хот., 2017 он.
11.С.Жанжан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. УБ хот., 2012 он
12.В.Н. Кудрявцев. Общая теория квалификация преступлений. 1999.
13.Gropp W. Notwehr gegen Unterlassen. Goltdammers Archiv fuer Strafreht. 1991
14.Н.Баатаржав.Криминологи.УБ . 2001 он
15.Л.Билгээ “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн ажлын арга зүй”, УБ., 2005 он
16.Stephanie Robertsn. “Unsafe ”Convictions: Defining and Compensating Miscarriages of Justice. London. 2003
17. В.Н. Кудрявцев. Общая теория квалификация преступлений. 1999. С.146
18.Монгол Улс дахь 2011 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ. 2012 он
19.Монгол Улс дахь 2012 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ. 2013 он
20.С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар толь. УБ. 2013 он
22.Монгол Улс дахь 2015 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ. 2016 он
23.Монгол Улс дахь 2016 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ. 2017 он.
24.2015-2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик үзүүлэлт 2020 он.
25.Монгол Улс дахь 2017 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ. 2018 он
26.Монгол Улс дахь 2018 оны гэмт хэрэг, захиргааны зөрчлийн нөхцөл байдал. УБ. 2019 он

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙГ ХҮЧИНДЭХ ГЭМТ ХЭРГИЙГ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛСАН БАЙДАЛ, ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

VALIDATION OF CHILD SEXUAL ABUSE IN SOME FOREIGN COUNTRIES' CRIMINAL LAW AND ITS COMPARATIVE ANALYSES

Б.Батбаяр
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн дэслэгч
B.Batbayar
University of Internal Affairs, postgraduate student, police lieutenant

Хураангуй: Бэлгийн эрх чөлөө, бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ялангуяа бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдалд харьцуулсан судалгаа хийж, Монгол Улсад нэвтрүүлэх боломжийн талаар санал зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг: Бага насны хүүхэд, хүчиндэх гэмт хэрэг, гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомж, харьцуулалт.

Abstract: We have focused on conducting a comparative study of the legalization of crimes against sexual freedom and sexual integrity, especially the rape of minors, in the criminal law of some foreign countries and our recommendations have been made on the possibility of introducing them in Mongolia.

Key words: Young children, rape, criminal legislation and comparisons of some foreign countries.

Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргээс хүүхдийг хамгаалах, эрүүгийн эрх зүйн зохицуулалтын талаар гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжийг харьцуулан судлах нь тухайн төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хууль зүйн хариуцлага хүлээлгэх, үндэсний хууль тогтоомжийг илүү боловсронгуй болгоход ач холбогдолтой. Судлаачийн зүгээс Орос, Казакстан, Герман, Франц, Дани зэрэг улсын Эрүүгийн хуульд бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг хуульчилсан байдлыг харьцуулан судалж онцлог болон ялгаатай талуудыг нээн харуулахыг зорьсон болно.

1. Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуулийн 131 дүгээр зүйлд Хүчиндэх гэмт хэргийг насанд хүрээгүй буюу 15-18 насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэх, хэрэв 14 насанд хүрээгүй хүүхдийг хүчиндсэн, урьд нь насанд хүрээгүй этгээдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж шийтгүүлсэн этгээд бол тус тус онц хүндрүүлэхээр заасан. Тухайлбал:

- Хүчиндэх, өөрөөр хэлбэл хохирогч болон бусад этгээдэд хүч хэрэглэн, хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй байдлыг ашиглан хурьцал үйлдсэн бол 3-6 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
- Хүчиндэх үйлдлийг:

а.Зохион байгуулалттай бүлэг, урьдчилан тохиролцсон бүлэг этгээд бүлэглэн үйлдсэн,

б.Алахаар буюу эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулахаар заналхийлж,

мөн хохирогч буюу бусад этгээдтэй онц хэрцгийгээр харьцаж үйлдсэн,

в.Хохирогчид бэлгийн замын өвчин халдаасан бол эрх чөлөөг 2 жил хүртэл хязгаарлах буюу хязгаарлахгүйгээр 4-10 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

- Хүчиндэх гэмт хэргийг:

а.Насанд хүрээгүй хүүхдийг

б.Хохирогчийн бие махбодод болгоомжгүйгээр хүнд хохирол учруулсан, бэлгийн замын халдварт өвчин халдаах буюу бусад хүнд үр дагаварт хүргэсэн бол 2 жил хүртэл эрх чөлөөг хязгаарлаж, 20 жил хүртэл тодорхой албан тушаал буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 8-10 жил хүртэл хорих ял шийтгэнэ[1] гэж заасан байна.

ОХУ-ын Эрүүгийн хуульд 16 нас хүрээгүй этгээдтэй хурьцах болон бэлгийн шинжтэй үйлдэлд хийх гэмт хэргийн үйлдлийг анх удаа үйлдсэн этгээд хохирогчтой гэр бүл болсон бол нийгмийн хор аюул арилсан гэж үзвэл шүүх ял шийтгэхээс чөлөөлж болно гэж хуульчилсан нь бусад улсын хуулиас шинэлэг талтай байна.

Тус 2 улсын Эрүүгийн хуульд харьцуулалт хийхэд хүүхдийн эсрэг гэмт хэргийн шинжийг заасан, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлсон байдал зэрэг зохицуулалтын арга, хууль зүйн техникийн арга хэрэгсэл, ашигласан байдал нь агуулга үзэл санааны хувьд адил болохыг харуулж байна.

Ялын санкцын тухайд хоёр улсын Эрүүгийн хуульд зөвхөн бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийн /12.1.4/, /131.3б/ ялыг харьцуулж үзвэл манай улсын ялын бодлого чанга байгаа нь дэвшилтэд алхам болж өгсөн.

2. Бүгд Найрамдах Казакстан Улсын Эрүүгийн хуулийн 120 дугаар зүйлд Хүчиндэх, өөрөөр хэлбэл хохирогч буюу бусад этгээдэд хүч хэрэглэн, хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хохирогчийн тусламж авах чадваргүй байдлыг ашиглан хурьцал үйлдсэн бол 3-5 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгэх.

121.3.

а.насан хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн,

б.хохирогчийн бие махбодод болгоомжгүйгээр хүнд хохирол учруулсан бэлгийн замын халдварт өвчин халдаах буюу бусад хүнд үр дагаварт хүргэсэн бол 2 жил хүртэл эрх чөлөөг хязгаарлах, 20 жил хүртэл тодорхой албан тушаал буюу тодорхой үйл ажиллагаа эрхлэхийг хориглох буюу хориглохгүйгээр 8-15 жил хүртэл хорих ял шийтгэнэ. Мөн хуулийн 124 дүгээр зүйл бага насны хүүхдийг садарлах асуудлыг дараах байдлаар шийтгэхээр тусгасан байна. Үүнд:

1.Бага насны хүүхдийг зориуд санаатайгаар хүч хэрэглэхгүйгээр садарласан бол 7-10 жил тодорхой албан тушаал үйл ажиллагаа эрхлэхийг хориглож 5-10 хорих ял шийтгэнэ.

2.Энэхүү үйлдлийг эцэг эх, сурган хүмүүжүүлэгч эсхүл Казакстан Улсын хууль тогтоомжоор түүнийг хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн бусад этгээд үйлдсэн бол тодорхой албан тушаал үйл ажиллагаа эрхлэх эрхийг бүх насаар нь хасаж, 7-10 жил хорих ял шийтгэнэ гэж тус тус заасан байна.[2]

Казакстан Улсын Эрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэргийн субъект

[1] (в ред. Федерального закона от 27.12.2009 N 377-ФЗ),

[2] Казакстан улсын эрүүгийн хуулийн 120 дугаар зүйл, 2007 он

нь зөвхөн эрэгтэй хүн, Монгол Улсад хүчиндэх болон бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийн гэмт хэргийн субъект нь эрэгтэй, эмэгтэй аль нь ч байхаар хуульчилж өгсөн нь шинэлэг байна.

Гэмт хэргийн субъектийн хувьд Монгол улс болон Казакстан улс нь эрүүгийн хариуцлага хүлээх чадварыг 14 наснаас эхлэн тооцсон нь нийтлэг тал болж байна.

Казакстан Улсын Эрүүгийн хуульд уг гэмт хэргийн зүйлчлэлийг системчлэн хуульчилсан нь хууль хэрэгжүүлэгчид илүү ойлгомжтой хэрэгжүүлэхэд хялбар болсон байна. Харин манай улсын тухайд бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг багцлан хүчиндэх гэмт хэрэгт тооцсон нь хуулийг хэрэгжүүлэхэд сөрөг талтай. Энэ төрлийн гэмт хэргийн /12.1.4/ хуулийн бодлогод зохих өөрчлөлт хийх, боловсронгуй болгох шаардлагатай болохыг харуулж байна.

3.Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуульд хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох (176), ноцтой байдлаар бэлгийн харьцаанд орох (176а), Хүүхдийг үхэлд хүргэх бэлгийн аюултай үйлдэл (176Ь), Бага насны хүүхэдтэй бэлгийн үйлдэлд хамтрах (180) зэргийг бие даасан зүйл болгон хуульчилсан төдийгүй харгалзан дэмжиж, асран хамгаалж байгаа этгээдийн эсрэг үйлдсэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг бие даасан гэмт хэрэгт тооцож зүйлчилсэн байна. Мөн хуулийн (174) зүйлд зааснаар асран хамгаалуулсан буюу (хүмүүжүүлэх, боловсрол олгуулахаар) итгэн хариуцуулсан арван зургаан нас хүрээгүй этгээдийн эсрэг, эсхүл өөрийн цусан төрлийн (төрсөн) буюу үрчилж авсан 18 нас хүрээгүй хүүхэд буюу асран хамгаалуулагчтай хурьцал үйлдсэн, тийм үйлдлийг өөртэй нь хийхийг зөвшөөрсөн бол ял шийтгэхээр хуульчилсан байна.

Герман Улс 2016 онд Эрүүгийн хуулийн 184 дүгээр зүйлд: “Бэлгийн албадлага”, “садар самуун үйлдэл” зэрэг нэр томьёоны зэрэгцээ “бэлгийн дарамт” гэсэн ойлголт, нэр томьёог шинээр бий болгосон. Мөн 176 дугаар зүйл хүүхэдтэй бэлгийн үйлдэл хийх, хэн нэгэн 14 нас хүрээгүй этгээдтэй бэлгийн үйлдэл хийсэн буюу түүнд өөртэйгөө хийх боломж бүрдүүлсэн бол 6 сараас 10 жил хүртэлх хугацаагаар, харгалзан /хөнгөрүүлэх/ үзэх тохиолдолд 5 жил хүртэл хорих буюу мөнгөөр торгох ял шийтгэнэ гэж заажээ.[3]

Герман Улс нь эрх зүйн сонгодог тогтолцоотой улсын хувьд бэлгийн дарамт учруулахыг шинээр хуульчилж байхад Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан бэлгийн дарамт учруулах буюу хохирогчид ажил, албан тушаал, нэр төр, эд хөрөнгө, сэтгэл санааны бусад байдлаар хохирол учруулах үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэж бэлгийн харьцаанд орох сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсвэл бэлгийн харьцаанд орохыг шаардсан үйлдлийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар хүчингүй болгосон. Ялангуяа энэ гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэхээр заасныг гэмт хэргээс хассан нь эмгэнэлтэй. Үүнийг дахин хуульчлах шаардлагатай гэж судлаач

[3] Gesetz zur Дnderung des stragesetzbuches-Verbesserung des Schutzes der sexuellen Selbstbestimmung. Druvksache 463/16 02.09.2016

миний хувьд үзэж байна. Мөн Эрүүгийн хуульд нь оногдуулах хорих ялыг тодорхойлохдоо хорих ялын доод хэмжээг тогтоож түүнээс дээш хэдэн жил нэмэгдүүлэн яллах боломжийг шүүхэд олгосон нь нэн чухал ач холбогдолтой гэж үзлээ.

Герман Улс нь хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг тусгайлан авч хэд хэдэн зүйлд тусгасан нь бусад улсын хувьд хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эрүүгийн эрх зүйн хамгаалалтын сонгодог жишээ болж байна. Мөн Герман улс нь Монгол улсын адил хүчиндэх гэмт хэргийн субъектийг эрэгтэй, эмэгтэй хэн ч байхаар хуульчилсан нь нийтлэг байна.

Тус улсын Эрүүгийн хуульд бага насны хүүхдийг хүчиндэхээр завдсан бол шийтгэлтэй гэж заасан заалтыг Монгол Улсын Эрүүгийн хуульд нэвтрүүлэх шаардлагатай гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.

4.Франц Улсын Эрүүгийн хуульд: “Хүч хэрэглэх, албадах, айлган сүрдүүлэх буюу хууран мэхлэх замаар үйлдэх бэлгийн нэвтрэлт (222-23)”-ийг хүчиндэх гэмт хэрэг гэж тодорхойлсон байна. (Бэлгийн нэвтрэлт гэдгийг бэлэг эрхтнээр буюу бэлэг эрхтэнд нэвтрэх гэж ойлгоно.) 16 насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэхээр зааж 20 жилийн ял шийтгэнэ.

Мөн хуулийн 222-24 зүйлд:

1.Хэрэв гэмтэл учруулсан буюу архаг өвчин тусгасан

2.Хэрэв 16 насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдсэн

3.Биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулан зориуд санаатайгаар үйлдсэн

4.Цусан төрлийн этгээд үйлдсэн

5.Эрх мэдлээ урвуулан ашиглаж үйлдсэн

6.Хэд хэдэн этгээд хамтран үйлдсэн

7.Зэвсэг хэрэглэж айлган сүрдүүлж үйлдсэн тохиолдолд хүндрүүлэх нөхцөлөөр 20 жил ял шийтгэнэ.[4]

Гэмт хэргийн нийтлэг субъектийн хувьд Монгол Улс, ХБНГУ, ОХУ, Казакстан, Япон, Солонгос Улсад Эрүүгийн хариуцлага хүлээх чадварыг 14 наснаас эхлэн тооцсон бол Франц Улс 13 нас хүрсэн хүн хүчиндэх гэмт хэргийн субъект болохоор хуульчилсан байна. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын санкц өндөр байгаагийн зэрэгцээ энэ гэмт хэрэгтэй чанга, хатуу аргаар тэмцдэг хуулийн зохицуулалт нь ололттой. Тус улсын Эрүүгийн хуулийг судалж өөрийн орны онцлогт тохируулан боловсронгуй болгох боломжтой гэж үзлээ.

Тус улс нь хууль ёсны буюу өөрийн төрсөн, жам ёсны буюу ясан төрлийн төрөл саднаас өргөж авсан хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн бол онц хүндрүүлэхээр зааж хуульчилснаараа ялгаатай байна.

5. Дани Улсын Эрүүгийн хуульд 15 нас хүрээгүй хүүхэдтэй бэлгийн харьцаанд орсон бол ял шийтгэнэ. Хэрэв хүүхэд 12 нас хүрээгүй буюу гэмт этгээд албадах, айлган сүрдүүлэх замаар бэлгийн харьцаанд ороход хүргэсэн бол хүндрүүлэхээр гяндан хорих ялыг 10 жил хүртэл нэмэгдүүлэхээр заажээ. /Бүлэг 24 бэлгэсийн гэмт хэргийн 222, 223 дугаар зүйл/

Дээрх улсуудын Эрүүгийн хуульд хохирогчийг өөрөөр тодорхойлжээ. Гадаадын зарим улсад бэлгийн эрх

[4] (в редакции закона № 98-468 от 17 июня 1998г)

чөлөө нь хүүхдийн хувьд 16-18 насанд хүлээн зөвшөөрөгдөх боловч бэлгийн халдашгүй эрх 16 нас хүртэл хохирогчийн хүсэл зоригоос үл хамааран эрүүгийн эрх зүйн хамгаалалтад байдаг байна. Харин Дани Улсад бэлгийн эрх чөлөөг 15 наснаас хүлээн зөвшөөрсөн бусад улсаас ялгаатай байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд хохирогчийг 14 насанд хүрсэн эсхүл 16 насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон тохиолдолд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан бол харин Дани Улсын хуульд гэмт этгээд тухайн этгээдийн эрүүл мэндийн байдал, насыг мэдээгүй, хайхрамжгүй хандсан бол уг үйлдлийг санаатай бус гэж үзэж шийтгэлийг тэр хэмжээгээр багасгаж оногдуулна гэж заасан нь объектын андуурлыг харгалзан ялыг хөнгөрүүлэн авч үзсэнийг дээрх харьцуулалт, судалгаанд үндэслэн үзвэл гэмт этгээдэд оногдуулах ялыг хөнгөрүүлэх нь энэ гэмт хэргийг үйлдсэн этгээдийг ял завшихаар байна гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.[5]

Эдгээр улсын Эрүүгийн хуулийг хуульчилсан байдлаас харахад хүчиндэх гэмт хэргийн объектив тал нь

1. Хүч хэрэглэх
2. Хүч хэрэглэхээр заналхийлэх /айлган сүрдүүлэх/
3. Хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй байдлыг далимдуулах
4. Хурьцал үйлдсэн буюу бэлгийн харьцаанд орсон үйлдэл гэж томьёолсон нь нийтлэг байна.

Дээрх улсуудын гэмт хэргийн субъектийн хувьд авч үзвэл Орос, Казакстан улс хүчиндэх гэмт хэргийн субъектийг зөвхөн эрэгтэй хүн, Герман, Дани, Франц, Монгол улс хүчиндэх гэмт хэргийн субъектийг эрэгтэй, эмэгтэй аль нь ч байхаар хуульчилсан нь нийтлэг байна.

Ихэнх улсад бэлгийн албадлага буюу бэлгийг дарамтыг бие даасан бүрэлдэхүүн болгон хуульчилсан байхад манай улсын хувьд бэлгийн дарамт учруулах гэмт хэргийг хүчингүй болгосон. Энэ гэмт хэргийг хүүхдийн эсрэг үйлдсэн бол хүндрүүлэхээр заасныг хүчингүй болгосон нь ухралт болсон нь анхаарал татаж байна.

Монгол Улсын болон гадаадын зарим улсын Эрүүгийн хуульд хүчиндэх, бага насны хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээг харьцуулан үзвэл:[6]

Хүснэгт № 1.

№		Монгол Улс	ОХУ	ХБНГУ	БНКУ	Франц Улс	Дани Улс
Хүчиндэх	Ердийн бүрэлдэхүүн					15 жил	
	Хүндрүүлэх	1-5 жил			15 жил хүртэл	20 жил	
	Онц хүндрүүлэх	5-12 жил	8-10 жил		10-15 жил	30 жил	

[5] Дани улсын эрүүгийн хууль, 1999 он /нэмэлт өөрчлөлт/

[6] Хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлс УБ, 2019 он

	Тусгайлан онц хүндрүүлэх	12-20 бүх насаар	12-20 жил			Бүх насаар	
Бэлгийн шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл	Ердийн бүрэлдэхүүн	6 сараас 2 жил				5 жил	
	Хүндрүүлэх	2-8 жил			8-15 жил	7 жил	
	Онц хүндрүүлэх	5-12 жил	8-15 жил		10-15 жил	10 жил	
	Тусгайлан онц хүндрүүлэх	12-20 жил			15-20, бүх насаар		
Бэлгийн албадлага бүхий бэлгийн дарамт	Ердийн бүрэлдэхүүн					1 жил	
	Хүндрүүлэх		5 жил хүртэл				
16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох	Ердийн бүрэлдэхүүн	6 сараас 1жил	4 жил хүртэл	1 жил	5 жил хүртэл		4 жил хүртэл
	Хүндрүүлэх	6 сараас 3 жил	6 жил хүртэл	6 сараас 10 жил	7-10 жил		6 жил хүртэл
	Онц хүндрүүлэх		8-15 жил	5-с доошгүй жил	10-15 жил		10 жил хүртэл
	Тусгайлан онц хүндрүүлэх		12-20 жил бүх насаар	10-с дээш, насаар нь			

Гадаадын зарим улсын энэ төрлийн гэмт хэргийн харьцуулсан судалгаанаас үзэхэд Эрүүгийн хуульд бага насны хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож ялтай болгосон байдал нь зарим улс нь үндэсний эрх зүйн тогтолцоо, ёс заншил, амьдралын хэвшил, нийгэм эдийн засаг, соёлын түвшин зэргээс хамаарч өөрийн гэсэн онцлогтой байна.

Дүгнэлт

Дээрх судалсан улсуудын Эрүүгийн хуульд хүчиндэх, бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг болгон авч үзэх нийтлэг хандлага байна. Тухайлбал, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Казакстан зэрэг улсад нарийвчлан хуульчилж өгсөн нь хуулийг хэрэгжүүлэхэд илүү ойлгомжтой, тодорхой байна. Харин Холбооны Бүгд Найрамдах Герман Улс нь бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг тусгайлан авч хэд хэдэн зүйл тусгасан нь бусад улсын хувьд эрүүгийн эрх зүйн хамгаалалтын сонгодог жишээ болсон байна.

Монгол Улсын хувьд зөвхөн бэлгийн харьцаанд орсон эсэхээр хязгаарлалгүй бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн бусад үйлдлийг хүчиндэх гэмт хэрэгт тооцдог болсон, хохирогчийн бэлгийн халдашгүй байдлыг хүйсийн ялгамжгүй байхаар тусгасан зэрэг нь олон улсын жишигт нийцэж байна.

Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн эсрэг үйлдлийг гэмт хэрэгт тооцож,

эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байдлыг харьцуулан судлахад Бүгд Найрамдах Солонгос Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуульд оногдуулах хорих ялыг тодорхойлохдоо хорих ялын доод хэмжээг тогтоож, түүнээс дээш хэдэн жил нэмэгдүүлэн яллах боломжийг шүүхэд олгосон нь сонирхол татаж байна. Харьцуулан судалсан ихэнх улсын Эрүүгийн хуульд бэлгийн харилцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчилсан байдлыг Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгах шаардлагатай байна.

Санал

1. Бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг Эрүүгийн хуульд бие даасан гэмт хэрэг болгон хуульчилж, ялын бодлогыг чангатгах;
2. Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид учирсан шууд ба шууд бус хохирол буюу хохирогчийн сэтгэл санааны хохирлыг үнэлж барагдуулах аргачлалыг бусад улсын туршлагаас судалж, бий болгох;
3. Гадаадын зарим улсын жишгээр бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдээд суллагдсан этгээдийг хохирогчдод дахин халдахаас сэргийлж цахим хяналтын төхөөрөмжийн тусламжтайгаар хяналтад байлгах;
4. Энэ төрлийн гэмт хэргийн хохирогч хүүхдийг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн дэргэд байцаахад хохирогч айж эмээх, үнэн зөв мэдүүлэхгүй байх тохиолдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор бага насны хүүхдийг мөрдөх, нотлох ажиллагаанд сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, мөрдөн байцаагч, шинжээч нараас бүрдсэн мэргэшсэн багийг ажиллуулах чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

Ном зүй

1. Хүүхдийн эрхийн тухай конвенц. НҮБ 1989
2. Эрүүгийн хууль. 2002, 2015
3. Карбоне Ж.И Юридическая социология. М.1986
4. “хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдалд хийсэн дүншинжилгээ” судалгааны тайлан. Хөгжлийн академи ТББ. УБ., 2017
5. Дэлхий дахины гэмт хэргийн загвар хууль. НҮБ., 2001
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017

АВЛИГЫН ГЭМТ ХЭРГИЙН ГЭРЧИЙГ ГҮЙЦЭТГЭХ АЖЛААР ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

LEGAL REGULATION FOR PROTECTION OF WITNESSES OF CORRUPTION CRIMES

Б.Батхуяг
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн дэслэгч
Batkhuyag.B
University of Internal Affairs, Post-graduate student, Police lieutenant

Хураангуй: Гэрч, хохирогчийг хамгаалах гэдэг нь гэрч, хохирогч, түүний хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд учирч болох аюулаас сэргийлэхийн тулд сахин хамгаалж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэлнэ[1]. Энэхүү өгүүлэлд авлигын гэмт хэргийн гэрчийг гүйцэтгэх ажлаар хамгаалах эрх зүйн зохицуулалт, өнөөгийн нөхцөл байдал, боловсронгуй болгох арга хэмжээг санал болгосон.

Abstract: Witness and victim protection means measures to protect and ensure the safety of witnesses, victims and their dependents.

This article suggests the legal framework for the protection of witnesses in corruption cases, the current situation, and measures to improve it.

Түлхүүр үг: Гэрч, авлига, хамгаалах, гэмт хэрэг, хууль.
Keywords: Witness, corruption, protection, crime, law.

Нэг:Эрх зүйн зохицуулалтын талаар

Нэгдсэн үндэсний байгууллагын ерөнхий ассемблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор батлагдсан бөгөөд Авлигын эсрэг конвенцыг Монгол Улс 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр соёрхон батлагдсан байдаг. Дээрх конвенцын 32 дугаар зүйлд гэрч, шинжээчийг хамгаалах талаар тусгасан бөгөөд Оролцогч улс бүр энэхүү конвенцийн дагуу тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон буюу айлган сүрдүүлгээс үр дүнтэйгээр хамгаалах арга хэмжээг дотоодын эрх зүйн тогтолцоондоо нийцүүлэн, боломжийн хэмжээндээ авна[2] гэж заасан байна. Авлигын эсрэг конвенцод Монгол Улс нэгдсэн орсноор олон улсын өмнө авлигыг гэмт хэрэгт тооцох, илрүүлэх, таслан зогсоох, тус гэмт хэргийн гэрчийг хамгаалах талаар чухал үүрэг хүлээсэн билээ.

Авлигын эсрэг конвенцод Монгол улс нэгдэн орсноор дотоодын хууль тогтоомжид авлигын гэмт хэргийн гэрчийг хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан. Тухайлбал: Монгол Улсын Үндсэн хуулийн 19.1 дэх хэсэгт ... Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна... 38.2.7 дахь хэсэгт "Засгийн газар ... дараах үндсэн

[1] Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код. УБ., 2018 он. 511.2 дахь тал
[2] НҮБ-ын Авлигын эсрэг конвенц / file://Авлига%20конвенц.pdf/

бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх[3]" гэж тус тус заасан байна.

Уг хуулийн 10 дугаар зүйлийн "Хүний халдашгүй байх эрхийг хангах" тухай заалтаас харахад гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн яллагдагчийн эрх зүйн байдал, шүүгдэгчийн халдашгүй байх эрх"-ийг хамгаалснаас биш хэргийн талаар ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэх гэрчийг хамгаалах асуудлыг орхигдуулсан байна.[4]

Үндсэн хуулийн дээрх заалтууд нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөний нийтлэг байдлыг илэрхийлж байгаа төдийгүй тусгайлсан эрх бий болгоход чиглэгдсэн. Өөрөөр хэлбэл нийгмийн тодорхой харилцааны онцлогтой холбоотойгоор иргэний эдлэх эрхийн үндэс болох юм.

Тэгэхээр Үндсэн хуулийн дээрх заалтуудаар Монгол Улсад гэрчийг хамгаалах асуудлыг тусгайлан зохицуулах Үндсэн хуулийн үндэслэл буй нь харагдаж байна.

Авлигын эсрэг хуулийг Монгол улсын Их хурлын 2006 оны 07 дугаар сарын 06-ны өдөр батлагдсан. Тус хуулийн зорилго нь авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигатай тэмцэх байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлж, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршдог[5] бөгөөд дээрх хуулиар гэрчийг хамгаалах бүрэн эрх, эрх зүйн үндсийг тогтоосон.

Мөн Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх заалтад Авлигатай тэмцэх газрын бүрэн эрхэд ..Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх[6].. бүрэн эрхтэй. Мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт ..авлигатай тэмцэх үйл ажиллагааны явцад туслалцаа үзүүлсэн этгээд, гэрчийг хамгаалах, тэдгээрт санхүүгийн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ гэж тус тус хуульчилсан байна. Дээрх хуулийн зохицуулалтаас үзэхэд авлигын гэмт хэргийн гэрчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх, биеэ даасан тусгай нэгж байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн бөгөөд тэр дундаа Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд Авлигатай тэмцэх газар, Тагнуулын Ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тус тусдаа гэрч, хохирогчийг хамгаалах тусгай албатай байна гэж хуульчилсан. Тухайлбал Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт Хамгаалалтын арга хэмжээг дараах байгууллагууд өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

-Цагдаагийн алба;

-Авлигатай тэмцэх газар;

-Тагнуулын ерөнхий газар зэрэг нь тухайн байгууллагын даргын дэргэд гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай албатай байна[7]. Энэхүү зохицуулалтаас үзэхэд Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн алба нь өөрийн эрх хэмжээний хүрээнд гэрчийг

[3] Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он. №1 /https://legalinfo.mn/mn/detail/367/

[4] Оюунчимэг.Т. Гэрч. УБ., 2013 он. 116 дахь тал

[5] Авлигын эсрэг хууль. УБ., 2006 он. 1 дүгээр зүйл /https://legalinfo.mn/mn/detail/8928/

[6] Авлигын эсрэг хууль. УБ., 2006 он. 18 дугаар зүйл /https://legalinfo.mn/mn/detail/8928/

[7] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль. УБ., 2013 он. 23 дугаар зүйл

хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх тусгай албатай байхаар зохицуулсан хэдий ч Авлигатай тэмцэх газар өөрийн бүрэн эрхийн хүрээнд тусгай нэгжийг байгуулаагүй байгаа нь дээрх эрх зүйн зохицуулалт бүрэн хэрэгжихгүй байгаа нь ажиглагдаж байна. Мөн Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг[8], Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2[9], 18 дугаар зүйлийн 18.5[10], 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн 25.1.2[11] дахь заалтуудад тус тус гэрчийг хамгаалах, туслалцаа үзүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж хуульчилсан боловч дээрх зардлыг улсын төсвөөс одоог хүртэлх хугацаанд санхүүжүүлээгүй нь улмаас авлигын гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах тусгай алба байгуулахад хүндрэл үүссэн байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар энэ хуулийн Урьдчилан сануулах, Тодорхой үйлдлийг хязгаарлах, Биечилсэн хамгаалалт, Мэдээллийн нууцлалыг хангах, Нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах; Аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээг өөрийн эрх хэмжээний хүрээнд хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Харин Нүүлгэн шилжүүлэх, Баримт бичиг солих, Гадаад төрхийг мэс заслын аргаар өөрчлөх зэрэг 3 хамгаалалтын арга хэмжээ нь онцгой арга хэмжээ бөгөөд Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс хэрэгжүүлдэг.

Хоёр: Өнөөгийн нөхцөл байдал

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1-7.6 дугаар зүйлд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд Авлигатай тэмцэх газарт гэрчийг хамгаалах алба, нэгж байхгүй нь улмаас практикт Цагдаагийн байгууллагын хамгаалалтад өгч, хамгаалуулах тохиолдол гарч байна. Тухайлбал: Цагдаагийн байгууллагаас Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу 2016 онд 42, 2017 онд 36, 2018 онд 65, 2019 онд, 2020 онд 101, 2021 оны эхний хагас жилд 104 нийт **482** иргэнийг хамгаалалтад авч, **453** аюулгүй байдлыг хангах хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж ажилласан. Үүнээс **Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу** 2018-2021 оны байдлаар гэрч 3, хамаарал бүхий этгээд 3 нийт 6 хамгаалуулагчаар Биечилсэн хамгаалалт 3, Аюулгүй газарт түр байрлуулах 1, Тодорхой үйлдлийг хязгаарлах 1 нийт 5 хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

[8] Авлигатай тэмцэх үйл ажиллагааны явцад туслалцаа үзүүлсэн этгээд, гэрчийг хамгаалах, тэдгээрт санхүүгийн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг **улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.**

[9] Шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 7.1-д заасан аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болох бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг **улсын төсвөөс санхүүжүүлнэ**.

[10] Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 18.1.4-т заасан нийгмийн бусад туслалцаа үзүүлэхэд шаардагдах зардлыг **улсын төсвөөс санхүүжүүлнэ**.

[11] Засгийн газар гэрч, хохирогчийг хамгаалах талаар дараах үүрэг хүлээнэ. Үүнд: 25.1.2.**гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээний зардлыг улсын төсвийн төсөлд** тусгах.

Хамгаалалтад авагдсан гэрч, хамаарал бүхий этгээд[12]:

График:1

Дээрх судалгаанаас дүгнэхэд гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулахад чиглэсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг бүрэн хангахад гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль чухал байр суурь эзлэх төдийгүй гэрч 3, хамаарал бүхий этгээд 3-г хамгаалалтад авсан юм.

Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах харьяалалд цагдаагийн байгууллага Авлигатай тэмцэх газар, Тагнуулын байгууллагын[13] харьяалах гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхгүй. Авлигатай тэмцэх байгууллага дараахь гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулна. Үүнд:

---

[12] Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн тоон мэдээ. УБ., 2021 он. 8 дахь тал

[13] Тагнуулын байгууллага: Эрүүгийн хуулийн 14.5 /Иргэн сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх/, 14.6 /Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх/, 14.7 /Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах/, 14.8 /Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах/, 14.9 /Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах/, 19.1/Эх орноосоо урвах/, 19.2/Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, саатуулах/, 19.3/Төрийн өндөр албан тушаалтны амь биед халдах/, 19.4/Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах/, 19.5/Зэвсэгт үймээн дэгдээх/, 19.6/Хорлон сүйтгэх/, 19.7/Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх/, 19.8/Экстремист үйл ажиллагаа явуулах/, 19.9/Үндэсний эв нэгдлийг бусниулах/, 19.10/Тагнуул хийх/, 19.11/Төрийн нууцыг хууль бусаар олж авах/, 19.12/Төрийн нууцыг задруулах/, 19.13/Төрийн нууцыг үрэгдүүлэх/, 19.14/Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх/, 20.1/Террорист үйлдлийн талаар зориуд худал мэдээлэх/, 20.2/Террорист үйл ажиллагаанд уриалах, түүнийг нийтийн өмнө зөвтгөх, хатгах/, 21.13/Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих/, 27.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг /Агаарын хөдөлгөөний аюулгүй байдалд халдах/, 29.1/ Түрэмгийлэл, эсхүл дайныг төлөвлөх, бэлтгэх, өдөөх, дэгдээх/, 29.3/Үй олноор хөнөөх зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, борлуулах/, 29.5/Төрлөөр устгах/, 29.6/Хөлсний цэрэг ашиглах/, 29.7/Олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах/, 29.8/Террорист үйлдэл хийх/, 29.9/Террорист үйлдэлд бэлтгэх/, 29.10/Терроризмыг санхүүжүүлэх/, 29.11/Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх/ дүгээр зүйлд заасан гэмт хэрэгт;

Тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн 13.1/Хүн худалдаалах/, 18.2/Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх/, 18.5/Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх/, 18.6/Мөнгө угаах/ дугаар зүйл, 20.7 дугаар зүйлийн 3.3-т заасан гэмт хэрэгт.

Эрүүгийн хуулийн 22.1/Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах/, 22.3/Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах/, 22.4/Хахууль авах/, 22.5/Хахууль өгөх/, 22.6/Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтныг хахуульдах/, 22.7/Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх/, 22.8/Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 22.9/Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах/, 22.10/Үндэслэлгүйгээр хөрөнгөжих/, 22.11/Дураараа аашлах/, 22.12/Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт;

Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан авлигын гэмт хэргийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад илрүүлсэн Эрүүгийн хуулийн 18.6/Мөнгө угаах/ дугаар зүйлд заасан гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар хуульчилсан[14]. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад авлига, албан тушаалын гэмт хэргийн гэрч, хохирогч хамгаалуулах хүсэлтээ гаргаж шийдвэрлүүлэх тохиолдолд Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй мөрдөгч, түүнд хяналт тавьж буй прокурорт гаргаж Авлигатай тэмцэх байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна.

Харин Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь цагдаагийн байгууллагад харьяалуулсан гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Үүнээс үзвэл Авлигатай тэмцэх газарт гэрчийг хамгаалах тусгай алба байхгүй улмаас гэрчийг хамгаалуулахаар цагдаагийн байгууллагын хамгаалалтад өгч байгаа нь эрүүгийн процессын ажиллагааг зөрчиж буй явдал болж байна.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн гэрч, хохирогчийг хамгаалах тухай шийдвэрийг хэргийн өнгөөр авч үзвэл бүгд Авлигатай тэмцэх байгууллагын хэргийн харьяалалд хамаарч байна. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд хамгаалалтад авагдсан гэрч, хохирогч, түүний хамаарал бүхий этгээд, бусад шаардлагаар хамгаалалтад авагдсан этгээдийн амь нас, эрүүл мэндэд заналхийлэх тохиолдол нэлээдгүй гарч эдгээр нь ихэвчлэн дараах төрлийн хэрэгт холбогдон шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч байна.Тухайлбал:

[14]Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017 он. 6.1 дүгээр зүйл /https://legalinfo.mn/mn/detail/12694/

Хамгаалалтад авагдсан гэрч хэргийн өнгөөр[15]:

График:2

Эндээс дүгнэхэд авлигын гэмт хэргийн гэрч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн амь нас, эрүүл мэндэд халдах, халдахаар заналхийлэх тохиолдол нэлээд байгаа нь манай улсад авлигын гэмт хэргийн гэрчийг хамгаалах, бүтэц орон тоог бий болгох зайлшгүй шаардлага, цаг хугацаа бий болсон нь харагдаж байна. Эдгээр гэмт хэргийн гэрч, түүний хамаарал бүхий этгээд нарт хэрэгжүүлсэн хамгаалалтын арга хэмжээгээр авч үзвэл. Үүнд:

Хэрэгжүүлсэн хамгаалалтын арга хэмжээ:

График:3

Дүгнэлт:

Дээрх судалгаанаас дүгнэхэд авлигын гэмт хэргийн гэрчийг хамгаалах арга хэмжээг 3 хэлбэрээр дунджаар 2-3 удаа зохион байгуулдаг нь харагдаж байна. Үүнээс улсын хэмжээнд хамгийн өндөр үзүүлэлттэй хамгаалалтын арга хэмжээний нэг

[15] Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн тоон мэдээ. УБ., 2021 он. 8 дахь тал

хэлбэр нь Биечилсэн хамгаалалтын арга хэмжээ бөгөөд тухайн хамгаалалтыг арга хэмжээг зохион байгуулахад хамгийн их хүн, хүч, санхүү шаарддаг билээ.

Хамгаалалтад байгаа гэрчид хууль зүйн туслалцаа; сэтгэл зүйн туслалцаа; эрүүл мэндийн туслалцаа, нийгмийн бусад туслалцааг үзүүлж болох бөгөөд хууль зүйн болон сэтгэл зүйн туслалцааг энэ хуулийн 23.4-т заасан алба тус тус хариуцан хэрэгжүүлэх бөгөөд авлигын гэмт хэргийн гэрчийг хамгаалах нэгжийн дэргэд хууль зүй, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн баг, хэсгийг байгуулах эрх зүйн үндэс бүрдсэн. Үүнд үндэслэн Чатбот, гэрчийг хамгаалах бүртгэлийн системийг үйл ажиллагаандаа ашиглаж иргэдэд анхан шатны мэдээллийг үнэ төлбөргүй үзүүлэх, бүртгэх чиглэлээр ашиглах шаардлагатай байна.

Мөн авлигын гэмт хэргийн гэрчийг хамгаалахад гүйцэтгэх ажлын туслах хүч, арга, хэрэгслийг хамгаалалтын арга хэмжээтэй хослуулан хэрэглэхэд чухал үр дүнтэй байдаг. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь хэсэгт цагдаагийн байгууллага ...гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх... зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй[16] болохыг хуульчилсан. Харин Авлигатай тэмцэх газар нь гэрч, хохирогчийг хамгаалах чиглэлээр гүйцэтгэх ажил явуулах эрхийг хуульчлаагүй байна. Тухайлбал авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гэм буруутай этгээдийг олж тогтоох, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах[17] зорилгоор явуулдаг. Тиймээс хуульд нийцүүлэн гэрч, хохирогчийг хамгаалахад гүйцэтгэх ажил явуулах үндэслэл, зорилго, эрхийг хуульчлах шаардлагатай юм.

Эндээс авч үзвэл авлигын гэмт хэргийн гэрчийг хамгаалахад эрх зүйн зохицуулалтыг хууль тогтоомжоор зохицуулсан хэдий ч зарим зохицуулалт тусгагдаагүй орхигдсон байна. Тухайлбал цагдаагийн байгууллага гэрч, хохирогч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулах эрхтэй. Харин Авлигатай тэмцэх газар авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зорилгоор гүйцэтгэх ажил явуулдаг байна. Энэ нь нэг талаас авлигын гэмт хэргийн гэрчийг хамгаалах нэгж байгуулагдаагүй улмаас эрх зүйн зохицуулалтыг тусгаагүй байх талтай.

Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс нь цагдаагийн байгууллагад харьяалуулсан гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлд Авлигатай тэмцэх байгууллага нь авлигын гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг явуулдаг бөгөөд тухайн гэмт хэргийн гэрч, хамгаалалтын арга хэмжээнд орох тухай хүсэлтийг гаргасан тохиолдолд цагдаагийн байгууллагын хамгаалалтад өгч байна. Тухайлбал 2018-2021 оны байдлаар Хахууль авах, Албан тушаалын байдлаа урвуулан

[16] Гүйцэтгэх ажлын тухай хууль. УБ., 1997 он. 9 дүгээр зүйл/ https:legalinfo.mn/mn/detail/229/

[17] Гүйцэтгэх ажлын тухай хууль. УБ., 1997 он. 9 дүгээр зүйл/ https:legalinfo.mn/mn/detail/229 /

ашиглах гэмт хэргийн нийт гэрч 3, хамаарал бүхий этгээд 6 хүнийг хамгаалалтад авсан. Үүнээс үзвэл Авлигатай тэмцэх газарт гэрчийг хамгаалах тусгай алба байхгүй улмаас гэрчийг хамгаалуулахаар цагдаагийн байгууллагын хамгаалалтад өгч байгаа нь эрүүгийн процессын ажиллагааг зөрчиж буй юм.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд Авлигатай тэмцэх газрын даргын дэргэд гэрч, хохирогчийг хамгаалах тусгай албатай байна гэж хуулиар 2013 оноос хойш зохицуулсан хэдий ч одоог хүртэл хугацаанд тусгайлсан нэгжийг байгуулаагүй. Мөн Авлигын эсрэг хуульд авлигатай тэмцэх үйл ажиллагааны явцад туслалцаа үзүүлсэн этгээд, гэрчийг хамгаалах, тэдгээрт санхүүгийн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ гэж хуульчилсан боловч санхүү, төсвийг шийдвэрлэж өгөөгүй байна.

Санал:

1.Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн 9.1.6 дахь заалтад Авлигатай тэмцэх газар нь авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор гүйцэтгэх ажил явуулах, гэм буруутай этгээдийг олж тогтоох, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, **гэрч болон тэдгээрийн хамаарал бүхий этгээдийн аюулгүй байдлыг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх** зорилгоор гүйцэтгэх ажил явуулж болно гэсэн хэсгийг нэмэлтээр оруулж өгөх. Учир нь Гэрч, хохирогчийг тухай хуульд Авлигатай тэмцэх газрын даргын дэргэд гэрчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай албатай байна гэж хуульчилсан. Гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх бүтэц орон тоо батлагдсан тохиолдолд гүйцэтгэх ажлаар хамгаалах эрх зүйн зохицуулалтыг тусгаж өгөөгүй байгаа тул хуульд нийцүүлэн нэмэлт өөрчлөлт оруулах.,

Гэрч, хохирогчийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж буй нэгжийг үйл ажиллагааны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бие даасан төсөв, санхүүтэй болох асуудлыг шийдвэрлүүлэх. Учир нь Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг, Гэрч,хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 18 дугаар зүйлийн 18.5, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн 25.1.2 дахь заалтуудад тус тус гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ гэж хуульчилсан боловч хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Тиймээс хуульд нийцүүлэн жил бүрийн улсын төсөвт тусгах.,

Авлигын гэмт хэргийн гэрчийг хамгаалах нэгжийг Авлигатай тэмцэх газрын дэргэд байгуулах. Учир нь Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.4.12 дахь заалтад Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтад тухайн байгууллагын даргын дэргэд гэрчийг хамгаалах чиг үүрэг бүхий хамгаалалтын тусгай албатай байна гэж тус тус хуульчилсан боловч дээрх хуулийн зохицуулалт практикт бүрэн хэрэгжихгүй байна. Тиймээс дээрх хуулийн зохицуулалтад үндэслэн

авлигын гэмт хэргийн гэрчийг хамгаалах тусгай албыг бий болгох.,

Авлигын гэмт хэргийн гэрчид хууль зүйн туслалцаа; сэтгэл зүйн туслалцаа; эрүүл мэндийн туслалцаа, нийгмийн бусад туслалцааг үзүүлж болох бөгөөд хууль зүйн болон сэтгэл зүйн туслалцааг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 23.4-т заасан алба тус тус хариуцан хэрэгжүүлэх бөгөөд авлигын гэмт хэргийн гэрчийг хамгаалах нэгжийн дэргэд хууль зүй, сэтгэл зүйн туслалцаа үзүүлэх мэргэжлийн баг, хэсгийг байгуулах эрх зүйн үндэс бүрдсэн. Үүнд үндэслэн Чатбот, гэрч, хохирогчийг хамгаалах бүртгэлийн системийг үйл ажиллагаандаа ашиглаж иргэдэд анхан шатны мэдээллийг үнэ төлбөргүй үзүүлэх, бүртгэх чиглэлээр ашиглах.

Ашигласан материалын жагсаалт:

Нэг. Олон улсын гэрээ конвенц:

- НҮБ-ын Авлигын эсрэг конвенц,

Хоёр.Дотоодын хууль тогтоомж, эрх зүйн акт:

- Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он,

-Гүйцэтгэх ажлын тухай хууль. УБ., 1997 он,

-Авлигын эсрэг хууль. УБ., 2006 он,

-Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль. УБ., 2013 он,

-Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017 он,

- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код. УБ., 2018 он,

Гурав.Ном сурах бичиг:

- Оюунчимэг.Т. Гэрч. УБ., 2013 он,

Дөрөв.Тоон судалгаа:

- Цагдаагийн ерөнхий газрын Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтсийн тоон мэдээ. УБ., 2021 он.

ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ, ХЭВЛЭН НИЙТЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨНД ХАЛДАХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES IN THE CRIMINAL LAW THAT VIOLATION ON FREEDOM OF EXPRESSION AND THE PRESS

Э.Өнөболд
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр Гүйцэтгэлийн албаны сургуулийн Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн ахлах багш, хууль зүйн магистр, ахмад
Unubold.E
Senior lecturer, Department of Warding and Intelligence, the School of Court Decision Execution, University of Internal affairs, Master in law, and Captain;
Э.Цэрэнханд
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, хууль зүйн магистр, ахмад
Tserenkhand.E
Lecturer, Department of Decision execution, the School of Court Decision Execution, University of Internal affairs, Master in law, and Captain

Хураангуй: Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт, түүний эрх зүйн зохицуулалтыг дотоодын болон олон улсын хэм хэмжээний, судлаачдын үзэл баримтлалын хүрээнд судлан, энэ төрлийн харилцааг хамгаалсан эрүүгийн эрх зүйн хамгааллын хэрэгжилтийн бодит байдлыг судлан дүгнэлт, санал дэвшүүлсэн.

Abstract: The implementation of freedom of expression and freedom of expression and its legal regulation have been studied within the framework of domestic and international norms and the views of researchers, and the reality of the implementation of criminal law protection that protects this type of relationship has been reviewed and proposed.

Түлхүүр үгс: Хүний эрх, эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, нийтлэгч, гэмт хэрэг, ашиг сонирхол.

Key words: Human rights, freedoms, freedom of expression, freedom of the press, publishers, crimes, interests.

Удиртгал

“Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, адилхан нэр төр, ижил эрхтэй, тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заяасан бөгөөд өөр хоорондоо ахан дүүсийн ёсоор харилцах ёстой” гэсэн суурь зарчмыг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал[1]” -д дурдржээ.

Энэ ч утгаараа хүн бүр бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, түүнийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бий болгох нь дэлхийн улс орон, төр засгийн нэн тэргүүний үүрэг болох нь дамжиггүй.

Учир нь хүн төрөлхтний түүхийн туршид нийгмийг хамарсан бүхий л тэмцэл хүний эрхийн төлөө, үгээ хэлэх эрх чөлөөний төлөөх байсан гэхэд хилсдэхгүй байх.

Хөгжлийн хурдасгуур болсон мэдээлэл, түүнийг дамжуулах хурд асар

[1] Хүний эрхийн түгээмэл тунхаглал. Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. Уб., 1998. 3 дахь тал

ихээр нэмэгдсэнтэй холбоотойгоор хүний эрх, эрх чөлөө хийгээд нийгмийн хандлагад нөлөөлөх эерэг, сөрөг олон харилцаа бий болох боллоо.

Аливаа мэдээллийн үнэн, бодитой эсхүл худал, хуурмаг байдлыг дүгнэх, түүнд тавих хяналт, бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах асуудал сүүлийн жилүүдэд нийгэм, олон нийтийн анхаарлын төвд багтах болсон, судлах шаардлагатай сэдвийн нэг юм.

Хүний заяамал эрх болох үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хязгаарлах, түүнд хууль бусаар нөлөөлөх нөгөө талаас хэвлэн нийтлэгчийн эрх, эрх чөлөөг хязгаарлах нь олон нийтийн мэдэх эрхэд халдаж буй хэрэг төдийгүй нийгмийн томоохон ашиг сонирхолд аюул, занал учруулж болно. Иймд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн судалгаа хийгдэж байгаа энэ цаг үед өндөр ач холбогдолтой судлагдахуун билээ.

Өгүүллийн хүрээнд эрүүгийн хуулийн тусгай ангийн 14 дүгээр бүлгийн 14.3 дугаар зүйлд заасан "Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах" гэмт хэргийн шинж хийгээд, түүний шалтгаан нөхцөл, нийгэмд буй далд хэлбэрүүдийн талаар судлан таниулахыг зорьсон юм.

Үндсэн хэсэг

"Хүний эрх" гэх ухагдахуун нь хүн болж мэндлэхэд бидэнд заяагддаг жам ёсны бөгөөд хүн байх мөн чанарыг илэрхийлэгч байдаг.

Орчин үед хүний эрхийн тухай ойлголт нийгэмд голчлон судлагдаж, судлаач хүн бүр өөр өөрийнхөөрөө тайлбарлах болсон. Хүний эрхийн асуудлыг хүн бүр мэддэг хэр нь чухамдаа түүний мөн чанар, утга, агуулгыг төдийлөн сайн таниагүй байдал түгээмэл байдаг.

Хүний эрхийн талаарх хэд хэдэн үзэл санааг авч үзвэл:

- Эртний Ромын улс төрч Марк Туллий Цицерон "Жинхэнэ хууль гэдэг нь байгалийн хууль зүй тогтолд нийцсэн, хүн бүрт хамаатай, мөнхийн ухамсар юм" гэсэн нь хүний жам ёсны эрхийн талаарх үзэл санааг хамгийн анх илэрхийлсэн юм[2]. Цицероны үзлээр хүнийг байгалийн амьтан болохын хувьд хүн болж төрөх үед өгөгдсөн түүний биологийн өгөгдөл нь ямар ч хуулиар хязгаарлаж болохгүй үнэт зүйл бөгөөд түүнд нийцүүлэн бусад хууль тогтоомжоор эрх, эрх чөлөөг тодорхойлох нь чухал болохыг онцолжээ.
- Мөн Либерализмийн эцэг гэгдэх Жонн Локк Зүй ёсны суурь хуулийн талаар үзэл санааг дэвшүүлэхдээ "Хэн ч бусдын амь нас эрүүл мэнд, эрх чөлөө, эд хөрөнгөнд гэм хор учруулахгүй байх нь зүй ёсны суурь хууль юм" гэж тодорхойлсон байна[3].
- Харин Философийн шинжлэх ухааны үүднээс авч үзвэл "Хүний төрөлх мөн чанарыг агуулсан, аливаа нэг төр, шашин, хууль засаглалын ямар нэг тогтолцооноос олгогдож, зөвшөөрөгддөг хараат зүйл бус, харин заяагдмал шинжтэй объектив ухагдахуун юм" гэж үздэг.

[2] Чөлөөт нэвтэрхий толь-Википедиа. http//https://mn.wikipedia.org/

[3] П.Доржсүрэн. Жонн Локкын улс төрийн үзэл баримтлал. Улс төрийн боловсролын академийн онол-арга зүйн сэтгүүл., УБ 1994. №2. 12 дахь тал.

Эдгээр үзэл санааг нэгтгэвэл хүн нэг талаас нийгмийн амьтан, нөгөө талаас байгалийн амьтан болохынхоо хувьд дээрх 2 нөхцөлт харилцааг уялдуулан, өөрийн хүн болж төрснийхөө хувьд эдлэх ёстой эрх, эрх чөлөөг тэр дундаа амьд явах, эрүүл мэнд, эрх чөлөө, эд хөрөнгөд гэм хор учруулахгүй байх талаар хүний эрхийг хангаж, хамгаалах нь зүй ёсны хууль болох бөгөөд хүний эрхийг хангах арга зам болохыг тодорхойлжээ.

Хүний эрх гэж юу вэ?

Хүний эрх гэж ямар нэг хэм хэмжээгээр тогтоогдож, хүлээн зөвшөөрөгдсөн хувь хүний чөлөөт байдал юм. Энэ нь тухайн хувь хүний хэв шинж, ахуйн онцлог, нийгэмд эзлэх байр суурь, төр, бусад хүмүүстэй харилцах харилцаагаар илэрхийлэгддэг амьдрах арга, нөхцөл юм[4].

Хүний жам ёсны эрх нь байгалиас заяасан хүний амьдрах, үр удамтай байх эрх зэрэг хүнийг байгалийн бүтээгдэхүүн учраас түүний төрөлхийн заяамал хэрэгцээнээс эх үндэстэй, бичигдээгүй хуулиар зөвшөөрөгдсөн зан үйлийн боломж юм. Жам ёсны эрх гэдэг нь төрөөс тогтоож болохгүй эрхүүд болно. Хүний жам ёсны эрхэд хүний амьд явах, амьдрах, эрүүл аюулгүй орчинд аж төрөх, халдашгүй чөлөөтэй байх, гэр бүл, үр хүүхэдтэй байх зэрэг эрх хамаарна[5].

Тиймээс хүний жам ёсны эрх буюу хүний төрөлхийн хэрэгцээний нэг хэсэг нь өөрийгөө илэрхийлж, бусадтай харилцах хэрэгцээ мөн юм. Энэ агуулгын хүрээнд авч үзвэл хүн байгалийн амьтныхаа хувьд өөрийгөө илэрхийлэх хэрэгцээ шаардлага үүсэх бөгөөд энэ хэрэгцээ шаардлагыг гагцхүү үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Жам ёсны эрхийн бодит илэрхийлэл болох “амьдрах эрх” гэдэг бол хүн бүр өөрийгөө мэдэж, өөрийн амьдрал, хөгжил дэвшилдээ шийдвэр гаргах, оролцох эрхтэй байхаар тодорхойлогддог[6]. Энэхүү оролцох эрхийн хүрээнд хүн өөрийн үзэл бодлоо аливаа хэлбэрээр илэрхийлэх эрх, чөлөө хангагдах учиртай.

Өөрийн гэсэн итгэл үнэмшилтэй байх түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр тогтоож, үүнийг үндэсний хууль тогтоомж тэр дундаа Үндсэн хуульдаа тусгаж өгснөөр хүний эрх, эрх чөлөөний үндсэн баталгаа бүрэлддэг гэж үзэж болно.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь ардчилсан нийгмийн үнэт зүйл бөгөөд Монгол Улс Ардчилсан улс болохынхоо хувьд “Үндсэн хууль[7]”-ийн 16 дугаар зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх, мэдээлэлтэй байх эрхийг баталгаажуулсан байдаг.

Хүний эрхийг хамгаалах, хөхүүлэн дэмжихийн үндэс болсон ил тод байдал, хариуцан тайлагнах зарчмыг хэрэгжүүлэхэд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь зайлшгүй чухал нөхцөл болно. Жишээлбэл: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь

[4] Ж:Бямбадорж. Хууль сахиулагч ба хүний эрхийн асуудал илтгэл, “Хууль сахиулах үйл ажиллагаа ба Онол, практикийн тулгамдсан асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал. УБ., 2017.

[5] Хүний эрхийн үндэсний комисс. Хүний эрхэд суурилсан хандлага-Сургалтын гарын авлага. УБ., 8 дахь тал.

[6] Дэвид Боаз. Либертарианизм. УБ., 2005. 91 дэх тал.

[7] Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 1992. №01.

эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, нийлэн цугларах, мөн сонгох эрхээ эдлэхтэй салшгүй холбоотой. Үзэл санааны эрх чөлөө нь онц байдлын үед ч хэзээд үл үгүйсгэж болох тийм нэг бүрэлдэхүүн хэсэг мөн.

"Хүний эрхийн түгээмэл тунхаглал[8]"-ын 19 дүгээр зүйлд "Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй: энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана" гэж тодорхойлжээ.

Хүний эрхийн онол, суурь ойлголтуудын агуулга ач холбогдлын хүрээнд дүгнэвэл товчхондоо хүн болж төрсний хувьд, заяагдсан ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамаарч, эдэлбэл зохих эрх, эрх чөлөө бөгөөд хүнийг нэр төртэй, үнэ цэнэтэй амьдрах наад захын хэрэгцээ, шаардлага оршихуйн үндэс юм. Хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүний жам ёсны эрхээс тусгаарлан, хоёрдогч хэрэгцээ гэж үзэх нь хүний нийгмийн шинж чанарыг үгүйсгэсэн хэрэг болно.

Иймд хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хүний хамгийн үнэ цэнэтэй чухал эрхийн нэг юм.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь үзэл бодлоо илэрхийлэхгүй байх эрх чөлөөг дотроо агуулж байдаг. Үзэл бодолтой байх, үзэл бодолгүй байхыг албадах аливаа хэлбэрийн оролдлого хийхийг олон улсын хэм хэмжээгээр хориглосон байдаг. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүн өөрөө хүсэж илэрхийлэхээс үл хамааран хүн бүрт баталгаа нь хангагдсан байх тухай ойлголтыг илэрхийлж байна.

Английн улс төрч, судлаач Жон Стюарт Миль "эрх чөлөөг хүн бүр бусдын оролцоогүйгээр хийх зүйлээ сонгох боломж мөн" гэж тодорхойлсон байдаг. Тэгвэл хүн бүхэн өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр эдлэх, түүнийхээ төлөө аливаа нэгэн хариуцлага хүлээхгүй байх зарчмыг ойлгож болох юм.

Тэрбээр мөн "Эрх чөлөө" гэдэг бол жинхэнэ утгаараа бид өөрсдийн үйл хэргээ өөрсдийн хүслээр гүйцэтгэхдээ бусдын үйл хэргийг үгүйсгэхгүй, түүнд нь саад тотгор учруулахгүй байх явдал мөн гэжээ. Үүнээс харахад хүн бусдын эрх, эрх чөлөөнд халдахгүй л бол хүссэн зүйлээ хийж эрх чөлөөтэй байх эрх нь мөн л хүний өөрөө өөрийгөө мэдэх эрхэд нь үндэслэнэ гэсэн үг юм[9].

Эрх зүйт төр, хууль дээдлэх ёсны амин сүнс нь төрийн үйл ажиллагааг хязгаарлах замаар нийгмийн бүлэг болон хувь хүний үндсэн эрхийг хамгаалахад оршино[10]. Нэгэнт хүний эрхийг хамгаалах арга, механизм нь өөрөө хүний эрхийг хязгаарлах юм бол ямар нөхцөлд эрх, эрх чөлөөг хязгаарлах шаардлагатайг судлах нь зүйн хэрэг.

Хүн бүрийн эрхийн хязгаар нь нийгмийн бусад гишүүдэд эрхээ эдлэх боломжийг баталгаажуулахад орших бөгөөд энэ зааг хязгаарыг гагцхүү хуулиар тодорхойлно[11].

[8] Хүний эрхийн түгээмэл тунхаглал. Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. Уб., 1998. 3 дахь тал.

[9] Др.Найжель Ашфорд. Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд. УБ., 2007. 43 дахь тал.

[10] F.A.Hayet., Law, Legislation and Liberty, vols.1-3, Chicago, 1973-1979.

[11] Х.Тэмүүжин. Х.Jus Frast буюу ёст үг. УБ., 2005.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөний тухайд профессор О.Мөнхсайхан "..уг эрх чөлөө нь туйлын эрх чөлөө биш боловч эдгээрийг зохицуулсан зохицуулалт ялангуяа хязгаарласан аливаа зохицуулалт нь Үндсэн хуулийн болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын гол нөхцөлийг хангасан байх ёстой[12] гэсэн нь энэхүү эрх, эрх чөлөөний хэмжээ хязгаарыг тодорхойлж өгсөн.

Хүний жам ёсны эрхийн хувьд үзэл бодлоо аливаа хэлбэрээр илэрхийлэх эрхийг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр эдлэх эрхтэй боловч хэтийдсэн эрх хэмжээг хязгаарлах олон улсын стандартыг тогтоох нь зүй ёсны хэрэг юм. Тиймээс тэрхүү эрхийг зайлшгүй хязгаарлах нөхцөлийг онолын хувьд Ёорг Паул Мюллер "Хүний эрх, үндэсний аюулгүй байдал" гэх олон улсын симпозиумд тавьсан илтгэлдээ "үндсэн эрх, үндэсний аюулгүй байдлын зорилтуудтай харшилдах тохиолдолд юуны өмнө хүний эрх, эрх чөлөө хөндөгдөнө. Төрөөс хүний эрхийг хэр зэрэг хязгаарлаж болох вэ гэсэн асуудлыг шийдвэрлэх талаар маргаантай байгаа" хэмээн цохон тэмдэглээд үндсэн эрхийг хязгаарлаж болох дараах үндэслэлийг дэвшүүлсэн.[13] Үүнд:

1. Гагцхүү хуулийн үндсэн дээр
2. Үндсэн хуулийн өөр заалтад захируулж
3. Харьцангуйгаар
4. Үндсэн эрхийн цөм хэсгийг хөндөхгүйгээр
5. Хууль цаазат төрийн ямар нэг ерөнхий зарчмыг зөрчихгүйгээр хязгаарлаж болох тухай санал гаргасан байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын үзэл бодолтой байх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан 19 дүгээр зүйлд Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн хорооны 2011 оны 102 дугаар чуулганаар 34 дүгээр Ерөнхий тайлбарыг баталсан.

Энэхүү Ерөнхий тайлбарт үзэл бодолтой байх эрх нь "хүний өв тэгш хөгжлийн зайлшгүй нөхцөл бөгөөд эдгээр нь аль ч нийгмийн язгуур мөн чанар, аливаа чөлөөт ардчилсан нийгмийн тулгын чулуу мөн" гэж заасан[14].

Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактад нэгдэн орсон улс орнууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөнд хязгаарлалт тавихдаа уг эрхэд өөрт нь аюул учруулж болохгүй талаар уг тайлбарт сануулжээ. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд тавьсан аливаа хязгаарлалтыг хуулийн хүрээнд хийсэн гэдгээ НҮБ-ын гишүүн орнууд заавал нотлох үүрэгтэй байдаг.

Хязгаарлалтыг хамгийн бага хэмжээнд, тохирсон хязгаарлалт тогтоох зарчмыг баримтлан тогтоох бөгөөд хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоохдоо хууль тогтоомжоор тогтоох, тохирсон хэмжээг оногдуулах, зайлшгүй шаардлагатайг нотолсон байх гэсэн 3 шаардлагыг хангасан байх ёстой.

---

[12] О.Мөнхсайхан. "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь", эрх зүй сэтгүүл дугаар 38/2. УБ., 2017. 2 дахь тал.

[13] П.М.Ёорг. "Хүний эрх ба улс орны дотоод, гадаад аюулгүй байдлын асуудлууд /хүний үндсэн эрхийг хязгаарлах асуудлууд/, Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал-Олон улсын симпозиум. УБ., 1998. 75-76 дахь тал.

[14] Хүний эрхийн хороо, НҮБ. Ерөнхий тайлбар №34 албан бус орчуулга 2011.

Мөн Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүний эрхийн хороо 101 дэх хуралдаанаар Монгол Улсын засгийн газрын Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн тухай ээлжит тайланг хэлэлцээд Монгол Улсын Засгийн газарт "...сэтгүүлчийг аливаа сүрдүүлэг, заналхийлэл, халдлагын аливаа тохиолдлыг хуулийн дагуу мөрдөн шалгаж, гэмтэнд хариуцлага хүлээлгэхэд" анхаарал хандуулах зөвлөмж ирүүлснийг анхаарах нь зүйтэй юм.

Эдгээрээс үзвэл хүний эрх тэр дундаа үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хүн байх суурь хэм хэмжээг илэрхийлэгч бөгөөд нэгэнт хүн нийгмийн амьтан, нийгмийн бүтээгдэхүүн болохын хувьд тэрхүү нийгмийн хөгжил, хөдөлгөөн, өөрчлөлтөд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, тэрхүү эрхээ өөрийн сонгосон арга замаар бусдад түгээх нь салшгүй хэрэгцээ болж байна.

Иймээс үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө нь олон улсын хэм хэмжээгээр хамгаалагдсан халдаж үл болох эрх бөгөөд аливаа нэгэн байдлаар уг эрхэд хязгаарлалт тогтоох шаардлагатай бол түүний үндэслэл шаардлагын тухай НҮБ-ийн өмнө нотолж байж, хуулиар хязгаарлалт хийх боломжтойг санах нь зүйтэй.

Манай улс НҮБ-ын гишүүн болохын хувьд олон улсын хэм хэмжээг дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил хэрэгжүүлэх зарчмын дагуу үндэсний хууль тогтоомжоор хүний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хамгаалж ирсэн.

Шинэчлэн найруулсан эрүүгийн хуулиар "Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол[15]" гэж тодорхойлсон байна.

Энэ нь өмнөх эрүүгийн хуулийн тодорхойлолттой харьцуулахад өргөн агуулга бүхий, хамгаалагдах харилцааг өргөтгөсөн зэргээрээ хүний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах хууль зүйн нэг арга хэрэгсэл болсон гэж үзэж байна.

Хүн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө олон нийтийг хамарсан хурал, зөвлөгөөн, жагсаал, цуглааны үеэр үг хэлж, хэвлэл, мэдээллийн газруудаас зохион байгуулдаг нэвтрүүлэг, ярилцлагад оролцон мэдээллийн хэрэгслээр дамжуулан өөрийн бүтээл туурвилаа хэвлэн нийтлүүлэх замаар энэхүү эрхээ эдэлдэг нийтлэг шинжтэй.

Тиймдээ ч үзэл бодлын илэрхийлэл, хэвлэн нийтлүүлж байгаа бүтээл нь бодит байдалд нийцсэн, үнэн байх ёстой. Ингэснээр үзэл бодлоо илэрхийлэх эрхийг дан ганц хүний заяамал эрх гэсэн өнгөөр бус харин нийтийн ашиг сонирхол, нийгмийн сайн сайханд чиглэсэн нийгмийн шударга ёсны суурь гэж ойлгож болно[16].

Шударга үнэний төлөө үзэл бодлоо илэрхийлж эрх чөлөөгөө эдэлсэн хүнийг буруутгах, ажил албан тушаалаас халах, өөрчлөх, ажилд

[15] Монгол Улсын Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2016. №07.

[16] Х.Дорждалам. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, тусгай анги. УБ., 2021. 79 дэх тал.

авахгүй байх, тэтгэвэр тусламж, цалин хөлс, шагнал урамшуулал, амарч сувилуулах, сурч боловсрох, элдэв хөнгөлөлт авах эрхийг хасах зэрэг нь хүнийг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхсан үйлдэл бөгөөд ийм төрлийн үйлдлийг хүлээн зөвшөөрч хэрхэвч болохгүй.

Шинэчилсэн эрүүгийн хуульд заасан "Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах" гэмт хэргийн онцлог нь тухайн гэмт хэргийн хохирогчийг тодорхойлохдоо холбогдох хууль (Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль гэх мэт) тогтоомжийн хүрээнд хэвлэн нийтлэх эрхээ хэрэгжүүлсэн хэвлэн нийтлэгч байх агуулгыг илэрхийлсэн явдал юм.

"Хэвлэн нийтлэгч" гэдгийг судлаач С.Гантулга, Б.Энхболд нар дараах байдлаар авч байна. Үүнд:

"Сэтгүүлч" гэж гадаадын зарим улсын хууль тогтоомжоор хөдөлмөрийн буюу бусад гэрээний харилцаагаар холбогдсон, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээс олгосон бүрэн эрхийн дагуу үйл ажиллагаа эрхэлж буй бүртгэгдсэн, хэвлэл мэдээллийн редакцид мэдээ, мэдээллийг хянан тохиолдуулах, бүтээх, цугларуулах буюу бусад бэлтгэх ажил эрхэлж буй этгээдийг хэлнэ[17].

"Нийтлэгч" гэж тодорхой нэг хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаггүй боловч нийгэм, улс төрийн шинжтэй, цаг үеийн тулгамдсан асуудлаар өөрийнхөө үзэл бодол иргэний байр суурийг илэрхийлж, тодорхой баримт мэдээллийн хүрээнд эргэцүүлэн бодож, үнэлэлт, дүгнэлт өгч, түүнд олон нийтийн анхаарлыг хандуулж, сэтгэл зүйд нь нөлөөлөх зорилгоор нийтлэл зүйн бүтээлийг туурвидаг хүнийг хэлнэ[18].

Эдгээр нь агуулгын хувьд үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөгөө эдэлж байгаа субъект болох бөгөөд этгээд нь дээрх байдлаараа чөлөөт бичигчээс ялгарах шинжтэй бөгөөд тодорхой хууль тогтоомжоор зохицуулагдсан харилцаанд чиглэгдэхээр байна.

Гэмт хэргийн тодорхой шинжийг дээрх байдлаар тодорхойлсон нь хүний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг шинэ шатанд гаргахад чиглэсэн, хэвлэн нийтлэгчийн эрхийг хангасан шинэлэг зохицуулалт болсон юм.

Өмнөх буюу 2002 оны эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд "Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад учруулах[19]" гэмт хэргийг тодорхойлохдоо "Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол, албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол" гэж тодорхойлсон.

Үүнээс үзэхэд гэмт хэргийн үйлдлийн шинж, гэмт үйлдэл, хуулиар хамгаалагдах этгээдийг явцуу утгаар тодорхойлсон байна.

Хүснэгт 1. Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах гэмт хэргийн гэмт хэргийн бүрэлдэхүүнд хийсэн

[17] С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг /хоёр дахь хэвлэл/. УБ., 2008. 389 дэх тал.

[18] Чөлөөт нэвтэрхий толь-Википедиа. http//mn.wikipedia.org/.

[19] Монгол Улсын Эрүүгийн хууль // Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2002. №05.

шинжилгээ. 2002 оны болон 2015 оны эрүүгийн хуулийн хүрээнд

№	Гэмт хэргийн бүрэлдэхүүн	2002 оны эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйл	2015 оны эрүүгийн хуулийн 14.3 дугаар зүйл	Ялгаа нь
1	Объект	Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаа, Үндсэн хуульд зааснаар нуцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрх	Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх	Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаа ба итгэл үнэмшилтэй байх үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үг хэлэх хэвлэн нийтлэх эрхийг хэрэгжүүлэгч хэвлэн нийтлэгчийг хамааруулсан
2	Объектив тал	Субъект өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийсэн идэвхтэй үйлдэл, эс үйлдэл байна. Саад хийх нь сүрдүүлэх, зөвлөх, гуйх, дарамтлах, амлалт өгөх хэлбэртэй байж болно	Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн идэвхитэй үйлдэл байна	Хэвлэн нийтлэгчид нөлөөлж болох гэмт хэргийн үйлдлийн шинжийг өргөн хүрээгээр авч үзсэн
3	Субъект	Нийтлэг субъекттэй	Нийтлэг субъекттэй	Гэмт хэргийн субъектийн хувьд ижилхэн хуульчлагдсан.
4	Субъектив тал	Шууд санаатай, Өөрийн болон бусдын нэр төрийг хамгаалах гэсэн сэдэлтэй	Шууд санаатай, өөрийн үйлдлийг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж, түүнийг хүсэж үйлдсэн байх	Субъектив талын шинжийг ижил тодорхойлсон.

Энэхүү харьцуулалтаас үзэхэд эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар энэ гэмт хэргийн үйлдлийн шинж болон халдлагад өртөгчийг өргөтгөн тусгаснаар зөвхөн сэтгүүлч бус хууль ёсны дагуу өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг эдэлж байгаа хэнийг ч энэ хуулиар хамгаалах боломж бүрдсэн байна.

Дан ганц эрүүгийн хууль тогтоомжоор хүний хэвлэн нийтлэх эрх чөлөөг бүрэн хангаж, баталгаажуулах

боломжгүй бөгөөд дотоодын бусад хууль тогтоомжоор мөн дархлаажуулдаг билээ. Тухайлбал “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль”, “Харилцаа холбооны тухай хууль”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Өргөн нэвтрүүлгийн тухай хууль” зэргээр хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

Дээрх хууль тогтоомжууд нь төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөгөө хэрэгжүүлэгчийн эрх, эрх чөлөөнд нөлөөлөх, түүний хүрээ хязгаар, суурь зарчмуудыг тодорхойлно.

Тэгвэл энэ гэмт хэргийн нөхцөл байдал ямар түвшинд байгааг судлан үзье. Цагдаагийн ерөнхий газрын статистик тоо баримтаас үзэхэд эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлсэн үеэс буюу 2018 онд 6, 2019 онд 3, 2020 онд 5 гэмт хэрэг бүртгэгдсэн байх бөгөөд эдгээр нь тус бүлэгт заасан 9 гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэсэн дундаж тоо юм[20].

Гэхдээ энэ гэмт хэрэг бүртгэгдээгүй нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдээгүй байна гэж үзэж болохгүй. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийн хэрэгжилт хангалттай байна гэж үзэх үндэслэл биш бөгөөд гэмт хэргийн зүйлчлэл болоод үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд хандах хандлагаас шалтгаалан эрүүгийн хэрэг үүсгэж шалгахгүй байх, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанарыг үгүйсгэж байгаа хэрэг юм.

Нийгэмд энэ гэмт хэргийн хохирогч ихэвчлэн хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлч, нийтлэгч, редакцын ажилтан байх боломжтой байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт тавихгүй байхаар заасан ч төр, түүний байгууллага, албан тушаалтан мэдээ мэдээллийн агуулгад нөлөөлсөөр байна.

Тухайлбал 2011 оноос хойш Монгол Улсын Засгийн газраас уламжлалт болон цахим хэвлэл, мэдээлэлтэй холбоотой бодлогын гол баримт бичгүүд баталж Харилцаа холбооны зохицуулах хорооноос баримт бичгүүдийн биелэлтийг хангах хүрээнд мэдээллийн агуулгын зохицуулагчийн үүрэг гүйцэтгэх болсон ба Засгийн газраас 2013 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр “Цахим хуудас дахь сэтгэгдлийн нэгдсэн систем”-ийн тухай 01 тоот тогтоол, үүнд үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо “Сайтууд дахь сэтгэгдлийн харилцааг зохицуулах журам”-ыг 2013 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан.

Энэ мэтчилэн олон нийтийн мэдээллийн хэрэгслийн мэдээ, мэдээлэл, түүнд хандаж иргэд, хэвлэн нийтлэгчээс үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх Үндсэн хуулийн үзэл баримтлал, олон улсын хэм хэмжээтэй зөрчилдөж байгаа эрх зүйн актуудыг тогтоон баталж байгаа нь харамсалтай[21].

[20] Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2018, 2019, 2020 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. http//police.gov.mn/

[21] Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө. Хүний эрхийн ээлжит түгээмэл хэлэлцүүлэг, 22 дугаар хуралдаан. Женев., 2015.

Үүнээс гадна Глоб Интернэшнл төвөөс 2018 онд хийсэн “Сэтгүүлчдийн аюулгүй байдлын түвшин тогтоох” судалгаагаар 300 сэтгүүлч тутмын 52 хувьд редакцийн зүгээс нийтэлж, нэвтрүүлж буй зүйлтэй нь холбогдуулан цензурь тогтоодог гэж хариулжээ.

Мөн төвөөс гаргасан судалгааны дүнгээс үзэхэд 300 сэтгүүлч тутмын 52 хувь буюу 150-аас илүү нь энэ гэмт хэргийн хохирогч байх магадлалтай байгаа нь цаашид “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” гэмт хэргийн нийгэмд үзүүлэх хор аюул, сөрөг нөлөөлөл нь улам газар авах шинжтэй байгааг бүрэн тодорхойлж байна[22].

Энэ нь манай улсад сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд хууль бусаар халддаг цаашлаад эрүүгийн хуульд заасан үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид нийцэхгүй үйлдлүүд байсаар байгааг харуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2020 онд эрүүгийн хуульд өөрчлөлт оруулж “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг хуульчилсан нь хэвлэн нийтлэгчийн үйл ажиллагаанд маш том хязгаарлалт болсон билээ.

2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс хойш 2021 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар нийт 8 хүний эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл буюу “Худал мэдээлэл тараах” гэсэн зүйлээр шийтгэсэн байна[23].

“Худал мэдээлэл тараах” тухай ойлголт, тодорхойлолт байхгүйн улмаас эрх бүхий албан тушаалтан өөрийн үзэмжээр шийдэж, шийтгэл оногдуулах зэргээр ашиглах эрсдэлтэй юм.

Эрүүгийн хуулийн 13 дугаар бүлгийн 13.14 дэх зүйлд “Худал мэдээлэл тараах” гэмт хэргийг “хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол” гэж тодорхойлсон нь хэвлэн нийтлэгч өөрөө эрүүгийн хариуцлагад татагдах нөхцөлийг бүрдүүлж байна. Гэтэл тэрхүү мэдээллийг худал эсэхийг тогтоох хуулийн зохицуулалт, шалгуур үзүүлэлтийг хууль тогтоомжоор тогтоогоогүй байна.

“Хил хязгааргүй сурвалжлагчид” олон улсын байгууллагаас дэлхийн улс орнуудын хэвлэлийн эрх чөлөөний индексийг тодорхойлсон байна. 2021 оны 05 дугаар сарын 03-ны байдлаар дэлхийн 180 орноос 68 дугаарт Монгол Улс жагсаж, “хагас эрх чөлөөтэй” буюу “мэдэгдэхүйц асуудалтай орны жагсаалт”-д багтсан хэвээр байгаа нь дээрх тохиолдлын нэг адил ноцтой асуудлууд байгааг нотолсон хэрэг юм.

Нэг жишээ дурдвал:

“Амжилт.ком” цахим хуудас 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдөр “Ерөнхий сайдын “Хаан жимс” амралтын газар Туул гол руу бохироо асгаж байна” гэсэн мэдээллийг байрлуулан олон нийтэд түгээсний улмаас дараагийн өдөр нь тус сайтад хандах дотоодын хандалтыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос зогсоосон.

Шүүхэд гаргасан гомдлын дагуу Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2014 оны 12 дугаар сарын 18-

[22] Б.Пүрэвсүрэн, М.Оюунхорол. “Хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт ба цензур” өгүүлэл. Хүний эрх сэтгүүл. УБ., 2021. №01. 58 дахь тал.

[23] Шүүхийн шийдвэрийн цахим сан. http//new.shuukh.mn/eruuanhan.

ны өдрийн 20 дугаар шүүхийн 615 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2015 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн магадлал, Улсын дээд шүүхийн 2015 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 120 дугаар тогтоолоор Харилцаа холбооны зохицуулах хорооны шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

Харилцаа холбооны зохицуулах хорооны шийдвэр үндэслэлгүй болох нь 3 шатны шүүхийн шийдвэрээр нотлогдсон бөгөөд сайтын хандалтыг хаасан нь үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг ноцтой зөрчсөн үйлдэл болсон юм.

Нөгөөтэйгүүр томоохон корпараци, хуулийн этгээдээс ашиг сонирхлоо хамгаалах зорилгын хүрээнд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй "хамтын ажиллагааны гэрээ"-г байгуулах болсон нийтлэг үзэгдэл газар авч байна. Тус гэрээ нь Монгол Улсын Иргэний хуулийн зохицуулалтад нийцсэн хууль ёсны үйлдэл мэт боловч үнэн хэрэгтээ хэвлэн нийтлэгчийн үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг бүдүүлгээр дарангуйлж буй хэрэг юм.

Тус гэрээний агуулгаар гэрээ байгуулсан хүн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхолд хамаарах мэдээ, мэдээллийг олон нийтэд мэдээллэх, нийтлэх эсэх асуудлыг талууд харилцан тохиролцох талаар зохицуулж байгаа нь сэтгүүлч, хэвлэн нийтлэгчийн үндэслэл бүхий мэдээллийг олон нийтэд мэдээллэхийг хязгаарлаж байгаа эрүүгийн хуулиар хамгаалагдсан харилцааг шууд зөрчиж байгаа үйл ажиллагаа билээ.

"Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах" гэмт хэргийн нөхцөл байдал далд хэлбэрт шижлин, нийгэм, олон нийтийн эрх, ашиг сонирхолд үзүүлэх хор уршиг нэмэгдсээр байгааг дээрх баримт, жишээнүүд тодхон харуулж байна.

Иймд "Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах" гэмт хэрэг тодорхой халхавчин дор улам далд хэлбэрээр үйлдэгдэх, цэцэглэн хөгжих боломжийг бүрдүүлж байгаа бөгөөд үүнийг таслан зогсоох, хязгаарлах нийгмийн хэрэгцээ шаардлага үүсээд байгаад анхаарал хандуулж, хяналт тавих цаг тулгарч байна.

Манай улсад хэвлэн нийтлэгчийн эрх чөлөөг хамгаалах буюу "Шүгэл үлээгч"-ийн эрх зүйн байдлыг хамгаалах бие даасан эрх зүйн зохицуулалт нэн шаардлагатай байна. Энэ төрлийн зохицуулалт байхгүйгээс үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэхгүй байгааг дурдах нь зүйтэй.

Хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх, хэвлэн нийтлэх эрх чөлөө нь өргөн утгаараа нийгмийн хөгжлийн хөшүүрэг болдог чухал ач холбогдолтой. Иймд энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх бодит хэрэгцээ нийгэмд бий.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь тухайн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, тодорхой судалгаа , мэдээллийн үндсэн дээр түүнийг арилгахад чиглэсэн зохион байгуулалтын цогц арга хэмжээ байх тул хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж, зөрчигдсөн тохиолдолд сэргээх, тус эрхийг хэрэгжүүлэх, хамгаалах, гэмт хэргийн далд хэлбэрийг илрүүлэх шинэ арга зүй нэн шаардлагатай байна.

Нийгэмд тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгаа эсэх, түүний цаашдын чиг хандлагыг тодорхойлохдоо гэмт явдлын түвшин буюу эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгэгдсэн болоод бүртгэгдээгүй далд хэлбэрт байгаа гэмт хэргийн түвшингээр нь тодорхойлдог.

Дүгнэлт

1. Хүний эрхийн онол, суурь ойлголтуудын агуулга ач холбогдлын хүрээнд дүгнэвэл товчхондоо хүн болж төрсний хувьд, заяагдсан ямар нэгэн ялгаатай байдлаас үл хамаарч, эдэлбэл зохих эрх, эрх чөлөө бөгөөд хүнийг нэр төртэй, үнэ цэнэтэй амьдрах наад захын хэрэгцээ, шаардлага оршихуйн үндэс юм. Хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүний жам ёсны эрхээс тусгаарлан, хоёрдогч хэрэгцээ гэж үзэх нь хүний нийгмийн шинж чанарыг үгүйсгэсэн хэрэг болно.

Иймд хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хүний хамгийн үнэ цэнэтэй чухал эрхийн нэг гэж үзэж байна.

2. Нэгэнт хүн нийгмийн амьтан, нийгмийн бүтээгдэхүүн болохын хувьд тэрхүү нийгмийн хөгжил, хөдөлгөөн, өөрчлөлтөд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, тэрхүү эрхээ өөрийн сонгосон арга замаар бусдад түгээх эрхтэй. Хүн төрөлхтний салшгүй хэрэгцээ болсон үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг дэмжин хамгаалж, зохистой хэмжээнд ёс суртахууны цензурь, шаардлагад нийцүүлэн хөхүүлэн дэмжих нь өнөөгийн нийгмийн чухал нэгэн үнэт зүйл болжээ.

3. Өмнөх буюу 2002 оны Эрүүгийн хуулийн “Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх” гэмт хэргийн объект, хохирогчийг тусгай субъект буюу зөвхөн сэтгүүлч байхаар тодорхойлж байсан нь томьёоллын хувьд харьцангуй явцуу хүрээнд авч үзсэн хэрэг байв.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” гэмт хэрэгт гэмт хэргийн объектыг өргөн хүрээнд авч үзэн, хэвлэн нийтлэгч байхаар тодорхойлсон нь түүгээр хамгаалагдах харилцааг шууд өргөтгөсөн, мөн гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын үйлдэл, эс үйлдэхүйг нарийвчилсан нь хэвлэн нийтлэгчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахад томоохон дэвшил гарсан байна гэж дүгнэж байна.

4. “Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах” гэмт хэргийн талаар тодорхой бүртгэгдсэн тоо баримт байхгүй байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг нийгэмд далд хэлбэрээр үйлдэгдэж байж болзошгүй нөхцөл байдал ажиглагдаж байна.

Иймд хүний үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн далд хэлбэрээр үйлдэгдэж байж болзошгүй нөхцөл байдалд анхаарах шаардлагатай.

Өнөөгийн үйлчилж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд манай улсад “Шүгэл үлээгч” буюу нууц эх сурвалжийг хамгаалах зохицуулалтыг бий болгох нь энэ төрлийн харилцааг хамгаалах бас нэгэн томоохон хэрэгцээ гэж үзэж байна.

Санал

1.Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд зааснаар “Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензурь/ тогтоохгүй” гэсэн хуулийн заалтыг хэрэгжүүлэх.

Үүний тулд хуулийн заалтад харшилсан журам, зааврыг хүчингүй болгох;

2.Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын улс төрөөс хараат байдлыг арилгах;

3.Нийтлэгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа үйлдлийг нарийвчлан шалгах, нийтлэгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалахад шаардлагатай эрх зүйн зохицуулалт бий болгож, сэтгүүлчийн нууц нэр ашиглах эрхийг эрх зүйн хэм хэмжээгээр баталгаажуулах;

4.Хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан, цахим хуудас, сайт, мэдээллийн цахим эх сурвалжуудын Харилцаа холбооны зохицуулах хороотой хэрхэн харилцах талаар тодорхойлсон бие даасан эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

5.Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний тухай бие даасан эрх зүйн зохицуулалт бий болгож, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилтийг хангах шаардлагатай хэмээн үзэж дээрх саналуудыг дэвшүүлж байна.

Ном зүй

Хууль тогтоомж

6. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 1992 он. №01

7. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2002 он. № 05

8. Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2016 он. №07

9. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 1998 он. №10

10.Харилцаа холбооны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2001 он. №43

11.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2011 он. №26

Сурах бичиг, нэг сэдэвт бүтээл, гарын авлага

12.Дэвид Боаз. Либертарианизм. УБ., 2005 он.

13.Х.Дорждалам. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй, тусгай анги. УБ., 2021 он.

14.Г.Гантөмөр, С.Гантулга нар. Эрүүгийн эрх зүй ерөнхий анги. УБ., 2020 он.

15.С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг /хоёр дахь хэвлэл/. УБ., 2008 он.

16.Хүний эрхийн түгээмэл тунхаглал. Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. Уб., 1998 он.

17.Др.Найжель Ашфорд. Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд. УБ., 2007 он.

18.Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл

19.О.Мөнхсайхан. “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь”, эрх зүй сэтгүүл дугаар 38/2. УБ., 2017 он.

20.Х.Тэмүүжин. X.Jus Frast буюу ёст үг. УБ., 2005 он.

21.Б.Пүрэвсүрэн, М.Оюунхорол. “Хэвлэн нийтлэх эрх чөлөөний хэрэгжилт ба цензур” өгүүлэл. Хүний эрх сэтгүүл. УБ., 2021 он. №01

22.П.Доржсүрэн. Жонн Локкын улс төрийн үзэл баримтлал. Улс төрийн боловсролын академийн онол-арга зүйн сэтгүүл., УБ 1994. №2

23.П.М.Ёорг. “Хүний эрх ба улс орны дотоод, гадаад аюулгүй байдлын асуудлууд /хүний үндсэн эрхийг хязгаарлах асуудлууд/, Хүний эрх ба үндэсний аюулгүй байдал-Олон улсын симпозиум. УБ., 1998 он.

24.Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө. Хүний эрхийн ээлжит түгээмэл хэлэлцүүлэг, 22 дугаар хуралдаан. Женев., 2015 он.

Цахим эх сурвалж

25.Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2018, 2019, 2020 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ. http//police.gov.mn/

26.Чөлөөт нэвтэрхий толь-Википедиа. http//mn.wikipedia.org/

27.Шүүхийн шийдвэрийн цахим сан. http//new.shuukh.mn/

ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН ЗАРИМ ШАЛТГААН НӨХЦӨЛ

SOME CAUSES AND CONDITIONS OF CYBERCRIME

Т.Туяа
Цагдаагийн сургуулийн сургалтын арга зүйч, цагдаагийн дэд хурандаа
T.Tuya
Training methodologist of Police school, police lieutenant colonel

Хураангуй: Нийтлэлд мэдээллийн технологийн тусламжтайгаар боловсруулагдсан мэдээлэл виртуал орчинд компьютерын систем, сүлжээг мэдээллийг задруулах, тэдгээрийн техник хангамж, программ хангамж, цахим өгөгдлийг санаатайгаар хулгайлах, гэмтээх, түүнчлэн үйлчилгээг тасалдуулах, буруу чиглүүлэхээс хамгаалах үндсэн ойлголтыг холбогдох эрх зүйн актуудад нэмэлт өөрчлөлт оруулах нь тулгамдсан асуудлыг нэг мөн.

Abstract: In this article, we have focused on how information processed in a virtual environment with the help of information technology can be used to disclose information about computer systems and networks, their hardware, software, and theft of electronic databases, as well as to protect services from interruptions and misdirection. It is important to study the issue of amending the legal acts related to the above basic concepts.

Түлхүүр үг: Мэдээллийн технологи, техник хангамж, программ хангамж, кибер аюулгүй байдал, кибер халдлага, кибер гэмт хэрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг.

Key words: Information technology, hardware, software, cyber security, cyber attack, cybercrime, crimes against cyber security or information technology security

Оршил

XXI зуун бол мэдээлэл технологийн эрин үе юм. **Мэдээллийн технологи** гэдэг нь Америкийн Мэдээллийн Технологийн Холбооны (ITAA) тодорхойлсноор “Компьютер дээр суурилсан мэдээллийн систем, программ хангамж болон техник хангамжийн дизайн, хөгжүүлэлт, хэрэгжүүлэлт, хангамж болон удирдлагыг судлахыг хэлнэ".

Мэдээллийн технологи нь цахим тооцоолуур болон программ хангамжийг ашиглан мэдээллийг хувиргах, хадгалах, хамгаалах, боловсруулах, дамжуулах болон найдвартайгаар хүлээн авах тухайг судалдаг. Мэдээллийн технологи нь одоо дэлхийг хавтгайруулагч хүчин зүйл болоод байгаа бөгөөд дэлхийн хөгжлийг тодорхойлогч тэргүүн эгнээний хүчин зүйл болж байна. Мэдээллийн технологи (МТ) нь ихэвчлэн бизнес болон бусад аж ахуйн нэгжийн хүрээнд өгөгдөл дамжуулах, удирдаж, хадгалах, хүлээн авах компьютерын программ мөн харилцаа холбооны хэрэгсэл юм. Энэ нэр томьёог компьютер, компьютерын сүлжээ гэдэгтэй адил үг болгон ихээхэн ашигладаг ч мэдээллийн технологи нь бусад мэдээлэл түгээх технологиуд болох телевиз, ухаалаг утас, хиймэл дагуул зэргийг хамруулдаг. Компьютерын техник хангамж, программ хангамж, цахилгаан хэрэгсэл, хагас дамжуулагч, интернэт, харилцаа холбооны тоног төхөөрөмж, цахим худалдаа, компьютерын үйлчилгээг агуулсан мэдээллийн технологитой холбогдсон байдаг.

Ойролцоогоор МЭӨ 3000 жилийн тэртээд Месопотами дахь Шумерчууд бичиг үсэг бий болгосноос эхлэн хүн төрөлхтөн мэдээллийг хадгалах, олборлох, ашиглах мөн мэдээлэл солилцох болсон боловч мэдээллийн технологи гэх нэр томьёог анх 1958 онд “Харвардын Бизнесийн тойм” сэтгүүлийн нийтлэлд Харолд Ж Леавит

болон Томас Л Вислер нар бичсэн бөгөөд “энэ шинэ технологид одоогоор тогтсон ганц ч нэр байхгүй байна. Бид үүнийг мэдээллийн технологи гэж нэрлэх хэрэгтэй.” гэсэн байдаг. Тэдний тодорхойлолт гурван хэсгээс бүрддэг. Тэдгээр нь: боловсруулах арга, шийдвэр гаргах статистикийн болон математикийн арга замын программ мөн компьютерын программаар дамжуулан өндөр сэтгэхүйн загварчлал юм. Мэдээллийг хадгалах ба боловсруулах технологийн ажиллагаан дээр тулгуурлан МТ-ийн хөгжлийг дараах дөрвөн ялгаатай үе шатуудад хуваах боломжтой. Механикаас өмнөх (МЭӨ 3000-МЭ 1450), механик (1450-1840), электромеханик (1840-1940), электрон (1940-одоог хүртэл)[1].

Үндсэн хэсэг

1996 онд интернэт хэрэглэгчдийн тоо Монгол улсад 500 гаруй байсан бол 2020 онд интернэт хэрэглэгчдийн тоо 3,941,700 болон өссөн явдал манай улсын ихэнх хэрэглэгч цахим орчинд эрх зүйн харилцаанд оролцож байна. Цаашид энэхүү хэрэглэгчдийн тоо нэмэгдэхийн хэрээр цахим орчинд[2]: кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох үйл ажиллагааг хэрэгжүүлдэг төв, нэгжийг хууль сахиулах байгууллагын бүтцэд ажиллуулах нь зүйтэй.

Компьютерын аюулгүй байдал, кибер аюулгүй байдал, мэдээллийн технологийн аюулгүй байдал (МТ-ийн аюулгүй байдал) нь компьютерын систем, сүлжээг мэдээллийг задруулах, тэдгээрийн техник хангамж, программ хангамж, цахим өгөгдлийг санаатайгаар хулгайлах, гэмтээх, түүнчлэн үйлчилгээг тасалдуулах, буруу чиглүүлэхээс хамгаалах явдал юм.

Манай улсын хувьд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д мэдээллийн аюулгүй байдлыг үндэсний аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн хэмээн тодорхойлсон хэдий ч кибер аюулгүй байдлын индексийн гол үзүүлэлт болох хууль эрх зүйн орчин бүрдээгүй, үндэсний кибер халдлага, зөрчлөөс сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллага байхгүй, хамтын ажиллагаа дутмаг зэрэг үндэслэлээр 2017 онд 104 дүгээр байранд, 2018 онд 85 дугаар байранд эрэмбэлэгдсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Хувь хүний мэдээлэл /өгөгдөл/-ийг хамгаалах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төслийг шинээр боловсруулах, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийг хангах тухай хуулийг шинэчлэн найруулж, УИХ-ын 2021 оны намрын чуулганаар хэлэлцэн батлуулсан.[3]

Кибер гэмт хэрэг нь үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгт тооцогддог бөгөөд дэлхийн эдийн засагт жилд дунджаар 1 их наяд орчим ам.долларын хохирол учруулдаг аж. Уг гэмт хэргийг үйлдэгчдийн тоо жил бүр нэмэгдэж, арга хэлбэр нь илүү боловсронгуй болсоор байна. Иймд кибер гэмт хэрэг гэж юу болох, түүний онцлог шинж чанар, гэмт этгээдүүдийн үйл ажиллагааны талаар ойлголт, мэдээлэлтэй болсноор хохирогч болохоос урьдчилан сэргийлэх боломжтой.[4]

Олон улсад кибер гэмт хэрэг гэдэгт: Cyber attack-Кибер халдлага, Phishing-фишинг, Internet Fraud-онлайн мөрдлөг, заналхийлэл, Skimming-картны гэмт хэрэг, Online gift cart fraud-онлайн залилан, садар самуун дүрс бичлэг тараах, интернэтэд суурилсан оюуны өмчийн эсрэг гэмт хэргүүдийг багтаан ойлгодог ба Кибер гэмт хэргийн талаарх ойлголт нь Монгол Улсын

[1] https://en.wikipedia.org/wiki/
[2] http://www.1212.mn/
[3] www.parliament.mn
[4] https://gia.gov.mn/49/item/643/

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 26 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн төрлүүдээр хязгаарлагддаггүй.

Манай Улсын хувьд цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн тоо сүүлийн жилүүдэд харьцангуй өссөн үзүүлэлттэй байгаа нь цахимжсан өнөөгийн нийгэмд хэн бүхэн аюулд өртөх магадлал өндөр болж байгааг харуулж байна.

Цахим сүлжээний эрх зүйн зохицуулалтаас "Зохиогчийн эрхийн гэрээ", Дэлхийн оюуны өмчийн байгууллага 1996 он, "Цахим худалдааны талаарх загвар хууль", Нэгдсэн үндэстний байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн хороо. 1996 он, "Нууцлалын бодлогын удирдамж" Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага. 1997 он, "Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглах тухай" Нэгдсэн үндэсний байгууллагын Ерөнхий Ассамблей 2005 он зөвлөмж, "Электрон хэлцлийн тухай" жишиг хууль НҮБ-ын олон улсын худалдааны байгууллага-ууд холбогдох эрх зүйн актуудыг батлан гаргаж мөрдөж байна[5]. Будапешт хотын 2001 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн "Цахим гэмт хэргийн тухай конвенц"-д Эрүүгийн салбарын хамтын ажиллагааны талаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа Европын Зөвлөлийн конвенцууд, тэдгээрт нийцсэн гишүүн болон бусад орнуудын хооронд байгуулагдсан хүчин төгөлдөр үйлчилж буй бусад ижил төстэй гэрээг харгалзан үзэж, тэдгээрт энэхүү Конвенц нь компьютерын сүлжээ, мэдээлэлтэй холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах, зүйлчлэх, гэмт хэргийн цахим нотлох баримтыг цуглуулах ажиллагааг зохицуулсан нэмэлт болохыг онцлон тэмдэглэж, Цахим гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын харилцан ойлголцол, хамтын ажиллагаа, үүний дотор НҮБ, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Европын холбоо, "Их 8"-ын хэрэгжүүлж буй үйл явдлуудыг сайшаасан байдаг. Тус конвенц нь компьютерын сүлжээ сүлжээ, мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, ашиглалтын эсрэг шууд чиглэсэн халдлагыг таслан зогсоох, тийм халдлагыг гэмт хэрэг болгон хуульчлах, түүнийг дотоодын болон олон улсын түвшинд илрүүлэх, мөрдөх, яллах, тийм гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй хууль тогтоомж батлах, холбогдох олон улсын итгэмжлэгдсэн, шуурхай хамтын ажиллагааг сайтар зохион байгуулахад чухал болохыг хүлээн зөвшөөрсөн.

Олон улсын түвшинд эрх зүйн зохицуулалт хийх зарим оролдлогууд хийгдэхийн хажуугаар улс орнууд дотоодын эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлсээр байна. Интернэт сүлжээний тархац дэрхийн дахинд харилцан адилгүй байгаа бөгөөд АНУ, ЕХ, ИБУИНВУ, Япон, БНСУ зэрэг хөгжингүй орнуудад интернэт хэрэглээн дэх эрх зүйн зохицуулалт нь харьцангуй өндөр түвшинд хөгжиж байна.

Санал

Цахим орчин дахь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс хяналт, шүүлтүүр тавьж хэрэгжүүлэх. Олон хандалттай цахим хуудас байвал түүнийг бүртгэдэг, мэдээллийг нь хянадаг, худал эсэхийг шүүдэг Хяналтын институт бий болгох,

Мэдээллийн технологийг ашиглахад хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай бөгөөд цахим гэмт хэрэгтэй тэмцэхэд төрийн байгууллага болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангах,

Шүүлтүүрийн программ хангамж нь бүх төрлийн онлайн халдлагаас хамгаалах, насанд хүрэгчдийн бооцоот тоглоом гэх мэт цахим хуудас руу хандалтыг хязгаарлахын тулд мэдээллийн сан нь байнга

[5] В.Амартүвшин, Цахим сүлжээний үүсэл ба цахим хэлцэл, Хууль дээдлэх ёс сэтгүүл №1(2021), 41 дэх тал

шинэчлэгддэг, интернэтийн орчинг хянах боломжтой.

Ашигласан материал:

1. Монгол улсын Эрүүгийн хууль, УБ. 2017 он
2. Монгол улсын Зөрчлийн тухай хууль, УБ. 2017 он
3. Кибер аюулгүй байдлын тухай хуулийн төсөл, УБ. 2021 он
4. Цахим гэмт хэргийн тухай конвенц, Будапешт хот, 2001 он
5. В.Амартүвшин, Цахим сүлжээний үүсэл ба цахим хэлцэл, Хууль дээдлэх ёс сэтгүүл №1(2021)
6. https://www.gia.gov.mn//
7. http://www.1212.mn/

ТЕРРОРИЗМЫН ТУХАЙ НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ БА ЭРДЭМТЭН СУДЛААЧДЫН ҮЗЭЛ САНАА

DEFINITIONS OF THE TERRORISM AND DIFFERENT PERSPECTIVES OF SCHOLARSHIPS

Б.Баянмөнх
ДХИС-ийн ЦС-ийн ЦЭЗТ-ийн дэд профессор, доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
B. Bayanmunkh
Associate Professor at the Department of Police Law, University of Internal Affairs Doctor of Law (Ph. D), Police Lieutenant Colonel

Товчлол: Терроризм нь нийгмийн сөрөг үзэгдэл болохын хувьд нийгмийн шинжлэх ухааны олон салбарын судлагдахуун байсаар ирсэн бөгөөд сүүлийн хагас зуун жилд криминологийн шинжлэх ухаанд өргөн далайцтайгаар судлагдаж байна. Энэхүү гэмт явдал төвөгтэй болохын хэрээр түүнийг нарийвчлан тодорхойлох, судлах, тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй, үр дүнтэй шинэлэг арга хэлбэрээр явуулах нь терроризмын аюулаас учрах хор уршгийг нэмэгдүүлэхгүй байх, бууруулах нэг үндэс болно.

Энэхүү өгүүлэл нь гадаадын эрдэмтэн, судлаачид “терроризм”-ыг нэр томьёоны хувьд хэрхэн тодорхойлсон хийгээд, тэдгээрийн үзэл санааг нийтлэг ба ялгаатай байдлаар нь ангилан үзэхийн зэрэгцээ цаашид терроризмтой тэмцэхэд анхаарах зарим асуудлын талаар товч авч үзсэн болно.

Abstract: Abstract: Terrorism is a multidisciplinary field of study that draws on theories and methods from different disciplines, approaches social science to better understand as a social phenomenon. As the study of terrorism continues to develop, it is likely that connections between terrorism research and more traditional criminological approaches will widen and deepen.

We have also seen a grouping connection between the traditional criminological emphasis on understanding legal processing in general with an urgent contemporary desire to prevent or mitigate terrorist attack. Both these developments are also related to the need deal as effectively as possible with the criminal justice processing of those charged and convicted for terrorism-related offences.

This article aims to analyze how the terminology of terrorism is defined by different perspectives and approaches of social science and briefly examine the current issues to counter terrorism and contemporary challenges to prevent in the future.

Түлхүүр үг: эрдэмтэн, судлаач, терроризм, террор, террорист халдлага, үзэл суртал, шашин, кибер, хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалт

Keywords: scientists, researchers, terrorism, terrorist attacks, ideology, religion, cyber, laws and regulations

Удиртгал. XXI зуунд эрч хүчээ аван хүрээгээ улам бүр тэлсээр байгаа даяаршил дэлхий дахины хөгжлийн нийтлэг нөхцөл, чиг хандлага, харилцан хамаарлыг тодорхойлж буйг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрч байна.

Даяаршил, даяарчлалын эрин үеийн хүн төрөлхтөнд учруулж буй аюул заналын нэг нь “терроризм” гэгч үзэгдэл болж байна. Энэ нь хил хязгаар, том жижиг, баян хоосон, хөгжил дэвшил, ямар нэгэн үндэстэн ястныг үл ялган

хаана ч хэзээ ч гарч болзошгүйгээр нэн аюултай юм.[1]

Дэлхий дахинаа даяаршлын үйл явц улам бүр гүнзгийрэхийн зэрэгцээ олон улсыг хамарсан, үндэстэн дамнасан зохион байгуулалттай, алан хядах үйл ажиллагаа түүнээс улбаасан гэмт хэрэг, тухайлбал галт зэвсэг, мансууруулах бодис болон хүнийг хууль бусаар хил давуулан наймаалах гэмт хэргүүд газар авч, терроризмын аюул улам бүр дэлхийг хэрэн сүлжиж байгаа нь улс орнуудыг нэгдмэл хүчээр хамтарч ажиллахыг зүй ёсоор шаардаж байна.

Терроризм нь үзэл сурталжсан хүчирхийлэл дээр үндэслэсэн системтэйгээр хэрэглэгддэг, тэмцлийн хурц сөрөг арга хэлбэр юм.[2]

Энэ нь нийгмийн аюулгүй байдлыг алдагдуулах, олон улс, улсын хэмжээний онц чухал объектуудыг эзлэх, халдахыг завдах, ард түмнийг айлган сүрдүүлэх, алан хядах бүлэглэлүүдийн эрх ашгийг хангахуйц шийдвэрийг удирдлагын зүгээс гаргуулах зорилгоор бие хүн болон байгууллагын эсрэг хүчирхийлэл үйлдэх, эд хөрөнгө, бусад материаллаг зүйлсийг гэмтээх, устгах, улс орны дотор улс төр, эдийн засгийн онцгой байдлыг бий болгох, улмаар улс хоорондын харилцааг хүндрүүлэх, дайн үүсгэх шалтгаан, нөхцлийг бий болгох, үндэстэн ястангуудын хооронд хагалган бутаргах үйл ажиллагааг санаатайгаар зохион байгуулах явдал юм.

Өнөөдөр дэлхийн улс орнуудын эрдэмтэн судлаачдын гаргасан терроризмын тухай нэр томъёоны тодорхойлолтууд нь өөр хоорондоо харилцан адилгүй байдлаар тодорхойлогдож, тухайн улсынхаа хууль тогтоомжид тусгагдаж байгаа нь нэгдсэн нэг ойлголтод хүрээгүй, өөр өөрсдийн субъектив хандлагаар тодорхойлж ирсэн нь тулгамдсан асуудал болжээ гэж судлаачийн хувьд үзэж байна.

Үндсэн хэсэг. Терроризмын зорилго нь улс төр, нийгмийн байгууллын тогтолцоог өөрчлөх, төрийн байгууллын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, олон улсын харилцаа, улс орнуудын төрийн хяналт, удирдлагад нөлөөлөх гэсэн үндсэндээ улс төрийн агуулгатай байна.[3] Энэ нь нийгмийн тогтолцооны аюулгүй байдлыг алдагдуулах, иргэд, олон нийтийг айлган сүрдүүлэх арга хэрэгслийг ашиглан хүсэл зорилгоо гүйцэтгүүлэх явдлаар илэрч байна.

Нэг. Бүх төрлийн терроризмын үндсэн зарчим нь нэгдмэл, хүчирхийлэлд суурилсан, ертөнцийг үзэх үзэл, ёс суртахуун, улс төрийн үзэл бодол, бодлого мөн бөгөөд иргэд, олон нийтийг алах, алахаар заналхийлэх, айлган сүрдүүлэх зэрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг зорилгодоо хүрэх гол хэрэгсэл болгон сонгосонд оршино.

“Терроризм гэж нийгмийн аюулгүй байдалд заналхийлэх, хүн амыг айлган сүрдүүлэх болон төр засгийн гаргаж буй шийдвэрт нөлөөлөх зорилгоор тэсэлж дэлбэлэх, галдан шатаах болон нийгмийн аюултай бусад үйлдэл хийх замаар хүний амь нас хохироох, эд материалын мэдэгдэхүйц хохирол учруулах үйлдэл хийх, эсвэл

[1] Баатар Ч, Алтангэрэл Ч. Терроризмын аюул, түүнээс өөрийгөө болон ойр дотныхоо хамгаалах нь. Уб.2006. 6 дахь тал

[2] Баатар Ч. Терроризм, аюулгүй байдал. Уб.2006. 7 дахь тал

[3] Дашзэвэг Ц, Чагнаадорж Д. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. Уб. 2004. 20 дахь тал

тийм үйлдэл хийхээр заналхийлэхийг хэлнэ” гэсэн нийтлэг тодорхойлолтыг судлаачид дэвшүүлдэг.[4]

Терроризмын талаар дэлхийн олон улс орны эрдэмтэн судлаачид тодорхойлолт өгсөнөөс гадна төрийн байгууллагууд нь мөн адил өөрийн гэсэн онцлог бүхий тодорхойлолтыг гаргасан байдаг. Тухайлбал:

- АНУ-ын Холбооны мөрдөх товчоо: “Терроризм бол улс төрийн болон нийгмийн зорилгодоо хүрэхийн тулд төр, засагт шахалт үзүүлэх, энгийн иргэдийг айлган сүрдүүлэх аргаар бие хүн, тэдний эд хөрөнгийн эсрэг хууль бусаар хүч хэрэглэх эсхүл хүчирхийлэхийг хэлнэ”
- АНУ-ын Төрийн департамент: “Үндэстэн дамнасан бүлэглэл эсвэл нууц агентууд улс төрийн сэдэлтэйгээр нийгмийн тодорхой хэсэг, гэмгүй номхон ард иргэд, чухал алба хашдаг эрх мэдэл бүхий хүмүүст нөлөөлөх зорилгоор иргэний байгууламжийг бай болгон зориуд санаатай үйлдэж буй хүчирхийлэлийг терроризм гэнэ”
- АНУ-ын БХЯ: “Улс төр, шашин, үзэл суртлын зорилгоор төр, засаг, нийгэмд шахалт үзүүлэх, эсвэл тэднийг айлган сүрдүүлэх зорилго бүхий зориуд санаатай үйлдэж буй хүчирхийлэл, хүчирхийлэх аюулыг терроризм гэнэ”
- ОХУ: “Терроризм бол хувьсгалт болон экстремист агуулгатай хүчирхийллийн (ялангуяа хүмүүсийг алж хөнөөх, хулгайлах, барьцаалах гэх мэтээр) гэмт үйлдэл мөн. Хууль бус бүлэглэлийн бэлтгэн явуулж буй террорист үйлдэл нь засаглалын ноёрхолын арчаагүй байдлыг харуулах эсхүл засаглалын байгууллагаас сөрөг үйлдэл явуулахыг өдөөн турхирахад оршино. Эдгээрийн аль аль нь эрх барьж буй улс төрийн засаглалын байгууллагын талаар олон нийтэд сөрөг санал сэтгэгдэл бүрдүүлэх зорилго агуулж байдаг”
- Их Британи: “Улс төр, шашин, үзэл суртлын зорилгынхоо төлөө, үүний дотор нийгмийг эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар харгис хүчирхийлэл хэрэглэхийг терроризм гэнэ”
- НАТО: “Терроризм гэж хөрөнгө, санхүү, хөнөөх хэрэгслийн хүчинд дулдуйдсан хууль бус зэвсэгт бүлэглэлээс улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэх онцгой харгис үйлдлийг зөвтгөн, нийгэмд бүхэлд нь, эсвэл түүний тодорхой хэсэгт айдас, аймшиг төрүүлэх зорилгоор энгийн иргэд, иргэдийн эд хөрөнгийн эсрэг зориуд санаатайгаар үйлдэж буй хэт харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх үйлдлийг хэлнэ” хэмээн тус тус тодорхойлжээ.[5]

Түүнчлэн гадаадын зарим орны эрдэмтэн судлаачид терроризмын талаар өөр өөрсдийн зүгээс янз бүрээр тайлбарлан бичиж байна. Тухайлбал,

- Терроризм судлаач У.Лакер “Терроризм нь төрийн бус хүчирхийлэл үйлдэх буюу нийгмийг айдаст автуулахаар эмх замбараагүй байдал бий болгох, удирдах албан тушаалтныг хүлцэнгүй болгох, зайлуулах, улс төрийн өөрчлөлт хийх зорилгоор

[4] Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал. ОУ-н эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Уб.2016. 126 дахь тал. Сүхчуулун С. “Евразийн орчин дахь терроризмын аюул ба Монгол Улсад нөлөөлөх нөлөөлөл” илтгэлээс хэсэгчилэн авав.

[5] Дашзэвэг Ц, Чагнаадорж Д. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. Уб. 2004. 24-25 дахь тал

хүчирхийлэл үйлдэх аргаар айлган сүрдүүлэх явдал”[6]

- Колумбийн их сургуулийн судлаач П. Уилкинсон “Улс төрийн терроризм бол улс төрд айлган сүрдүүлэх аргыг ашигласан, философи үндэслэлтэй, зорилго чиглэл бүхий улс төрийн бодлого юм”
- ОХУ-ын судлаач М.Одесский, Д.Фельдман нар “Нийгмийн тогтвортой, нэгдмэл ухамсрыг айлган сүрдүүлэх хэрэгслээр удирдан залах арга бол терроризм мөн”
- ОХУ-ын эрдэмтэн, судлаач А.С.Ахиезер “Терроризм бол зохион байгуулалттай бүлэглэлийн эцсийн арга, өөрөөр хэлбэл аллага үйлдэх, дэлбэлэх, барьцаалах гэх мэт аргаар олон түмний сэтгэл зүйг өөрчлөх, нийгмийн амьдралыг хүндрүүлэх, зогсонги байдалд оруулах, эргүүлэх, төрийн байгууламжийг эвдлэх, олон нийтийн амьдралд үл гүйцэтгэлдэх үзэл бодол шингээх, тогтоох гэсэн оролдлого”
- ОХУ-ын эрдэмтэн Л.А.Моджоран “Терроризм бол ямар нэгэн улс төрийн зорилгод хүрэхийн тулд үйлдэгдэж буй хүчирхийлэл бөгөөд олон улсын конвенци, нийгмийн амьдралын хэм хэмжээ, хууль журмыг уландаа гишгилсэн үйлдэл мөн”
- Терроризм судлаач Е. Кожушко “Терроризм бол улс төрийн тэмцлийн тактик бөгөөд үзэл суртлын хувьд үйл ажиллагаагаа зөвтгөсөн тогтолцоот шинж чанартай, аллага, хорлон сүйтгэх ажиллагаа, ажил хаялт, хулгайлалт гэх мэт үйл ажиллагаагаар илэрхийлэгдэх хүмүүсийн амьдралын аюулгүй байдал, амьдрал ахуйд занал учруулалт юм”
- Ираны шашин судлаач Аяатулла Таскири “Терроризм бол хүнлэг бус, хууль бус үйл ажиллагаа, хүн төрөлхтөнд тэр тусмаа шашны хувьд ч хүлээн зөвшөөрөгдсөн эрхийг зөрчсөн хүний аюулгүй байдлын эсрэг чиглэсэн зорилго, чиглэл бүхий бүх л үйлдлийг хэлнэ”
- Доктор Сарфараз Ниази “Терроризм бол улс төрийн зорилгоор үйлдэгдэж буй хүчирхийлэл, тухайлбал аллага, хүн барьцаалах, онгоц барьцаалах, бөмбөгдөх, дэлбэлэх гэх мэт үйлдлийг хэлнэ”[7] хэмээн тус тус тодорхойлжээ.

Харин манай улсын эрдэмтэн судлаачид арай өөрөөр тодорхойлж, ном бүтээлдээ тусгажээ. Тухайлбал:

Доктор (Sc.D), профессор С. Нарангэрэл “Терроризм бол өргөн утгаараа террорист бодлого ба практик, хүч хэрэглэсэн гэмт явдлын төрөл” гэж тодорхойлсон бөгөөд явцуу утгаараа:

- Хувь хүн буюу байгууллагад хүч хэрэглэх ба хүч хэрэглэхээр заналхийлэх, түүнчлэн хүмүүсийг үхэлд хүргэх;
- Эд хөрөнгийн үлэмж хохирол аюулыг бий болгосон эд хөрөнгө ба бусад материаллаг объектыг устгах гэмтээх буюу устгахаар гэмтээхээр айлган сүрдүүлэх, тэрчлэн нийгэмд аюултай өөр хор уршиг бий болгох;
- Нийгмийн аюулгүй байдал зөрчих, хүн амыг айлгах буюу террористуудад ашигтай шийдвэрийг төр, засгийн байгууллагуудаар гаргуулах, эд хөрөнгийн буюу бусад

[6] Баатар Ч. Терроризм ба аюулгүй байдал. Уб.2006. 6 дахь тал

[7] Дашзэвэг Ц, Чагнаадорж Д. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. Уб. 2004. 25 дахь тал

хууль бус ашиг сонирхлыг гүйцэлдүүлэхээр нөлөөлөл үзүүлэх;

- Төрийн болон олон нийтийн зүтгэлтний үйл ажиллагааг зогсоох, эсхүл тийм үйл ажиллагаанаас өс авах зорилгоор түүний амь биед халдах;

- Олон улсын хамгаалалтад байдаг гадаад улсын төлөөлөгчид буюу олон улсын байгууллагын ажилтан, тэрчлэн олон улсын хамгаалалтад байдаг этгээдийн албан байр, эсхүл тээврийн хэрэгсэлд довтлох эдгээр хэргийг дайн өдөөх буюу олон улсын байдлыг хүндрүүлэх зорилгоор үйлдэх[8] зэрэг үйлдлүүдийг тус тус хамааруулан үзсэн байна.

Ц.Доржням, М.Цогтоо, С.Эрдэнэ "1. Хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээдээс улс төр, шашин, үзэл суртлын зорилгоор нийгмийг бүхэлд нь, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар харгис хүчирхийлэл үйлдэх, 2. Экстремист шинж бүхий хүчирхийллийн гэмт үйлдэл, 3. Хууль бус зэвсэгт бүлэглэлээс улс төрийн зорилгодоо хүрэхийн тулд төр, засагт шахалт үзүүлэх, гэмгүй номхон ард иргэдийг айлган сүрдүүлэхээр иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх гэмт үйлдэл"[9] гэж тус тус тодорхойлжээ.

Харин Манай улсын хувьд Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.1-д "терроризм" гэж улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төрийн байгуулал, нийгэм, эсхүл түүний тодорхой хэсэгт нөлөөлөн айдаст автуулахаар хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг"[10] гэж тодорхойлсон байдаг байна.

Энэхүү тодорхойлолтыг дэлхийн улс орнууд болон олон улсын эрдэмтэн судлаачдын гаргасан тодорхойлолтуудтай харьцуулан үзэхэд нийгэмд бүхэлд нь эсхүл түүний тодорхой бүлэгт айдас, аймшиг төрүүлэх зорилгын хувьд төсөөтэй боловч төдийлөн оновчтой бус байна хэмээсэн байдаг.

Дэлхийн улс орнуудын эрдэмтэн судлаачид "Терроризм" хэмээх энэхүү үгийг янз бүрээр ойлгож, тайлбар хийж, үзэл бодлоо илэрхийлсээр байгаа боловч тодорхой нэгдсэн ойлголтыг агуулсан нэг тодорхойлолтыг одоо хүртэл өгч чадаагүй байна.

Гадаадын зарим улс орон болон эрдэмтэн судлаачдын гаргасан дээрхи тодорхойлолтуудыг нэгтгэн авч үзээд дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

1. Дэлхийн улс орнууд болон олон улсын эрдэмтэн судлаачид өнөөг хүртэл терроризмын талаар нэгдсэн ойлголтод хүрч чадаагүй, өөр өөрсдийн өнцгөөс харж тодорхойлолтоо гаргасаар ирсэн байна.

2. Терроризм гэсэн ойлголтыг аль өнцгөөс, хэн тодорхойлолт өгч буйгаас хамаарах субъектив хандлагатай асуудал болсон байна.

3. Терроризмын талаар нэгдсэн нэг ойлголттой болж чадаагүй учраас улс орнууд өөр өөрийн хууль эрх зүйн орчиндоо харилцан адилгүй байдлаар тусгаснаар терроризмтой тэмцэх үйл

[8] Нарангэрэл С. Эрх зүйн эх толь бичиг. 2016

[9] Доржням Ц, Цогтоо М, Эрдэнэ С. Аюулгүй байдлын нэр томъёоны тайлбар толь. Уб.2016. 144-145 дахь тал

[10] Төрийн мэдээлэл. 2019. №41. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль

ажиллагааны үндсэн чиглэл, хамрах хүрээ нь өөр өөр байдлаар тодорхойлогдож байгаа нь тулгамдсан асуудлын нэг болсон байна.

Нөгөө талаараа терроризм нь нийгмийг эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулах зорилго бүхий сэтгэл зүйн дайралт гэж үзэж болох бөгөөд үүнийг зарим эрдэмтэн, судлаачид тодорхойлолтондоо тусгаж өгөөгүй орхигдуулсан нь ажиглагдаж байна.

Терроризмын зорилгыг дараах байдлаар тодорхойлж болох юм. Тухайлбал:

- Нийгмийг айдаст автуулах;
- Хууль бусаар засгийн эрхийг авах;
- Эдийн засгийн хохирол учруулах;
- Шашны сөрөг нөлөөлөлийг бий болгох;
- Улс орны улс төр, эдийн засгийн хүчин чадлыг сулруулах;
- Үндэстэн хоорондын зөрчилдөөн үүсгэх;
- Улс оронд нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсгэх зэрэг болно.

Терроризм үүсэх үндсэн шалтгаануудыг улстөрийн, нийгэм-эдийн засгийн, эдийн засгийн, шашны, оюун санааны гэж 5 ангилдаг байна. Шалтгаануудын эх сурвалжийг хөөн дурдваас, улстөрийн тогтворгүй байдал гэдэг бол терроризм үүсэх үндсэн шалтгаан болж байна.[11]

Терроризмыг халдлагын объект, ашиглаж буй арга, техник хэрэгсэл, субъектив хандлага зэрэг олон хүчин зүйлээс нь хамааруулж, дараах байдлаар төрөлжүүлж болохоор байна. Тухайлбал:

- Олон улсын терроризм;
- Улс төрийн терроризм;
- Эдийн засгийн терроризм;
- Үзэл суртлын терроризм;
- Био терроризм;
- Цөмийн терроризм;
- Кибер терроризм;
- Шашны терроризм;
- Сэтгэл зүйн терроризм зэрэг ангилж болохоор байна.

Дээрхи терроризмын төрөл хэлбэрүүдээс гадна эрдэмтэн судлаачид ном бүтээлдээ терррористмын шинэ төрөл, нэршлүүдийг гаргаж бичсээр байна. Тухайлбал, Угсаатны терроризм, Нарко терроризм, Лалын терроризм гэх зэргийг дурдаж болно.

Манай улсын хууль тогтоомжид “Олон улсын терроризм” гэж олон улсын харилцаа, улс орнуудын төрийн хяналт, удирдлагад нөлөөлөх зорилго бүхий улс дамжсан терроризмыг[12] хэлнэ хэмээн тодорхойлсон байдаг.

Бараг хүн төрөлхтний соёл иргэншил үүссэн цагаас террорист аргыг улс төрийн байгууллагууд, шашны бүлэглэлүүд, улс орнууд өргөн хэрэглэсээр ирсэн байна.[13]

Терроризмын тодорхойлолтыг эрдэмтэн судлаачид өөр өөрсдийн үзэл бодол, тухайн улс орны төрийн байгууллагуудын үзэл баримтлал, терроризмд хандах субъектив хандлагаар тодорхойлж, шинэ төрлийн терроризмын тодорхойлолтуудыг гаргасаар байгаа бөгөөд цаашдаа ч гаргасаар байх болно.

[11] https://montsame.mn/mn/read/12426

[12] Төрийн мэдээлэл. 2019. №41. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.2.

[13] Баатар Ч, Алтангэрэл Ч. Терроризмын аюул, түүнээс өөрийгөө болон ойр дотныхоо хамгаалах нь. Уб.2006. 10 дахь тал

Зарим эрдэмтэн судлаачид терроризмын шинэ нэг төрлийн тодорхойлолтыг гаргаж байна. Тухайлбал: “Угсаатны терроризм гэж үндэсний олонхийн дотор цөөнх болж буй үндэс угсаатны төлөөлөгчид үндэсний улс төрийн тусгаар тогтнолоо олж авах ганц арга нь терроризм хэмээн үзэж түүнийг тэмцэлдээ ашиглах үйл ажиллагаа”[14] гэж тодорхойлжээ.

Дээрхи бүх тодорхойлолтуудыг авч үзвэл терроризмын зорилго нь улс төр, эдийн засаг, философи, үзэл суртал, шашны болон өөр бусад ямар нэг зорилгыг агуулсан ч байсан тэдний үйл ажиллагааг зөвтгөх үндэслэл байхгүй юм.

Хоёр. Терроризмтой тэмцэх үндсэн арга бол терроризм бий болох үндэс суурь бүрдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулах явдал юм.

Өнөөдөр террорист халдлагыг гарсан хойно нь хөрөнгө мөнгө, хүч хэрэгсэл, цаг хугацаа зарцуулан байж түүнийг илрүүлэх, шийдвэрлэхдээ биш, харин гарахаас нь өмнө аль болох урьдчилан сэргийлэх, терроризм бий болох шалтгаан, нөхцлүүдийг арилгахад чиглэгдсэн арга хэмжээг иж бүрэн цогцолбороор нь явуулах нь өнөөгийн дэлхийн улс орнуудын терроризмтой тэмцэх үйл ажиллагааны үндсэн тулгуур зарчим нь байх ёстой.

Тиймээс терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээний хэрэгжилтэд хамааралгүй нэг байгууллага, иргэд байхгүй бөгөөд үүнийг иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагад ухуулан сурталчилах, тайлбарлан таниулах ажлыг чанартай, хурдан шуурхай зохион байгуулах явдал чухал юм.

Өнөөдөр бид терроризмоос урьдчилан сэргийлэх, тэмцэхдээ үндэсний хууль тогтоомжийн шинэчлэлд онцгой анхаарч, терроризмын тухай ойлголтыг улам илүү тодорхой болгох, алан хядах шинж бүхий гэмт хэргийн бүрэлдхүүнийг тогтоох, үндэсний хууль тогтоомжийг олон улсын жишиг стандартанд хүргэх, олон улсын гэрээ, конвенцийн заалттай нийцүүлэх замаар боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

Дэлхийн улс орнуудад терроризмаас урьдчилан сэргийлэх асуудал хурцаар тавигдаж байгаа өнөө үед энэ үүрэг нь гагцхүү төр, засаг захиргаанд өгөх нь өрөөсгөл юм.

Терроризмоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг дэлхийн улс орнуудын тэргүүн туршлагад тулгуурлан бодлогын түвшинд боловсруулах, нөгөө талаар иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, эрх зүйн орчинг бүрдүүлэх замаар улс орондоо терроризм үүсэх шалтгаан, нөхцлийг тогтоож, түүнийг арилгах арга хэмжээг цогц байдлаар авах явдал юм.

Терроризмаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний зорилго нь a) Терроризм үүсэх шалтгаан, нөхцөл бүрдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, арилга b) Төрийн тогтвортой ажиллагаа хийгээд иргэд, төрийн байгууллагуудын сонор сэрэмжийн тусламжтайгаар иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг террорист ажиллагаа, үйлдлээс сэргийлэн хамгаалах, c) терроризмтой тэмцэх

[14] Доржням Ц, Цогтоо М, Эрдэнэ С. Аюулгүй байдлын нэр томъёоны тайлбар толь. Уб.2016. 144-145 дахь тал

хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршиж байна.

Аливаа улс орон дахь ажилгүйдэл, ядуурал, авилгал, хээл хахуул, шашин хоорондын зөрчил, угсаатан хоорондын зөрчил, тэмцэл нь терроризм үүсэх хөрс, үндэс болдог бөгөөд эдгээрийг террористууд өөрсдийн ашиг сонирхолдоо овжин ашигладаг нь нотлогдсоор байна.[15]

Сүүлийн үед террористууд улс орон, олон нийт, үндэстэн хоорондын болон шашны нөлөөллийг ашиглан зэвсэгт тэмцэлд оруулж болзошгүй байгаа нь бүс нутгуудад болж байгаа үйл явдлуудаас тодорхой болж байна.

Бид юуны өмнө аливаа террорист халдлага аюул заналыг зэргэлдээ орнуудад болж буй үйл явдал, тэдний гадаад шинж төрх байдал олон улс орныг хамрах хүрээ, далайц зэрэгт дүгнэлт хийж, улс орны хил хязгаарыг нэвтрэн орж ирж болзошгүй нөхцөлд хариу арга хэмжээг цаг алдалгүй авахад бэлэн байж, дотооддоо нэн сонор сэрэмжтэй, аюулыг урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд хууль сахиулах байгууллагуудаас гадна олон нийт өндөр мэдрэмжтэй, сонор сэрэмжтэй байхыг цаг үе зүй ёсоор сануулж байна.

Бид терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулбал тодорхой үр дүнд хүрнэ. Үүнд:

- Терроризмын аюул занал, түүний хор уршгийн талаар иргэд, олон нийтэд ухуулга сурталчилгаа, танилцуулгыг системтэйгээр зохион байгуулж явуулах;
- Хил, гааль, мэргэжлийн хяналтын байгууллагуудын хяналт, шалгалтын техник хэрэгслийг сүүлийн үеийн шинжлэх ухааны ололтонд тулгуурлан шинэчлэх;
- Гадаад паспорт, иргэний үнэмлэх, визний нууцлалыг сайжруулах;
- Хувийн хамгаалалтын албадын үйл ажиллагааг сайжруулах, эрх зүйн орчныг бүрдүүлж өгөх;
- Гадаад орнуудын терроризмтой тэмцэх тусгай чиг үүргүүдийн байгууллагуудын хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах;
- Мэргэжлийн тусгай албадын алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг өндөр хэмжээнд тогтмол бэлэн байдалд байлгах;
- Терроризмтой тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, түүний эрх зүйн орчинг бүрдүүлж өгөх зэрэг олон ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлбэл тодорхой хэмжээнд үр дүнд хүрнэ гэж үзэж байна.

Терроризмын аюул заналаас урьдчилан сэргийлэх нэг чухал үндсэн арга бол иргэдийн сонор сэрэмж юм. Ер нь сонор сэрэмж сайтай газар гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх боломж өндөр, гэмт хэргийн илрүүлэлт ч сайтай байдаг.

Үүнийг хууль сахиулах чиг үүргийн байгууллагууд анхааралдаа авч сонор сэрэмжийг дээшлүүлэх, албаны бэлэн байдлыг өндөр түвшинд байлгах, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт тогтмол хийж байх нь энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх болно.

[15] Дашзэвэг Ц, Чагнаадорж Д. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. Уб. 2004. 34 дэх= тал

Монгол Улс терроризмын эсрэг олон улсын үйл ажиллагааг дэмжиж дотооддоо холбогдох тогтоол шийдвэр гаргаж, түүний хэрэгжилтийг хангах, дэлхийн олон улс орнуудтай хамтран ажиллах, мэдээлэл харилцан солилцох зэрэг шат дараатай арга хэмжээ авч байна.

Тухайлбал "Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай" Монгол Улсын хууль, "Терроризмын эсрэг олон улсын эвсэл байгуулахыг дэмжих тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Терроризмын эсрэг олон улсын эвслийн үйл ажиллагааг дэмжих тухай" Засгийн газрын тогтоол, "Олон улсын алан хядах үйл ажиллагаанаас сэрэмжлэх арга хэмжээний тухай" Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийг тус тус батлан гаргасан.

"Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай" Монгол Улсын хуулинд терроризмаас сэргийлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг зааж, түүний аюулаас сэргийлэх талаар төрийн байгууллага, хуулийн этгээд, иргэний хүлээх үүргийг тогтоож өгсөн.

Энэ хуулиар Засгийн газар нь терроризмаас сэргийлэх үндсэн арга хэмжээг улсын хэмжээнд нэгтгэн зохион байгуулах, терроризмаас сэргийлэх арга хэмжээний улсын нэгдсэн төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг зохион байгуулах үндсэн чиг үүргийг хүлээж байна.

Терроризмын үйл ажиллагаа нь олон улсын хэмжээнд байгалийн эх үүсвэрийн нөөц, үнэт ашиг малтмалаар баялаг газар нутагт дарангуйлал тогтоох, дэлхийн улс гүрнүүдийн төр, эдийн засгийн бодлогод нөлөөлөх оролдлого хийх, олон нийтийг хамруулсан улам их их аюул занал учруулж болзошгүй боллоо.

Манай улсын хувьд "Үндэсний аюулгүй байдлын тухай хууль"-д заасан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын терроризмаас сэргийлэх талаар мэдээлэл солилцоо, хамтын ажиллагааг зохицуулах үүрэг бүхий "Зохицуулах зөвлөл"-ийг Тагнуулын төв байгууллагын даргаар ахлуулан байгуулан ажиллаж байна.

Ялангуяа бүс нутгийн тогтворгүй байдал үүсэхэд нөлөөлж буй терроризмын үр хөврөлийг үндсэрхэг үзэл, шашны үл тэвчих буюу хэт даврагч үзэл, цөмийн болон ердийн зэвсгийн тархалт, хууль бус цагаачлал, хүний арилжаа, хар тамхи, мансууруулах бодисын худалдаа, хил, газар нутгийн маргаан, зохион байгуулалттай гэмт хэрэг, амьдралын доройтол, ядуурал зэрэг нь олон зүйл нөхцөлдүүлдэг.

Тиймээс терроризмын гэмт хэрэгт холбогдож болзошгүй, террорист халдлага үйлдэж магадгүй гэсэн дор дурдсан этгээдүүдэд тавих захиргааны хяналтыг чангатгах, хяналтын эрх зүйн орчныг бүрдүүлэх, хяналт тавих субъектүүдийн ажлын зохион байгуулалтыг тодорхой болгож, нэгдсэн зохион байгуулалт, удирдлагаар хангах шаардлага нэгэнтээ бий болсон байна.

Сүүлийн 10 гаруй жилийн турш дэлхийн олон оронд болж байгаа терроризмтой холбоотой үйл явдлуудыг иргэд, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хангалттай үзэж, тодорхой хэмжээний ойлголтыг авсан гэж үзэж болно. Гэвч терроризмд хандах иргэдийн сэтгэлгээ өөрчлөгдсөнгүй нь олон нийтийн аливаад хандах сэтгэлгээний өөрчлөлт, шинэчлэл гэдэг зүйл, зүгээр нэг

санаснаар хийгддэг зүйл биш гэдгийг үүнээс харж болохоор байна.

Нийгмийн шинэчлэлийг тодорхойлох нэг гол хүчин зүйл иргэдийн сэтгэлгээ байдаг. Тэгвэл иргэдийн сэтгэлгээ хэзээ бүрэн өөрчлөгдөх вэ? гэсэн асуулт гарч ирнэ. Олон улсын жишээнээс харахад бүтэн нэг үе нугарч байж нийгмийн сэтгэлгээ өөрчлөгддөг бөгөөд нийгмийн гишүүдийн сэтгэлгээ үзэл бодол нь олон жилийн хэвшмэл хандлагаар бий болж бэхэждэг.

Өнөөдөр терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээний хэрэгжилтэд хамааралгүй нэг байгууллага, аж ахуйн нэгж, иргэд байхгүй бөгөөд үүнийг иргэд, олон нийтэд ухуулан сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг чанартай, хурдан шуурхай зохион байгуулбал терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх боломж тэр хэрээр нэмэгдэнэ.

Тэр тусмаа манай улсад терроризмтой холбоотой гэмт хэрэг гараагүй /гарсан ч олон нийтэд мэдээлэгдээгүй/ нь түүний хор аюулын талаар мэдээлэлгүй, учрах аюулын талаар ойлголт байхгүй байгаа, үүнд ард иргэд нь дасал болсон нь хамгийн том эрсдэлийг дагуулж байна. Энэ нь терроризмд хандах иргэдийн сэтгэлгээ өөрчлөгдөхгүй байх үндэс болж байгаа бөгөөд үүнийг шинэ үеийн залууст олгож байгаа боловсролын сургалтын агуулгад өөрчлөлт оруулах явдлаар өөрчлөгдөж болно.

Дүгнэлт. Терроризм гэдэг бол улстөр, шашин, нийгмийн үзэл суртал болон хууль бус зорилтоо гүйцэлдүүлэх үүднээс иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд харгис аргаар хүчирхийлэл үйлдэх замаар айлган сүрдүүлэх үйлдэл юм байна.

Терроризмын талаар дэлхийн улс орнуудын төрийн байгууллагынх нь баримталж буй үзэл баримтлал, эрдэмтэн судлаачдын гаргасан тодорхойлолтуудыг шинжин үзвээс нэгдсэн нэг ойлголтод өнөөг хүртэл хүрээгүй, өөр өөрсдийн улс оронд болж буй нөхцөл байдал, аль өнцгөөс, хэн тодорхойлолт өгч буйгаас хамааралтайгаар субъектив байдлаар тодорхойлж ирсэн байна.

Энэ нь улс орнууд терроризмын талаар харилцан адилгүй байдлаар тодорхойлж, хууль тогтоомжиндоо тусгаж өгсөн нь терроризмтой тэмцэх үйл ажиллагааны чиглэл, хамрах хүрээ өөр өөрөөр тодорхойлогдох нэг хүчин зүйл болжээ.

Дэлхийн улс орнууд терроризмтой тэмцэх чиглэлээр янз бүрийн арга замаар тэмцэж ирсэн боловч төгс үр дүнтэй аргыг өнөөдөр хүртэл гаргаж чадаагүй байна. Энэ нь терроризмтой тэмцэх ажил нь зөвхөн төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын ажил, иргэн, төрийн болон төрийн бус, нутгийн захиргааны байгууллага гээд бүх нийтийн идэвхитэй оролцоотойгоор үр дүнд хүрдэг ажил юм байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Терроризмын тодорхойлолтыг олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн шинээр тодорхойлж, олон улсын хурлаар хэлэлцүүлэн нэгдсэн нэг ойлголтод хүрэх асуудлыг яаралтай шийдвэрлэх;

2. Олон улсын хурлаар хүлээн зөвшөөрөгдөх шинэ тодорхойлолтыг дэлхийн улс орнууд өөр өөрсдийнхөө хууль тогтоомжид тусгах замаар терроризмтой тэмцэх үйл

ажиллагааныхаа чиглэл, хамрах хүрээг шинээр тодорхойлох;

3. Терроризмтой тэмцэх чиглэлээр дэлхийн улс орнууд зөвхөн тусгай чиг үүргийн байгууллагын хүлээх үүрэг бус бүх нийтийн оролцоотойгоор хийгдэх ажил гэдгийг олон нийтдээ сурталчилах ажлыг төрийн бодлогын хэмжээнд зохион байгуулах;

4. Терроризмтой тэмцэх төрийн тусгай чиг үүргийн байгууллагуудын алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, харилцан, хамтран ажиллах чадавхийг нэмэгдүүлэх чиглэлээр жил бүр ажил, арга хэмжээг Засгийн газрын хэмжээнд зохион байгуулж хэрэгжүүлэх;

5. Иргэд олон нийтийн болон төрийн байгууллагуудын сонор сэрэмжийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх зэрэг болно.

Ашигласан материал.

1. Ц.Дашзэвэг, Д.Чагнаадорж. Олон улсын терроризм, түүнээс сэргийлэх зарим асуудалд. Уб. 2004
2. Ч.Баатар, Ч.Алтангэрэл. Терроризмын аюул, түүнээс өөрийгөө болон ойр дотныхоо хамгаалах нь. Уб.2006
3. Ч.Баатар. Терроризм, аюулгүй байдал. Уб.2006.
4. С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. Уб.2016
5. Ц.Доржням, М.Цогтоо, С.Эрдэнэ. Аюулгүй байдлын нэр томъёоны тайлбар толь. Уб.2016
6. Хууль сахиулах үйл ажиллагаа: онол, практикийн тулгамдсан асуудал. ОУ-н эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. Уб.2016.
7. Төрийн мэдээлэл. 2019. №41.
8. https://montsame.mn

ДОТООДЫН ЦЭРГИЙН “ХАРУУЛЧИН” МЭРГЭЖЛИЙН ҮҮРЭГ, АЖИЛБАРТ ХИЙСЭН ДАКУМ ШИНЖИЛГЭЭ

DACUM OF INTERNAL TROOPS “GUARD” DOCUMENT ANALYSIS AND CONCLUSIONS

Б.Батцоож.
ДХИС-ийн Ахлагчийн сургуулийн Цагдаагийн албаны тэнхимийн багш, хошууч
B. Battsooj.
Major, teacher of internal troops work department

Хураангуй: Монгол Улсын Дотоодын цэргийн байгууллага нь улсын онц чухал объектыг хамгаалах, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүрэгтэй байгууллага юм. Дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдаас дээрх чиг үүргийг нэр төртэй хэрэгжүүлэхэд мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлагатай алба хаагчийг бэлтгэх сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтын орчин нөхцөлийг сайжруулах асуудал тулгамдаж байна. Иймээс Дотоодын цэргийн ахлагч бүрэлдэхүүний ажил, үүрэгт Дакум шинжилгээ хийж “Харуулчин” мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх талаар авч үзсэн болно.

Abstract: The Internal Troops of Mongolia is the organization responsible for protecting of especially impotant national objects, maintaining public order, and ensuring public safety. There is an urgent problem to develop a training program and improve the training environment to prepare professional servicemen with professional knowledge, skills and attitudes in order to carry out these functions with dignity. Therefore, Dakum analyzed the work and responsibilities of the Internal Troops sergeant stuff and considered updating the “Guardian” vocational training program.

Түлхүүр үг: харуулчин, мэргэжлийн сургалт, дакум шинжилгээ
Keywords: security guard, professional training, Dacum analysis.

Удиртгал. Монгол Улсын Дотоодын цэргийн байгууллага нь улсын онц чухал объектыг хамгаалах, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх, террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага юм.

Монгол Улсын Дотоодын цэрэг нь тухайн цаг үеийхээ нийгэм эдийн засгийн хөгжилтэй шууд уялдан хөгжиж улсын онц чухал объектыг хамгаалах, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүргээ биелүүлсээр ирсэн байдаг. Дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдаас дээрх чиг үүргийг нэр төртэй хэрэгжүүлэхэд мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлагатай алба хаагчийг бэлтгэх орчныг бүрдүүлэх, боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай байна.

Иймд Дотоодын цэргийн байгууллагын хөгжил, шинэчлэлд оршиж байгаа тулгамдсан асуудлуудын нэг болох Дотоодын цэргийн ахлагч бүрэлдэхүүний ажил, үүрэгт дакум шинжилгээ хийж “Харуулчин”

мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх шаардлагатай байна.

Сэдвийн судлагдсан байдал: Судлаач, доктор Ц.Наранчимэгийн "Монголын цагдаагийн салбарт мэргэжлийн тасралтгүй боловсролыг хөгжүүлэх зарим асуудал" 2013 он, судлаач Р.Бат-Оргилын "Цагдаагийн алба хаагчдын мэргэшүүлэх сургалтын өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт" /2008 он/ сэдвийн дор зөвхөн мэргэшүүлэх сургалтын асуудлыг дагнан судалсан байна

Дотоодын цэргийн сургалттай холбоотой "Дотоодын цэргийн сургалтын стандарт"-ыг Дотоодын цэргийн штабаас санаачлан ЦЕГ-ын даргын баталсан 2010, 2012 оны стандартууд байдаг. Эдгээр ном, бүтээл, стандарт нь дотоодын цэргийн алба хаагчдын эрх зүйн зохицуулалтын онолын эх сурвалж болж байгаа хэдий ч мэргэжлийн сургалтад чиглэгдсэн Дакум судалгаа одоогоор алга байна.

Судалгааны ажлын ач холбогдол: Дотоодын цэргийн алба хаагчдын мэргэжлийн сургалтад үүрэг, ажилбарын Дакум шинжилгээг хийснээр Дотоодын цэргийн байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалтын талаар бодлого боловсруулах, хянах, хөдөлмөрийн харилцаатай холбогдох мэдээллийг авах, ажилтны ур чадварыг үнэлэх боломжтой.

Үндсэн хэсэг. Хүн төрөлхтний түүхийн аль ч үед нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөшүүрэг нь хүний нөөц, түүний хөгжил байсаар ирсэн билээ. Дотоодын цэргийн алба хаагч тэр дундаа харуулчин ахлагч бүрэлдэхүүний сургалт, хөгжилд анхаарах нь тэдний үйл ажиллагааг идэвхжүүлэх, санал санаачилгыг нэмэгдүүлэх, чадварлаг зөв хандлагатай алба хаагч бэлтгэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Дотоодын цэргийн байгууллагын сургалтын үйл ажиллагааг зохицуулсан хэд хэдэн эрх зүйн баримт бичгүүд байдаг. Үүнд:

Хүснэгт №1

№	Дотоодын цэргийн командлагчийн тушаал	Журмын товч утга
1.	Дотоодын цэргийн командлагчийн 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн "Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлах тухай" А/03 дугаар тушаал,	Цагдаа, Дотоодын цэргийн алба хаагчийн мэргэшлийн мэдлэг, ур чадвар, боловсролын түвшинг тасралтгүй дээшлүүлэх, алба хаагчийн өөрөө сурч, хөгжих хандлагыг төлөвшүүлэх, эрмэлзлэлийг дэмжих, хөгжүүлэхэд оршино.
2.	Дотоодын цэргийн албаны сургалтын нормативын эмхэтгэл	Дотоодын цэргийн албаны сургалтын хөтөлбөрийн дагуу олгосон мэдлэг, ур чадварын түвшинг тогтоох нормативуудыг тусгаж, цаашид давтан болон мэргэшүүлэх сургалтад хамруулахад оршино.
3.	Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам код 1/310 Сургалт бэлтгэлийг зохион байгуулах 2018 оны А/02 тушаал	Дотоодын цэргийн анги, байгууллага, бие бүрэлдэхүүний дунд мэргэжлийн бэлтгэл, давтан болон албаны сургалт зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
4.	Дотоодын цэргийн үйл ажиллагааны журам код 1/305. Бие бялдрын шалгуур үзүүлэлтийг дүгнэх	Монгол Улсын Төрийн цэргийн байгууллагууд, тэдгээрийн харьяа нэгтгэл анги, салбарт цэргийн биеийн тамирын бэлтгэлийг зохион байгуулах, цэргийн алба хаагчдын бие бялдрын түвшинг тогтоох, иргэнийг цэргийн бүх шатны сургуульд

	Зэвсэгт хүчний жанжин штабын даргын 2017 оны А/505 тушаал	элсүүлэх, цэргийн алба хаагчийг албан тушаалын шаардлага хангаж буй эсэхийг тогтооход оршино.

Дотоодын цэргийн анги, салбарууд нь сургалтын хөтөлбөр, нормативуудын дагуу сургалтын чиглэлээр тодорхой үйл ажиллагаануудыг тогтмол явуулдаг.

Дотоод хэргийн их сургуулийн Ахлагчийн сургууль нь Дотоодын цэргийн "Харуулчин"[1] мэргэжлээр 3 сарын хугацаатай батлагдсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу мэргэжлийн сургалтыг зохион байгуулдаг. Сургалтын хугацаанд 596 орчим цагийн багтаамжтайгаар "Дотоодын цэргийн алба үйл ажиллагааны эрх зүйн үндсийг судлах", "Улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагаанд суралцах", "Объектын хамгаалалтын инженер техник, холбоо дохиолол, теле хяналтын хэрэгслийг ашиглах", "Дотоодын цэргийн алба, үйл ажиллагааны үед хүний эрхийг хангах", "Албан хэрэг хөтлөлтийг судлах", "Цэргийн нийтлэг дүрмүүдийг судлах", "Гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт, урьдчилан сэргийлэх ажлыг судлах", "Бие хамгаалах бэлтгэлийг эзэмших", "Цэргийн байр зүйн бэлтгэлийг эзэмших", "Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх", "Алба хаагчийн ёс зүй, сэтгэл зүй ур чадварыг эзэмших", "Дотоодын цэрэг гэмт хэрэг, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад оролцох", "Онцгой нөхцөл байдал үүссэн үеийн арга ажиллагаанд суралцах", "Обьектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх ажиллагаанд суралцах", "Албаны тусгай хэрэгсэл хэрэглэх", "Албаны галт зэвсэг хэрэглэх", "Алба хаагчийн ёс зүй, харилцааны ур чадвар, сэтгэл зүйг судлах", "Амьд үлдэх ур чадвар эзэмших " зэрэг 16 төрлийн хичээлийг үзэж судалдаг. [2]

Чадамжийн нэгжийн төлөвлөлтийг хүснэгтээр харуулбал:

[1] "Харуулчин" гэсэн үг, нэр томьёог судалж, хайж үзэхэд Монгол хэлний тайлбар толинуудаас олдсонгүй. Харин "Харуул" хэмээх үгийг "Монгол хэлний их тайлбар толь"-д 1-рт: Аливаа зүйлийг манаж, харгалздаг этгээд: харуул суулгах (хязгаар боомтын газар манаа байгуулах), харуул томилох (нэр цохон харуул хийлгэх), харуул харах (дайсныг сэрж сэргийлэх), харуул чангатгах (харуулын тоог нэмж, сонор сэрэмжийг нь дээшлүүлэх), харуулд гарах (манааанд гарах), харуулын байр (манааны байр), харуулын онгоц (харуул хийхэд хэрэглэх онгоц), харуулын цэрэг (манааны цэрэг) - *Хэрмийн их хаалгыг харуулын цэргүүд нээж, сүйх тэрэг ойр дагалдах хүмүүсийг оруулан цэргүүдийг гадаа үлдээв.* Ш.Нацагдорж. Мандхай цэцэн хатан., хүндэт харуул (а. Төрийн ямар нэг онцгой үйл явдлын үеэр ёслол хүндэтгэлийн ажиллагаанд оролцдог, тусгай бэлтгэгдсэн цэргүүд; б. Хүндэт хүний хөрөг, хөшөө бунхан зэргийг сахин хамгаалах харуул) - *Чанга чанга алхлан ирэх хүндэт харуулын халаа солилцохыг харж, Кремлийн цагтай цагаа тааруулахад бахтай сайхан байдаг.* М.Чойжил. Андын нутаг алсдахгүй., алтны харуул [түүх] (Манж Чин улсын үе буюу XVIII зууны сүүлийн хагаст Монгол нутагт алт эрдэнийн чулуу бусад ашигт малтмалыг ашиглахыг манж нар хориглон Засагт хан, Сайн ноён хан хоёр аймгийн нутагт орших Алтан ууланд гаргасан харуул), гэрийн харуул [түүх] (Хаант Орос улсын хилийн дагуу байгуулсан Манж улсын хил хязгаарын харуул), дотуур харуул [түүх] (Манж нар 1788 онд гэр харуул болон хошуу нутгийн зах нийлсэн газрыг давхар сэргийлэх зорилгоор байгуулсан харуул), харуул манаа [хоршоо] (эд зүйл, байшин барилга зэргийг харгалзан манах нь) - *Соёл боловсрол ба хүний элбэрэлт ёсыг сахих эн тэргүүний харуул манаа мэт үзэгдэх юм нэг ч үгүй.* Ж.Верн. Арван таван наст капитан; 2-рт: Холын бараа харахаар өндөрлөг газар байгуулсан цонж: харуулын цамхаг (алсын бараа ажиглан харах өндөрлөг тагт) гэж тайлбарласан байна.

[2] "Цагдаа", "Цагдаа-жолооч", "Харуулчин" сургалтын хөтөлбөр. ДХИС-ийн харьяа Ахлагчийн сургууль 2020 он

Хүснэгт №2

№	Чадамжийн нэгжийн нэр	Чадамжийн нэгжийн код	Нийт мэдлэг, ур чадвар олгох цаг	Онол	Ур чадвар олгох цаг		
					Сургууль дээрх	Үйлдвэрлэл дээрх	Хээрийн сургалт
А. Мэргэжлийн суурь хэсэг			130	40	54		36
1	Амьд үлдэх ур чадвар эзэмших	-	14	2	8		4
2	Цэргийн нийтлэг дүрмүүдийг хэрэгжүүлэх	-	34	6			28
3	Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх	-	20	4	12		4
4	Алба хаагчийн ёс зүй, харилцааны сэтгэл зүй	-	14	4	10		
5	Албан хэрэг хөтлөлтийг мөрдөх	-	18	6	12		
6	Дотоодын цэргийн алба, үйл ажиллагааны эрх зүйн үндэс	-	22	14	8		
7	Дотоодын цэргийн алба, үйл ажиллагааны үед хүний эрхийг хангах	-	8	4	4		
Б. Мэргэшүүлэх хэсэг			370	78	152	96	44
8	Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх	-	114	14	68	14	18
9	Хамгаалалтад инженер техник, холбоо дохиолол, теле хяналтын хэрэгслийг ашиглах	-	26	6	4	14	2
10	Гэмт хэрэг, зөрчлийн тухай ойлголт, урьдчилан сэргийлэх ажлыг судлах	-	10	4	6		
11	Цэргийн байр зүйг ашиглах	-	32	6	8	14	4
12	Мөр судлах	-	20	6	10		4
13	Улсын онц чухал объектыг хамгаалах үйл ажиллагаа эзэмших	-	114	32	38	40	4
14	Дотоодын цэрэг гэмт хэргийг таслан зогсоох, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад оролцох	-	32	6	4	14	8
15	Онцгой нөхцөл байдал үүссэн үеийн арга ажиллагааг эзэмших	-	22	4	14		4
Сургалтын нийт цаг			500	118	206	96	80
Онол, дадлагын харьцаа:			23.6%:76.4%				
Г.Блог хичээл							
16	Хээрийн дадлагын хичээлийг судлах	-		80			80
В.Үйлдвэрлэлийн дадлагын сургалтын цаг							
Танилцах дадлага (Дотоодын цэргийн 05, 805 дугаар анги)				40		40	
Үйлдвэрлэлийн дадлага (Дотоодын цэргийн 05, 805 дугаар анги)				56		56	
Нийт цаг						96	
Г. Танхимын бус сургалт							

№	Хичээлийн сэдэв	Дасгал	Нийт цаг	Тайлбар
1	Багшийн удирдлаган доорх бие даалт	28	28	
2	Усанд сэлэлт	120	120	
3	Мото бэлтгэл	86	86	
4	Жагсаалын бэлтгэл	52	52	
5	Клиник сургалт (Дотоодын цэргийн 05, 805 дугаар анги)	8	8	
6	Явган марш (30 км)	8	8	
7	Гүйлтүүд (3, 5, 10 км)	6	6	
8	Нийт цаг	308	308	

Түүнчлэн Дотоодын цэргийн мэргэжлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгуулах саналыг тухай бүр ЦЕГ, Дотоодын цэргийн штаб болон төгсөгчдөөс авч, суралцагчдын сахилга ёс зүй төлөвшил, хүний эрхийн мэдлэг, мэргэжлийн чадамжийг дээшлүүлэх сургалтыг хичээлийн хөтөлбөрт түлхүү оруулах талаар санал солилцож, хамтран ажилладаг байна.

Дотоодын цэргийн мэргэжлийн сургалтын 30-35%-ийг онолын хичээл, дадлага, практикийн хичээл нь 65-70%-ийг эзэлдэг байна. Мөн танилцах дадлага, үйлдвэрлэлийн дадлага, хээрийн бэлтгэлд оролцож байна.

Ахлагчийн сургуулиас сургалтын үйл ажиллагаа, чанарыг сайжруулах, захиалагч агентлаг байгууллагатай харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэх, ахлагч бүрэлдэхүүний тулгамдсан асуудлыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг нээн илрүүлэх зорилгоор жил бүр “Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд ахлагч бүрэлдэхүүний оролцоо, тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг уламжлал болгон зохион байгуулж, хурлаас гарсан зөвлөмжийг зохих байгууллагын удирдлагад /ЦЕГ, ДЦШ, ШШГЕГ, ОБЕГ, ХХЕГ г,м/ хүргүүлж байгаа нь ахлагч бүрэлдэхүүнийг дэмжих, хөгжүүлэх бодит ажил болсон байна.

АНУ-ын Калифорнийн их сургуулийн профессор Блаугийн тодорхойлсноор шинэ үеийн цагдаа, дотоодын цэргийн байгууллага нь өөрийн үйл ажиллагааг зохицуулах хууль тогтоомжтой, үйл ажиллагаа нь олон нийтэд чиглэсэн, мэргэшсэн, тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг байх гэж тодорхойлоод хамгийн гол шинж нь мэргэжлийн болон мэргэшсэн байх явдал гэж тус тус дүгнэжээ.[3]

АНУ, ХБНГУ, БНСУ, Турк улсын Дотоодын цэргийн мэргэжлийн, давтан сургалтын дундаж хугацаа 2 жилээс 3 жилийн хугацаатайгаар коллежи, их сургуулийн төвшинд шаталсан байдалтайгаар сургалтуудаа явуулж байна. ХБНГУ-ын Бавари мужийн “Нийтийн захиргаа, хууль сахиулах дээд сургууль”-ийн Дотоодын цэргийн мэргэжлийн сургалтын хөтөлбөр нь 2.5 жилийн хугацаатайгаар “Дотоодын цэргийг”[4] бэлтгэж байна. Уг сургуульд элсэн суралцах иргэн нь Герман улсын

[3] Blau P.M. “A Formal Theory of Differentiation in Organisations”, American Sociological Review 35:1999. 201-218 p

[4] Олон улсын түвшинд “цагдаа” гэдэг нэр томьёог олон нийтийн хэв журам хамгаалах улсын үйлчилгээний байгуулага, Дотоодын цэргийг зэвсэгт цагдаа, үндэсний аюулгүй байдлын гвард, дотоод аюулгүй байдлы хангагч цэрэг гэж ихэнх улс оронд тайлбарладаг. Цагдааг Англи хэлэнд “police” буюу энэ нь “журамлагч, эргүүл

бүрэн дунд боловсролтой, эрүүл мэндийн хувьд зохих шалгуурыг хангасан иргэн байхыг шаарддаг байна.

Үүнээс харахад зарим улс орны Дотоодын цэргийн сургалтын тогтолцоонд мэргэжлийн, давтан сургалтын эзлэх байр суурь нэгдүгээрт эрэмблэгдэж сургалтын төлөвлөгөөний үлэмж хэсэг нь чиглэгдсэн байна. Тухайн улсын онцлогоос хамааран "Дотоодын цэргийн" мэргэжлийн, давтан сургалт нь хэд хэдэн үе шатыг багтаасан иж бүрэн, тасралтгүй шинжтэй явагддаг байна.

Манай улсын хувьд Дотоодын цэргийн алба хаагчид түүний дотор ахлагч бүрэлдэхүүний албан үүргээ гүйцэтгэх мэдлэг, чадварын түвшин, ёс зүй, харилцааны соёл, Улсын онц чухал обьектыг хамгаалах, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах чадвар харьцангуй сул байгааг "Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгаа"[5], "Хүний эрхийн тайлан"[6]-д тус тус дурьдаад сонгон шалгаруулалт болон сургалтад анхаарал хандуулахыг зөвлөсөн байна.

Дотоодын цэргийн "Харуулчин" мэргэжлийн үүрэг ажилбарын ДАКУМ /DACUM/ шинжилгээ

DACUM буюу ажил мэргэжлийн дүн шинжилгээ хийх аргыг сургалтын төрөл, хэлбэр, хэрэгцээг тодорхойлох олон аргуудаас хамгийн үр дүнтэй, бодитой хэмээн хөгжингүй орнуудын мэргэжлийн сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагаанд хэрэглэж ирсэн.

Ажил мэргэжлийн анализ дүн шинжилгээ хийх гэдэг нь тодорхой ажил мэргэжилтэй холбоотой тавигдах ажлын шаардлагын талаарх мэдээллийг системтэйгээр олж цуглуулах үйл явц бөгөөд тухайн ажил мэргэжил тус бүрийн дэлгэрэнгүй дүрслэх тойм зураглал болдог. Өөрөөр хэлбэл алба хаагчийг ажлын байрны бодит шаардлагад нийцүүлэн бэлтгэхэд чиглэсэн, тухайн мэргэжлийн ажлын байрны үүрэг, ажилбар, алхмуудыг төвөггүй хийхэд шаардагдах тодорхой мэдлэг, чадвар, хандлагыг цогц чадамжаар нь эзэмшүүлж дадлагажуулахад чиглэнэ.

Дотоодын цэргийн "Харуулчин" мэргэжлийн сургалтын хөтөлбөрт DACUM шинжилгээг ашигласнаар дараах дэвшилд хүрнэ гэж тооцсон. Үүнд:

- Тогтсон хөтөлбөрөөр сургалт явуулахад зарим тохиолдолд шаардлагаүй мэдээлэл дамжуулж цаг алддаг. Энэ зай завсрыг DACUM арилгана.
- Яг хэрэгтэй мэдээлэл, журам зааврыг тусгай хөтөлбөрт сургалтаар олгодог.
- Чадамжийн стандартад нийцсэн ажлын байрны тодорхойлолт боловсруулж болдог
- Ажлын байрны чадамжийн нэгжийн бодит гүйцэтгэлээр ажилтанг үнэлэх боломжийг бий болгодог
- Чадамжийн стандарт, ажлын байрны тодорхойлолтод нийцүүлэн

хийгч, хуулийн хэрэгжилтийг хянагч" гэсэн утгатай, Францаар Полице (фр. police) иргэний эрх эрх чөлөөг, хэв журмыг хамгаалах захиргааний байгуулага, Германаар Polizei, (лат-politia,) нийгмийн хэв журмыг хамгаалах улсын удирдлага, Ирландаар Police- Иргэний аюулгүй байдлыг хангах, төрөөс үзүүлж байгаа тусламж, Грекээр-politeia-1. засаг захиргааны удирдлага, 2. хот, хотхоны хамгаалалт гэсэн утгатай.

[5] Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгаа, Уб. 2015

[6] Хүний эрхийн тайлан, Уб. 2018, 2019

сургалтын хөтөлбөр, хичээлийг чадамж тус бүрээр боловсруулах боломжтой.

- Хөтөлбөрийг ажлын байрны шаардлага, үүрэг, ажилбарт гарсан өөрчлөлтийн дагуу тасралтгүй сайжруулж болдог.

Энэхүү "Харуулчин" мэргэжлийн чадамжийн стандартыг "Хөтөлбөр хөгжүүлэх DACUM аргачлал", "Зааварчилгаа хөгжүүлэх, хөтөлбөрийг загварчлах SCID аргачлал" ашиглан боловсруулсан.

Дотоодын цэргийн "Харуулчин" мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг сайжруулах ажлын хүрээнд Мэргэжлийн боловсролын сургалтын арга зүйч багш, Дотоодын цэргийн 05, 09 дүгээр ангиудаас харуулчны үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид мөн миний бие хамтран харуулчны ажил, үүрэгт Дакум шинжилгээг хийсэн.

Харуулчны ажил, мэргэжлийн Дакум шинжилгээг хийхдээ үүргийг дараах байдлаар хуваасан. Үүнд:

A. Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлж, дотоодын цэргийн алба хаагчийн ёс зүйн харилцааг эрхэмлэх

B. Харуулын үүрэг гүйцэтгэх

C. Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх

D. Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх

E. Дэмжлэг үзүүлэх үүрэг гүйцэтгэх

F. Цэргийн нийтлэг дүрмүүдийг мөрдөх гэсэн 6 үүргийн дагуу цаашид ажилбаруудад хуваагдсан.

"Удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлж, дотоодын цэргийн алба хаагчийн ёс зүйн харилцааг эрхэмлэх" үүргийн хүрээнд удирдлагаас өгсөн үүргийг биелүүлэх, дотоодын цэргийн албан хаагчийн ёс зүйг сахих, авлига, хүнд суртлаас ангид байх, албаны бэлэн байдал хангах, хүний эрхийг хангах ажилбарт хуваагдсан.

"Харуулын үүрэг гүйцэтгэх" үүргийн хүрээнд харуулын бэлтгэл хангасан байх, шуурхай удирдлагын болон салбарын захирагч, харуулын даргаас үүрэг чиглэл авах, ээлж хүлээлцэх, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа явуулах, харуулын цэгт үүрэг үйцэтгэх, газар орны үзлэг хийх, зорчигч ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх гэсэн ажилбарт хуваагдсан байна.

"Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх" үүргийн хүрээнд биеийн хүч хэрэглэх, тусгай хэрэгсэл хэрэглэх , галт зэвсэг хэрэглэх ажилбаруудад хуваагдсан байна.

"Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх" үүргийн хүрээнд амьсгалын замыг чөлөөлөх, хугарал, мултралын үед анхны тусламж үзүүлэх, уус алдалтын үед анхны тусламж үзүүлэх, түлэгдэлтийн үед анхны тусламж үзүүлэх, хөлдөлт, осголтын үед анхны тусламж үзүүлэх, угаар, хордлогын үед анхны тусламж үзүүлэх ажилбаруудад хуваагдсан байна.

"Дэмжлэг үзүүлэх үүрэг гүйцэтгэх" үүргийн хүрээнд нийтийн хэв журам сахиулахад оролцох, гэмт хэргийг таслан зогсооход оролцох, олон нийтийг аюлгүй байдлыг хангахад оролцох, онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах ажилбаруудад хуваагдсан байна.

"Цэргийн нийтлэг дүрмүүдийг мөрдөх" үүргийн хүрээнд ажилбаруудад хуваагдсан байна. Эдгээр үүрэг, ажилбарууд нь чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн чадамжийн нэгж, элемент, гүцэтгэлийн шалгуур үзүүлэлт болно.

Хүснэгтээр харуулбал: Харуулчин мэргэжлийн үүрэг, ажилбарын жагсаалт

Хүснэгт №3

Үүрэг	Ажилбар
А. Өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх	А-1 Удирдлагаас өгсөн үүргийг биелүүлэх А-2 Дотоодын цэргийн албан хаагчийн ёс зүйг сахих А-3 Албаны бэлэн байдал хангах
В. Харуулын үүрэг гүйцэтгэх	В-1 Харуулын бэлтгэл хангах В-2 Харуулын үүрэг, чиглэл, зааварчилгаа авах В-3 Ээлж хүлээлцэх В-4 Харуул, хамгаалалтын үүрэг гүйцэтгэх В-5 Шалган нэвтрүүлэх үүрэг гүйцэтгэх В-6 Обьектыг түр хугацаагаар хамгаалах В-7 Зорчигч ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх
С Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх	С-1 Биеийн хүч хэрэглэх С-2 Тусгай хэрэгсэл хэрэглэх С-3 Галт зэвсэг хэрэглэх
D. Эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх	D-1 Амьсгалын замыг чөлөөлөх D-2 Хугарал, мултралын үед анхны тусламж үзүүлэх D-3 Цус алдалтын үед анхны тусламж үзүүлэх D-4 Түлэгдэлтийн үед анхны тусламж үзүүлэх D-5 Хөлдөлт, осголтын үед анхны тусламж үзүүлэх D-6 Угаар, хордлогын үед анхны тусламж үзүүлэх D-7 Амилуулах суурь тусламж үзүүлэх
Е. Дэмжлэг үзүүлэх үүрэг гүйцэтгэх	Е-1 Нийтийн хэв журам сахиулахад оролцох Е-2 Гэмт хэргийг таслан зогсооход оролцох Е-3 Олон нийтийн аюулгүй байдлыг хангахад оролцох Е-4 Онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах
F Цэргийн нийтлэг дүрмийн хэрэгжилтийг хангах	F-1 Цэргийн дотоод албаны дүрмийг мөрдөх F-2 Цэргийн сахилгын дүрмийг мөрдөх F-3 Цэргийн хүрээний ба харуулын албаны дүрмийг мөрдөх

Цаашид алхам нь /элемент/ гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд хуваагдана. Өөрөөр хэлбэл хичээлийн сэдэв, дэд сэдвүүдэд задарч байна гэж ойлгож болно. Жишээ болгож В-4 буюу "Харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх" гэсэн ажилбарт дараах гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүд байгааг хүснэгтээр харуулсан байна.

Хүснэгт №4

№	Алхам /элемент/	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
1	Хамгаалалтын системийг ашиглах	1.Объектын хамгаалалтын хүч хэрэгслийг, хамгийн оновчтой байдлаар бүлэглэн байрлуулах, 2 .Хамгаалалтын систем нь объектын хамгаалалтын найдвартай байдал, түүнд тавигдах шаардлагыг бүрэн хангасан, объектын онцлог, улирал, цаг агаарын байдалд зохицсон байна. 3.Харуулын үүрэг гүйцэтгэх байрлалаа мэдэх 4.Харуулчин (цагийн манаач), шалган нэвтрүүлэгчийн албан үүргээ гүйцэтгэх байраа мэдэх, 5.Хамгаалалтын зааг, хяналтын чиглэлээ мэдэх 6.Хамгаалалтын инженер-техникийн болон холбоо, дохиолол, хяналтын хэрэгслүүдийг ашиглан харилцах

		7.Хамгаалж байгаа объектын захиргааны болон харилцан ажиллагаатай байгууллагын ажилчдыг ялгаж таних
2	Хамгаалалтын арга хэлбэрийг сонгон хэрэглэх	1.Хамгаалж байгаа объектын онцлог, байршлаас хамааран объектыг хамгаалах хэлбэрийг сонгон авах. 2.Хяналтын хэрэгслээр хяналт үйлдэх, 3.Хамгаалах объект болон эрсдэл бүхий хэсгүүдийг байнгын хяналтад байлгах, зөрчил гарсан тохиолдолд баримтжуулах, шуурхай илрүүлэх зорилгоор хяналтын хэрэгслийг ашиглах бөгөөд оператор харуулчин хяналтыг хийх бөгөөд сэжигтэй хөдөлгөөн илэрвэл баримтжуулж, харуулын даргад мэдэгдэн харуулын даргын шийдвэрээр ажиллана. 4.Харуулын цэгийн байрнаас цонхоор хамгаалуулахаар хариуцуулж өгсөн объект, эд зүйлийг бүрэн хянахад учир дутагдалтай тул хэсэгчлэн хяналт явуулна. 5.Харуулын цэгийн гадна /хяналтын талбай/-аас хяналт үйлдэхдээ өөрийн байрлалыг зөв сонгож, хяналт явуулах чиглэлд байгаа объект, эд зүйлийг нэг бүрчлэн нүдээр бүртгэж, өөрчлөлт орсон эсэх, гадны хөдөлгөөнд ажиглалт явуулна. 6.Эргүүл хийх байдлаар хөдөлгөөнтэйгөөр хяналт үйлдэхдээ хүн нуугдаж болзошгүй газар, нүдэнд үл үзэгдэх хэсэг, аюултай дөхөц газруудад хяналт үйлдэнэ. Эргүүлийн аргаар хяналт үйлдэхийн өмнө явах чиглэл, зарцуулах хугацааг тооцож, хувцас хэрэгсэл, албаны нохойг бэлтгэнэ. 7.Хяналт үйлдэх, хосолсон буюу хөдөлгөөнтэй эргүүл хийх, нэмэлтээр шаардлагатай ачаалалтай ШНЦ-т үүрэг гүйцэтгэх 8.Мэдээллийн дагуу шуурхай арга хэмжээ авах 9.Өгөгдсөн мэдээллийг зөв боловсруулан цагийн байдалд тохируулан шийдвэр гаргах 10. Шөнийн цагт таних нэрээр харьцах, хосолсон буюу эргүүл шалгалт, хянах тавцангаас гадна талд хяналт үйлдэх
	Объектын хамгаалалтын бүс дотор газар орны үзлэг явуулах	1.Газар орны үзлэгийг хамгаалж байгаа объектод гарч болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг цаг алдалгүй илрүүлэн таслан зогсоох, болзошгүй аюул, зөрчлийн эрсдлийг бууруулах зорилгоор хийнэ. 2.Газар орны үзлэгийг байнгын, төлөвлөгөөт үзлэг гэж ангилна. 3.Байнгын үзлэгийг харуулчин өглөө, оройны байгалын гэгээ орсон, тасарсан үед , харуулд тусалж байгаа ээлж, томилогдсон бүрэлдэхүүн өдөр бүр объектын газар орны тодорхой хэсэгт хэсэгчлэн хийнэ. 4.Объектын төв хэсгээс нь зах хэсэг рүү хийх үзлэг; 5.Зах хэсгээс нь төв хэсэг рүү хийх үзлэг; 6.Зах хэсгээс нь зах хэсэг рүү хийх үзлэг гэсэн 3 хэлбэрээр явуулах. 7.Хэсэгчилж үзлэг хийх арга: Хамгаалж буйгаа объектын газар орны тодорхой хэсэг газрыг сонгон авч үзлэг хийх 8.Самналт хийх арга: Хамгаалж байгаа объектын газар орныг бүхэлд нь хамруулж хийх. 9.Тойрог маягаар үзлэг хийх арга нь Хамгаалж байгаа объектын газар орны тодорхой хэсэг газрыг сонгон авч алсаас нь дотогш, дотроос нь гадагш тойрог маягаар хийх.

Дотоодын цэргийн “Харуулчин” мэргэжлийн үүрэг, ажилбарт хийсэн дээрх шинжилгээг дараах байдлаар ашиглаж болно Үүнд:

- Ажлын байрны тодорхойлолт боловсруулах
- Үүрэг, ажилбарын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох
- Үүрэг, ажилбарын мэргэшлийн түвшний хүрээг тодорхойлох
- Мэргэжлийн ажилтан бэлтгэх
- Сонгон шалгаруулалт явуулах
- Мэргэжил ур чадварын түвшин тогтоох шалгалт авах
- Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах
- Мэргэжлийн индекс/кодыг тодорхойлох

Дотоодын цэргийн байгууллага болон бусад төрийн байгууллага, сургалтын байгууллага, ажил хайгч, иргэн, суралцагч зэрэг хэрэглэгчдийн нийтлэг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн энэхүү чадамжийн стандартыг сонирхогч талууд дараах байдлаар ашиглах боломжтой. Үүнд:

- Төрийн байгууллага хөдөлмөр эрхлэлт, мэргэжлийн боловсрол, сургалтын талаар бодлого боловсруулах, хянах, хөдөлмөрийн харилцаатай холбогдох мэдээллийг авах, ажилтны ур чадварыг үнэлэх;
- Ажил олгогчид нь ажлын байрны тодорхойлолт, аж ахуйн нэгж байгууллагын дотоод дүрэм, журам боловсруулах;
- Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалтын байгууллага, мэргэжлийн чиглэлийн сургуулиуд нь сургалтын хөтөлбөрөө боловсруулах, төгсөгчдийн ур чадварын үнэлгээ хийх, мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах;
- Ажил хайгч иргэд, иргэн, суралцагч ажлын байрны хэрэгцээ шаардлага, түүнд шаардагдах ур чадвар, мэдлэг, хандлага төлөвшил, хөдөлмөрийн нөхцөлийн талаарх мэдээллийг олж авахад ашиглаж болно.

Чадамжийн стандарт дахь мэргэжлийн үүрэг, ажилбар, мэргэшлийн түвшний хүрээ, ажлын байранд гүйцэтгэх үйл ажиллагаа, хөдөлмөрийн нөхцөл, тавигдах шаардлага, ашиглах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагын талаарх мэдээллийг ашиглан YAMAT-08 дахь мэргэшлийн нэршил, индекс/кодыг шинэчлэх үндэслэл болно.

Мөн чадамжид суурилсан сургалтын “СВТ” хөтөлбөр, ур чадварын үнэлгээний стандарт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой бусад бичиг баримтыг боловсруулахад ашиглах үндсэн мэдээллийг агуулсан суурь баримт бичиг болох юм.

Дүгнэлт. Хөгжингүй орны Дотоодын цэрэг, түүнтэй адилтгах сургалтын жишиг, Дотоодын цэрийн “Харуулчин” мэргэжлийн үүрэг, ажилбарт хийсэн ДАКУМ шинжилгээ зэргийг үндэслэн Дотоодын цэргийн мэргэжлийн сургалтыг сайжруулах дараах **дүгнэлтийг** хийж болохоор байна.

Дотоодын цэргийн “Харуулчин” мэргэжлийн үүрэг, ажилбарт ДАКУМ шинжилгээг хийгээгүй үед дараах алдаанууд гарч болзошгүй байна. Тухайлбал тогтсон хөтөлбөрөөр сургалт явуулахад зарим тохиолдолд шаардлагаүй мэдээлэл дамжуулж цаг алддаг, яг хэрэгтэй мэдээлэл, журам зааврыг хөтөлбөрт орхигдох, чадамжийн стандартад нийцсэн ажлын байрны тодорхойлолт боловсруулаагүй

байх, ажлын байрны чадамжийн нэгжийн бодит гүйцэтгэлээр ажилтанг үнэлж чадахгүй байх, хөтөлбөрийг ажлын байрны шаардлага, үүрэг, ажилбарт гарсан өөрчлөлтийн дагуу тасралтгүй сайжруулалт хийхгүй байх гэх мэт.

Цаашид манай улс Дотоодын цэргийн мэргэжлийн болон давтан сургалтыг

- УИХ-ын 2020 оны 52-р тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт тусгасан "Олон улсын шаардлага хангасан дээд боловсролын сургалтын байгууллагын тоог нэмэгдүүлж, чанарыг дээшлүүлэн олон улсад эрэмбэлэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр бүхий үндэсний судалгааны их сургуультай болсон байна, боловсролын засаглал, удирдлагын тогтолцоог тодорхой болгож, тасралтгүй сайжрах хариуцлагын тогтолцоог бүрдүүлсэн байна",

- "Монгол улсын дунд хугацааны хөгжлийн стратеги"-т "Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан дээд боловсролын салбар дундын сургалтын баазыг байгуулж, суралцагчдад ур чадварын дадлага, туршлага олгох",

- УИХ-ын 2015 оны 12-р тогтоолоор батлагдсан "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого"-д "Боловсролын олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн орон нутаг, үндэсний онцлогт суурилсан сургалтын тогтолцоог бий болгох",

- 2014 оны Засгийн газрын 79 дүгээр тогтоолоор батлагдсан "Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр"-т заасан "эрүүл, чадварлаг хүний нөөц" бүрдүүлэх зорилго, зорилтуудтай тус тус уялдуулан олон улсын "Дотоодын цэргийн мэргэжлийн сургалт"-ын жишигт нийцүүлэх шаардлагатай байна.

Иймд ХБНГУ, БНСУ, БНТУ, ОХУ, БНХАУ зэрэг орны Дотоодын цэргийн мэргэжлийн сургалтын хөтөлбөр төлөвлөгөөг манай орны онцлогт тохируулан боловсруулж сургалтын хугацааг 1 жилээс 2 жил хүртэл хугацаагаар явуулах нь үр дүнтэй гэж судлаачийн хувьд үзэж байна.

Санал. Дээрх дүгнэлтийн хүрээнд дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Дотоодын цэргийн "Харуулчин" мэргэжлийн сургалтад давтамжтайгаар ДАКУМ шинжилгээг ашиглаж сайжруулалт хийж байх;
2. Дотоодын цэргийн байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалтын талаар бодлого боловсруулах, хянах, хөдөлмөрийн харилцаатай холбогдох мэдээллийг авах, ажилтны ур чадварыг үнэлэх;
3. ДХИС-ийн харьяа Ахлагчийн сургууль нь ДЦ-ийн ахлагч бэлтгэх дамжаа төгсөгчдийн ур чадварын үнэлгээ хийх, мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах;
4. Дотоодын цэрийн "Харуулчин" мэргэжлийн үүрэг, ажилбарт хийсэн ДАКУМ шинжилгээг үндэслэн Дотоодын цэргийн байгууллага, сургалтын байгууллага, ажил хайгч, иргэн, суралцагч зэрэг хэрэглэгчдийн нийтлэг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн энэхүү чадамжийн стандартыг сонирхогч талууд ашиглах;

Тухайлбал Дотоодын цэргийн байгууллага, мөн сургалтын байгууллагууд ажлын байрны тодорхойлолт боловсруулах, үүрэг, ажилбарын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, үүрэг, ажилбарын мэргэшлийн түвшний хүрээг

тодорхойлох, мэргэжлийн ажилтан бэлтгэх, сонгон шалгаруулалт явуулах, мэргэжил ур чадварын түвшин тогтоох шалгалт авах, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, мэргэжлийн индекс/кодыг тодорхойлох гэх мэт.

5. ДХИС-ийн харъяа Ахлагчийн сургууль, ЦЕГ-ын “Цагдаа, Дотоодын цэргийн сургалын нэгдсэн төв”хамтран ахлагч бүрэлдэхүүний чадамжийг дээшлүүлэх хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх

6. ДХИС-ийн харьяа Ахлагчийн сургууль нь ДЦ-ийн ахлагч бэлтгэх дамжаа төгсөгчдийг мөшгих судалгаа хийх;

Ашигласан материал

Нэг. Хууль, тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он
- Цагдаагийн байгууллагын тухай хууль, 1993 он
- Цагдаагийн албаны тухай хууль, 2017 он
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, 1993 он
- Монгол Улсын Төрийн албаны тухайн хууль, 2002 он
- Дотоодын цэргийн тухай хууль, 2017 он
- Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017 он
- Боловсролын тухай хууль, 2002 он
- Дээд боловсролын тухай хууль, 2002 он
- Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, 2002 он .
- Гэгээрлийн болон Хууль зүйн сайдын " Хууль зүйн сургалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" хамтарсан тушаал 1997 он .
- 2003 оны 208 тоот тушаал "Албаны сургалтыг зохион байгуулж үр дүнг тооцох, тайлагнах журам" .
- Дотоодын цэргийн сургалтын стандарт. Уб 2010, 2012. ЦЕГ

Хоёр. Бусад эх сурвалж

- “Цагдаагийн байгууллагын боловсон хүчний тухай заавар" Уб. 2003 он
- Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоол "Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"
- Монголын цагдаагийн салбарт мэргэжлийн тасралтгүй боловсролыг хөгжүүлэх зарим асуудал" доктор, Ц.Наранчимэг. Уб. 2013 он
- Цагдаагийн алба хаагчдын мэргэшүүлэх сургалтын өнөөгийн байдал Р.Бат-Оргилын эрх зүйн зохицуулалт". Уб. 2008 он

ЗАМЫН ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧДААС ГАРГАЖ БУЙ САХИЛГЫН ЗӨРЧИЛ БА НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛ

FACTORS THAT CAUSE DISCIPLINARY VIOLATIONS OF TRAFFIC POLICE OFFICERS

Д.Бат-Эрдэнэ,
Цагдаа судлалын магистрант, Цагдаагийн хошууч
Bat Erdene.D
Major police, Student of the Police Studies

Хураангуй: Сахилга хариуцлагын тухай ойлголт бол зөвхөн цагдаагийн алба хаагчаар зогсохгүй нийт төрийн албаны ажлын гүйцэтгэл, хөдөлмөрийн харилцаанд ч ижил тэгш хамаардаг нэгэн цул ойлголт байдаг. Учир нь аливаа ажил үүргийг гүйцэтгэх дүрэм, журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж түүний дагуу сахилга, хариуцлагын харилцаанд төрийн алба хаагч заавал оролцдог.

Энэхүү өгүүлэлд төрийн алба хаагчийн сахилга, хариуцлага, түүний ач холбогдол болон цагдаагийн алба хаагчдаас гаргаж буй сахилгын зөрчил, тэр дундаа замын цагдаагийн алба хаагчдаас гаргаж буй сахилгын зөрчил, түүний онцлог шинж, зөрчил гаргахад нөлөөлж буй хүчин зүйл, зөрчлийг бууруулах зарим арга замын талаар товч авч үзсэн болно.

Abstract: the concept of the discipline and responsibility is not only applicable for police officers, it applies same for all public servants in terms of the completion and relations of work matters. All the regulations, bylaws and instructions of public servants are accordance with relevant laws.

This article would state about effectiveness of the responsibility of the discipline and disciplinary violations of the police officers especially traffic police officers. Moreover, this article studies what factors causing disciplinary violations of traffic police officers briefly.

Түлхүүр үг: Төрийн алба, төрийн тусгай алба хаагч, ёс суртахуун, сахилга, хариуцлага, цагдаагийн алба хаагч, замын цагдаагийн алба хаагч, иргэн

Keywords: public servant, special servant of the public, ethics, discipline, responsibility, police officer, traffic police officer, citizen

Удиртгал: Ёс суртахууны үндсэн үүрэг нь хүмүүсийн харилцааг зохицуулах, үнэлэмж баримжаалалтай болгох, зөв сэдэлтэй болгох, урьдчилан зөвөөр хандах гэх мэт ухамсрын түвшинд үнэлэгдэхүйц ойлголт юм.

Аливаа төр, улс оршин тогтнож ирсэн түүхэндээ өөрийн зорилго, чиг үүргийг тодорхойлж, түүнийгээ хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлж ирсэн нь төрийн алба бөгөөд төрийн алба нь торийг тодорхойлж ирсэн онол, арга зүй, үзэл хандлагыг дагаж мөн чанар, агуулгын хувьд хувьсаж ирсэн нь бий.[1]

Академич С.Нарангэрэл "Төр бүхэлдээ бүх ард түмнээс иш үндсээ авч байдаг бөгөөд ... үүнийг нь нийгэм болон төрөөс (бас зарчмын үүднээс болон үзэл санааны хувьд, хүн амын зүгээс ч) хүлээн зөвшөөрсөн байдаг. Нийгэм дэх хууль ёсны зарчим хатуу

[1] Д.Лүндээжанцан , Н.Жалбажав, Д.Отгонтуяа. Эрх зүйн филисофи. УБ . , 1998. 93 дахь тал

чанд, яв цав байдаг нь үүнээс үүдэлтэй юм."Үүрэг", "Хариуцлага" тэргүүн байранд тавигдаж дараа нь хууль ёсны шинж товойн гарч ирж байгаа ийм байдлаар эрх зүйг ойлгох нь ... үндэслэгээтэй байдаг.[2]

Өнөөдөр төрийн жинхэнэ албан хаагчийн ангилалд багтаж буй төрийн тусгай алба хаагч нь нийгмийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг хангасан өндөр мэдлэг, ур чадвартай, мэргэшсэн, тогтвортой байх шаардлага тулгарч байна.

Төрийн албыг ёс зүйтэй, сахилга баттай, шинэлэг сэтгэлгээ, зөв хандлагатай, чадварлаг алба хаагчдаар бүрдүүлэн, чадахуй (мерит)-н зарчимд суурилсан шатлан дэвшүүлэх тогтолцоог хэвшүүлэх нь хуулиа дээдэлдэг, иргэндээ үйлчилдэг төрийн албыг төлөвшүүлэх

Төрийн алба хаагчдын ажлын цаг ашиглалт, бүтээмжийг нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг сайжруулах, төрийн албаны стандартыг мөрдөж ажиллах, шахалт шаардлагаар биш санал санаачилгаар ажиллах соёл, дэг журмыг хэвшүүлэхэд сахилга, хариуцлага чухал ач холбогдолтой юм.

Төрийн албаны тухай хуулийн 13.1 /Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараахь албан тушаал хамаарна/-ын 13.1.4 “зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага”[3] гэж заасан байдаг.

Төрийн тусгай алба хаагчид цагдаагийн алба хаагч, тэр дундаа замын цагдаагийн алба хаагчийн сахилга, хариуцлагын талаар энэхүү өгүүлэлд товч авч үзэх болно.

Сэдвийн хамрах хүрээ: Энэхүү өгүүллийн сэдвийн хамрах хүрээ нь зөвхөн замын цагдаагийн алба хаагчдаас гаргаж буй сахилгын зөрчил, түүний онцлог шинж, зөрчил гаргахад нөлөөлж буй хүчин зүйл, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зарим арга замаар хязгаарлагдаж байна.

Үндсэн хэсэг. Төрийн албаны хариуцлагын асуудал нь нэгдүгээрт алба хаагч албаны эрх, үүргээ зөрчихгүй байх хариуцлага, хоёрдугаарт албаны эрх, үүргээ зөрчсөний төлөө хүлээх хариуцлага гэсэн агуулгаар илэрнэ.

Хууль зүйн ухааны доктор (Ph.D) Н.Мөнхзул “Төрийн тусгай алба хаагчид хүлээлгэх сахилгын хариуцлага” бүтээлдээ “Монголын төрт ёсны түүхэн хугацаанд “нийгэм” аливаа сөрөг үзэгдлээс ангид байж чадаагүй учраас төрд “хүч”-ийг ашиглах замаар хуулийн хүрээнд албадлага хэрэглэн нийгмийн сайн мууг дэнсэлж ирсэн түүхтэй. Нөгөө талаас хүчийг олсон төр засаглах эрхээ хэрэгжүүлэх явцдаа өөрийн эрх ямбаа хэтрүүлэх, дураар авирлах, хариуцлага алдаж ирсэн түүх цөөнгүй байна. Тиймээс төрийн эрх мэдэл, түүнийг хэрэгжүүлэгч алба хаагчдын хүч байх ёстой хэм хэмжээнээс хэтрэхээс сэргийлэх, төрийн эрх мэдлийг хязгаарлаж хууль зүйн түвшинд барьж

[2] С.Нарангэрэл, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо . УБ . , 2001. 6 дахь тал

[3] Төрийн мэдээлэл. 2018. №1. Төрийн албаны тухай хууль

байх үүднээс тэдэнд хууль зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг Монгол улсын үе үеийн эрх зүйн баримт бичгүүдэд тусгаж иржээ”[4] хэмээн тэмдэглээд төрийн албан хаагчдад хариуцлага оногдуулж ирсэн эрх зүйн түүхийг үечлэн тодорхойлжээ.

Үүргээ зөрчсөний төлөө хүлээх хариуцлага буюу негатив утгаар нь авч үзвэл төрийн тусгай алба хаагчид хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцаа нь хууль зүйн хариуцлагын тогтолцоотой нягт уялдаатай бөгөөд түүний дагуу төрийн тусга хаагчийн хүлээх хариуцлага нь:

- Эрүүгийн хариуцлага
- Захиргааны хариуцлага
- Хохирол нөхөн төлөх хариуцлага
- Сахилгын хариуцлага гэсэн төрөлтэй[5] байна.

Сахилгын хариуцлага нь байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, алба хаагчийн үүрэг, хориглох хэм хэмжээг тогтоосон хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан журам, заавар, дүрмээр тогтоогдсон хэм хэмжээг сахихыг шаардсан, түүнийг зөрчсөн тохиолдолд шийтгэл ногдуулах хууль зүйн хариуцлагын нэг төрөл юм.[6]

Төрийн бүх шатны байгууллагад сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж, хариуцлагатай, ил тод, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлж, иргэдийн төрд итгэх итгэлийг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас2018 оны 8 дугаар сарын 22-ны өдөр 258 дугаар “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай”[7] тогтоол гаргаж хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байдаг.

Цагдаагийн байгууллага бол Цагдаагийн албаны тухай хуульд заасан чиг үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлж, нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомжийн өөрт хамаарах эрх зүйн актын хэрэгжилтэд хяналт тавих, зөрчигдсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх үүрэг төрийн тусгай албын нэг юм.

Цагдаагийн байгууллага бол төрийн тусгай чиг үүрэг бүхий онцгой субъект болохын хувьд алба хаагчдын албан үүргээ гүйцэтгэх аливаа үйл ажиллагаанд тавигдах шаардлага, ажлын бус цагаар ч биеэ авч явах байдал нь хууль, дүрэмд захирагдаж байдаг.

Цагдаагийн алба хаагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зэрэг олон эрх зүйн актыг дагаж мөрдөх бөгөөд эдгээрт харшлах аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь сахилгын зөрчил хэмээх ойлголтыг бий болгодог. Тодруулбал зөвхөн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмаар 9 бүлэг бүхий 260 орчим журмыг кодолж өгсөн нь алба хаагчид өдөр тутмын үйл

[4] Мөнхзул Н. Төрийн тусгай алба хаагчид хүлээлгэх сахилыгн хариуцлагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал. /хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл/. Уб.2016. 54 дахь тал

[5] Нямсүрэн Ч. Эрх зүйн ерөнхий онол: Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал. Уб.2010. 397 дахь тал

[6] Мөнхзул Н. Төрийн тусгай алба хаагчид хүлээлгэх сахилыгн хариуцлагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал. /хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл/. Уб.2016. 102 дахь тал

[7] https://legalinfo.mn/mn/detail/13621

ажиллагаандаа дагаж мөрдөх шаардлагатай эрх зүйн акт болж байна.

Сүүлийн жилүүдэд цагдаагийн алба хаагчийн сахилга хариуцлагын асуудал багагүй хөндөгдөх болсон. Үүнийг тэр бүр шууд утгаараа алба хаагчийн буруутай үйл ажиллагаа гэж үзэх эсэх нь энэхүү сонгон авсан сэдвийн үндсэн шалтгаан болно. Өөрөөр хэлбэл алба хаагчийн буруутай үйл ажиллагаа нь сахилгын зөрчлийн тоог нэмэгдүүлж байна уу, бусад хүчин зүйлс нөлөөлж байна уу гэдгийг олж илрүүлэх нь чухал юм.

Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн 1.1 дүгээр зүйлд "Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрмийн зорилго нь цагдаагийн албаны хэвийн үйл ажиллагаа, захирах захирагдах ёс, хүний эрхийг хангах, алба хаагчийн сахилга, хариуцлагыг журамлан зохицуулах замаар тэдний эрх ашиг, цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр хүндийг хамгаалахад оршино"[8] гэж зааснаас харвал сахилгын зөрчилтэй холбоотой уг сэдэв нь цагдаагийн байгууллагын хэмжээнд зайлшгүй судлах сэдэв мөн болох нь харагдаж байна.

Учир нь цагдаагийн алба хаагч, тэр дундаа замын цагдаагийн алба хаагч албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тодорхой хууль, дүрэм зөрчиж, сахилгын зөрчил гаргаж байгаа нь тухайн алба хаагчийн мэдлэг, чадварын дутуу байдал болон бусад хандлагаас хамааран сахилгын зөрчлийн асуудал үүсдэг бол тухайн асуудалд мөн үнэлэлт дүгнэлт өгөх нь өнөөгийн нөхцөлд гарцаагүй тулгамдсан асуудал юм.

Цагдаагийн ерөнхий газрын 2021 оны Удирдах албан тушаалтны зөвлөгөөнөөр цагдаагийн алба хаагчийн архидан согтуурахтай холбоотой сахилга, хариуцлагын асуудлыг онцгойлон авч үзжээ. Үүнээс зарим тоо баримтыг дурдвал: Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2021 онд 1256 алба хаагч аливаа зөрчилд холбогдсоноос 255 нь архидан согтуурахтай холбоотой байна.

Алба хаагчийн сахилга, ёс зүйн зөрчилд холбогдож байгаа үндсэн шалтгаан болох архидан согтуурах явдал буурахгүй байна гэж үзжээ. Мөн түүгээр зогсохгүй 1-3 жил ажилласан алба хаагч жилд өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж байгаа алба хаагчдын 47 хувийг эзэлж байгаа нь шинээр орсон алба хаагчид цагдаагийн байгууллагад дасан зохицоход хүндрэл учирч, төсөөлөл, бодит байдлын зөрүүнээс үүдэлтэйгээр эрхэлж буй ажилдаа сэтгэл хангалуун бус байгаатай холбоотой гэж дүгнэжээ.

Мөн 2021 оны жилийн эцсийн байдлаар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдаас Авлигатай тэмцэх газарт 204, Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст 71, Тагнуулын ерөнхий газрын Мөрдөн шалгах хэлтэст 5, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын нийт 280 хэрэгт 297 алба хаагч холбогдон шалгагдсан бол өргөдөл, гомдлоор нийт 2078 алба хаагч шалгагдсан тухай судалгааг танилцуулсан байна. Тэгвэл энэхүү 2078 өргөдөл гомдлыг шалгах явцад 1102 тохиолдолд алба хаагчийн буруутай үйл ажиллагаа тогтоогдоогүй байна.

[8] Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Уб. 2018. 16 дахь тал

Эдгээрээс харвал сахилгын зөрчлийг зөвхөн хувь хүний буруутай үйл ажиллагаа мэтээр харах нь хамгийн өрөөсгөл ойлголт болох бөгөөд энэ нь ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон энэрэнгүй ёсны зарчмаас хэт хазайсан, шинэчлэл, хөгжлөөс ухарсныг илтгэж буй юм.

Алба хаагчийн өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөж буй аливаа эрх зүйн хэмжээ эргээд өөрийг нь хамгаалж чаддаг эсэх нь эргэлзээтэй бөгөөд хууль, тушаал шийдвэрийн дагуу ажилласныхаа төлөө сахилгын зөрчилд холбогдон хариуцлага хүлээдэг талаар судалгаанд оролцсон алба хаагчид нэг бус удаа дурдсан.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд гарч буй сахилгын зөрчлийн тоо хэмжээ, тухайн үйлдэгдэж буй зөрчлүүд зөвхөн сүүлийн жилүүдэд өсөөд байгаа асуудал биш бөгөөд төрөл зүйлийн хувьд ч гэсэн өмнө жилүүдэд тодорхой давтамжтайгаар өсөж байсныг дараах тоон үзүүлэлтээс харж болно.

График №1

Сүүлийн 5 жил буюу 2017-2021 оны сахилгын статистик мэдээг харвал сахилгын зөрчилд холбогдож, хариуцлага хүлээсэн алба хаагчдын дундаж 1302 буюу нийт алба хаагчдын тоонд харьцуулахад 13 хувийг эзэлж байна. Үүнээс харвал сүүлийн 5 жилд сахилгын зөрчилд холбогдож байгаа алба хаагчдын тоо үндсэндээ буурсан гэж хэлж болохоор байна.

Эдгээр онуудад сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагчдын сахилгын зөрчлийг ажлын хариуцлага алдсан, ажил тасалсан, архидан согтуурсан, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль зөрчсөн зөрчлүүд давамгайлж байгаа бөгөөд цагдаагийн төв байгууллагын зүгээс зөвхөн архидан согтуурсан сахилгын зөрчилтэй холбоотой асуудалд анхаарал хандуулж байна.

Үүний нэг илрэл нь Нээлттэй нийгэм форумын захиалгаар хийгдэж буй “Цагдаагийн албаны тухай хуулийн зарим зүйлийн хэрэгжилт” сэдэвт бодлогын судалгааны явцын тайланд дурдагдсан алба хаагчдын судалгааны асуулгад хариулснаас харвал цагдаагийн алба хаагчид сахилгын зөрчилд холбогдож байгаа нь зарим талаараа дээр дурдсанчлан алба хаагчийг хамгаалан эрх зүйн хамгаалалт дутуу дулимаг байдагтай холбоотой гэж үзжээ.

Мөн 102 тусгай дугаарт 2018 оны 4 дүгээр сараас 2021 оны 11 дүгээр сар

хүртэл Цагдаагийн алба хаагчтай холбоотой 3442 /давхардсан тоогоор болон цагдаагийн алба хаагчтай холбогдолгүй дуудлага мэдээлэл багтсан/ мэдээллээс шүүж харвал Цагдаагийн алба хаагч, техник хэрэгсэл хохирсон 287 тохиолдол байна. Харин 2450 орчим дуудлага нь цагдаагийн алба хаагчийн буруутай үйл ажиллагаатай холбоотой байна. Нийт дуудлагын 234 нь цагдаагийн алба хаагч дуудлагаар очих үед үүссэн асуудалтай холбоотой бол үүний 11 тохиолдолд цагдаагийн алба хаагч хохирсон байна.

Дээрх судалгаануудаас харвал цагдаагийн алба хаагчийн сахилгын зөрчлийн тулгамдсан асуудал нь архидан согтуурах байдал огт биш бөгөөд хууль сахин биелүүлэх, иргэдтэй харилцах чадвар зэрэгт суурилсан онол, практикын мэдлэг, ур чадварын асуудалтай холбоотой байна. Түүнээс гадна цөөнгүй алба хаагч ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гэмт хэрэгт холбогдож байгаа нь алба хаагчийн нийгмийн баталгаа тааруу байгааг шууд илтгэнэ. Түүгээр зогсохгүй өмнөх хугацаанд үйлдэгдэж байсан сахилгын зөрчлийг алба хаагчдын тоотой харьцуулахад харин ч буусан дүр зураг харагдаж байна.

Тээврийн цагдаагийн албаны алба хаагчдын 2018-2021 оны 9 дүгээр сар хүртэлх хугацааны сахилгын зөрчлийн дэлгэрэнгүй мэдээнээс харвал 2018 онд 30, 2019 онд 58, 2020 онд 42, 2021 оны 09 дүгээр сарын байдлаар 58 алба хаагч сахилгын зөрчилд холбогдсон байгаа нь цаашид өсөх хандлагатай байгааг доорхи графикаас харж болохоор байна.

График №2



Замын цагдаагийн алба хаагчдын гаргаж байгаа зөрчлийн хэлбэрээр авч үзвэл архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэж гаргасан зөрчил 2020 онд 12 байсан бол 2021 оны 09 дүгээр сарын байдлаар мөн 12, Албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргээ хангалтгүй биелүүлсний улмаас сахилгын шийтгэл оногдуулсан тохиолдол сүүлийн 2 жилд 15 нэгжээр өссөн зэрэг үзүүлэлт гарсан байна.

Замын цагдаагийн газрын статистик тоо мэдээнээс үзвэл 2019, 2021 онуудад алба хаагчдаас гаргасан сахилгын зөрчил нэмэгдэж байгаа нь доорхи графикаас харж болохоор байна.

График №3



Дээрхи хүснэгтээс харвал 4 жилийн хугацаанд гарсан нийт 219 зөрчлийн 66.95% /дундаж/ -ийг офицер эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Зөрчлийн өсөлтийг харвал 2019, 2020 онуудад тогтмол өссөн нь харагдаж байна.

Эдгээр сахилгын зөрчилд танхайрах, замын хөдөлгөөн зөрчсөн, ажлын хариуцлага алдсан, хууль зөрчсөн, дүрэмт хувцастай архи уусан, иргэдтэй харилцах харилцаа хандлагын асуудлаас үүдэлтэй байна.

Нөгөө талаар сахилгын зөрчлийн тоо нэмэгдэж байгаа нь цагдаагийн байгууллагын бүтэц, орон тоо өөрчлөгдөж, бүрэлдэхүүний тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаатай салшгүй холбоотой бөгөөд цагдаагийн төв байгууллагаас ажиллаж буй ажиллах хүчний тоонд харьцуулан дүгнэлт хийж, өмнөх үеийнхтэй харьцуулж байх нь хамгийн тодорхой, бодит дүгнэлт болно.

2020, 2021 онуудад сахилгын шийтгэл оногдуулсан байдалд дэлгэрэнгүй задаргаа хийж харвал: Нэгдүгээрт 2020 онд сахилгын шийтгэл оногдуулсан алба хаагчдын ажилласан жилийн онцлогоор 0-5 жил ажилласан алба хаагч 8, 5-15 жил ажилласан алба хаагч 18, 15 ба түүнээс дээш жил ажилласан алба хаагч 16 байх бөгөөд үүний дотор 22-оос дээш ажилласан алба хаагч 8 байна.

Харин 2021 онд сахилгын шийтгэл оногдуулсан алба хаагчдын ажилласан жилийн онцлогоор 0-5 жил ажилласан алба хаагч 8, 5-15 жил ажилласан алба хаагч 28, 15 ба түүнээс дээш жил ажилласан алба хаагч 22 байх бөгөөд үүний дотор 22-оос дээш ажилласан алба хаагч 10 байна.

Энэ нь үндсэндээ шинээр томилогдсон алба хаагчид гэхээсээ илүү дадлага туршлагатай алба хаагчид сахилгын зөрчилд холбогддог болохыг харуулж байна.

Хоёрдугаарт 2020 онд сахилгын шийтгэл оногдуулсан 42 тохиолдлын ажлын хариуцлага алдсан 23, архидан согтуурсан 13, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хууль зөрчсөн 2, үүрэг даалгавар үл биелүүлсэн 4 тохиолдол байх бөгөөд эдгээрийн 39-ийг нь хувь хүний буруутай үйл ажиллагаа гэж дүгнэжээ.

Харин 2021 оны сахилгын шийтгэл оногдуулсан 58 тохиолдлын ажлын хариуцлага алдсан 37, архидан согтуурсан 12, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хууль зөрчсөн 5, үүрэг даалгавар үл биелүүлсэн 4 тохиолдол, байх бөгөөд эдгээрийн 55-ыг нь хувь хүний буруутай үйл ажиллагаа гэж дүгнэжээ.

Эдгээр сахилгын зөрчил оногдуулах шалтгааны хамгийн өндөр хувийг эзэлж буй ажлын хариуцлага алдсан талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийвэл:

- 2020 оны хувьд хуулиар харьяалуулсан гэмт хэргийг шалгаж шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, алба хаагчийн болон удирдах албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эрх бүхий албан тушаалтны хуульд нийцсэн зөвлөмж, шийдвэрийг биелүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн, цагдаагийн төв байгууллагаас тогтоосон журмыг зөрчсөн, хамгаалуулагчийн автомашины цуваг батлагдсан маршрутаас өөр замаар авч явсан гэх зөрчлүүд давамгайлж байна.
- 2021 оны хувьд алба хаагчийн болон удирдах албан тушаалтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн, хуулиар харьяалуулсан гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн, зөрчил шалган шийдвэрлэх чиглэлээр алба хаагчдад мэргэжлийн дэмжлэг үзүүлж, түүнд хяналт тавьж дүнг танилцуулах талаар албан тушаалын тодорхойлолтод заасан зорилт чиг үүргээ хангалтгүй биелүүлсэн, Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зөрчсөн гэх зөрчлүүд давамгайлж байна.

Эдгээрээс харвал жил бүр сахилгын шийтгэл оногдуулж буй шалтгаан нөхцөл нь харьцангуй өөр бөгөөд тухайн сахилгын шийтгэлийг оногдуулж байгаа субъекттэй холбоотой байж болохоор байна.

Сүүлийн 2 жилийн хугацаанд сахилгын шийтгэл оногдуулсан нийт 100 алба хаагчийн 46 буюу 50 орчим хувь нь ахлах ба түүнээс дээш удирдах албан тушаалтнууд байна. Үүний дотор хэлтсийн дарга 19, газрын дарга 2 байна.

Хэлтсийн даргын албан тушаалтай алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулах хариуцсан нэгжийн хэмжээнд гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, түүний хэрэгжилтийг тооцохдоо холбогдох журам, аргачлалыг баримтлаагүй, хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, алба хаагчдын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй, албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн гэсэн 2 үндсэн шалтгаан байна. Түүнээс гадна аливаа сахилгын зөрчилтэй холбоотой асуудал бүр дээр байгууллагын удирдлагын зүгээс архидан согтуурах асуудлыг удаа дараа хөндөж байгаа нь судалгааны ажилд гарцаагүй дурдах тодорхой асуудлын нэг болоод байна.

Сүүлийн 2 жилд замын цагдаагийн алба хаагчдад сахилгын шийтгэл хүлээлгэсний 10 тохиолдол нь өндөржүүлсэн бэлэн байдал болон албаны бэлэн байдал зарласан үед архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн гэх шалтгаантай байна.

Энэ нь албаны дүрэмт хувцастай болон, ажлын цагаар архи, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн,

архи, согтуурруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ зам тээврийн осол гаргасан гэх шалтгаанд хамаарахгүй дүн мэдээ юм. Эндээс харвал ямар нэгэн байдлаар шууд харагдах зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүй байхгүй үед ч алба хаагчийг сахилгын зөрчилд холдогдуулж байна. Мөн удирдах албан тушаалтанд алба хаагчдын ажлын гүйцэтгэл, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй гэсэн шалтгаанаар сахилгын шийтгэл оногдуулж байгаа нь хүний эрхийн суурь зарчимд нийцэж байгаа эсэх нь эргэлзээтэй байна.

Замын цагдаагийн газраас алба хаагчдынхаа сахилга хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор алба хаагчдын харилцаа хандлагыг өөрчлөх, харилцааны зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, хурал, зөвлөлгөөн, богино хэмжээний видео хичээл, зөвлөм, гарын авлага гаргах, хувь ярилцлага хийх гэх мэт олон ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн байдаг.

Эдгээр тайлан мэдээнээс харвал зохион байгуулж байгаа ажил арга хэмжээний хувьд дутагдалтай тал харагдахгүй байх бөгөөд харин тухайн арга хэмжээний чанарыг сайжруулах, хэлбэрийг өөрчлөх шаардлага ажиглагдаж байна. Тухайлбал орчин үеийн сургалтын арга барил шавь төвьтэй буюу аливаа суралцагч бие даан суралцах, багаар хамтран ажиллах, ярилцах, асуудал дэвшүүлж гарц, гаргалгааг тодорхойлох зэрэгт тулгуурлан явагдах болсон.

Өөрөөр хэлбэл сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагчдад удирдах албан тушаалтан эсвэл сургагч багш нар биш өмнө нь сахилгын зөрчилд холбогдож арга хэмжээ авахуулсан алба хаагчид өөрсдийн алдаа дутагдалд дүгнэлт хийх байдлаар бусдад хэрэгтэй мэдээ, мэдээлэл өгөх байдлаар сургалт зохион байгуулвал илүү үр дүнтэй байж болно гэж үзэж банйа.

Үүнтэй холбоотойгоор сахилгын шийтгэл оногдуулсан алба хаагчтай холбоотой сургалтын асуудал гарч ирэх бөгөөд одоогийн зохицуулалтаар сахилгын шийтгэл хүлээсэн алба хаагч Цагдаагийн албаны тухай хуулийн 81.6[9], Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрмийн 3.3[10]-т тус тус зааснаар ёс зүйн төлбөртэй сургалтад заавал хамрагдах үүргийг хүлээдэг.

Гэтэл цагдаагийн алба хаагчийн хувийн сахилга баттай холбоотой асуудал төдийлөн ач холбогдол өгч ярьдаггүй. Хувийн сахилга бат гэдэг нь урт хугацааны зорилгодоо хүрэхийн тулд бодол, сэтгэл хөдлөлөө удирдах чадвар юм. Асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргах зэрэг “өндөр түвшний” даалгавруудыг тархины урд хэсэг гүйцэлдүүлдэг. Тархины энэ хэсэг хувийн сахилга бат болон өөрийгөө хянах чадварыг ч мөн зохицуулдаг байна.

Замын цагдаагийн алба хаагчдын сахилга, ёс зүй зөрчсөн, гэмт хэрэг үйлдсэн тухай мэдээлэл хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд цацагдаж байгаа нь Замын цагдаагийн газрын нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна.

Цагдаагийн байгууллагын үе үеийн удирдлага, хамт олон алба хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйн

[9] Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

[10] Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Уб. 2018. 15 дахь тал

байдалд санаа зовниж, тооцоо судалгаа хийж, гэмт хэрэг, зөрчлийг гаргуулахгүй байх, бууруулах талаар бодлогын түвшинд тодорхой ажлуудыг хийж иржээ.

Түүний илрэл нь Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм, Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм зэрэг бодлогын бичиг баримтууд, Цагдаагийн албаны тухай хуульд Дотоод хяналт, аюулгүй байдлын нэгж Цагдаагийн албаны тухай хуулийн 13.2-т заасан чиг, үүргийн хүрээнд ажиллах талаар тусгагдсан. Цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн зөрчил, гэмт хэрэгт холбогдох явдал сүүлийн жилүүдэд тоон үзүүлэлтээр буурсан харагдаж байгаа боловч, таслан зогсоогдохгүй байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйд хувь хүний, байгууллагын, нийгмийн хүчин зүйлс болон улс орны нөхцөл байдал эерэг, сөрөг хэлбэрээр нөлөөлж байдаг. Төрийн удирдлагын системийн хувьд алдаа дутагдал нилээн байдаг бөгөөд жишээлбэл, албан тушаал дэвших үр дүн муутай систем (Мексик, Турк), ажлын байрны тогтворгүй байдал (Мексик), сэдэлжүүлэлт муутай (Швейцар), нөхөн төлбөр, урамшуулалд нөөц хязгаарлагдмал (Унгар, Польш, Мексик, Турк), нэгдсэн үнэт зүйлс байхгүй, сэтгэл ханамжгүй ажлын орчин (Швейцар) зэрэг нь төрийн албан хаагчдын ажлын орчин нөхцлийг хангалтгүй бүрдүүлсэн байна.[11]

Цагдаагийн төв байгууллагын зүгээс алба хаагчдын сахилгын зөрчилтэй холбоотой асуудалд хэт субъектив байдлаар хандаж, илт алба хаагчдыг буруутгах үзэл санаа давамгайлж байгааг онцлон тэмдэглэж байна. Мөн сахилгын зөрчлийг хэтэрхий механик байдлаар ухамсарлаж, алба хаагчдын сэтгэл зүйн байдал, байгууллага болон алба хаагчдын харилцаанд хамаарах аливаа шинжлэх ухааны үндэслэлтэй онолуудыг баримтлахгүй зөвхөн сахилгын дүрэм, хууль тогтоомжид заасан үгээр асуудалд хандаж байгаа нь тодорхой харагдаж байна.

Үүний нэг илрэл нь цагдаагийн төв байгууллагын зүгээс аливаа хурал, зөвлөгөөний үеэр сахилгын зөрчил буухгүй байгаа улам бүр өсөөд байна гэх хандлагыг удаа дараа гаргаж алба хаагчдын албандаа хандах хандлага, итгэл үнэмшилд сөргөөр нөлөөлж байна.

Замын цагдаа нарын шаардлага жигд бус, ялгавартай ханддаг, хүнд сурталтай, дарамталдаг гэсэн судалгааны дүгнэлт гарсан бөгөөд шалтгаан нөхцлийг судалж үзэхэд хувь хүний хүмүүжил, сэтгэлгээ, хандлагаас шалтгаалж байгаа боловч цагдаагийн алба хаагчийн ажиллах нөхцөл хангалтгүй, замын зохион байгуулалтын ойлгомжгүй байдлаас жолооч, явган зорчигч нарт тухайн ойлголт төрж байна. Эдгээр шалтгаан нөхцөл тус бүрээр тодорхойлоход:

Нэг. Шаардлага жигд бус: Замын цагдаагийн алба хаагч замын хөдөлгөөний дүрмийн зөрчилд жигд шаардлага тавьж чадахгүй байгаа нь тэдний гүйцэтгэж буй үүрэгтэй холбоотой юм. Оргил ачааллын үед хөдөлгөөн зохицуулж байхдаа хамгаалах бүс хэрэглээгүй жолооч, улсын дугааргүй авто машин, бүрэн бус

[11] OECD "Trust in Government: Ethics measures in OECD countries" 2000, page 72

тээврийн хэрэгсэл гэх мэт зөрчлийг шалгадаггүй.

Замын хөдөлгөөнд хяналт тавих үедээ дээрх зөрчлөөс гадна бусад зөрчилд хариуцлага тооцон ажилладаг. Энэ нь шаардлага жигд бус байгаа юм шиг харагддаг. Мөн тодорхой зөрчлийн нэр заасан буюу “Суудлын даруулга”, “Гарц”, “Гэрэл” гэх мэт аян зохион байгуулдаг нь шаардлагыг жигд бус болгодог мэт ойлголт төрүүлж байна.

Хоёр. Ялгавартай ханддаг: Улсын дугаарын сүүлийн цифрээр хөдөлгөөнд оролцох, зорчих хэсгийн 1-р эгнээгээр зорчихгүй байх журмууд нь тусгай дуут болон гэрэл дохио тавьсан автомашинд үйлчилдэггүйтэй холбоотой иргэдийн дунд буруу олйголт үүссэн байдаг. Түүнээс гадна дугаарын хязгаарлалт хэрэгжиж эхэлэнтэй холбогдуулан дуут болон гэрэл дохионы зөвшөөрөл авах хүсэлт 8 дахин нэмэгдсэн бөгөөд одоогоор 1700 гаруй тээврийн хэрэгсэл дугаарын хязгаарлалтад орохгүй, 1-р эгнээгээр зорчиж байна гэсэн тооцоо гарчээ. Үүнийг төрийн алба тушаалтан дүрэм, журмыг биелүүлэх ёс зүй төлөвшөөгүй байдал харагдахаас гадна албан үүргээ гүйцэтгэж буй цагдаагийн алба хаагчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж байна гэж үзсэн.

Гурав. Хүнд сурталтай: Замын цагдаагийн алба хаагчийн гаргадан хүнд суртлын талаар жолооч нараас асуухад:

- зөрчлийг шуурхай шийдвэрлэхгүй уддаг,
- зам тээврийн ослын асуудлыг шийдвэрлэхдээ удаан хугацаагаар хүлээлгэдэг,
- овор ихтэй, хүнд, аюултай ачааны зөвшөөрөл олгохдоо уддаг,
- эрх хасагдсан жолоочийн асуудлыг шийдвэрлэхдээ гэмт хэрэгтэн мэт харилцдаг, чирэгдүүлдэг гэсэн хариултууд давамгайлсан байна.

Харин энэхүү илтгэлийн дүгнэлтэд цагдаагийн алба хаагчийн мэргэжлийн болон замын хөдөлгөөнд оролцогчдын талаарх ойлголтыг өөрчлөх шаардлагатай гэж дурджээ. Тэгэхээр нөгөө талаасаа замын цагдаагийн алба хаагч сахилгын зөрчилд холбогдож байгаа нь зөвхөн алба хаагчийн зүгээс үүсэж буй хүчин зүйл биш юм хэмээх ойлголтод хүрч болох ажээ.

Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм дэх заалтуудаас онцлон сахилгын зөрчилд холбогдож болох үндэслэлүүдийг тодорхойлж, түүний үр дүнгээр сахилгын зөрчлийг бууруулах арга замыг зөв тодорхойлох боломжтой гэж үзэж байна.

Дүгнэлт. Замын цагдаагийн алба хаагчийн сахилгын зөрчлийн тулгамдсан асуудал нь хууль хэрэглээ, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн байдал, харилцаа хандлага төлөвшилт ихээхэн хамаарч байгаа бөгөөд өнөө цагт алба хаагчдын албандаа дасан зохицох асуудлыг илүү шинэлэг байдлаар тодорхойлж, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн байгууллагын соёл, менежментэд суурилан албаны бүхий л харилцааг хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

Замын цагдаагийн алба хаагчийн сахилгын зөрчлийн шалтгаан нөхцөл нь байгууллагын соёл, мэргэжлийн ёс зүйтэй салшгүй холбоотой бөгөөд хууль ёсоор баталгаажсан аливаа эрх зүйн хэм хэмжээ, зан үйлийн горим журмыг дагаж мөрдөх нь хүний ухамсарт сэтгэхүйтэй шууд холбогдож байна. Зан байдал, харилцаа хандлага, мэдлэг чадвартай холбоотойгоор сахилгын зөрчил үйлдэгдэж байгаад анхаарлаа хандуулж, сахилгын зөрчлийг

бууруулах арга замыг олон талаас нь тодорхойлох шаардлага тулгарч байна.

Мөн замын цагдаагийн алба хаагчдын гаргаж буй сахилгын зөрчлийг бууруулахдаа ёс суртахуунтай холбосон ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлбэл үр дүнтэй гэж үзэж байна.

Санал. Замын цагдаагийн алба хаагчдаас гаргаж буй сахилгын зөрчлийг бууруулах чиглэлээр дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Замын цагдаагийн албан хаагчдын зан харилцаа, ёс суртахууны түвшинг тогтоох судалгаа явуулж, түүнд тохирсон арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах

2. Замын цагдаагийн хүний нөөцийг бүрдүүлэх сонгон шалгаруулж авахдаа тухайн иргэний зан харилцаа, хүмүүжлийн суурь төлөвшилтийг сайтар харгалзах зохицуулалтыг боловсруулах

3. Замын цагдаагийн алба хаагчийн гаргасан ямар зан үйлийг сахилгын зөрчилд тооцох, түүнд оногдуулах сахилгын шийтгэлийн төрөл хэмжээг тодорхой болгож, “Цагдаагийн алба хаагчийн сахилгын дүрэм”-д нэмж тусгаж өгөх

4. Замын цагдаагийн алба хаагчийн ажлын онцлог, ачааллаас үүдэлтэй стрессийг арилгах талаар төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх

5. Замын цагдаагийн газраас зөрчил гаргасан алба хаагчийн хувь хүний биед сөрөг нөлөө үзүүлж уур уцаартай, захирангуй, дээрэнгүй харьцдаг болгож байгаа сөрөг нөлөө нь хүний зан чанарт хэрхэн нөлөөлж байгаа дээр иж бүрэн судалгаа хийх

Ашигласан материал

1. Д.Лүндээжанцан, Н.Жалбажав, Д.Отгонтуяа. Эрх зүйн филисофи. Уб.1998

2. С.Нарангэрэл, Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо . Уб.2001

3. Ч.Нямсүрэн Эрх зүйн ерөнхий онол: Үндсэн ойлголт, тулгамдсан асуудал. Уб.2010.

4. Мөнхзул Н. Төрийн тусгай алба хаагчид хүлээлгэх сахилыгн хариуцлагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарим асуудал. /хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл/. Уб.2016.

5. ECD “Trust in Government: Ethics measures in OECD countries” 2000

6. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Уб. 2018.

7. Төрийн мэдээлэл. 2018. №1.

8. https://legalinfo.mn/mn/detail/13621

ЭРГҮҮЛИЙН ЦАГДААГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

SEVERAL ISSUES RELATED TO THE LEGAL REGULATION OF PATROLMEN WORK

Ц.Мягмарсүрэн
Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахлагч
Ts. Myagmarsuren
Police Sergeant, Graduate Student of the University of Internal Affairs

Хураангуй: Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах үүргийг гүйцэтгэхэд цагдаагийн эргүүл бүр хуулийн зохих мэдлэг, ухаалаг тэсвэртэй байр суурь, чанд сахилга, өндөр сонор сэрэмж, боловсон харьцаа, цэрэгжилч жагсаалч, шуурхай үйл ажиллагаа, өөрийгөө болон бусдыг хамгаалах чадварыг өвч эзэмшсэн, өргөсөн тангарагтаа үнэнч байх нь хүлээсэн үүргээ алдаа мадаггүй, биелүүлэн үндсэн нөхцөл мөн[1].

Энэхүү өгүүлэлд цагдаагийн эргүүл нэршлийн үүсэл хөгжил, үг зүйн тайлбар болон эргүүлийн цагдаа, ахлагч бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, түүний онцлог шинж, анхаарах зарим асуудлын талаар товч авч үзсэн болно.

Abstract: Knowledge of the law, sane and patient attitude, strict discipline, vigilance, courteous treatment of civilians, military and physical training, operational flexibility, self-defense skills and protection of other persons, as well as loyalty to one's oath are considered as the main conditions for patrolmen to fulfill their duty to protect public order, prevent offenses and combating crime.

This thesis work is addressed the matters on a patrolman term origin and its morphological analysis, and some issues related to the legal regulation and specific procedures of the patrolmen and sergeants' work.

Түлхүүр үг: Нийгмийн хэв журам, нийтийн хэв журам, цагдаа, эргүүл, эргүүлийн цагдаа, цагдаагийн ахлагч бүрэлдэхүүн, ахлагч цол, тодорхой ажиллагаа, эрх зүйн зохицуулалт.

Key words: Public order, police, patrol, patrolman, police sergeant, special operations, legal regulation.

Удиртгал. Хүний нийгэм, үүсэж хөгжсөн үеэс гэмт явдлын улмаас үүсэх хор аюултай нүүр тулан учирсаар ирсэн түүхтэй. Хүн төрөлхтөн гэмт явдлыг зөвхөн хатуу чанд ял шийтгэлийн хүчээр хориглон зогсоох боломжгүйг ухаарсан цагаас хойш, нийгмийн сөрөг үзэгдлийн хамгийн тод илрэл болсон гэмт явдлаас урьдчилан сэргийлэх тухай ойлголтыг бий болгожээ.[2]

Нийгмийн сөрөг үзэгдэл болох гэмт хэрэг, зөрчлийг орхих бус, харин түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй, үр дүнтэй зохион байгуулж явуулахыг эрх зүйт ёс биднээс шаардаж байна.

Ардчилсан нийгэмд цагдаагийн байгууллагын гүйцэтгэх чухал үүрэг нь Монгол Улсын Үндсэн хуулинд заасан иргэдийн эрх, эрх чөлөө, тэдний амь

[1] Баярсайхан Э. Цагдаагийн эргүүл, харуулын хийж гүйцэтгэх үйл ажиллагаа. Уб.2002. 3 дахь тал.
[2] Даштүдэв Г. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. Уб., 2007. 123 дахь тал.

нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах явдал юм.

Гэмт явдлын гаралт нутаг дэвсгэр бүрт харилцан адилгүй байдаг нь уг нийгмийн үзэгдлийн онцлог шинж бөгөөд энэ нь олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Тухайлбал, нийгэм-хүн ам зүй, нийгэм-сэтгэл зүй, нийгэм-соёлын болон аж ахуй-эдийн засгийн шинжүүдээс шалтгаалан ялгавартай байдаг.

Гэмт явдал өмнөх нийгмээс өвлөгдөж ирсэн нийгмийн түүхэн үзэгдэл юм. Гэмт хэргийг тодорхой хүн үйлддэг байхад гэмт явдал нь нийгмийн амьдралын нөхцөлөөр төрдөг, нийгмийн сөрөг үзэгдлүүд болох гэмт хэргийн нийлбэр ойголт юм. Гэмт явдал нь тухайн нийгэмд тодорхой цаг үеийн дотор үйлдэгдэн гарсан харьцангуй олон гэмт хэргүүдийн нийлбэр мөн. Харин гэмт хэрэг нь хүний бие даасан ухамсартай үйл ажиллагаа, өөрөөр хэлбэл тодорхой гэмт зан төлөвийн үр дагавар мөн[3].

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндсэн хэлбэр бол эргүүл, харуул, хамгаалалт билээ.

Сэдвийн хязгаарлалт: Цагдаагийн эргүүл тэр дундаа эргүүлийн цагдаа, ахлагч бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтаар энэхүү өгүүллийн сэдвийн хязгаарлалт тодорхойлогдож байна.

Үндсэн хэсэг. Өнөөдөр иргэний Үндсэн хуулиар баталгаажсан эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, эрх ашиг нь зөрчигдсөн тохиолдолд сэргээн хангах асуудал нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн олон байгууллагад тусгайлсан хууль тогтоомжоор зохицуулж өгсөн байдаг билээ.

Тухайлбал, Тагнуулын байгууллага, Цагдаагийн байгууллага, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Онцгой байдлын байгууллага болон Мэргэжлийн хяналтын байгууллага, Эрүүл мэндийн байгууллага гэх мэт олон байгууллагууд өөр өөрсдийн хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажилд эргүүл, харуулын хүчийг бүрэн дайчлан ажиллуулах явдал өнөөдөр чухлаар тавигдаж байна[4].

Нийгмийн хэв журам нь хүний ухамсарт амьдралын үр дүн болох зан үйл, үйлдлээр илрэх хүмүүсийн хүсэл зоригийн харилцаанаас бүрэлдэн буй болно.

Нийгмийн хэв журам гэдэг нь хүмүүсийн хоорондоо харилцах явцад хүн амын амгалан тайван байдал, иргэдийн ая тухтай амрах, хөдөлмөрлөх бололцоог хангах, төрийн ба төрийн бус байгууллагын хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилготой иргэний хэрэгцээт шаардлагатай нөхцөлдөн гарсан, Монголын ард түмний эрх ашигт нийцэх зан заншил, уламжлал, ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцааны бүхэл тогтолцоо юм[5].

Нийгмийн хэв журам тогтоох, нийтийн хэв журам сахиулах үйл

[3] Жанцан Н. Гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ. Уб. 1986. 5-6 дахь тал.

[4] Энхбаяр А. Цагдаагийн эргүүл харуулыг удирдан зохион байгуулах аргачлал. Уб. 2002. 4 дэх тал.

[5] Самбуу О. Нийгмийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр суралцагсдын гарын авлага. Уб.2008. 3 дахь тал.

ажиллагааны үндсэн хэлбэр нь эргүүл юм.

Монгол хэлний их тайлбар толинд:

- Эргүүл гэдэг үгийг "Хянах, сэргийлэх, харж хамгаалах албан тушаалтан: гудамжийн эргүүл (хотын доторх хэв журмыг сахиулагч хүн), эргүүл манаа /хоршоо/, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг харж хамгаалах, хэв журам сахиулах үүрэг бүхий хүн"

- Цагдаа гэдэг үгийг "Цагдан сэргийлэх газрын албан хаагч: сэргийлэгч: цагдаа залуу (цагдан сэргийлэхийн албан хаагч залуу), цагдаагийн арми (орон нутгийн цагдаагийн хүчинд тулгуурлан байгуулдаг зэвсэгт хүчин), цагдаагийн байгууллага (хүн ам, төр, олон нийтийн байгууллагын хэвийн ажиллаж амьдрах боломжийг хангах зорилгоор нийгмийн дэг журмыг сахин хамгаалж, хэрэг зөрчлөөс сэргийлэх, таслан зогсоох үүрэг бүхий төрийн захиргааны тусгай байгууллага), замын цагдаа (замын хөдөлгөөний журмыг сахиулагч), хэсгийн цагдаа (засаг захиргааны хамгийн бага нэгжийн аюулгүй, амгалан тайван байдлыг сахиулах сэргийлэгч[6])" хэмээн тодорхойлжээ.

Цагдаагийн эргүүл, харуул нь гудамж талбай, тээврийн зам, нисэх ба төмөр замын буудал, цэнгэлдэх хүрээлэн, цэцэрлэг, үзвэр үйлчилгээний газар түүнчлэн нийтийг хамарсан болон иргэний хамгаалалтын арга хэмжээ явуулж байгаа үед хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх гол хүч юм. Олон нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гэмт хэрэг илрүүлэх, гэмт этгээдийг эрэн сурвалжлах, баривчлах үйл ажиллагаа нь цагдаагийн эргүүл, харуулын гол үүрэг мөн[7].

Цагдаагийн байгууллагын нийт алба хаагчдын 60 гаруй хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлдэг. Тэр дундаа ахлагч бүрэлдэхүүний 80 гаруй хувийг нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны харьяанд багтан, нийтийн хэв журам сахиулах үүргийг голлон гүйцэтгэж байна.

Цагдаагийн эргүүл гэж гудамж, талбай, үйлчилгээний цэг зэрэг олон нийтийн газарт гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах зорилгоор ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг[8] ойлгоно.

Цагдаагийн эргүүлийн үйл ажиллагаа нь цагдаагийн нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилготой хийгдэж буй цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн нэг чиглэл гэж үзэж байна.

Эргүүл нь англи хэлэнд "patrol", орос хэлэнд "патруль" гэсэн үгээр хэрэглэгдэж байна. Patrol гэдэг нь "тусгай газар зүйн бүсэд хяналт тавих үүрэг хүлээсэн хууль сахиулах болон цэргийн албан хаагчид, эсвэл хувийн аюулгүй байдлын гэрээт гүйцэтгэгч" гэж тодорхойлжээ[9].

Эргүүл буюу Patrol гэсэн үгийг "merriam-webster"-ийн толь бичигт дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

[6] https://mongoltoli.mn/dictionary/detail/136783

[7] Энхбаяр А. Цагдаагийн эргүүл харуулыг удирдан зохион байгуулах аргачлал. Уб. 2002. 4 дэх тал.

[8] ЦЕГ-ын даргын 2014 оны 01 сарын 22-ны өдрийн 34 дүгээр тушаалаар батлагдсан "Цагдаагийн эргүүл харуулын дүрэм"-ийн 2.1.1.

[9] www.google.mn. https://en.wikipedia.org/wiki/Patrol

1. Ажиглалт хийх, аюулгүй байдлыг хангах зорилгоор харуулын гинжин хэлхээний дагуу тойрон алхах, замаар дайран өнгөрөх үйл ажиллагаа; Туршилт, аюулгүй байдал, байлдааны ажилд зориулсан хүн буюу тээврийн хэрэгслийн нэгж;

2. Скаутын ахлагч[10] гэж тайлбарлажээ.

Судлаач Т.Батсүх "Цагдан сэргийлэхийн сэргийлэн хамгаалах алба" номондоо "эргүүл гэдэг нь хэв журам сахиулах, гэмт хэрэгтэй тэмцэх цагдан сэргийлэхийн харуулын үндсэн төрөл юм"[11] тодорхойлжээ.

Доктор Г.Ганбаатар "Эргүүлийн үйл ажиллагааг зохион байгуулж байгаа төрлөөс хамаарч дараах ерөнхий байдлаар ангилан авч үзсэн байна"[12]. Үүнд:

- Хууль сахиулах байгууллагын эргүүл;
- Иргэдийн оролцоот эргүүл;
- Аж, ахуйн нэгж, байгууллагын эргүүл.

Гудамж талбай, олон нийтийн газарт хэв журам сахиулах үүрэг гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлийн талаарх дуудлага мэдээлэлд шуурхай очих, цагдаагийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг халуун мөрөөр нь илрүүлэх, таслан зогсоох, баривчлах, хэрэг учралын газрыг хамгаалах, зөрчлийг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг бөгөөд үүнийг цагдаагийн эргүүл гэж нэрлэдэг[13].

Цагдаагийн эргүүл гэж гудамж, талбай, үйлчилгээний цэг зэрэг олон нийтийн газарт гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах зорилгоор ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч[14]-ийг ойлгоно. Цагдаагийн эргүүлийг явуулж буй үүрэг гүйцэтгэж буй хэлбэр, орчин нөхцөлөөс нь хамаарч дараах 2 үндсэн хэлбэрийн эргүүлд хуваан үзэж болохоор байна. Үүнд:

- Явган эргүүл
- Хөдөлгөөнт эргүүл гэж 2 ангилж болно[15].

Явган эргүүлд дараах эргүүлүүдийг хамааруулан авч үзэж болохоор байна. Тухайлбал:

1. Явган эргүүл;
2. Явуулын эргүүл;
3. Нохойтой эргүүл;
4. Дугуйт эргүүл;
5. Хүч нэмэгдүүлсэн эргүүл;
6. Галт тэрэгний дагалдах эргүүл.

Харин хөдөлгөөнт эргүүлд дараах эргүүлүүдийг хамааруулан авч үзэж болохоор байна. Үүнд:

1. машинт эргүүл;
2. морьт эргүүл;
3. мотоциклтой эргүүл;
4. завьтай эргүүл;
5. байгаль хамгаалах эргүүл.

Дээр дурдагдсан нийт 11 эргүүлийн төрөл байх бөгөөд дийлэнх буюу 7 эргүүлийн нэр томьёоны тодорхойлолтыг өнөөдөр хүртэл хууль тогтоомж, эрх зүйн актанд нарийвчлан тодорхойлж өгөөгүй байна.

[10] www.merriam-webster.com/dictionary/patrol
[11] Т. Батсүх. Цагдан сэргийлэхийн сэргийлэн хамгаалах алба. УБ. 1975. 64 дэх тал.
[12] Хууль сахиулахуй сэтгүүл. 2016.№ 02
[13] Хууль сахиулахуй сэтгүүл. 2016.№ 02
[14] Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 01 сарын 22-ны өдрийн 34 дүгээр тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Цагдаагийн эргүүл харуулын дүрэм"-ийн 2.1.1
[15] Монгол Улсын ЗГ-ын 1994 оны 106 дугаар тогтоол. Цагдаагийн эргүүл харуулын дүрэм.

Цагдаагийн эргүүл, харуулын дүрэмд дараах 4 эргүүлийн нэр томьёоны тодорхойлолтыг тусгасан байна. Үүнд:

- ”Цагдаагийн эргүүл” - гудамж, талбай, үйлчилгээний цэг зэрэг олон нийтийн газарт гэмт хэрэгтэй тэмцэх, хэв журам сахиулах зорилгоор ажиллаж байгаа цагдаагийн алба хаагчийг;
- Нийтийн хэв журмын эргүүл” - эргүүлийн нэг чиглэлд ажиллах үүрэгтэй эргүүлийг;
- ”Хөдөлгөөнт эргүүл” - эргүүлийн хоёр ба түүнээс дээш чиглэлийн хооронд явж ажиллах эргүүлийг;
- ”Явуулын эргүүл” - тээврийн хэрэгслээр болон явган аялагчдыг дагаж ажиллах эргүүлийг хэлнэ[16] гэж тодорхойлжээ.

“The Police in America” номонд[17] эргүүлийг цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны үндсэн хэсэг гэж үздэг Үүнд:

1. Цагдаагийн ажилтны ихэнх нь эргүүл хийхээр томилогдсон бөгөөд үйл ажиллагааны дийлэнх хувийг эзэлдэг.
2. Цагдаагийн эргүүл нь цагдаагийн үйл ажиллагаанд маш чухал шийдвэр гаргагч бөгөөд гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны хаалгач.
3. Цагдаагийн эргүүл хийсэн туршлага нь цагдаагийн алба хаагчийн мэргэжил дээшлүүлэх үндэс нь болдог.

Цагдаагийн эргүүл нь цагдаагийн үйл ажиллагааны олон нийтэд харагдаж буй бэлэг тэмдэг юм.[18]

Цагдаагийн эргүүлийг явган, унадаг дугуй, морь, тээврийн хэрэгслээр эргүүл хийж болох бөгөөд цагдаагийн хувцастай, энгийн хувцастай, дангаараа эсвэл хосоороо эргүүл хийж болно.

Эргүүлийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд хийсэн судалгааны үндсэн дээр ажиллуулна[19].

Цагдаагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа ахлагч бүрэлдэхүүн нь дараах хуулийг удирдлага болгон мөрдөж ажиллана. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Цагдаагийн албаны тухай хууль;
3. Зөрчлийн тухай хууль;
4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
5. Гэр бүл хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль;
6. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль;
7. Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн хүнийг албадан эрүүлжүүлэх тухай хууль;
8. Тамхины хяналтын тухай хууль;
9. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль;
10. Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль зэрэг 10 гаруй хууль нь цагдаагийн эргүүлийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс болж байна.

Мөн цагдаагийн эргүүлийн ахлагч бүрэлдэхүүний үйл ажиллагаа нь ерөнхий харилцааг зохицуулсан 3

[16] Барбаатар Н. Цагдаагийн эргүүлийн офицерын гүйцэтгэх үүрэг, түүнд хийсэн дүн шинжилгээ. /Магистрын зэрэг горилсон судалгааны ажил/. Уб.2020. 11 дэх тал.

[17] www.google.mn. Samual Walker, Charles M Katz The police of America an introduction. 5th edition. 195p.

[18] Барбаатар Н. Цагдаагийн эргүүлийн офицерын гүйцэтгэх үүрэг, түүнд хийсэн дүн шинжилгээ. /Магистрын зэрэг горилсон судалгааны ажил/. Уб.2020. 8 дахь тал.

[19] Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Уб.2018. 569 дэх тал.

дүрэм, 1 стандарт, тодорхой харилцааг зохицуулсан 36 журам, болон төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тухайн цаг үеийн шинжтэй гаргасан тогтоол, захирамж, тушаал, шийдвэр, үүрэг даалгавар зэргээр үйл ажиллагааны эрх зүйн үндэс тодорхойлогдож байна.

Ерөнхий харилцааг зохицуулсан эрх зүйн акт:

Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм, Сахилгын дүрэм, Цагдаагийн алба хаагчийн ёс зүйн дүрэм,[20] Цагдаагийн эргүүлийн стандарт[21], ЗД-ийн захирамж, ИТХ-ын тогтоол гэх мэт.

Тодорхой харилцааг зохицуулсан эрх зүйн акт:

Гэмт хэрэг, зөрчлийн талаар гомдол, мэдээлэл хүлээн авах журам /код 202/, Гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах журам /код 205/, Осол, гэмтлийн үед анхны тусламж үзүүлэх журам /код 209/, Тэсэрч дэлбэрэх, химийн хорт болон цацраг идэвхт бодисын талаарх мэдээлэл хүлээн авч, ажиллах журам /код 211/, Биечилсэн судалгаа хийх журам /код 212/, Гэмт хэрэг, зөрчлийг шалгах хойшлуулшгүй ажиллагааны журам /код 213/, Бичиг баримтыг үзэж шалгах журам /код 214/, Хүний бие, тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийх журам /код 215/, Эд зүйл, хөрөнгө, мөнгө агуулсан байр савыг битүүмжлэх журам /код 216/, Эд зүйл, тээврийн хэрэгсэл, баримт бичиг түр хураан авах журам /код 217/, Иргэн, албан тушаалтнаас тайлбар авах, гаргуулах журам /код 218/, Шинжилгээнд зориулж дээж, дардас, хэв хэлбэр, загвар авах журам /код 219/, Согтуурулах ундаа, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх, хордуулах бодис хэрэглэсэн эсэхийг шалгах журам /код 220/, Нутаг дэвсгэр, орон байранд нэвтрэн орох, гарахад хяналт тогтоох журам /код 221/, Байгууллага, иргэний орон байранд нэвтрэн орох журам /код 222/, Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүнийг баривчлах, төрийн байгууллагад хүргэх журам /код 223/, Замын хөдөлгөөний урсгал, чиглэлийг түр өөрчлөх, хаах журам /код 224/, Түр саатуулах журам /код 225/, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх журам /код 227/, Эрэн сурвалжлах журам /код 229/, Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон гадаадын иргэнтэй харилцах журам /код 232/, Тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэх журам /код 233/, Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх журам /код 234/, Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах журам /код 240/, Тэмдэглэл, илтгэх хуудас үйлдэх журам /код 245/[22], Цагдаагийн эргүүл, харуулын дүрмийг хэрэгжүүлэх журам /код 400/, Эргүүлийн үүрэг гүйцэтгэх журам /код 401/, Авто эргүүл ажиллах журам /код 402/, Морьт эргүүл хийх журам /код 403/, Нийтийн болон хэв журмын урамшилтай эргүүл, жижүүрийг мэргэжлийн удирдлагаар хангаж, хамтран ажиллах журам /код 404/, Замын хөдөлгөөнийг зохицуулах, хянаж шалгах журам /код 406/, Зөрчлийг хянан шийдвэрлэх журам /код 408/[23] Дипломат төлөөлөгчийн газар, улсын онц чухал обьектын харуул, хамгаалалтыг зохион байгуулах /код 501/, Жагсаал, цуглааны үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах /код 502/, Жагсаал, цуглааныг албадан тараах /код 503/, Нийтийн эмх

[20] Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Уб.2018. 13-15 дахь тал

[21] ЦЕГ-ын даргын 2019 оны 6 дугаар сарын 21-ны өдрийн А/156 тоот тушаалаар баталсан.

[22] ЦЕГ-ын даргын 2017 оны 12 сарын 28-ны өдрийн А/262 тоот тушаалаар батлагдсан.

[23] Мөн өдрийн А/264 тоот тушаалаар батлагдсан.

замбараагүй байдал үүссэн үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах /код 504/, Онц байдал зарласан үед нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах /код 505/, Төрийн болон гадаадын дээд хэмжээний зочин төлөөлөгчийн айлчлалын үед хамгаалалт зохион байгуулах /код 506/, Гамшгийн үеийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 508/[24] зэрэг нийтдээ 39 үйл ажиллагааны журмаар цагдаагийн эргүүлийн ахлагч бүрэлдэхүүнээс явуулах тодорхой ажиллагаа зохицуулагдаж байна.

Энд нэг зүйлийг онцлон авч үзэхэд эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа эргүүлийн цагдаагийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт нь эргүүлийн офицерийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалттай адил бөгөөд офицер, цагдаа гэсэн ялгагдах зохицуулалт байхгүй, цагдаагийн алба хаагч гэсэн нийтлэг зохицуулалтаар үйл ажиллагаа явагддаг байна.

Эрх, үүргийн хувьд дээрхи зохицуулалтуудын зарим нь шууд эрх олгосон, харин зарим нь цагдаагийн байгууллагад олгосон эрх хэмжээний хүрээнд эдлэх эрх байгаа бөгөөд эргүүлийн офицер, цагдаа гэж ялгагдахгүй байдаг байна.

Гэвч энэ нь эргүүлийн цагдаа, алба хаагч гэсэн нэршлээр биш цагдаагийн алба хаагч гэсэн нийтлэг эрхээр олгогдсон эрхийн хүрээнд зохицуулагдсан байна.

Зарим талаараа эргүүлийн цагдаа ба цагдаагийн алба хаагч гэсэн нэрээр биш цагдаагийн байгууллага гэсэн нэр томьёоны хүрээнд олгогдсон эрх нь цагдаагийн алба хаагч эдэлж болохоор зохицуулагдсан байдаг байна. Тухайлбал, Цагдаагийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д “Цагдаагийн байгууллага гамшиг, хорио цээрийн дэглэм сахиулах хүрээнд нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах хэлбэрээр хяналт тавина”[25] гэсэн заалт цагдаагийн алба хаагч гэж тусгаагүй боловч цагдаагийн байгууллага хяналт тавихаар заажээ.

Цагдаагийн алба хаагчийн хуулиар олгогдсон бүх эрхийг эргүүлийн цагдаа эдлэх бүрэн боломжтой юм. Эргүүлийн цагдаа нь цагдаагийн дэд ахлагч, цагдаагийн ахлагч, цагдаагийн ахлах ахлагч, сургагч ахлагч гэсэн цолтой байна.

Цагдаагийн албаны тухай хуульд эргүүлтэй холбоотой 5 зүйл заалт бүхий зохицуулалт байна. Тухайлбал:

- 11 дүгээр зүйл /Нийтийн хэв журам хамгаалах/-ийн 11.1.2.гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих;
- 14.3.Цагдаагийн төв байгууллага нь нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд дараахь үүрэг гүйцэтгэнэ: 14.3.3.гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл судалгаанд үндэслэн урьдчилан сэргийлэх, эргүүлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стандарт, дүрэм, журам, заавар, зөвлөмж боловсруулах, боловсронгуй болгох, биелэлтийг хангах;
- 21 дүгээр зүйл /Цагдаагийн төв байгууллагын даргын бүрэн эрх/-ийн

[24] ЦЕГ-ын даргын 2017 оны 12 сарын 28-ны өдрийн А/265 тоот тушаалаар батлагдсан.

[25] Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

21.1.3.цагдаагийн байгууллагын дотоод албаны дүрэм, цагдаагийн хүрээний болон эргүүл, харуулын дүрэм, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх бусад дүрэм, журам, зааврыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангуулах;

- 54 дүгээр зүйл /Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх/-ийн 54.6.4.тусгай хэрэгслийн үйлчлэл дуусах, эсхүл үүссэн аюултай нөхцөл арилах хүртэл тухайн орчинд эргүүл, хамгаалалт гаргаж, зөвлөгөө, сануулга өгөх

- 86 дугаар зүйл /Нийгмийн баталгаа/-ийн 86.2.Цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал обьектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно.[26]

Цагдаагийн албаны тухай хуульд заасан эргүүлтэй холбоотой дээрхи зохицуулалтууд нь эргүүл хийхтэй техник хэрэгсэл ашиглах, цагдаагийн төв байгууллагаас эргүүлийн үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн акт гаргах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг хангуулах, хүндэрсэн нөхцөл байдал хэвийн горимд ортол эргүүл хийх, эргүүлд ажилласан хугацааг 1 жил 3 сараар тооцох зэрэг 5 харилцааг зохицуулсан байна.

Цагдаагийн эргүүл нь дараах үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

а/гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, хэв журам сахиулах;

б/цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандартыг дагаж мөрдөх;

в/эргүүлийн чиглэлийн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлын талаар биечилсэн судалгаа хийж, эргүүлийн чиглэлийн орчинд хяналт тавьж ажиллах;

г/гэмт хэрэг, зөрчлийн талаар иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авч, шуурхай арга хэмжээ авах;

д/хуульд заасан хойшлуулшгүй ажиллагаа явуулах;

е/иргэдтэй холбоотой ажиллах, тусламж, туслалцаа үзүүлэх, тэдэнд тулгарч буй асуудлыг аль боломжтой байдлаар хуулийн дагуу шийдвэрлэх, зөвлөх;

ж/онцлог нөхцөл байдлын талаар иргэдээс ирүүлсэн санал, гомдлыг хүлээн авч жижүүрийн ахлах офицерт мэдэгдэх;

з/мэдээлэл өгсөн иргэний овог, нэр, гэрийн хаяг, утасны дугаарыг нэг бүрчлэн бичиж тэмдэглэж авах, дуудлага мэдээллийн хяналтын хуудас бөглүүлэх;

и/гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээд оргон зугтаасан үед цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 223-т заасныг баримтлах;

к/гэмт этгээдийн бие, эд зүйлд үзлэг хийхдээ цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 215-д заасныг баримтлах;

л/сэжигтэй этгээдийг саатуулан шалгахдаа Цагдаагийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан үндэслэлээр шалгах;

[26] Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

м/нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж, ноцтойгоор танхайрч буй этгээдүүдийн үйлдлийн талаар шуурхай удирдлагын төвд нэн яаралтай мэдэгдэж, өөрийн аюулгүй байдлыг хангаж, гэмт хэргийн өрнөлийг баримтжуулж, боломжгүй тохиолдолд нэмэлт хүч, хэрэгслийн тусламжтайгаар түүнийг таслан зогсоох;

н/гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээд цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн тохиолдолд биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсгийг Цагдаагийн албаны тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтран баталсан 2017 оны А/224/А/102 дугаар тушаалаар баталсан зааварт заасны дагуу хэрэглэх;

о/илрүүлсэн хэрэг, зөрчил, нөхцөл байдлын талаар илтгэх хуудас бичиж, нэгдсэн тоо бүртгэлд оруулах;

п/хоногт хийсэн ажлаа тэмдэглэн, тооцоо хөтлөх[27].

Дээрхи үүргүүд нь зөвхөн гудамж талбай, олон нийтийн газар нийтийн хэв журам сахиулах, өөрөөр хэлбэл нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам болон эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан тушаал, шийдвэрийн биелэлтэд хяналт тавихтай холбоотой зохицуулалтууд тусгагдсан байна.

Харин гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, захиргааны хяналт тавихтай холбоотой үүргүүдийг дээрхи журамд тусгаагүй байна.

Эргүүлийн үүрэг гүйцэтгэх цагдаа нь хариуцсан чиглэлд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллана.

Цагдаагийн эргүүлийн үйл ажиллагаанд нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга, эргүүл хариуцсан нэгжийн дарга нь эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг үнэлж, дүгнэн, эргүүлийн ажлын үр дүнтэй тогтмол танилцаж, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн, удирдлага зохион байгуулалтаар ханган, хяналт тавьж ажиллана.

Цагдаагийн эргүүл, харуулын томилгоог тухайн цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр томилно. Эргүүлийн хэсэг бүрд ахлагч томилно. Албан үүргээ гүйцэтгэж байгаа эргүүл, харуулыг татан буулгах, бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах эрхийг зөвхөн тухайн эргүүл, харуулыг томилсон дарга эдэлнэ[28].

2021 онд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагч, ажилтнуудаас албан үүргээ гүйцэтгэх явцдаа зөрчлийн шинжтэй 9 үйлдэлд 9 алба хаагч, гэмт хэргийн шинжтэй 171 үйлдэлд 187 алба хаагч тус тус өртөж хохирсон байна[29].

Гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирсон алба хаагчдын дийлэнхи нь нийтийн хэв журам сахиулах үүрэг гүйцэтгэж байгаа эргүүлийн цагдаа бөгөөд цагдаагийн ахлагч бүрэлдэхүүн өртсөн нь анхаарал татсан асуудал болж байна.

[27] Эргүүлийн үүрэг гүйцэтгэх журам /код 401-ын 401.4.1.

[28] Эргүүл харуулын дүрмийн 3 дугаар зүйл /Цагдаагийн эргүүл, харуулын удирдлага, зохион байгуулалт/-ийн 3.1-3.3

[29] https://police.gov.mn. ЦЕГ-ы 2021 оны үйл ажиллагааны тайлангаас хэсэгчилэн авав.

Зөвхөн 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр иргэдээс нийт 1696 дуудлага мэдээлэл хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн байна. Үүнээс Нийслэл хотод гэмт хэргийн-72, зөрчлийн-619, гэр бүл хүчирхийллийн-103, зам тээврийн ослын-237, бусад 302 нийт 1333 дуудлага мэдээллийг шуурхай шалгаж шийдвэрлэсэн байна[30].

Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, коронавируст халдварын цар тахлаас хүн амыг урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагчийн тушаалаар нийт бие бүрэлдэхүүнийг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 2, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт 3 удаа шилжүүлэн хорио цээрийн дэглэм сахиулах хамгаалалт, зохицуулалтад давхардсан тоогоор 386.056, гадаад улсаас Монгол Улсын иргэдийг татан авах 354 удаагийн тусгай үүргийн нислэг, хилийн боомтоор 77 удаагийн татан авах, тусгаарлах үеийн хамгаалалтад давхардсан тоогоор 14.455, вакцины 47 удаагийн татан авалтаар 7.828.690 хүн/тунг татан авч, хүргэх үеийн хамгаалалт, зохицуулалтад 341 алба хаагч тус тус үүрэг гүйцэтгэсэн.

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний газруудад холбогдох журам, тусгай нөхцөл шаардлага, Хариуцлагын гэрээний хэрэгжилтийг хангуулах зорилгоор “Худалдаа, үйлчилгээний газруудад хийх хамтарсан хяналт шалгалтын удирдамж”- ийг баталж, энэ оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс хойших хугацаанд Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтарсан хяналт, шалгалтыг зохион байгуулж, цагдаагийн байгууллагаас давхардсан тоогоор 12131, Мэргэжлийн хяналтын газраас 9222, Нийслэлийн захирагчийн албанаас 10599, нийт давхардсан тоогоор 31952 алба хаагч үүрэг гүйцэтгэж, 77005 иргэн, хуулийн этгээдийг шалгаж, хариуцлагын гэрээгүй үйл ажиллагаа явуулсан 341, Корона вируст халдвар /КОВИД-19/-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам зөрчсөн 10583, тусгай нөхцөл шаардлага зөрчсөн 1616, цаг хэтрүүлэн ажилласан 390, бусад 1085 нийт 14015 зөрчил илрүүлж, 8893 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 1921 зөрчилд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж нийт 262 хуулийн этгээд, 1549 хүнийг 352.900.000 төгрөгөөр торгожээ[31].

Дээрхи бүх хамгаалалт болон зөрчил шалгах ажиллагааны дийлэнхи хэсгийг нийтийн хэв журам хамгаалах үүрэг бүхий эргүүлийн цагдаа нар хэрэгжүүлсэн нь тэдний ажлын ачаалал ямар өндөр болохын зэрэгцээ үндсэн үүргийн нэг болохыг харж болохоор байна.

Ард иргэдтэй хамгийн их ойр байж, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа эргүүлийн цагдаа нараас гаргаж байгаа сахилгын зөрчил нь ихэвчлэн хувь хүний суурь хүмүүжил, албандаа хандаж байгаа сэтгэлгээний сөрөг

[30] https://www.facebook.com/hevjurmiinalba/

[31] Police.gov.mn. ЦЕГ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлангаас хэсэгчилэн авав.

хандлага төлөвшсөн байгаатай холбон үзэж болохоор байна.

Тиймээс эргүүлийн цагдаа нарын ажлын ачааллаас үүдэлтэй сэтгэл зүйн сөрөг хандлагыг тодорхой үе шаттайгаар өөрчлөх ажлыг зохион байгуулалттай хийх, энэ талын зохицуулалтыг хууль тогтоомж, эрх зүйн актад тусгаж өгөх шаардлагатай байна.

Дүгнэлт. Иргэд олон түмэнтэй нэн тэргүүнд нүүр тулан ажиллаж, харилцдаг утгаараа цагдаагийн байгууллагын нэр хүнд, нүүр царайг харуулдаг голлох алба бол Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба бөгөөд тус албаны нийт бие бүрэлдэхүүний 70 гаруй хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлдэг бөгөөд эргүүлийн цагдаа нар хэв журам сахиулах үндсэн хүч хэрэгсэл болдог юм байна.

Эргүүлийн цагдаа нарын гүйцэтгэх үүрэг, тодорхой ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны эрх зүйн үндэс нь 10 гаруй хууль, ерөнхий харилцааг зохицуулсан 3 дүрэм, 1 стандарт, тодорхой харилцааг зохицуулсан 40 орчим журмаар зохицуулагддаг байна.

Эргүүлийн цагдаа буюу ахлагч бүрэлдэхүүний үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан эрх зүйн зохицуулалт байхгүй бөгөөд цагдаагийн алба хаагч гэсэн нийтлэг нэршлээр нийтлэг шинжтэй эрх зүйн актаар зохицуулсаар иржээ.

Санал. Хууль сахиулах үйл ажиллагаанд оролцож эргүүлийн цагдаа нарын чадавхыг дээшлүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс дараах саналыг дэвшүүлж байна.сайжруулах үүднээс дараах саналыг дэвшүүлж байна.

1. Эргүүлийн цагдаа нарын гүйцэтгэх үүрэг, түүний эрх хэмжээг эргүүлийн офицерын гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээнээс ялгамжтай байдлаар тодорхойлж, Цагдаагийн эргүүл, харуулын дүрэм болон Эргүүлийн үүрэг гүйцэтгэх журам /код 401/-д тусгаж өгөх;
2. Эргүүлийн цагдаа нарт олон шат дамжлагын дарга нараас өгч буй үүрэг, даалгаврын давхардлыг арилгаж, нэгдсэн нэг удирдлагаар хангаж өгдөг зохицуулалтыг Цагдаагийн эргүүл, харуулын дүрэмд тусгаж өгөх;
3. Цагдаагийн эргүүлийн стандартын талаар 4 цагийн сургалтыг хагас жил дутам явуулж, байнга сануулж хэвшүүлэх;
4. Цагдаагийн эргүүлийн байршлыг зөв оновчтой тодорхойлох, гэмт хэрэг, зөрчил их гардаг эмзэг цэгүүд дээр тодорхой цагуудад эргүүлийг ажиллуулах, бусад цагт нь амраах зохицуулалтыг нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага анхаарч ажиллах.

Ашигласан материал

Монгол Улсын хууль тогтоомж:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Цагдаагийн албаны тухай хууль
3. Зөрчлийн тухай хууль
4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
5. Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль
6. Гэр бүл хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль;
7. Тамхины хяналтын тухай хууль
8. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль

9. Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль

Ном сурах бичиг, гарын авлага:

10.Т. Батсүх. Цагдан сэргийлэхийн сэргийлэн хамгаалах алба. Уб.1975.

11.Н.Жанцан. Гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ. Уб. 1986.

12.Э.Баярсайхан. Цагдаагийн эргүүл, харуулын хийж гүйцэтгэх үйл ажиллагаа. Уб.2002.

13.А.Энхбаяр. Цагдаагийн эргүүл харуулыг удирдан зохион байгуулах аргачлал. Уб. 2002.

14.Г.Даштүдэв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй. Уб., 2007.

15.О.Самбуу Нийгмийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр суралцагсдын гарын авлага. Уб.2008

16.Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам. Уб.2018.

Сонин сэтгүүл:

17.Хууль сахиулахуй. 2016.№ 2

18.Төрийн мэдээлэл. 2017. №8

Судалгааны ажил, тайлан мэдээ:

19.Барбаатар Н. Цагдаагийн эргүүлийн офицерын гүйцэтгэх үүрэг, түүнд хийсэн дүн шинжилгээ. /Магистрын зэрэг горилсон судалгааны ажил/. Уб.2020.

20.ЦЕГ-ын 2021 оны үйл ажиллагааны тайлан

Гадаад эх сурвалж:

21.Samual Walker, Charles M Katz The police of America an introduction. 5th edition.

Цахим эх сурвалж:

22. https://mongoltoli.mn
23. https://en.wikipedia.org
24. www.merriam-webster.com
25. https://police.gov.mn
26. https://www.facebook.com /hevjurmiinalba/

ХИЛИЙН ЦЭРГИЙН АЛБАНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ХИЛИЙН ЦЭРГИЙН АЛБАНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

В.Пүрэвбаасан
ДХИС-ийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага стратегийн профессорын багийн дэд профессор, доктор (Ph.D), хурандаа
В.Пүрэвбаасан
ДХИС-ийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага стратегийн профессорын багийн дэд профессор, доктор (Ph.D), хурандаа

Хураангуй: Цагийн байдлын өөрчлөлт, дайн, байлдааны үед цэргийг хамгаалах асуудал нь цэргийн шинжлэх ухаанд цэргийн хамгаалалт нэртэйгээр хэрэгждэг. Тайван цагт цэргийн албаны аюулгүй байдлыг хангах гэсэн ойлголт, арга хэмжээгээр хэрэгжиж байна. Хилийн цэргийн албаны аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалтын асуудал нь удирдлагын тогтолцооны хувьд цэргийн удирдлага, эрсдэлийн удирдлага, төрийн захиргааны удирдлага зэрэг удирдлагын онолын гурван төрлийн шинж, чиг үүргүүдийг өөртөө агуулдаг. Иймд удирдах албан тушаалтан нь тухайн нөхцөл байдалд тохируулж, удирдлагын чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ.

Abstract: It is implemented the issue of military protection in times of change, war, and wars is known in military science as military defense. Then, the concept of military security is being implemented in the peacetime. There are three types of management theory characteristics and functions in the management system: military management, risk management, and public administration management of security management and organization of the Border Guard Service. Therefore, the manager should adapt to the situation and perform management functions.

Түлхүүр үг: Хилийн цэргийн албаны аюулгүй байдал (ХЦААБ), цэргийн албаны аюулгүй байдлын комисс, удирдлага, зохион байгуулалт.

Keywords: Border Security Service, Commission of Military Security, management, organization.

Оршил

ХЦААБ-ыг хангах удирдлага нь цэргийн алба хаагчдын амь нас, эрүүл мэнд, орон нутгийн иргэд, тэдгээрийн өмч, хүрээлэн буй орчинд учирч болзошгүй хор хохирлоос урьдчилан сэргийлэх, цэргийн албанд хортой, аюултай хүчин зүйлийг илрүүлэн оношлох, цэргийн алба хаах аюулгүй нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, цэргийн нийтлэг дүрэм, түүнтэй уялдуулан гаргасан ХХЕГ-ын даргын эрх зүйн зохицуулалтын актуудад заасан шаардлагуудыг биелүүлэхэд чиглэсэн цэргийн анги байгууллагуудын удирдлага, албан тушаалтнуудын зорилго бүхий цогц үйл ажиллагаагаар хэрэгждэг.

Үндсэн хэсэг

ХЦААБ-ыг хангах удирдлагыг хилийн цэргийн анги байгууллагын дарга (захирагч) хэрэгжүүлнэ. ХЦААБ-ын хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэгч, хэлтэс, албадын уялдааг хангуулах, хяналт, шалгалтын дүн, тайлан судалгаанд дүн шинжилгээг хийн,

холбогдох шийдвэрийн санал гаргах үндсэн нэгж нь “Цэргийн албаны аюулгүй байдлын комисс” байна.

Цэргийн албаны аюулгүй байдлын комисс: ХЦААБ-ын комисс (цаашид комисс гэх) цэргийн албаны аюулгүй байдлыг хангах ажлыг сайжруулах, цэргийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах аюулгүй нөхцөлийг бий болгох талаар албан тушаалтнуудад практик дэмжлэг үзүүлэх чиглэлээр анги байгууллагын захирагч нарт хамтын санал боловсруулах, тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэгтэй зөвлөлдөх байгууллага юм. ХХБ-ын хэмжээнд ХЦ-ийн штабын даргаар ахлуулсан Комиссыг ХХЕГ-ын даргын тушаалаар, хилийн цэргийн ангид Захирагчийн 1 дүгээр орлогч, штабын даргаар ахлуулсан комиссыг ангийн захирагчийн тушаалаар тус тус баталж томилно. Комиссын бүрэлдэхүүнд ангийн захирагчийн орлогч нар, албадын дарга нар, цэргийн албаны аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий албан тушаалтан багтана. Комиссын орлогч дарга нь ХХЕГ-т Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудтиын газар (ХШҮДАГ)-ын дарга, хилийн ангид дотоод хяналтын албаны дарга, нарийн бичгийн дарга нь цэргийн албаны аюулгүй байдал (ЦААБ), эрсдэлийн үнэлгээ хариуцсан ахлах офицер байна.

Комиссын үндсэн зорилго нь: Цэргийн албаны аюулгүй байдлын талаар мэдээлэл цуглуулах, бүртгэх, боловсруулах, арга хэмжээ зохион байгуулах, цэргийн албанд аюултай хүчин зүйлийг цаг тухайд нь илрүүлэх, ЦАХ-дыг аюулгүй ажиллагааны шаардлагыг биелүүлэхэд бэлтгэх ажлыг сайжруулах, цэргийн албаны аюулгүй ажиллагааны нөхцөлийг тодорхойлоход оршино.

Комиссын бүрэлдэхүүний бүрэн эрх.

Комиссын дарга:

- ХХЕГ-ын даргын УХХ-ыг удирдан зохион байгуулах удирдамжийн хугацаанд хийж гүйцэтгэх комиссын ажлын төлөвлөгөө, комиссын хурлын хэлэлцэх асуудлыг ХХЕГ-ын даргаар болон ангийн захирагчаар батлуулна;
- комиссын хурал болох хугацаа, газрыг тодорхойлно;
- комиссын хурлыг зохион байгуулж явуулна;
- ангийн захирагчид албаны аюулгүй байдлыг хангах асуудлаар албан тушаалтнуудын саналыг комиссын хурал дээр сонсож хэлэлцэх талаар санал бэлтгэнэ;
- харьяа салбар, албадын албаны аюулгүй байдлын талаар ангийн захирагчид илтгэл хүргүүлнэ.

Комиссын гишүүд нь:

- комиссын хуралдаан дээр авч хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэхэд оролцоно;
- комиссын ажлын төлөвлөгөө, хэлэлцэх асуудал, хэлэлцэж буй асуудалд санал бэлтгэн оруулна;
- комиссын даргын тушаалаар комиссын хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэж, комиссын ажлын төлөвлөгөөний биелэлтийг илтгэнэ;
- ангийн захирагчийн тушаалын дагуу албаны аюулгүй байдлын шаардлагын биелэлтийг шалгана.

Комиссын нарийн бичиг:

- комиссын ажлыг зохион байгуулалт, техникийн талаас хангана;
- комиссын даргын удирдлагаар комиссын ажлын төлөвлөгөө, комиссын хурлаар хэлэлцэх асуудал, лавлагаа

мэдээллийн материал, комиссын хуралд шаардлагатай бусад бичиг баримтыг бэлэн болгоно;

- комиссын гишүүдэд ээлжит хурлын огноо, хугацаа, явагдах газар, хэлэлцэх асуудлын мэдээллийг хүргэнэ;
- хурлын тэмдэглэл хөтөлнө;
- комиссын ажлын төлөвлөгөөний биелэлт, комиссын даргын өгсөн үүргийг комиссын гишүүд хэрхэн биелүүлж буйд хяналт тавина;
- комиссын бичиг хэргийг хөтөлнө;
- комиссын ажлын төлөвлөгөөнд гишүүд болон албан тушаалтнуудын оруулах саналыг нэгтгэнэ;
- харьяа салбар, албадын албаны аюулгүй байдал ямар төвшинд байгаа талаар ангийн захирагчид хүргэх илтгэлийн төслийг бэлтгэнэ.

Комиссын үйл ажиллагааг зохион байгуулах нь:

- ХХЕГ-ын даргын болон хилийн цэргийн ангийн захирагчийн баталсан тухайн сургалтын жилийн ажлын төлөвлөгөөний дагуу комиссын ажил зохион байгуулагдана;
- тухайн сургалтын жилийн комиссын ажлын төлөвлөгөөтэй уялдуулан улиралд нэгээс цөөнгүй удаа комиссын хурлыг зохион байгуулна. Комиссын хурлын төгсгөлд тэмдэглэл хөтөлж, комиссын бүх гишүүдээр гарын үсэг зуруулж, комиссын даргаар батлуулна;
- комиссын ажлын үр дүн, гаргасан шийдвэрийн талаар комиссын дарга сар бүр ХХЕГ-ын дарга болон ангийн захирагчид бичгээр илтгэнэ;
- Илтгэлд ХХЕГ-ын болон ангийн ЦААБ, комиссын ажлын төлөвлөгөөний биелэлт, тодорхой арга хэмжээний үед илэрсэн зөрчил, түүнийг арилгах санал, зэргийг тусган, ЦАХ-дын нас баралт, шархдалт, гэмтлийн шалтгааныг судалж, тухайн тайлант хугацааны статистик материалыг хавсарган, ХХЕГ, хилийн цэргийн ангийн албаны аюулгүй байдлыг сайжруулах санал, ангийн захирагчийн тушаалаар алба хаагчдад хүргэсэн үүргийг биелүүлэх чиглэлээр албан тушаалтнуудын хийж гүйцэтгэж буй ажлын талаар тусгана.

Комисс нь дараах асуудлуудыг судалж, санал боловсруулна:

- бие бүрэлдэхүүнийг ангийн өдөр тутмын үйл ажиллагааны явцад үүсэн бий болох болон гаднын аюултай хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах нөхцөлийг хангасан байдал, тухайн нөхцөлийг бий болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүн;
- албан сургалт, бэлтгэл (марш, сургуулилт, буудлага үйлдэх), зэвсэг, цэргийн болон тусгай техник ашиглах, харуулын болон дотоодын харуул хамгаалалт, тусгай ажил, хичээл явуулах;
- ангийн болон хилд үүрэг гүйцэтгэх тээврийн хэрэгслийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх;
- цэргийн албаны аюулгүй байдлын хангалтыг сайжруулах зэрэг болно.

Түүнчлэн ангийн захирагчийн зааврaар:

- ЦААБ-ыг хангах чиглэлээр шийдвэр гаргахад нь санал бэлтгэн оруулах;
- ЦААБ-ыг хангах асуудлаар тушаалын төсөл бэлтгэх;
- ЦААБ-ыг хангах ажлыг төлөвлөх;

- ангийн өдөр тутмын үйл ажиллагаанд ЦААБ-ыг хангах чиглэлээр цогц дадлагын хичээл, уралдаан тэмцээн, бага хурал, сарын ажил зохион байгуулж явуулахад оролцох;
- албан тушаалтнуудад ЦААБ-ыг хангах практик ажлын чиглэлээр сургалт явуулж, тэдэнд мэдээлэл-сурталчилгааны ажил явуулахад оролцох;
- ЦААБ-ыг хангах чиглэлээр үүрэг хүлээсэн албан тушаалтнуудын үйл ажиллагаанд дүгнэлт судалгаа хийж, ангийн өдөр тутмын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах аюулгүй нөхцөлийг бий болгосон ажлын туршлагыг нь нэгтгэн дүгнэж, түгээн дэлгэрүүлэх;
- ЦААБ, эрсдэлийн үнэлгээ хариуцсан ажилтны санал хүсэлтийг сонсох;
- хилийн цэргийн ангийн өдөр тутмын үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавихад оролцоно.

ХЦААБ-ыг хангах шийдвэр гаргах:

ХХЕГ-ын дарга “УХХ-ыг удирдан зохион байгуулах удирдамж”-даа ХЦААБ-ыг хангах холбогдох заалтыг оруулна.

Энэ заалтын дагуу хилийн цэргийн ангийн захирагч (дарга) ЦААБ-ыг хангах шийдвэрийг гаргаж, “ЦААБ-ыг хангах, албыг зохион байгуулах” тушаалаар баталгаажуулна.

Шийдвэр гаргахын өмнө цэргийн албаны аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн даргын орлогч, албадын дарга, мэргэжилтнүүд анхдагч мэдээллийг судалж нягтлах, даргад хүргэх саналыг бэлтгэх, цагийн байдлыг үнэлэх ажил хийгдэнэ.

Шийдвэрт захирагч:

- цэргийн албаны аюултай хүчин зүйлүүдийг хязгаарлах арга хэмжээ;
- ЦАХ-ийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан цэргийн анги байгууллага, түүний салбар, албадын өдөр тутмын үйл ажиллагааны арга хэмжээг биелүүлэхэд тавигдах аюулгүй байдлын шаардлага;
- ЦААБ-ыг хангах зохион байгуулалтын болон техникийн цогц арга хэмжээ зэргийг тодорхойлдог.

Шийдвэрт нэмэлтээр:

- аюултай болон хортой хүчин зүйлийг заасан объектуудын мэдээллийн хүснэгт;
- онц аюултай нэг удаагийн ажлын (ЦАХ-ийн албан үүрэгт хамааралгүй жагсаалт), түүнийг аюул осолгүй гүйцэтгэх журам;
- аюулгүй байдлыг хангах шаардлагыг хилчдэд хүргэх зааварчилга, явуулах хөтөлбөр;
- ЦААБ-ын зорилтуудыг хангах арга хэмжээний жагсаалт;
- аюулгүй байдлыг хангах комисс, баг, бүлгийн тооны болон албан тушаалын бүрэлдэхүүн;
- албан тушаалтнуудын удирдах, харилцан ажиллах схем зэргийг тусгана.

Шийдвэрийг үндэслэн цэргийн анги байгууллага дээр албан тушаалтнуудын хүлээх үүргийг боловсруулах буюу тодотгол хийнэ. Үүнд:

ЦААБ-ыг хангах асуудлаар боловсруулагдсан төлөвлөгөөт бичиг баримтад тухайн асуудлын зорилго, зорилт, арга хэмжээ, хариуцах эзнийг тусгасан байна;

Цэргийн албаны аюулгүй нөхцөлийг бий болгох, хангах ажил зохиогдоно.

ХЦААБ-ыг хангах арга хэмжээг төлөвлөх:

ХЦААБ-ыг хангах арга хэмжээг төлөвлөх нь сургалтын явцад (хичээлийн жил) хилийн цэргийн ангид өдөр тутмын үйл ажиллагааг ерөнхийд нь төлөвлөх ажлын нэг бүрдэл хэсэг юм. Энэ нь хариуцсан хэсэгт улсын хил хамгаалалтыг удирдан зохион байгуулах тушаалыг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй хамт хэрэгжих бөгөөд даргын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээний системийг багтаадаг.

ХЦААБ-ыг хангах ажлыг зохион байгуулахын тулд тухайн ангид боловсруулсан дэг журам тогтоох, цэргүүдийн алба гүйцэтгэлийг сайжруулах, ЦААБ-ыг хангах цогц төлөвлөгөөнд (цаашид цогц төлөвлөгөө гэх) “ХЦААБ-ыг хангах нь” гэсэн тусдаа бүлэг оруулж өгнө. Энэ бүлэгт ХЦААБ-ын тогтолцоог бүрдүүлэгч элементүүдийн аюулгүй байдлыг хангах 26 арга хэмжээ, ХЦААБ-ын хангах үйл ажиллагааны 11 чиглэлийг (нэмэлтээр ХЦААБ-ыг хангах 55 арга хэмжээ байж болно) тусган хэрэгжүүлнэ.

Цогц төлөвлөгөөний “ХЦААБ-ыг хангах нь” гэсэн бүлэгт тусгагдсан арга хэмжээний жагсаалтыг ЦАХ амь насаа алдсан эсэх, тэдний гэмтэл бэртэл, шарх авсан шалтгаан, нөхцөл байдлын судалгааны үр дүн, шийдвэр, тухайн жилийн хугацаанд албаны бэлэн байдлыг хангах, түүнийг биелүүлэх нөхцөл зэргийг харгалзан боловсруулна.

Цогц төлөвлөгөөнд тусгагдсан ХЦААБ-ыг хангах арга хэмжээ, мөн түүнчлэн дээд дарга нарын дэвшүүлсэн тодорхой зорилт, нөхцөл байдлын өөрчлөлт, тушаал шийдвэр, удирдамж, зааврыг хэрэгжүүлэх зайлшгүй арга хэмжээ зэрэг нь ангийн сарын үндсэн ажлын төлөвлөгөө, анги салбарын хүмүүжлийн ажлын төлөвлөгөө, салбар, албадын хичээлийн төлөвлөгөө, албан тушаалтнуудын сар (7 хоног)-ын ажлын төлөвлөгөөнд туссан байна.

ХЦААБ-ын зохион байгуулалт:

Хилийн цэргийн анги байгууллага нэг бүрд ХЦААБ-ын хөгжил, зохион байгуулалтыг тодорхойлогч нь:

ХЦААБ-ын зохион байгуулалтыг зохицуулагч эрх зүйн хэм хэмжээний бааз суурь (цэргийн нийтлэг дүрмүүд, ХХБ-ын цэргийн албыг зохион байгуулах заавар, ХЦААБ-ыг хангах заавар, хил хамгаалах албаны аюулгүй арга хэмжээний заавар, Хилийн цэргийн штабуудын албаны заавар);

ХЦААБ-ыг хангах асуудлыг хариуцсан албан тушаалтныг томилсон тушаал шийдвэр, хөгжлийн хэтийн төлөв;

хилийн цэргийн анги байгууллагын албан тушаалтны ХЦААБ-ыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа юм.

ХЦААБ-ыг хангахад хилчдийн гүйцэтгэх үүргийг дараах үндсэн чиглэлүүдээр тодорхойлдог. Үүнд:

1. хилчдийн амь нас эрсдэх, гэмтэл бэртэл авах төвшнийг бууруулахад чиглэсэн цэргийн өндөр сахилга дэг журам тогтоох;

Энэ чиглэлийн хүрээнд нийт алба хаагч нар:

- дүрэм журмыг дагаж мөрдөх, цэргийн сахилга дэг журмын норм хэмжээг мөрдөхдөө үлгэр жишээч байх;
- анги, салбарт сахилга дэг журамтай, ахмад настнаа хүндэтгэдэг байх эерэг уламжлалыг бий болгон төлөвшүүлэх;

- хууль, цэргийн дүрэм, журам зааврын шаардлагыг хэлбэрэлтгүй биелүүлэх ёстой.

2. ХЦААБ-ыг хангах гол чухал чиглэл нь хилчдийн хоорондын харилцаанд дүрмийн зөрчил гарах, бусад эрх зүйн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх явдал юм.

Энэ чиглэлд хилчид:

- өөртөө өндөр шаардлага тавих;

- хоорондын харилцаанд дүрэм журмыг зайлшгүй мөрдөх бодит шаардлага байгаа болон түүнийг мөрдөхийн утга учрыг ухамсарлан дэс дараатайгаар тэр төвшинд хүрэх;

- харилцаандаа бие биеэ бүдүүлгээр доромжлон гомдоох байдлыг гаргахгүй байж, хамт алба хаагчдын хувь хүний давуу талыг нь хүндлэх.

3. хилчид амиа егүүтгэхээс урьдчилан сэргийлэх;

Энэ арга хэмжээг авч явуулахдаа цэргийн хамт олны дунд ёс суртахуун сэтгэл зүйн таатай нөхцөл байдал бий болгоход ихээхэн анхаарал хандуулж, цэргийн алба хаагчдын дунд дүрэм журмын зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, сэтгэл зүйн нийцтэй байдлыг хангах нь зүйтэй.

4. зэвсэг, галт хэрэгсэлтэй ажиллах үеийн дүрэм журмыг мөрдөх ажлыг хангах. Зэвсэг, галт хэрэгсэл, тэсрэх бодис нь цэргийн өдөр тутмын үйл ажиллагааны нэг салшгүй хэсэг юм. Эдгээр нь хилчдийн өөрийнх нь төдийгүй бусдын амь насанд онц аюултай. Үүнээс үүдэн хилчид нэг бүр:

- өөрийн эзэмшиж буй зэвсгийн үзүүлэлтийг сайтар мэдэж байх;
- удирдамж, зааварт заасан шаардлагаар зохицуулагддаг зэвсэг, галт хэрэгсэлтэй ажиллах үеийн аюулгүйн арга хэмжээ, дүрэм журмыг мэддэг, мөрддөг байх ёстой;
- цэргийн сургуулилт, өдөр тутмын үйл ажиллагаа, харуулын алба, дотоод алба, байлдааны жижүүрийн явцад ХЦААБ-ыг өндөр төвшинд хангахын тулд тодорхой арга хэмжээнүүдийг чанд мөрдөж ажиллах ёстой.

Аливаа нөхцөлд хилчид хэрхэн биеэ авч явах журам нь аюулгүй байдлын шаардлагуудыг тодорхойлж, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”, “Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль”, “Монгол улсын хилийн тухай хууль”, “Монгол улсын цэргийн нийтлэг дүрмүүд”, “Хил хамгаалалтын дүрмүүд”, “Хил хамгаалах албаны аюулгүй ажиллагааны заавар”, “Цэргийн албаны зохион байгуулалтын заавар”, “Монгол улсын хилийн цэргийн штабуудын албаны заавар” зэрэг эрх зүйн хэм хэмжээний үндсэн долоон баримт бичиг, эдгээрийг нэгтгэсэн “ХЦААБ-ыг хангах заавар” эрх зүйн баримт бичгээр зохицуулагдана.

Хилийн цэргийн алба хаагч бүр бүх төрлийн ААХЗ, аюулгүй байдлын шаардлагыг өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх үүрэгтэй. Тэр өөрийн эрүүл мэндийг хамгаалахад анхаарах, өдөр бүр тэсвэр хатуужил, биеийн тамирын бэлтгэл ба спортоор хичээллэх, хор хөнөөлтэй дадал (тамхи татах, архи хэрэглэх)-аас зайлсхийх, мансууруулах бэлдмэл ба сэтгэцэд нөлөөлөх бодисын хэрэглээнд автахгүй байх ёстой.

Энэ зорилгоор дараах үүрэг хүлээнэ:

- өөрийн албан тушаал ба тусгай үүргийг биелүүлэх аюулгүй арга болон барилыг судлах, цэргийн албаны аюулгүй байдлын шаардлагуудын

талаар зааварчилгаа авах, байран дээр заасан үүргийг гүйцэтгэх дадлага хийх, түүнчлэн аюулгүй байдлын шаардлагуудыг биелүүлэх талаарх онолын мэдлэг ба практик дадлагын шалгалтыг өгөх;

- нэг бүрийн болон нийтийн хамгаалах хэрэгслийг зөв хэрэглэх, түүнчлэн зайлшгүй тохиолдлуудад эмчилгээ-ариутгалын хэрэгслийг ашиглах ба анхны тусламж үзүүлэх;
- өөрийн шууд захирах даргад цэргийн алба хаагчийн буруугаас цэргийн алба хаагчийн амь нас, эрүүл мэнд, орон нутгийн иргэдийн амь нас эрүүл мэнд, эд хөрөнгөнд заналхийлсэн нөхцөлийн тухай, эсвэл хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулсан тухай, түүнчлэн өдөр тутмын үйл ажиллагааны арга хэмжээнүүдийг гүйцэтгэх үед түүнд эсвэл цэргийн алба хаагчийн гэмтэл бэртлийн баримт бүрийн тухай, эсвэл өөрийн эрүүл мэнд муудаж байгаа тухай яаралтай илтгэх;
- тогтоосон хугацаанд эмнэлгийн үзлэг (шинжилгээ)-т хамрагдах зэрэг болно.

Хилийн цэргийн анги бүр цэргийн алба хаагчийн өдөр тутмын үйл ажиллагааны онцлог, шинжийг тусгасан өөрийн тусгай үүргүүдтэй байдаг ба аюулгүй байдлын заавар, цэргийн дүрэм нь ямар ч байдлаас хамаарахгүйгээр дурын нөхцөлүүдэд биелэгдэх ёстой. Ийм маягаар Хилийн цэргийн албаны аюулгүй байдлыг хангах нь хилийн цэргийн анги, салбарын албаны бэлэн байдлын чухал хүчин зүйл, үндэс болно.

ХЦААБ-ыг хангах зохион байгуулалтын арга хэмжээнүүд нь дараах байдлаар хэрэгжинэ. Үүнд:

- ХХЕГ, хилийн цэргийн ангийн Штаб нь ХЦААБ, дэг журам хангах, хэлтэс, албадуудын ажлын уялдааг хангах, цэргийн алба болон албаны бэлтгэлийн аюулгүй байдлыг хангах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, сургалт, дадлагыг зохион байгуулах, дүн шинжилгээ хийх ажлыг хэрэгжүүлнэ;
- бүх шатны дарга, захирагч нар нь УХХ, ШНА, ХБАБ-ыг хангах, албаны амьтад, автомашин техник ашиглах үед хилчид гэмтэж бэртэх, амь үрэгдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна;
- хүн эмнэлгийн алба нь хилчдийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн урьдчилан сэргийлэх болон эмчилгээний цогц арга хэмжээг зохион байгуулна;
- Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, дотоод хяналтын хэлтэс, алба ХЦААБ-ыг хангах үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, залруулах, эрсдэлийн үнэлгээг хийх, алба хаагчдад туслах, эргэх холбоог хангаж ажиллана.

Түүнчлэн штаб, удирдах албан тушаалтан бүр алба үйл ажиллагаандаа ХЦААБ-ын тогтолцоог бүрдүүлэгч элементүүдийн аюулгүй байдлыг хангах 26 арга хэмжээ, ХЦААБ-ын хангах үйл ажиллагааны 11 чиглэлийг (нэмэлт-55) хэрэгжүүлэн зохион байгуулна.

ХЦААБ-ыг хариуцсан албан тушаалтнууд нь дараах арга хэмжээнүүдэд анхаарч ажиллана. Үүнд:

ХЦААБ-ыг хангах үйл ажиллагааны зорилго нь бие бүрэлдэхүүнд нөлөөлөх тодорхой аюул эрсдэлийн (харилцан хамаарал бүхий бүлэг, аюултай болон хортой хүчин зүйл) нөлөөллийг хамгийн бага төвшинд хүртэл бууруулах нөхцөлийг баталгаажуулах цэргийн албаны нөхцөл юм. Эдгээрт:

- Хилийн цагийн манаа, жижүүр, (алба) харуулын болон дотоод алба гүйцэтгэх, цэргийн зэвсэг техникийн ашиглалт, засварлах, сэргээн засах, ажил гүйцэтгэх, түүнчлэн өдөр тутмын үйл ажиллагааны бусад үүргийг хэрэгжүүлэхдээ аюулгүй байдлыг хангах;
- ХЦААБ-ыг эмнэлгийн үйлчилгээний үүднээс хангах арга хэмжээ авч явуулах
- Хүрээлэн буй орчныг хамгаалах, байгалийн гамшиг, халдварт өвчин гарсан үед зохих арга хэмжээ авч явуулах, галын аюулгүй байдлыг хангах г.м.

Энэхүү үйл ажиллагааны зорилгоос үүдэн ХЦААБ-ыг хангах үндсэн зорилтуудыг дараах байдлаар ангилж үзэж болно. Үүнд:

- ЦАХ-дад албаны аюулгүй байдлын нөхцөлийг хангах хувийн хариуцлага бий болгох, амьдралын өөр өөр нөхцөлд аюулгүй ажиллах дадал чадварыг төлөвшүүлэх;
- сургалт, албаны бэлтгэл, зэвсэг техникийн ашиглалт, аж ахуй, барилгын ажлын явцад ЦАХ-ын амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх;
- зэвсэг, техник, галт хэрэгсэлтэй ажиллах, хичээл, буудлага, хээрийн сургалт, өдөр тутмын үйл ажиллагааны аюулгүй нөхцөлийг бүрдүүлэх төрөл бүрийн ажлын гүйцэтгэлд хяналт тавих арга хэмжээг хэрэгжүүлэх;
- хилийн цэргийн анги байгууллагын бүх албан тушаалтнууд эдгээр зорилтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

ХЦААБ-ыг хангах ажлыг хилийн цэргийн анги байгууллагын бүх албан тушаалтнууд хариуцсан чиглэлээрээ хэрэгжүүлнэ.

Бие бүрэлдэхүүнтэй ажилладаг байгууллагууд цэргийн ангийн сахилга дэг журмын байдалд судалгаа хийж, түүнийг бэхжүүлэх арга хэмжээ боловсруулан, ажил зохион байгуулж, цэрэг амиа хорлох үйл явдал гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Дүгнэлт

Хилийн цэргийн албаны аюулгүй байдал /ХЦААБ/ нь бүх төрлийн ААХЗ, дотоод албаны болон цэргийн дүрмүүдийг хэрэгжүүлэх цэргийн албаны зохион байгуулалт, цэргийн аж ахуйн болон улсын хил хамгаалалт, түүнд шаардлагатай үйл ажиллагаануудын стандартуудаас бүрдэх ба ЦАХ-дын албан үүргээ гүйцэтгэх үед учирч болох аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагаа, эрүүл аюулгүй орчин, ЦААБ-ыг хангахад тавих хяналт шалгалтын цогц юм.

Хил хамгаалах байгууллагад ХЦААБ-ыг хангах удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэгч нэгж нь “Цэргийн албаны аюулгүй байдлын комисс” юм.

ХЦААБ-ын удирдлага, зохион байгуулалтыг бүх шатны алба хаагч, нэгжүүд дараах байдлаар хариуцаж, хэрэгжүүлнэ. Үүнд:

- ХХЕГ-ын хэмжээнд Штаб (ЦААБ-ын алба) хариуцаж, хэрэгжилтэд хяналт тавих нэгж нь Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар;

- хилийн цэргийн ангид штаб (ЦААБ хариуцсан ахлах офицер), дотоод хяналтын алба хамтран;
- хилийн салбарт дарга, орлогч нар;
- хилийн харуулд харуулын дарга;
- хилийн манаанд манааны ахлагч;
- хариуцагч албан тушаалтнууд нь бүх шатны дарга, захирагч;
- хэрэгжүүлэгч нь бие бүрэлдэхүүн, орон нутгийн ард иргэд юм.

Санал

Дээрх судалгаанаас үндэслэн ХЦААБ-ын удирдлага, зохион байгуулалтын үндсэн чиг үүрэг нь доорх арга хэмжээнүүдээс бүрдэнэ гэсэн санал дэвшүүлж байна. Үүнд:

- ХЦААБ-ыг хангах ахлах даргын шийдвэр гаргах;
- ХЦААБ-ыг хангах арга хэмжээг төлөвлөх;
- ХЦААБ-ыг хангах арга хэмжээг зохион байгуулах;
- ХЦААБ-ын хяналт, шалгалт;
- ХЦААБ-ын дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ;
- ХЦААБ-ын мэдээллийн бүртгэл хөтлөх зэрэг болно. Энэ нь өөрөө ХЦААБ-ыг хангах удирдлага, зохион байгуулалтын аргачлал болно.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Хилийн тухай хууль. Уб., 2016. 31 дүгээр зүйл
2. ОХУ-ын ЗХ-ний цэргийн албаны аюулгүй байдлыг хангах удирдамж. Мос.,2015. 2,2 дугаар зүйл
3. Полковник А.Медведев. преподаватель ВНУЦ СВ “Общевойсковая академия ВС РФ”
4. Цэргийн нэр томьёоны тайлбар толь. Уб.,2014. 702х., т77;
5. Эрдэнэцогт.Д., “Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах үндэслэл” сэдэвт докторын зэрэг горилсон диссертаци. Уб.,2002.140х,т65;
6. Түмэн.Б., “Байлдаанд цэргийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо”. Гарын авлага, Уб.,2005.30х,т3.
7. Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны зохион байгуулалтын заавар. Уб.,2019.1.1 дэх заалт
8. Пүрэвбаасан.В. “Хил хамгаалах байгууллагын цэргийн албаны аюулгүй байдлыг хангах арга зам” докторын судалгааны ажил. Уб., 2020. 3 дугаар бүлгээс.

СЭТГЭЛ ХАНАМЖИД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ШИНЖИЛГЭЭ: /ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ЖИШЭЭГЭЭР/

THE ANALYSIS OF IMPACTS ON SATISFACTION: THE CASE OF EMERGENCY MANAGEMENT AGENCY ON TUW PROVINCE

Б.Ганзагас
ДХИС-ийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гамшиг судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан-багш, ахлах дэслэгч
Г.Хатанбаатар
ДХИС-ийн Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн ахлах багш, хошууч
Ganzagas.B
Researcher, Disaster Studies Center, Integrated Scientific Research Institute, University of Internal Affairs, Mongolia. Senior Lieutenant
Khatanbaatar.G
A Senior Lecturer at department of Disaster protection agency of Emergency Management School at University of Internal Affairs, Mongolia, Major

Хураангуй: Бид Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Төв аймгийн онцгой байдлын газрын алба хаагчдаас сэтгэл ханамжийн судалгаа авч, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн шинжилгээг хийлээ. Энэхүү судалгаанд удирдах ажилтан болон алба хаагчид хамрагдсан байна. Судалгаагаар сэтгэл ханамжийн онолын болон практикийн асуудлыг авч үзэн өгөгдлийг Smart PLS 3.0 программ хангамжаар шинжилсэн.

Түлхүүр үг: Онцгой байдлын алба, алба хаагч, сэтгэл ханамж

Abstract: Our study conducted the impacts and factors of satisfaction survey of of the staff of the Emergency Management Agency of Tuv aimag under the National Emergency Management Agency. The study involved employees of leading and executing. The study analyzed theoretical and practical issues of satisfaction and analyzed the data with Smart PLS 3.0 software.

Keywords: National Emergency Management Agency , employees, satisfaction, job satisfaction

Судалгааны ажилд ашигласан үндсэн ойлголт:

Энэхүү судалгааны ажлын үндсэн ойлголт, нэр томьёог дараах байдлаар товч тайлбарлах боломжтой. Үүнд:

Алба хаагч: Цэргийн байгууллагад цэргийн алба биеэр хааж байгаа Монгол Улсын иргэнийг

Сэтгэл ханамж: Тухайн байгууллагаас гарч буй чанар буюу үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг

Онцгой байдлын байгууллагын амжилтын үндсэн нэг томоохон хэсэг бол алба хаагч нар байдаг. Байгууллага алба хаагчдынхаа чадварыг бүрэн дайчлахын тулд тэдний сэтгэл ханамжид нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлон гаргаж ирсэн байх нь чухал юм.

Алба хаагчдыг сэтгэл ханамжтай байхад нөлөөлдөг, тэднийг идэвхжүүлэх хүчин зүйлийг мэдсэнээр мэдээллийн эх үүсвэртэй болж, алба хаагч нарт тохирсон идэвхжүүлэлтийн аргыг хэрэглэх боломжтой юм.

Иймээс байгууллагынхаа гол үнэт хүчин зүйл болох алба хаагчдынхаа сэтгэл ханамжтай ажлаа хийхэд ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг тодорхойлж, сэтгэл ханамжийн төвшинг хэрхэн яаж ахиулж болох тухай судалгааг Онцгой байдлын

байгууллагын алба хаагчдын сэтгэл ханамжийг үнэлэх судалгааг Төв аймгийн онцгой байдлын газрын алба хаагчдын жишээн дээр үзүүлж байгаад оршиж байна.

Ёс зүй, харилцаа, хандлага: Ёс зүй гэдэг нь хүн юу хийх ёстой, юунаас татгалзах ёстой хэм хэмжээг судалдаг. Харилцаа нь хоёр ба түүнээс дээш хүмүүсийн хооронд үүссэн ойлголцлын илэрхийлэл. Хандлага гэдэг нь юунд сэтгэл ханамжтай байгааг илэрхийлэх үнэлгээ.

Ажлын байрны гадуурх сургалт: Сургалт нь тухайн газарт, тодорхой ажлын байрнаас хол, урт хугацаагаар явагддаг сургалтын арга юм.

Ажлын байран дахь сургалт: Ажилчдыг ажлын байран дээр ажиллаж ажиллаж байхдаа сургах арга юм.

Ажлын туршлага: Хувь хүний туршлага, сэтгэгдэл, ажиглалт, бодит үйл ажиллагааны явцад олж авсан тодорхой мэдлэг.

Ажлын гүйцэтгэл: Энэ нь тухайн хүн ажлаа сайн хийдэг эсэхийг тодорхойлдог үнэлгээ юм.

Дээрх хувьсагчдын нөлөөллийг судлахаар дараах загварыг санал болгон таамаглал дэвшүүллээ.



Загвар 1. Ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйл

Таамаглал-1. Ёс зүй , харилцаа, хандлага ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө.

Таамаглал-2. Ажлын байрны гадуурх сургалт ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө.

Таамаглал-1. Ажлын байран дахь сургалт ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө.

Таамаглал-1. Ажлын сургалт ажлын гүйцэтгэлд эергээр нөлөөлнө.

Судалгааны боловсруулалт, үр дүн

Төв аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчдад 2021 оны 11 дүгээр сарын 22-нд “Харилцаа хандлага ба сэтгэл ханамж” сэдэвт сургалт зохион байгуулж тухайн сургалтад оролцсон 50 гаруй алба хаагчдаас судалгаа авч боловсруулалт хийсэн.

Төв аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчдаас судалгаанд эрэгтэй 33, эмэгтэй 6, үүнээс ахлагч 23, офицер 16; насны ангиллаар авч үзэхэд 22-25 насны 12, 26-29 насны 11, 30-33 насны 4, 34-37 насны 5, 38-41 насны 4, 42-45 насны 3, боловсролын зэргээр нь эрх зүйч мэргэжилтэй 7, нягтлан бодогч 2, инженер 4, эдийн засагч 1, агрономич 1, жолооч 4, гал сөнөөгч 20 мэргэжилтэй нийт 39 алба хаагч тус судалгаанд хамрагдсан байна. Судалгааны хариултыг “SMART-PLS 3” программаар нэгтгэн доорх байдлаар үр дүнг нэгтгэв.

Загвар №1. **Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн**
/ Төв аймгийн онцгой байдлын алба хаагчдын ажлын гүйцэтгэл/



Тайлбар: eth-Ёс зүй, харилцаа, хандлага, out tr-Ажлын байрны гадуурх сургалт, in tr-Ажлын байран дахь сургалт, exp-Ажлын туршлага, per-Ажлын гүйцэтгэл

Төв аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчдын хувьд, хэмжил зүй болон хүчин зүйлийн шинжилгээний үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

Ёс зүй, харилцаа, хандлагын хүчин зүйлийн үр дүн **0.640-0.88** хооронд хэлбэлзэж, дундаж хэлбэлзлийн утга **0.500** байгаа нь хангалттай сайн, Кронпа альфа утга **0.754** байгаа нь үр дүн сайн, Нийлмэл найдвартай байдлын үр дүн **0.831** байгаа нь үр дүн маш сайн байгааг илтгэж байна.

Ажлын байрны гадуурх сургалтын хүчин зүйлийн үр дүн **0.793-0.875** хооронд хэлбэлзэж, дундаж хэлбэлзлийн утга **0.686** байгаа нь маш сайн, , Кронпа альфа утга **0.887** байгаа нь үр дүн сайн, Нийлмэл найдвартай байдлын үр дүн **0.916** байгаа нь үр дүн маш сайн байгааг илтгэж байна.

Ажлын байран дахь сургалтын хүчин зүйлийн үр дүн **0.633-0.840** хооронд хэлбэлзэж, дундаж хэлбэлзлийн утга **0.520** байгаа нь маш сайн, , Кронпа альфа утга **0.767** байгаа нь үр дүн сайн, Нийлмэл найдвартай байдлын үр дүн **0.843** байгаа нь үр дүн маш сайн байгааг илтгэж байна.

Ажлын туршлагын хүчин зүйлийн үр дүн **0.818-0.881** хооронд хэлбэлзэж, дундаж хэлбэлзлийн утга **0.735** байгаа нь маш сайн, , Кронпа альфа утга **0.910** байгаа нь үр дүн сайн, Нийлмэл найдвартай байдлын үр дүн **0.933** байгаа нь үр дүн маш сайн байгааг илтгэж байна.

Ажлын гүйцэтгэлийн хүчин зүйлийн үр дүн **0.775-0.901** хооронд хэлбэлзэж, дундаж хэлбэлзлийн утга **0.732** байгаа нь маш сайн, , Кронпа альфа утга **0.947** байгаа нь үр дүн сайн, Нийлмэл найдвартай байдлын үр дүн **0.956** байгаа нь үр дүн маш сайн байгааг илтгэж байна.

Хүснэгт №1. **Хэмжил зүйн шинжилгээний үр дүн**

/ Төв аймгийн Онцгой байдлын алба хаагчдын ажлын гүйцэтгэл/

Хувьсагч, хүчин зүйл	Код	Далд хувьсагчийн утга	Кронпа-Альфа	Найдвартай байдал	Дундаж утга
Ёс зүй, харилцаа, хандлага	Eth-1	0.649	0.754	0.831	0.500
	Eth-2	0.651			
	Eth-3	0.676			
	Eth-4	0.888			
	Eth-5	0.640			
Ажлын байрны гадуурх сургалт	Out tr-1	0.805	0.887	0.916	0.686
	Out tr-2	0.833			
	Out tr-3	0.832			
	Out tr-4	0.875			
	Out tr-5	0.793			
Ажлын байран дахь сургалт	In tr-1	0.654	0.767	0.843	0.520
	In tr-2	0.755			
	In tr-3	0.840			
	In tr-4	0.706			
	In tr-5	0.633			
Ажлын туршлага	Exp-1	0.818	0.910	0.933	0.735
	Exp-2	0.872			
	Exp-3	0.873			
	Exp-4	0.841			
	Exp-5	0.881			
Ажлын гүйцэтгэл	Per-1	0.817	0.947	0.956	0.732
	Per-2	0.866			
	Per-3	0.775			
	Per-4	0.867			
	Per-5	0.864			
	Per-6	0.855			
	Per-7	0.901			
	Per-8	0.892			

Тайлбар: eth-Ёс зүй, харилцаа, хандлага, out tr-Ажлын байрны гадуурх сургалт, in tr-Ажлын байран дахь сургалт, exp-Ажлын туршлага, per-Ажлын гүйцэтгэл

Төв аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчдаас авсан судалгааны далд хувьсагчийн хамаарлын хувьд, Ёс зүй, харилцаа, хандлага ба ажлын гүйцэтгэл 0.635, ажлын гүйцэтгэл ба ажлын гадуурх сургалт 0.496, ажлын байран дахь сургалт ба ажлын байрны гадуурх сургалт 0.662, ажлын байрны гадуурх сургалт ба ажлын туршлага 0.532 үр дүнтэйгээр өндөр хамааралтай байна.

Хүснэгт №2. **Далд хувьсагчийн хамаарлын шинжилгээ**

/ Төв аймгийн Онцгой байдлын алба хаагчдын ажлын гүйцэтгэл/

Хувьсагчид	Ёс зүй, харилцаа, хандлага	Ажлын гүйцэтгэл	Ажлын байран дахь сургалт	Ажлын байрны гадуурх сургалт	Ажлын туршлага
Ёс зүй, харилцаа, хандлага	0.707				
Ажлын гүйцэтгэл	**0.635**	0.855			
Ажлын байран дахь сургалт	0.381	0.477	0.721		
Ажлын байрны гадуурх сургалт	0.482	**0.496**	**0.662**	0.828	
Ажлын туршлага	0.491	0.756	0.537	**0.532**	**0.857**

Тайлбар: Судалгааны үр дүн

Хүснэгт №3. **Замын шинжилгээ**

/ Төв аймгийн Онцгой байдлын алба хаагчдын ажлын гүйцэтгэл/

№	Таамаглал	Дундаж утга	Стандарт хэлбэлзэл	Т статистик утга	Р үнэ цэнэ	Үр дүн
1	Т-1	0.345	0.123	2.765	0.006	батлагдсан
2	Т-2	0.084	0.150	0.281	0.779	батлагдсангүй
3	Т-3	-0.013	0.171	0.027	0.979	батлагдсангүй
4	Т-4	0.549	0.172	3.283	0.001	батлагдсан

Тайлбар: Судалгааны үр дүн

Төв аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчдаас авсан нийт 4 таамаглал бүхий загвар судалгааны боловсруулалтын үр дүнгээс, алба хаагчдын ажлын байран дахь сургалт, ажлын байрны гадуурх сургалт ажлын гүйцэтгэлд эерэг нөлөө үзүүлж чадахгүй харагдаж байна.

Дүгнэлт

Төв аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчдын ажлын гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлийг онол арга зүйн үндэслэлтэйгээр, эрдэмтдийн судалгааны ажлын таамаглалыг дэмжин судлахын тулд шууд нөлөөлөлтэй 4 таамаглалтай загвар санал болгож, таамаглалыг батлах оролдлогыг энэхүү судалгааны ажлаар хийлээ.

Энэхүү судалгаанд Төв аймгийн Онцгой байдлын газрын алба хаагчдаас судалгаанд эрэгтэй 33, эмэгтэй 6, үүнээс ахлагч 23, офицер 16; насны ангиллаар авч үзэхэд 22-25 насны 12, 26-29 насны 11, 30-33 насны 4, 34-37 насны 5, 38-41 насны 4, 42-45 насны 3, боловсролын зэргээр нь эрх зүйч мэргэжилтэй 7, нягтлан бодогч 2, инженер 4, эдийн засагч 1, агрономич 1, жолооч 4, гал сөнөөгч 20 мэргэжилтэй нийт 39 алба хаагч тус судалгаанд хамрагдсан байна.

Ном зүй:

1. Г. Цэрэн “Байгууллагын зан төлөв” 2014 он, УБ хот,
2. Ц.Цэцэгмаа “Хүний нөөцийн менежмент” онол, практик, жишээ 2009 он, УБ хот,
3. М.Нармандах, Б.Довчинбалжир, Л.Санжрагчаа “Хүний нөөцийн ажилтны гарын авлага” 2011 он, УБ хот,
4. П. Наранцэцэг “Хүний нөөцийн менежмент ” 2014 он, УБ хот,
5. Н.Цэнд, Г.Батхүрэл, Я.Шуурав, Х,Пүрэвдавга, Ц.Цэцэгмаа, Н.О.Лизунов, Л.Цэрэнчимэд, Д.Оюунчимэг “Менежмент” сурах бичиг 2013 он, УБ хот,
6. Х.Пүрэвдавга, Г.Батхүрэл “Хүний нөөцийн менежмент” сурах бичиг 2015 он, УБ хот,
7. И.Батхишиг “Мотивацийг ашиглан хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх боломж, арга зам” 2013 он, УБ хот,
8. Б.Батжаргал “Бүтээмж ба цалин” 2008 он, УБ хот,
9. Д.Болормаа,Т.Оюунгэрэл “Хүний нөөцийн удирдлага”сурах бичиг, 2008 он, УБ хот,

Англи хэл дээр ашигласан номын жагсаалт:

1. Saintur Tsog, (2020), Human Resource Management of the Border Protection Agency, doctoral dissertation, University of Internal Affairs of Mongolia, pp 28-31.
2. Parker, I. 2001. Absolute PowerPoint. The New Yorker May 28, p. 76.
3. Keller, J. 2003. Is PowerPoint the devil? Chicago Tribune, posted January 23.
4. Patty, A. 2007. Research points the finger at PowerPoint. Available online at http://www.smh.com.au/articles/2007/04/03/1175366240499.html. Accessed 7 September 2009
5. Manning, A., and N. Amare. 2006. Visual-rhetoric ethics: Beyond accuracy and injury Technical communication 53: 195–211.
6. Tufte, E. R. 2003a. The cognitive style of PowerPoint. Cheshire, CT: Graphics Press.

Судалгааны ажлын баримтжуулсан мэдээлэл



20220310 Smart.txt | *GANZAGAS B.splsm | PLS Algorithm (Run No. 1)

Construct Reliability and Validity

Matrix | Cronbach's Alpha | rho_A | Composite Reliability | Average Variance

	Cronbach's Al...	Composite Rel...	Average Varian...
Ес зүй, харилцаа, хандлага	0.754	0.831	0.500
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ	0.947	0.956	0.732
Ажлын байран дахь сургалт	0.767	0.843	0.520
Ажлын байрны гадуурх сургалт	0.887	0.916	0.686
Ажлын туршлага	0.910	0.933	0.735



20220310 Smart.txt | *GANZAGAS B.splsm | PLS Algorithm (Run No. 1) | Bootstrapping (Run No. 1)

Path Coefficients

Mean, STDEV, T-Values, P-Values | Confidence Intervals | Confidence Intervals Bias Corrected | Samples

	Original Sampl...	Sample Mean (...	Standard Devia...	T Statistics (|O/...	P Values
Ес зүй, харилцаа, хандлага -> АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ	0.340	0.345	0.123	2.765	0.006
Ажлын байран дахь сургалт -> АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ	0.042	0.084	0.150	0.281	0.779
Ажлын байрны гадуурх сургалт -> АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ	0.005	-0.013	0.171	0.027	0.979
Ажлын туршлага -> АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ	0.564	0.549	0.172	3.283	0.001

ГАМШГААС ХАМГААЛАХ БЭЛЭН БАЙДАЛ, БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТОД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF DISASTER PREPAREDNESS AND EMERGENCY PREPAREDNESS DEGREE

Б.Амарбаяр
Дотоод хэргийн их сургуулийн “Гамшиг судлал”-ын магистрант, ахлах дэслэгч
Amarbayar.B
Master of Disaster Manajment, University of Internal Affairs

Хураангуй: Гамшгаас хамгаалах бэлэн байдал, байдлын зэргийн тухай ойлголт, тодорхойлолтуудыг шинжлэн үзэж шинээр тодорхойлохыг зорьсон болно. Шинжилгээний энэ хэсэг нь хураангуй, үндсэн хэсэг, дүгнэлт, ашигласан материал хэсгээс бүрдэнэ.

Abstract: analysis of disaster preparedness, understanding and definition of preparedness degree.

This part of the analysis consists of a summary, a man part, a conclusion and the material used.

Түлхүүр үгс: гамшиг, бэлэн байдал, бэлэн байдлын зэрэг.
Keywords: Disaster, readiness, emergency readiness

Үндсэн хэсэг:

Гамшгаас хамгаалах бэлэн байдал, байдлын зэргийн тухай ойлголт, тодорхойлолтуудын талаар нэвтэрхий толь бичиг, хууль, стандарт, судлаачид өөрийн тодорхойлолтоор авч үзсэн байна. Тийм учраас нэг мөр болгох үүднээс нэгтгэн шинжлэн үзэх зүйтэй юм. Тиймээс "Гамшгаас хамгаалах бэлэн байдал" гэсэн ойлголтыг хоёрдмол утгагүйгээр тодорхойлох шаардлагатай байна.

“Гамшгаас хамгаалах бэлэн байдал” хэмээх ойлголтын тогтсон тодорхойлолтыг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Нэр томьёоны тодорхойлолтууд	Эх сурвалж
1.	**Гамшгаас хамгаалах бэлэн байдал** Болзошгүй гамшгийн аюулаас хүн ам, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчныг хамгаалах, урьдчилан сэргийлэх, гамшгийн үед аврах, хор уршгийг арилгах, гамшгийн дараа хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага болон гамшгаас хамгаалах алба, төрийн болон нутгийн захиргаа, аж ахуйн нэгж байгууллагыг сургаж бэлтгэн, бэлтгэл бэлэн байдлыг хангахыг[1].	Монгол улсын стандарт, гамшгийн холбогдолтой Нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги, MNS 6010:2009, албан хэвлэл, Стандартчилал, хэмжил зүйн газар, Улаанбаатар, 2009 он, 3.1.3 заалт
2.	Бэлэн байдал (готовность)- эрсдэлийн дүн шинжилгээнд үндэслэн, гамшгийн эрсдэлийн удирдлагаас авч хэрэгжүүлсэн гамшиг тохиолдохоос	Паламдорж Ш, нарын, Цэргийн нэр томьёоны

[1] МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ, MNS 6010: 2009, Ангилалтын код 01.040.13; 13.200, Стандартчилал Хэмжил Зүйн Үндэсний Зөвлөлийн 2009 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн 42 дугаар тогтоолоор батлав. Энэ стандарт нь 2010 оны 01 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн хүчинтэй. Энэхүү стандартыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 11 дүгээр сарын 18 өдрийн 532 тоот тушаалаар байгуулагдсан Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, тэргүүн дэслэгч С.Хүрэлсүх ахлагчтай ажлын хэсэг боловсруулж, ГСХ-ийн захирал, доктор Б.Баяржаргал хянасан байна.

	өмнөх үйл ажиллагааны үр дүн. Бэлэн байдалд нөмрөх аюул занал, бодит гамшигтай тулгарах үед, эрсдэлтэй байгаа хүний амь нас, эд хөрөнгийг тухайн аюулын талаар сэрэмжлүүлэх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх, авран туслах үйл ажиллагаа багтах бөгөөд урьчилан таамаглаж, эрт залан мэдээлэх, байгууллагын бүтэц, бэлэн байдлын стратеги, бодлогыг хэрэгжүүлэх, сайжруулах асуудал багтдаг[2].	тайлбар толь, УБ., 2014, 102 талд
3.	Бэлэн байдал (Preparedness, готовность)- Гамшгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд авч хэрэгжүүлдэг гамшгийн өмнөх үйл ажиллагаа бөгөөд эрсдэлийн дүн шинжилгээнд үндэслэгдэнэ. Үүнд бэлэн байдлын стратеги, бодлого, байгууллагын бүтэц, зарлан мэдээлэл, урьдчилан мэдээлэх боломж, чадвар болон заналхийлж байгаа аюул эсвэл бодит гамшигтай тулгархад аюулаас сэрэмжлүүлж, зохих арга хэмжээг авч, эрсдэлтэй байгаа олон нийтийн амь нас, эд хөрөнгийг хамгаалахад туслах арга хэмжээг тодорхойлох төлөвлөгөө боловсруулах/ сайжруулах үйл ажиллагаа багтана[3].	ОБЕГ Гамшиг судлалын хүрээлэн, Гамшгийн нэр томьёоны тайлбар толь, УБ., 2012, 6 талд
4.	Байлдааны бэлэн байдал (боевая готовность)- -цагийн байдлын ямар ч нөхцөлд, тогтоосон хугацаанд байлдаанд орох, дээд командлалаас өгсөн үүргийг мадаггүй биелүүлэх цэргийн жинхэнэ чадвар. Байлдааны бэлэн байдлыг захирагч штабаас үүргээ зөв ойлгох, болзошгүй ажиллагаанд бэлтгэх, цагийн байдлын өөрчлөлтийг урьдчилан харах болон цэргийн нэгтгэл ангийн байлдах чадвараар тодорхойлогдоно. Байлдааны бэлэн байдлын чадварыг зэрэг нь тайван цагт цэргийг тайван цагт байдлааны байдалд богино хугацаанд оруулах, байлдаанд зохион байгуулалттай шилжүүлэх, дайны үед байлдааны үүрэг шууд биелүүлэх чадварыг хангахад чиглэдэг[4].	Паламдорж нарын, Цэргийн нэр томьёоны тайлбар толь, УБ., 2014, 68 талд
5.	Preparedness (Бэлэн байдал) Эрсдэлийн нарийвчилсан дүн шинжилгээнүүдэд үндэслэн, гамшгийн эрсдэлийн удирдлагын хам сэдвийн хүрээнд авч хэрэгжүүлсэн гамшгийн өмнөх үйл ажиллагаанууд. Үүнд нөмөрч буй аюул занал, бодит гамшигтай тулгарах үед эрсдэлтэй байгаа хүй хамтлагийн амь нас, эд хөрөнгийг тухайн аюулын талаар сэрэмжлүүлэн, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж, авран туслахтай холбогдсон үйл ажиллагаануудыг тодорхойлох ба урьдчилан таамаглаж, эрт зарлан мэдээлэх чадамж, байгууллагын бүтэц, бэлэн байдлын стратеги, бодлогыг ерөнхийд нь хөгжүүлэх/ сайжруулах асуудлууд багтана[5].	ОБЕГ, ОБА эрдэм шинжилгээний хүрээлэн, Гамшгаас хамгаалах асуудалтай холбогдол бүхий товчилсон үг, нэр томьёоны тайлбар, УБ., 2007, 22 талд
6.	Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуульд Гамшгаас хамгаалах бэлэн байдлын тухай ойлголт,	Гэсэн заалтууд л байна. Тодорхойлолт алга байна

[2] Паламдорж нарын, Цэргийн нэр томьёоны тайлбар толь, УБ., 2014, 102 талд
[3] ОБЕГ Гамшиг судлалын хүрээлэн, Гамшгийн нэр томьёоны тайлбар толь, УБ., 2012, 6 талд
[4] Паламдорж нарын, Цэргийн нэр томьёоны тайлбар толь, УБ., 2014, 68 талд
[5] ОБЕГ, ОБА эрдэм шинжилгээний хүрээлэн, Гамшгаас хамгаалах асуудалтай холбогдол бүхий товчилсон үг, нэр томьёоны тайлбар, УБ., 2007, 22 талд

	тодорхойлолт байгаа эсэхийг үзэхэд 10 дугаар зүйл. “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах”, “10.1. Гамшгаас хамгаалах бэлэн байдал нь дараах зэрэгтэй байна”	
7.	Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хуульд “гал түймэр унтраах” гэсэн заалт байгаа болохоос галын аюулын үеийн бэлэн байдлын тухай заалт алга.	Заалт алга байна.

Дээрхээс үзвэл, гамшгаас хамгаалах бэлэн байдал гэдэг ойлголтыг нэг мөр болгон тодорхойлох шаардлага харагдаж байна. Бэлэн байдал, байлдааны бэлэн байдал гэсэн Цэргийн нэр томьёоны тайлбар толь, Монгол улсын стандартаар тогтоосон Гамшгийн холбогдолтой Нэр томьёо, тодорхойлолт, ОБЕГ, Гамшиг судлалын хүрээлэн, Гамшгийн нэр томьёоны тайлбар тольд тодорхойлсон ойлголтуудыг харьцуулан шинжлэн үзээд гамшгийн бэлэн байдлын тодорхойлолтыг дүгнэлт хэсэгт заасан байдлаар тодорхойлж болох юм гэж үзлээ.

Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийн талаар Монгол Улсын Гамшгаас хамгаалах хуульд өргөн хэрэглэж байна. Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг гэсэн тодорхойлолт л мөн одоогоор алга байна. Харин Гамшгаас хамгаалах тухай хуульд “Гамшгаас хамгаалах бэлэн байдал нь дараах зэрэгтэй байна:[6]” 10.1.1.өдөр тутмын бэлэн байдал; 10.1.2.өндөржүүлсэн бэлэн байдал; 10.1.3.бүх нийтийн бэлэн байдал гэжээ. Улмаар гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргүүдэд хэрэгжүүлэх арга хэмжээг заасан байна.

“Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг гэж тухайн цагийн байдалтай уялдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний үе шатыг хэлнэ” гэж болно. Эдгээр үе шатанд авч явуулах арга хэмжээнүүдийг Онцгой байдлын газар, хэлтэс, гал унтраах аврах анги, салбар, салаа бүрийн гүйцэтгэх үүрэгтэй холбогдуулан төлөвлөж хэрэгжүүлнэ.

Дүгнэлт

Төрийн цэргийн байгууллагуудад бэлэн байдал гэдгийг өөрсдийн ажил үүргийн онцлогт тохируулан янз бүрээр тодорхойлон авч үздэг хэдий ч агуулгын хувьд ойролцоо байна.

Онцгой байдлын байгууллагын хувьд “Гамшгаас хамгаалах бэлэн байдал гэж гамшиг, (осол, сүйрэл, онцгой нөхцөл байдал) бий болсон үед Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон гамшгаас хамгаалах Улсын алба, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой байдлын газар, хэлтэс, байгууллагын удирдлага, штаб, хүч хэрэгсэл, аврах бригад, гал түймэр унтраах, аврах анги, салбар, нэгж, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн нь цагийн байдлын ямар ч нөхцөлд, тогтоосон хугацаанд гамшигтай тэмцэх, хор уршгийг арилгахад дээд удирдлага (дарга) захирагчаас өгсөн үүргийг цаг хугацаанд нь биелүүлэх жинхэнэ чадварыг хэлнэ” гэж тодорхойлж болох юм гэсэн дүгнэлт хийлээ.

Мөн “Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг гэж тухайн цагийн байдалтай уялдуулан авч хэрэгжүүлэх

[6] Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.1 дэх заалт

арга хэмжээний үе шатыг хэлнэ” гэж тодорхойлж болох юм гэж үзлээ.

Төрийн цэргийн байгууллагууд “бэлэн байдал” гэдэг тодорхойлолтыг өөрсдийн ажил үүргийн онцлогт тулгуурлан өөр өөрөөр тодорхойлон авч үздэг хэдий ч утга найруулагын хувьд ойролцоо байна.

“Гамшгаас хамгаалах “Бэлэн байдал”гэж гамшиг, аюулт үзэгдэл, осол бий болсон үед орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн нь ямар ч нөхцөлд, тогтоосон хугацаанд урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгоход дээд удирдлага (дарга) захирагчаас өгсөн үүргийг цаг хугацаанд нь биелүүлэх чадварыг хэлнэ” гэж тодорхойлж болох юм гэсэн дүгнэлт хийлээ.

Ашигласан материал:

1. Монгол улсын стандарт, гамшгийн холбогдолтой Нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги, MNS 6010:2009, албан хэвлэл, Стандартчилал, хэмжил зүйн газар, Улаанбаатар, 2009 он

2. Паламдорж Ш, нарын, Цэргийн нэр томьёоны тайлбар толь, УБ., 2014,

3. ОБЕГ Гамшиг судлалын хүрээлэн, Гамшгийн нэр томьёоны тайлбар толь, УБ., 2012,

4. ОБЕГ, ОБА эрдэм шинжилгээний хүрээлэн, Гамшгаас хамгаалах асуудалтай холбогдол бүхий товчилсон үг, нэр томьёоны тайлбар, УБ., 2007

ГОЛ УСНЫ АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ,ЭРГИЙН ХАМГААЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ БОЛОМЖ

PREVENTING RIVER HAZARDS AND OPPORTUNITIES TO IMPROVE PROTECTION

Б.Батдэлгэр
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Batdelger.B
University of internal affairs master Senior Lieutenant

Хураангуй: Энэхүү өгүүлэлд Улаанбаатар хотод голын эрэг дагуу иргэдийг үер, усны ослоос урьдчилан сэргийлэх, эргийн хамгаалалтын зурвасын хяналтыг нэмэгдүүлж, видео аналитик, хяналтын камер, зарлан мэдээллэх системийг хослуулан ашиглах боломж, бусад улс орны арга туршлагын тухай судалгааны талаар өгүүлэв.

Abstract: This article discusses the prevention of floods and water accidents along the riverbanks in Ulaanbaatar and the increase of control over the coastal protection strip; The possibility of using a combination of video analytics, surveillance cameras and warning systems, as well as research on the experience of other countries.

Түлхүүр үгс: Гол усны аюулаас урьдчилан сэргийлэх, эргийн хамгаалалт, хяналтын камер, зарлан мэдээллэх систем

Key words: Preventing river hazards, coastal protection, surveillance cameras, warning system

Удиртгал

Дэлхийн улс орнууд гамшиг осол гарсны дараа тэмцэхээс илүүтэй түүнээс урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах нь улс орны хөгжил дэвшилд эерэгээр нөлөөлнө гэсэн үзэл санааг хэрэгжүүлж эхэлж байна. Өөрөөр хэлбэл, “Гамшгаас хамгаалах менежмент”-ээс “Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх менежмент”-ийн чиг хандлагыг баримтлах болжээ.

Дэлхийн хэмжээнд жил бүр 370 000 орчим хүн живж нас барж байгаагийн 90 гаруй хувь нь бага, дунд орлоготой орнуудад тохиолддог. Эдгээр нас баралтын талаас илүү хувь нь 25-аас доош насныхан байгаа бөгөөд 5-аас доош насны хүүхдүүд хамгийн их эрсдэлтэй тулгарч байна. Усны осол нь дэлхий даяар 5-14 насны хүүхдүүдийн нас баралтын үндсэн шалтгааны гуравдугаарт ордог.[1]

Зураг 1. Усны ослын тухай баримтууд

[1] WHO, Preventing drowning: an implementation guide, 2017

Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд жил бүр 60 гаруй хүн усанд осолдож, амь насаа алдаж байна. Түүнчлэн Улаанбаатар хотод сүүлийн жилүүдэд гамшигт үзэгдэл, гал түймэр, үер ус, техникийн осол, зөрчлүүд удаа дараа гарч эрдэнэт хүний амь нас, эд хөрөнгөнд их хэмжээний хохирол учруулснаас төр засгаас ихээхэн хэмжээний төсөв, хөрөнгө зарцуулагдаж, урьдчилан сэргийлэх, авран хамгаалах ажиллагаа, гал түймрийг унтраах, таслан зогсоох зэрэг шаталсан арга хэмжээ авахад иргэн бүр санаачилгатай, идэвхитэй оролцох, гамшгаас хамгаалах шинэ эрх зүйн орчин, шинэ тогтолцоог бий болгож гамшигтай тэмцэх талаар олон талт үйл ажиллагаа явуулахад чухал тулгамдсан асуудлын нэг бол мэдээллийн технологитой уялдуулах явдал юм.

Үндсэн хэсэг

Гол усны аюулыг тодорхойлбол Монгол Улсын “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 4.1.5 заалтын дагуу “аюул” гэж хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй аюулт үзэгдэл, осол, хүний буруутай үйл ажиллагааг хэлнэ гэж тодорхойлжээ. Иймд аливаа гол, ус, үерийн аюултай холбоотойгоор хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учрах үзэгдлийг гол усны аюул гэж тодорхойлж болно гэж үзэж байна.

Гол, усны осол нь ихэвчлэн иргэдийн анхаарал болгоомжгүй байдлаас тохиолдох ба автомашин техник хэрэгсэлдээ найдах, бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхих, эцэг, эхчүүдийн сонор сэрэмжгүй байдал, архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ гол усанд орох зэрэг шалтгаанаас үүдэлтэй байдаг. Ялангуяа зуны улиралд аялал зугаалга, амралтын үе эхэлснээр нуур, гол мөрний эрэг дагуух хөдөлгөөн ихсэж анзааргагүй, бодлогогүй байдлаасаа болж нуур, үерлэсэн гол мөрөнд живэх тохиолдол цөөнгүй гардаг. Харин өвөл, хаврын улиралд нуур, гол мөрний ус заагдсан хэмжээнд хүртэл хөлдөж бэхжээгүй болон бүрэн хайлж дуусаагүй байхад түүн дээгүүр зорчих хөдөлгөөн хийх, гулгах зэрэг нь иргэдийг эрсдэлд оруулах гол нөхцөл болж байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2021 оны дөрөвдүгээр сарын A/RES/75/273 тоот тогтоолоор “Усанд живэхээс урьдчилан сэргийлэх дэлхийн өдөр”-ийг жил бүрийн долдугаар сарын 25-нд тэмдэглэхээр тунхаглажээ. (UNO, 2019)

Зураг 2. Усны ослын тухай баримтууд



БНСУ-ын Хаеунда эрэг дээр хяналтын камер, автомат анхааруулах систем

Амьдралын чанар сайжрахын хэрээр Солонгосын далайн эрэг дээрх амралт зугаалгын үйл ажиллагаа нэмэгдэж, үүний сацуу далайн эрэг дээр аялагчдын аюулгүй байдалтай холбоотой хэд хэдэн асуудал гарч ирсэн байна. 2007-2009 онд Хаеунда далайн эрэгт далайн давалгааны улмаас олон арван хүн аюулд өртөж байжээ. Тиймээс Солонгосын засгийн газрын зүгээс далайн эрэг дээр амрагчдыг хамгаалахын тулд аюулгүй байдлын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. БНСУ-ын Цаг уурын албанаас далайн эрэг дээр аялагчдыг хамгаалахын тулд давалгааны үүслийг урьдчилан таамаглах механизмыг тодорхойлох шаардлагатай болсон. Ийнхүү усны ослын хохирлыг бууруулах, мөн давалгааг ажиглах арга техникийг боловсруулах судалгааны төслийг эхлүүлсэн байна. Хоёр жилийн хугацааг (2010 оны 6-р сараас 2012 оны 5-р сар хүртэл) хамарсан судалгааны төсөл нь хоёр үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

Хаа сайгүй байдаг мэдрэгчийн сүлжээний техник дээр тулгуурлан одоогийн хойч үеийнхэнд зориулсан урьдчилан таамаглах хэрэгслүүдийг боловсруулах

Далайн эрэг дээр аялагчдын аюулгүй байдлыг хангах автомат анхааруулах системийг бий болгох

2010 оны 7 дугаар сарын 6–ны өдрөөс 8 дугаар сарын 18-ны өдрийн хооронд олж авсан ажиглалтын өгөгдлийн дагуу GUI-д суурилсан таамаглалын хөтөлбөрийг боловсруулсан байна. Төслийн хоёр дахь жилд (2011 оны 6 дугаар сараас 2012 оны 5 дугаар сар хүртэл) урьдчилан таамаглах програмыг одоогийн ажиглалттай харьцуулан баталгаажуулжээ. Хоёр дахь жилийн даалгавраа биелүүлэхийн тулд далайн эргийн нөхцөл байдлын бодит цагийн өгөгдөл дамжуулах техникийг боловсруулж, будгийн туршилтыг хийсэн байна. Эдгээр ажлуудаас гадна RFID хоолой ашиглан автомат дохиоллын шинэ системийг бий болгож далайн эрэг дээрх иргэдийн аюулгүй байдлыг хангах системийг ажиллагаанд оруулсан байна. (Н.К.Вае, 2011)

Одоогийн байдлаар Монгол улсын хувьд гол, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг дараах 4 үндсэн чиглэлээр авч хэрэгжүүлдэг: (Онцгой байдлын ерөнхий газар, 2019)

Зураг 3. Усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ



Зураг:4 Улаанбаатар хотын Туул голын дагуух ослын зураг



Хүн амын 40 гаруй хувь нь оршин сууж байгаа Улаанбаатар хотын хүн амын төвлөрөл, амралт зугаалга, иргэдийн анхаарал болгоомжгүй байдлаас үүдэн Хан-Уул, Баянзүрх дүүрэгүүдэд голчлон усны ослын 31 хувийг эзэлж байна. Усны осол тохиолдож байгаа эрсдэл өндөртэй газруудын байршлыг зураглан, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж үйл ажиллагаагаа илүү оновчтой болгох нь судалгаанд суурилсан онолын үндэстэй, бодитой арга хэмжээг авахад чухал ач холбогдолтой байна.

Closed Circuit TeleVision буюу CCTV нь хяналтын камерын дүрсийг утастай болон утасгүй сүлжээгээр тодорхой зайнд дамжуулан хяналт хийх техникийн цогц шийдэл юм. Теле хяналтын системийг банк, нисэх онгоцны буудал, гудамж талбай, худалдааны төв, цэрэг, цагдаа зэрэг төрийн болон хувийн байгууллага, хувь хүмүүс хяналт, хамгаалалтын чиглэлээр өргөнөөр ашигладаг байна. Теле хяналтын систем нь нэг ба түүнээс дээш тооны хяналтын камеруудтай байх ба тэдгээрийн видео дүрс, аудио (дуу), өгөгдлийг тодорхой зайнд дамжуулж хяналтын дэлгэц дээр харуулах бөгөөд бичлэг, өгөгдлийг зориулалтын төхөөрөмжид хадгалдаг.

Нийслэл засаг даргын 2019 оын 07 дугаар сарын 30-ны өдрийн А/755 захирамж (газар, 2019), Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт ашиглаж байгаа болон цаашид шинээр суурилуулахаар төлөвлөж буй хяналтын камеруудыг телехяналтын камерын нэгдсэн системд оруулж, мэдээллийг өргөн хүрээнд зохистой ашиглах, хамгаалах зорилго бүхий “Улаанбаатар хотын телехяналтын нэгдсэн системийн төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам” Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн С/45 дугаар тушаалаар Монгол Улсын стандарт “Теле хяналтын системийн

техникийн ерөнхий шаардлага MNS 6423:2019” баталсан байдаг. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор “ Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам ”-ыг баталсан байдаг. “

Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийг олон нийтэд түшиглэсэн, хяналттай хүүхэд асрах үйлчилгээнд хамруулах нь живэх эрсдлийг бууруулах төдийгүй эрүүл мэндийн хувьд батлагдсан бусад ашиг тустай. Сургуулийн насны хүүхдүүдэд усанд сэлэх, усны аюулгүй байдал, уснаас аврах ур чадварыг эзэмшүүлэх нь бас нэг чухал арга юм. Гэхдээ энэхүү сургалтын арга хэмжээг явуулахдаа аюулгүй байдлын талаар онцлон анхаарч, аюулгүй байдлын туршсан сургалтын хөтөлбөр, аюулгүй сургалтын бүс, шалгалт, суралцагчийн сонголт, суралцагч ба багшийн аюулгүй байдлыг хангах нөхцөл зэргийг багтаасан эрсдлийн ерөнхий менежментийг хийх ёстой.

Усны аюулгүй байдлын үндэсний стратегийг боловсруулах нь усны эргэн тойрон дахь аюулгүй байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, шийдлүүдийн талаар зөвшилцлийг бий болгох, олон салбарын үйл ажиллагааг чиглүүлэх стратегийн чиглэл, хүрээг бий болгож, хүчин чармайлтыг хянах, үнэлэх боломжийг олгоно. (UNO, 2019)

Зураг: 5 Усны ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Теле хяналт, зарлан мэдээлэх систем:

Телехяналтын систем нь аналог болон тоон хяналтын камерууд дээр суурилагдах ба тэдгээрийн видео дүрс, аудио (дуу), өгөгдлийг тодорхой зайнд дамжуулж хяналтын дэлгэц дээр харуулах бөгөөд бичлэг, өгөгдлийг зориулалтын төхөөрөмжид хадгалдаг. Телехяналтын систем нь аналог, дижитал гэсэн 2 төрөлтэй байдаг.

Теле хяналтын камерын төрөл

Зураг 4 Тоон хяналтын системийн ажиллагааны бүтэц



Зураг 5 Аналог, Тоон хяналтын системийн ажиллагааны бүтэц



Теле хяналтын камерыг зориулалтаас нь хамаарч дотор болон гадна, хөдөлгөөнт ба чиглэлийн гэж тус тус ангилдаг. Хөдөлгөөнт камер нь 360 градус эргэдэг ба дүрсийг таталт хийж нарийвчилсан харж болдог. Чиглэлийн камер байнгын нэг чигт хяналт тавих байдлаар ашигладаг.

Зураг: 6 Голын эрэг дагуу суурилуулсан теле хяналт болон зарлан мэдээллэх системийн бүтэц



Манай орны нөхцөлд теле хяналтын системийг төрийн болон төрийн бус байгууллага, гудамж талбай, худалдаа үйлчилгээний төвүүд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд аюулгүй байдлаа хангах, хяналт тавих зорилгоор өргөнөөр ашигладаг

.

Зураг 7. Хяналтын систем, өгөгдөл дамжуулах процесс



Зураг 8. Камерын системийн хяналтын хэсэг

Олон нийт цугларсан газарт хөдөлгөөнт болон хөдөлгөөнгүй камерыг хослуулан ашиглах нь илүү үр дүнтэй байдаг. Чиглэлийн камеруудыг чиглэлийг тохируулан, хөдөлгөөнт камераар тухай газар талбайг ойртуулан татах, эргүүлэх, дагуулж харах зориулалтаар нэг цэгт суурилуулж ашиглавал тухайн орчинд бүрэн хяналт тавих боломжтой.

Дүгнэлт

Аливаа гамшгийн үед мэргэжлийн аврах байгууллагын тусламж иртэл дийлэнх тохиолдолд иргэд өөрсдийгөө болон бусдыг авран хамгаалж, учирч болох эрсдэлийг бууруулж байгаа нь гадны улс орнуудад тохиолдсон гамшгийн байдал, түүнийг даван туулж байгаа туршлага, сургамж харуулж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед аврах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд сайн дурын ажилтнуудын оролцох оролцоо, гүйцэтгэх үүрэг дэлхий нийтэд улам бүр өсөн нэмэгдсээр байна.

Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх, эргийн хамгаалалтын зурвасын хяналтыг нэмэгдүүлж видео аналитик, хяналтын камер, зарлан мэдээллэх системийг хослуулан ашиглах судалгааны ажлыг хийж гүйцэтгэснээр гол усанд осолдож амь насаа алдах тохиолдлыг бууруулахаас гадна онол, практикт болон урьдчилан сэргийлэх аврах ажил зарцуулах зардлыг хэмнэхэд хувь нэмэр оруулах ач холбогдолтой. Гол усанд осолдох аюултай газарт теле хяналтын камер суурилуулснаар мэдээллийг шуурхай хүлээн авч хариу арга хэмжээ авах нөхцөл бүрдэнэ. Мөн анхааруулах сэрэмжлүүлэх завьт эргүүл, хөдөлгөөнт эргүүлийг хянах боломж бүрдэнэ. Төхөөрөмжийг шаардлагатай байршилд байрлуулан урьдчилан сэргийлэх, анхааруулах, хяналт тавьснаар урьдчилан сэргийлэх ажилд зарцуулдаг байсан зардал тодорхой хэмжээгээр буурна

Ашигласан ном зүй

H.K.Bae, D. a. (2011). Observation and Forecasting of rip current generation in Haeundae beach, Korea plan and experiment. Journal of Coastal research, 1-7.

UNO. (2019 оны July 25). www.un.org. United nations: https://www.un.org/

Нийслэлийн засаг даргын захирамж. Мэдээллийн технологийн газар: https://it.ub.gov.mn/

ОБХ, Ч. (2020 оны 06 17). Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс. Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтэс: http://chd.nema.gov.mn

Онцгой байдлын ерөнхий газар. (2019 оны 6 4). Удирдамж. Онцгой байдлын ерөнхий газар: https://nema.gov.mn/

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛ БА ИРГЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

FIRE DANGER AND CIVIL SAFETY IN BUILDINGS

Б.Гантөмөр
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Gantumur.B
University of internal affairs master Senior Lieutenant

Хураангуй: Энэ өгүүллэгийн хүрээнд манай улсын хот суурин газарт олноор баригдаж байгаа барилга байгууламжийн гал түймрийн аюул хүний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх байдлыг авч үзэв. Мөн барилга байгууламжийн гал түймрийн аюулын үнэлгээний арга зүй, гал түймрийн улмаас хүмүүс хохирох нөхцөлт магадлалыг тодорхойллоо.

Abstract: This article examines the impact of fire on large-scale construction in urban areas of Mongolia. In addition, the methodology of fire hazard assessment of buildings and facilities and the probability of people being injured due to fires were determined.

Түлхүүр үгс: Барилга байгууламж, гал түймэр, иргэн, гал түймрийн аюул, гал түймрийн эрсдэл

Key words: Buildings, fires, civilians, fire hazards, fire risk

Удиртгал

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгаажна” гэж тунхаглахын сацуу, Монгол Улсын “оршин тогтнохуйн аюулгүй байдал”, “эдийн засгийн аюулгүй байдал”, “дотоод аюулгүй байдал”, “хүний аюулгүй байдал”, “хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал”, “мэдээллийн аюулгүй байдал” харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгаажихыг[1] онцлон дурдсан байна. Эдгээрээс хүний аюулгүй байдал нь хүн төрөлхтний анхдагч, нэн эртний хэрэгцээ юм. Байгаль, зэрлэг ан амьтны зүгээс ирэх аюул заналаас өөрийгөө хамгаалах анхдагч шинжтэй байсан хэрэгцээ нь хөгжлийн үе шат бүрд хувьсан өөрчлөгдсөөр ирсэн ба, өнөөгийн хүний нийгэм хөгжил, аж үйлдвэржилтийг дагасан төвлөрөлтэй уялдаа бүхий аюулгүй байдлын шинэ шинэ хэрэгцээнүүдийг бий болгосон. Эдгээрийн нэг нь хүний амьдралын нэн чухал хэрэгцээ болох барилга байгууламжийн гал түймрийн аюулгүй байдал юм.

Сүүлийн үед дэлхий дахинд олон нийтийн ба орон сууцны барилгад томоохон хэмжээний гал түймэр гарч олон хүний амь нас эрсдэх, их хэмжээний шууд ба шууд бус хохирол учрах аюул занал түгээмэл болж байна.

Манай улсын нийгмийн болон амьдралын чиг хандлага, соёл иргэншилд томоохон өөрчлөлтүүд гарч, хот суурин газарт хүн амын нягтрал ихсэж, хот төлөвлөлтийн бодлого алдагдан, гал түймрийн аюулгүй

[1] Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын Их хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48-р тогтоол.

байдлыг хангаагүй барилга байгууламж олноор баригдаж байна.

Эдгээр барилга байгууламжид уламжлалт тоосго, модон материал хэрэглэх хэмжээ багасаж полимер материалыг улам өргөн хэрэглэх болсон нь түүнийг үйлдвэрлэх түүхий эд элбэг, өртөг бага, ашиглахад хялбар, хөдөлмөрийн бүтээмж өндөртэй холбоотой юм. Эдгээр материал нь хямд төсөр үнэтэй, шатамхай шинж чанартай учир гал түймрийн эрсдэлийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Шатамхай полимер материал нь мод, цаас гэх мэт хялбар шатдаг материалуудаас хүчтэй шатдаг ба шаталтын бүтээгдэхүүн нь хордуулах чанар өндөртэй. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад түүнийг хэрэглэх, үйлдвэрлэхийг хориглосон ямар нэг стандарт, норм дүрэм байхгүй байгаа тул хэрэглээг хязгаарлах, хориглох боломжгүй байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндөж байна. Иймээс гал түймрийн аюулаас сэргийлэх, иргэний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай эрдэм, судалгааны ажилд төрийн зүгээс ач холбогдол өгч, бодлогоор дэмжих нь зүйтэй байна.

Үндсэн хэсэг

Нэг. Барилга байгууламжийн гал түймрийн аюул, түүнд нөлөөлж буй хүчин зүйл

Гал түймэр нь байгаль төдийгүй хүний амьдрал эд материалд асар их хохирол учруулдаг бөгөөд техногений шинжтэй (хүний үйл ажиллагаатай холбоотой) хамгийн аюултай хэрэг, учрал юм. Тухайлбал манай оронд 2005-2015 онд жилд дунджаар 3552 аюулт үзэгдэл, осол гарснаас 3245 буюу 91,3%-ийг гал түймэр эзэлж байна2.

Иймд гал түймрийн аюул, түүний эрсдэл, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлийн талаар судлах нь тус салбарын үйл ажиллагааг цаашид улам боловсронгуй болгох, урьдчилан сэргийлэх чиглэлд ихээхэн чухал ач холбогдолтой.

Аливаа барилга нь инженер-техникийн шийдлийн хувьд гал түймрийн аюулгүй байдлыг хангасан байхаар төлөвлөгддөг. Өөрөөр хэлбэл гал түймэр гарах үед хүмүүсийг аврах, гал түймрийн голомтод гал унтраах бие бүрэлдэхүүнийг хүрэлцэн очих, гал түймэр унтраах бодис хүргэх, шатаж байгаа барилгаас болон барилга нурах үед зэргэлдээ барилгад гал түймэр дэлгэрүүлэхгүй байх нөхцөл боломжоор хангасан шийдэлтэй байх шаардлагатай.

Олон улсад төрөл бүрийн өвөрмөц шийдэл бүхий өндөр барилгуудыг барих болсон ба эдгээр барилгуудын галын динамикийн онцлог3, гал түймрийн аюулаас хамгаалах асуудал инженерүүдийн тулгамдсан асуудлын нэг хэвээр байсаар байна.

Барилга байгууламжийн загвар, хэмжээ, шинэ төрлийн барилгын материалтай холбоотой галын ачааллын өсөлт зэргээс хамаарч болзошгүй гал түймрийн аюулыг нэмэгдүүлсээр байгааг 1-р зурагт үзүүлэв.

[2] Монгол улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээний эмхэтгэл 2014, 2015, ГСХ, 2016 он.

[3] Patrick G. Cox High Rise Fire Protection

1 дүгээр зураг. Гал түймрийн аюулд нөлөөлж буй хүчин зүйлүүд

1-р зургаас үзэхэд болзошгүй гал түймрийн аюулд нөлөөлж буй хүчин зүйлд галын тархалтын хурд, гал хөгжих хугацаа зэрэг динамик процесс хамаарч байгаа нь гал түймрээс учрах хохирлын хэмжээ хугацаанаас шууд пропорционал хамааралтай болохыг илэрхийлж байна.

Иймд тухайн барилга байгууламжийг үүрэг зориулалтаас нь хамааруулан 5 ангилж (Ф1-Ф5) гал тэсвэршилтийн зэргээр 5 хуваан (I-Y) гал түймрийн аюулгүй байдлын шаардлагыг хийц бүтээцийн гал тэсвэрлэх хугацаагаар тогтоодог. Эдгээр ангилал зэрэглэлд нийцүүлэн гал түймрийн аюулаас хамгаалах шийдлийг төлөвлөдөг ба түүнийг хэрхэн хангасан байдалд хяналт хийх замаар урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг (2-р зураг).

2 дугаар зураг. Барилга байгууламжийн гал түймрийн аюулгүй байдлын хяналт

Барилгын бүтээцийн галын аюулын ангийг гал түймэр дэлгэрэх, тархах түүний аюултай хүчин зүйл бий болоход түүний оролцох хэмжээгээр тогтоодог. Өөрөөр хэлбэл тэдгээрийн зориулалт, технологийн үйл ажиллагааны онцлогоор тогтоогдоно4. 2-р зураг болон Монгол улсад барилга

[4] БНбД 21-01-02 "Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" 5.17-р заалт

байгууламжийн гал түймрийн аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлж буй байдлаас үзэхэд галын ачааллын тооцоо, эрсдэлийн үнэлгээ хийгдэхгүй байна. Төлөвлөлтийн хувьд зөвхөн норм дүрэм, стандартын шаардлагаар хэрэгжүүлж байгаа нь ажиглагддаг. Иймд галын аюулгүйн норм, дүрэм, хууль эрх зүйн актуудын талаар тусгайлан авч үзье.

Дэлхийн ихэнх хөгжингүй улс орны барилгын хууль тогтоомжийн салшгүй нэг хэсэг нь галын аюулгүй байдлын норм дүрэм юм. Тэдгээр нь дэлхий нийтэд барилгын үйлдвэрлэл, хөгжил болон барилгын нормын эх сурвалж болж байдаг. Эдгээрийн хэлбэржилтэнд үндэсний барилга, газар нутгийн соёл, эдийн засаг нөлөөлж байдаг. Иймээс зарим нэг томоохон улс гүрэнд одоог хүртэл нэгдсэн галын норм дүрэм бий болоогүй байна. Жишээ нь АНУ олон муж улстай бөгөөд тэдгээрт барилгын гал эсэргүүцэх дөрвөн дүрэм үйлчилдэг5. Тэдгээр нь барилгын дүрэм ба барилгын үйлдвэрлэлийн холбооны дүрмийг төдийгүй гал эсэргүүцэх ерөнхий асуудлуудыг багтаасан байдаг байна.

Орчин үеийн барилгын нормчлолын систем нь 19-р зууны сүүлээр хэлбэржиж эхэлсэн бөгөөд барилга барих, зураг төсөл зохиох тэдгээрийн тооцоо, галын аюулаас хамгаалах системийн нормчлолыг тусгах болсон байна. Мөн түүнчлэн гал түймрийн аюулаас хамгаалах нормчлолд гал түймрийн эрсдэлийг тооцон тусгах болжээ (3-р зураг).

3-р зургаас үзэхэд анхны нормчлол нь гал түймэр ба ослыг ерөнхийлөн дүгнэсэн, технологийн хөгжил, нийгмийн хэрэгцээний хөгжил зэрэг тогтмол өөрчлөгдөж байх зүйлсийг тооцолгүй зөвхөн нэг талаас харсан өрөөсгөл систем байсан. 1970-аад оноос шинжлэх ухаан ба инженерийн аргатай хамт хөгжиж эхэлсэн. Тухайлбал барилгын аюулгүй байдал, найдвартай байдал, барилга барих нийлмэл технологи ба зураг төсөл, тухайн барилга ашиглах хугацаа, болзошгүй эрсдэлийн тоон утгыг тусгах болсон байна.



[5] http://lib.znate.ru



3 дугаар зураг. Гал түймрээс хамгаалах бичиг баримтын хэлбэржилтийн өөрчлөлт

Монгол Улс 1960-аад оноос гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээрх ОХУ-ын барилгын норм дүрмийг баримталж эхэлсэн байна. 1970-аад оноос зарим нэг норм дүрмийг эх хэл дээр хөрвүүлэн ашиглах болжээ. Өнөөгийн байдлаар барилга байгууламжийн гал тэсвэршилтийн зэрэг, галын аюулын анги, гал түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2002 онд боловсруулсан “Барилга байгууламжийн галын аюулгүй байдал” БНбД 21-01-02, “Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм” БНбД 21-02-02 гэсэн үндсэн заавал мөрдөх эрх зүйн акт байна.

Уг нормуудад тухайн гал тэсвэршилтийн зэргийн барилгад ашиглах материалуудын галын техникийн үзүүлэлтийг хамаарах ангиллаар байхаар тусгаж өгсөн бөгөөд орчин үед хэрэглэгдэж байгаа полимер материалуудтай хийц (полимер дүүргэгчтэй сэндвич, полимер хавтан, бусад хийцүүд гэх мэт)-ийн талаар тодорхой заалт, тэдгээрийн галын аюулыг үнэлэх арга, аргачлал, стандарт байхгүй байгаа нь бүх барилгад өргөн ашиглах нөхцөл боломжийг олгожээ. Ингэснээр объектын гал түймрийн эрсдэлийг нэмэгдүүлсэн байна.

Иймд орчин үед өргөн хэрэглэгдэж байгаа галын аюултай полимер материалуудын хэрэглэх хүрээ, аюулыг үнэлэх арга, аргачлал, стандартыг барилгын норм дүрэмд тусгах нь байгууллагын үйл ажиллагаа, гал түймрийн эрсдэлийн үнэлгээ гэх мэт зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад чухал ач холбогдолтой.

Гадаадын улс орнуудад гарч байгаа аюулгүй байдлын дүрэм нормд полимер материалын хэрэглээг хязгаарласан хатуу журмууд тусгагдах болсон ба полимер материал, бүтээгдэхүүний галын аюулгүй байдлын ангилал, сертификатчилал, чанар стандартын журам үйлчилдэг.

Шинээр үйлдвэрлэлд нэвтэрч буй олон нэр төрлийн полимер материалуудын галын аюултай үзүүлэлтийг олон улсад хүлээн зөвшөөрсөн ISO стандартаар тодорхойлох стандарт, тэдгээрийн хэрэглэх хүрээний нормыг батлан гаргах зайлшгүй шаардлага байна гэж үзлээ.

Хоёр. Барилга, байгууламж дахь иргэний аюулгүй байдал

Барилга байгууламж дахь иргэний аюулгүй байдлыг тодорхойлохын тулд гал түймрийн нөхцөл байдлын талаарх статистик мэдээнд дүн шинжилгээ хийе.

Монгол улсад жилд дунджаар 3200 орчим аюулт үзэгдэл, осол тохиолддогийн 90 гаруй хувийг объектын болон ой, хээрийн түймэр харин үлдсэн 10 орчим хувийг бусад аюулт үзэгдэл, осол эзэлдэг байна.

2005-2015 онд объектын түймэр 33563 удаа гарч гал түймрийн улмаас 951 хүн амь насаа алдсан байна6. Үүнээс нас барсан болон түлэгдэж бэртсэн хүүхдийн (0-16 нас) тоог 4-р зурагт үзүүлэв.

4 дүгээр зураг. 2005-2015 оны объектын түймэрт нас барсан болон түлэгдэж бэртсэн хүүхдийн тоо

4-р зургаас үзэхэд 2005-2015 онд гарсан объектын түймэрт 221 хүүхэд амь насаа алдсан нь нийт амь насаа алдсан хүний 23%-ийг эзэлж байна.

Сүүлийн үед дэлхий дахин болон монгол улсын хэмжээнд олон нийтийн болон орон сууцны барилгад томоохон хэмжээний гал түймэр гарч олон хүний амь нас эрсдэх, их хэмжээний шууд ба шууд бус хохирол учрах болсон.

Манай улсад баригдаж буй барилгын ихэнхэд нь дулаалга, дотоод заслыг хийхдээ полистиролын гаралтай пенополистирол, пенополиурентаныг сонгож байгаа нь[7] судалгаанаас харагдсан ба тэдгээрийн талаар тодорхой мэдлэг, мэдээлэлтэй байх нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрсдийн эрсдэлийг багасгах нэг чухал алхам болно.

Энэ талаар бодит гал түймрийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд дараах үр дүн илэрсэн байна[8]. Үүнд:

1. Барилгын гадна дулаалгын материалд хөөсөнцөр полистиролыг ихээр хэрэглэх болсон нь тухайн барилгын гал тэсвэршилтийг бууруулах хүчин зүйлийн нэг болоод байна. Жишээ 1: 2013 оны 4 дүгээр сарын 29-нд Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хороонд байрлах “Орчлон” хороллын 41 дүгээр байранд гал түймэр гарсны улмаас тухайн блокийн гадна 1-10 давхар хүртэл шатаж олон хүний амь нас эрсдэлтэй байдалд орж, 20 гаруй айл эд материалаараа хохирсон.

[6] ГСХ-ийн 2005-2015 оны шифрийн мэдээ.

[7] С.Базаррагчаа, “Пенополистирол ба пенополиуретаны шатамхай чанарыг үнэлэх судалгаа”, 2015 он

[8] С.Базаррагчаа, “Барилга байгууламжийн гал тэсвэршилтийн зэрэгт полимер материалын нөлөөлөх байдлын судалгаа, ГСХ бүтээлийн эмхэтгэл, 2013 он.

Жишээ 2. “Нарантуул” олон улсын худалдааны төвийн хүнсний захын барилгын хана нь төмөр бетон карказтай хөнгөн блокоор дүүргэлт хийж, пенополистирол дүүргэгч бүхий сэндвич хавтангаар дулаалга хийгдсэн, дээврийн хэсэгт төмөр карказ зангидаж пенополиуретанаар дулаалга хийсэн металл хавтас бүхий барилга байсан бөгөөд гал түймэр гарсны улмаас тухайн полимер материалууд нь барилгын гал тэсвэрлэх хугацааг бууруулан галын тархалтад нөлөөлж галыг дэмжигч болж оролцсон нь нотлогдсон.

2. Галын аюултай полимер материалаар олон нийтийн барилгын дотоод заслыг хийж байгаа нь гал түймрийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Жишээ 3: ОХУ-ын “Доголон морь” шөнийн клуб-ресторан заалны таазыг полистиролын гаралтай пенопласт, пенополистиролоор бүрсэн байсан бөгөөд пиротехникийн хэрэгслийг ажиллуусны улмаас гал түймэр гарсан ба полимерийн уугилтаас ялгарсан хорт болон угаарийн хийнээс олон хүн амь эрсэдсэн. Пенополистиролын шаталтын үед өндөр хортой бодисууд тухайлбал синилийн хүчил, азотын оксидууд ялгардаг. Түүгээр хүн 1-2 гүнзгий амьсгалахад үхэлд хүрдэг[9] байна.

Манай улсад дээрх байдал үүсэхгүй гэсэн баталгаа өнөөдрийн байдлаар байхгүй байна. Амьдрал дээр баригдаж буй барилгын дийлэнхэд нь дулаалгын материалаар нь пенополистирол, пенополиурентаныг сонгож байгаа нь судалгаанаас харагдсан. Тухайлбал 2010 онд Гамшиг судлалын хүрээлэнгийн Галын судалгааны баг “Өндөр барилгын галын аюулын эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ судалгааны тайлан” гаргасан бөгөөд уг судалгаанд барилгын комисс хүлээн авсан албан ёсны 208 өндөр барилга хамрагдсан. Судалгаанаас үзэхэд Улаанбаатар хотод сүүлийн 3 жилд өндөр барилгын тоо эрс өссөн ба тэдгээрийн хийц бүтээц нь олон улсын стандартад дөхөж очсон боловч ихэнх барилгууд нь гадна дулаалгыг шатдаг хөөсөнцөр полистиролоор хийсэн нь дээрх барилгуудын гал тэсвэршилтийн зэргийг бууруулах хүчин зүйлийн нэг болсон байна.

Мөн түүнчлэн барилга байгууламжийн гал түймрээс хамгаалах ерөнхий хийцлэлийн 3,4%, гадна хийцийн 12,2%, аврах зам гарц, хөлийн өрөө, шатны хонгил, цахилгаан шатны өмнөх талбайн хана, таазны дүүргэгч, засал чимэглэл зэргийн 2,4% нь стандартын шаардлага хангаагүй, 16,8%-д утаанд автахгүй шат төлөвлөгдөөгүй байгаа нь иргэд гал түймэрт өртөх, утаанд хордох аюулыг үүсгэсэн, зарим барилга хоорондын галын аюулгүй байдлын зай алдагдсан байгаа нь гал түймрийн үед конвекцийн, кондукцийн дулаан солилцооны нөлөөлөлд хялбар өртөн гал тархан дэлгэрэх таатай нөхцөлийг бүрдүүлж олон барилгад гал дэлгэрэх магадлалтай байгаа нь өндөр эрсдэлтэй байдалд хүргэсэн10 байгааг тодорхойлсон.

Дээрх судалгаа шинжилгээнээс үзэхэд барилга, байгууламж дахь иргэний аюулгүй байдал нилээд эрсдэл

[9]Мальцев В.В. Причиной гибели людей в «Хромой лошади» стали пары пенополистирола. Комментарии к заметке на сайте Вести.ru

[10]Д.Баян-Эрдэнэ, С.Базаррагчаа , Өндөр барилгын галын аюулын эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ судалгааны тайлан, ГСХ-ийн бүтээлийн эмхэтгэл, 2010 он.

ихтэй байна гэж дүгнэх үндэслэлтэй байна.

Гурав. Барилга байгууламжийн гал түймрийн аюулын үнэлгээний арга зүй, хүмүүс хохирох нөхцөлт магадлал

Байгаль техникийн гаралтай гамшгийн эрсдэлийг үнэлэх нийтлэг арга зүй байдаг бөгөөд дараах томъёогоор илэрхийлэгдэнэ.

R=R1xR2xR3 (1)

энд: R1- аюулт үзэгдэл үүсэх магадлал, R2-эмзэг байдлын магадлал, R3-гамшгийн хохирлын магадлал.

(1) томьёог төрөл бүрийн байгаль техникийн гаралтай гамшгийн үед тодорхой хэлбэрт шилжүүлэн ашиглаж болдог[11]. Иймд болзошгүй хувийн эрсдэлийг нийслэлийн хэмжээнд тооцоход дараах байдлаар шилжүүлэн ашиглая.

$$R_1 = \frac{\text{гарсан гал түймрийн тоо}}{\text{хүн амын тоо}} = \frac{3249}{1345500} = 0{,}002$$

$$R_2 = \frac{\text{гал түймэрт нас барсан хүний тоо}}{\text{гарсан гал түймрийн тоо}} = \frac{31}{3249} = 0{,}0095$$

$$R_3 = R_1 \cdot R_2 = 0{,}002 \cdot 0{,}0095 = 1{,}91 \cdot 10^{-5}$$

Хувь хүний эрсдэл 1,91·10-5 гарч байгаа нь зөвшөөрөгдсөн эрсдэлийг тогтоох Эшбийн шалгуураар “Онцгой нөхцөлд зөвшөөрөх боломжтой” гэсэн шалгуурт харгалзаж байна. Энэ нь урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг байнга хянах, аюулгүй байдлыг хангах, галын автомат систем суурилуулах, иргэдийг ГАУС мэдлэг чадварыг дээшлүүлэх гэх мэт үйл ажиллагааг чанартай зохион байгуулах тусгай хөтөлбөр, төлөвлөгөө шаардлагатай болохыг харуулж байна.

Судалгаанаас харахад барилга байгууламжийн гал түймрийн аюултай нөхцөл байдлаас хүмүүсийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах системийг 5-р зурагт харуулсан байдлаар авч үзэж болно.

5 дугаар зураг. Хүмүүсийг гал түймрийн аюултай хүчин зүйлийн үйлчлэлээс хамгаалах систем

[11] С.Хүрэлсүх нар, Гамшгийн эрсдэлийн үнэлгээний зарим асуудлууд, УБ хот, 2014 он, х-62-69.

5-р зургаас үзэхэд хүмүүсийг хамгаалах систем нь гал түймрийн аюулыг эрт илрүүлэх, унтраах, хүмүүсийг аюулгүй байрлалд нүүлгэн шилжүүлэх систем, галыг анхны эх үүсвэрт нь түргэн шуурхай унтраах систем, галын тархалтыг хязгаарлах эсэргүүцэн хамгаалах, болзошгүй гал түймрийн аюулын үед аюулгүй газарт шилжих, барилга байгууламжийн гал түймрийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаарх сургалт дадлагын системийн иж бүрдэл болох нь харагдаж байна. Эдгээр системийг зүй зохистой, оновчтой зохион байгуулахын тулд хамгийн түрүүн хүмүүсийн мэдлэг, сургалт дадлага чухал үүрэгтэй.

Харин барилга байгууламжийн гал түймрийн аюулыг тодорхойлох тоон шинжилгээний алгоритмыг 6-р зурагт харуулав. Уг алгоритмын дагуу шинжилгээг бүрэн гүйцэд хийснээр тухайн объектын аюулгүй байдал хангагдана.

Хүн ам олноор оршдог олон нийтийн болон орон сууцны барилга байгууламжийн хийц бүтээц, материалын галын аюулгүй байдал хамгийн чухал. Үүний аюулгүй байдлыг хангах асуудал дан ганц Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хяналтын байцаагч нарын үүрэг биш юм. Иймд тэдгээрийн талаар тодорхой мэдлэг, мэдээлэлтэй байх нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өөрсдийн эрсдэлийг багасгах нэг чухал алхам болно.

Барилга байгууламжийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэхийн тулд:

Барилга байгууламжийн зураг төслийн үе шатанд тавих анхаарал, шаардлагыг нэмэгдүүлэх;

Гал түймэр гарах магадлал өндөртэй орон сууц, олон нийтийн барилгын иргэд, ажилчдын өөрийн болон бусдын амь нас эд хөрөнгийг аврах, аж ахуйгаа эрсдэл багатай авч гарах аргад сургах;

Пенополистирол, пенополиуретанаар дулаалга хийсэн барилга байгууламжийг галын анхан шатны багаж хэрэгсэл, гал унтраах автомат дохиоллын системээр иж бүрэн тоноглоход анхаарах;

Барилгын материалыг лабораторийн туршилтад хамруулан сертификачлах эрх зүйн зохицуулалтыг Барилгын тухай, Галын аюулгүй байдлын тухай хуульд суулгаж өгөх; зэрэг үйл ажиллагааг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.



6 дугаар зураг. Барилга байгууламжийн гал түймрийн аюулыг тодорхойлох тоон шинжилгээний алгоритм

Дүгнэлт

1.Шинээр үйлдвэрлэлд нэвтэрч буй олон нэр төрлийн полимер материалуудын галын аюултай үзүүлэлтийг олон улсад хүлээн зөвшөөрсөн ISO стандартаар тодорхойлох, стандарт, тэдгээрийн хэрэглэх хүрээний нормыг батлан

гаргах зайлшгүй шаардлага байна гэж үзлээ.

Улмаар хөгжлийн дараагийн шатанд нано технологийн хэрэглээ ч бий болох нь зайлшгүй. Иймд энэ талын бодит үндэслэлтэй, цэгцтэй, хэрэглэгч ашиглахад хялбар ойлгогдох хэмжээний судалгааны материал бий болгох, улмаар амьдралд нэвтрүүлэх зайлшгүй шаардлага байгаа нь судалгаанаас харагдаж байна.

2.Нийслэлийн хэмжээнд хувь хүний эрсдэл 1.91·10-5 гарч байгаа нь зөвшөөрөгдсөн эрсдэлийг тогтоох Эшбийн шалгуураар "Онцгой нөхцөлд зөвшөөрөх боломжтой" гэсэн шалгуурт харгалзаж байна. Энэ нь урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг байнга хянах, аюулгүй байдлыг хангах, галын автомат систем суурилуулах, иргэдийг гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг чадварыг дээшлүүлэх гэх мэт үйл ажиллагааг чанартай зохион байгуулах тусгай хөтөлбөр, төлөвлөгөө бий болгох, ерөнхий боловсролын болон дээд боловсролын сургалтын системд галын аюулаас урьдчилан сэргийлэх хөтөлбөртэй болох шаардлагатай болохыг харуулж байна.

3.Хүн ам олноор оршдог олон нийтийн болон орон сууцны барилга байгууламжийн хийц бүтээц, материалын галын аюулгүй байдал хамгийн чухал. Аюулгүй байдлыг хангах асуудал Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хяналтын байцаагч нарын үүрэг төдийгүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг юм. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн хувьд тодорхой мэдлэг, мэдээлэлтэй байх нь өөрсдөд учрах эрсдэлийг багасгах нэг чухал алхам болно.

4.Барилга байгууламжийн гал түймрийн аюулыг тодорхойлох тоон шинжилгээний алгоритмыг дэвшүүлэв. Уг алгоритмын дагуу шинжилгээг бүрэн гүйцэд хийснээр тухайн барилга байгууламжийн аюулгүй байдал хангагдана гэж үзлээ.

Ашигласан материал

1. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын Их хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48-р тогтоол.
2. Монгол улсад тохиолдсон аюулт үзэгдэл, ослын мэдээний эмхтгэл 2014, 2015, ГСХ, 2016 он.
3. Patrick G. Cox High Rise Fire Protection
4. БНбД 21-01-02 "Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" 5.17-р заалт
5. ГСХ-ийн 2005-2015 оны шифрийн мэдээ.
6. С.Базаррагчаа, "Пенополистирол ба пенополиуретаны шатамхай чанарыг үнэлэх судалгаа", 2015 он
7. С.Базаррагчаа, "Барилга байгууламжийн гал тэсвэршилтийн зэрэгт полимер материалын нөлөөлөх байдлын судалгаа, ГСХ бүтээлийн эмхтгэл, 2013 он.
8. Мальцев В.В. Причиной гибели людей в «Хромой лошади» стали пары пенополистирола. Комментарии к заметке на сайте Вести.ru
9. Д.Баян-Эрдэнэ, С.Базаррагчаа , Өндөр барилгын галын аюулын эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ судалгааны тайлан, ГСХ-ийн бүтээлийн эмхтгэл, 2010 он.

10.С.Хүрэлсүх нар, Гамшгийн эрсдэлийн үнэлгээний зарим асуудлууд, УБ хот, 2014 он, х-62-69.
11.“Барилга байгууламжийн галын аюулгүй байдал” БНбД 21-01-02,
12.“Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм” БНбД 21-02-02
13.Fire Resistance Directory, January, 198, Underwriters Laboratories inc.
14.J.C.Wakefield “A Toxicological Review of the Products of Combustion”, 2010
15.Nelson, G.L., In Fire and Polymers II: Materials and Tests for Hazard Prevention, Nelson, G.L., ed., American Chemical Society, Washington, D.C., 1995, Vol. 599, pp. 1-26.
16.http://lib.znate.ru
17.www.nfpa.org
18.http://www.stf.mn
19.www.cgamma.ru/spravochnik/pogarobesopas.nost
20.www.usfa.fema.gov
21.www.firefighternearmiss.com
22.www.hyogo.uncrd.or.jp
23.http://porotherm-ural.ru

НИЙСЛЭЛИЙН ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ АНГИУДЫН БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ХАНГАЛТАД ХИЙСЭН СУДАЛГАА

THE ANALYSIS OF SUPPLY EQUIPMENT FOR FIRE FIGHTING AND RESCUE IN CAPITAL CITY

Г.Золжавхлан
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Zoljavkhlan.G
University of internal affairs master Senior Lieutenant

Хураангуй: Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2004 онд Гал түймэртэй тэмцэх газар, Иргэний хамгаалалтын газар, Улсын нөөцийн газрыг нэгтгэн Онцгой байдлын алба бий болгон зохион байгуулсан хөгжлийн явцдаа 100 жилийн түүхийг бүтээсэн. Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагааны талаар эрдэмтэн судлаачид эрдэм шинжилгээ судалгааны ажил хийж, судалгааны үр дүнг нэвтрүүлэх, хэрэгжүүлэхээр тасралтгүй үйл явц хэрэгжсээр байна. Харин онцгой байдлын байгууллагын техник, тоног төхөөрөмжийн хүрэлцээний талаар хийсэн нэг сэдэвт бүтээл, судалгааны ажил ховор байгаа тул энэхүү өгүүлэл нь гамшгийн үеийн ар тал хангалтын техник багаж зэвсэглэмжийн хүрэлцээг судалсан.

Abstract: It is created 100 years history that its merged and organized National Emergency Management Agency by approved a decision of the Mongolian Goverment in 2004 between Fire Fighting Agency, Civil Defense and State Reserve Agency. Scholars and researchers are implementing to continous process for introducing, conducting and doing the research activities of Emergence Management Agency. There were lack one topic research, study about equipments' sufficiency of Emergencey Agency but our research were studied rear and supplies' technology and equipments.

Түлхүүр үг: Онцгой байдал, гамшиг, гал түймэр, ар тал хангалт, техник багаж хэрэгсэл

Key words: Emergency, disaster, fire, rear supply, technology and equipment.

Удиртгал

Судалгааны ажлын үндэслэл: Гамшгийг хохирол багатай даван туулахын үндэс нь гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх явдал юм. Харин гамшгаас хамгаалах чадавхын гол үзүүлэлт нь багаж, хэрэгсэл тоног төхөөрөмжийн хангалт гэж үзэж болно. Болзошгүй гал түймрийн үед түүний сөрөг нөлөөллийг арилгахад чиглэсэн зохистой арга хэмжээг авах хүн хүч, техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдан үүргээ гүйцэтгэхэд бэлтгэгдсэн байдлаар илэрхийлэгдэнэ. Тусгай багаж хэрэгсэл, техник зэвсэглэмжээр сайтар хангагдсан аврагч, гал сөнөөгч л гал түймэр унтраах ажиллагааг амжилттай гүйцэтгэдэг.

Нийслэлийн гал түймрийн аюулаас хамгаалагдсан байдлыг нэмэгдүүлэхэд Засаг дарга хуулиар хүлээсэн үүргээ нэг мөр хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд шинээр газар олгох, инженерийн шугам сүлжээг засварлах, шинэ дэд бүтэц бий болгоход Онцгой байдлын байгууллага, тэр дундаа нийслэлийн гал түймэртэй тэмцэх байгууллагын санал дүгнэлтийг заавал оруулж, зөвшилцөж байх шаардлагатай юм. Гал түймэр унтраах аврах ангийн багаж, тоног төхөөрөмжийн хангалтыг, “Гал унтраах анги, хэсэг, аврах нэгж

MNS 6412:2013 стандарт”-ыг баримтлан гүйцэтгэж ирсэн байна[1].

Үндсэн хэсэг: Ар талын хангалт гэдэг нь цэргийн байлдааны бэлэн байдал, өдөр тутмын үйл ажиллагааг хангах, даалгасан үүргийг биелүүлэхэд чиглэсэн цэргийн материалын, тээврийн ба бусад аж ахуйн хангалт, үйлчилгээний арга хэмжээний нэгдэл; цэргийн байлдааны ажиллагааны нэг төрөл; Ар тал хангалт нь материал хэрэгслийн, тээврийн, инженер-аэродромын, аэродром-техникийн, хүн эмнэлгийн, мал эмнэлэг-эрүүл ахуйн, худалдаа, ахуйн үйлчилгээний, орон сууц санхүүгийн хангалтуудыг өөртөө багтаана[2].

Онцгой нөхцөл байдлын үед албан хаагчдыг зэвсэг, техник, ар талын материал хэрэгслээр хангах, тээвэрлэх, аврах багажаар хангах, өвчтөн шархтанд эмнэлгийн тусламж үзүүлэх, тэдгээрийг гамшгийн голомтоос татан гаргах зорилгоор бий болгосон хүч хэрэгслийн бүлэглэлийг онцгой байдлын албаны ар тал гэнэ [3] гэж тодорхойлж болно.

Ар тал хангалт гэдэг нэр томьёог дэлхийн II дайны үеийн байлдааны талбарт “хангамж ба тээвэрлэлт “ гэдэг ойлголтоор ашиглаж эхэлсэн. Ар тал хангалт гэдэг нь материал, техник хэрэгслийн хангалтыг зөв тоо хэмжээгээр, оновчтой захиалгаар, сайн чанар байдалтайгаар, шаардлагатай газарт нь зохих цаг хугацаанд худалдан авч нийлүүлэх, хуваарилан хүргэх үйл ажиллагаа[4] юм.

Онцгой нөхцөл байдлын албаны бүх талын хангалт нь аврах ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд захирагч штабаас аврагчдыг аврах ажиллагаанд цагт нь зохион байгуулалттай орох аврах ажиллагааг амжилттай явуулах таатай нөхцлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн төрөл, тусгай мэргэжлийн дэмжлэг болон хангалтын хүч хэрэгслийн нягт ажиллагааг хангах зорилгоор хэрэгжүүлж буй арга хэмжээ[5] юм.

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 24.1-т...техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бараа материал нь ар тал хангалтын үндсэн тулгуур ойлголтыг гаргаж өгсөн нь бидний судалгааны ажлын үндсэн ойлголттой шууд холбогдож байна.

Аврах ажиллагааны бүрэлдэхүүнд багтаж, аврагчдын эрүүл мэнд, зэвсэг техникийн бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадварыг тасралтгүй хангах зорилгоор бүрдүүлсэн материал хэрэгслийн нөөц бүхий эмнэлгийн, засвар татан гаргалтын, тээврийн, аж ахуйн зориулалтын хүч хэрэгслээс бүрдсэн ар тал техникийн анги салбаруудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүрээ юм.

Гамшиг ослын үед болон тайван цагт Онцгой байдлын албаны ар талын хангалтыг зохион байгуулах үйл ажиллагаа нь улс орны эдийн засгийн чадавхи, зэвсэглэмж, техник технологийн шинэчлэлийн төвшин, тайван цагт бүрдүүлсэн материал хэрэглэлийн нөөцийн хэмжээ, тэдгээрийн зохистой байршуулалт, ар

[1] П.Амарзаяа болон бусад,Судалгааны ажлын эмхтгэл,УБ,2015,х-131

[2] Ш.Паламдорж нар. Цэргийн нэр томьёоны тайлбар толь.

[3] П.Цэдэв, “Онцгой байдлын үеийн ар тал хангалт” илтгэл

[4] Ник Картер, Гамшгийн менежмент гарын авлага, Англи хэлнээс орчуулсан хэвлэл, УБ хот, 2005 он, 257 дахь тал.

[5] П.Цэдэв, “Онцгой байдлын үеийн ар тал хангалт” ЭШӨ, 2015 он

талын бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, ар талын техник, хүч хэрэгслийн хангалтын байдал зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

Онцгой байдлын ар талын үндсэн үүрэг нь аврах үйл ажиллагааг ямарч нөхцөлд явуулахад зэвсэг техник, ар талын материал хэрэгслээр тасралтгүй хангах, өвчтөн шархтанд эмнэлгийн тусламж үзүүлэх, тэдгээрийг гамшгийн голомтоос татан гаргах явдал юм.[6]

Онцгой байдлын удирдлага бол захирагч, штаб болон удирдлагын бусад байгууллагууд цагийн байдлын тухай мэдээлэл авч судлан шинжилж нягтлан, шийдвэр гаргаж гүйцэтгэгчид нь хүргэх замаар аврах ажиллагаанд бэлтгэх болон аврах ажиллагааны явцад анги, салбарын хүчин чармайлтыг аврах үүргээ амжилттай биелүүлэхэд чиглүүлэх зүй зохистой үйл ажиллагаа мөн.

Ар талын удирдлага бол Онцгой байдлын удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсэг юм. Ар талын удирдлага гэдэг нь аврах ажиллагаанд зэвсэг техник, ар талын материал хэрэгсэл, эрүүл мэндийн хангалтыг зохион байгуулж явуулахад захирагч, штаб, ар талын дарга, төрөл, мэргэжлийн албадын дарга нараас явуулж буй үйл ажиллагаа бөгөөд ар талыг бэлэн байлгах, бэлтгэх, ар талын өмнө тавигдсан үүргийг биелүүлэх явцад түүнийг удирдах үйл ажиллагаа юм[7].

Ар талын удирдлагын үндсэн зорилго нь аврах үйл ажиллагаанд тавигдсан үүргийг биелүүлэхийн тулд цагийн байдлын тодорхой нөхцөлд ар талын хүч хэрэгслийг дээд зэргээр үр бүтээлтэй ашиглах нөхцөлийг хангах явдал юм.

Ар талын удирдлагын үндсэн агуулгад доорх арга хэмжээ хамаарагдана.Үүнд:

ар талын хангалтыг зохион байгуулах саналыг цаг тухайд нь хэрэгжих үндэслэлтэйгээр гаргаж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэгч нарт маш богино хугацаанд хүргэх;

аврах үйл ажиллагаанд ар талын хангалтыг төлөвлөх;

харьяа анги, салбарт тавигдсан үүрэг хүргэх;

удирдлагын ар талын байр болон ар талын харьяа анги, салбаруудын харилцан ажиллагаа, хангалтын уялдаа холбоог зохион байгуулах;

аврах үйл ажиллагаанд бэлтгэх түүнийг зохион байгуулж явуулах үед ар талын төрөл бүрийн хэрэгслийг ашиглаж тасралтгүй удирдах;

цагийн байдлын мэдээг тасралтгүй олох, цуглуулах, судлах, тогтоох;

өгөгдсөн үүргийн гүйцэтгэлийг хянаж, туслалцаа үзүүлэх зэрэг болно.

Ар талын удирдлагын үндсэн агуулгыг хангахын тулд ар талыг бэлэн байдлын өндөр түвшинд байлгах, удирдлагын ар талын байр болон ар талын анги, салбарын удирдлагын байрын тогтвортой ажиллагааг хангах, цагийн байдлын мэдээг цуглуулах, удирдлагын ба холбооны хэрэгслийг үр бүтээлтэй ашиглах, албан тушаалтнуудын ар талын мэдлэгийг гүнзгийрүүлэх, ажлын тэргүүний арга барилыг амьдралд нэвтрүүлэх, аврах үйл ажиллагааны удирдлагыг нарийн зохион байгуулах шаардлагатай юм.

[6] П.Цэдэв, “Онцгой байдлын үеийн ар тал хангалт” гарын авлага, 3 дахь тал

[7] Ц.Төрмөнх “Цэргийн ар тал, техникийн хангалтын үндэс” гарын авлага

Ар талын хангалт нь дараах зарчмуудтай байна[8]. Үүнд:

Ар талын хангалтын албаны бэлэн байдал болон бэлэн байдлын зэргүүдэд шилжихэд байнга бэлэн байх;

Ар талын хангалтын хүч хэрэгслийг зөв хувиарлан ашиглах чадвартай байх;

Ар талын хангалт тасралтгүй бүрэн хэмжээгээр тухай бүрд нь хийгдэж байх;

Ар талын хангалтыг зөрчил гарч болзошгүй чиглэлд төвлөрүүлж, төлөвлөгдсөн байх;

Ар талын хангалт нь арвилан хэмнэлтийн зарчимд тулгуурлагдсан байх;

Ар талын хангалтын материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлсэн байх;

Ар талын хүч хэрэгсэл сургагдсан, ашиглах чадвартай маневарлах хугацааг зөв сонгож хийж чаддаг байх;

Ар талын удирдлагын тогтвортой байдлыг өндөр түвшинд байлгах зэрэг болно.

Ар талын удирдлага нь Онцгой байдлын албаны удирдлагын нэгэн адил өндөр бэлэн байдалтай, шуурхай бүтээлч ажиллагаатай, бат тогтвортой байх шаардлагатай. Ар талын удирдлагад дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

Тасралтгүй байх;

хатуу чанд байх;

уян хатан байх.

Нийслэлийн гал түймэр унтраах, аврах ангиудын багаж хэрэгслийн хангалтад хийсэн судалгаа: Нийслэлийн онцгой байдлын гал түймэр унтраах, аврах ангиудад одоо байгаа, ашиглагдаж буй багаж хэрэгслийн жагсаалтаас харахад хангагдсан багаж хэрэгслийн тоо ширхэг, шаардлагатай байгаа багаж хэрэгсэл, байвал зохих багаж хэрэгслийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ.

Судалгаанд нийт 15 анги нэгжид бүртгэлтэй багаж хэрэгслийн жагсаалтаас хамгийн их элэгдэл өгч, дахин сэлгэх шаардлага гардаг 79 төрлийн багаж хэрэгслэлээс эхний 3 төрлийг түүвэрлэлээ. Үүнд:

Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл /иж бүрэн/

Галын гар шат /эвхдэг, гурав сунадаг, араатай/

Даралтын хоолой /51,66,77 мм/

Судалгааны тоон өгөгдөлд түүвэрлэлт хийн 15 анги нэгжийн хооронд харьцуулалт хийн дүрсэлсэн.

Зураг 1. Хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангалтын судалгаа



[8] Ц.Төрмөнх "Цэргийн ар тал, техникийн хангалтын үндэс" гарын авлага

Судалгаандаа, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийн хангалтыг бүрэн ашиглахын тулд одоогоор жигнэсэн дундаж үзүүлэлтээр боловсруулалт хийхэд, нэгдүгээр зэрэглэлийн ангид 51.60 хувийн ашиглалттай байгаа ба 48.40 хувийн хэрэгцээ шаардлага байгааг, хоёрдугаар зэрэглэлийн ангийн хувьд 32.08 хувийн ашиглалттай байгаа ба 67.92 хувийн хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна. Иймд зэрэглэлтэй ангиудын нийлбэрийг нийслэлийн хэмжээнд тооцоолон дүгнэхэд, ашиглагдаж байгаа нь 83.68 хувь, шаардлагатай нь 16.32 хувь байна /Зураг 1/.

Зураг 2. Галын гар шатны хангалтын судалгаа



Судалгаандаа, гар шатнуудын хангалтыг бүрэн ашиглахын тулд одоогоор жигнэсэн дундаж үзүүлэлтээр боловсруулалт хийхэд, нэг болон хоёрдугаар зэрэглэлтэй ангиудын нийлбэрийг нийслэлийн хэмжээнд тооцоолон дүгнэхэд, ашиглагдаж байгаа нь 61.76 хувь, шаардлагатай нь 38.23 хувь байна /Зураг 2/.

Зураг 3. Даралтын хоолойн хангалтын судалгаа

Судалгаандаа, даралтын хоолойн хангалтыг бүрэн ашиглахын тулд одоогоор жигнэсэн дундаж үзүүлэлтээр боловсруулалт хийхэд, нэг болон хоёрдугаар зэрэглэлтэй ангиудын нийлбэрийг нийслэлийн хэмжээнд тооцоолон дүгнэхэд, ашиглагдаж байгаа нь 81.42 хувь, шаардлагатай нь 18.57 хувь байна /Зураг 3/.

Зураг 4. Нийт багаж хэрэгслийн дүн

Нийслэлийн онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах ангиудад ашиглагдаж байгаа болон цаашид нэн шаардлагатай 79 нэр төрлийн багаж хэрэгслэлээс нийт байх нь 9962, ашиглагдаж байгаа 4388 шаардлагатай 5574 тус тус байна /Зураг 4/.

Энэ судалгааны ажлын хүрээнд Нийслэлийн хэмжээний Гал түймэр унтраах, аврах ангийн гал түймэр унтраах, аврах ажиллагаа явуулах тусгай хэрэгслийн хангалтын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийлээ.

ДҮГНЭЛТ

Аврах анги, салбаруудын ар талын хангалт түүний бэлтгэл ажлаас ихээхэн хамаарна. Ар талын хангалтыг зохион байгуулахдаа ар талын хүч хэрэгслийг уян хатан, зохистой ашиглах, ар талын анги салбаруудыг гамшгийн хөнөөлд аль болох бага өртөхөөр тооцох ёстой.

Гамшиг осолд аврагч нарыг бэлтгэх ажиллагаатай нэгэн зэрэг ар талын бэлтгэл ажил явагдах ба түүнд дараах арга хэмжээнүүд багтана:

ар талын анги, салбаруудыг бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэл, ар талын техник , сэлбэг, бусад эд хогшлоор нөхөн хангах:

материал хэрэглэлийн нөөцийг тогтоосон хэмжээгээр нөхөн бүрдүүлэх:

ар талын хангалтын төлөвлөгөөг албад, салбараар тодотгох:

бүх төрлийн тооцоог хийж, ар талын хангалтын шийдвэр гаргахад бэлэн болгох:

ар талын байгууламжийг бий болгох зэрэг болно.

Ар талын хүч хэрэгслийг аврах ангийн бие бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг, газар орон, цаг агаарын байдал, ар талын анги, салбаруудын харуул, хамгаалалтыг зохион байгуулах боломж зэрэг олон хүчин зүйлийг харгалзан байрлуулна. Аврах ажиллагааны бэлтгэлийн явцад, аврагч нарын бүх төрлийн материал хэрэглэлийн хангалтыг тасралтгүй, цаг тухайд нь, шуурхай зохион байгуулах, өвчтөн шархтан, нэрвэгдэгсэд эвдэрч, гэмтсэн техник хэрэгслийг татан гаргах, засаж сэлбэх нь ар талын гол үүрэг байдаг.

Энэхүү судалгааны ажлаараа, Нийслэлийн онцгой байдлын газрын Гал түймэр унтраах, аврах 15 ангийн багаж хэрэгслийн шаардлагатай тоон судалгааг гаргаж ажилалаа. Иймд Нийслэлийн хэмжээний Гамшиг, осол, гал түймрийн аюулаас хувь хүн болон хуулийн этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах хуулиар хүлээсэн үүргээ биелүүэх үүднээс дутагдалтай байгаа багаж хэрэгслийг анги тус бүрт бүрэн хангах, шаадлагатай хөрөнгө мөнгийг шийдвэрлэх нэн тэргүүн юм.

Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх ар талын 115 дугаар анги байгуулагдаад үйл ажиллагаа явагдаж байна. Иймд бүх төрлийн тооцоо хийж, ар тал хангалтын төлөвлөгөөг албад, салбараар гаргаж багаж хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх нь чухал юм.

Судалгааны ажлаар зэрэгцүүлэн харьцуулалт хийн боловсруулан үр дүнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна Үүнд:

Гал түймэр унтраах, аврах ангиудын үйлчлэх хүрээний стандартыг тооцоолох.

Гал унтраах автомашин гал түймрийн голомтод ажиллах хүчин чадлыг тодорхойлох.

Хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГАЛ ТҮЙМЭР УНТРААС АВРАХ АНГИУДЫН БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ХАНГАЛТЫН СУДАЛГАА

Гал түймэр унтраах, аврах анги			10		11		14		18		26		28		29		30		34		35		63		64		65		74		80		нийт			
тоо	автомашин	Байгаа зохих	4		2		2		2		2		2		2		2		2		2		2		2		2		2		2					
	Албан хаагч		107		34		43		47		61		49		37		42		50		42		50		53		34		36		31		ХАНГАГДСАН	ШАЛГАГДАГААЙ	БАЙХАЙ ЗОХИХ	ХАНГАЛТЫН ХУВЬ
Гал унтраах багаж хэрэгсэл			хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай	хангагдсан	шаардлагатай				
1	Дулаан эсэргүүцэх менгелег хувцас	4	14	10	20	6	12	8	16	8	18	4	14	8	14	7	11	8	10	17	1	8	10	10	8	12	14	3	15	7	11	10	8	119	171	290	41.034
2	Аюулын үүсэл хувцас хэрэгсэл /нэг бүрэн/	кнб		70	33	20	10	40	0	40	3	50	7	20	25	30	3	30	8	40	6	25	13	35	11	20	29	20	10	30	3	20	7	460	165	625	73.6
3	Хамгаалалтын нүдний шил		24		24		18	2	18		18		24		18		18		18		18		24		18		12		18		18		2	264	266	0.7519
4	Аврах олс иж бүрдэл	3	6	5	13	4	8	3	9	1	14	5	7	7	5	1	11	5	7	5	7	2	7	2	10	8	7	7	5	1	11	6	6	61	116	177	34.463
5	Хорт хий утаанаас хамгаалах баг	кнб		57	46	11	19	16	13	19	24	24	33	19	26	15	18	14	24	7	39	19	19	27	19	20	29	13	17	15	18	22	5	283	331	614	46.091
6	Хорт хий утаанаас хамгаалах багны нөөц бөөрөг		20	16	8		16	10	10	5	15	5	15	4	16	10	10	10	10	2	18		20	12	8	5	15	6	14	10	10	6	14	91	189	280	32.5
7	компрессор		1	2		1		1		1		1		1		1		1		1		1		1		1		1		1		1		15	0	15	100
8	Гал унтраагуур	1	14	4	11	2	12	3	13	2	16	1	15	2	16	4	12	4	11		16	2	13	2	14	1	16	2	14	4	12	2	14	31	193	224	13.839
9	Дөл дарах бүтээлэг		8	15			6	10			8	6	2		8		8		8		8		8		8		8		8		8		8	31	88	119	26.05
10	Өндөр бариллаас хүн аврах үүлэн хоолой		1		2		1		1		1		1		1		1		1		1		1		1		1		1		1		1	0	15	15	0
11	Аврах хийлдэг дэвсгэр		1	1			1		1		1		1		1		1		1		1		1		1		1		1		1		1	1	13	14	7.1429
12	Энхдэг шат	1	2	2	4	2	2	2	4	3	2	1	3	5		1	3		4	1	3	3		1	3	3	2	1	3	1	3	2	2	27	35	62	43.548
13	3 сундаг шат	1	1	7		2	1	2	1	2	2	2	1	5		1	2	2	1	3		2		3		3	1	2	1	1	2	3		39	10	49	79.592
14	Довтолгооны аралт шат	1	2	6		2	2	2	1	2	4	2	2	5		1	3	2	2	3	1	2	1	3	1	3	2	3	1	1	3	3		39	20	59	66.102
15	Зөөврийн мотопомп	1	1	2	3	1	2	2	1	2	2	3		1	2		3	1	2	2	1		2	2	1	3	1	1	2		3	2	1	22	23	45	48.889
16	Галын голомт илрүүлэгч [illegible] резиний үлгэлэ	1	2	2	1		4	1	3	1	4	1	3	1		1	3	1	3	1	3	1	2	1	3	1	4		4	1	3	1	3	13	40	53	24.528
74	шалгач [illegible] ашиллаан хөнгөрөлгөө	1			4	1	1		2		3		2	1	1		2		2		2		1		2	1	2		2		2	1	1	4	27	31	12.903
75	эмийн сан	1			4	1	1	1	1	1	2	1	1	1	1	1	1	2		1	1	1		1	1	2	1	2		1	1	1	1	16	15	31	51.613
76	аврах шуудаг	3		2	10	2	4	3	3	1	8	3	3		6	2	4	1	5		6	3		2	4	1	8	1	5	2	4	1	5	22	71	93	23.656
77	аврах олсны хамгаалагч булан	2		2	6	2	2	1	3		6	2	2		4		4		4		4	2		2	2	1	5		4		4		4	12	50	62	19.355
78	дуулгын зөөр	2		14			4	2	2	4	2	2	2	2	2	4		4		4		4		8		6		4		4		4		62	12	74	83.784
79	гал түймрээс хамгаалах нөмрөг	2		5	3	10		10			6	2	2	4			4	8			2	5		5			2	5			4	10		64	19	83	77.108
	ДҮН			478	653	180	405	332	309	277	473	337	445	434	304	225	379	193	429	199	452	213	321	292	406	557	380	204	371	225	379	467	247	4388	5574	9962	44.047
	НИЙТ			1131		585		641		750		782		738		604		622		651		534		698		937		575		604		714		43.472332			3434.3
	ХУВЬ			42.26348		30.76923		51.79407		36.93333		43.094629		58.807588		37.251656		31.02894		30.56836		39.88764		41.83381		59.44504		35.47826		37.251656		65.40616		43.183014			дундаж хувь

Ном зүй.

1.Гамшгаас хамгаалах тухай хууль, УБ.,2017

2.Гамшигтай тэмцэх үндэсний чадавхыг бий болгохын төлөө, НҮБ, Гамшгийн аюулыг бууруулах олон улсын стратегийн газар, 2007

3.Дамдин.П, Гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент УБ., 1989

4.Монгол Улсын гамшгийн удирдлагын шинэчлэлт, МОН/02/305 төсөл, УБ., 2004

5.Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны 12. дугаар сарын 20 ны өдрийн А/921 дугаар тушаалын хавсралт Уснаас эрэн хайх, аврах ажиллагааг зохион байгуулах журам

6.Үржин.О, Цэдэв.П, нарын Аюулгүй амьдрах ухааны үндэс I.II.III гарын авлага

7.Үржин.О, Гамшгийн менежмент дэд дэвтэр, УБ., 2004

8.Үржин.О Цэдэв.П нарын Гамшгаас хамгаалах үндэс УБ., 2017

9.Үржин.О, Байгалийн болон технологийн үүдэлтэй аюул, ослын тухай ойлголт, УБ., 2004

10.Цэдэв.П, Усанд шумбаж эрэн хайх ажил, УБ., 2010

11.Цэдэв.П, Гамшгийн эрсдэлийг бууруулах туршлага, түүхэн сургамж, Ред., УБ., 2006

АВРАГЧДЫН СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

INTERNATIONAL EXPERIENCE IN LIFEGUARD TRAINING

Н.Төгсбаяр
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахлах дэслэгч
Tugsbayar.N
University of internal affairs master Senior Lieutenant

Хураангуй: Онцгой байдлын байгууллагын хамгийн их анхаарал татаж байгаа мөн анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай асуудлын нэг бол алба хаагчдын дотоодын болон гадаадын системтэй сургалтын асуудал юм. Төрөл мэргэжлийн аврагч нарт тусгай мэргэжлийн шаталсан чиглэлийн сургалт дутмаг, албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргийн хуваарийг төдийлөн хангадаггүй, гамшиг ослын голомтод үүрэг гүйцэтгэх ур чадвар, чадамж сул байгаагаас шалтгаалан өөрсдийн амь нас, эрүүл мэндээр хохирох, тактикийн алдаа дутагдал гаргах зэрэг асуудал тулгарч байна. Иймээс төрөл мэргэжлийн аврагч нарт явагдаж байгаа сургалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, эрчимжүүлэх зэргээр сургалтын нөлөөг нэмэгдүүлэх асуудлыг хөндөж бусад улс орны сургалтын системтэй харьцуулан судлах, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг судлах зорилт тавьсан юм.

Abstract: One of the most important and urgent issues for the emergency services is the personnels, domestic and foreign systematic training. There is a lack of specialized training for rescuers does not meet the job description specified in the job description,loss of life and health due to lack of skills and abilities to act at the disaster site;There are problems such as making tactical mistakes. Therefore the type, expand training for professional rescuers;to compare the training system of other countries to increase the impact of training, such as intensification, The aim was to study whether it could be implemented.

Түлхүүр үг: Аврагч, сургалт бэлтгэл, Онцгой байдлын байгууллага.
Key words: rescue, training, Emergency Management Agency.

Удиртгал

Сургалтын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэших хэсгээс бүрдэх бөгөөд асуулга тус бүр нь дараах зорилтыг хэрэгжүүлнэ. Ерөнхий суурь хэсгийн агуулга нь алба хаагчдад боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх,

Мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь шинжлэх ухаан, технологи, нийгэм, хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай онол-арга зүйн мэдлэг эзэмшүүлэх,

Мэргэших хэсгийн агуулга нь нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн тухайн мэргэжлээр мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх" гэж хуульчилсан байдаг.

Сургалт гэдэг ухагдахууны талаар эрдэмтэн судлаачдын олон тодорхойлолт байдаг. Тэдгээрийг тоймлон нэгтгэн авч үзвэл:

Сургалт бол тодорхой тогтолцоо бүхий мэдлэг, чадвар, дадал төлөвшүүлж, боловсрол олгох, дамжуулах үйл ажиллагаа, төлөвлөгдсөн үйл явц, арга хэрэгсэл, тогтолцоо юм[1].

[1] М.Тэгшжаргал. Боловсрол судлал. УБ, 2010 он

Сургалт бол чанарын өөрчлөлт хийх хэрэгсэл бас орчин юм

Сургалт бол багшийн сургах, шавийн сурч танин мэдэх үйл ажиллагааны нэгдэл, амьдрал, үйл ажиллагааны орчин үеийн шаардлагад нийцүүлэн амьдрах ухаан, нийгмийн туршлагыг ахмад үеэс хойч үедээ систем дэс дараатай, зорилго чиглэлтэйгээр зохион байгуулалттайгаар дамжуулан өвлүүлэхэд чиглэсэн зорилго, агуулга, зарчим, арга хэлбэр, хэрэгсэл гэсэн үндсэн бүтэц бүхий тасралтгүй хөгжих үйл явц юм.

Сургалт бол бие хүнийг төлөвшүүлэх, хөгжүүлэх ажлын гол цөм нь юм. "Сургалт бол гамшгаас урьдчилан сэргийлэх иргэн бүрт хүрч ажиллах түлхүүр мөн[2]". Харин "бэлтгэл" гэдэг үгийг монгол хэлний тайлбар тольд бэлдвэр, урьдчилан бэлдсэн юм. бэлэн болгож зэхэх[3] гэж тайлбарлажээ.

Үндсэн хэсэг

Онцгой байдлын нэр томьёо, үндсэн ухагдахуунууд:

Онцгой байдлын албаны үндсэн нэр томъёо, ойлголт ухагдахуунуудыг дараах байдлаар тодорхойлж байна.

"гамшгийн онцгой нөхцөл байдал" гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг[4];

Онцгой нөхцөл байдал гэж тодорхой нутаг дэвсгэрт осол, байгалын аюулт үзэгдэл, сүйрэл, байгалын бусад гамшгийн улмаас хүний амь нас үрэгдэх, хүмүүсийн эрүүл мэнд буюу хүрээлэн буй байгаль орчимд гэм хор учруулах, материалын үлэмж хохирол бий болох, хүмүүсийн амьдралын хэвийн үйл ажиллагаа алдагдахаар нөхцөл байдал үүсэхийг хэлнэ[5].

Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гамшгаас хамгаалах төрийн бодлого, гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй байгууллага юм.

Онцгой нөхцөл байдал үүссэн үед гамшиг ослын голомтод аврах ажиллагааг зохион байгуулах мэргэжлийн алба хаагчдын аврагч гэнэ.

Аврагч нь (Эрэн хайх аврах ажиллагаанд бэлтгэгдсэн эрх бүхий алба хаагч)-ийг[6] хэлнэ.

Онцгой байдлын байгууллагад төрөл мэргэжлийн аврагч нар нь дараах төрөлтэй байна. Үүнд

Аврагч-химичин: Албаны бэлэн байдлыг хангаж, цацраг, химийн бодис алдагдсан болон хүн, малын гоц халдварт өвчин тархсан үед тандалт явуулах, саармагжуулах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх үүрэгтэй

Аврагч-химичин нь:

1.Цацраг, химийн бодис алдагдан болон хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед тандалт явуулах, саармагжуулах, халдваргүйжүүлэлт хийх

2.Цацраг, химийн бодис алдагдсан болон хүн, малын гоц

[2] О.Үржин Гамшгийн удирдлагын өөрчлөлт, шинэчлэл. Илтгэл, Үндэсний бага хурал. УБ. 2001 он

[3] Я.Цэвэл. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, УБ. 2013 он

[4] Гамшгаас хамгаалах тухай хууль

[5] С.Нарангэрэл “Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг", УБ. 2015 он

[6] “Эрэн хайх аврах ажиллагаа ОББС 0001:2018” стандарт

халдварт өвчин гарсан үед тандалт явуулах, саармагжуулах, халдваргүйжүүлэх дадлага, сургуульд хамрагдах, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч-тэсэлгээчин: Албаны бэлэн байдлыг хангаж, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж, тэсэрч, дэлбэрэх бодисыг аюулгүй болгох үүрэгтэй.

Аврагч-тэсэлгээчин нь:

1.Тэсэрч дэлбэрэх бодисыг аюулгүй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх

2.Тэсрэх бодис аюулгүй болгох тусгай зориулалтын техник, багаж хэрэгслийн бэлэн байдал, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч тэсэлгээчин-нохой хөтлөгч: Төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагад албаны нохойг эрэн хайх аврах чиглэлээр сургах, албаны нохойн ур чадварыг дээшлүүлэх үүрэгтэй.

Аврагч тэсэлгээчин-нохой хөтлөгч нь:

1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд сургалт, хүний хөгжлийн бодлого чиг үүргийг хэрэгжүүлэх.

2.Гамшгийн голомтод албаны нохой ашиглаж эрэн, хайх аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч-нохой хөтлөгч: Төв орон нутгийн Онцгой байдлын байгууллагад албаны нохойг эрэн хайх аврах чиглэлээр сургах, албаны нохойн ур чадварыг дээшлүүлэх үүрэгтэй

Аврагч-нохой хөтлөгч нь:

1.Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд сургалт, хүний хөгжлийн бодлого чиг үүргийг хэрэгжүүлэх.

2.Гамшгийн голомтод албаны нохой ашиглаж эрэн, хайх аврах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч-усчин: Албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах

Аврагч-усчин нь:

1.Гамшиг ослын үед ажиллах бэлтгэл бэлэн байдлыг хангаж, төлөвлөгөөт сургалтад тасралтгүй хамрагдах

2.Аюулгүй ажиллагааг чанд сахиж ажиллах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч: Албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангаж, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалах

Аврагч нь:

1.Гамшиг ослын үед ажиллах бэлтгэл бэлэн байдлыг хангаж, төлөвлөгөөт сургалтад тасралтгүй хамрагдах

2.Аюулгүй ажиллагааг чанд сахиж ажиллах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Холбоочин-аврагч: Гамшиг ослын дуудлагыг цаг алдалгүй түргэн шуурхай, үнэн зөв хүлээн авч, холбогдох албан тушаалтанд хүргэх

Холбоочин-аврагч нь:

1.Гамшиг ослын дуудлагыг хүлээн авч, гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдыг мэдээ мэдээллээр хангах

2.Холбооны техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдлыг хангах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Аврагч жолооч-холбоочин: Албаны техникийн өдөр тутмын бэлтгэл, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэн хүний амь нас эрүүл мэнд, эд хөрөнгийг аврах хамгаалах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

Аврагч жолооч-холбоочин нь:

1.Эрэн хайх, аврах ажиллагаан тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж багаж зэвсэглэмжийн бэлтгэл бэлэн байдлыг хангах.

2.Автомашин техникийг ажиллуулах явцад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа болон замын хөдөлгөөний хууль, дүрмийг мөрдөн ажиллах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Эмнэлгийн зааварлагч[7]: Гамшгийн голомтод нэрвэгдэгсэд, аврах багийн бүрэлдэхүүнд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, эмнэлгийн байгууллагад шилжүүлэх, шаардлагатай тохиолдолд зөөвөрлөх

Эмнэлгийн зааварлагч нь:

1.Иргэд багийн хамт олон гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх зааварчилгаа өгөх, сургалт зохион байгуулах

2.Нэрвэгдэгсдэд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх гэх мэт.

2012 онд ШУ-ны доктор, профессор О.Үржин. доктор, профессор П Цэдэв нар "Эрэн хайх аврах ажил" ном гаргаж түүнд төрөл бүрийн гамшгийн үед эрэн хайх аврах ажлыг гүйцэтгэх талаар авч үзсэн байна. Мөн 2017 онд Гамшгаас хамгаалах үндэс" /Мэргэжлийн анги (тусгай чиг үүргийн томилгоот бүлгийн бүрэлдэхүүнд зориулав/ ном гаргасан. Энэ номонд гамшгаас хамгаалах эрх зүйн үндэс аюулт үзэгдэл, ослын ойлголт, учруулах хор уршиг, хамгаалах арга хэмжээ, орон нутаг, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөлт, үйл ажиллагааны талаар авч үзсэн байна.

Харин ХСИС-ийн магистр хурандаа С.Баттөмөр "Аврах үйл ажиллагаанд аврагчдын сэтгэл зүй, бие бялдар, ур чадварын бэлтгэл нөлөөлөх нь" Хошууч Ж.Алтанхуяг "Аврагчдын сургалтын онол арга зүй, сургалт бэлтгэлд хийсэн шинжилгээ, сургалтыг боловсронгуй болгох арга зам" сэдвээр магистрын судалгааны ажил хийжээ. Энэ судалгаа нь аврагчдын сургалт бэлтгэлийн боловсрол олгох сургалтын онол арга зүйн үндэс, онцгой байдлын алба хаах хугацаандаа мэргэжилтэй ажилтан бэлтгэх боломж, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний загварыг боловсруулсан байна.

Судлаачдын бүтээлд аврагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсронгуй болгох арга зам талаас нь голчлон судалсан бол энэхүү судалгааны ажлаар аврагчдын өнөөгийн сургалт бэлтгэл, давтан сургах хэрэгцээг нь тодорхойлж байгаараа онцлог юм.

Гадаад орны зарим туршлага

а) БНСУ-ын аврагч нарын сургалт

БНСУ-ын Онцгой байдлын албанд анх элсэн орохдоо элсэхийг хүсэгч нь тухайн мэргэжлийн чиглэлээр дипломын болон түүнээс дээш зэрэгтэй байна гэсэн шаардлага тавьдаг байна[8]. Мөн тус шаардлагыг хангасан иргэдээс төрийн жинхэнэ албаны шалгалт гэж авдаг ба төрийн жинхэнэ албаны шалгалт нь 9 дүгээр зэргийн төрийн жинхэнэ албан хаагч гэсэн шатлалаас /ихээс бага руу/ 1 дүгээр зэргийн төрийн жинхэнэ албан хаагч гэсэн зэрэгтэй

[7] ОБЕГ-ын даргын 2019 оны А/239 тушаал

[8] Fire-related laws of korea 2016.x.187

байдаг. Онцгой байдлын албанд гал сөнөөгч, аврагчаар орохын тулд 9-р зэргийн жинхэнэ албан хаагчийн шалгалтад тэнцсэн байх ёстой байдаг байна

Мөн анх аврагч, гал сөнөөгч албан тушаалд томилогдсон алба хаагч эхний 6-8 сар тухайн мэргэжлээр 10 дээш жил ажилласан албан хаагчийн удирдлагын доор зөвхөн дадлагажигчаар ажиллуулдаг ба үндсэн цалингийн 80 хувьтай тэнцэх хэмжээний цалин авдаг байна. Энэ нь илүү дадлага туршлагатай болгох зорилготой юм. Өөрөөр хэлбэл хүний амь насыг аврах, гал, устай тэмцэх амаргүй ажлыг өндөр хариуцлагын дор гүйцэтгэх ёстойг энд харуулж байна.

Аврагч, гал сөнөөгч нар анх томилогдсон албан тушаалдаа 1 жил ажилласны дараа албан тушаал ахих, өөр орон нутаг руу шилжих боломжтой болдог байна. Ингэхдээ албан тушаал ахихын тулд тухайн албан тушаалын зэрэглэлийн дагуу тогтоосон тусгай шалгалт байдаг ба тус шалгалтад заавал тэнцсэн байх шаардлага тавьдаг. Тус шалгалт нь онолын, ур чадварын гэсэн 2 үе шаттай явагддаг байна. Эндээс үзвэл, аврагч, гал сөнөөгч нар нь нэг албан тушаалдаа байнга ажиллах бус мэдлэгтэй, ур чадвартай бол албан тушаал дэвших бүрэн боломжтой нь харагдаж байна.

Мөн бүсүүдэд албан хаагч нарын мэргэжил дээшлүүлэх төв гэж байдаг ба тус төвд тусгай хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж дипломын мэргэжилтэй албан хаагч бакалаврын зэрэгтэй болж болдог.

БНСУ-д аврагчдад мэргэжлийн зэрэг олгодог ба 1, 2, 3 гэсэн мэргэшлийн зэргээс шалтгаалж цалингийн нэмэгдэл авдаг байна. Тухайлбал БНСУ-ын ерөнхийлөгчийн баталсан хэд хэдэн түвшний сургалтын гэрчилгээ /сертификат/ байдаг байна. Үүнд:

- Эмнэлгийн анхны тусламжийн 1, 2 дугаар зэрэг
- Галын аюулгүй байдал хариуцагч 1, 2, 3 дугаар зэрэг
- Галын тоног төхөөрөмжийн инженерийн 1, 2 дугаар зэрэг /Fire Mechanical Professional Engineers/
- Галын дохиоллын инженерийн 1, 2 дугаар зэрэг /Fire Mechanical Professional Engineers/
- Барилгын галын аюулгүй байдлын инженерийн 1, 2 дугаар зэрэг/ Fire Mechanical Professional Engineers//

Дээрх гэрчилгээг албан хаагч нар өөрсдөө бэлдэж онолын мэдлэг, биеэр хийж гүйцэтгэх /ур чадвар/ гэсэн 2 төрлөөр өгч тэнцсэн тохиолдолд гэрчилгээ авдаг ба тэнцсэн албан хаагч нар цалингийн нэмэгдэл авах, тэтгэвэрт гарсны дараа бусад аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах бүрэн боломжтой болдог байна. Энэ нь өөрийн мэргэжлийн мэдлэг чадвараа нэмэгдүүлэх бас нэг боломж болж байгаа юм.

Аврагч нар 15 удаа өдрийн ээлж, 15 удаа шөнийн ээлж гэсэн тогтолцоогоор ажилладаг ба 7 хоногт 2 удаа онолын хичээлд 2 удаа дадлагын хичээлд заавал хамрагддаг байна. Мөн тус улсын их дээд сургуулиудад хүлээн зөвшөөрөгдсөн сургалтын хөтөлбөрийн дагуу аврагч нар жилд 5-12 кредитийн хичээл судалдаг төлөвлөгөөтэй байдаг бол тухайн аврагч 40 кредит судалсан тохиолдолд мэргэжлийн дагуу их дээд сургуулиудын 3 дугаар курсээс үргэлжлүүлэн суралцах боломжтой болдог байна.

б) АНУ-ын аврагч нарын сургалт

(Кансас мужын их сургуулийн гал сөнөөгч болон аврагчийн сургалтын жишээн дээр)

АНУ Кансас мужын гал сөнөөх анхан шатны сургалт[9]

Институтын гал сөнөөх сургалт нь үндсэн гал сөнөөгчийн сургалтын хөтөлбөрөөс гадна галын багаж хэрэгслийн ашиглалт, хэрэглээ болон жолооч, оператор зэрэг түвшний өргөн хүрээг хамардаг. Гал сөнөөгчийн 1 болон 2 дугаар түвшний сургалтын сэдвүүдийн зорилго нь Гал сөнөөгчийн үндсэн сургалтуудаас гадна гал унтраах ангийн хэрэгцээ шаардлагаас үүдэн агаарын тээврийн ослын үед аврах гал сөнөөх, ус шахагч төхөөрөмжтэй ажиллах, бусад багаж тоног төхөөрөмжтэй ажиллах түүнчлэн операторын, жолоочийн гэсэн сургалтуудад чиглэнэ. Хөтөлбөрийн энэ түвшин нь аврагч, гал сөнөөгчийн үйл ажиллагааны бүхий л үе шатыг агуулсан байдаг. Үүнд:

•Гал сөнөөгчийн үндсэн сургалт

•Эрэн хайх болон аврах ажиллагааны үндсэн техник

•Жолооч/оператор: Агаарын тээврийн аврах ажиллагаа

•Жолооч/оператор: Агаарын тээврийн аврах болон гал сөнөөх ажиллагаа

•Жолооч/оператор: Ус шахагч төхөөрөмж

•Жолооч/оператор: ус шахагч/агаарын тээврийн

•Онцгой байдлын үе дэх түргэн тусламжийн жолооч бэлтгэх сургалтын хөтөлбөр

•Этанол: хариу арга хэмжээ авах

•Гал сөнөөгч I

•Гал сөнөөгч II

•Гал сөнөөгчийн ур чадварын сургалт

•Онцгой байдлын үед пропаныг тээвэрлэх-сургалтын танхим, лабораторид

•Аюултай хэрэглэгдэхүүнүүдийн тухай ойлголт

•Аюултай материалуудын ашиглалт

Галын зааварлагчийн сургалт болон хөгжил

Гал түймэртэй тэмцэх газрын ажилтнуудад үндэсний гал түймэртэй тэмцэх байгууллагын гэрчилгээ авахын тулд галын зааварлагч болон гал сөнөөгч гэсэн ангиудад элсэлт авч сургалт явуулдаг байна.

Мэргэжлийн ур чадвар өндөртэй галын зааварлагч, үндэсний галын аюулгүй байдлын ассоциацийн 1041 стандартын дагуу хөтөлбөр боловсруулж сургалт зохион байгуулна. Энэ сургалтын хөтөлбөр нь галын зааварлагч, гал сөнөөгчийг хувь хүний хөгжил болон мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэхэд түлхэц болдог байна.

Сургалтын 2-р хэсэг нь семинар, дадлага бөгөөд 16 орчим цаг үргэлжилнэ, семинарыг нүүр тулсан ярилцлага маягаар явуулах ба суралцагчдыг бодит байдалтай танилцуулахад илүү анхаарч дадлагаар онолыг бататгадаг байна.

Семинар: Энэ семинарыг АНУ-ын олонхи мужуудад гал сөнөөгч болон галын зааварлагч бэлтгэх сургалтын хөтөлбөртөө тусгасан байдаг. Гал сөнөөгч болон аврагчийн институт нь энэхүү сургалтыг явуулахад шаардагдах бүхий л багаж тоног

[9] Burmaa N 2016 conference bookiet 8 shajing the future- organizational development in public administration

төхөөрөмжөөр хангасан төдийгүй багш боловсон хүчний асуудлыг ч мөн шийджээ. Галын зааварлагч гэсэн статус нь зааварлагч багшийн өөрийн мэргэжлийн ур чадвартай нягт уялдаа холбоотой байдаг ба мөн түүнчлэн цагийн багш нь институтын бусад багш нартай ижил эрхтэй, адил үүрэг хүлээдэг. Институтээс гаргасан журамд дээрх галын зааварлагчийн гэсэн статус маш чухал ач холбогдолтой.

Гал сөнөөгчийн сургалт семинар

Энэ хөтөлбөрийн хамгийн чухал гол анхаарах сэдэв бол жил тутамд явагддаг галын сургуулиас зохион байгуулдаг семинар юм. Кансас даяар бүс нутгийн семинарт нэг өдрийг зориулан галын аюулгүй байдал түүнээс сэргийлэх болон хор уршгийн талаар сургалт зохион байгуулдаг. Илтгэгчид нь үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн илтгэгчид байдаг бөгөөд өөрсдийн илтгэлээ семинар хэлбэрээр хүргэдэг. Энэ нь маш их үр өгөөжтэй семинар болдог бөгөөд жилд 500 орчим аврагч, гал сөнөөгчид тус сургалтанд хамрагддаг. Энэхүү 1 удаагийн хөтөлбөрт сонсогчид давамгайлан оролцдог ба аврах гал унтраах ангиудаар дамжуулан сургалт дадлага хослуулан явуулдаг. Кансас мужийн институт нь тус сургалтандаа маш олон тооны гал сөнөөгч, аврах албаны байгууллагуудтай хамтран ажилладаг.

Аврагчдын техникийн сургалт

Аврагчийн техникийн хөтөлбөрт мэргэжлийн ур чадвар нь MEPA 1006 (National Fire Protection Association) стандартаар баталгаажсан байна. Энэ хөтөлбөрт олс ашиглан аврах аврагч, хязгаарлагдмал орон зайн ажиллагааны аврагч, тээврийн хэрэгсэл болон машинаас хүн татаж гаргах ажиллагааны аврагч, барилгын осол аваараас аврах ажиллагааны аврагч, усны гүнээс аврах ажиллагааны аврагч, гадаргын усны үерээс аврах аврагч зэрэг сэдвүүд байна. Эдгээр аврагчдын төрөл нь стандарт төрлүүдэд багтдаг бөгөөд шумбагч аврагч, далайн гүний ослоос аврах аврагч зэрэг олон төрөл байдаг ба мөн хязгаарлагдмал цөөн тооны мөсний аврагчид байна. Гэсэн хэдий боловч стандартад багтдаггүй аврагчийн төрөл байна энэ төрлүүд мөн аврагчийн сургалтын хөтөлбөрт ч багтдаггүй жишээ нь: тариалангийн талбайг хамгаалах, ан агнуураас зэрлэг болон ховордсон ан амьтдыг аврах. Бусад төрлийн аврагчид хөтөлбөрийн хүрээнд аврагчийн техникийн сургалтын хөтөлбөрт хамрагдана. Энэ хөтөлбөрт:

- 1 ба 2-р шатны - Хязгаарлагдмал орон зайд аврах ажиллагаа явуулах сургалт
- Агнуурын амьтад болон тариалангийн талбай устгагдахаас хамгаалах аврах ажиллагааны сургалт
- Аврах ажиллагаа явуулах техник хэрэгсэл
- Кансас мужид болж болзошгүй усны үерээс аврах ажиллагааны бэлтгэл 1
- Аврах систем 1
- Аврах систем 2
- Олс ашиглан аврах үйл ажиллагаа
- Олс ашиглан аврах үйл ажиллагааны үндсэн зарчим, техник
- Барилгын нурангиас аврах үйл ажиллагаа
- Барилгын нурангиас аврах үйл ажиллагааны техник
- Суваг шуудуунаас аврах -үйл ажиллагаа
- Тээврийн хэрэгслийг осол аваараас аврах ажиллагаа

Олс ашиглан аврах ажиллагааны техник 5 хоног 40 цагийн сургалт анхан шат болон гүнзгийрүүлсэн өндөр түвшний техникийн хөтөлбөрүүд үргэлжилнэ. Хязгаарлагдмал орон зайд аврах ажиллагааг гүйцэтгэх, үйлдвэрлэлийн ослын аврах ажиллагаа, уулархаг газар гарсан осол, гамшгаас аврах ажиллагаа явуулах ур чадварууд хамаарагдана. 1982 онд Олс ашиглан аврах ажиллагааг анхлан ашиглаж ирсэн бөгөөд энэхүү сургалтаараа хэрхэн олс ашиглан осол аваар болох үеэр аврах ажиллагааг амжилттай явуулах талаар мөн техник хэрэгслийн ашиглалт, хэрэглээ, хадгалалтын талаар судална. Мэргэжлийн аврагчийн сургалт туршлага он жил өнгөрөх тусам сургалтын чанар сайжирч, сургуулиуд улсын төсвөөс өгөх хөрөнгө мөнгө санхүүжилт өссөөр байна.

Ур чадварын сургалт

Тоног төхөөрөмжийн сонголт, хяналт шалгалт болон засвар үйлчилгээ, анхны тусламжийн хайрцаг ашиглалт, механик системийн давуу тал, хамгаалалт, системийг бууруулах, олсоор буух, системийг нэмэгдүүлэх, дамжин өнгөрөх зангилаа, Системийн аюулгүй байдлын хүчин зүйлс, хог хаягдал тоос шороог цэвэрлэх, таслан авах, дамнуурга ашиглан нүүлгэн шилжүүлэх. Бодит байдал дээрх аврах ажиллагааг сургалтын аврах ажиллагааны хувилбарт заасан байдаг. Олон төрлийн сургалтын технологиудыг мэргэжлийн аврах, гал сөнөөх үйл ажиллагаатай уялдуулан эзэмшүүлдэг байна.

Сургалтын төлбөр

Бүртгүүлээд 45 хоногийн дотор төлбөрөө төлбөл 1075$, бүртгүүлээд 45 хоногтоо багтаж төлбөрөө төлөөгүй нөхцөлд 1125$ байна.

Оюутан сонсогчийн дээд талын хязгаар 16 хүнтэй хичээллэдэг байна.

Хосолсон ур чадвар

Олс ашиглан аврах техникч 1/2 ангийн аврах сургалтын зарчим, аврах олсны техник, галаас аврах, цамхагт ажиллаж байгаа хүмүүсийг олс хэрэглэж ур чадвараа ашиглан аврах бүрдэл бүхий техник, хязгаарлагдмал орчинд аврах ажиллагаа, эрэн хайх, аврах үйл ажиллагаа (USAR), уулархаг газарт гарсан ослоос аврах ажиллагаа, хот суурин газарт эрэн хайх, аврах үйл ажиллагаа явуулах (USAR), нисдэг тэрэг агаарын тээврийг ашиглан эрэн хайх аврах үйл ажиллагаа, завь ашиглан аврах ажиллагаа гүйцэтгэх, тактикийн маневр, аж үйлдвэрийн ослоос аврах.

Техникчийн түвшний 24 цагийн эрчимт онол практик хослуулсан сургалт аврагчийн гамшиг ослын үед нүүлгэн шилжүүлэлт хийх ур чадвар NEPA 1006 стандартын дагуу. Практикт яаралтай түргэн тусламжийг цаг алдалгүй мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэх.

Аврагчийн үйл ажиллагааны үндсэн гол зүйл бол аврагчийн аврах тоног төхөөрөмж юм. Эдгээр төхөөрөмжүүдийн хэрэглээ, ашиглалт техникийн үнэлгээ бүрэн бүтэн байдлыг онол болон практикийн түвшинд судлах нь хамгийн чухал ач холбогдолтой байна.

1980-иад оны эхээр аврах анги, нэгтгэлийн сургалт тэдгээрийн хичээлийн хөтөлбөр анх үүсэн бий болжээ. Он жил өнгөрөх тусам аврах ажиллагаа, аврагчийн нарийн мэргэжил өргөжин тэлснээр барилга байгууламжийн, хүнд даацийн авто тээврийн болон уул уурхай, түүнчлэн өндөр технологийн гэзэг олон салбарт гарч болзошгүй аюул ослоос урьдчилан

сэргийлэх болоод таслан зогсоох аврах үйл ажиллагааг зохион байгуулах шаардлага урган гарсан.

Тэдний гол зорилго бол эрэн хайх аврах ажиллагааг яаралтай түргэн шуурхай хийж гүйцэтгэх.

Зааварлагчийн удирдсан практик сургалтыг хийж гүйцэтгэх тусам ур чадвар сайжирдаг байна.

Аюулгүй байдлыг хангах сургалтыг аврагчид илүү үр дүнтэй болгохын тулд мөн ажиллагааны ур чадвараа нэмэгдүүлэхэд сургалтын талбайд олон цагаар бэлтгэл сургуулилт хийх шаардлагатай. Бодит байдалд илүү ойр байхын тулд тухайн орчин нөхцөлийг амьд мэт бүрдүүлж өгөх нь суралцагчийн сэтгэл зүйд ч мөн эерэгээр нөлөөлж сургалтын чанарыг сайжруулна.

Тусламж үзүүлэх аврагчийн сургалтын курс

Сүүлийн жилүүдэд дэлхийн дулааралтай холбоотойгоор маш олон тооны осол байгалын гамшиг тохиолдог болж байгаа. Үүнтэй холбоотойгоор аврагч тэр дундаа шумбагч, завьтай аврагч гээд олон төрлийн шинэ сургалтын системүүд шинээр бий болсон байна.

Дүгнэлт

Олон улсын аврагч, гал сөнөөгч нар нь мэргэжлийн дагуу дипломын буюу түүнээс дээш боловсролтой байдаг байна. Энэ нь аврагч, гал сөнөөгч нарын мэдлэг, боловсролын түвшинг харуулж байгаа ба нөгөө талаасаа гамшиг ослын үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагааг илүү үр дүнтэй гүйцэтгэх баталгаа болж байгаа юм.

Байгууллагад ажиллаж буй хүмүүсийн ажлын гүйцэтгэлээс байгууллагын ажлын эцсийн үр дүн хамаардаг. Өндөр хурдацтай өөрчлөгдөж байгаа шинжлэх ухаан, техник, технологийн хөгжил дэвшил, өөрчлөлт зэрэгт зохицон ажиллахын тулд байгууллага ажиллагсдынхаа мэдлэг, чадвар, чадамжийг байнга тасралтгүй дээшлүүлж байх хэрэгцээ шаардлага урган гарч ирж байна.

Тиймээс байгууллагын шаардлагад нийцсэн боловсон хүчинтэй байх, тэрхүү боловсон хүчнийхээ мэдлэг мэргэжил, ур чадварыг нэмэгдүүлэх талаар системтэй үйл ажиллагаа явуулах зайлшгүй шаардлага бий болж байгаа билээ.

Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын сургалт явуулах эрх зүйн орчин, Аврах анги салбарт явагдаж буй сургалт, бэлтгэл, мэргэжлийн аврагч нарыг бэлтгэх, тэднийг давтан сургах, мэргэшүүлэх үйл ажиллагааны тогтолцоо, сургалтын агуулга, сургалт, дадлагын төвийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

1. Burmaa N (2016) conference bookiet 8 shajing the future- organizational development in public administration.
2. М.Тэгшжаргал. Боловсрол судлал. УБ, 2010 он
3. О.Үржин Гамшгийн удирдлагын өөрчлөлт, шинэчлэл. Үндэсний бага хурал. УБ. 2001 он
4. Я.Цэвэл. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, УБ. 2013 он
5. ОБЕГ,2012
6. С.Нарангэрэл “Монголын эрх зүйн англи, орос, латин хадмал эх толь бичиг", УБ. 2015 он
7. ОБЕГ-ын даргын 2019 оны А/239 тушаал
8. Fire-related laws of Korea 2016.
9. “Эрэн хайх аврах ажиллагаа ОББС 0001:2018” стандарт

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАХ НЬ

COOPERATING DISASTER RISK REDUCTION ACTIVITIES WITH DEVELOPMENT POLICY

Г.Гаваадамба
Дотоод хэргийн их сургуулийн магистрант ахмад
Gavaadamba.G
University of internal affairs master captain

Хураангуй: Аливаа үйл ажиллагааг хийх, төлөвлөхдөө түүний хамаарлыг нарийн нягт судлах явдал нь нийгмийн болоод арга зүйн шаардлагын хувьд үр дүнтэй сонгомол арга байдаг. Сүүлийн 30-аад жилийн байдлаас үзэхэд дэлхийн дулаарал, нийгмийн чөлөөт харилцааны нөлөөгөөр манай улс оронд байгаль, цаг уурын өөрчлөлт, нийгмийн төрөл бүрийн халдварт өвчин, газар хөдлөлт гэх мэт гамшиг тохиолдож байна. Монгол Улсад 10 гаруй аюулт үзэгдэл тохиолдож байна.

Abstract: Careful study of the relevance of any activity is an effective alternative approach to social and methodological requirements. In the last 30 years, due to global warming and free social relations, our country has been experiencing disasters such as natural and climate change, various social infectious diseases, and earthquakes. There are more than 10 disasters in Mongolia.

Түлхүүр үгс: Гамшиг, гамшгаас хамгаалах, гамшгийн эрсдэл, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хөгжлийн бодлоготой уялдуулах, хөгжлийн бодлого

Key words: Disaster, disaster protection, risk of disaster, reduction of disaster risk, coordinate disaster risk reduction activities with development policies, development policy

Удиртгал: Монгол оронд 1990-ээд оны дунд үеэс хойш ган, зудыг тооцохгүйгээр ус, цаг агаарын түр зуурын гамшигт үзэгдлийн улмаас учирдаг хохирлын хэмжээ жил бүр 10-12 тэрбум төгрөгт хүрэх болсон.[1] Мөн сүүлийн 20 жилд тохиолдсон байгалийн нийт аюулт үзэгдлийн 60 хувийг цаг агаарын гаралтай, 32 хувийг биологийн гаралтай, 7 хувийг геологийн гаралтай аюул эзэлдэг байна.[2]

Байгалийн аюулт үзэгдлийн нөхцөл байдал нь гамшгийн менежментийг сайжруулах, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд нэн чухал ач холбогдол өгөх ёстойг харуулж байна. Мөн гамшиг нь хөгжлийг сааруулдаг болох нь түүхийн явцад нотлогдсон байдаг. Иймээс хөгжлийн бодлогыг тухайн орон нутгийн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, төлөвлөлттэй холбон шинжлэх ухааны байдлаар хандахыг шаардах болсон.

Уур амьсгалын өөрчлөлт, техник технологийн хувьсал, хүний хүчин зүйл, үйлдлээс үйлдэлтэй өнөөдөр тохиолдож буй аюулт үзэгдэл, ослын төлөв байдал нь улс орны нийгэм, эдийн засаг болон тогтвортой хөгжил,

[1] Н.Нямхорлоо " Монгол оронд тохиолдсон байгалийн аюулт үзэгдэл, түүний эрсдлийг бууруулах нь". Хууль сахиулах салбарын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам" сэдэвт илтгэлийн эмхэтгэл. 2014 он

[2] Гамшиг судлалын хүрээлэн. 2000-2014 оны судалгааны тайлан.

цаашлаад Үндэсний Аюулгүй Байдалд сөргөөр нөлөөлөх, түүнээс урьдчилан сэргийлэх, аюулыг бууруулах зохицуулалт, менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь төр засгийн бодлого, үйл ажиллагааны хүрээнд явагддаг хөгжил дэвшлийн үзүүлэлтэд нэн тэргүүний асуудал болоод зогсохгүй гамшгийн эрсдэлийн бууруулах менежментийн бодлогыг дэлхий нийтээрээ авч үзэх болсон.

Үндсэн хэсэг: Дэлхий дээр тохиолддог байгалийн 30 гаруй аюулт үзэгдлээс манай оронд ган, зуд, цасан болон шороон шуурга, хуй салхи, цөлжилт, аянга, аадар бороо, үер, хүн малын Олон Улсын хөл хориот гоц халдварт өвчний тархалт зэрэг байгалийн гаралтай 10 гаруй аюулт үзэгдэл, ой хээрийн түймэр, нисэх онгоцны сүйрэл, гол нуурын мөсний цөмрөлт, уурхайн дэлбэрэлт, гүнийн нуралт, химийн хорт бодисын хордуулалт, объектын гал түймэр болон авто тээврийн холбогдолтой осол, зэрэг хүний буруутай үйл ажиллагаа, техникийн холбогдолтой осол гарч, хүний амь нас, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин сүйрч, нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол учирч байна.

Мөн сүүлийн 2 жилд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тархалт Монгол Улсын нийгэм эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, амь насанд ихээхэн хохирол учруулж байна.

2000 оноос өмнө байгалийн гамшгийн аюулыг бууруулах үйл ажиллагаа нь гамшгийн үр дагаврыг арилгах, нэрвэгдэгсдэд тусламж үзүүлэх, аврах ажиллагааг зохион байгуулах гэх мэт гамшгийн хойноос нь хийх ажилд чиглэж байв. Гэвч байгалийн гамшгийн давтамж, гамшгаас учрах хохирол улам бүр өсөн нэмэгдэж байгаа нь энэ арга нь үр дүн муутай гэдгийг нэгэнт харуулсан учраас байгалийн гамшгийн аюулыг бууруулах илүү үр дүнтэй шинэ үзэл баримтлал авч хэрэгжүүлэх нь юу юунаас чухал болж ирсэн.

Ийм учир болж буй гамшгийн аюулыг өнгөрсний дараа биш түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ гэдэг нийгмийн өмнө чухлаар тавигдах болж холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхэлсний нэг хэсэг нь гамшгийн эрсдэлийг бууруулах менежментийн бодлого байлаа.

Гамшгийн менежмент гэж нэн тэргүүнд эрсдэл ихтэй хүн амын эмзэг байдлыг бууруулах болон гамшиг тохиолдсон үед түүний хор уршгийг арилгах арга хэмжээг аль болохоор үр дүнтэй болгох зорилготой өргөн хүрээтэй, хөгжлийн хандлага багц үйл ажиллагаа[3] юм гэж тодорхойлсноос үзэхэд гамшгийн эрсдэлийг бууруулах менежментийн зорилго нь:

Хүн амын эмзэг байдлаас үүссэн гамшгийн бодит хохирлыг бууруулах, арилгах

Гамшигт нэрвэгдсэн хүн амд яаралтай тусламж үзүүлэх

Урьд өмнө байсан эрсдэлээс бага эрсдэлтэй болгохын тулд үр дүнтэй, урт хугацааны сэргээн босгох арга хэмжээг авахад оршино.

Өргөн утгаар нь авч үзвэл гамшгийн эрсдэлийг бууруулахын үндсэн зорилго нь боломжтой тохиолдолд гамшгийн аюул үүсэхээс сэргийлэх, эсвэл нийгмийн эмзэг байдлыг[4] бууруулах замаар хохирлын

[3] П.Дамдин "Гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент", 2005 он, 30 дах тал

[4] Эмзэг байдал-"Олон нийтийн аюулын нөлөөнд өртөх байдлыг ихэсгэх биет, нийгэм-эдийн засгийн, хүрээлэн буй орчны хүчин зүйлүүдээр

хэмжээг багасгаж тогтвортой хөгжлийн нөхцөлийг бүрдүүлэх юм. Энэ үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийн үнэлгээ хийх, нийгмийн эмзэг байдлыг бууруулах болзошгүй аюулын[5] сөрөг нөлөөллөөс зайлс хийх арга хэмжээ хамаардаг.[6]

Гамшгийн эрсдэлийг бууруулах[7] нь гамшиг үүсэх онц аюултай объектууд, экологи, байгалийн аюултай үзэгдлүүдийг ажиглах, хүрээлэн буй орчны төлөвт мониторинг үнэлгээ хийх, хууль, эрх зүй, зохион байгуулалт, эдийн засаг, инженер техник, экологийн хамгаалалт, эрүүл ахуй, хорио цээрийн арга хэмжээнүүдийг тусгасан цогц бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас тогтдог. Үндсэн зорилго нь боломжтой тохиолдолд аюулт үзэгдэл үүсэхээс сэргийлэх, эсвэл нийгмийн эмзэг байдлыг бууруулах замаар хохирлын хэмжээг багасгаж тогтвортой хөгжлийн нөхцөлийг бүрдүүлэхэд хөгжлийн бодлоготой уялдуулан хийх нь хэтийн аюулыг багасгах чухал ач холбогдолтой.

Хөгжлийн бодлого гэдэг нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх урт ба дунд хугацааны бодлогын баримт бичиг юм. Бодлогын зорилго нь шударга ёс, сахилга хариуцлагатай, тогтвортой төрийн тогтолцоог бэхжүүлж, үндэсний хөгжлийн нэгдсэн бодлогоор эдийн засгийн өрсөлдөх чадвараа дээшлүүлж, иргэдийнхээ амьдралын түвшинг сайжруулах, тэдгээрийн аюулгүй байдлыг шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүйгээр хангахад оршино.

Гамшгийн эрсдэлийг бууруулахыг хөгжлийн төлөвлөлтөд уялдуулан тусгах нь:

Үндэсний болон салбарын хөгжлийн бүх төсөл, хөтөлбөрүүд болзошгүй гамшиг, уур амьсгалын эрсдэлийг тооцсон, нөлөөллийг нь даван туулах чадвартай байх явдлыг баталгаажуулах;

Үндэсний болон салбарын хөгжлийн бүх төсөл, хөтөлбөрүүд санаандгүй байдлаар бүх салбар (эдийн засаг, нийгэм, биет бүтээн байгуулалт болон байгаль орчны) уур амьсгал, гамшгийн эрсдэлд өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлэхгүй байх явдлыг баталгаажуулах;

Үндэсний болон салбарын хөгжлийн бүх төсөл, хөтөлбөрүүд хөгжлийн зорилгод хувь нэмэр оруулж, болзошгүй гамшиг, уур амьсгалын эрсдэлийг бууруулах явдлыг баталгаажуулах зэрэг бодлогоор төлөвлөгдөж хэрэгжиж байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хөгжлийн бодлоготой уялдуулан хийх төлөвлөлтийн асуудал хариуцсан албан хаагчид нь хөгжлийн бодлого, төлөвлөлт болон хууль, эрх зүйн орчны талаар өндөр мэдлэг,

---

эсвэл үйл ажиллагаагаар тодорхойлогдох нөхцөл байдал” гэж тодорхойлсон байдаг.

[5] Аюул гэж “Хүн амын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулах, нийгэм-эдийн засгийн үйл ажиллагааг тасалдуулах эсвэл хүрээлэн буй орчинг доройтуулах ноцтой үйл явдал, үзэгдэл эсвэл хүний үйл ажиллагаа юм. Аюулд ирээдүйд гамшиг учруулах нуугдмал нөхцөл байдал хамрагдаж болох бөгөөд янз бүрийн гаралтай: байгалийн (геологийн, ус, цаг уурын, биологийн) эсвэл хүний үйл ажиллагаанаас үүссэн (хүрээлэн буй орчны доройтол, технологийн аюул) байж болно.” гэж Хёогогийн үйл ажиллагааны хүрээнд тодорхойлогдсон.

[6] Д.Сэржмядаг “Гамшгаас хамгаалах менежментийн үндэс, Уб, 2017 он, 96 дахь тал

[7] Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа - гамшгийн эрсдэлийг үнэлэх, болзошгүй хохиролын хэмжээг багасгах, гамшгийг хохирол багатай даван туулах чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ” гэж “Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д тодорхойлсон байна.

туршлагатай байхын зэрэгцээ бодлого боловсруулах явцад дараах үндсэн 6 асуудлыг заавал авч үзэх шаардлагатай. Үүнд:

1.Улс орны хууль, эрх зүйд нийцсэн байх

2.Байгаль орчны бохирдол, доройтлыг бууруулах

3.Байгалийн баялгийн хомсдлыг бууруулах

4.Жендэрийн тэгш байдлыг хангах

5.Орлогыг шударга хуваарилах, ядуурлыг бууруулах

6.Бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хамгийн зөв сайн уялдуулан хийхэд дараах шалгууруудыг заавал авч үзэх хэрэгтэй.[8] Үүнд :

Ирээдүйд чиглэсэн байх

Гадаад орчинтой уялдсан байх

Шинийг эрэлхийлсэн, уян хатан бүтээлч байх

Нотолгоонд тулгуурлах

Тэгш хүртээмжтэй байх

Хамтарсан байх

Сургамжаас суралцсан байх

Харилцаа олон нийтэд бодлогыг хэрхэн хүргэх асуудлыг авч үзэх

Үнэлгээ хийх

Хяналт тавих

Дүгнэлт: Монгол Улс хөгжлийн бодлогын хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах бүх нийтийн ойлголтыг гүнзгийрүүлэх, мэдлэг олгох, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны удирдлагын засаглалыг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах, гамшгийн дараах сэргээн босгох, нөхөн сэргээх, шинээр барьж байгуулах үйл ажиллагааг урт хугацаанд төлөвлөн хэрэгжүүлэх хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж байгаа хэдий ч гарах үр нөлөөний хувьд хангалтгүй байна.

Conclusion: Deepen the community disaster risk reduction within the framework of Mongolia's development policy, impart knowledge, strengthen governance in disaster risk reduction activities, increase investment in disaster risk reduction activities, to ensure disaster preparedness, post-disaster recovery, rehabilitation, although a long-term development policy for new construction is being implemented, its impact is insufficient.

Санал: Гамшгийн эрсдэлийг удирдах тогтолцоог бодлогоор бэхжүүлэх

Удирдах тогтолцоог чадваржуулах үйл ажиллагааг Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлоготой уялдуулах

Гамшгийн эрсдэлийг бууруулах стратеги бодлого боловсруулах үйл ажиллагаандаа хөгжингүй орнуудын туршлага, арга барилыг Монгол Улсын онцлогт нийцүүлэн тусгах.

New idea: Strengthen the disaster risk management system through policy

Coordinate management capacity building with Mongolia's long-term development policy

Incorporate the experience and approaches of developed countries in the development of strategic risk reduction policies in accordance with the specifics of Mongolia.

Ашигласан материал

[8] Эх сурвалж: http://managementstudyguide.com

1. Гамшгаас хамгаалах тухай хууль
2. Д.Сэржмядаг “Гамшгаас хамгаалах менежментийн үндэс. УБ. 2017 он.
3. П.Дамдин “Гамшгийн эрсдэлийг бууруулах менежмент”. 2005 он.
4. Хууль сахиулах салбарын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт илтгэлийн эмхтгэл. 2014 он
5. Гамшиг судлал хүрээлэнгийн 2000-2014 оны тайлан
6. Sources
7. Law on Disaster Protection
8. D.Serjmyadag “Fundamentals of Disaster Management. UB. 2017.
9. P.Damdin “Disaster risk reduction management”. 2005
10. Compilation of reports on “Law Enforcement Challenges and Solutions”. 2014
11. Report of the Institute of Disaster Management for 2000-2014

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ГАЛ ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ЗАМ

THE WAYS FOR REDUCING THE RISK OF FIRE PERCHANCE IN CONSTRUCTION SECTOR

Э.Уганбаяр
ДХИС-ийн Удирдлагын академийн Онцгой байдлын удирдлага, стратегийн профессорын багийн дэд профессор, хошууч
Uuganbayar E
Assiociate professor at team of Emergency Management and strategy of Executive Leadership Academy at University of Internal Affairs, Mongolia.
Э.Энхбаяр
ДХИС-ийн Ахлагчийн сургуулийн Онцгой байдлын албаны тэнхимийн багш, хошууч
Enkhbayar E
Lecturer at department of Emergency Management of Non-comissioned Officer's School at University of Internal Affairs, Mongolia

Хураангуй: Монгол улсын хэмжээнд сүүлийн 5 жилд гарсан гал түймрийн статистик тоо баримт дээр үндэслэн гал түймрийн эрсдэлийн тооцоолол гаргаж, гал түймрийн шалтгаан нөхцөл, учруулах хор уршиг, хохирлын тоо хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. Иймд тухайн гарсан гал түймрийн тоо хэмжээ, хохирлын аюулыг бууруулах арга хэмжээг төлөвлөхөд оршино.

Abstract: There are increasing year by year the numbers of damage of amount, the causes of fires, the fire risk estimates on the based on the fire statistics of last five years in Mongolia. Thus, its to planning the ways for reducing damages of the number of the fire on time. We are studied about situation, cause and risk on construction sectors' fire.

Түлхүүр үг: Хүн амын статистик судалгаа, гал түймрийн статистик тоо баримт, гал түймрийн аюул болон эрсдэлийн түвшин, галын автомат дохиоллын систем, галын аюулгүй байдал

Keywords: Democraphic of statistic, fire, fire statistic, level of risk, system of the fire signal

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэж заасан байдаг.

Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд заналхийлж буй хамгийн том аюул нь байгалийн гамшиг болон хүмүүсийн буруутай үйл ажиллагаанаас гаралтай осол, гал түймэр болж байдаг. Судалгаагаар Улаанбаатар хотын хэмжээнд жилд дунджаар 1894 объектын гал түймэр бүртгэгдэж, гал түймрийн улмаас жилд дунджаар 55 хүн амь насаа алдаж, гал түймрийн улмаас жилд дунджаар 12.1 тэрбум төгрөгийн хохирол учирсан. Нийт гал түймрийн 45.1% нь гэр орон сууц, барилга байгууламжид гал түймэр гарсан байна.

Гал түймэр үүсэж тархан дэлгэрэх нь онолын хувьд шатах материал, хүчилтөрөгчийн орчин, галын эх үүсвэрээс шалтгаалдаг.

Амьдрал дээр эдгээр хүчин зүйлс нь хүн амын суурьшилт, тэдгээрийн үйлдэл, хотжилт, барилгын материал, газрын тосны салбарын объектууд болдог. Эдгээр хүчин зүйлсийн хоорондын харилцан хамаарлаас

шалтгаалан гал түймэр үүсэж тархан дэлгэрч хүн ам, мал амьтан, эд материалд ноцтой хохирлыг учруулдаг.

Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд сүүлийн 5 жилд гарсан гал түймрийн статистик тоо баримт Зураг.1, гал түймрийн улмаас амь насаа алдсан иргэдийн тоо Зураг.2, гал түймрийн улмаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирол Зураг.3-т тус тус харууллаа.



Зураг.1 Улаанбаатар хотын гал түймрийн тоо

Зураг.2. Гал түймрийн улмаас амь насаа алдсан иргэд

Зураг. 3. Гал түймрийн улмаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирол

Улаанбаатар хотод хүн ам ихээр төвлөрч гэр хороолол өргөжин тэлж байгаа нь гал түймрийн эрсдэлийг нэмэгдүүлсээр байна.

Манай улсын нийт хүн амын 67.2 хувь нь хот, суурин газар үүнээс 47.1 хувь буюу 2 хүн тутмын нэг нь нийслэл Улаанбаатар хотод амьдардаг. Тэр дундаа нийслэл хотын нийт хүн амын 95.1 хувь буюу 1,56 сая хүн төвийн 6 дүүрэгт амьдарч байна.

Монгол Улсын Үндэсний статистикийн хорооноос 10 жил тутамд зохион байгуулдаг. 2020 оны хүн ам, орон сууцны тооллогоор /ХАОСТ/ Улаанбаатар хотод амьдардаг хүн амын өрхийн тоог сууцны төрлөөр нь ангилсан ангиллыг Зураг.4. үзэж болно. Доорх судалгаанаас харахад Улаанбаатар хотын нийт 414292 өрхийн 1499140 хүн амыг орон сууцны болон сууцны тусдаа байшин, гэрт амьдардаг өрхийн судалгаагаар гэр хороололд нийт 208049 өрхийн 50,2 хувь буюу, хүн

амын 751157 буюу 50,1 хувь нь хувийн байшин болон монгол гэрт амьдарч байна.

Харин *байшин хороололд* 206243 өрх буюу 49,8 хувь, хүн амын 747983 хүн ам буюу 49,9 хувь нь нийтийн орон сууц болон тусдаа тохилог орон сууцанд амьдарч байна.



Зураг. 4. Улаанбаатар хотын хүн амын өрхийн тоог сууцны төрлөөр нь ангилсан ангилал

Улаанбаатар хотын хэмжээнд гарсан гал түймрийг статистик тоо баримт дээр үндэслэж судалгааны ажлын үр дүнгийн хүрээнд гал түймрийн эрсдэлийг Олон Улсын түвшинд ашиглагддаг эрсдэлийн томьёоллоор тодорхойлж үзсэн.

Үүнд: *Жилд 1000 хүн амд учирч болзошгүй гал түймрийн эрсдэлийг 100 гал түймрийн улмаас нас барах тоог, 100000 хүн амд харьцуулан илэрхийлж нэг хүнд ноогдох гал түймрийн эрсдэлийг тодорхойлсон.*

1.Гал түймрийн эрсдэл R_1 – нэгж хугацаанд гарсан гал түймрийг хүн амд харьцуулсан харьцаа. Зураг.5

$$R_1 = \frac{N_{\text{гал түймэр.}}}{Q_{\text{хүн ам.}}} \left[\frac{\text{гал түймэр}}{\text{хүн.жил}}\right];$$



Зураг. 5 гал түймрийг хүн амд харьцуулсан харьцаа

2.Гал түймрийн эрсдэл R2 –. Зураг.6

$$R_2 = \frac{Q_{\text{нас баралт.}}}{N_{\text{гал түймэр.}}} \left[\frac{\text{нас баралт}}{10^2\text{гал түймэр}}\right];$$



Зураг.6. гал түймрийн улмаас нас барсан хүмүүсийн тооцоолол

3.Гал түймрийн эрсдэл R3 – нэгж хугацаанд гарсан гал түймрийн улмаас нас барах магадлал,

$$R_3 = \frac{Q_{\text{нас баралт.}}}{Q_{\text{хүн ам.}}} \left[\frac{\text{нас баралт}}{10^5\text{хүн.жил}}\right];$$



Зураг.7. Гал түймрийн улмаас нас барах хүний магадлалын тооцоолол

Гал түймрийн шууд эрсдэлийг тодорхойлохдоо R_1, R_2, R_3 харилцан холбоогоор тодорхойлж болно.

$$R_3 = R_1 \cdot R_2 \ .$$

Хүснэгт 2.

Гал түймрийн эрсдэл	$R_1 \cdot 10^3$	$R_2 \cdot 10^2$	$R_3 \cdot 10^5$
2017	1,70	1,82	3,10
2018	1,77	2,44	4,33
2019	1,89	1,88	3,56
2020	1,14	4,19	4,78
2021	0,99	2,1	2,16
Гал түймрийн эрсдэлийн 5 жилийн дундаж	1,50	2,25	3,56

Дээрх томьёоллоор *хүснэгт.2* Монгол Улсын хүн амын тал хувь нь амьдардаг Улаанбаатар хотын хүн амын 1000 хүн тутамд 1,5 гал түймэр ноогдож, 100 гал түймэр тутамд 2,25 хүн өртөж нас баран, нэг жилд 100000 хүн тутмаас 3,56 хүн гал түймэрт өртөж нас барах тооцоолол харагдаж байна.

Нийслэл хотын хэмжээнд жилд дунджаар 1894 объектын гал түймрийн шалтгаан нөхцлийг ангилан үзвэл ил галын улмаас – 18%, цахилгаан ашиглалтын буруугаас – 33%, пийшин, зуухны яндангийн цонолт – 42%, бусад – 7% шалтгаанаас гал түймэр гарсан байна. Зураг 8-аас харж болно. Гал түймэр гарч байгаа эдгээр шалтгаан нь нийгмийн нөхцөл байдал, ард иргэдийн амьдралын түвшин, өрхийн орлого зэргээс шууд хамааралтай.

Зураг 8. НОБГ-ын 2021 оны статистик мэдээ

Суурин газрын хэмжээнд гал түймрийн аюулын үндсэн эх үүсвэр нь хүн амын хэт төвлөрөл, пийшин, зуухны аюулгүй байдлыг хангаагүй, цахилгааны хэт ачаалал, стандартын бус цахилгаан хэрэгсэл ашигласан, байшингийн тааз, шувуун нурууны орчинд яндангийн цонолтоос хамгаалсан үл шатах материалаар хамгаалалт хийгээгүй, ил задгай газар үнс нурмаа асгадаг гэх мэт нөхцөлүүд нь аюулын эх үүсвэр болж байдаг.

Дээрх гал түймрийн аюулын эрсдэлийг бууруулахын тулд аж ахуйн нэгж байгууллага болон иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс галын автомат дохиоллын системийг өргөн хүрээнд дэлгэрүүлж, галын аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах асуудал тулгарч байна.

Монгол Улсад техник, тоног төхөөрөмжийн хөгжил хурдацтай хөгжихийн зэрэгцээ тэдгээрийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг мэдээлэл, техник, тоног төхөөрөмжийн хүрээнд шийдэх асуудал гараад байгаа билээ. Манай улс социализмын үед зөвхөн “Гал импекс” төрийн өмчит байгууллагын хүрээнд улсын бүхий л галын аюулгүй байдлыг хангах тоног, төхөөрөмж нийлүүлж худалдаалдаг байсан. 1992 оноос хойш энэ чиглэлээр олон хувийн хэвшлийн компани үйл ажиллагаа эрхлэх болсон бөгөөд энэхүү хөгжлийг дагаж мэдээллийн болон аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмж нь их хэмжээгээр нийлүүлэгдэж байна.

Өнөөгийн байдлаар гал түймрээс урьдчилан сэргийлэх дохиолол, автомат тоног төхөөрөмжийн суурилуулалт, угсралтын ажлыг гүйцэтгэдэг аж ахуйн нэгж, байгууллагууд өссөн нэмэгдсээр байна.

Гал түймэр унтраах автомат тоног төхөөрөмжийг

- спринклер
- дренчир
- аэрозоль
- нунтаг
- хий гэх мэтээр ангилна.

Гал түймрийг илрүүлэх зорилгоор

- гар мэдээлэгч
- утааны
- дулааны

- оптик
- хэт ягаан туяаны г.м ангилна.

Бүх төрлийн барилгуудад галын дохиололтой байх ёстой ба конторын зориулалттайгаас бусад барилгуудад давхар болгоны гарах хаалгуудын дэргэд гар кнопууд байна. Барилга, байгууламжийн гал түймрээс урьдчилан сэргийлэх дохиоллын систем нь хяналтын төв удирдлагаар хангагдсан системүүд нь цахилгааны хяналттай эх үүсвэртэй 24 цаг цахилгаанаар тэжээх чадвар бүхий батерейтэй хийгдсэн байх шаардлагатай.

Судалгаанд хамрагдсан нийт барилга байгууламжуудын дийлэнх хувьд гал түймэр унтраах автомат тоног төхөөрөмж суурилагдаагүй бөгөөд энэ нь эдийн засаг болон хот төлөвлөлтийн шаардлагаас улбаатай юм. Нийслэлийн дүүргүүдийн гал түймрээс урьдчилан сэргийлэх автомат тоног төхөөрөмж төлөвлөгдсөн барилга байгууламжийг 3 дугаар хүснэгтээр харуулав.

3-р хүснэгт. Автомат тоног төхөөрөмж суурилагдсан барилгын тоо

№	Барилгын хаяг	Нийт өндөр барилгын тоо	Үүнээс автомат тоног төхөөрөмж суурилагдсан	
1	Баянзүрх	50+2	17	32%
2	Баянгол	53	10	18%
3	Чингэлтэй	23	11	47%
4	Хан-Уул	26+2	11	39,2%
5	Сонгино-Хайрхан	22	11	50%
6	Сүхбаатар	28+2	14	46,6%
7	Нийт	208	74	35,5%

Судалгааны дүнгээс харахад барилга, байгууламжид гал түймэр унтраах автомат тоног төхөөрөмжийг төлөвлөхдөө зөвхөн мэдрэгч, мэдээлэгчийг ашиглаж байгаа бөгөөд энэ нь үйлчилгээ, албан газруудад л үйлчилж байна. Гал түймрээс урьдчилан сэргийлэх автомат дохиолол нь зарим нэг орон сууцанд төлөвлөгдөн ашиглаж байгаа боловч эдгээр нь чанарын шаардлага хангахгүй байгааг судалгааны үр дүнгээс харж болно.

Олон улсын стандартад барилга байгууламжийн гал түймрийн аюулгүй байдлын хангахдаа доор дурдсан зүйл заалтыг тусгасан байдаг байна. Үүнд:

Барилгын аль ч хэсгээс шатны хонгил хүртэлх зай 30 метрээс багагүй байх ёстой. Хэрэв тухайн барилга усан спринклерийн системтэй бол энэ зайг 45 метр хүртэл нэмэгдүүлж болно. Барилгын блокуудын эргэн тойрон галын машин техник орж гарахад зориулж 6 метр өргөн зурвас гаргасан байх ёстой. Газар доорх болон барилгын дээд давхруудад байрлуулсан автомат гал түймэр унтраах насос, дизель мотортой насосууд бүхий системүүд нь барилгын удирдлагын төв системтэй нэгтгэсэн байдаг.

Барилга байгууламжийг төлөвлөхдөө юуны өмнө гал түймрийн үед хүмүүсийн аюулгүй байдлыг хангах, гал түймэр эсэргүүцэх хамгаалалтын системтэй байхаар тооцдог. Олон давхар барилга байгууламжийн үндсэн авралтын зам гарц нь шат байдаг учраас гал түймрийн үед утаажилтанд өртөхөөргүйгээр төлөвлөгдсөн байх шаардлагатай.

Өөрөөр хэлбэл гал түймрийн үед утаа зайлуулах систем нь өрөөний аль нэг хэсэгт үүссэн гал түймрийн эхний

үед хүмүүсийг тухайн хэсгээс нүүлгэн шилжүүлэлтийг хангахын тулд төлөвлөгддөг.[1]

Өндөр барилгад гал түймэр гарсан үед өрөө тасалгааны агаарын солилцоо, шатлагын бүтээгдэхүүний тархах хурд зэрэг нь дараах зүйлүүдээс ихээхэн шалтгаална. Үүнд:

- Барилгын хийц бүтээцээс хамаарсан салхины даралтын үйлчлэл;
- Барилгын агааржуулалтын системийн ажиллагаа, хүчин чадал;
- Гал түймрийн нөхцөлд эзлэхүүнээр тархсан илүүдэл даралтын үйлчлэл г.м болно.

Иймд барилгын агааржуулалтын системийг төлөвлөхдөө гал түймрийн аюулгүй байдлын үүднээс өрөөнүүдийн гол босоо хоолойд давхар бүрийн агаар цуглуулах хоолой холбогдох газарт гал барих хавхлага, агаарын хаалт тавих шаардлагатай байдаг.

Судалгаанаас харахад ашиглалтад орсон барилга, байгууламжийн 29,3% -д гал түймрийн үед иргэд, үйлчлүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах үүднээс утаа зайлуулах болон агааржуулалтын систем огт байхгүй байна. Нийслэлийн барилга, байгууламжийн агааржуулалт болон утаа зайлуулах систем төлөвлөгдсөн судалгааг 9-р зурагт харуулсан.

9-р зураг. Барилга, байгууламжийн утаа зайлуулах болон агааржуулалтын систем

Дээрх зургаас харахад барилга, байгууламжид гал түймэр гарсан тохиолдолд иргэдийг нүүлгэн шилжүүлэх аврах үйл ажиллагаа явуулахад ихээхэн хүндрэл учирч болзошгүй.

Нийслэл хотын хэмжээнд орон сууцны 83651 гаруй барилга байгууламжид амьдарч буй 206243 өрхийн 747983 оршин суугчид болон тэдгээрт үйлчилгээ эрхлэгчдийн гал түймэрт өртөх магадлал өндөр байгаа нь уг барилга байгууламжид буй гал түймрийн аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмж тэдгээрийн хадгалалт, ашиглалт хангалтгүй байгаа нь энэхүү судалгааны ажлын үр дүнгээс харагдаж байна.

Дүгнэлт

Статистик тоо баримтаас харахад нийслэлийн Онцгой байдлын газрын бүтцийн нэгжүүдийн Гал түймэр унтраах, аврах ангиудад сүүлийн 5 жилийн дунджаар жилд 1894 объектын гал түймэр бүртгэгдэж, гал түймрийн улмаас жилд дунджаар 55 хүн амь

[1] БНбД 41-02-01 –ын “5. Түймрийн үеийн утаа эсэргүүцэх хамгаалалт”

насаа алдаж, гал түймрийн улмаас жилд дунджаар 12.1 тэрбум төгрөгийн хохирол учирсан. Нийт гал түймрийн 45.1% нь гэр орон сууц, барилга байгууламжид гарсан нь Улаанбаатар хотын хүн амын 1000 хүн тутамд 1,5 гал түймэр ногдож, 100 гал түймэр тутамд 2,25 хүн өртөж нас баран, нэг жилд 100000 хүн тутмаас $R_3 \cdot 10^5$ =3,56 ≈ 4 хүн гал түймэрт өртөж нас барах тооцоолол гарсан.

Хүн ихээр төвлөрсөн Улаанбаатар хотын хэмжээнд объектын гал түймрийн тоо, хохирлын хэмжээг бууруулахад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоо, чадавхыг сайжруулах, барилга байгууламжид зайлшгүй байх галын автомат дохиоллын системийн төлөвлөлтийг барилгын норм, нормативын баримт бичгийн хүрээнд төлөвлөлтийг сайжруулах, түүнд тавих хяналтын механизмыг сайжруулах тулгамдсан асуудал болж байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т “Төрийн болон нутгийн захиргааны байгууллага тухайн жилийн төсвийн 1.0 хувийг гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд төлөвлөж зарцуулна гэж заасанчлан нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд хуучин төлөвлөгдсөн гал автомат дохиоллын системийн засвар үйлчилгээг тогтмол холбогдох мэргэжлийн байгууллагаар хийлгэх, төлөвлөгдөөгүй байгууллагууд шинээр дахин төлөвлөх нэн тэргүүний асуудал болж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль Төрийн мэдээлэл., УБ. 1992 он №1
2. Гамшгаас хамгаалах тухай хууль.
3. Монгол улсын Галын аюулгүй байдлын тухай хууль.
4. Жилийн дундаж хүн амын тоо https://www.1212.mn/tables.aspx
5. Улаанбаатар хотын өрхийн судалгаа https://www.1212.mn/tables.aspx
6. Төвлөрсөн болон бие даасан инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд амьдардаг өрхийн судалгаа https://www.1212.mn/tables.aspx

ЦАГ УУРЫН ТАНДАН СУДАЛГААГ ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНД АШИГЛАХАД ТУЛГАРЧ БУЙ СААД БЭРХШЭЭЛ

OBSTACLES TO USING SPATIAL WEATHER FORECASTING IN HUMANITARIAN EARLY ACTION

Ч.Нямхүү
Дотоод хэргийн их сургуулийн магистрант
Nyamkhuu.Ch
University of internal affairs master

Хураангуй: Цаг уурын өөрчлөлтийн улмаас байгалийн гаралтай гамшиг, аюулт үзэгдлийн тоо, давтамж нэмэгдэж нийгэм, эдийн засагт үзүүлэх хор уршиг нэмэгдсээр байна.[1] Уламжлалт гамшгийн дараа хариу арга хэмжээ болгон хэрэгжүүлдэг хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг сайжруулах боломжийг олон улсын байгууллагууд туршин хэрэгжүүлсээр байгаа ба Цаг уурын урьдчилсан мэдээнд тулгуурласан санхүүжилт хөтөлбөрийг Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбоо 10 гаруй оронд дэмжин, хэрэгжүүлж байна.[2] Монгол Улсад энэхүү хөтөлбөрийг Ус, цаг уур орчны шинжилгээний хүрээлэнгээс зудын эрсдэлийн зурагт үндэслэн зудын эрт хариу арга хэмжээг Монголын улаан загалмай нийгэмлэг хэрэгжүүлж байна. Энэхүү судалгааны ажлын хүрээнд тус хариу арга хэмжээний механизмыг олон улсын төвшинд удаан болон хурдан явцтай гамшгийн үед хэрхэн ашиглаж байгаа талаар болон тулгарч буй саад бэрхшээлд дүн шинжилгээ хийсэн болно

Abstract: Due to climate change, the number and frequency of natural disasters and disasters are increasing, and the social and economic damage is increasing. International organizations have been experimenting with opportunities to improve post-disaster humanitarian assistance, and the International Federation of Red Cross and Red Crescent Societies (IFRC) has supported and implemented meteorological forecasting programs in more than 10 countries. In Mongolia, the program is implemented by the Mongolian Red Cross Society for Early Dzud Response based on a dzud risk map from the Institute of Meteorology and Hydrology. This study analyzes how the response mechanism is used internationally in slow and rapid disasters and the challenges it faces.

Түлхүүр үгс: Зайнаас тандан судлал, хүмүүнлэгийн тусламж, эрт сэрэмжлүүлэг, эрт хариу арга хэмжээ, зуд

Key words: Spatial weather forecasting, humanitarian assistance, early action, early warning, dzud

Удиртгал: Орчин үеийн дэлхийн уур амьсгалын эрчимтэй дулаарлын улмаас агаар мандлын гаралтай аюулт үзэгдлийн давтамж нэмэгдэн, учруулах хор хохирол нь улам бүр өсөж, дэлхийн улс орнуудын үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх шинэ аюул болж байна. Манай улсад цаг уурын гаралтай аюулт үзэгдэл жилд дунджаар 54 удаа болдог ба сүүлийн 10 жилд энэ тоо 1.5-2.7 дахин өссөн байна. Цаг агаарын аюулт үзэгдлээс учирсан хохирлын улсын ДНБ-д эзлэх хувь 2000, 2001 болон 2010 онуудад өндөр буюу 5.4-

1 J. Kellett and A. Caravani, “Financing disaster risk reduction: a 20-year story of international
2 Review of the pilot phase of the forecast-based action by the disaster relief emergency fund 2018-2020, Robert Roots, 2021

11.7% байгаа нь эдгээр жилүүдэд нүүрлэсэн ган, зудад олон тооны мал хорогдсонтой холбоотой.[3] Монгол орны жилийн дундаж агаарын температур 1940 оноос хойш 2.1°С градусаар дулаарсан бөгөөд энэ нь дэлхийн дунджаас даруй 3 дахин их байгаа төдийгүй ирээдүйн өөрчлөлтийг хүлэмжийн хийн ялгарал А2, В1 гэсэн хувилбаруудаар тооцсон үр дүнгээр цаашид зун илүү халуун болж, хур тунадас багасах, өвөлд хүйтрэлт зөөлөрч, хур тунадас нэмэгдэх хандлага гарч байгаа нь ган, зуд, үер, цасан болон шороон шуурга, хэт халуун зэрэг аюулт үзэгдлүүд улам ихсэхийг илтгэж байна. Улс орны нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол учруулдаг 10 гаруй төрлийн цаг агаарын үзэгдэл байдгаас нийгэм эдийн засгийн эрсдэлээрээ ган, зуд, ой хээрийн түймэр, цасан шуурга, уруйн үер, эрс хүйтрэлт зэрэг нь голлох гамшигт үзэгдлийн тоонд багтдаг. Сүүлийн 20 жилийн хугацаанд болсон цаг агаарын аюулт үзэгдлийн 93%-г ЦУОШГ-аас урьдчилан анхааруулсан байдаг хэдий ч 502 хүн амь насаа алдаж, 29.6 сая мал хорогдож, 773.8 тэрбум төгрөгийн хохирол учирсан байдаг. 2010 онд олон сараар үргэлжилсэн их хүйтэн болж, ойр ойрхон их хэмжээгээр орсон цас нь зудын нөхцөлийг үүсгэж, мал сүрэг үй олноор хорогдож, улс нийгэмд 526 тэрбум гаруй төгрөгийн хохирол учруулсан нь эдгээр жилүүдэд учирсан нийт хохирлын 86% байна. Мэдээж гангийн улмаас усалгаагүй тариалангийн ургац алдах, бэлчээрийн ургац муугаас мал сүрэг тарга хүчээ авч чадахгүй ашиг шим нь хомстох зэрэг ихээхэн хохирол гардаг боловч одоогоор энэ алдагдлыг тооцож чадахгүй, тэр байтугай зудын хохиролд зөвхөн үхсэн малын үнэ л орсон байгаа юм. Цаг агаарын гаралтай нийт аюулт үзэгдлүүдийн 57% нь гэнэтийн шинж чанартай, үзэгдлүүд буюу ширүүн аадар, уруйн үер, аянга, мөндөр, нөөлөг салхи зэрэг байдаг бөгөөд 2018 онд гэнэтийн үзэгдлийн учруулсан хохирол нь цаг агаарын аюулт үзэгдлээс учирсан нийт хохирлын 93%-г эзэлсэн байдаг.[4]

Хувиран өөрчлөгдөж байгаа байгаль, цаг уурын орчинд хүн ард, мал сүрэг, эдийн засаг, нийгмийн аюулгүй байдлыг хамгаалахын тулд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоонд цаг уурын аюулт үзэгдлийн эрсдэлийг нарийн тусгаж өгөх шаардлага тулгарч байна. Ус цаг уурын аюулт үзэгдлийн нөлөөллийг бууруулах хууль, эрх зүйн орчин, зохион байгуулалтын үндсийг дээшлүүлэх, үндэсний цаг уурын алба болон байгалийн гамшигтай тэмцдэг тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын чадавх, уялдаа холбоог сайжруулж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгох, ус цаг уурын аюулт үзэгдлийг тандан судлах мониторинг сайжруулах, аюулт үзэгдлээс сэрэмжлүүлэх мэдээ мэдээллийн чанар хүртээмжийг сайжруулах, малчид иргэдийг байгалийн гамшгийг хамгийн бага хохиролтойгоор даван туулах аргад сургах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох талаар иргэдийн сэтгэлгээг өөрчлөх, бэлчээрийн менежментийг сайжруулж малын тоо

3 Ш.Болдбаатар "Үндэсний аюулгүй байдал нөлөөлөх зудын эрсдэлийг бууруулах арга зам", УБ хот, 2016 он.

4 Ш.Болдбаатар, Монгол орны зудын эрсдэлийн менежментийн өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ, Улаанбаатар хот, 2016 он.

толгойг бэлчээрийн даацтай уялдуулах, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын идэвх, оролцоог урамшуулж, хамтын ажиллагааг бэхжүүлэх нь байгалийн гамшиг, гэнэтийн аюултай тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж, эрсдэлийг бууруулна гэж үзэж байна.

Үндсэн хэсэг: Цаг уурын тандан судалгааг ашиглан хүмүүнлэгийн тусламж үзүүлэх үйл ажиллагааг өнөөгийн байдлаар 30 улс хэрэгжүүлэн туршиж байна. Улс орнууд бүс нутгийн цаг уурын онцлог, цаг уурын тандан судалгаа явуулах нөөц бололцоо, хөрөнгө, хамтын ажиллагааны зэргээс хамааран өөр өөрийн өвөрмөц шийдэл бүхий хариу арга хэмжээний цогцыг бий болгож байна. Энэхүү дэд бүлэгт зарим улсын цаг уурын тандан судалгааг ашиглан хэрхэн хүмүүнлэгийн эрт хариу арга хэмжээг зохион байгуулж байгаа тухай авч үзнэ. Доор дурдсан жишээ нь олон улсад бусад Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүд хэрхэн эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлж байгаа мөн тэдний сайн туршлага, саад бэрхшээлийг судалж Монгол улсад эрт хариу арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэхэд ашиглаж болохуйц туршлага судалж, дүн шинжилгээг хийх судлагдахуун болно. Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооноос 2018 оноос хойш Цаг уурын урьдчилсан мэдээнд суурилсан санхүүжилт хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадавх бүхий үндэсний нийгэмлэгүүдэд зориулан гамшгийн яаралтай тусламжийн сангаас санхүүжилт авах боломжийг бүрдүүлсэн байна. Үүнд гамшгийн эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооны маягтын дагуу (үүнд цаг уурын найдвартай мэдээ, түүнд хийсэн дүн шинжилгээ, хариу арга хэмжээний төрөл, эмзэг байдлыг тодорхойлсон байдал зэрэг.) боловсруулж, батлуулсан байх шаардлагыг тавьдаг байна. Тус маягтыг “Эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх журам” буюу “Early action protocol эсвэл Standard operating procedure” гэж нэрлэдэг. Эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдахад санхүүжилт нь 3 үндсэн хэсэгтэй байх ба үүнд Readiness буюу бэлэн байдлыг хангах, pre-positioning буюу урьдчилан байршуулах болон early action буюу эрт хариу арга хэмжээний санхүүжилт багтдаг. Readiness болон pre-positioning-д хамаарах санхүүжилт нь урьдчилан олгогдсоноор эрт хариу арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах (сайн дурын идэвхтнүүдийг бэлтгэх, хариу арга хэмжээнд оролцогч талуудтай урьдчилан уулзалтуудыг зохион байгуулах гэх мэт, тусламжийн барааг урьдчилан байршуулах гэх мэт.) боломжийг бүрдүүлдэг. Энэхүү 3 төрлийн санхүүжилтээс дээрх 2 төрлийн санхүүжилт Үндэсний нийгэмлэг нь Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбоогоор эрт хариу арга хэмжээний төлөвлөгөөгөө батлуулж, гэрээ байгуулснаар олгогддог бол эрт хариу арга хэмжээний санхүүжилт буюу early action хэсгийн санхүүжилт нь төлөвлөгөөнд заасан аюул нь эрт хариу арга хэмжээг идэвхжүүлэх аюулын босго үзүүлэлтэд хүрэхүйц буюу тохиолдох өндөр магадлалтай тохиолдолд олгогддог. Нийт санхүүжилтийн хэмжээ нь 250,000 Швейцар франк буюу 715 сая гаруй Монгол төгрөг бөгөөд эрт хариу арга

хэмжээний төлөвлөгөө нь 5 жилийн хугацаанд хүчинтэй байна.[5] Эрт хариу арга хэмжээ хэрэгжихүйц аюул 5 жилийн хугацаанд болоогүй тохиолдолд эрт хариу арга хэмжээний төлөвлөгөөг дахин шинэчилж Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбоогоор дахин батлуулах юм.

Доор дурдсан жишээнүүд нь Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооны эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх сангаас өөрсдийн төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлсэн үндэсний нийгэмлэгүүдийн жишээ болно.

Перу улс нь өвөрмөц газар нутгийн байршилтай бөгөөд Андын нурууны хүйтэн урсгал, Номхон далайн халуун агаар, Амазоны чийглэгээс хамааран цаг уурын байдал нь олон төрөл байна.[6] Үүнээс үүдэн цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн төрөл харьцангуй олон байдаг бөгөөд Андын нурууны орчмын оршин суугчид хэт хүйтрэлт, ширэнгэн ойд оршин суугчид нь үерт өртөмтгий байдаг ба сүүлийн жилүүдэд Эл Ниний нөлөөгөөр цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн эрчим болон давтамж ихээхэн нэмэгдээд байна.[7] Перу улсын Улаан загалмай нийгэмлэг 2015 оноос хэт хүйтрэлт, их цас болон Амазон мөрний удаан явцтай үерийн эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх төслийг эхлүүлсэн байна. Эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх босго үзүүлэлтийг тогтоохдоо тухайн бүс нутаг аюулт үзэгдлийн түүх түүний нөлөө, хүн амын эмзэг байдал зэрэгт дүн шинжилгээ хийсэн байна. Мөн түүнчлэн аюулт үзэгдлийн зэрэглэлийг (Хүснэгт 2) хот бүхэнд тусад нь боловсруулсан байна. Хэт, хүйтрэлт болон их цасны улмаас нутгийн иргэдийн гаршуулан тэжээдэг лам гөрөөс олноор хорогдох, хүмүүс амьсгалын замын өвчлөлд нэрвэгдэх мөн цаашлаад ядуурлыг нэмэгдүүлэх хүчин зүйл болдог байна. Перу улсын Улаан загалмай нийгэмлэг Цаг уурын албатай хамтран дээр дурдсан аюулын зэрэглэлийн мэдээллийг автоматжуулах үйлчилгээг бий болгосон ба цаг уурын аюулт үзэгдлийн шууд мэдээллийг холбогдох Улаан загалмайн ажилтан, Онцгой байдлын байгууллагын ажилтнууд, орон нутгийн удирдлага, иргэд, сайн дурын идэвхтнүүдэд шууд мэдээлэх боломж бүрдсэн байна. Эрт хариу арга хэмжээг их цас, хэт хүйтрэлтээс өмнө 5 хоногийн өмнө хэрэгжүүлэх ба 5-аас доош насны 100 хүүхэд, өндөр настай, амьсгалын замын архаг хууч өвчтэй 200 хүнтэй өрх зэрэг 625 өрхийг хамруулах юм. Хариу арга хэмжээнд амьтны антибиотик, витамин болон элэг хамгаалах эмийг агуулсан багц, берзент, дулаан хувцас, нүдний шил болон хамгаалах хэрэгсэлийн багц, хүрэм, бээлий, оймс, гутал, дулаалгын берзэнтийн багц мөн түүнээс гадна радио, телевизээр цацах нөлөөллийн ажлууд багтсан байна. Энэхүү хариу арга хэмжээний зорилго нь цаг уурын үзэгдэлд өртөмтгий хүн амын бэлэн байдлыг хангах, цаг уурын аюулт үзэгдлийн тэдэнд үзүүлэх нөлөөллийг бууруулах замаар хүн амын эрүүл мэнд, тогтвортой амьжиргааг

5 https://reliefweb.int/sites/reliefweb.int/files/resources/AnticipatoryActionHLE2021_CoChairsStatement.pdf

6 https://www.forecast-based-financing.org /wp-content /uploads/2020/04/Factsheet_Peru.pdf

7 https://www.anticipation-hub.org/Documents/Briefing_Sheets_and_Fact_Sheets/Experience_in_the_Peruvian_Amazon_region-Flooding.pdf

дэмжих юм. Энэхүү эрт хариу арга хэмжээний идэвхижих аюулын зэрэглэл одоогийн байдлаар хүрээгүй байгаа учир үр дүнгийн шинжилгээ хязгаарлагдмал байв.

Перу улсад хэрэгжиж буй өөр нэгэн эрт хариу арга хэмжээний төрөл нь үерийн эрт хариу хэмжээ юм. Жил бүрийн 12-5 сарын хугацаанд Андын нуруунд ордог бороноос үүдэлтэй уруйн үерт олон хүн нэрвэгддэг байна. Цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэйгээр хур бороо орох зүй тогтол өөрчлөгдөж, илүүтэй ширүүн бөгөөд олон давтамжтай болсон байна. Үерийн уснаас үүдэлтэй дэд бүтцийн болоод иргэдийн эрүүл мэнд, амьжиргаатай холбоотой эрсдэл үүсч эхэлсэн байна.

Перу улсад Уруйн үер болон Амазон мөрний үерээс шалтгаалан 2012 болон 2015 онд нийт 4,917 өрх гэр оронгүй болж, 112,024 өрхийн байшин, нийт 350 мянга гаруй хүн нэрвэгдсэн байна. Үерийн улмаас ундны усны хомстол үүсэн, усаар дамжин халдварладаг өвчин тархаж эхэлсэн юм. Хэдийгээр орон нутгийн иргэд улирлын чанартай тохиолддог тогтмол үерийн үед амьдарч дадсаар ирсэн боловч сүүлийн жилүүдэд үерийн тохиолдлын тоо олширч, Амазон мөрний үерлэх төвшин өмнөх жилүүдийнхээс нэмэгдэх болсон байна.

Амазон мөрний үерийн 30 жилийн түүхэн мэдээллийг ашиглан Перу улсын Улаан загалмай болон Онцгой байдлын байгууллага, Цаг уурын алба хамтран эрт хариу арга хэмжээг идэвхжүүлэх үерийн аюултай төвшинг тодорхойлсон байна. Сүүлийн 30 жилд үерлэсэн үерийн урьдчилсан мэдээтэй адил цаг уурын мэдээ бүртгэгдсэн тохиолдолд эрт хариу арга хэмжээг идэвхжүүлж, 9 хоногийн хугацаанд хэрэгжүүлэх юм. Хариу арга хэмжээний хүрээнд иргэдэд эрт сэрэмжлүүлэх мэдээг хүргэх, нүүлгэн шилжүүлэх болон бэлэн мөнгөний тусламж үзүүлэх, ялаа, шумуулаас хамгаалах тор, ариун цэврийн багц, цэвэр усны сав, хлорин, анхны тусламжийн багц зэргийг олгосон байна.

Вьетнам улс нь Ази-Номхон далайн бүс нутагт оршдог далайн хуй салхи, үер, ган, хэт халалт болон хөрсний гулгалт, ойн түймэр, далайн ус ихээр нэвтрэх зэрэг байгалийн аюулт үзэгдлүүд тохиолддог бөгөөд сүүлийн жилүүдэд хотжилт, хүн амын төвлөрөлт нэмэгдсэн болон дэлхийн дулаарлын улмаас илүү эрчимтэй, удаан үргэлжлэх болсон хэт халалт нь нэн аюултай төвшинд хүрээд байгаа юм.[8] Хэт халалт нь зүрх судасны, амьсгалын тогтолцооны өвчнийг хүндрүүлэх, наранд цохиулах улмаар үхэлд хүргэх ч аюултай юм. Вьетнам улсын нийслэл Ханой хотноо гадаа олон цагаар ажиллах шаардлагатай олон хүн байдаг бөгөөд Вьетнам улсын Улаан загалмай нь 3 хотод хэт халалт болохоос 1 хоногийн өмнө, хэт халалт явагдаж байх үед авах 3 хоногийн арга хэмжээг зохион байгуулсан байна. Хариу арга хэмжээний хүрээнд гадаа олон цагаар ажилладаг иргэд сэрүүцэх, шингэн зүйл уух боломж бүхий асруудыг байршуулсан ба биечлэн иргэдтэй уулзах, олон нийтийн сүлжээ, масс мессеж үйлчилгээг ашиглах зэргээр нөлөөллийн үйл ажиллагааг явуулсан байна. Эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх босго үзүүлэлтийг Вьетнам улсын Цаг уурын албатай зөвхөн энэхүү

8 https://www.anticipation-hub.org/experience/anticipatory-action-in-the-world/vietnam/fbf-ready-reducing-heat-waves-impacts-on-the-vulnerable-populations-of-hanoi/

төсөлд зориулан бүтээсэн бөгөөд халууны индекс нь 2 өдөр дараалан Дананг хотод 47,13 Цельсийн градус, Ханой болон Хай Понг хотод 48,16 Цельсийн градус болон түүнээс дээш хүрвэл уг эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх юм. Хэрвээ цаг уурын мэдээлэл халалт эхэлнэ гэж заасан өдрөөс 3 өдрийн өмнө өөрчлөгдсөн тохиолдолд эрт хариу арга хэмжээг цуцлах юм.

Энэхүү эрт хариу арга хэмжээг 2019 оны 7-р сарын 18-21-ний өдрүүдэд хэрэгжүүлсэн бөгөөд Ханой хотод халууны индекс 47.5 Цельсийн градус хүрсэн байна. Цаг уурын урьдчилсан мэдээг Ханой хотын Цаг уурын алба 3 хоногийн өмнө Улаан загалмайд хүргэсэн ба хэт халалтаас хэрхэн эрүүл мэндээ хамгаалах тухай мэдээллийг олон нийтэд хүргэх , сэрүүцэх цэгүүдийг байршуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба мөн гэртээ агааржуулагч, сэнс авах боломжгүй өрхүүдэд бэлэн мөнгөний тусламж үзүүлсэн байна. Зураг 6-д үзүүлсэнчлэн хэт халалт нь өндөр настан, бага орлоготой, гадаа олон цагаар ажилладаг иргэд, амьсгал, зүрх, судасны өвчтэй иргэдэд аюултай юм. Хэт халалтын улмаас нийт эмнэлгээр эмчлүүлэгчдийн тоо 20%-иар, амьсгал, зүрх, судасны өвчлөлийн 45.9%-иар нэмэгдэх магадлалтай байна.[9] Эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд 4 хоногийн турш нийт 479 иргэн сэрүүцэх өрөөгөөр үйлчлүүлсэн ба 1 хүнд дунджаар 10 минут үйлчлүүлсэн байна. Нийт үйлчлүүлсэн иргэдийн 26% нь цагийн ажилтан, 23% нь барилгачин, 14% нь хүргэлтийн ажилтан, 9.5% нь гудамжинд олон цагаар ажилладаг ажилтан байжээ. Нийт сэрүүцэх өрөөгөөр үйлчлүүлсэн иргэдийн 70.5% нь өрөөгөөр үйлчлүүлсний дараа биеийн байдал нь сайжирсан гэж хариу өгсөн байна.

Бангладеш улс нь өөрийн газарзүйн онцлогоос хамааран байгалийн гаралтай аюулт үзэгдэлд өртөмтгий билээ. Бангладеш улс нь нам дор газар байрлах бөгөөд дэлхийд томд тооцогдох олон голууд оршдог, хуурай газар дээрээ ус ихтэй улс юм. Борооны улирлын үед үерлэх нь энгийн үзэгдэл бөгөөд тухайн үед жилд орох хур тунадасны 80% нь ордог байна. Зарим жилүүдэд үер аюултай төвшинд хүрч 1 сая гаруй хүн үерт нэрвэгддэг бөгөөд үерээс гадна хүчтэй хуй салхи, циклон жилд 2-3 удаа тохиолддог байна. Бангладеш улс 2017 оны 7-8-р сард циклоны эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн бөгөөд далайн эрэг дагуу 13 хотын 20,000 иргэд нэрвэгдэх эрсдэлтэй гэж дүгнэсэн ба цаг уурын албатай хамтарсан эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх босго аюулын зэрэглэлийг тогтоосон байна.[10] Эрт хариу арга хэмжээ идэвхэжсэн тохиолдолд эрт хариу арга хэмжээг циклон эх газарт хүрэхээс өмнө 30 цагийн дотор хэрэгжүүлэх юм. Эрт хариу арга хэмжээнд хүнс болон цэвэр ус, анхны тусламжийн иж бүрдэл, нүүн шилжүүлэх үйлчилгээ зэрэг багтсан байна. Эрт хариу арга хэмжээний гол зорилго нь байгалийн аюулт үзэгдлийн нөлөөллийг боломжит хэмжээнд бууруулах бөгөөд иргэдэд өөрсдийн эд

9 Dinnissen, Susan & Faucet, Jerome & Van, Thang & Vu, Thang & Dinh, Trong & Quang, Trung. (2020). Fostering anticipatory humanitarian actions for heatwaves in Hanoi through forecast-based financing. Climate Services.

10 https://www.anticipation-hub.org/experience/anticipatory-action-in-the-world/Bangladesh/forecast-based-financing-in-bangladesh/

зүйлс, мал зэргээ аюулгүй газарт зөөвөрлөх боломж олгох, анхны тусламжийн иж бүрдэл, хүнсний тусламжийг үзүүлснээр тэдний амьдралд үзүүлэх циклоны нөлөөллийг бууруулж байгаа юм. Бангладешийн цаг уурын алба, Энэтхэгийн цаг уурын алба, Европын богино хугацааны цаг уурын мэдээний алба, Олон улсын цаг уурын мэдээний системээс 125км/ц-аас дээш хурдтай циклон эргийг чиглэн ирж байгаа тухай мэдээлэл гаргавал эрт хариу арга хэмжээг идэвхжүүлэх юм. 2019 онд хэрэгжүүлсэн эрт хариу арга хэмжээний үеэр 1 өрхөд 53 Ам.доллар болон бусад дээр дурдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Хариу арга хэмжээний дараа аюулт үзэгдлээс өмнө тусламж авсан буюу эрт хариу арга хэмжээнд хамрагдсан болон циклоны үеийн хариу арга хэмжээнд хамрагдсан тусламж хүртэгчдийг харьцуулсан судалгааг хийж эрт хариу арга хэмжээний үр дүнг үнэлсэн байна. Ингэхэд эрт хариу арга хэмжээнд хамрагдсан иргэд өөрсдийн эд хогшил, малаа бага зарж борлуулсан, хоол хүнс, малаа бага алдсан байна. Байгалийн аюулт үзэгдлийг эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд удаан явцтай болон хурдан явцтай гэж ангилж болох ба циклон, уруйн үер, хөрсний унанги зэрэг харьцангуй богино хугацаанд тохиолдож их хохирол учруулж болохуйц үзэгдлүүдийг хурдан явцтай гэж нэрлэх бол зуд, цөлжилт, хэт халалт зэрэг шууд бус, аажмаар тохиолддог аюулт үзэгдлүүдийг хурдан явцтай гэж үзэж болохоор байна. Аюулт үзэгдлийн тохиолдох хурднаас шалтгаалан мөн эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх механизм буюу авах арга хэмжээ, аюулын зэрэглэлийн босго үзүүлэлт зэрэг бүх төлөвлөлт өөр өөр байна[11]. Жишээлбэл цөлжилт буюу гангийн хариу арга хэмжээ авах боломжит хугацаа нь 1-3 сар байдаг бол өмнө дурдсанчлан циклонд хариу арга хэмжээ авах боломжит хугацаа нь 24-72 цаг байна. Бангладеш улсад 2020 онд хэрэгжүүлсэн циклоны эрт хариу арга хэмжээний санхүүжилт нь хүсэлт гаргасан өдрөөс хойш 10 хоногийн дараа Бангладешийн Улаан хавирган сард олгогдсон бөгөөд шилжүүлэг 3 өөр банкаар дамжсан байна.

Дүгнэлт

Эрт хариу арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах гол элементүүдийн нэг нь шинжлэх ухаанаар батлагдсан, найдаж болохуйц цаг уурын урьдчилсан мэдээнд суурилсан хариу арга хэмжээг хэрэгжүүлэх босго үзүүлэлт юм. Эквадор улсад тохиолдсон галт уулын идэвхжилтийн хариу арга хэмжээний босго үзүүлэлт нь галт уулын идэвхжилтээс үүдэлтэй биетэд үүсэх үнсний зузаан 2 мм хүрвэл хариу арга хэмжээг хэрэгжүүлнэ гэх босго үзүүлэлтийг эрт хариу арга хэмжээний төлөвлөгөөнд оруулсан хэдий ч бодит байдалд үнсний зузаан 1 мм хүрэхэд зорилтот бүлгийн хүн амд асар их хохирол амсуулсан учир тус босго үзүүлэлтийг шинэчлэхэд хүрсэн байна. Филиппин улсад далайн хуй салхины хариу арга хэмжээний босго үзүүлэлтийг тогтоохдоо “510” олон улсын цахим эрдэмтэн судлаачдын багтай хамтран 3 хотын нийт хүн амын 10% нь нэрвэгдэх өндөр эрсдэлтэй үед

11 Review of the pilot phase of the forecast-based action by the disaster relief emergency fund 2018-2020, Robert Roots, 2021.

хариу арга хэмжээг 64 цагийн дотор хэрэгжүүлэх босго үзүүлэлтийг тогтоосон нь босго үзүүлэлтийг тогтоохдоо тухайн улсын онцлог, нөхцөл байдлыг сайтар ойлгодог мэргэжилтэн судлаачдын зөвлөгөөг ашиглан босго үзүүлэлтийг сайжруулах боломжтой гэдгийг харуулсан сайн жишээ юм. Дээрх жишээнүүдээс үзэхэд цаг уурын холбогдох мэдээ нь тодорхой бус, найдваргүй эсвэл бусад дата, эх сурвалж байхгүй үед оновчтой босго үзүүлэлтийг бий болгох хэрэгцээ байгаа нь харагдаж байна. Хэдийгээр эрт хариу арга хэмжээний төлөвлөгөөнд заасан босго үзүүлэлтэд хүрэхгүй байгаа ч Үндэсний нийгэмлэг эсвэл орон нутгийн эрдэм шинжилгээний багийн зөвлөмжийн дагуу эрт хариу арга хэмжээг идэвхжүүлэх механизмыг тодорхой хяналтын дор бий болгох нь өөрөө уян хатан шийдэл байж болох юм.

Нөгөө талаар Олон улсын Улаан загалмай, Улаан хавирган сар нийгэмлэгүүдийн холбооноос 2019 онд батлагдсан 8 эрт хариу арга хэмжээний төлөвлөгөөнөөс 2020 онд 5 нь идэвхэжсэн байгаа нь эрт хариу арга хэмжээг зөвхөн нэн ноцтой нөхцөл байдалд эрт хариу арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлага буюу 5 жилд 1 удаа идэвхжих шаардлагыг хангахуйц өндөр байна уу? Цаашлаад хүмүүнлэгийн тусламж шаардагдах онцгой нөхцөл байдлыг хэрхэн тодорхойлж байгааг гүнзгий судлах хэрэгцээг бий болгож байна

Ашигласан материал

1. Төрийн мэдээлэл" хууль тогтоомжийн эмхтгэл №07 /964/.
2. Л.Нацагдорж, М.Должинсүрэн “Монгол оронд тохиолддог байгалийн гамшигт үзэгдлүүд” УБ хот. 2016 он.
3. П.Дамдин “Үндэсний аюулгүй байдалд байгалийн гамшгийн үзүүлэх нөлөөг бууруулах арга зам”.УБ хот. 2012он;
4. Ш.Болдбаатар “Үндэсний аюулгүй байдал нөлөөлөх зудын эрсдэлийг бууруулах арга зам”, УБ хот, 2016 он.
5. Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга
6. http://www.jstor.org/stable/42748364.
7. World Food Programme, “Forecast-based financing in Nepal, a return-on-investment study,” 2019.
8. https://www.fao.org/3/ca2595en/CA2595EN.pdf
9. НҮБХХ, 2009-2010 оны зудын сургамж тайлан. УБ хот. 2010 он.
10. Дэлхийн банкны банкны Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн тайлан, УБ хот. 2021 он.
11. http://www.geoforum.mn/index.php?pid=80&nid=234
12. http://icc.mn/
13. С.Жигжидсүрэн, Төрөл бүрийн тэжээл бэлтгэх гарын авлага, Улаанбаатар хот, 2010 он.
14. Ш.Болдбаатар, Монгол орны зудын эрсдэлийн менежментийн өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ, Улаанбаатар хот, 2016 он.
15. Ш.Болдбаатар, Монгол орны зудын эрсдэлийн менежментийн өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ, Улаанбаатар хот, 2016 он.
16. Lessons from the dzud, Adaptation and resilience in Mongolian pastoral social-ecological system, Marna E. Fernбndez-Gimenez, Batbuyan Batjav and Batkhishig Baival, 2012.
17. Малчны аж байдлын судалгаа, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын институци, 2018.

18.The effects of anticipatory actions and humanitarian response on vulnerable herder households in Mongolia's extreme winter season 2019/20: evidence from a quasi-experimental evaluation, Clemens Gros, 2021.

19.Эрт сэрэмжлүүлэг, эрт хариу арга хэмжээний нөлөө, НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Ром, 2018.

ИННОВАЦИЙГ ЦАГДААГИЙН АЛБАНД АШИГЛАХ ЗАРИМ БОЛОМЖ

USE INNOVATION IN POLICE OPPORTUNITY

Б.Бямбасүрэн
Магистрант, ТЗЦГ-ын чиглэлийн ахлах ажилтан, цагдаагийн хошууч
B.Byambasuren
Senior Officer of the General Administration, police major

Хураангуй: Цагдаагийн албаны үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, цагдаагийн алба хаагчийг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх, зөвхөн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор инновацийн зарим шийдлийг Цагдаагийн албанд ашиглах боломжийн талаар энэхүү өгүүлэлд товч авч үзсэн болно.

Abstract: The study explored the possibility of using some innovative solutions in the police in order to organize the activities of the police quickly and efficiently, to create conditions for police officers to work productively and sustainably, to respect human rights and freedoms, and to perform their official functions only.

Түлхүүр үг: инноваци, цагдаагийн алба
Keywords: innovation, police

Удиртгал. Инновацийн тухай хуульд зааснаар Инноваци гэдэг нь шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах цогц үйл явц[1] бөгөөд Инновацийн үйл ажиллагаа гэж шинэ санаа, шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, технологи, ажил үйлчилгээг бий болгож зах зээлд нийлүүлэхэд чиглэсэн арга хэмжээ юм.

Гэмт хэрэг мөрдөхүйн хөгжлийг философи, ёс зүй, уламжлал, соёл, нийгэм эдийн засаг, хууль эрх зүй, улс төр хийгээд шинжлэх ухааны ололт амжилт, технологийн дэвшилтэт техник хэрэгсэл гэх мэт олон салбар мэдлэгийн хүрээнд авч үзэх шаардлагатай байдаг.

Гэмт хэрэг нь өөрийн гэсэн зүй тогтолтой бөгөөд түүнийг илрүүлэх, шалгах, мөрдөх үйл ажиллагаа нь харилцан уялдаатай байдаг. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг нийгмийн үзэгдлийнхээ хувьд түүний хүрсэн түвшин гарал үүслээрээ үүсэн бий болох, өөрчлөгдөх (үгүй болох эсхүл үгүйсгэгдэх) үе шатлалтай гэж үзвэл үүнийг дагаж гэмт хэргийг мөрдөх тэрхүү зүй тогтол харилцан хамааралтай байна.

Энэхүү хамаарлыг социодинамикийн үүднээс авч үзвэл хөгжлийнхөө дээд эрэмбэ руу буюу энгийнээс илүү нарийн руу чиглэсэн тасралтгүй хөгжих нөгөөтэйгүүр аажмаар өөрчлөгдөн хувьсаж байдаг зүй тогтол юм.

Үндсэн хэсэг. Нийгмийн хөгжил хөдөлгөөний үйл явцад тасралтгүй хөгжиж ирсэн бүхий л үзэгдэл юмсыг дагалдаж ямагт түүний сүүдэр болох гэмт хэрэг, зан үйл энэхүү цаг үеийг хүртэл тасралтгүй орон зайгаа үлдээж хадгалсаар байна. Хүн төрөлхтөн бий болж оршин тогтнох үеэс эхлэн өдийг хүртэл нийгмийн хөгжил хөдөлгөөний

[1] Төрийн мэдээлэл. 2012. №24. Инновацийн тухай хууль

үйл явц хөгжин өөрчлөгдөж ирсээр байна.

Аливаа нийгэмд төр нь хүчтэй байж иргэдийнхээ эрхийг хамгаалж улс үндэстнийхээ аюулгүй байдлыг хангадаг нь зүй билээ. Хүчтэй төр оршин тогтнохын нэг үндэс бол цэрэг, цагдаа, хууль сахиулах байгууллагууддэлхийн стандартад нийцсэн орчин үеийн техник технологийн дэвшилтийгхэрэглэн үйл ажиллагаагаа мэргэжлийн өндөр түвшинд тасралтгүй явуулах баталгаа юм.

Дэлхийн улс орнуудын цагдаа, хууль сахиулах байгууллагуудүйл ажиллагаандаа шинжлэх ухаанд суурилсан инновацийг нэвтрүүлж улсынхаа үндэсний аюулгүй байдлыг ханган хамгаалах болжээ.[2]

АНУ-д 1980-1990 онуудад боловсруулсан инновацийг өнөөг хүртэл хөгжүүлэн хэрэглэж байна. XIX зуун болон XX зууны эхэн үед Америкийн хууль сахиулах байгууллагын ажилтнууд үндсэндээ улс төрийн үйлчилгээний ажилтнууд байсан ба тэдэнд эрүүгийн хуулийн болон иргэний эрхийн мэдлэг хязгаарлагдмал байсан байна Цагдаагийн инновацийг АНУ-ын эрдэмтэд (Мооре, Спелман нар):

- Хөтөлбөрийн;
- Захиргааны;
- Технологий;
- Стратегийн гэж ерөнхий байдлаар 4 ангилсан байна.

Хөтөлбөрийн инноваци нь цагдаагийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хийгдэж байгаа төрөл бүрийн хөтөлбөрүүд тухайлбал, “хагархай цонх” /broken windows/хөтөлбөр, “хөршийгөө харах” /neighborhood watch/ хөтөлбөр, сургуулийн насныханд хар тамхиний хор хөнөөлийн талаар сургалт явуулах хөтөлбөр, насанд хүрээгүйчүүдэд хорих ангийн бодит байдлыг мэдүүлэх ажиллагаа зэрэг.

Захиргааны инноваци нь цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа өөрсдийгөө хэрхэн бэлтгэх, ололт амжилтаа тооцоолох зэргийн өөрчлөлт шинэчлэл байдаг. Цагдаагийн хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах, түүнийг үнэлэх, түүнчлэн шинэ технологи, сургалт зэргээр дадлагажуулах зэрэг нь багтдаг байна.

Технологийн инноваци гэдэгт цагдаагийн хөнөөлт бус зэр зэвсэг, эдлэл хэрэглэл, ДНК-ийн шинжилгээ болон гэмт хэргийн цахим зураглал хийх зэргийг шинэчлэх асуудал хамаардаг. Технологийн инноваци нь мэдээлэлд суурилсан технологи(soft) болон материалд суурилсан технологи (hard) гэсэн 2 хэлбэртэй байдаг.

АНУ-д технологийн инноваци асар хурдтай хийгдэж байгаа бөгөөд софт хэлбэрийн инновациудын хувьд компьютерийн шинэ программ хангамж, ангилалын систем, гэмт хэргийн анализ хийх техник, (Компстат) баримт мэдээ болон системийн холбооны техник, түүнчлэн материалд суурилсан технологийн хувьд хурууны хээний бүртгэл, гар утасны мэдээлэл хадгалах тусгай төв, цагдааг хамгаалах хэрэгсэл зэрэг (хүрэм, сум нэвтэрдэггүй хантааз, цагдаагийн машин гэх мэт) байдаг байна.[3]

[2] Б.Одонгэрэл “ АНУ дахь цагдаагийн инноваци, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал, түүнээс суралцах нь” Хууль сахиулахуйн инноваци ОУЭШХ 2014 он 173 дахь тал.

[3] Жеймс Бирне. Гарри Маркс “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон цагдаагийн үйл ажиллагаан дэхь технологийн инновацийн хэрэгжилт, үр нөлөөний судалгаа”. 2011 он

Стратегийн инноваци гэдэгт цагдаагийн албан хаагчид үйл ажиллагаагаа явуулах зорилго, арга барил, боловсруулах асуудал, түүнд хүрэх шийдэл, гарах үр дагавар зэрэг хамаардаг. Нэг ёсондоо боловсруулах боловсруулалт.

Монгол Улсад цагдаагийн инноваци хийх хэрэгцээ, шаардлага:

Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хуульд Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн гэж тодорхойлсон байдаг. Цагдаагийн байгууллагад олон жилийн турш уламжлалаа хадгалсан шинэчлэл хийгдсээр байгаа ч шинжлэх ухаан, судалгаанд суурилсан томоохон инновациудыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Цагдаагийн албаны тухай хуулийн тавдугаар бүлэгт цагдаагийн алба хаагчид биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болох үндэслэл журмыг хуульчилсан нь Монгол Улсын цагдаагийн байгууллагад албадлага хэтрүүлэхгүйгээр хэрэглэж, цагдаагийн алба хаагчид гэмт халдлагаас өөрсдийгөө болон бусдыг хамгаалах эрх зүйн орчин бий болсон явдал юм.

Монгол улсад нийгэм, эдийн засаг өөр бусад хүчин зүйлсээс шалтгаалан гэмт хэргийн тоо өсөн нэмэгдэж ард иргэдийн цагдаад итгэх итгэл, тэднийг үнэлэх сэтгэл хангамж сул байгаа нь 1960 оны АНУ-ын цагдаагийн байгууллага шинэчлэл хийх үндэслэл болсон шалтгаантай адил байгааг харуулж байна.

Одоо үед гадаадын болон дотоодын зарим судлаачид Монгол Улсын цагдаагийн байгууллагад мэргэжлийн болон технологийн шинэчлэл хийснээр үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, шуурхай хүргэх үндсэн нөхцлийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Тийм учраас цагдаагийн байгууллагад шинэчлэл хийхийн тулд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр технологийн инноваци нэвтрүүлэх шаардлагатай байна.

Манай улсын хуулийн салбарт дутагдаад байгаа нэг зүйл бол цагдаагийг байгууллагын үйл ажиллагааг батлан хамгаалахболон аюулгүй байдлын салбарын үйл ажиллагаанаас ангид ойлгох үзэл суртал юм.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа нь эцсийн зорилгодоо Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдыг хангах ажиллагаатай хүйн холбоотой зүйл юм.[4]

Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн[5] хэмээн заасан нь цагдаагийн байгууллагынүйл ажиллагаа нь улс орныг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай холбогдох төрийн эрүүгийн бодлогын агуулга чиглэлийг баталгаажуулж байгаа тодорхойлолт юм.

Ерөнхийдөө зарим хүн цагдаагийн байгууллагын асуудлыг

[4] Ч.Баатар Хууль сахиулахуйн инноваци, аюулгүй байдал хамгаалалтын үйл ажиллагааны тулгамдсан зарим асуудал

[5] Монгол улсын үндсэн хууль 11-р зүйл.

хэлэлцэхэд зэвсэг,техник ямар хамаатай юм гэсэн байр сууринаас хандаж магадгүй. Энэ нь ташаа ойлголт болох бөгөөд цагдаагийн байгууллагын үйл ажиллагаагаа нь тэмцлийн шинж чанартай, хуулиар эрх олгогдсон зэвсэг, техник ашиглаж төрийн хуулийг сахиулдагт гол учир шалтгаан нь байгаа юм.

Цагдаагийн алба хаагч хууль сахиулах үйл ажиллагаанд өдөр тутамд зайлшгүй зарим технологийг хэрэглэх шаардлага тулгарч байна.Тухайлбал:

1. Цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдал, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхтэй холбоотой тусгай хэрэгсэл буюу цагдаагийн алба хаагчийн агсамж шаардлага хангаагүй байгаа нь практикт өдөр тутамд мэдрэгдэж байна. Цагдаагийн байгууллагаас 2016 онд цагдаагийн алба хаагчийн тусгай хэрэгсэл, аюулгүй байдалтай холбоотой судалгаанд нийт 4935 алба хаагч оролцсон санал асуулгад цагдаагийн алба хаагчдын үйл ажиллагаандаа хэрэглэдэг тусгай хэрэгсэл хангалтгүй гэсэн дүгнэлт өгчээ. Ийм дүгнэлтэд хүрэх болсон үндэслэл нь нийт 34 төрлийн техник хэрэгслээр 30 хүрэхгүй хувь нь хангагдсан, 50 гаруй хувь нь зарим төрлийн техник хэрэгсэл огт байхгүй, 10 орчим хувь хангалт хийгдээгүй байгаа гэж дундаж үнэлгээ хийжээ.

Цагдаагийн албаны тухай хуулийн Тавдугаар бүлэгт[6] Цагдаагийн алба хаагч цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болногэж заасан.Харин практикт гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай техник, технологи хангалтгүй байгаа нь харагдаж байна.

2. Шинэ санаа, технологийг хэрэгжүүлэх мэдлэг чадвар бүхий алба хаагч “технологи”

Техник технологийн санаачлагыг цагдаагийн байгууллагынүйл ажиллагаанд богино хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх ажлын гол үндсэн хүч бол цагдаагийн алба хаагчид юм. Ийнхүү шинэ санаа, технологийг хэрэгжүүлэх мэдлэг чадвар бүхий алба хаагчийг бий болгоход бодлого,сургалт,мэдээллийн сүлжээ,хүрээг зөв тодорхойлох хэрэгтэй. Энэ чиглэлээр бодлого боловсруулж, сургалт явуулж, мэдлэгийг бүтээснээр чадвар бүхий алба хаагч бэлтгэгдэх нь гарцаагүй юм.

Иймд цагдаагийн байгууллага үйл ажиллагаандаа шинэчлэл хийх ажлыг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж, гэмт хэрэгтэй тэмцэх,олон нийтийн аюулгүй байдлыг хангах,нийтийн хэв журмыг хамгаалахүйл ажиллагаандаа Secure alert буюу цахим хянагч электрон гав, полиграф, GPS, Comp stat,Crime mapping, CCTY,хэргийн газарт ашиглах зөөврийн тоног төхөөрөмж зэрэг орчин үеийн смарт системүүдийг нэвтрүүлж ашиглах зэргээр хууль сахиулах салбарт техник технологийн шинэчлэл инноваци хийх шаардлагатай гэж үзэж байна.[7] Үүнд:

Английн цагдаагийн байгууллагын нэвтрүүлсэн CCTV буюу хяналтын системийг өөрийн улсдаа нэвтрүүлж энэхүү системийн тусламжтайгаар үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэх үйл ажиллагаандаа ашиглаж болохоор юм.

[6] Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

[7] Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2013. №4

Английн цагдаагийн байгууллага хяналтын систем ашиглаж тухайн үед үйлдэгдсэн гэмт хэргийн 90% илрүүлж чадаж байна. Энэхүү үйл ажиллагаандаа “Поли фейс” системийг давхар ашиглаж байна.

Нийслэл болон аймаг орон нутагт камерын хяналтын системийг бүрэн ашиглаж,хяналтын төв байгуулж үйл ажиллагааны обьектоо хяналтандаа авч болно.[8] Иймээс энэхүү хяналтын камерийг зөвхөн хувийн болон бусад үйл ажиллагаа явуулж байгаа газар бус цагдаагийн алба давхар хянах хэрэгтэй байна.

Хяналтын камерын тодорхой нэг пост гаргаж чадсанаар дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Гэмт хэрэгтэнг эрж хайхад үрэгддэг үнэт цаг хугацаа, зардал хэмнэгдэнэ.

2. Иргэний амьд явах эрх болон аюулгүй орчинд амьдрах эрх баталгаажина.

3. Гэмт хэргийн гаралт багасч, олон нийтийн гудамж талбайд үйлдэгддэг танхай, дээрэм, хулгай бусад гэмт хэрэг багасна.

4. Цагдаагийн алба хаагчдын амрах цаг бага боловч нэмэгдэнэ.

5. Цагдаагийн байгууллагын нэр хүнд өсөж жинхэнэ утгаараа хяналтыг бий болгож чадна.

6. Гэмт хэргийн илрүүлэлтийн хувь нэмэгдэх зэрэг олон ач холбогдолтой болно.

Мөн гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийдэг Comp.Stat загварыг өөрийн орны цагдаагийн байгууллагад нэвтрүүлж гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцөл, стратегийн ач холбогдолтой асуудлыг шийдвэрлэх, тодорхой үйл ажиллагаанд анализ хийх, гэмт хэргийн гаралт, төрөл, гэмт хэрэг гарсан цэг бусад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлоход ашиглагдаж байгаа мэдээ мэдээлэл, түүний үнэн зөв эсэхийг цаг хугацаанд нь дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэх юм.

Анх 1994 онд АНУ-н Нью-Йорк хотод цагдаагийн комиссар Уильям Браттон цагдаагийн хэлтсийн мэдээлэлд суурилсан удирдлагын загварыг танилцуулсан бөгөөд энэхүү загвар нь АНУ даяар маш хурдан тархаж энэ нь гэмт хэрэг бууруулахад чиглэсэн орчин үеийн менежментийн загвар болж чадсан байна.[9]

Хамгийн амархан ашиглах боломжтой стандарт, чанарын шаардлагыг хангасан цахим хяналтын төхөөрөмж нь АНУ-н Secure Cuff технологи юм.[10]

АНУ-д гэмт хэрэг үйлдсэн болон гэрийн хориond байгаа этгээдийг шүүхийн тогтоолоор GPS төхөөрөмж хосолсон цахим хяналтын төхөөрөмжийг ашиглан хугацаатай мөрдөх , мөрдлөгийн явцад гарах зардлыг тухайн этгээдээр өөрөөр нь төлүүлж хянадаг байна.

Энэхүү хяналтыг АНУ-н газар нутаг дээр хүчин төгөлдөр үйлчилдэг хуулийн дагуу гэмт этгээдээр өөрийг нь хянах хоног тутамд хэрэглэх цагийн хураамжийг нь хяналтын компанид төлүүлж тухайн компани нь уг этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах замаар хамтарч ажилладаг байна.[11]

Ардчилсан нийгэмд Үндсэн хуулиар хүний эрх эрх чөлөөг дээдлэн

[8] Г.Бямбадорж“Цагдаагийн байгууллагын шинэчлэл” өгүүлэл-УБ,2014
[9] http://www. Compstat.umd.edu
[10] www.securerealert.com/securecuff./
[11] www.securealert.com/securecuff/

баталгаажуулснаар хүний хөгжлийг эрхэм зорилго болгож баривчлах, хорих ялыг иргэнд үр нөлөөтэй нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэх нөгөө талаас гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх , нийгмийн дэг журмыг сайжруулах, иргэдийн амьдрах аюулгүй, амар тайван орчинг бүрдүүлэх явдал юм.[12]

Цагдаагийн алба гэмт хэрэгтэй тэмцэх шилдэг 5 технологи (cool cop tech: 5 new technologies helping police fight crime)

АНУ нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, үндэсний аюулгүй байдлаа хангах үйл ажиллагаандаа дэвшилтэд 5 төрлийн технологи түлхүү ашигладаг бөгөөд АНУ судлаач Todd R.Weiss үзэж байгаагаар "...тэдгээр нь зөвхөн хувь хүн-бие цагдаагийн шаардлага хангасан технологи биш, бүх улсын цагдаагийн оффицеруудад хэргийг мөрдөх болон шийдвэрлэхэд зориулсан өндөр технологи бүхий зэр зэвсэг байдаг" гэжээ. Эдгээр технологийг тус тусад нь авч үзвэл:

- It's flying police drone! (нисдэг цагдаа буюу удирдлагатай нисдэг камер)
- GPS vehicle pursuit darts: A cautionary tale (GPS буюу байршил тогтоогч сум)
- Gunshots tell a story, if you pay attention (хурд хэмжигч буу)
- Need to see what's happening? Toss in a robotic camera (робот камер)
- Tablets aren't just for writing speeding tickets anymore (олон үйлдэлт таблет)

Харин эдгээр 5 төрлийн технологиос Монгол Улсад ашиглах боломжтой талаас нь судалж үзсэний үүднээс "Таблет" шинэлэг технологийн шийдлийг тусгах нь ач холбогдол нь илүү юм гэж үзэж байна.

Сүүлийн жилүүдэд Apple компанийн IPads болон бусад таблетуудыг АНУ гэлтгүй бусад өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнуудын цагдаагийн газар хэлтсүүдэд ашиглах болсон бөгөөд цагдаагийн ажлыг улам хялбар болгож чадсанаар тэдний хэрэглэх дуртай нэн чухал дэвшилтэт технологийн хэрэгсэл болж байна.

АНУ-ын цагдаагийн албан хаагчдын дунд судалгаагаар Ipad нь:

1.Суурин компьютер болон зөөврийн компьютерээс жижиг, хурдан шаламгай ажиллахад хялбар бөгөөд гадуур ажил үүргээ гүйцэтгэж явахдаа давхар дотоод бичих, шивэх ажлаа гүйцэтгэх боломжтой.

2.Хийж болох үйлдлүүд хязгаарлагдах боломжгүй өргөн хүрээтэй бөгөөд хүссэн зүйлээ татаж суурилуулах боломжтой.

3.Хэргийн газар болон гэмт хэрэгтний мэдээллийг заавал хэлтэс, архив, лавлагааны газар очиж авах шаардлагагүй ба хэдэн км зайнаас ч хүссэн мэдээллээ авах бусад албан хаагчидтай солилцох боломжийг олгодог.

4.Ipad нь интернэтээс хүссэн мэдээллээ цуглуулах, өөрийн болон бусдын газар зүйн байрлалыг мэдэх боломжтой бөгөөд дотор эд ангидаа ялтасан чиптэй учир цагдаагийн алба хаагчид аюул осол тохиолдсон үед хэлтэс хэсэгтээ мэдэгдэх боломжтой гэх мэт давуу талууд их болох нь харагдаж байна.

[12] Ш.Чулуун "Монгол Улсын хууль сахиулах үйл ажиллагаанд цахим хянагч /электрон гав /-ыг ашиглах хэрэгцээ шаардлага, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал" илтгэл-Уб. 2016

Биометриксийг өнөөгийн чиг хандлага цагдаагийн алба болон бусад салбарт хэрхэн ашиглаж болох. Энэхүү сэдвийн дараагийн үндсэн агуулга бол биометриксийг цагдаагийн албаны үйл ажиллагаатай хэрхэн холбож чадах вэ? гэдэгт тулгуурлалаа.

Орчин үеийн технологийн хөгжлийн үр дүнд төрөл бүрийн техник хэрэгслийг зохион бүтээж өндөр хурдаар чухал мэдээллийг бидэнд олгосноор амьдралыг илүү хялбар болгож байна.[13]

Аливаа технологийн инноваци нь түүний хэрэглэгчдэд нуугдмал аюул учруулдаг. Үүнээс урьдчилан сэргийлэх үүднээс нууц үг, нэвтрэх карт ашигласаар ирсэн боловч нууц үг, картаа алдах эсхүл бусад этгээдүүд хуурамчаар дуурайлган хийж хууль бусаар бусдын халдашгүй эрх эрх чөлөөнд нэвтрэх явдал гарсаар байна. Тиймээс кибер аюулгүй байдлыг сайжруулах үйл явц нь “Биометрикс”-ийг бий болгоход хүргэсэн.

1.**Гарын хээний биометрик fingerprint biometrics -** Энэ нь хамгийн анх ашиглагдаж ирсэн бөгөөд хөгжлөөрөө нилээд өндөр түвшинд хүрсэн. Гарын хурууны хээний битүү, гогцоо, нуман гэсэн 3 үндсэн бүлэгт нь хуваагддаг гарын арьсны бичил товгорууд дээр онцлог цэгүүдээр харьцуулан хүний дахин давтагдашгүй шинж байдлыг илтгэдэг. Манай улсад энэ технологийг 11 төрлийн лавлагаа авах түц машинд хэрэглэгдэж байна.

2.**Нүдний солонголог бүрхэвчийн биометрик Iris biometrics -** Энэ нь хүний нүдний урд хэсэг хүүхэн харааний эргэн тойронд байдаг солонголог бүрхэвчийн зураглалыг сканердеж санд бүртгэгдсэн бусад зураглалуудтай харьцуулдаг. Маш хялбар хурдтай бас үр дүн сайтай.

3.**Дүр төрх таних биометрик face recognition -** Сүүлийн үед өргөн тархаж байгаа биометрескийн нэг төрөл бөгөөд хүний нүүрний нүд, хамар, уруул зэрэг эрхтэнүүдийн хэмжээ,байрлал, харилцан адилгүй дахин давтагдашгүй бөгөөд зайнаас шууд харьцуулалт хийж болох хамгийн хялбар биометрикс юм.

4.**ДНХ-н биометрик (DNA biometrics) -** Энэ төрөл нь хамгийн найдвартай харьцуулалтыг гаргадаг боловч цаг хугацаа их зарцуулдаг, хөрөнгө шаардлагатай, заавал хүнээс дээж авдгаараа хууль сахиулах байгууллагаас бусад олон нийтэд тэр бүр хэргэлдэггүй.

5.**Дуу авианы адилтгал (voice recognition)** - Хүний дуу авиа нь хувь хүнд онцлог байдаг бөгөөд шүүх шинжилгээнтий практикт 1980-аад оноос туршиж нэвтрүүлсэн байна. Сүүлийн жилүүдэд хувийн секторт мөн ашиглаж эхэлсэн байна.

6.**Гарын үсгийн биометрикс (signature biometrics) -** гар бичмэл гарын үсгийг шүүх шинжилгээний практикт олон жил өргөнөөр ашиглаж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд гарын үсгийг харьцуулдаг биометрик шинээр гарч ирээд хувийн секторт илүү ашиглаж байна.

7.**Гарын геометрээр таних (hand biometrics)** - Хүний гарын геометрийн хэмжээсүүдийн онцлог байдал бөгөөд энэ хэмжээсүүдээр биометрикийн адилтгалыг хувийн секторт түлхүү ашигладаг болсон байна.

[13] Б.Батмягмар “Биометриксийн өнөөгийн байдал чиг хандлага” илтгэл.Уб.2014

Биометрикс нь цаашдаа улам боловсронгуй болж хүний үнэр, хүний биеийн шингэн, ДНК, чихний хэлбэр, тархины бичлэг зэрэг шинэ төрлүүд гарч ирэн хөгжих хандлагатай байгаа билээ.

Харин энэхүү төхөөрөмжүүд нь аль хэдийн манай улсын хөрсөн дээр бууж чадсан ба яг одоогоор цагдаагийн алба болон бусад хууль сахиулах үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад хэвийн үйл ажиллагаагаа илүү боловсронгуй болгоход инновацийн шийдлүүдийг өргөнөөр ашиглах хэрэгтэй байна.

ДҮГНЭЛТ. Цагдаагийн албаны үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, цагдаагийн алба хаагчийг үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэх, зөвхөн албаны чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор зайлшгүй тохиолдолд хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд хүний эрх, эрх чөлөөнд халддаг байх болон хуулийг хэрэгжүүлэх явцад гарч буй бусад хүндрэл бэрхшээлийг арилгах шаардлага тулгарч байна.

Өнөөдөр нийгмийн сэтгэлгээ өөрчлөгдөж, иргэдийн хууь эрх зүйн мэдлэг нэмэгдэхийн хэрээр техник технологийн хөгжлөө дагаад гэмт хэрэг, зөрчил шинэ түвшинд гарч байгаа нь тулгамдсан асуудал болж байна.

Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд дэлхийн улс орнуудын цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрээд тодорхой үр дүнд хүрсэн, дэвшилтэд шинэ техник технологи, инновацийн санаануудыг өөрийн оронд нэвтрүүлэх нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, шуурхай шийдвэрлэхэд үр дүнтэй тул нэн даруй судалгаа хийж нэвтрүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулах шаардлага тулгарч байна.

САНАЛ. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цахим хяналтын төхөөрөмжийг ашиглах стандарт, аргачлалыг боловсронгуй болгох
2. Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд холбогдох хууль эрх зүйн таатай орчин бий болгох.
3. Шинэ техник, технологийг сургалт, эрдэм шинжилгээний нэгдсэн төв лаборатори байгуулж түүндээ иж бүрэн туршилт, судалгаа хийх замаар практикт нэвтрүүлэх
4. Байгууллага руу нэвтрэх, мэдээллийн санг ашиглах зэрэг нууцлалтай холбоотой үйл ажиллагаандаа биометриксийг нэвтрүүлэх үүнд цагдаагийн алба хяналт тавьж ажиллах
5. Дүр төрх таньдаг, хурууны хээгээр мэдээлэл олгодог үйлчилгээг үйлчилгээний бүхий л салбаруудад өргөнөөр нэвтрүүлэх

Ашигласан материал

Монгол Улсын хууль тогтоомж

1. Монгол улсын Үндсэн хууль
2. Инновацийн тухай хууль
3. Цагдаагийн албаны тухай хууль

Судалгааны ажил:

4. Жеймс Бирне. Гарри Маркс “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон цагдаагийн үйл ажиллагаан дэхь технологийн инновацийн хэрэгжилт, үр нөлөөний судалгаа”. 2011

5. Х.Мэндээ “Цагдаагийн албан хаагчийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалыг боловсронгуй болгох асуудал” Уб. 2013 Магистрын ажил.

6. Б.Одонгэрэл “АНУ дахь цагдаагийн инноваци, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал, түүнээс суралцах нь” Хууль сахиулахуйн инноваци ОУЭШХ-н эмхэтгэл. Уб. 2014

Сонин, сэтгүүл:

7. Төрийн мэдээлэл. 2012. №24.

8. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2013. №4

9. Төрийн мэдээлэл. 2017. №8.

Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл

10.Г.Бямбадорж “Цагдаагийн байгууллагын шинэчлэл” /өгүүлэл/. Уб.2014

11.Б.Батмягмар “Биометриксийн өнөөгийн байдал чиг хандлага” /илтгэл/ Уб.2014

12.Ч.Баатар Хууль сахиулахуйн инноваци, аюулгүй байдал хамгаалалтын үйл ажиллагааны тулгамдсан зарим асуудал

13.Д.Булган “Цагдаагийн байгууллагын хууль сахиулах инноваци” /илтгэл/ Уб.2015 Ш.Чулуун “Монгол Улсын хууль сахиулах үйл ажиллагаанд цахим хянагч /электрон гав /-ыг ашиглах хэрэгцээ шаардлага, эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” /илтгэл/. Уб.2016

Цахим эх сурвалж:

14.http://www. Compstat.umd.edu

15.www.securerealert.com /securecuff.

16.http://www.computerworld.com

17.@TechManTalking

АЖИЛ ОЛГОГЧДООР ТӨГСӨГЧИЙГ ҮНЭЛҮҮЛСЭН СУДАЛГАА: ДХИС-ИЙН УДИРДЛАГЫН АКАДЕМИЙН ЖИШЭЭН ДЭЭР

THE STUDY OF EVALUATION ON GRADUATES BY EMPLOYERS: THE CASE OF EXECUTIVE LEADERSHIP ACADEMY AT UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS, MONGOLIA

Д.Сундуйсүрэн
ДХИС-ийн УА-ийн Удирдахуйн ухааны профессорын профессор, доктор цагдаагийн хурандаа
Sunduisuren.D
Ph.D, Professor of Management team of management for the Executive Leadership Academy of the University of Internal Affairs, Mongolia, police colonel.
Ц.Амгаланбаяр
ДХИС-ийн УА-ийн Удирдахуйн ухааны профессорын дэд профессор, доктор, бригадын генерал
Amgalanbayar.Ts
Ph.D, Sub professor of management team of Executive Leadership Academy of the University of Internal Affairs, Mongolia, brigade general
Ц.Баясгалан
ДХИС-ийн УА-ийн Удирдахуйн ухааны профессорын багийн ахлах багш, доктор, дэд профессор, ахлах дэслэгч
Bayasgalan.Ts
Ph.D, A Senior lecturer of management team of Executive Leadership Academy of the University of Internal Affairs, Mongolia, senior Lieutenant

Хураангуй: Бид ДХИС-ийн Удирдлагын академийн төгсөгчдийн ур чадварыг ажил олгогчид хэрхэн үнэлж буйг их сургуульд нэвтрүүлж буй ISO9001:2016 стандартын шаардлагыг хангах байдалд тулгуурлан судаллаа. Бидний судалгаанд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллагын удирдах ажилтан, ажил олгогчид хамрагдсан. Судалгаагаар сэтгэл ханамжийн онолын болон практикийн асуудлыг авч үзэн өгөгдлийг Smart PLS 3.0, SPSS-23.0 программ хангамжаар шинжилсэн.

Түлхүүр үгс: мэдлэг, ур чадвар, удирдах ур чадвар, ажил олгогчдын сэтгэл ханамж, Дотоод хэргийн их сургууль (ДХИС)

Abstract: The aim of this study is to provide an overview of the importance of alumni's skills how assessed through employers' satisfaction. We attempt to evaluate the employer satisfaction of alumni from the Executive Leadership Academy at University of Internal Affairs, Mongolia. We are implementing ISO9001:2016 during this academic year in the UIAM. Our study was significant in considering both theoretical and practical issues and for practices in University of Internal Affairs, Mongolia /UIAM/. Data were estimated by Smart PLS 3.0 and SPSS-23.0 software and Cronbach's alpha index have been used for data analysis and reliability analysis of the questionnaire, respectively.

Key words: knowledge, skills, employers' satisfaction and University of Internal Affairs, Mongolia (UIAM).

Судлах үндэслэл, судлагдсан байдал

Дэлхий дахинаа 1980, 1990-ээд онд төрийн удирдлага, боловсролын салбарын хамтын ажиллагаа хурдацтай өсөж, чанараар өрсөлдөх хандлага зонхилж байна.

Дээд боловсролын салбарт чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлснээр тухайн боловсролын байгууллагын үйл ажиллагааг оролцогч, сонирхогч талуудтай холбон хамтран ажиллах шаардлага зүй ёсоор тулгардаг. Иймээс олон улсын эрдэмтэд ISO 21001:2018 стандартыг боловсролын салбартай уялдуулан дараах байдлаар судалсан байна. Үүнд:

Эрик Вибисоно (2019), “ISO21001:2018 удирдлагын тогтолцоог боловсролын байгууллагуудад хэрэгжүүлэх нь” судалгааны ажилдаа зарим улс орнууд энэхүү тогтолцоог хэрхэн нэвтрүүлсэн туршлагын талаар харьцуулсан судалгаа хийсэн. Мөн судалгааныхаа ажлаар зөвхөн боловсролын байгууллагад хэрэгждэг стандартыг дангаар хэрэгжүүлэхээс илүүтэй бусад стандарттай хамт нэвтрүүлснээр амжилтад хүрсэн бодит жишээг эшлэл болгосон.

Нуно Мелао (2012), “Боловсрол дахь ISO 9001 стандартын нөлөөлөл ба амжилтын хүчин зүйлүүд: Португалийн мэргэжлийн сургуулиудын туршлага” судалгааны ажлаараа ISO9001:2015 чанарын менежментийн тогтолцоог боловсролын салбарт хэрхэн хэрэгжүүлсэн талаар TQM -Total Quality Management ба Чанарын удирдлагын талаар боловсролын салбарт боловсролын үр ашиг, боловсролын чанар, хариуцлагын асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа талаар дэлгэрэнгүй судалсан. Судалгааны ажлын дүгнэлтээр, Португал Улсын мэргэжлийн сургуулиудад ISO 9001:2000 стандартын давуу тал, сул тал, амжилтын хүчин зүйлсийг бодит кейс судалгаагаар батлан загварчлал санал болгосон.

Дээрх эрдэмтдийн судалсан судалгааны ажлаас харахад, чанарын менежментийн тогтолцоог аль аль нь хамтад нь судалсан байна.

Бид энэхүү судалгааны ажлаараа, хэрэгжүүлж буй хөтөлбөрийн оролцогч, сонирхогч талын хамтын ажиллагаа, тэдний сэтгэл ханамжийг онцлон судалсан. Ингэхдээ төгсөгчдийн ур чадвар, харилцаа, мэдлэг, ажилдаа тууштай хандах удирдлагын арга барилыг ажил олгогчид хэрхэн үнэлэхийг таамаглан загвар боловсруулсан.

Загвар 1. Ажил олгогчдын сэтгэл ханамжид нөлөөлөх нөлөөлөл



Тайлбар: Судлаачдын санал болгож буй загвар

Т1: Төгсөгчдийн ур чадвар ажил олгогчдын сэтгэл ханамжид эергээр нөлөөлнө.

Т2: Төгсөгчдийн харилцаа нь ажил олгогчдын сэтгэл ханамжид эергээр нөлөөлнө.

Т3: Төгсөгчдийн мэдлэг нь ажил олгогчдын сэтгэл ханамжид эергээр нөлөөлнө.

Т4: Төгсөгчдийн мэргэжлийн ур чадвар нь ажил олгогчдын сэтгэл ханамжид эергээр нөлөөлнө.

Дотоод хэргийн их сургуулийг төгссөн төгсөгчид өөрсдийн ур чадварт ямар үнэ цэнээр хандаж байгааг судлах зорилгоор “Хууль сахиулах удирдлага” магистрын хөтөлбөрийн төгсөгчдийг судалгаандаа хамруулсан.

Судалгааны арга зүй, үр дүн:

Бидний судалгаа бол учир шалтгааныг тодорхойлох хайгуулын судалгаа тул таамаглал болгон дэвшүүлж буй хувьсагчдын хоорондын шалтгаан-үр дагаврын хамаарлыг судалсан нь онцлог болсон. Коппер (1998), учир шалтгааны судалгаа нь загварчлалд тулгуурладаг гэж тодорхойлсон. Хуссей (1997) хувьсагчдыг судалж, тодорхой тэдгээрийн хоорондын шалтгаан-үр дагаврын хамаарлыг тогтоож болох боломжийг хайх гэсэн бол Зикмунд (2003), уг судалгааг чанарын судалгааны дараагийн алхам руу шилжихээс өмнө асуудлын мөн чанарыг судлахаар төлөвлөж буй судалгааны ажлын суурь гэж тус тус тодорхойлсон.

Бид судалгааны асуумж хэмжихдээ Лайкертын хэмжээсийг ашигласан. Энэхүү хэмжээс нь асуулт туст оролцогчид өөрийн үнэлэмжээр хэрхэн санал нийлэх, санал нийлэхгүй байгаа төвшинг хэмжихэд онооны шатлал ашигладаг. Онооны шатлал нь сонголтыг илүү хязгаарлан хянадаг тул бид судалгаандаа таван онооны шатлалыг ашигласан. Судалгааны ажлын боловсруулалтыг SPSS 25.0 болон SmartPLS-3.0 программ хангамжийг ашиглан хувьсагч бүрийн дотоод найдвартай байдал, нийцтэй байдал, хамаарал, замын шинжилгээгээр таамаглалыг шалгасан.

Манай судалгаанд 216 оролцогчид оролцон хувьсагч бүрийг үнэлсэн.

Загвар 2. Ажил олгогчдын сэтгэл ханамжийн бүтцийн шинжилгээний үр дүн



Тайлбар: SK-төгсөгчдийн ур чадвар, CO- төгсөгчдийн харилцаа, KN-төгсөгчдийн мэдлэг, SkLe- төгсөгчдийн удирдах арга барил, SAT-Ажил олгогчдын сэтгэл ханамж

Хүснэгт 1а. Хэмжил зүйн шинжилгээ / төгсөгчдийн ур чадвар/

ITEMS	Codes	Factor analysis	Cronbach's Alpha	Composite reliability	AVE
Alumni's skills	SK-1	**0.924**	**0.939**	**0.956**	**0.845**
	SK-2	**0.923**			
	SK-3	**0.915**			
	SK-4	**0.916**			

тайлбар: SK-төгсөгчдийн ур чадвар

Төгсөгчдийн ур чадварыг хэмжихэд 4 далд хувьсагч 0.915-0.924, Кронбах альфа 0.939, нийлмэл найдвартай байдал 0.956, дундаж хэлбэлзэл 0.845 байна.

Хүснэгт 1б. Хэмжил зүйн шинжилгээ / төгсөгчдийн харилцаа/

Alumni's communication	CO-1	**0.899**	**0.920**	**0.943**	**0.806**
	CO-2	**0.900**			
	CO-3	**0.895**			
	CO-4	**0.897**			

тайлбар: CO- төгсөгчдийн харилцаа

Төгсөгчдийн харилцааг хэмжихэд, 4 далд хувьсагч 0.895-0.900, Кронбах альфа 0.920, нийлмэл найдвартай байдал 0.943, дундаж хэлбэлзэл 0.806 байна.

Хүснэгт 1в. Хэмжил зүйн шинжилгээ / төгсөгчдийн мэдлэг/

Alumni's knowledge	KN-1	**0.871**	**0.900**	**0.930**	**0.770**
	KN-2	**0.909**			
	KN-3	**0.906**			
	KN-4	**0.821**			

тайлбар: KN- төгсөгчдийн мэдлэг

Төгсөгчдийн мэдлэгийг хэмжихэд, 4 далд хувьсагч 0.821-0.909, Кронбах альфа 0.900, нийлмэл найдвартай байдал 0.930, дундаж хэлбэлзэл 0.770 байна.

Хүснэгт 1г. Хэмжил зүйн шинжилгээ /төгсөгчдийн удирдах арга барил/

Alumni's managerial skills	Skle-1	**0.922**	**0.938**	**0.956**	**0.770**
	Skle-2	**0.906**			
	Skle-3	**0.939**			
	Skle-4	**0.906**			

тайлбар: SkLe- төгсөгчдийн удирдах арга барил

Төгсөгчдийн удирдлагын ур чадварыг хэмжихэд, 4 далд хувьсагч 0.906-0.939, Кронбах альфа 0.938, нийлмэл найдвартай байдал 0.956, дундаж хэлбэлзэл 0.770 байна.

Хүснэгт 1д. Хэмжил зүйн шинжилгээ /ажил олгогчдын сэтгэл ханамж/

Employers' satisfaction	SAT-1	0.921	0.937	0.952	0.798
	SAT-2	0.911			
	SAT-3	0.931			
	SAT-4	0.864			
	SAT-5	0.834			

тайлбар: SAT-Ажил олгогчдын сэтгэл ханамж

Төгсөгчдийн үнэлсэн ажил олгогчдын сэтгэл ханамжийг хэмжихэд, 5 далд хувьсагч 0.834-0.931, Кронбах альфа 0.937, нийлмэл найдвартай байдал 0.952, дундаж хэлбэлзэл 0.798 байна [Загвар 2, Хүснэгт 1а-1д].

Хүснэгт 2. Замын шинжилгээний үр дүн

Таамаглал	Стандарт хазайлт	Т статистик утга	П үнэ цэнэ	Үр дүн
SK → SAT	0.230	0.552	0.581	батлагдаагүй
CO → SAT	0.239	0.119	0.905	батлагдаагүй
KE → SAT	0.222	0.290	0.772	батлагдаагүй
SkLe → SAT	0.115	5.508	0.000	батлагдсан

Noted: SK-alumni's skills, CO-alumni's communication, KN-Alumni's knowledge, SkLe-Alumni's managerial skills, SAT-Employers' satisfaction

Замын шинжилгээний үр дүнд дараах байдалтай байна. Үүнд:

Т1: Төгсөгчдийн ур чадвар ажил олгогчдын сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлсэнгүй, учир нь Р үнэ цэнэ 0.581; Т2: Р утга 0.905 байсан тул төгсөгчдийн харилцаа ажил олгогчдын сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлээгүй. Т3: Р утга 0.772 байсан тул төгсөгчдийн мэдлэг ажил олгогчдын сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлээгүй. Т4: Төгсөгчдийн удирдах арга барил нь ажил олгогчдын сэтгэл ханамжид эергээр нөлөөлсөн нь Р үнэ цэнэ 0.000 үр дүнгээр батлагдсан.

Дүгнэлт

ДХИС-ийн Удирдлагын Академийн төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, харилцаа, удирдах арга барилыг ажил олгогчийн сэтгэл ханамжаар үнэлүүлэн судаллаа. Энэхүү судалгаа нь ажил олгогчийн хэрэгцээ, хүлээлт, сонирхогч талын үнэлэмжийг судлахыг оролдсон ба төгсөгчдийг ажил олгогчоор чанарын судалгааны арга зүйгээр үнэлүүлэн шинжилсэн онцлог судалгаа байсан.

Бидний судалгаанд дөрвөн таамаглалыг нарийвчлан авч үзсэнээс нэг таамаглал батлагдан, гурван таамаглал батлагдаагүй. Батлагдаагүй гурван таамаглалын далд хувьсагчдад дахин нарийвчилсан шинжилгээ хийх нь зүйтэй гэж дүгнэх боломжтой.

Судалгааны ажлын баримтжуулсан мэдээллээс дараагийн цуврал судалгааны суурь судалгааг авах, бусад судалгааны ажилтай харьцуулсан судалгаа хийх боломж бүрэн бүрдсэн гэж дүгнэж байна.

Ном зүй

Beehr, T. A. (1995). Psychological stress in the workplace. London and New York: Routledge.

Cooper, H. (1998). Synthesizing research: A guide for literature (3rd ed.). Oaks, CA: Sage Publications, Thousand.

Cronbach, L. J. (1946). Response sets and test validity. Educational and Psychological Measurement, 6(4), 475-494. Available at: https://doi.org/10.1177/001316444600600405.

Donabedian, A. (1988). The quality of care: How can it be assessed? Jama, 260(12), 1743-1748. Available at: https://doi.org/10.1001/jama.1988.03410120089033.

Evanschitzky, H., Groening, C., Mittal, V., & Wunderlich, M. (2011). How employer and employee satisfaction affect customer satisfaction: An application to franchise services. Journal of Service Research, 14(2), 136-148. Available at: https://doi.org/10.1177/1094670510390202.

Beehr, T. A. (1995). Psychological stress in the workplace. London and New York: Routledge.

Cooper, H. (1998). Synthesizing research: A guide for literature (3rd ed.). Oaks, CA: Sage Publications, Thousand.

Cronbach, L. J. (1946). Response sets and test validity. Educational and Psychological Measurement, 6(4), 475-494. Available at: https://doi.org/10.1177/001316444600600405.

Donabedian, A. (1988). The quality of care: How can it be assessed? Jama, 260(12), 1743-1748. Available at: https://doi.org/10.1001/jama.1988.03410120089033.

Evanschitzky, H., Groening, C., Mittal, V., & Wunderlich, M. (2011). How employer and employee satisfaction affect customer satisfaction: An application to franchise services. Journal of Service Research, 14(2), 136-148. Available at: https://doi.org/10.1177/1094670510390202

Судалгааны ажлын баримтжуулсан мэдээлэл

Path Coefficients

Mean, STDEV, T-Values, P-... | Confidence Intervals | Confidence Intervals Bias ... | Samples | Copy to Clipboard: Excel Format

	Original Sampl...	Sample Mean (...	Standard Devia...	T Statistics (|O/...	P Values
Alumni's communication -> EMPLOYERS' SATISFA...	0.029	0.048	0.239	0.119	0.905
Alumni's knowledge -> EMPLOYERS' SATISFACTION	0.065	0.087	0.222	0.290	0.772
Alumni's managerial skills -> EMPLOYERS' SATISFA...	0.635	0.603	0.115	5.508	0.000
Alumni's skills -> EMPLOYERS' SATISFACTION	0.127	0.117	0.230	0.552	0.581

Construct Reliability and Validity

Matrix | Cronbach's Alpha | rho_A | Composite Reliability | Average Varia

	Cronbach's Al...	Composite Rel...	Average Varian...
Alumni's communication	0.920	0.943	0.806
Alumni's knowledge	0.900	0.930	0.770
Alumni's managerial skills	0.938	0.956	0.844
Alumni's skills	0.939	0.956	0.845
EMPLOYERS' SATISFACTION	0.937	0.952	0.798

R Square

Matrix | R Square | R Square Adjusted

	R Square	R Square Adjus...
EMPLOYERS' SATISFACTION	0.628	0.608

Discriminant Validity

Fornell-Larcker Crite... | Cross Loadings | Heterotrait-Monotrait... | Heterotrait-Monotrait... | Copy to Clipboard:

	Alumni's com...	Alumni's know...	Alumni's man...	Alumni's skills	EMPLOYERS' S...
Alumni's communication	0.898				
Alumni's knowledge	0.900	0.878			
Alumni's managerial skills	0.601	0.656	0.919		
Alumni's skills	0.928	0.876	0.638	0.919	
EMPLOYERS' SATISFACTION	0.586	0.618	0.776	0.615	0.893

ОСОБЕННОСТИ ПРОФЕССИОНАЛЬНО-ОРИЕНТИРОВАННОГО ОБУЧЕНИЯ ИНОСТРАННОМУ ЯЗЫКУ СОТРУДНИКОВ ПОЛИЦИИ

PECULIARITIES OF PROFESSIONALLY ORIENTED FOREIGN LANGUAGE TRAINING OF POLICE OFFICERS

Нестерова Валерия Евгеньевна
Старший преподаватель кафедры иностранных языков Уральского юридического института МВД России
Nesterova Valeria Evgenevna
Senior lecturer of the Department of the foreign languages of the Ural Law Institute of the Ministry of the Interior of the Russian Federation

Аннотация: в статье рассматриваются особенности и трудности реализации профессионально-ориентированного обучения курсантов на практических занятиях по иностранному языку, а также важность и необходимость языковой подготовки сотрудников органов внутренних дел. В современной системе высшего образования главной целью обучения иностранному языку является формирование коммуникативной компетенции. В связи с этим, в образовательных организациях системы МВД России взят курс на профильно-ориентированное обучение, под которым понимается применение образовательных технологий, позволяющих организовать образовательный процесс не только с учетом профессиональной направленности обучения и его специфики, но также с акцентом на личность обучающегося, его интересы, способности и потребности.

Abstract. The article highlights the peculiarities and difficulties of cadets' professionally-oriented training in the foreign language practical classes, the importance and necessity of language training of Internal Affairs Bodies employees as well. The modern system of higher education considers formation of the communicative competence as the main goal of the foreign language training. In this regard, the educational establishments of the system of the Ministry of Internal Affairs of Russia have headed for professionally oriented training that is understood as the implementation of educational technologies that allow organizing the educational process taking into account not only the professional orientation of education and its specifics but with an emphasis on a student's personality, his or her interests, abilities and needs.

Ключевые слова: профильно-ориентированное обучение, иноязычная коммуникативная компетенция, практическая деятельность, языковая подготовка, международное общение, диалогическое высказывание, правоохранительные органы, сотрудник полиции.

Keywords: professionally oriented training, foreign language communicative competence, practice, language training, international communication, dialogue, law enforcement bodies, police officer.

Introduction

The modern requirements in the sphere of education aimed at training of highly qualified specialists who will be able to solve complex professional tasks due to a high level of students' general and professional development, creative and critical thinking, the ability to apply theoretical knowledge in practice and the ability to adapt to changing social, political and economic conditions. One of the latest requirements is speaking one or more

foreign languages, therefore the language training is of particular importance because it gives future specialists the opportunity to get communication skills unlimited by language barriers and monocultural thinking[1]. Thus, the practical mastering of a foreign language should be considered as a means of both professional and personal development. This means that the integral components of an efficient specialist's professional training combine the intercultural communicative competence and the foreign language communicative competence[2].

Police officers' professional activity is directly related to communication. The complexity and unpredictability of their work requires officers to be ready to act in an unforeseen situation arisen during interaction with various categories of people including foreigners. So, foreign language training is especially important and relevant for those law enforcement officers who are engaged in maintaining security and public order while mass events at the international level. Such a governmental and social order involves the constant language training mastering in educational institutions of the Ministry of Internal Affairs of Russia and in specialized courses as a part of additional professional education.

Results of the study and discussion

At present the methodology of foreign languages training finds the professionally oriented training to be the most effective approach allowing students to obtain such a level of foreign language competence that gives an opportunity to use the language in their future professional practice. The main goal of the discipline "The Foreign Language" is the communicative competence formation that allows the students to formulate their thoughts in a foreign language in order to conduct an equal dialogue with native speakers during the intercultural interaction process. In order to assist the cadets and listeners to fulfill their professional tasks effectively it is necessary to organize and optimize the whole educational process. On the one hand it is appropriate to ensure the targeted mastering of the cadets' oral speech skills allowing them to respond to the most typical professional communication situations adequately and competently, on the other hand it is important to expand the socio-cultural horizons of police officers.

So, as it has been noted the main task of law enforcement officers' professional training through a foreign language is to give the general knowledge about linguistic and cultural aspects, the structure of the language itself, to develop skills and abilities in all types of speech activity (speaking, reading, writing and listening), but speaking should be emphasized first of all. Therefore, it is recommended to pay special attention to mastering the dialogic speech that is considered to be a form of oral communication where interlocuters exchange some information using various language means, establish contact and mutual understanding and influence each

[1] Нестерова В.Е. Реализация инновационной системы языковой подготовки в неязыковых вузах: проблемы и перспективы: сборник материалов международной научно-практической конференции: в 2 ч. Ч 2. - Воронеж: Воронежский институт МВД России, 2016. – С. 34.

[2] Гальскова Н.Д. Образование в области иностранных языков: новые вызовы и приоритеты // Иностранные языки в школе, 2008. – № 5. – С. 3.

other according to a concrete communicative intention.

The dialogic speech mastering is primarily aimed at developing the skills and abilities to build a constructive dialogue in various situations of real communication, taking into account the nature of communicative partners and their inter-role interaction. The dialogue involves the solution of a specific situational issues aimed at modeling professionally oriented situations where it is appropriate to apply the obtained knowledge in complex practical situations close to reality. Training dialogues involve the development of various types of speech statements, clichйd phrases, professional and legal terminology, getting practical skills and knowledge of the sociocultural background as well[3]. In addition, a dialogue is an effective means for working out grammatical structures, vocabulary and cultural realities. It is an intermediate stage for verification and control of all types of speech activity including extensive and intensive reading, active and passive vocabulary, proficiency level of grammar and listening. Working with dialogues on professional topics also may solve some problems with motivation, shyness, fear of making a mistake promoting the development speaking skills.

The modern methodology approaches to speaking training provides several basic key points to overcome difficulties in improving the dialogic speech: 1) personalization, i.e., students are more willing and more successful in completing tasks that involve describing their life experience. So, it is better to act out dialogues between a police officer and citizens, criminals, victims, witnesses, judges and ithers; 2) variability, i.e., creating cadets' own storyline; 3) the balance between correct speech and fluency in speech; 4) time distribution, i.e., cadets need enough time to prepare their dialogues especially if they have to work out new lexical-grammatical or speech units in order to minimize the number of mistakes.

A lecturer is also recommended to take into account three main aspects while preparing a practical class withing the implementation of profile-oriented training approach:

- the subject-substantive aspect lies in the necessity to select factual knowledge on the topic necessary for students' unprepared speech in a given situation;

- the linguistic aspect involves the selection of lexical units sufficient for expressing thoughts in a foreign language;

- the communicative aspect is realized through the purposeful use of selected lexical units to solve communicative problems[4].

Role-playing games are considered to be an effective form of dialogue speech training as such kind of games is close to live speech and to tasks of real communicative acts within the professional communication[5]. Another effective method of working on a given situation is the method of comparative analysis by E.I. Talia. This method is

[3] Лыскова М.И. Английский язык в ситуациях профессионального общения сотрудников органов внутренних дел: учебное пособие. – Тюмень: Тюменский институт повышения квалификации сотрудников МВД России, 2013. – С. 12-17.

[4] Максимова Э.А. Структура педагогического знания учителя иностранного языка: Автореферат диссертации… кандидата педагогических наук. – Ленинград, 1983. – 73 с.

[5] Педагогическое мастерство: материалы IV Междунар. науч. конф. (г. Москва, февраль 2014 г.). – Москва: Буки-Веди, 2014. – С. 198-199.

aimed at the development of students' ability to make up a dialogic or monologue based on previously studied authentic material practiced in different exercise after, for instance, reading or listening. Such kind of activity helps to solve several educational tasks such as extension of cadets' professional vocabulary, mastering listening, reading and writing skills, cultivation tolerance to other participants' opinions. The method of comparative analysis in law establishments can be applied in the process of working on such topics as: "The Constitution of the Russian Federation", "The structure of the British Police", "Political System of the USA", "Cybercrime", "Combating Drug Trafficking", "Economic Crimes" and others. These dialogues-discussions withing the comparative analysis are productive tasks and, as may be given for self-training[6].

For example, after reading the text "The Russian Constitution" the cadets may be suggested to fill in the gaps into the following mini-dialogue:

Cadet A: What day is considered to be Day of the Russian Constitution adoption?

Cadet B: Let me think. Is it …?

Cadet A: Yes, you are right. What are the branches of power under the Constitution?

Cadet B: Well, I think …

Cadet A: You are absolutely correct. Which branch of power is responsible for law enforcement?

Cadet B: Oh, I know it for sure, it is …

Cadet A: Well done!

As practice shows one the main difficulties in making up a dialogical or monologue is a language barrier due to the lack of cadets' skills to connect individual sentences grammatically correct and to select the appropriate lexical, syntactic and word-formation means. That is why the main task of a tutor is to form the ability to establish connections between sentences. For this purpose it is necessary to use practical tasks at the single sentence level, for example, to make up a complex sentence from several simple sentences, to describe the appearance of a person in one sentence. So, for example, while studying the topic "Identification" cadets using separate lexical units describe the appearance of a victim, a criminal, a witness, their distinctive marks and character traits, then combine these lexemes into a coherent sentence and create a photofit. Finally, the resulting description is integrated into a dialogue between a police officer and a victim or a criminal[7]. The cadets may be given the following sample:

Police Officer: Good morning, Sir (Madam). I'm a captain of Police … May I ask you several questions? Can you testify?

Foreigner: Morning, officer. Yes, of course. I'm a victim (a witness/an eyewitness).

Police Officer: Will you show me your identity papers?

Foreigner: Here they are.

Police Officer: Have you seen the criminal (criminals) before?

Foreigner: No, I haven't (Yes, I have).

[6] Настольная книга преподавателя иностранного языка: Справ. пособ. / Маслыко Е.А., Бабинская П.К. – Москва: ВШ, 2008. – 522 с.

[7] Каргина, Е.М. Особенности профильно-ориентированного обучения иностранному языку // Культура и образование, 2014. – № 5 (9). – С. 2.

Police Officer: What did he (she/them) look like?

Foreigner: Well, let me think… He (she/them) was (were) old (elderly/young/of middle age), tall (short/ of medium height) and thin (fat/slander).

Police Officer: What was he (she/them) dressed in?

Foreigner: He (she/them) was (were) dressed in a jacket (raincoat, coat, shirt, t-shirt, dress, blouse) and trousers (jeans, shorts, skirt,).

Police Officer: What colour was his (her/their) jacket (raincoat, coat, shirt, t-shirt, dress, blouse)?

Foreigner: His (her/their) jacket (raincoat, coat, shirt, t-shirt, dress, blouse) was (black, white, green, blue, brown).

Police Officer: Has he (she/them) any distinctive marks?

Foreigner: Yes, he (she/them) has a scar (moustache, a beard, a scar, glasses, a tattoo, a mole).

Police Officer: Thank you for the information. Sign here, please.

Foreigner: You are welcome, officer.

In addition, it is relevant to use exercises aimed at transferring separate sentences of the dialogic speech in a monologue statement and then translating entire passages of dialogues into indirect speech and vice versa. This kind of a task can be used during studying such professionally oriented topics as “Protection of public order and ensuring public safety”, “Road safety”, “Combating terrorism” and others. For example, cadets are given such kind of mini-dialogues and are asked to transfer them into indirect speech or retell the main idea to their group-mates:

Police Officer: Hello, my name is senior lieutenant … You’ve violated road traffic rules. It’s prohibited to park a car here.

Foreigner: I’m really sorry, officer. I was in a hurry and didn’t pay attention to the sign.

Police Officer: Show me your driving license, please.

Foreigner: Here it is.

Police Officer: They are okey but you have to pay a fine for a wrong parking.

Foreigner: No problem, Sir.

Conclusions

Thus, in the process of studying professionally oriented language material a two-way relationship is established. This relationship unites the students’ desire to get special knowledge in their specialty and the success of mastering the language itself, i.e., professionally oriented approach can be considered not only from the standpoint of pragmatics but also as a means of intellectual, social and professional development.

One of the key principles for the successful implementation of professionally oriented training is the principle of situatedness implemented through the use of various speech situations of professional communication which are a combination of speech and non-speech conditions necessary for the implementation of a particular speech action.

The language training of cadets of the higher education institution of the Ministry of Internal Affairs and current police officers is becoming in demand today, since a foreign language creates the basis for professional mobility and increases the opportunities for professional self-realization. So the

professionally oriented approach helps to unite professional, practical, general educational, communication-oriented, developmental and educational components.

Список использованной литературы

1. Гальскова Н.Д. Образование в области иностранных языков: новые вызовы и приоритеты // Иностранные языки в школе, 2008. – № 5. – С. 2-7.

2. Каргина Е.М. Особенности профильно-ориентированного обучения иностранному языку // Культура и образование, 2014. – № 5 (9). – С. 1-9.

3. Лыскова М.И. Английский язык в ситуациях профессионального общения сотрудников органов внутренних дел: учебное пособие. – Тюмень: Тюменский институт повышения квалификации сотрудников МВД России, 2013. – 118 с.

4. Максимова Э.А. Структура педагогического знания учителя иностранного языка: Автореферат диссертации… кандидата педагогических наук. – Ленинград, 1983. – 73 с.

5. Настольная книга преподавателя иностранного языка: Справ. пособ. / Маслыко Е.А., Бабинская П.К. – Москва: ВШ, 2008. – 522с.

6. Нестерова В.Е. Реализация инновационной системы языковой подготовки в неязыковых вузах: проблемы и перспективы: сборник материалов международной научно-практической конференции: в 2 ч. Ч 2. - Воронеж: Воронежский институт МВД России, 2016. – С. 34-36.

7. Педагогическое мастерство: материалы IV Междунар. науч. конф. (г. Москва, февраль 2014 г.). – Москва: Буки-Веди, 2014. – С. 198-203.

ШҮҮГЧ ХАРААТ БУС БАЙЖ, ГАГЦХҮҮ ХУУЛЬД ЗАХИРАГДАХ ЗАРЧМЫН ШИНЭ СОРИЛТ

JUDGES ARE INDEPENDENT AND ONLY PRINCIPLE OF THE LAW NEW CHALLENGE

М.Долгорсүрэн
ШУА-ийн Философийн хүрээлэн Улс төр, эрх зүйн салбарын ЭШДэА, хууль зүйн магистр, хуульч, өмгөөлөгч
M.Dolgorsuren
Mongolian Academy of Sciences Institute of Philosophy Department of legal and Political studies Researcher, Master of Law (LL.M), advocate

Хураангуй: Энэхүү эрдэм шинжилгээний өгүүллээр Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлт, 2021 онд баталсан Шүүхийн тухай хууль, олон улсын эрх зүйн баримт бичигт шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах зарчмын тулгамдаж буй өнөөгийн сорилтыг судалж, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал дэвшүүлэхийг зорилоо.

Abstract: This research article examines the current challenges of the principle of independence of judges in the 2019 amendments to the Constitution of Mongolia, the Law on Courts adopted in 2021, and international legal documents, and the improvement of its legal environment aimed at proposing.

Түлхүүр үгс: Шүүгч, хараат бус байх, хуульд захирагдах зарчим, сорилт
Key words: Judge, independence, rule of law, challenges

Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "*Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ",* 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэгт *Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана*" гэж тус тус заасан. Энэ нь шүүх бие даасан байх, шүүгч хараат бус байх, шүүгч зөвхөн хуульд захирагдах гэсэн харилцан хамааралтай хос зарчмууд юм[1] гэж Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор Б.Чимид онцлон тэмдэглэжээ. Монгол Улсын Үндсэн хуульд ингэж харилцан хамааралтай хос зарчмуудыг бүрэн утгаар нь томьёолж тэдгээрийг хангах зохион байгуулалт, эрх зүйн болон улс төр-эдийн засгийн баталгаа, механизмын эрх зүйн үндсийг тогтоож өгсөн билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг тодорхойлох "*Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах"* зарчим нь шүүх эрх мэдлийн мөн чанар, гол онцлог, шударга ёс, шүүгчийн статусын амин сүнсийг илэрхийлсэн Үндсэн хуулийн үндсэн зарчим бөгөөд шинэ үзэл баримтлалын гол цөм нь юм. Шүүх эрх мэдлийн хараат бус, бие даасан байдал нь шүүхийн байгууллагын тогтолцоо, юуны өмнө түүний бүрэлдэхүүн болох шүүгчдийн хараат бус байдал, бүтцийн нэгж болох шүүхүүдийн бие даасан байдал болон үйл ажиллагааны үндсэн

[1] Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. 2 дахь хэвлэл. УБ., 2017. 261 дэх тал

зарчим, тэдгээрийг хангах баталгаагаар[2] тодорхойлогддог.

Шүүгч буюу шүүх бүрэлдэхүүн шүүх эрх мэдлийг хараат бус үндсэн дээр, зөвхөн хуулийн дагуу бие дааж төгс хэрэгжүүлдэг. Шүүгчид ингэж эрх зүйн онцгой нөхцөл тогтоосон нь түүний хараат бус байж гагцхүү хуульд захирагдан ажиллах хос зарчмыг хангахад утга агуулга нь оршдог.

Шүүх эрх мэдлийн хувьд өнөөдөр шүүгч хараат бус байх зарчим дээрээ хатуу зогсож, зоригтой, шийдэмгий байж, шийдвэрийнхээ үндэслэл нотолгоо, тайлбарын онолын түвшинг дээшлүүлэн, улс төрийн нам, хүчин, албан тушаалтны элдэв шахалт, шаардлага, ятгалгат автахгүйгээр үндсэн чиг үүргээ шударгаар хэрэгжүүлэх нь нэн чухал болж байна.

Шүүгч гагцхүү хуульд захирагдах зарчмыг шүүх эрх мэдлийн хүрээнд авч үзэх учиртайг доктор, профессор Б.Чимид багш өөрийн бүтээлд тэмдэглэж, Үндсэн хуульд тодорхойлсон дараах бусад үндэслэлийг багтаан ойлгох талаар онцолжээ. Үүнд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага хэрэгжүүлэхийг хориглох, шүүх зөвхөн Үндсэн хуульд нийцсэн олон улсын гэрээг хуулийн адил хэрэглэх, шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтоох, хуулийн албан ёсны тайлбар хуулиас зөрвөл зөвхөн хуулийг хэрэглэх[3] зэрэг үндэслэлийг багтаан ойлгоно. Иймд шүүгч гагцхүү хуульд захирагдах Үндсэн хуулийн зарчмыг зөвхөн үгийн утгаар бус, агуулга болон хэрэгжих механизмын хувьд ойлгож хэрэглэх маш чухал шаардлагатай байна.

Шүүх бие даасан байх, шүүгч хараат бус байх зарчмын үүднээс Ерөнхийлөгч нь шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд аль ч талаараа нөлөөлөх ёсгүй гэсэн өвөрмөц нөхцөл төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим хийгээд шүүх эрх мэдлийн онцлогоос урган гардаг[4]. Үүнтэй уялдан Ерөнхийлөгч шүүгчдийг томилж, илгээж байгаагаараа шүүхийн бие даасан, шүүгчдийн хараат бус байдлын Үндсэн хуулийн баталгаа болж байдаг.

Шүүгчийг томилохдоо мэдлэг, ёс зүйтэй, шударга шулуун байдал, тал үл харах буюу төвийг сахих байдлаасаа илүү төрийн бодлогод үнэнч байх, улс төрийн хувьд найдвартай байдлыг харгалздаг байжээ[5]. Шүүгчдийг сонгох, томилох тогтсон аргачлал улс орон бүрт шүүх тогтолцоо болгонд харилцан адилгүй байдаг ба тэдгээрийн дунд шатлан захирах ёс байдаггүй. Тухайн улс шүүгчийн томилгоонд ямар ч аргыг хэрэглэсэн ч, энэ нь ил тод, олон нийтийн хяналт дор явагдах ёстой. Шүүхийн томилгоонд ил тод байдал, олон нийтийн хяналтыг бий болгох нь шүүхэд ажиллах хамгийн чадвартай хүнийг сонгох, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг олж авахад нэн чухал ач холбогдолтой. Гадны нөлөөнд автаагүй ил тод процесс нь хамгийн ур чадвартай шүүгчийг шилж сонгох боломжийг олгодог.

[2] Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл. хоёрдугаар дэвтэр. УБ., 2004. 122-123 дахь тал

[3] Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. 2 дахь хэвлэл. УБ., 2017. 263 дахь тал

[4] Б.Чимид. Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал нэгдүгээр дэвтэр. УБ., 2008. 138-139 дэх тал

[5] Улсын Их Хурал, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2016.110 дахь тал

Манай Улсад Үндсэн хууль, холбогдох бусад хуулийн дагуу шүүгч нарыг бүх насаар нь тэтгэврийн нас хүртэл нь томилдог. Шүүгч нарын ажил үүргээ гүйцэтгэх хугацаа нь төрийн албан тушаалтан, намын дарга нар, дээд шатны шүүгч нар, түүнчлэн төр засгийн өөрчлөлтөөс үл хамаарна. Хуулийн эдгээр заалтаас үзвэл шүүгчийн бүрэн эрхийн хугацаа хуулиар хамгаалагдсан нь харагдаж байна. Эдүгээ шүүгч нарыг ажилд томилох, дэвшүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах, бүрэн эрхийн хугацаа, цалин хангамж ба шүүхийн санхүүжилттэй холбоотой хараат бус байдлын үндсэн баталгаа Монгол Улсад Үндсэн хуулийн болон бусад хуулийн түвшинд бий болсон гэж дүгнэж болно. Гурван шатлал бүхий шүүхийн шинэтгэлийн явцад батлагдсан хууль, хууль тогтоомжийн бусад актууд нь шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэхэд чиглэгджээ.

Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа, дэвших, буурах, огцрох үндэслэл журам, аж амьдралын нөхцөл, нийгмийн хангамж, халамжийн тогтолцоо, хэр хэмжээ, шагнаж урамшуулах нь зохистой эсэх хүртэл хөндөж яригддаг эмзэг асуудлыг багтаадаг.[6] Монгол төр шүүгчийн хувийн хараат биш байх нөхцөлийг хангах үүрэгтэй болсон. Шүүгчдийг улс төрийн хүчнүүдийн нөлөөний гадна байлгахын тулд л хөндлөнгөөс томилох зарчмыг хэрэглэсэн нь бас үзэл баримтлалын шинэлэг тал нь юм.

Шүүхүүд хуулиар хуваарилагдсан шүүх эрх мэдлийг тус тусдаа бие даан хэрэгжүүлдэг нь төрийн эрх мэдлийн нөгөө 2 салаанаас түүний ялгарах гол онцлог бөгөөд бие даасан байх зайлшгүй байдлын үндэс болдог. Үүнээс үүдэн шүүгч хараат бус байхын тулд "*шүүх бие даасан байх*" ёс зарчмыг Үндсэн хуулиар бататгасан байна. Энэ бол шүүхийн талаарх шинэ үзэл баримтлалын нэг илрэл юм.

Олон улсын эрх зүйн баримт бичгүүд болон Банглорын зарчмын жишгийг үндэс болговол шүүхийн хараат бус байдал дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд[7]:

❖ Шүүх нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдэлтэй ижил эрх зүйн байдалтай төрийн бие даасан эрх мэдэл

❖ Хараат бус байдлаа хадгалахын тулд шүүх нь бодлогоо өөрөө тодорхойлно.

❖ Шүүхийн төсвийг өөрсдөө боловсруулж, батлуулахаар Парламентад оруулна.

❖ Шүүгч нарыг томилох буюу сонгох, дэвшүүлэх журам нь ил тод, тодорхой байх

❖ Шүүгч нарыг бүх насаар нь томилох

❖ Шүүгч нарын цалин нь амьдралд хүрэлцээтэй байх

❖ Шүүгч нар боловсрол, туршлагын хувь наад захын өндөр шаардлага хангасан байх

❖ Шүүгчийг дэвшүүлэх нь түүний мэргэжлийн мэдлэг, туршлага, ёс зүйн чанарыг бодитоор үнэлсний үндсэн дээр хийгдэх

❖ Шүүгчид сахилгын арга хэмжээ ногдуулах буюу огцруулах

[6] Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл. хоёрдугаар дэвтэр. УБ., 2004.128 дахь тал

[7] Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн судалгаа, мэдээллийн төв, Олон Улсын онол-практикийн бага хурлын илтгэлийн эмхэтгэл-Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүхийн захиргааны үүрэг, тулгамдсан асуудлууд. УБ., 2014. 22 дахь тал

ажиллагааг зөвхөн сахилгын зөрчил гаргасан, эсхүл ажил эрхлэх чадваргүй болсны үндсэн дээр ихэнх төлөв буюу бүхэлдээ шүүгч нараас бүрдсэн сахилгын баг хэрэгжүүлэх учиртай бөгөөд шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага болох Сахилгын хороог Монгол Улсын Шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулиар 2021 онд шинээр байгуулсан.

2013 оны Шүүх байгуулах тухай хуулийн дагуу тухайн үед ажиллаж байсан давж заалдах болон анхан шатны шүүхийн бүх шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлж, өөрчлөн байгуулагдсан шүүхэд нь дахин томилох саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид уламжилсан ч Ерөнхийлөгч шүүгчдийг тойргийн шүүхэд нь дахин томилсон зарлигийг гаргахдаа нийт 409 шүүгчээс 397-г томилж, 12 шүүгчийг томилоогүй үлдээсэн.[8] Энэ байдал 2015 оны Шүүх байгуулах тухай хуулийн дагуу хийгдсэн томилгоонд дахин давтагдаж мөн л нэг шүүгчийг томилохгүйгээр албан тушаалаас нь огцруулжээ.[9] Ийнхүү огцруулахдаа эдгээр шүүгч нарт огт мэдэгдээгүй, ямар үндэслэлээр томилоогүй нь тодорхойгүй байжээ. Тодорхой бус шалтгаанаар дахин томилогдоогүй шүүгч нар болон Хуульчдын холбоо, Шүүхийн ерөнхий зөвлөл, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндсэн хуулийн цэц, иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхэд хандсан боловч тусыг эс олсон байна.[10] Уг нь Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсэг нь шүүгчдийг Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу шүүгчийг огцруулахаас бусад тохиолдолд албан тушаалаас нь огцруулахаас хамгаалдаг. Энэхүү тогтолцоо нь 2000 оноос хойш бодит үр дүнгээ өгч эхэлсэн бөгөөд авлигын асуудал гарсаар байгаа боловч төрийн албан хаагчийн зохисгүй үйлдлийг хязгаарлах чадвар тодорхой хэмжээнд бүрдсэнийг харуулж байна. Гэхдээ шүүхийн зохион байгуулалт өөрчлөгдөх бүрт ийм байдал давтагдахгүй гэх баталгаа байхгүй байгаа тул Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4 дэх хэсгийн заалт шүүгч нарыг дур зоргоор огцруулахаас хангалттай хамгаалалт болж чадахгүй байсаар иржээ[11]. Шүүгчийн ажилд ямар нэг байдлаар хөндлөнгөөс оролцохыг Үндсэн хуулийн болон хуулийн түвшинд хориглож огцруулахгүй байх аргыг 2021 онд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуульд Шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хязгаарлах, түдгэлзүүлэх, дуусгавар болгохыг хориглох ерөнхий байдлаар зохицуулсан боловч

[8] Ж.Хунан, П.Баттулга, М.Мөнхжаргал. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: Шүүгчийн томилгоо. УБ., 2015.96-97 дахь тал

[9] Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны зургаадугаар сарын 30-ны өдрийн 110 болон 111 дүгээр зарлиг.

[10] Ерөнхийлөгчийн Тамгын газраас Үндсэн хуулийн Цэцэд өгсөн тайлбарт дээрх шүүгчдийг ёс зүйн ноцтой зөрчил гаргасан гэсэн үндэслэлээр Ерөнхийлөгч итгэл хүлээлгээгүй гэсэн байх боловч эдгээр шүүгчийг огцруулах, хууль зөрчсөн талаар Шүүхийн Ес зүйн хорооны шийдвэр, түүнчлэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр байхгүй байна. Ж.Хунан, П.Баттулга, М.Мөнхжаргал, *Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: Шүүгчийн томилгоо*. УБ., 2015

[11] Улсын Их Хурал, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2016.117 дахь тал

тодорхой нарийвчлан зохицуулах нь чухал юм.

Монгол Улс нь шүүхийн шинэтгэлийг шилжилтийн үе буюу 1992 оноос хойш үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа бөгөөд 2013 он хүртэл нэг л хуулиар шүүхийн зохион байгуулалт, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа, шүүгчийн сонгон шалгаруулалт, шүүхийн захиргааны асуудлыг зохицуулж байсан. 2013 онд Монгол Улсын Шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хуулийг баталж шүүх эрх мэдлийн хүрээн дэх эрх зүйн зохицуулалтыг илүү шинэчлэн хуульчилсан. Судалгаанаас үзэхэд шүүгчийн сонгон шалгаруулах ажиллагаа, шүүгчид тавигдаж буй шалгуур үзүүлэлт бодитой, обьектив болж чадаагүй, шүүгчийг сонгон шалгаруулах ажиллагааг албан тушаалтан өөрийн үзэмжийн хүрээнд шийдвэрлэх бололцоо байсаар байжээ[12]. Мөн шүүхийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөлтийн үед Үндсэн хуулийн дагуу шүүгч хугацаагүй томилогдох зарчим зөрчигдөж, зарим шүүгч албан тушаалаасаа чөлөөлөгдсөн, зарим шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүй шилжүүлэн томилсон тохиолдол гарсаар байсан[13]. Харин 2021 онд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуульд шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр албан тушаалд болон өөр шүүхэд шилжүүлэх, эсхүл сэлгэн ажиллуулахыг хориглох баталгаагаар хангана гэж ерөнхий байдлаар зохицуулжээ. Шүүгч насаараа томилогддог заншилтай бөгөөд тэднийг халж, солихгүй байх зарчим нь тэдний хараат бус байдлын нэг үндсэн баталгаа нь болдог.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэгт "*Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно*" гэсэн заалт нь шүүгч чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх зарчмын шинэ сорилт бөгөөд Шүүхийн Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдал хангагдах нэн чухал ач холбогдолтой.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн 49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсэгт "*Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно*", 2021 онд баталсан Монгол Улсын

[12]Нээлттэй нийгэм форум. Шүүгчийн томилгооны өнөөгийн нөхцөл байдал судалгааны тайлан. УБ., 2016. дугаар 18.

[13]Улсын Их Хурал, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2016.114 дэх тал

Шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 56, 95-116 дугаар зүйлд шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага болох Сахилгын хорооны зөвөлгөөн, сахилгын хорооны дарга, гишүүний бүрэн эрх, үүрэг, хориглох зүйл, чөлөөлөх, огцруулах, сахилгын бусад шийтгэл оногдуулах, сахилгын хорооны ажлын алба, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааг зохицуулсан нь шүүгчийн хараат бус байдлын бас нэг шинэ сорилт.

2021 онд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт "*Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байж, гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд захирагдана".* Мөн хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсэгт "*Шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хязгаарлах, түдгэлзүүлэх, дуусгавар болгохыг хориглох, шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр албан тушаалд болон өөр шүүхэд шилжүүлэх, эсхүл сэлгэн ажиллуулахыг хориглох, хугацаагүй томилогдож, захиргааны болон гуравдагч этгээдийн санаачилгаар чөлөөлөгдөхгүй, огцрохгүй, аливаа дайчилгаа болон цэргийн жинхэнэ албанд татахгүй байх, шүүгчийн эдийн засгийн болон нийгмийн хангамж, халамжийн тогтолцоог энэ хууль болон бусад хуулиар бүрдүүлэх, хангах, шүүгч өөрийн хүсэлтээр ахисан түвшинд мэргэшлээ дээшлүүлэх зорилгоор хоёр жил хүртэл хугацаагаар гадаад улсад суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болсон тохиолдолд ажлын байр нь хэвээр хадгалагдах зэрэг баталгаагаар хангана"* гэж хуульчилсан нь шүүгч хараат бус байх зарчмын шинэ сорилт бөгөөд шүүгчийн хараат бус байх зарчмыг хангаж, бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Дүгнэлт

Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах зарчмыг хангах нь түүний төвийг сахисан байр суурийг хадгалах гол түлхүүр. Мөн шүүгч хараат бус байх нь ард иргэдийн эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг бодитой хамгаалах хамгийн хүчирхэг механизм шүүх эрх мэдлийн эрх зүйн баталгаа болж өгдгөөрөө чухал ач холбогдолтой. Шүүгчийн *хараат бус* байдал нь хууль дээдлэх ёс, шүүн таслах ажиллагааг шударгаар шийдвэрлэхдээ бусад шүүгч, шүүхийн ажилтнаас *хараат бус* байна.

Шүүгчийг томилох шийдвэрийг шүүгчийн ур чадвар, туршлага, нөлөөнд үл автах чадавхад нь тулгуурлан гаргаж байхыг шүүгчийн сонгон шалгаруулалт болон томилгоог зохицуулдаг хууль тогтоомж эрх зүйн актад нарийвчлан маш тодорхой тусгах зайлшгүй шаардлагатай байна.

Шүүх эрх мэдлийн байгууллагын зохион байгуулалтын бүтцийн зохистой болон тогтвортой байдлыг хадгалах, төрийн албан хаагч албан тушаалдаа тогтвортой мэргэшиж ажиллах, шүүгчийн хараат бус байдлыг дээшлүүлэх баталгааг хангах нь нэн чухал байна. Эдгээр асуудлыг

амжилттай хэрэгжүүлвэл шүүх эрх мэдлийн хараат бус байдал, хууль ёст тогтвортой хөгжлийн нийгмийг бүрдүүлж, эрх зүйт төрийг бэхжүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах, ухаалаг засаглалын зорилтууд хангагдах үндсэн нөхцөл бүрдэнэ.

Шүүгчийн хараат бус байх зарчмыг шүүх засаглалтай холбоотой бүхий л хууль тогтоомжид илүү сайн нарийвчилж тусгах шаардлагатай байна.

Харин шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах зарчмыг хэрэгжүүлэх арга механизмыг нийгмийн хөгжлийн дагуу улс төр, эрх зүйн талаас нь улам бүр төгөлдөржүүлэх шаардлага ямагт нэн тэргүүнд тавигдаж байна.

Хараат бус байдлыг хангах шаардлага нь шүүх засаглалын байгууллагад төдийгүй шүүгч бүрт хамаарах бөгөөд шүүхийн эрх мэдлийн байгууллагын ажилтнууд Засгийн газар, парламент, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд, бусад шүүгч эсвэл гуравдагч этгээдийн шууд болон шууд бус нөлөөллөөс ангид байх байдлыг хангах нь маш чухал юм. Шүүгчдийг улс төрийн хүчнүүдийн нөлөөний гадна байлгахын тулд л хөндлөнгөөс томилох зарчмыг хэрэглэсэн нь шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах зарчмын шинэ сорилт юм. Шүүгч хараат бус байхын тулд "*шүүх бие даасан байх*" ёс зарчмыг Үндсэн хуулиар бататгасан нь шүүхийн талаархи шинэ сорилтын бас нэг илрэл юм.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр өөрчлөн найруулсан 49 дүгээр зүйлийн 49.5 дахь хэсэгт "*Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно*" гэсэн заалт нь шүүгч чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны ил тод байдал хангагдах нэн чухал ач холбогдолтой шинэ сорилт болсон.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр нэмсэн 49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсэгт "*Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно*", 2021 онд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 56, 95-116 дугаар зүйлд шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага болох Сахилгын хорооны зөвөлгөөн, сахилгын хорооны ажлын алба, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааг зохицуулсан нь шүүгчийн хараат бус байдлын бас нэг шинэ сорилт.

2021 онд баталсан Монгол Улсын Шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/

хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байж, гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд захирагдана. Мөн хуульд Шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хязгаарлах, түдгэлзүүлэх, дуусгавар болгохыг хориглох, шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр албан тушаалд болон өөр шүүхэд шилжүүлэх, эсхүл сэлгэн ажиллуулахыг хориглох, хугацаагүй томилогдож, захиргааны болон гуравдагч этгээдийн санаачилгаар чөлөөлөгдөхгүй, огцрохгүй, аливаа дайчилгаа болон цэргийн жинхэнэ албанд татахгүй байх, шүүгчийн эдийн засгийн болон нийгмийн хангамж, халамжийн тогтолцоог энэ хууль болон бусад хуулиар бүрдүүлэх, хангах, шүүгч өөрийн хүсэлтээр ахисан түвшинд мэргэшлээ дээшлүүлэх зорилгоор хоёр жил хүртэл хугацаагаар гадаад улсад суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх болсон тохиолдолд ажлын байр нь хэвээр хадгалагдах зэрэг баталгаагаар хангана гэж хуульчилсан нь шүүгчийн хараат бус байх зарчмыг хангаж, бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд түүний шинэ сорилт болоод байна.

Санал

-Шүүгчдийг сонгох, томилох, дэвшүүлэх, үнэлж дүгнэх, хариуцлага тооцох тогтолцооны шударга ил тод байдлыг хангах

-Шүүгчийг томилох шийдвэрийг шүүгчийн ур чадвар, туршлага, нөлөөнд үл автах чадавхад нь тулгуурлан гаргах

-Шүүгчийн сонгон шалгаруулалт болон томилгооны эрх зүйн зохицуулалтыг нарийвчилж тодорхой болгох

-Хэрэг маргааныг хуваарилах тогтолцоог стандартчилах

-Шүүгчийн хараат бус байх зарчмыг шүүх засаглалтай холбоотой бүхий л хууль тогтоомжид нарийвчилж маш тодорхой тусгах

- Шүүгчийн бүрэн эрхийг хязгаарлах, түдгэлзүүлэх, дуусгавар болгохыг хориглох эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тодорхойлох

Эх сурвалж

Хууль

1. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992

2. Монгол Улсын шүүхийн тухай хууль. УБ., 2021

Монгол хэл дээр

3. Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. УБ., 2008.

4. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 2017

5. Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал: хүний эрх, шүүх эрх мэдэл. хоёрдугаар дэвтэр. УБ., 2004

6. Б.Чимид. Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал нэгдүгээр дэвтэр. УБ., 2008

7. Хууль зүйн үндэсний төв. Дэлхийн улсуудын шүүхийн тогтолцоо. УБ., 2005

8. Европын шүүгчдийн ёс зүйн дүрэм. УБ., 2011

9. Шүүх засаглалын хараат бус байдлын үндсэн зарчмууд. УБ., 2013

10.Бангалорын зарчмууд. УБ., 2012

11.Шүүгчдийн олон улсын хороо хараат бус хариуцлагатай байдлын талаарх олон улсын зарчмууд. УБ., 2007

12.Л.Бямбаа. Шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц-илтгэлийн эмхэтгэл. УБ ., 2007

13.Нээлттэй нийгэм форум. Шүүгчийн томилгооны өнөөгийн нөхцөл байдал. судалгааны тайлан. УБ., 2016

14.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, Шүүхийн бие даасан шүүгчийн хараат бус байдлын тухай Үндсэн хуулийн эрх зүйн үндэслэл илтгэлийн эмхэтгэл. УБ., 2007

15.Улсын Их Хурал, Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ. УБ., 2016

16.Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн судалгаа, мэдээллийн төв, Олон Улсын онол-практикийн бага хурлын илтгэлийн эмхэтгэл-Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад шүүхийн захиргааны үүрэг, тулгамдсан асуудлууд. УБ., 2014

17.Ж.Хунан, П.Баттулга, М.Мөнхжаргал. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: Шүүгчийн томилгоо. УБ., 2015

18.УИХ, Д.Банзрагч, Ц.Намсрай. Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн дүгнэлт 5, УБ., 2016

19.Үндэсний хөгжлийн газар. Монгол Улсын хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар, уялдаанд хийсэн шинжилгээ.тайлан I. УБ., 2018

20.ШУА-ийн Философийн хүрээлэн. “Тогтвортой хөгжил ба Үндсэн хууль” эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ., 2020

Цахим эх сурвалж

21.www.legalinfo.mn

22.www.supremecourt.mn

23.www.transparency.org

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БАТАЛГАА, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ

ECONOMIC GUARANTEES FOR PUBLIC SECTOR SPECIAL OFFICIALS, COMPARITIVE ANALYZES OF LEGAL REGULATIONS

Д,Наранбаатар
Цагдаа судлалын магистрант, цагдаагийн ахмад
D.Naranbaatar
Graduate student of policing studies, police captain

Хураангуй: Аливаа байгууллага ажилтныхаа нийгмийн баталгаа, тэр дундаа эдийн засгийн баталгааг илүүтэй хангаж өгөх нь тэднийг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлдэг бөгөөд ингэснээр үйл ажиллагааны зорилго, зорилтуудыг бүрэн биелүүлэх боломжийг нэмэгдүүлдэг.

Энэхүү өгүүлэлд Монгол Улсын хууль тогтоомжид төрийн тусгай алба хаагчдын эдийн засгийн баталгааг хэрхэн тусгасан, тэдгээрийн хоорондын нийтлэг ба ялгамжтай байдлыг судлан гаргаж, судлаачийн үүднээс гаргасан дүгнэлт, дэвшүүлсэн зарим саналын талаар товч тусгалаа.

Abstract: Any organization is supposed to ensuring employees with safety and security in terms of social and economic benefits enables them to work highly effective and efficiently in performance, consequently, achieve the organizational objective.

This article examines how the legislation of Mongolia sufficiently provide the economic guarantees of civil servants, in particular, policing and home security employees. This study attempts to analyze the commonalities and differences between rule and regulations, and then it offers some recommendations to improve loopholes to provide better protection of the employees.

Түлхүүр үг: Төрийн тусгай албан хаагч, нийгмийн баталгаа, эдийн засгийн баталгаа, цагдаа, дотоодын цэрэг, хил, шүүхийн шийдвэр, төрийн тусгай хамгаалалт, авлиагатэй тэмцэх газрын алба хаагч

Key word: public sector special employee, social and economic protection, domestic-homeland security, special agents-policing, internal and border troops, correctional service.

Удиртгал. Монгол Улсын төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн 33.6 дахь хэсэгт “төрийн байгууллага нь төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангаж ажиллана”[1] гэж заасан. Мөн төрийн албан хаагч гэж төрийн албан тушаалыг эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ гэж заасан байдаг.

Төрийн байгууллагууд ажилчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь тэдний амьжиргааны үндэс болсон цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажлын орчин нөхцлийг сайжруулах, ажиллах нөхцөл бололцоогоор хангах, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх сургалтанд хамруулах, эрүүл мэндийн болон

[1] Төрийн мэдээлэл. 2018. №1. Төрийн албаны тухай хууль

нийгмийн даатгалын зохих хувийг төр хариуцах, үр дүнгийн урамшуулал олгох зэрэг ерөнхий үйл ажиллагаанд чиглэгдэж байна.

Төрийн албан хаагчдын ажиллах нөхцлийг жигд сайжруулж, нийгмийн асуудлыг үнэн зөв, бодит судалгаанд үндэслэн, нээлттэй, ил тод байдлаар шийдвэрлэх нь төрийн албан хаагчдын тогтвор суурьшилтай, үр бүтээмжтэй, идэвх санаачлагатай ажиллах үндсэн нөхцөл болно.

Үндсэн хэсэг. Монгол Улсын Үндсэн хуулийн 19.1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна"[2] гэж заасан байдаг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын үзэл баримтлалын 3.2-д "Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн"[3] гэж заасан байдаг.

Төрийн албаны тухай хуулийн 13.1.6-д заасан цагдаа, тагнуул, онцгой байдал, төрийн тусгай хамгаалалт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаын алба хаагч зэрэг төрийн тусгай албан тушаалд хамаарах алба хаагчдын гүйцэтгэх үүргийн онцлог, түүнчлэн Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг баталгаанаас гадна тухайн чиг үүргийн онцлогоос хамааран өөрсдийнх үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хуулиар баталгаажуулсан эдийн засгийн баталгаа, түүний эрх зүйн зохицуулалтын талаар авч үзлээ.

Төрийн тусгай албан тушаалд Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаалтнууд хамаардаг.

Тухайлбал, Төрийн албаны тухай хуулийн 13.1.6-д "зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн"[4] зэрэг албан тушаалтнууд байна.

Нийгмийн бодлогоор дамжуулан хүний эрх чөлөөг хангах, хамгаалан бэхжүүлэх, хүний хөгжлийг хөхүүлэн дэмжих нь дэлхийн аль ч улс орны хувьд төрийн бодлогын амин чухал чиглэлийн нэг байдаг. Хүний эрхий хамгаалалт, түүний нийгмийн баталгаа нь хүний хөгжлийн үндэс суурь, ардчилал, ардчилсан засаглалын гол шалгуур үзүүлэлтийн нэг болдог.[5]

Манай улс ардчилсан тогтолцоотой, зах зээлийн эдийн засагтай орны хувьд иргэний хөдөлмөрлөх эрх нь улс төр, хууль эрх зүйн болоод эдийн засаг, нийгмийн баталгаагаар хамгаалагдсан байдаг. Хөдөлмөр эрхэлж буй хүн бүр баталгаатай, аюулгүй ажлын байранд

[2] Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль
[3] https://legalinfo.mn/mn/detail/6163
[4] Төрийн мэдээлэл. 2018. №1. Төрийн албаны тухай хууль
[5] Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгэм тогтолцоо ба бодлого. Уб.2013. 60 дахь тал

ажиллах, шударга цалин хөлс авах, нийгмийн даатгалд хамрагдах, эвлэлдэн нэгдэх болон хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах эрхээ бүрэн эдлэх ёстой. Энэ суурь эрх бодиттой хэрэгжих эрх зүйн байталгаа нь хууль, олон улсын гэрээ конвенциор баталгаажсан байдаг.

Монгол орны хувьд хүн амын амьдралын чадварт нөлөөлөх нийгмийн шинжтэй эрсдэлээс иргэдийн нийгмийн баталгааг хамгаалах асуудлыг нийгмийн даатгалын системээр дамжуулан шийдвэрлэж байна.[6]

Төрийн тусгай алба хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг баталгаагаар хангагдахаас гадна чиг үүргийн онцлогоор тухайн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хуулиар бусад эдийн засгийн нэмэгдэл баталгаагаар хангагддаг.

Төрийн албаны тухай хуулийн 61.1-д зааснаар төрийн албан хаагч дараахь нийтлэг 10 баталгаагаар хангагдахаар тусгагдсан байна. Үүнд:

1. Албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах;

2. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах;

3. Гүйцэтгэж байгаа албан үүргийн шинж байдлаас хамааран зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах төрийн тээврийн хэрэгслийн зардлын зохих хэсгийг нөхөн авах;

4. Албан үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүлийн гишүүнийг тухайн ажиллаж байгаа байгууллага, эсхүл цагдаагийн байгууллагаар хамгаалуулах;

5. Орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх;

6. Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоосон ээлжийн амралт эдлэх;

7. Төрийн хөрөнгөөр 6 хүртэлх сарын хугацаагаар давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамрагдах, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалын цалинг авах;

8. Үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс албан хаагчид учирсан эд хөрөнгийн хохирлыг төр хариуцаж, гэм буруутай этгээдээр хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлэх;

9. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох;

10.Хууль тогтоомжоор тогтоосон бусад баталгаа[7].

Дээрхи төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа бөгөөд төрийн тусгай алба хаагчид нэмэгдэл эдийн засгийн баталгаагаар хангагддаг нь дараах хүчин зүйлтэй холбоотой. Тухайлбал:

- Цэрэг, цагдаагийн цолтой төрийн тусгай алба хаагчид өөрсдийн чиг үүргээ хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтлэг болон тусгай албадлага хэрэглэх эрхтэй байдаг.

- Цэргийн цолтой төрийн тусгай албан хаагчид үйл ажиллагааныхаа явцад амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирол үзэх эрсдэл үүрдэг.

[6] Мөн бүтээл. 101 дэх тал

[7] Төрийн мэдээлэл. 2018. №1. Төрийн албаны тухай хууль

- Төрийн тусгай албан тушаалд хамаарах бусад алба хаагчдаас[8] ялгагдах нэг онцлог нь тэд бүгд цэрэг, цагдаагийн цол хэрэглэж, тушаалаар үүрэг гүйцэтгэдэг.

Цэргийн цолтой төрийн тусгай алба хаагчдын эдийн засгийн баталгаа эдлэх учир шалтгааны заримаас дурдах нь зүйтэй.

Цагдаагийн алба хаагчид гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд гэмт хэрэг, зөрчил үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй гэмт санаа бодол агуулсан этгээдүүдтэй харилцаанд орж эрсдэл үүрдэг.

Хил хамгаалах албаны алба хаагчид хилийн дагуу төв суурин газраас алслагдсан нутаг дэвсгэрт хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид шүүхээр ял шийтгүүлсэн ялтны ял эдлүүлэх ажиллагаа болон шүүхийн тогтоол гүйцэтгэх зэрэг эрсдэл дагуулсан ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Авлигатай тэмцэх газрын алба хаагчид төрийн өндөр дээд албан тушаалтнуудын эд хөрөнгө завшсан, авлига авсан хэргийг мөрдөн шалгадаг.

Онцгой байдлын алба хаагчид гал түймэр болон химийн болон аюултай бодис, осол аваарь гээд амь насаа эрсдэл оруулан бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг авран хамгаалахын тулд голомтын бүс дээр гардан ажилладаг.

Цагдаагийн алба хаагчид Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан 8 эдийн засгийн баталгаагаар хангагддаг байна. Тухайлбал:

1. Цагдаагийн алба хаагч ээлжийн амралтаараа өөрийн, эсхүл эхнэр, нөхрийн төрсөн нутагт ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно.

2. Цагдаагийн алба хаагч шилжин ажиллах болсноос шалтгаалан эхнэр, нөхөр нь хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно.

3. Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц байдлын үед болон голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчид албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.

4. Цагдаагийн байгууллага алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно. Цагдаагийн алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны

[8] Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах, гүйцэтгэх албан тушаал, дипломат албан тушаал, гаалийн байцаагч зэрэг болно.

зардлын хэмжээг цагдаагийн төв байгууллагын дарга тогтооно.

5. Нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор цагдаагийн байгууллагад ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүмүүст уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж байгаа онгоц, автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож олгоно.

6. Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсын цагдаагийн их, дээд сургуульд суралцагч цагдаагийн алба хаагчийн суралцах хугацааны цалин хөлс, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна.

7. Сургуульд цагдаагийн байгууллагын захиалгаар суралцаж байгаа сонсогчийн дүрэмт хувцасны болон ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна.

8. Цагдаагийн алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин болон төрийн тусгай алба хаасан хугацаа, албан ажлын онцгой нөхцөл, цагдаагийн мэргэжлийн зэргийн болон эрдмийн зэрэг, цолны, хуульд заасан бусад нэмэгдлийг авна.[9]

Засгийн газар цагдаагийн алба хаагчийн хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ. Цагдаагийн байгууллагын алба хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, жишиг, нэмэгдлийн хэмжээг Засгийн газар тогтооно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 287 дугаар зүйлд заасан эдийн засгийн баталгаагаар хангагддаг байна.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч өөр аймаг, хот суурин газарт шилжин ажиллах болсноос шалтгаалан түүний эхнэр /нөхөр/ хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүний гэр бүлийг тэргүүн ээлжид түүний мэргэжлийн болон түүнтэй дүйцэхүйц ажлаар хангах бөгөөд ажлаар хангаагүй тохиолдолд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгоно.

2. Ээлжийн ажил, үүрэг гүйцэтгэдэг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг онцгой тохиолдолд илүү цагаар ажиллуулсан бол ажилласан цаг тутамд ногдох албан тушаалын цалинг олгоно.

3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеэр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно.

4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчид олгох хүнсний болон эдийн хангалт, хоолны зардлын хэмжээг Засгийн газар тогтооно.

5. Аймаг, хот хооронд түүнчлэн аймаг, хот дотор шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжин ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүнд уналга, ачаа тээшийн зардлыг тухайн үед мөрдөж

[9] Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

байгаа онгоц, автомашин, төмөр замын тээврийн үнэлгээгээр тооцож олгоно.

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар гадаад улсын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын их, дээд сургуульд суралцагч алба хаагчийн суралцах хугацааны сургалтын тэтгэлэг, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна.

7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн цалин хөлс нь үндсэн цалин, цолны цалин болон төрийн тусгай алба хаасан хугацааны, онцгой нөхцөлийн, ялтан, хоригдолтой ажилласны, мэргэжлийн зэргийн, эрдмийн зэрэг, цолны болон хуульд заасан бусад нэмэгдийг авна.[10]

Онцгой байдлын алба хаагч Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйл /Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн үүргээ биелүүлэх баталгаа/-д заасан дараах нэмэгдэл эдийн засгийн баталгаагаар хангагдана. Үүнд:

1. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн алба хаасан хугацааг тооцохдоо алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно.

2. Голомтын бүсэд ажилласан онцгой байдлын байгууллагын алба хаагч болон бусад төрийн цэргийн байгууллагын алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.

3. Албан үүргээ зохих журмын дагуу биелүүлснээс алба хаагч болон бусдын эд хөрөнгөд учирсан хохирлыг төр хариуцна.

4. Онцгой байдлын байгууллагын алба хаагч цацраг идэвхт, химийн хортой болон аюултай бодис, далд уурхай, ой, хээрийн түймэр, халдварт өвчин, цар тахлын голомт, усны ослын үед ажилласан тохиолдолд хордлого тайлах болон сэтгэл зүй, бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамрагдана.

5. Онцгой байдлын байгууллагын алба хаагчид онцгой гавьяа байгуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгож болно.

6. Онцгой байдлын байгууллагын алба хаагчид амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгоно.

7. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийн онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн 30 хувиас доошгүй байна.

8. Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт байрлах онцгой байдлын байгууллагын харьяа нэгжид тухайн аймгийн харьяалалгүй алба хаагчийг томилон ажиллуулбал түүнд албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг улирал тутамд олгоно.

9. Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа онцгой байдлын байгууллагын алба хаагчид таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно.[11]

10.Алба хаагч албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа

[10] Төрийн мэдээлэл 2017. №24. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

[11] Энэ хэсгийг 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн бөгөөд 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө

алдсан бол хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно.

11.Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно.[12]

Мөнгөн урамшуулал олгох журмыг санхүү, төсвийн болон онцгой байдлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална. Онцгой байдлын байгууллагын алба хаагчийг гэнэтийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд заавал даатгуулах бөгөөд зардлыг төр хариуцна. Онцгой байдлын байгууллагын алба хаагч нь мэргэшлийн зэрэгтэй байх бөгөөд мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох журмыг Засгийн газар батална.

Тагнуулын байгууллагын алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг баталгаагаар хангагдахаас гадна Тагнуулын байгууллагын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан дараах эдийн засгийн баталгаагаар хангагдана. Тухайлбал:

1. Албан үүргээ гүйцэтгэж яваад илчлэгдсэн буюу хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар тагнуулын байгууллагад цаашид ажиллах боломжгүй болсон тагнуулын ажилтныг өөр ажлаар хангах буюу эсхүл мэргэжил эзэмших, шинээр оршин суух газартаа төвхнөхөд тагнуулын байгууллага туслалцаа үзүүлж холбогдох зардлыг төр хариуцна.

2. Өндөржүүлсэн бэлэн байдал, ажлын бус цагаар болон шөнийн ээлжинд ажиллах үед хоол, унааны зардал, сургалт, дадлагын үед хүнсний болон эдийн хангалтыг тагнуулын байгууллага хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд амраах, нөхөн сэргээх, эмчлүүлэх боломжоор хангана.

3. Албан үүргээ гүйцэтгэхдээ нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон тохиолдолд гарсан зардлыг тагнуулын байгууллага хариуцна.

4. Байгууллагынхаа шийдвэрээр өөр газарт шилжин ажиллах болсноос түүний эхнэр /нөхөр/ нь эрхэлж буй ажил, хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнд тагнуулын ажилтны нэг сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тагнуулын байгууллага олгоно.

5. Ээлжийн амралтаараа хөдөө орон нутаг явах бол түүний болон эхнэр /нөхөр/-ийн ирэх, очих замын зардлыг тухайн үед мөрдөж байгаа автомашин, төмөр замын үнэлгээгээр тооцож 2 жилд нэг удаа олгоно.

6. Гадаадын тусгай алба, байгууллага, гэмт бүлэглэлд нэвтрэн тусгай үүрэг гүйцэтгэсэн, ажиглалтын албанд болон техникийн албаны тусгай нэгжид ажилласан нэг жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно.

[12] https://legalinfo.mn/mn/detail?lawid=12458

7. Тагнуулын байгууллагын албан хаагч нь хуульд заасан бусад хөнгөлөлт, нөхөн төлбөр эдэлнэ.[13]

Тагнуулын байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг баталгаагаар хангагдахаас гадна Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан дараах эдийн засгийн баталгаагаар хангагдана. Тухайлбал:

1. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчид жил бүр ажлын 15 өдрийн амралт олгох ба төрийн алба хаасан 5 жил тутамд ажлын 2 өдрийн нэмэгдэл амралт олгоно.

2. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн цалин хөлс Төрийн албаны тухай хуулийн 57.2.3-т заасан цалин, нэмэгдлээс бүрдэнэ.

3. Өндөржүүлсэн бэлэн байдал, ажлын бус цагаар болон шөнийн ээлжид ажиллах үед хоол, унааны зардал, сургалт, дадлагын үед хүнсний болон эдийн хангалтыг төрийн тусгай хамгаалалтын газар хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд амраах, нөхөн сэргээх, эмчлүүлэх боломжоор хангана.

4. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон барилга, бусад зүйлийн гадна цэгт болон далд хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно.

5. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн харилцааг цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

6. Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч хуульд заасан бусад баталгаагаар хангагдана.[14]

Авлигатай тэмцэх газрын алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг баталгаагаар хангагдахаас гадна Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйлд заасан дараах эдийн засгийн баталгаагаар хангагдана. Тухайлбал:

1. Авлигатай тэмцэх газрын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж, үйл ажиллагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана.

2. Авлигатай тэмцэх газрын төсвийг улсын төсөвт тусгайлан тусгах бөгөөд энэхүү төсөв нь үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна.

3. Авлигатай тэмцэх газрын тухайн жилийн төсвийг өмнөх оны батлагдсан төсвийн хэмжээнээс бууруулан батлахыг хориглоно.

4. Авлигатай тэмцэх газрын гүйцэтгэх ажлын төсвийг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооноос хянаж, санал болгосноор Улсын Их Хурал батална.

5. Авлигатай тэмцэх газрыг ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техник хэрэгсэл, албан хаагчийг орон сууцаар хангах, авлигатай тэмцэх үйл ажиллагааны явцад туслалцаа үзүүлсэн этгээд, гэрчийг хамгаалах, тэдгээрт санхүүгийн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг улсын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.

[13] Төрийн мэдээлэл 1999. №35. Тагнуулын байгууллагын тухай хууль

[14] Төрийн мэдээлэл 1995 №7. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль

6. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин, албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, эрдмийн зэргийн нэмэгдлээс бүрдэх бөгөөд тэдгээрийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

7. Авлигатай тэмцэх газарт тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан албан хаагчид аминдаа орон сууц барих, амьдралын нэн тэргүүний хэрэгцээт зүйл худалдан авах, өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сургахад нь төрөөс хөнгөлөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгнө.

8. Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга нь Засгийн газрын гишүүнтэй адил бүрэн эрхийн баталгаа, хангамжтай байна.[15]

Хилчин нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг баталгаагаар хангагдахаас гадна Монгол Улсын Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасан дараах эдийн засгийн баталгаагаар хангагдана. Тухайлбал:

1. Иргэн улсын хилд албан үүрэг гүйцэтгэх үедээ гэмт халдлагын улмаас амь насаа алдвал түүний гэр бүлд энэ хуулийн 39.8-д заасан цалингийн дунджаар тооцсон таван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно.

2. Албан үүрэг гүйцэтгэж байгаад гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон бол эмчилгээний зардал, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэсэн зардлыг төр хариуцна.

3. Улсын хил дээр алба хааж байгаа хилчний гэр бүлийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгоно.

4. Хилийн салбар, харуулд алба хааж байгаа хилчин хүнсний хангамжаар хангагдах бөгөөд хүнсний хангамжийн хэмжээг Засгийн газар тогтооно.

5. Хилчин, түүний гэр бүлийг ээлжийн амралтаараа /нөхөр, эхнэрийн/ нутагтаа амарвал хоёр жилд нэг удаа ирэх, очих унааны зардлыг төр хариуцна.

6. Улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн салбарт 50 хувь, суурин бус газарт байрладаг хилийн цэргийн ангид 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн цэргийн анги, агаарын цэргийн салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно.[16]

Дотоодын цэргийн алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн нийтлэг баталгаагаар хангагдахаас гадна Дотоодын цэргийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан дараах эдийн засгийн баталгаагаар хангагдана. Тухайлбал:

1. Хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа дотоодын цэргийн алба хаагчид Цагдаагийн албаны тухай

[15] Төрийн мэдээлэл 2006 №35. Авлигын эсрэг хууль

[16] Төрийн мэдээлэл 2017. №6. Монгол Улсын Хилийн тухай хууль

хуулиар цагдаагийн алба хаагчид олгосон баталгаа нэгэн адил үйлчилнэ.

2. Дотоодын цэргийн алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авна.

3. Дотоодын цэргийн алба хаагчийн ажилласан хугацааг тооцоход улсын онц чухал обьектын харуул хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцно.[17]

Эрх зүйн зохицуулалтын хувьд төрийн тусгай алба хаагчид Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг баталгаагаар хангагдахаас гадна тус тусын байгууллагын үйл ажиллагааны онцлогоос хамааран эдийн засгийн нэмэгдэл баталгаа нь харилцан адилгүй байдлаар тусгагдсан болохыг доорхи хүснэгтээс харж болно.

Хүснэгт №1

№	Төрийн тусгай албан тушаалтан	Эрх зүйн зохицуулалт	Нийтлэг баталгаа	Ялгагдах онцлог шинж бүхий баталгаа
1.	Цагдаагийн албан хаагч	Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд	-ээлжийн амралтаараа явах замын зардлыг 2 жилд нэг удаа олгоно. -шилжин ажиллах бол гэр бүлийн гишүүнийг ажлаар хангах ба хангаагүй бол эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг улсаас олгоно. -Гадаад улсын цагдаагийн их, дээд сургуульд суралцагч суралцах хугацааны цалин хөлс, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна. -Цагдаагийн байгууллага алба хаагчийг өндөржүүлсэн бэлэн байдал болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеийн хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно. -Цолны цалин болон төрийн тусгай алба хаасан хугацаа, албан ажлын онцгой нөхцөл, цагдаагийн мэргэжлийн зэргийн болон эрдмийн зэрэг, цолны, хуульд заасан бусад нэмэгдлийг авна	- Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц байдлын үед болон голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчид албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.

[17] Төрийн мэдээлэл. 2017. №12. Дотоодын цэргийн тухай хууль

2.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллаг ын алба хаагч	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 287 дугаар зүйл	- өөр аймаг, хот суурин газарт шилжин ажиллах бол гэр бүлийн гишүүнийг ажлаар хангах бөгөөд хангаагүй тохиолдолд эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс олгоно. - өндөржүүлсэн бэлэн байдал зарласан үед болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеийн хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгоно. - шилжин ажиллахаар томилогдсон алба хаагчид уналга, ачаа тээш, зам хоногийн зардал, түүний гэр бүлийн болон асрамжид нь байдаг хүнд уналга, ачаа тээшийн зардлыг тооцож олгоно. - их, дээд сургуульд суралцагч алба хаагчийн суралцах хугацааны сургалтын тэтгэлэг, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна.	- Ээлжийн ажил, үүрэг гүйцэтгэдэг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийг онцгой тохиолдолд илүү цагаар ажиллуулсан бол ажилласан цаг тутамд ногдох албан тушаалын цалинг олгоно.

3.	Онцгой байдлын алба хаагч	Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйл	- их, дээд сургуульд суралцагч алба хаагчийн суралцах хугацааны сургалтын тэтгэлэг, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцна - онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ албан тушаалын үндсэн цалингийн 30 хувиас доошгүй байна - Онцгой байдлын байгууллагын захиалгаар суралцсан, онцгой байдлын алба хаагчийг бэлтгэх чиг үүрэг бүхий дээд боловсролын сургалтын байгууллагад цэргийн цолтой ажилласан, хугацаат цэргийн алба хаасан, онцгой байдлын сургуульд сонсогчоор суралцсан, уул уурхайн аврах албанд ажилласан хугацааг онцгой байдлын байгууллагад төрийн тусгай алба хаасан хугацаанд оруулан тооцно	- Алба хаасан зургаан сар тутмыг найман сард дүйцүүлэн тооцно - Голомтын бүсэд ажилласан алба хаагчийн албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно - онцгой гавьяа байгуулсан тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 100 дахин хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх мөнгөн урамшуулал олгож болно. - амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгоно. - Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт тухайн аймгийн харьяалалгүй алба хаагчийг томилбол үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх нэмэгдлийг улирал тутамд олгоно. - Аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй 5 ба түүнээс дээш жил ажилласан бол таван жил тутамд 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулыг олгоно - Албан үүргээ гүйцэтгэх явцад хөдөлмөрийн чадвараа алдсан бол алдалтын хувь хэмжээг харгалзан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30, 60, 90 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн нөхөн олговор олгоно

4.	Тагнуулын байгууллагын алба хаагч	Тагнуулын байгууллагын тухай хуулийн 24 дүгээр зүйл	- Өндөржүүлсэн бэлэн байдал, ажлын бус цаг болон шөнийн ээлжинд ажиллах үед хоол, унааны зардал, сургалт, дадлагын үед хүнсний болон эдийн хангалтыг тагнуулын байгууллага хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд амраах, нөхөн сэргээх, эмчлүүлэх боломжоор хангана. - Нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон тохиолдолд гарсан зардлыг тагнуулын байгууллага хариуцна. - Байгууллагынхаа шийдвэрээр өөр газарт шилжин ажиллах болсноор эхнэр /нөхөр/ нь эрхэлж буй ажил, хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнд нэг сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тагнуулын байгууллага олгоно. - Ээлжийн амралтаараа хөдөө орон нутаг явах замын зардлыг 2 жилд нэг удаа олгоно.	- хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар тагнуулын байгууллагад цаашид ажиллах боломжгүй болсон тагнуулын ажилтныг өөр ажлаар хангах буюу эсхүл мэргэжил эзэмших, шинээр оршин суух газартаа төвхнөхөд тагнуулын байгууллага туслалцаа үзүүлж холбогдох зардлыг төр хариуцна - тусгай үүрэг гүйцэтгэсэн, ажиглалтын албанд болон техникийн албаны тусгай нэгжид ажилласан нэг жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно.
5.	Төрийн тусгай хамгаалалтын алба хаагч	Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 16 -р зүйл	- жил бүр ажлын 15 өдрийн амралт олгох ба төрийн алба хаасан 5 жил тутамд ажлын 2 өдрийн нэмэгдэл амралт олгоно - Өндөржүүлсэн бэлэн байдал, ажлын бус цагаар болон шөнийн ээлжид ажиллах үед хоол, унааны зардал, сургалт, дадлагын үед хүнсний болон эдийн хангалтыг төрийн тусгай хамгаалалтын газар хариуцах	- Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон барилга, бусад зүйлийн гадна цэгт болон далд хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно

6.	Авлигатай тэмцэх газрын алба хаагч	Авлигын эсрэг хуулийн 29 дүгээр зүйл		- АТГ-ын төсвийг улсын төсөвт тусгайлан тусгах бөгөөд хараат бусаар хэрэгжүүлэх шаардлагыг хангасан байна. - ажлын байр, шаардлагатай тоног төхөөрөмж, тээврийн болон техник хэрэгсэл, албан хаагчийг орон сууцаар хангах, туслалцаа үзүүлсэн этгээд, гэрчийг хамгаалах, тэдгээрт санхүүгийн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. - тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласан албан хаагчид аминдаа орон сууц барих, амьдралын хэрэгцээт зүйл худалдан авах, өөрийн хүсэлтээр суралцах болон хүүхдээ сургахад нь төрөөс хөнгөлөлттэй зээл олгох, шаардлагатай бол зээлийн баталгаа гаргаж өгнө
7.	Хил хамгаалах байгууллаг ын хилчин	Монгол Улсын Хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйл	- Улсын хил дээр алба хааж байгаа хилчний гэр бүлийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгоно. - Хилчин, түүний гэр бүлийг ээлжийн амралтаараа /нөхөр, эхнэрийн/ нутагтаа амарвал хоёр жилд нэг удаа ирэх, очих унааны зардлыг төр хариуцна.	- Хилийн салбар, харуулд алба хааж байгаа хилчин хүнсний хангамжаар хангана. - Улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа алба хаагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг сарын үндсэн цалингаас хилийн салбарт 50 хувь, суурин бус газарт байрладаг хилийн цэргийн ангид 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг анги, салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно
8.	Дотоодын цэргийн алба хаагч	Дотоодын цэргийн тухай хуулийн 36 дугаар зүйл	- дотоодын цэргийн алба хаагчид Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн алба хаагчид олгосон баталгаа нэгэн адил үйлчилнэ. - Дотоодын цэргийн алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авна. - Дотоодын цэргийн алба хаагчийн ажилласан хугацааг тооцоход улсын онц чухал обьектын харуул хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцно	

Төрийн тусгай алба хаагчдын эдийн засгийн баталгаануудаас хууль тогтоомжид Авлигатай тэмцэх газар болон Онцгой байдлын албаны алба хаагчид бусад алба хаагчдаас илүү эрх хэмжээний эдийн засгийн баталгаа эдлэхээр тусгагдсан байгааг харж болохоор байна. Тус баталгааны зарим зохицуулалт нь нь Авлигатай тэмцэх газрын эрүүгийн хэргийн мөрдөгч нарт илүүтэй хамаарч байна. Нийтлэг зохицуулалтуудыг түүвэрлэн авч үзвэл:

- Бүх цолтой төрийн тусгай алба хаагчид цолны цалин болон төрийн тусгай алба хаасан хугацаа, албан ажлын онцгой нөхцөл, цагдаагийн мэргэжлийн зэргийн болон эрдмийн зэрэг, цолны, хуульд заасан бусад нэмэгдлийг бүгд авдаг;
- Алба хаагчдын ээлжийн амралтаараа явах зардлыг Цагдаа, Тагнуул, Хил, Дотоодын цэрэг;
- Шилжин ажилласан алба хаагчийн гэр бүлийн гишүүнийг ажлаар хангах ба хангаагүй бол эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг улсаас олгох зохицуулалтыг Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Тагнуул, Хил, Дотоодын цэрэг;
- Гадаад улсын их, дээд сургуульд суралцагч суралцах хугацааны цалин хөлс, ирэх, буцах тээврийн зардлыг төр хариуцах зохицуулалтыг Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Тагнуул, Хил, Дотоодын цэрэг;
- Өндөржүүлсэн бэлэн байдал болон ажлын бус цагаар, шөнийн ээлжид, хээрийн сургууль, дадлагын үеийн хүнсний болон эдийн хангалтаар хангаж, хоолны зардлыг олгодог зохицуулалтыг Цагдаа, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Тагнуул, Төрийн тусгай хамгаалалтын газар, Дотоодын цэргийн алба хаагчид

Дүгнэлт. Төрийн албаны тухай хуульд заасан нийтлэг баталгаанууд төрийн тусгай алба хаагчдын үйл ажиллагааг зохицуулсан хуулинд агуулгын хувьд зохих хэмжээнд бүгд тусгагдсан байна. Төрийн тусгай албан тушаалд хамаарах албан тушаалтнуудаас цэрэг, цагдаагийн цолтой алба хаагчдын нэг ялгагдах онцлог шинж нь Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар нэмэгдэл эдийн засгийн баталгаа нь давхар хангагддаг байна.

Мөн дээрхи тусгай албан тушаалтад хамаарах алба хаагчдын эдийн засгийн баталгааг зарим нь өөрийнхөө хууль тогтоомжид тусгай зүйл болгоод оруулсан бол зарим нь үүргээ биелүүлэх баталгаа гэсэн нийтлэг нэршлийн хүрээнд

Түүнчлэн цэргийн цолтой төрийн тусгай алба хаагчдын үйл ажиллагааны эрх хэмжээг зохицуулсан хуулинд тусгагдсан эдийн засгийн баталгаанууд нь тэдний хүнд хэцүү нөхцөлд үүрэг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх нэг зохицуулалт болдог байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Тухайлбал:

1. Ээлжийн ажил, үүрэг гүйцэтгэдэг алба хаагчийг онцгой тохиолдолд илүү цагаар ажиллуулсан бол ажилласан цаг тутамд ногдох албан тушаалын цалинг олгох зохицуулалтыг цэргийн цолтой төрийн тусгай тушаалд хамаарах алба хаагчдад олгох зохицуулалтыг бий болгох;
2. Амь нас, эрүүл мэнд хохирох өндөр эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэвэл мөнгөн урамшуулал олгох Онцгой байдлын алба хаагчдын эдэлдэг баталгааг цэргийн цолтой төрийн тусгай тушаалд хамаарах алба хаагчдад нэгэн адил хамаатуулах;

3. Алслагдсан аймаг, сумын нутаг дэвсгэрт тухайн аймгийн харьяалалгүй алба хаагчийг томилон ажиллуулбал үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх нэмэгдлийг улирал тутамд олгодог зохицуулалтад цэргийн цолтой төрийн тусгай тушаалд хамаарах алба хаагчдад нэгэн адил хамаатуулах;

Ашигласан материал

Монгол Улсын хууль:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Авлигын эсрэг хууль
3. Төрийн албаны тухай хууль
4. Цагдаагийн албаны тухай хууль
5. Дотоодын цэргийн тухай хууль
6. Монгол Улсын Хилийн тухай хууль
7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль
8. Тагнуулын байгууллагын тухай хууль
9. Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль

Ном, сурах бичиг, гарын авлага

10.Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгэм тогтолцоо ба бодлого. Уб.2013.

Сэтгүүл, судалгааны ажил:

1. Төрийн мэдээлэл. 1992. №1
2. Төрийн мэдээлэл 1995 №7
3. Төрийн мэдээлэл 1999. №35
4. Төрийн мэдээлэл. 2017. №8
5. Төрийн мэдээлэл 2017. №24
6. Төрийн мэдээлэл 2017. №6
7. Төрийн мэдээлэл. 2017. №12
8. Төрийн мэдээлэл. 2018. №1
9. Төрийн мэдээлэл. 2018. №1

Цахим эх сурвалж:

10.legalinfo.mn

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ПРОЦЕССИЙН ЭРХ ЗҮЙН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

CHALLENGE IN FOCUS: MONGOLIAN CONSTITUTIONAL PROCEDURAL LAW

С.Оюунчимэг
ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хошууч
Oyunchimeg.S
Senior lecturer, department of civil law, Law and Social Science Institute, the University of Internal Affairs, Mongolia, major

Хураангуй: Үндсэн хуулийн хяналтыг Үндсэн хуулийн шүүх журмаар хэрэгжүүлдэг улс орны туршлага, эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд нийтлэг байдлаар аливаа иргэн Үндсэн хуулийн шүүхэд хандахдаа зөвхөн өөрт хамаарах асуудлаар буюу өөрийн эрх, эрх чөлөө нь “зөрчигдсөн” гэх үндэслэлээр хандахаас бус, өөр бусад иргэн, нийтийн эрх ашгийн өмнөөс хандах эрхгүй байдаг. Тэгвэл Монгол Улсын хувьд ийм хязгаарлалт байдаггүй онцлогтой. Иргэн хүн Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх аль ч асуудлаар хандах өргөн эрхтэй байдгаараа бусад улсын Үндсэн хуулийн шүүхээс онцлогтой. Уг онцлог нь давуу талыг агуулдаг боловч бодит байдал дээрээ олон дутагдалтай байдлыг үүсгэж байдгийг анхаарах хэрэгтэй.

Abstact: A study of the experience and legal regulation of countries where constitutional control is exercised by the Constitutional Court generally shows that when a citizen appeals to the Constitutional Court not only on matters that concern him or her but also on the grounds that his or her rights and freedoms have been "violated." have no right to act on behalf of profit. It is strange there are not those restrictions in Mongolia. It is the difference that a citizen has the right to appeal to any issue within the jurisdiction of the Constitutional Tsets from the Constitutional Courts of other countries It should pay attention that this feature has its advantages, but in practice, it has many disadvantages.

Түлхүүр үг: Үндсэн хуулийн цэц, Үндсэн эрх, Үндсэн хуулийн хяналт, үндсэн хуулийг дээдлэх, Үндсэн хуулийн маргаан

Keywords: Constitutional court, basic liberty, Constitutional control, Constitutional power, Constitutional debate

Монгол Улсад 1990 оны ардчилсан хувьсгалийг хуульчлан бэхжүүлсэн Үндсэн хуулийг 1992 онд баталж тус улсын зорилгын туйлыг эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан байгуулах явдал гэж тунхаглажээ. Хүний эрх эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, нийгэм улс төрийн тогтолцоог ардчилж хувийн болон нийтийн өмчийн аливаа хэлбэрийн тэгш эрхийг баталгаажуулсан зах зээлийн харилцааг хөгжүүлсэн хүн төрөлхтөний хөгжлийн түгээмэл зүй тогтолд нийцсэн нийгмийг байгуулах асуудал МУ-ын шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалын тулгуур суурь нь юм.

МУ-д шинэ Үндсэн хуулиа баталсанаас хойш гучаад жилийн хугацаанд уг хуульд нийцүүлэн нийгмийг жолоодон зохион байгуулах гол хүч төрийн байгууллагын зохион байгуулалт үйл ажиллагааг ардчилах, нийгмийн харилцааг зохицуулах үндсэн хэрэгсэл эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлэх талаар олон ажил хийсэн боловч өнөөдрийг хүртэл үргэжилж л

байна. Өнгөрсөн хугацаанд төрийн эрх барих дээд байгууллага Улсын их хурлын болон төрийн тэргүүн Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг тус бүр 8 удаа явуулж эдгээртэй уялдуулж орон нутгийн өөрөө удирдах байгууллага засаг захиргаа болон гүйцэтгэх засаглалын эрх мэдлийн бүх шатны байгууллагын бүтэц зохион байгуулалтад ихээхэн өөрчлөлт хийлээ.

Дээрхи гучаад жилийн 2003 он хүртлэх эхний арван жилийн хугацаанд шинэ Үндсэн хуульд нийцүүлэн хийсэн эрх зүйн шинэтгэлийн үр дүнд төр засгийн дээд, төв, орон нутгийн болон салбарын байгууллагуудын эрх зүйн орчинг бүхэлд нь бүрдүүлэв. Үүнд Улсын их хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага засаг захиргааны харилцааг зохицуулсан хуулиуд, Үндсэн хуулийн цэц, Шүүхийн тухай болон прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр биелүүлэх, өмгөөлөх зэрэг байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулдаг олон нэр төрлийн хуулиудыг гаргасан[1] билээ. Цаашилбал 2017 оныг дуустал сүүлийн 10 дахь жилд Монгол улсын хэмжээнд дахин эрх зүйн шинэтгэлийг Шүүхийн тухай багц хууль, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай багц хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай гэх мэт хуулиудаар дамжуулан хууль зүйн салбарын шинэтгэлийг хийлээ.

Мөн Монгол улсын Үндсэн хуульд 2019 оны 11 сарын 14-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулж 2000 онд Үндсэн хуульд орсон зарим алдаатай нэмэлт өөрчлөлтийг засах зорилгоор, Монгол улсын үндсэн хуулийн зорилго, түүнийг хангах хөгжлийн зарим саад тотгорыг Үндсэн хуулийн хүрээнд засварлах зорилгоор нэмэлт өөрчлөлтийг бүх ард түмнээр хэлэлцүүлж, санал асуулгын дүнг нэгтгэх замаар өөрчлөлтийг оруулсаан. Одоо бидэнд Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг органик хуулиар дэлгэрүүлэн хуульчлах, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байна. Тэр дундаа миний илтгэлийн агуулга болох Үндсэн хуулийн процессын эрх зүйн зарим асуудалд анхаарлаа хандуулъя.

Монгол Улс ардчилсан шинэ тогтолцоонд шилжин эрх зүйт төрийг бүрэлдүүлэх үндэс болсон шинэ Үндсэн хуулийг 1992 онд батлахдаа Үндсэн хуулийг хамгаалах, түүний биелэлтэд дээд хяналт тавих чиг үүрэг бүхий үндсэн хуулийн шүүхийг Үндсэн хуулийн цэц нэртэй байгуулсан билээ. Энэ нь дэлхийн ардчилсан олон улс орнуудын түгээмэл чиг хандлагад нийцсэн цоо шинэ институтийг Монгол Улсад бий болгосон ололт болсон.

Үндсэн хуулийн шүүх бол Үндсэн хуулийг хэлбэрэлтгүй сахин хамгаалахын тулд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагууд болон эрх мэдэл бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагаа Үндсэн хуулийн тулгуур үзэл баримтлалд нийцэж буй эсэхийг хянаж, түүнд нийцүүлж эрх баригчдын эрх мэдлийг хязгаарлах, хүний хөндөгдсөн, хязгаарлагдсан эрхийг сэргээн тогтоох чадамжтай байгууллага байх ёстой юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлд “Монгол

[1] Г.Совд, С.Нарангэрэл. Ред. “Хууль зүйн тайлбар толь” /хамтын бүтээл/. УБ., 2003 он,

Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага мөн" хэмээн заасан. Энэ талаар Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүргээ энэ хуульд заасан маргааны талаар дүгнэлт гаргах, энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргааныг магадлан шийдвэрлэх замаар хэрэгжүүлнэ" гэсэн байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэж, магадлан шийдвэрлэж Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгааг хангахад оршино.[2] Тодруулж хэлбэл, Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавих чиг үүргээ Үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэх үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ. Иймд Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг зохицуулдаг эрх зүйн орчин тодорхой бөгөөд ямар нэгэн хийдэлгүй байх нь нэн чухал асуудал.

Шинэ Үндсэн хууль баталсны дараахан 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Монгол Улсын Бага Хурлаас Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг, 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг тус тус баталж, Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг дээрх хоёр хуулиар зохицуулж ирсэн. Үндсэн хуулийн цэц байгуулагдсанаас хойших 25 жилийн хугацаанд уг 2 хуульд зарим нэмэлт, өөрчлөлт орсныг эс тооцвол Үндсэн хуулийн үзэл баримтлал, суурь зарчим, нийгмийн хөгжлийн чиг хандлага, эрх зүйн шинэтгэлийн үйл явцтай уялдсан дорвитой өөрчлөлт хийгдээгүй өнөөг хүрсэн байна. Монгол Улсын хувьд өмнө нь Үндсэн хуулийн биелэлтэд хяналт тавьж, Үндсэн хуулийн маргаан шийдвэрлэж ирсэн практик туршлага, энэ талаарх онолын суурь болон харьцуулсан судалгаа хийгдэж байгаагүй тэр үед дээрх хуулиудыг батлагдсан нь хуулиар зохицуулбал зохих зарим харилцааг зохицуулалтгүй орхигдуулсан, давхардал, хийдэлтэй зэрэг учир дутагдалтай зохицуулалтууд одоог хүртэл үйлчилсээр байна. Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийг дэлхийн бусад улсын Үндсэн хуулийн шүүхийн нийтлэг жишигт ойртуулах, үндсэн хуулийн эрх зүйн маргааныг Үндсэн хуулийнхаа үзэл баримтлалд нийцүүлэн онолын түвшинд, хараат бус, үнэн зөв, бодитой шийдвэрлэх эрх зүйн орчин, бусад баталгааг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага энэ цаг үед зүй ёсоор үүсээд байгаа билээ. Мөн сүүлийн жилүүдэд шүүх эрх мэдлийн хүрээнд хийгдэж буй өөрчлөлт, шинэтгэлтэй Үндсэн хуулийн цэцийн тухай хууль тогтоомжийг уялдуулах асуудал үүсээд байна.

Энэ үүднээс судлаач миний бие уг илтгэлийн хүрээнд Үндсэн хуулийн цэцийн чиг үүрэг, мөн чанарт нь нийцүүлэн Үндсэн хуулийн цэцийн

[2] Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 1 дүгээр зүйл

маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг улам боловсронгуй болгохтой холбоотой зарим асуудлыг энд дурдаж, шийдвэрлэх арга замыг талаарх өөрийн саналаа илэрхийлэхийг зорьсон болно.

Монгол Улсын Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн тухай холбогдох хууль заасаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын тогтоол, бусад шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, сонгуулийн төв байгууллагын санал асуулга, сонгуулийн талаарх шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаарх маргааныг хянан шийдвэрлэж, Үндсэн хуульд нийцээгүй болох нь тогтоогдсон тохиолдолд хүчингүй болгох эрхтэй. Мөн төрийн дээд албан тушаалтнууд буюу Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч, Улсын Ерөнхий прокурор /үйл ажиллагаа, ёс зүй, шийдвэр/ Үндсэн хууль зөрчсөн эсэх, тэднийг огцруулах, эгүүлэн татах үндэс байгаа эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэгтэй байдаг. Эдгээр нь Үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргаан юм.

Монгол Улсын ердийн болон дагнасан шүүхийн, мөн дэлхийн ихэнх улс орны Үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдвэрлэх асуудлыг маргааны агуулгаар нь хуульчлан тогтоосон байдаг. Харин Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хянан шийдвэрлэх маргааныг Үндсэн хууль болон салбар хуулиар тогтоохдоо жагсаалтын гаргах байдлаар буюу “тоочих” хэлбэрээр тусгасан[3]. Энэ нь харьяалан шийдвэрлэх маргааны төрлийг нэмэгдүүлэх буюу иргэний үндсэн эрхийг хяналтыг хэрэгжүүлэхүүлэх боломжийг хязгаарлаж байдаг. Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээг Үндсэн хуульдаа[4] нэгэнт тоочиж заасан тул Үндсэн хуулийн цэцийн тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох замаар уг асуудлыг бүрэн шийдвэрлэх боломж хомс гэж зарим Цэцийн гишүүд, эрдэмтэд үздэг. Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан, эрдэмтэн Ц.Сарантуяа “Цэц одоо үйлчилж байгаа хууль тогтоомжийн дагуу хууль тогтоох эрх мэдлийг бүхэлд нь (хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр), гүйцэтгэх эрх мэдлээс зөвхөн заримыг (зарлиг, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын тогтоол, бусад шийдвэр) нь хянах эрхтэй, харин шүүх эрх мэдлийн байгууллагын шийдвэрийг хянах боломж хуульчлагдаагүй байна”[5] хэмээн дүгнэсэн байдаг. Мөн Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргааныг өргөтгөх буюу иргэний үндсэн эрхийн маргааныг Цэц шийдвэрлэх нь зүйтэй гэсэн байр суурьтай эрдэмтэн, судлаач нар цөөнгүй бөгөөд өөрсдийн бүтээл, илтгэл, судалгааны багийн дүгнэлт, зөвлөмж зэрэгтээ энэ талаарх байр сууриа цөөнгүй илэрхийлсэн байна.[6]

Харин илтгэгчийн зүгээс Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлд заасаар “Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих”

[3] Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг

[4] Мөн тэнд

[5] Сарантуяа Ц., “Үндсэн хуулийн процессын эрх зүй” Улаанбаатар, 2005, 128-129 дэх тал

[6] Эрдэмтэн Чимид Б., Амарсанаа Ж., Энхбаатар Ч., Сарантуяа Ц., Өнөрбаяр Ч., Тэмүүжин Х., Мөнхсайхан О. болон бусад судлаач нарын бүтээл, илтгэл, нийтлэл, өгүүлэлд цөөнгүй дурдагдсан байна.

бүрэн эрхийг Үндсэн хуулийн цэцэд олгогдсон учир энэхүү “дээд хяналт”-ын хүрээнд иргэдийн үндсэн эрхийн маргаан буюу Үндсэн хуулийн гомдол /Constitutional complait/-ыг хянах боломжтой хэмээн үзэж байна. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл дэх “Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт” гэсэн ойлголтыг Үндсэн хуулийн биелэлтэд тавих бүрэн хяналт, Үндсэн хуульд бүрэн хяналт тавих гэсэн агуулгаар ойлгож болох бөгөөд Үндсэн хуульт ёс болон Үндсэн хуулийн шүүхийн өөрийнх нь зорилго, чиг үүргийн агуулгаас авч үзвэл энэ хүрээнд иргэдийн үндсэн эрхийн маргааныг хянан шийдвэрлэж боломжтой. Цэц Үндсэн хуулийн биелэлтэд бүрэн буюу дээд хяналт тавих чиг үүргийнхээ дагуу аливаа төрийн буюу нийтийн захиргааны байгууллага, шүүхийн шийдвэр иргэн хүний үндсэн эрхийг зөрчсөн эсэхийг холбогдох маргааныг хянан шийдвэрлэх замаар тогтоож, холбогдох хүний эрхийг зөрчлийг таслан зогсоох үндэстэй юм. Үндсэн хуулийн эхийг баригч, доктор Б.Чимид багш нэгэнтээ Үндсэн хуульт ёсны үзэл баримтлалаар Үндсэн хуулийн хяналтыг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой талаар дурдсан байдаг. Мөн Үндсэн хуулийн эрх зүй судлаач эрдэмтэд энэхүү үзэл санааг дэмжсэн санал, дүгнэлтийг өөрсдийн бүтээл, илтгэл, судалгаандаа цөөнгүй тусгаж ирсэн байдаг[7].

Дээрхээс дүгнэхэд, Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлд заасан “Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих” чиг үүргийн хүрээнд иргэдийн үндсэн эрхийн маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх боломжтой талаар Монгол Улсын хуульчид, эрдэмтэд, түүнчлэн холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнууд нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай байна. Мөн энэ хүрээндээ Үндсэн хуулийн цэцийн холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгон өөрчилж Үндсэн хуулийн гомдлыг хянан шийдвэрлэх журмын талаарх тусгайлсан зохицуулалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд тусган уг асуудлыг шийдвэрлэх боломжтой байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Үндсэн хууль зөрчсөн маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар, эсвэл Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэдэг. Иргэн өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдөж байна гэж үзвэл Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх аль ч асуудлаар Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргадаг. Харин өөрийнх нь эрх, хууль ёсны ашиг сонирхол, эрх чөлөө хөндөгдөөгүй боловч нийтийн ашиг сонирхлын үүднээс Үндсэн хуулийн цэцэд хандахдаа мэдээлэл ирүүлнэ.

Үндсэн хуулийн хяналтыг Үндсэн хуулийн шүүх журмаар хэрэгжүүлдэг улс орны туршлага, эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд нийтлэг байдлаар аливаа иргэн Үндсэн хуулийн шүүхэд хандахдаа зөвхөн өөрт хамаарах асуудлаар буюу өөрийн эрх, эрх чөлөө нь “зөрчигдсөн” гэх үндэслэлээр хандахаас бус, өөр бусад

[7] Улсын Их Хурал болон НҮБ- Хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: дүн шинжилгээ, Улаанбаатар, 2015, 79-80 дахь тал гэх мэт

иргэн, нийтийн эрх ашгийн өмнөөс хандах эрхгүй байдаг. Тэгвэл Монгол Улсын хувьд ийм хязгаарлалт байдаггүй онцлогтой. Иргэн хүн Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх аль ч асуудлаар хандах өргөн эрхтэй байдгаараа бусад улсын Үндсэн хуулийн шүүхээс онцлогтой. Уг онцлог нь давуу талыг агуулдаг боловч бодит байдал дээрээ олон дутагдалтай байдлыг үүсгэж байдаг. Үндсэн хуулийн цэцийн практикийг судлан үзэхэд дараах дутагдалтай тал ажиглагдаж байна. Үүнд:

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байна. [8]

Шүүхийн агуу их хэмээн нэрлэж болох тэр зорилго нь хүчирхийлэх аливаа үзэл санааг эрх зүйн үзэл санаагаар сольж, төр засаг ба түүний ашиглах дуртай хүч хоёрын завсар эрх зүйн саад тогтооход оршдог. Энд Үндсэн хуулийн шүүх (хяналт)-ийн гүйцэтгэх үүрэг маш их. Европ даяар шүүхгүй Үндсэн хууль шүдгүй арслан лугаа адил гэж ярьдаг нь үүнтэй салшгүй холбоотой билээ.

Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон улс орнуудад Үндсэн хуулийн шүүхийг байгуулах замаар төрийн үйл ажиллагаанд тавих шүүхийн хяналтыг төлөвшүүлэх явдал түгээмэл байна.[9] Тухайлбал, ардчилсан сонгуулийн дүнд тогтсон төр засгийн бодлогын үр дүнд Европын олон улс оронд фашист дэглэм тогтож, үүний уршгаар дэлхийн 2 дугаар дайныг өдөөсөн. Дайны дараагаар улс орны төр, нийгмийн байгууллыг сэргээн тогтоох, шинэчлэх ажлын хүрээнд Үндсэн хуулийн төслийг боловсруулахад хоёр үндсэн асуудлыг төсөл боловсруулагчид анхаарч байсан юм.

Нэгдүгээрт, аливаа төр засаг, түүний дотор ардчилсан сонгуулийн дүнд байгуулагдсан төр ч хүний үндсэн эрхийг зөрчиж болохгүй, Хоёрдугаарт, хүний үндсэн эрхийг хамгаалах Үндсэн хуулийн шүүхийг байгуулах явдал байсан юм.[10] Үүнтэй төсөөтэй гэж хэлж болох зүй тогтол, үйл явцыг Монгол Улс тойрч гараагүй юм. Тодруулбал, Монгол улсад Үндсэн хуулийн хяналтын тухай үзэл санаа анхлан БНМАУ-ын Ардын Их Хурлын XI дэх удаагийн сонгуулийн IX чуулган (1990 оны 5 дугаар сар) БНМАУ- ын Үндсэн хуулийн Нэмэлтийн хуулийг баталж мөрдүүлсний дараа Үндсэн хуулийн хяналтын тусгай байгууллагын тухай асуудал яригдаж эхэлсэн юм. Чингээд БНМАУ-ын Ардын Их Хурлын XII дахь удаагийн сонгуулийн анхдугаар хуралдаанаар (1990 оны 9 дүгээр сар) "БНМАУ-ын Үндсэн хуулийн хяналтын зөвлөлийн тухай асуудлыг хэлэлцсэн байна. Эл

[8] Монгол Улсын Үндсэн хуулийн шүүхийг "Цэц" хэмээн нэрлэсэн нь бас учиртай. Я.Цэвэл абугайн "Монгол хэлний товч тайлбар толь"-д Цэц "юмны онч, цэц булаалдах, цэц харвах, цэц хэлэлцэх" хэмээн тайлбарласан байна. Тэгэхлээр асуудлын ончийг олж мэргэн шийдвэрлэх гэсэн угийн утгаар энэ үгийг сонгон авсан нь илэрхий байна. Утгын хувьд бас монгол төрийн болон үндэсний уламжлалыг бодолцсон аж. Энэ нь нэг талаас, Их Монгол Улсын үеэс хаанд зөвлөх эрх бүхий Сэцдийн зөвлөл ажиллаж, Цэц гэдэг үгийг төрийн чухал институцийн нэр болгож байсан төрийн түүхэн уламжлалыг, нөгөө талаас, монгол үндэсний сонгодог спорт-эрийн гурван наадмын гол цөм болох бөхийн маргааныг магадлан шийдвэрлэдэг хөлийн цэц" дээр үеэс ажиллаж, асуудлыг ончтой зөв шийдэж ирсэн үндэсний уламжлалыг бодолцсон хэрэг юм. Гол нь улсын гол хууль Үндсэн хуулийг онч мэргэнээр сахин хамгаалах утгыг бэлгэдэж, Үндсэн хуулийн цэц хэмээн нэрлэсэн болой.

[9] Tom Ginsburg, Judicial Review in New Democracies: Consttutional Courts in Asian Cases, Cambridge University Press, 2003, Өмнөтгөл хэсэг

[10] Tom Ginsburg, Judicial Review in New Democracies: Constitutional Courts in Asian Cases, Cambridge University Press, 2003, P 2

хуралдаан дээр депутат Т.Очирхүү, О.Очиржав, Ч.Пүрэвдорж, С.Баяр, Ж.Чунагсүрэн, Ч.Хурц, Э.Бат-Үүл нарын 10 гаруй хүн үг хэлж, тэдний зарим нь ийм зөвлөл байгуулах нь зүйтэй гэж үзэж байхад, нөгөө хэсэг нь зөвлөл байх хэрэггүй гэсэн санал гаргасан байна. Эцэст нь БНМАУ-ын Үндсэн хуулийн хяналтын зөвлөл байгуулах эсэх тухай санал хураалгахад хуралдаанд оролцсон депутатуудын их зонхийн саналаар энэ удаад тийм зөвлөл байгуулах шаардлагагүй гэж үзсэн юм.[11]

Харин Монгол Улсын Үндсэн хуулийн төслийн анхны хувилбарыг Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг боловсруулан комиссоор дахин дахин хэлэлцсэний дараа Улсын Бага Хурлаар хүлээн зөвшөөрч "Монгол Улсын Их Цааз" гэсэн нэртэйгээр оршил, таван бүлэг, наян нэгэн зүйлтэй төслийг ард нийтээр хэлэлцүүлсэн юм. Төслийн гуравдугаар бүлгийн "Шүүх эрх мэдэл" гэсэн дөрөв дэх хэсгийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх, Их цаазын холбогдолтой маргааныг хянан шийдвэрлэх эрхийг Их цаазын цэц тус тус хэрэгжүүлнэ" гэж шүүх эрх мэдлийн бүлэгт багтаан хуульчлахаар төлөвлөж байжээ.

Хожим шинэ Үндсэн хуулийг хэлэлцэн батлахад төслийн анхны хувилбарт тусгагдсан байсан Цэцийн гишүүний тоотой холбогдсон, Ерөнхийлөгч байсан хүн чөлөөлөгдсөний дараа Цэцийн гишүүн байж болох, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газрын хооронд гарсан маргааныг шийдвэрлэх, төрийн дээд байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг Улсын Их Хурал болон Ерөнхийлөгчийн хүсэлтээр хянан үзэх, Цэцийн шийдвэрийг ард нийтийн санал хураалтаар хүчингүй болгох заалтуудыг хассан байна.

Улмаар 1992 онд Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсанаар Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх шүүх байгуулах эрх зүйн үндэс бүрджээ. Үндсэн хуулийн хяналтын зөвлөл, холбоо хэлбэрийн системийн үйл ажиллагааны зарим дутагдал илт байсан тул хуучин социалист орнууд дайны дараах Европт өргөн дэлгэрсэн загвар болон хэлбэрээр Үндсэн хуулийн хяналтын институтийг байгуулах үзэл санааг дэмжин хүлээж авсан. Монгол Улс ч үүний нэгэн адил Үндсэн хуулийн хяналтыг Үндсэн хуулийн шүүх байдлаар авч хэрэглэсэн бөгөөд өнөөдөр эрдэмтэд Үндсэн хуулийн Цэц хэмээх оноосон нэртэй Үндсэн хуулийн шүүхтэй болсон нь манай улсын хувьд орчин үеийн ардчилсан эрх зүйт төр рүү хийсэн зарчмын том алхам боллоо хэмээн дүгнэж байна.[12] Үндсэн хуулийн цэцийг үндсэн хуулийн шүүх мөн эсэх талаар маргах нь өдгөө ач холбогдол багатай юм. Учир нь Үндсэн хуулийн маргааныг шийдвэрлэдэг байгууллага бол шүүх мөн. Цэц бол Үндсэн хуулийн маргааныг шийдвэрлэдэг байгууллага. Үүнээс үүдээд Цэц бол шүүх гэж үзнэ.[13] Нөгөө талаар Цэц нь шүүхийн журмаар ажилладаг, Үндсэн хуулийн маргааныг

[11] Улсын Их Хурлын Тамгын газрын Архивын материал, Үндсэн хуулийн төсөл боловсруулах үед холбогдох баримт бичгүүд.

[12] Ц.Сарантуяа, Үндсэн хууль ба үндсэн хуулийн шүүх: Үндсэн хуулийг шүүхийн журмаар хамгаалах асуудалд, Монголын төр, эрх зүй сэтгүүл, 2002, №1, 21 дэх тал

[13] Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн үзэл баримтлал бол эрх зүйн системийн хууль зүйн үндэс мөн, (Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл), Уб, 2007, 168 дахь тал

эцэслэн шийдвэрлэх замаар Үндсэн хуулийг хэрэглэдэг, тайлбарладаг.

Энэ тухай доктор, профессор Н.Жанцан "Үндсэн хуулийн цэцийг шүүх болгож байгаа үндсэн шинжийг дараах байдлаар тодорхойлж болох юм. Нэгд: Цэц маргааныг магадлан шийдвэрлэдэг байгууллага. Хоёрт: Цэц Үндсэн хууль зөрчсөн маргааныг зөвхөн өргөдөл, мэдээллийн үндсэн дээр буюу тодорхой субъектийн хүсэлтээр авч үзнэ. Өөрөөр хэлбэл өөрийн санаачилгаар маргааныг авч шийдвэрлэхгүй. Гуравт: Шийдвэрлэж байгаа маргааны талаар эцсийн шийдвэр гаргана"[14] гэжээ. Үүний зэрэгцээ Үндсэн хуулийн цэцийн шийдвэр нь заавал биелэгдэх шинжтэй байдаг, гармагцаа хүчин төгөлдөр болдог зэрэг нь Цэцийг шүүх болохыг давхар нотлох нэг гол шалгуур үзүүлэлт билээ.[15]

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа юм. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийг Улсын Их Хурал. Ерөнхийлөгч, Засгийн газрын нэгэн адил Үндсэн хуулийн байгууллага гэж үздэг.

Эрх зүйн хэм хэмжээний онолыг үндэслэгч Ханс Кельзен нийтийн эрх ашгийг илэрхийлсэн өргөдөл, мэдээллийн талаар дүгнэж хэлэхдээ "нийтийн эрх ашгийг илэрхийлсэн өргөдөл, мэдээлэл /actio popularis/ нь Үндсэн хуулийг хамгаалах хүчирхэг баталгаа юм. Гэвч ийм өргөдөл, мэдээлэл гаргагч нь өөрийн эрхээ зүй бусаар ашиглах өндөр магадлалтай, мөн Үндсэн хуулийн шүүхэд ийм өргөдөл, мэдээлэл ихээхэн ачаалал үүсгэх эрсдэлтэй байдаг" гэж үзэж тэрээр ийм зохицуулалтыг дэмждэггүй байжээ.[16] Тодруулж хийсвэр жишээ авч тайлбарлавал Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн одоогийн зохицуулалтаар аливаа нэг иргэний мэдээллийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдыг огцруулах боломжтой бөгөөд тухайн хүний цаана байгаа ашиг сонирхлыг Цэцээс тогтоох боломжгүй байдаг. Энэ мэт мэдээллийг шалгах ажиллагааны үр дүнд тухайн албан тушаалтын албаны нэр хүнд болон цаашлаад Засгийг газар, төрийн байгууллыг тогтвортой байдалд асуудал үүсэх боломж ямар нэг байдлаар байдаг, ялангуяа нийгмийг сүлжээ өндөр хөгжсөн одоогийн нийгэмд. Бусад улсын туршлагыг судлан үзэхэд Үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдвэрлэх аливаа маргаан тухай бүрт хандах эрх бүхий этгээдийг хуулиар нарийн тогтоосон байдаг.

Дүгнэлт

Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмууд нь холбогдох хуулиудад хэт ерөнхий томьёологдсон байдаг. Иймд шүүхийн шинэтгэлийн хүрээнд хийгдсэн

[14] Н.Жанцан, Үндсэн хуулийн цэц ба Үндсэн хуулийн үзэл санаа, (Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл), Уб. 2007, 152 дахь тал

[15] Н. Жанцан, Үндсэн хуулийн цэц ба үндсэн хуульт ёсны төлөвшил, Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын хандлага. ОУЭШБХуралд тавьсан илтгэлийг үзнэ үү.

[16] Арне Мавчич "Үндсэн хуулийн хяналт", Улаанбаатар, 2014, /Г.Баясгалан, Д.Сугар, Д.Одбаяр нарын орчуулга, үүсмэл бүтээл/ 63 дахь тал

дэвшилттэй зохицуулалтыг Үндсэн хуулийн процессын хууль тусгах талаар алхам хийх хэрэгтэй гэж судлаачийн зүгээс харж байна. Тухайлбал, Үндсэн хуулийн цэц нийтийн эрх зүйн маргааныг шийдвэрлэдэг шүүхийн хувьд нотлох баримтыг шүүх цуглуулах талаарх мөрдөн шалгах зарчим Цэцэд үйлчлэх ёстой. Энэ үндэслэлээр холбогдох процессын хуульд уг зарчмыг тусгах хэрэгтэй байна. Мөн уг хүрээнд нотлох баримт цуглуулах талаарх эрх зүйн зохицуулалт тун дутагдалтай байгаа одоогийн хуулийг зохицуулалтыг сайжруулах нь зүйтэй юм. Үндсэн хуулийн цэцийн маргааны нэг тал нь иргэн, нөгөө тал нь төрийн байгууллага, албан тушаалтан байдаг тул нотлох баримтыг гаргах, бүрдүүлэхэд учирч болох саад бэрхшээлийг арилгах үүднээс дээрх нотлох баримттай холбоотой зарчим болоод энэ талаарх зохицуулалтыг илүү тодорхой болгох нь чухал ач холбогдолтой. “Ubi societus, ubi jus" буюу "Хаана нийгэм байна, тэнд эрх зүй оршдог" гэсэн эрх зүйн шинжлэх ухааны тулгуур зарчмыг Үндсэн хуулийн үзэл баримтлалын эх үндэс болохыг хүлээн зөвшөөрөх аваас Үндсэн хуульт ёсны үзэл санаа Монголд 1990-ээд онд огцом үүсч бүрэлдсэн биш, харин түүхэн уламжлал, шинэтгэл хоёрын тусгал-үр дүн мөн гэж болно. Эцэст нь товч дүгнэхэд, 200 гаруй жилийн тэртээ Напелон Бонапарт "Энэ дэлхий дээр илдийн болон оюун санааны гэсэн хоёр хүч оршиж байна. Алс хэтдээ оюун санааны хүч ялна дийлнэ" гэжээ. Орчин үеийн үндсэн хуульт ёс оюун санааны хүчтэй мөнхийн уялдаатай билээ гэсэн үзэл санаагаар эрдэм шинжилгээний өгүүллийг төгсгөе.

Эх сурвалжийн жагсаалт

1. Монгол улсын Үндсэн хууль” УБ., 1992 он, ТМ №1
2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль УБ., 1997 он, ТМ №6
3. Г.Совд, С.Нарангэрэл. Ред. “Хууль зүйн тайлбар толь” /хамтын бүтээл/. УБ., 2003 он,
4. Ц.Сарантуяа., “Үндсэн хуулийн процессын эрх зүй” Улаанбаатар, 2005, 128-129 дэх тал
5. Ц.Сарантуяа, Үндсэн хууль ба үндсэн хуулийн шүүх: Үндсэн хуулийг шүүхийн журмаар хамгаалах асуудалд, Монголын төр, эрх зүй сэтгүүл, 2002, №1, 21 дэх тал
6. Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн үзэл баримтлал бол эрх зүйн системийн хууль зүйн үндэс мөн, (Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл), Уб, 2007, 168 дахь тал
7. Н.Жанцан, Үндсэн хуулийн цэц ба Үндсэн хуулийн үзэл санаа, (Монгол Улсын Үндсэн хуулийн цэц. Өгүүлэл, илтгэлийн эмхтгэл), Уб. 2007, 152 дахь тал
8. Н. Жанцан, Үндсэн хуулийн цэц ба үндсэн хуульт ёсны төлөвшил, Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын хандлага. ОУЭШБХуралд тавьсан илтгэл
9. Улсын Их Хурал болон НҮБ-Хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: дүн шинжилгээ, Улаанбаатар, 2015, 79-80 дахь тал гэх мэт
10. Улсын Их Хурлын Тамгын газрын Архивын материал, Үндсэн хуулийн төсөл боловсруулах үед холбогдох баримт бичгүүд.

11.Арне Мавчич “Үндсэн хуулийн хяналт”, Улаанбаатар, 2014, /Г.Баясгалан, Д.Сугар, Д.Одбаяр нарын орчуулга, үүсмэл бүтээл/ 63 дахь тал

12.Tom Ginsburg, Judicial Review in New Democracies: Consttutional Courts in Asian Cases, Cambridge University Press, 2003, Өмнөтгөл хэсэг

13.Tom Ginsburg, Judicial Review in New Democracies: Constitutional Courts in Asian Cases, Cambridge University Press, 2003, P 2

ЦАХИМ ХУДАЛДААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES TO IMPROVE THE LEGAL REGULATION OF E-COMMERCE

М. Өлзий-Очир
ДХИС-ийн магистрант
Ulzii-Ochir.M
Postgraduate of University of internal affairs, Mongolia

Хураангуй: Монгол Улсын өнөөгийн нийгэмд “Цахим худалдаа ба түүний эрх зүйн зохицуулалт” гэх ойлголт илүү өргөн тархаад байна. Цахим худалдаа гэдэг нь зарж байгаа этгээдийн хувьд интернэтийн сүлжээнд байрлах өөрийн хаяг бүхий интернэт дэлгүүрээр дамжуулан бараагаа зарах бусдад үйлчилгээ үзүүлэх ба худалдан авалт хийж байгаа хүн төлбөрийн картаараа тухайн барааны төлбөрийг төлж бараа үйлчилгээ авах процесс юм. Цахим худалдаа нь бусад худалдааны төрлүүдээс интернэт орчинд хийгддэгээрээ ялгаатай. Нийгэмд ихээхэн байр суурь эзлэхийн зэрэгцээ сөрөг үр дагаварууд ч мөн адил үүсэж байгаа юм. Үүний учир нь хэрэглэгчийн бие, санаанд нь тохирсон бараа бүтээгдэхүүн нийлүүлэхгүй, түүнчлэн цахим худалдаа нэрийн дор гэмт хэрэг их үүсэж байна. Өнөөгийн байдлаар үүнтэй холбоотой маргааныг Монгол Улсын Иргэний хууль болон Эрүүгийн хуулиар хянан шийдвэрлэж байна.

Abstract: In today’s Mongolian society, the concert of “e-commerce and its legal regulation” is more widespread. E-Commerce is the process by which a seller sells goods through an online store with its own address on the internet, and the person making the purchase pays for the goods and services with a payment card. E-commerce is different from other types of commerce is that it is done online. While it has a significant place in society, it also has negative consequences. This is due to the fact that they do not supply products that suit the body and mind of the consumer, and there is a lot of crime under the name, of e-commerce. Currently, disputes related to this are being resolved under the Civil law and the Criminal law of Mongolia.

Түлхүүр үгс: Цахим худалдаа, эрх зүй, интернэт, техник технологи, сошиал нөлөөлөгчид, дижитал

Keywords: E-Commerce, legal, the internet, technologist, social influencers, digital

Хуулийн зохицуулалт: Монгол Улсын Иргэний хуулийн 22 дугаар бүлэг Худалдах-худалдан авах болон арилжаа

Legal regulation: Chapter 22 of the Civil law of Mongolia Sale, purchase and trade

Өнөөдөр хил хязгааргүй интернэт орчинд дэлхийн 7 тэрбум хүнээс 3,4 тэрбум гаруй нь холбогдож, улмаар улс орнуудын эдийн засаг платформ эдийн засаг хэлбэрт шилжиж байна. Өнөөгийн нийгэмд цахим худалдаа гэх ойлголт маш өргөн тархаж, хурдацтай хөгжиж байгаа бөгөөд улс орны хөгжилд шинэ боломж, шинэ нөхцөл байдлыг бий болгож байна. Орчин үеийн электрон худалдаа нь "дижитал" контентийг шууд онлайн хэрэглээнд зориулан захиалахаас эхлээд, уламжлалт бараа, үйлчилгээг захиалах, бусад төрлийн электрон худалдааг дэмжих үйлчилгээ гэзд бүх зүйлийг багтаадаг. Сүлжээний маркетинг, онлайн худалдаа, төлбөр төлөлт болон зар сурталчилгаа зэрэг энэ шинэ үг хэллэг ихээр агуулагддаг. Энэ цахим худалдаа нь эдийн засаг, нөгөө талаас нийгэмд асар их нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Цахим худалдаа зөвхөн худалдан авагчдад худалдах ч бус тэднийг татан

оролцуулахад дэлхий даяар жижиг, том бизнесүүдэд чухал хэрэгсэл нь болж байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 243 дугаар зүйлийн 234.1 Худалдах-Худалдан авах гэрээ

234.1 Худалдах-худалдан авах гэрээгээр худалдагч нь биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй хөрөнгө, түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх буюу бараа бэлтгэн нийлүүлэх, худалдан авагч нь худалдагчид хэлэлцэн тохирсон үнийг төлж, худалдан авсан хөрөнгөө хүлээн авах үүргийг тус тус хүлээнэ.

243.2 Худалдагч нь худалдаж байгаа эд хөрөнгийн зориулалт, хэрэглээний шинж чанар, хадгалах, хэрэглэх, тээвэрлэх нөхцөл, журам, баталгаат болон эдэлгээний хугацаа, үйлдвэрлэгчтэй холбогдсон үнэн зөв, бүрэн мэдээллийг худалдан авагчид өгөх үүрэгтэй[1]. Гэж заасан нь цахим худалдааг зохицуулах гол хууль болж байгаа бөгөөд худалдагч, худалдан авагчийн хооронд иргэний эрх зүйн харилцаа үүсэж байгаа юм. Иргэдэд биет байдлын доголдолтой бараа бүтээгдэхүүн зарж борлуулснаар шударга ёсны зарчим алдагдаж байна.

Энэ талаар жишээ татвал: Иргэн О.Гэрэл цахим худалдаа эрхэлдэг, фэйсбүүкийн нэгэн хаягаар холбогдон, цамцны захиалга өгөөд хохирсон байна. Захиалга авдаг групп хаягууд ихэвчлэн бараа бүтээгдэхүүнийг урьдчилгаа 30-50 хувиа төлсөн тохиолдолд, 7-14 хоногийн хугацаанд нийлүүлэх нь түгээмэл. Иргэн О.Гэрэлийн захиалга 10 хоногийн дотор ирсэн ч өнгө, зураг нь бүдэгхэн, чанарын шаардлага хангаагүй аж. Зураг дээрх шигээ бараа нийлүүлэхийг шаардаад, тус группийн админ гэх хүнд хэл амаараа доромжлуулаад л өнгөрчээ[2]. Энэ мэтчлэн сүүлийн үед цахимаар бараа бүтээгдэхүүн захиалан худалдаж авсан иргэдээс цахим худалдааны хохирогч болсон тухай гомдол мэдээлэл цагдаагийн байгууллагад ихээр бүртгэгдэж байгаа юм. Монгол улсад цахим худалдааг зохицуулах хуулийн заалт байхгүй бөгөөд цагдаагийн байгууллага энэ төрлийн гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн 17.3 залилах[3] зүйл ангиар хэрэг үүсгэж байна.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт өнөөдрийн байдлаар цахим худалдааны хохирогч болсон, өөрөөр хэлбэл бараа буцаалттай холбоотойгоор ихээхэн иргэд хандаж байна. Тус газарт хохирогчдыг хамгаалах чиглэлээр боловсруулан гаргасан тодорхой журам байдаггүй бөгөөд цахим худалдааны золиос болохгүй байх талаар сэрэмжлүүлэг, анхааруулга иргэддээ хүргэн ажилладаг байна.

Цахим худалдааны бараа бүтээгдэхүүн дэлгэцэнд маш цэвэрхэн, өө сэвгүй харагдаж, хүний харцыг ихэд булаадаг. Тиймээс худалдан авагчид өөрт хэрэгцээтэй эсэхээс үл шалтгаалан захиалах үзэгдэл маш их тохиолддог. Гэвч худалдан авагчдын анхаарлыг татаж, тухайн бүтээгдэхүүнийг борлуулахын тулд түүний ард зураг авалтын бүтэн баг ажиллан, дизайн зохиомжийг нь төлөвлөж, өнгө дүрсийг нь сэргээн, хэрэглэгчдэд хамгийн гоё сайхнаар харагдуулах боломжит бүх хувилбарыг ашигласан байдаг. Сүүлийн үед Social influencers буюу сошиал нөлөөлөгчид цахим хуудсаараа дамжуулан маркетинг хийх нь элбэг болсон. Олны танил хэн нэгэн аливаа брендийн гоо сайхны бүтээгдэхүүнийг хэрэглэсэн тухайгаа хуваалцахад л охид, эмэгтэйчүүдийн анхаарлыг татаж, худалдан авалтад нөлөөлдөг. Гэвч influencers захиалагч байгууллагаасаа цалин авч, тухайн бүтээгдэхүүнүүдийг борлуулахын тулд ажиллаж байгаа гэдгийг санаарай. Та бүхэнд цахимаар харуулсан бүтээгдэхүүн бодит

[1] Монгол Улсын Иргэний хуулийн 243.1 Худалдах-худалдан авах гэрээ

[2] https://news.mn/r/2387112/

[3] Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17.3 Залилах

байдлаас зөрүүтэй ч байж болох юм. Цахим худалдааны гол онцлог нь хэрэглэгч дэлхийн хаанаас ч, хэзээ ч бараа бүтээгдэхүүнээ захиалан авах боломжтой. Энэ нь маш том давуу тал боловч бид хүргэлтийн үйлчилгээг зайлшгүй харгалзан судлах шаардлагатай. Ихэнх онлайн дэлгүүрүүд бараагаа тодорхой хугацааны дараа таны гарт хүргэж өгдөг. Ингэхдээ буруу хаягаар очих, замдаа төөрөх, хугацаанаасаа хожимдох зэрэг олон эрсдэл үүсэх магадлалтай. Тиймээс хэрэглэгч захиалсан барааныхаа хүргэлтийн үйл явц, аюулгүй байдалд санаа тавьж, хаяг болон хугацаагаа сайтар нягтлах хэрэгтэй юм. Мөн худалдан авсан бараагаа буцаах тохиолдолд хэнд, хэрхэн хандах, нэмэлт шимтгэл төлөх эсэхээ урьдчилж мэдэх нь чухал бөгөөд тохиолдолд аливаа бараа хүргэлт болон буцаалтын явцад замдаа эвдэрч, гэмтэх нь ч бий. Тиймээс нөхөн төлбөр болон буцаах тээвэрлэлтийн зардлын талаар нарийвчлан судлах хэрэгтэй.

Өгүүлэл бичих хүрээнд “Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар”-аас 2020 он болон 2021 оны 04 сар хүртэлх маргааныг тоон судалгааны аргаар авч үзэхэд: 2020 онд нийт 10.381 иргэн хандсан байна. Үүнээс 115 утсаар 7027, дуут шуудангаар 1963, чатботоор 1219, и-баримт апликэйшнээр 192 гомдлыг тус тус хүлээн авсан байна. Мөн “Цахим худалдаа”-ны талаарх өргөдөл, гомдол 2021 он гарснаас хойш өнөөдрийг хүртэл 180 тохиолдол бүртгэгдсэн байна[4].

Дүгнэлт

Цахим худалдаа нь иргэд хооронд үүсэх эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргаан үүсдэг учраас Иргэний эрх зүйн харилцааны зарчим, болон Иргэний хуулийн 234.1 дүгээр зүйл заалтыг харгалзан үзэх хэрэгтэй. Цахим худалдаа гэх асуудлаар иргэдийн эрх хөндөгдөж байгаа учраас төрөөс хууль тогтоомж болон эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох хэрэгтэй. Мөн онлайн худалдаанд төрөөс ажлын хэсэг гаргаж хяналт зохицуулалтыг хийж, гэмт хэргийн шинжтэй зөрчил гарвал хүлээлгэх хариуцлагыг илүү өндөр болгох хэрэгтэй гэж үзэж байна. Мөн цахим худалдаа хийхдээ иргэд бүтээгдэхүүний гадаад үзэмж болон бодит зурганд дүн шинжилгээ хийх, цахим орчны суртчилгаанд хэт автахгүй байх, худалдан авалт хийх гэж байгаа цахим site-д хяналт, шалгалт хийх, төлбөрийн аюулгүй байдал болон хүргэлтийн үйлчилгээнд ач холбогдол өгөх зэргийг нэн анхаарах хэрэгтэй.

Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх санал:

1. Монгол Улсад цахим худалдаа гэх ойлголт хэдийд яаж үүссэн талаар судлах, худалдагч худалдан авагчийн харилцаа хамааралыг судлаж, дүгнэх;
2. Монгол Улсад цахим худалдааны эрх зүйн орчин хэр бүрэлдсэн эсэх, энэ талаар нарийвчлан тогтоосон хууль байх хэрэгтэй эсэх талаар эрдэмтэн судлаачдын судалгааны ажилтай харьцуулан судлах;
3. Одоогийн Ковид-19 цар тахал болон байгалийн давагдашгүй хүчин зүйлийн үед хил гаалиар бараа бүтээгдэхүүн авах, шилжүүлэхэд ихээхэн хүндрэл учирч байна. Тиймээс энэ нь “Дотоодын үйлдвэрлэгчдэд шинэ боломж”-ийг нээж өгч байна. Жишээ нь:
   - Зөвхөн нэг удаагийн худалдан авалт бус хэрэглэгчдийг байнгын худалдан авалт хийх нөхцөлийг бий болгох,
   - Цахим худалдаанд нэгдсэнээр орон даяар маш олон хүнд хямд зардлаар хүрэх, бүтээгдэхүүнээ

[4] Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар

таниулах, борлуулах сувгаа нэмэх боломж нээгдэнэ,

- Ирээдүйд Дэлхийн зах зээлд өөрсдийн бүтээгдэхүүнээ шууд эцсийн хэрэглэгчдэд хүргэх боломж нээгдэнэ. Манай улсын ихэнхи ААН, төрийн байгууллагууд интернэт сүлжээгээр дамжин онлайнаар бүтээгдэхүүн үйлчилгээгээ олон нийтэд яаж хүргэх гэдэг рүү тэмүүлж байгаа. Гэхдээ бидэнд туршлага байхгүйгээс алдаа оноотой байгаа. Энэ салбар цааш хөгжихөд бид том системээр нь харах хэрэгтэй. Бид АНУ, барууны орнуудыг жишиг болгохоос илүүтэйгээр Хятад, Орос хоёр хөршөө харах хэрэгтэй гэж үзэж байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Иргэний хууль
2. Ikon.mn мэдээ /интернэт/
3. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын цахим сан
4. Цахим худалдааны статистик бүртгэлийн шинжилгээ

НУТГИЙН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООНЫ ХЭВ МАЯГИЙГ ХАРЬЦУУЛАХ НЬ

LOCAL GOVERNMENT SYSTEM TYPES COMPARE

Ц.Түвшинбаяр
Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн магистрант, цагдаагийн дэд ахлагч
Tuwshinbayar.Ts
Graduate student of the School of Law and Social Sciences of the University of Internal Affairs, Deputy Chief of Police

Хураангуй: Зарим улсын нутгийн өөрийн удирдлагын тогтолцоог онцолж, өөрийн орныхтой харьцуулах замаар давуу ба сул тал, ялгаа онцлогийг тодруулах.

Abstract: Highlight the strengths, weaknesses, and differences of some countries by emphasizing their local self-governance systems and comparing them to their own.

Түлхүүр үг: Нутгийн удирдлагын тогтолцоо, Хэв маяг

Key words: Local government system, Style

Оршил

Зарим улсын нутгийн өөрийн удирдлагын тогтолцоог дараах хэсэгт бүлэглэн авч үзэх юм. Үүнд:

- Далайн буюу Англо-Америкийн \Их Британи, АНУ, Канад, Австрали, ШинэЗеланд зэрэг улс оронд төлөвшиж тогтсон\ загвар.
- Эх газрын \Франц, Герман, Итали, Испани, Швейцари, Португаль, ОХУ, ойрхи дорнодын орнуудыг хамардаг\ загвар
- Швед загвар \Скандиновын орнууд багтдаг\.
- “СССР” буюу зөвлөлтийн \ОХУ-н муж тойрог, автономит улсууд, БНХАУ, БНКАУ, БНАСУ, Монгол улсыг хамардаг\ хэв загвар гэж ангилан авч үздэг. [1]

Хүн төрөлхтөн олон мянган жилийн шударга ёсны төлөө тэмцлийнхээ үр дүнд хаанчлал, хаант засаг, эзэнт ёсны дарангуйллын тогтолцоог халсны дараах анхны ардчилсан Үндсэн хуулиудад орон нутгийн өөрийн удирдлагын тогтолцоог бий болгох заалт зохицуулалтыг хийхийг зорьж ирсэн билээ. Улс орнуудын үндсэн хуулийн энэ үзэл баримтлал нь XYIII-XX зуун, улмаар XXI зууны төрийн удирдлагын зохион байгуулалтын дэвшилт алхмуудын нэг болон төлөвшсөн болно. Харин хөгжлийн явцад түүхэн нөхцөл байдлын улмаас түрэмгийлэх, хүчээр дарангуйлах, залилах, хууран мэхлэх, худалдах, булаан авах замаар мөн чанарыг нь алдагдуулах нөхцөл байдал үүсэж байсныг үгүйсгэх аргагүй юм.

Үндсэн хэсэг

Англо – Америкийн загвар нь Англиас уламжлалтай бөгөөд АНУ, Канад, Австрали зэрэг улсуудад төвлөрсөн байна.

Уг загварт нутгийн өөрийн удирдлага нь хараат бус бие даасан нэгж байх ба дээрээс түүнийг удирдах гэж оролддоггүй. Төлөөллийн 19 байгууллага болон зарим албан тушаалтныг оршин суугчид сонгодог. Үйл ажиллагаа нь шүүхийн хяналтад байх онцлогтой. Англо – Америкийн хэв загварт нэн ялангуяа нутгийн өөрийн удирдлагын түвшинд захиргааны удирдлагыг төвлөрүүлэхгүй байх,

[1] (Доохүү.Б, Энхбаатар.Ч, Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй, УБ., 2006, хууд- 194

томилгоот албан тушаалаас аль болох татгалзан ажил үүргийн дагуу сонгон шалгаруулалт байх, албан тушаалтанд бусдыг захиран тушаах болон тушаал шийдвэр биелүүлээгүйн төлөө хариуцлага хүлээлгэх хоёрдмол эрхийг олгохгүй байх зарчмыг тууштай баримталдаг. Түүнчлэн сонгуульт албан тушаалтныг сонгуулийнх нь хугацаанд нь гэмт хэрэг үйлдэж шүүхээс шийтгүүлснээс бусад тохиолдолд өөрчлөхгүй, албан тушаал, дэвшүүлэхгүй байх зарчмыг иш үндэс болгодог нь тухайн албан тушаалтан хэн нэг дээд албан тушаалтнаас бус зөвхөн сонгогчдоосоо хамаарч оногдуулсан үүргийг хэнээс ч хараат бусаар хэрэгжүүлэх боломжоор илүүтэй хангагдана гэж үздэг байна. Энэ зарчмын талаар Францын эрдэмтэн Алексис Де Токвиль “Нэг хүнд захиран тушаах болон захирагдаагүйн төлөө шийтгэдэг хоёрдмол эрхийг олгодоггүй учраас удирдлагын шатлан захирах зарчим түшмэдүүдийн дунд үйлчилдэггүй, ер нь эрх мэдэл дээр нэмээд шагнах болон шийтгэх эрх мэдлийг олгож болохгүй” хэмээн тодорхойлсон нь анхаарч үзэх асуудлын нэг юм.

Сүүлийн үед энэ хэв загвар нутгийн өөрийн удирдлагыг төлөвшүүлэхэд илүү үр ашигтай загварт тооцогдох болсон. Уламжлалт ардчилал бүхий улс орнуудад жишээлбэл: Австрали улсын Засгийн газраас гаргасан өмнөд хэсгийнхээ нутгийн өөрийн удирдлагын талаарх тунхаг бичигт:

- Нутгийн өөрийн удирдлага гэж тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын ашиг сонирхолд нийцсэн тэдний өөрсдийн хариуцлагад үндэслэгдсэн нийгмийн үйл хэргийн тодорхой хэсгийг удирдах болон зохицуулах нутгийн удирдлагын эрх чадамжийг хэлнэ.
- Аливаа эрх мэдлийн өөр байгууллагад оногдуулаагүй бүхий л асуудлыг өөрсдийн санаачилгаар шийдвэрлэх эрхтэй ба түүнийг нь хязгаарлаж үл болно.
- ... ямарваа арга хэлбэрээр орон нутгийн эрх хэмжээнд халдах, НӨУ-ын бодлогод нөлөөлөх боломж бий болохыг хориглоно.
- Орон нутгийн өөрийн удирдлагын эрх мэдлийн байгууллага нь хуулиар олгогдсон эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандан шийдвэрлүүлэх эрхтэй гэж заажээ.

Америкийн нутгийн өөрөө удирдлагын \коммуны\ суурь зарчмыг доорх байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Нутгийн өөрөө удирдлагад албан тушаалтнууд нь сонгогддог.
- Оршин суугчид орон нутгийн шинжтэй асуудлаар санаа бодлоо коммуны хурал дээр илэрхийлдэг. Асуудлыг шийдвэрлэж өгнө үү гэж дээшээгээ засгийн газар хүртэл чирэгддэггүй.
- Орон нутгийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах асуудалд оршин суугчид идэвхтэй оролцдог.
- Орон нутагт засгийн газар төлөөлөгчөө ажиллуулдаггүй\ томилгооны засаг дарга гэсэн үг\

Эх газрын загвар нь Францаас уламжлагдсан, эх газрын европын, франц хэлний Латин Америкийн, Ойрхи Дорнодын улсуудад голчлон төлөвшсөн байна.

Энэ хэв загвар нь төрийн удирдлагыг нутгийн өөрийн удирдлагатай зэрэгцүүлэн хөгжүүлэх зарчмаар үйл ажиллагааг нь зохицуулдаг онцлогтой.

Манайхаас ялгаатай нь орон нутгийн удирдлагыг бүс нутгийн, нутгийн өөрийн удирдлагын гэж ангилдаг бөгөөд нутгийн өөрийн удирдлага нь зөвхөн нутаг дэвсгэрийн доод шатны нэгжид байгуулагддаг. Нутгийн өөрийн удирдлагын зөвлөл ба захирагчийг \мэрийг\ оршин суугчид сонгодог ба “мэр” нь общиний тэргүүний үүргийг давхар гүйцэтгэдэг, мөн нутгийн өөрийн удирдлагын шийдвэрийг

хэрэгжүүлэх үүрэг хүлээдгийг удирдлагын хосолмол хэлбэртэй гэж үздэг.

Эх газрын загвар бүхий улс орнуудаас **Франц** манайхтай адил төрийн байгууламжаараа нэгдмэл улс тул тус улсыг онцлон үзэх нь судалгааны ажилд илүү ач холбогдолтой гэж үзэж байна. Франц улсын засаг захиргааны нэгж нь ч манайхтай төстэй 3 шатлалтай. Тэдгээр нь төрийн болон орон нутгийн өөрийн удирдлагатай. Ялгаатай нь энэ улс төрийн байгууламжийн нэгдмэл шинжээ хадгалж орон нутагт төрийн болон өөрийн удирдлагыг манайх шиг холиогүй, жинхэнэ хослуулах хэлбэрээр хэрэгжүүлдэг байна. Энэ зарчим нь 1958 оны Үндсэн хуулиараа баталгаажсан байдаг. Францад орон нутгийн эрх барих байгууллагуудын үндсэн хуулийн статус нь чөлөөтэй үйл ажиллагаа явуулах зарчимд үндэслэсэн нь Орон нутгийн өөрийн удирдлагын тухай Европын Хартийн орон нутгийн бие даасан байдлыг хангах үзэл 21 баримтлалд нийцэж байна. Нөгөө талаас “улс үл хуваагдах” зарчмын дагуу орон нутгийн эрх барих байгууллагуудад хууль тогтоох эрх олгодоггүй. Үндсэн хуулийн зөвлөл (шүүх) нь энэ хоёр зарчмын тэнцвэрт хяналт тавьдаг байна. Францын Үндсэн хуулийн 72 дугаар зүйлд нутаг дэвсгэрийн хамтлагууд дахь Төрийн төлөөлөгч нь үндэсний ашиг сонирхлын асуудал, захиргааны хяналт, хуулийг мөрдүүлэх үүрэгтэй гэж заажээ. Орон нутгийн захиргааны удирдлагыг тус улсын Засгийн газраас томилсон төрийн төлөөлөгч/ төрийн албан хаагч/ хэрэгжүүлдэг. Түүний томилгоонд нутгийн өөрийн удирдлагын оролцоо байхгүй. Харин нутгийн өөрөө удирдах байгууллагын сонгууль 6 жил тутам явагдаж бүрэлдэхүүнээ шинэчилж байдаг. Төрийн удирдлагыг хэрэгжүүлдэг, манайхаар бол засаг даргатай дүйх албан хаагч нь улсынхаа Ерөнхийлөгч болон Ерөнхий сайдаас төвлөрсөн удирдлагатай. Төрийн удирдлагын болон нутгийн өөрийн удирдлагын гүйцэтгэх чиг үүрэг, хариуцах хариуцлагыг нь давхцал гаргахгүйгээр тодорхой хуульчлан тодорхойлсон байдаг ажээ.

Төвлөрлийг сааруулах буюу нутгийн өөрийн удирдлагыг дэмжих бодлого хэрэгжүүлэхдээ Франц улс 2 үндсэн нөхцөлийг гол болгон баримталдаг. Үүнд:

I. Орон нутагт төрөөс ялгаатай ямар эрх ашиг байгааг орон нутгийн шатлал болгоноор хуульчлан тодорхойлсон байх ёстой.

II. Нутгийн өөрийн удирдлага шийдвэр гаргахдаа болон шийдвэрээ хэрэгжүүлэхэд шаардагдах өмч, хэрэгслийг захиран зарцуулахдаа төрийн байгууллагаас хараат бус байх явдлыг хуульчлан тогтоосон байх гэсэн зарчмууд хамаарна.[2]

Энд Франц Улсыг онцлон дэлгэрүүлж авч үзэж байгаа гол шалтгаан нь манай улс засаглалын асуудлаа шийдвэрлэхдээ олон улсын жишиг хандлага гэж харвал өөрийн адил нэгдмэл төрийн байгууламж бүхий тогтолцоотой улс гэж үзсэнтэй холбоотой юм. Франц улс улс бол бидний нутагшуулах гэж сүүлийн 20 гаруй жил зорьж тэмцэж байгаа орчин үеийн ардчиллын үзэл санаа үйл хэргийн төрсөн эх орон, НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн байнгын 5 гишүүний нэг, Европын голлох улс, дэлхийн тэргүүлэх хүчирхэг гүрнүүдийн нэг гэдгийг бид мэднэ. Ардчиллын ч, сайн засаглалын ч онол, үзэл баримтлалын талаас Францын засаглалын загварыг өөрчилсөн зүйл өнөө хэр ховор байна. Тийм учраас манай улс нутгийн өөрийн удирдлага болон төрийн удирдлагын 22 хослолын зохистой байдлын шалгуурыг энэ улсынхтай юуны түрүү жишиж алдаа оноогоо шинжлэх бололцоотой билээ.

[2] http://www.hyno.ru/tom1/1740.html,

Харин Герман улсын тухайд бол Тус улсын нутгийн өөрийн удирдлагын зохион байгуулалт өөрийн онцлогтой бөгөөд нутгийн өөрөө удирдах ёсны Европын Хартийн үзэл баримтлалд нийцсэн, Англо- Америкийн ч, эх газрын ч зарчмыг хадгалсан байдаг учраас холимог хэлбэрийн гол төлөөлөл гэж судлаачид үзэх хандлага түгээмэл байна.

Германы нутгийн өөрийн удирдлага нь өмнөдийн, магистратын, бургомистрын, хойт хэсгийн гэсэн хэлбэрүүдээр тодорхойлогддог. Германы өмнөдийн загварт коммуны зөвлөл болон захиргааны тэргүүн бургомистрыг оршин суугчид сонгох бөгөөд бургомистр нь коммуны зөвлөлийг давхар тэргүүлдэг байна. Магистратын хэлбэрт оршин суугчдаас сонгогдсон төлөөллийн байгууллага нь өөрийн гүйцэтгэх байгууллага болох бургомистр ба хүндэт гишүүд бүхий магистрат эсвэл сенатыг байгуулдаг. Бургомистрын хэлбэр оршин суугчдаас сонгогдсон төлөөллийн байгууллагаас бургомистрыг сонгох бөгөөд тэрээр коммуны тэргүүний зэрэгцээ захиргааны тэргүүнийг хавсран гүйцэтгэдэг. Германы хойт хэсгийн хэлбэр нь Англо-Америкийн загвартай төстэй бөгөөд оршин суугчдаас сонгогддог төлөөллийн байгууллагаас гүйцэтгэх зөвлөлийг байгуулдаг. Харин гүйцэтгэх зөвлөл нь захиргааны үүрэг гүйцэтгэхгүй зөвхөн төлөөллийн байгууллагаас гаргах шийдвэрийг боловсруулдаг. Төлөөллийн байгууллагаас мөн коммуны захирал, захиргааны тэргүүнийг сонгодог. Германы нутгийн өөрөө удирдлага нь өмнөдийн бургомистер ба обербургомистер, магистрын хэлбэрүүд нь нэгдмэл нэг коллеги буюу общины зөвлөл, хот тосгодын зөвлөлийн хурал гэх мэтээр хүн амаасаа сонгогддог НӨУ-ын байгууллагатай. Общиний зөвлөл ба захиргааны тэргүүн бургомистерын оршин суугчдын сонгох бөгөөд бургомистер нь общиний давхар тэргүүлдэг байна. Германы өмнөд умард аль ч загварын нийтлэг нь сонгуульт байгууллагыг ард иргэд сонгож, түүний үйл ажиллагааг сонгуульт байгууллагаас сонгогдсон “хот тосгодын захирал” удирдан зохион байгуулдагт оршино.[3] Нутгийн өөрийн удирдлага төлөвшсөн улс орнуудад төсвийн орлогыг доорх эх үүсвэрүүдээр бүрдүүлдэг нь нийтлэг байна. Үүнд:

- Хүн амын орлогын татварын хэмжээг тогтоох, хураах, захиран зарцуулдаг эрхийг нутгийн өөрийн удирдлагад хадгалах;
- Орон нутгийн шинжтэй жижиг үйлдвэрлэл, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлогын албан татвар, оршин суугчдад үзүүлэх үйлчилгээний орлого;
- Улсын болон бүс нутгийн шинжтэй томоохон үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг орлогын албан татварын 10 хувь хүртэл хувь;
- Бусад \орон нутгийн шинжтэй төлбөр хураамжийн орлого, бууны, тээврийн хэрэгслийн, газар ашигласны төлбөр, усны газрын дээрх баялаг ашигласны гэх мэт\.

Нийгмийн хөгжлийн нэгэн үед алдаа оноо нь ижил төстэй байсан зарим улс орны Нутгийн өөрийн удирдлагын хөгжүүлэх талаарх бодлого үйл ажиллагааны чиглэлээс тоймлон авч үзвэл:

ОХУ-ын 1993 онд баталсан Үндэс хуульд ард түмэн өөрсдийнхөө эрх мэдлийг төр засгийн болон нутгийн өөрийн удирдлагын байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх, нутгийн өөрийн удирдлагын болон төрийн удирдлагын бүтцэд үл хамаарах, Нутгийн өөрийн удирдлагын зарчмуудыг бүс нутгийн хууль тогтоомжуудаар баталгаажуулах, НӨУ-ын байгууллагууд нь нийтийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах,

[3] Энхбаатар.Ч, Холбооны бүгд найрамдах герман улсын төрийн эрх зүй, УБ., 2009, хууд- 135

орон нутгийн төсвийг бүрдүүлж, татвар хураамж тогтоох, шүүхээр эрхээ хамгаалуулах эрхтэй байхаар заажээ.

ОХУ нь СССР буюу социалист систем задарсны дараа 1993 онд шинэ үндсэн хуулиа батлан шинэ улс, шинэ системийг үүсгэн Эх газрын буюу Европын улсуудын жишиг хандлагыг баримжаа болгон нутгийн өөрийн удирдлагын хийгээд нутгийн захиргааны тогтолцоо, бүтэц, эрх хэмжээг хуульчлан тогтоосон байна.

ОХУ нь төрийн байгууламжийн хувьд 21 бүгд найрамдах улсыг нэгтгэсэн холбооны улс бөгөөд 49 автономит муж 6 хязгаар, холбооны хэмжээний 2 хот \Москва Санкт-Петебург\-оос бүрдэнэ.

Нутгийн өөрийн удирдлага нь иргэдийн шууд сонгууль, референдум, санал хураалтын дагуу бий болох бөгөөд нутгийн өөрөө удирдах байгууллага нь иргэдээс 2 жилд нэг удаа сонгогддог төлөөлөгчдийн хурал юм.

Нутгийн төлөөлөгчдийн хурал нь нутгийн чанартай нийтийн эзэмшлийн өмчийг захиран зарцуулах асуудлыг хариуцахаас гадна орон нутгийн төсөв бүрдүүлэх талаар хураамжийг тогтоох, нийгмийн хэв журмыг хамгаалах зэрэг эрх хэмжээтэй. Тэрчлэн орон нутаг дахь орон сууцны фондын ашиглалт хамгаалалт эмнэлэг, боловсролын байгууллагад холбогдох асуудлыг хариуцахаар хуульчлагджээ. Тухайлбал,

“Орон 24 нутгийн боловсролын байгууллагын бие даасан асуудлыг төрийн захиргааны төв болон дээд байгууллага шийдвэрлэж үл болно” гэсэн Үндсэн хуулийн зарчмаас нь тодорхой илэрдэг. Хуучин уламжлал эдүгээ зарим талаар алдагдсан ч түүний дэвшилттэй зүйлсийг нөхөн сэргээж нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох тал дээр Оросын олон судлаач эрдэмтэд санал бодлого дэвшүүлсээр байна.

Скандиновын орнуудын хамгийн голлох төлөөлөгч болсон Швед нь бичмэл бус Үндсэн хуультай 1 цөөн орны тоонд багтдаг боловч нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх зүйн зохицуулалтыг хамгийн үлгэр жишээ сонгодог байдлаар төлөвшүүлж чадсанаараа олон орны анхаарлыг татдаг.

Шведийн Үндсэн хууль нь хэд хэдэн үндсэн хуульчилсан актын хэлбэрээр гарснаас хамгийн нөлөөтэй буюу голлох эх сурвалж нь 1974 оны Удирдлагын хэлбэрийн тухай Үндсэн хуульчилсан акт бөгөөд нутгийн удирдлагын хэм хэмжээ илүү ихийг агуулдгаараа онцлогтой. Тухайлбал:

- Коммуны түвшинд шийдвэр гаргах эрх мэдлийг иргэд өөрсдөө сонгосон төлөөллийн байгууллагаараа дамжуулж хэрэгжүүлэх.
- Орон нутгийн чанартай буюу нутгийн иргэдийн эрх ашигт холбогдох зарчмын шинжтэй нийтлэг асуудлуудыг зөвхөн муниципалитетийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг байх.
- Нутаг дэвсгэрийн хэмжээнд татвар тогтоох, хураан авах эрхтэй гэх зэрэг. Муж, коммуний зөвлөлийг 4 жилийн хугацаатай сонгож байгуулна.

Зөвлөл нь нутгийн хэмжээнд шийдвэр гаргагч үндсэн гол субъект болох бөгөөд орон нутгийн татвараас эхлээд нутгийн удирдлагын бүтцийг тогтоох нутгийн хөгжлийн болон цаг үеийн асуудлыг шийдвэрлэх эрхтэйгээс гадна нийгмийн халамж үйлчилгээ, эмнэлэг, боловсрол, соёл, урлаг болон тээвэр аж ахуйн бизнесийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавихад чиглэгдсэн бүхий л асуудалд оролцдог онцлогтой. Мужууд нь эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсролын салбар дахь асуудлыг бие даан шийдвэрлэхэд онцгой анхаардаг байна. Зөвлөл нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэх хороодыг байгуулах бөгөөд мөн нийгмийн үйлчилгээний болон үйлчилгээ үзүүлэгч хороодыг байгуулна. Гүйцэтгэх хороо бол нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл мөн төдийгүй зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэн зохион 1 Ихэнх улс орон

Үндсэн хуулийг төрөлжүүлж нэгтгэж баталдаг байхад зарим улс орон бичмэл бус Үндсэн хуулийн шинжтэй хэд хэдэн хуулиудын нийлбэрийг Үндсэн хуулийн хэмжээнд зарлан тунхагласан байдаг. Тухайлбал Их Британийн бичмэл бус Үндсэн хуульд багтдаг 1972 оны нутгийн удирдлагын тухай хууль, Шведийн 1974 оны удирдлагын хэлбэрийн тухай үндсэн хуульчилсан хууль тогтоомж бөгөөд НӨУ-ын хэм хэмжээг тэдгээрт илүү их агуулсан онцлогтой байдаг байна. 25 байгуулах үндсэн үүрэгтэй ажилладаг. Мужийн дарга орон нутгийн хөгжлийн асуудлыг засгийн газрын өмнө хариуцдаг. Мужийн зөвлөл татварыг тогтоохдоо Парламентаас тогтоосон дээд хязгаарыг баримтлан татвараа өөрөө тогтоодог. Шведийн Үндсэн хуульд: “Шведийн ардчилал нь иргэдийн төлөөллийн болон Парламентын тогтолцоо, орон нутгийн өөрөө удирдах байгууллагаар дамжин хэрэгжинэ” гэж заасан нь өнөөдрөөс амьдралд бодит биеллээ олжээ.

Зөвлөлтийн хэв загвар нь \БНХАУ, БНКУ, БНАСАУ, Монгол\ нутгийн өөрийн удирдлагын язгуураас нэлээд ангид төрийг бүтцэд багтдаг, шаталсан удирдлага бүхий орон нутгийн засаг захиргааны нэгж байдаг байна. Нутгийн өөрийн удирдлагын хараат бус байх зарчим нь хүн төрөлхтний заяагдмал эрхийн асуудал бөгөөд энэхүү эрхийг нийт улс орны болон нийтийн эрх ашгийн үүднээс зарим нэг хэсгийг нь хязгаарлаж болохоос биш, түүнд шууд халдах тухай ойлголт байх учиргүй билээ. Францын эрдэмтэн Алексис Де Токиль “...засаглалын анхдагч үндэс нь улс, төр ч байтугай ард түмэн ч биш. Харин өөрсдийн асуудлыг бие даан зохицуулах эрх бүхий сайн дурын үндсэн дээр нэгдсэн чөлөөт ард түмнүүдийн нэгдэл зөвхөн общинд буюу нутгийн өөрийн удирдлагад байдаг” гэсэн нь иргэд өөрсдийн эрх ашгийн асуудлыг шийдвэрлэх явцдаа эвлэлдэн нэгдэж, эвлэлдэн нэгдсэн олон түмэн хүчтэй байдгийг илэрхийлсэн ойлголт юм.\

Төрийн ба орон нутгийн удирдлагын харилцан хамаарал

Төрийн нэгдмэл байгууламжтай ихэнх орнууд улсаа муж, аймагт хуваадаг бөгөөд Засаг даргыг нь ард иргэд нь шууд сонгодог эсвэл төрийн тэргүүн томилдог байна. Нэгдмэл тогтолцоотой зарим улсад төв Засгийн газар нь эрх мэдлээ орон нутгийн засаг захиргаадад тусгайлан шилжүүлж, эргээд орон нутгийн захиргаадын шийдвэрийг хэрэгсэхгүй байж болдог. Зарим нэгдмэл улсуудад орон нутгийн засаг захиргаад ерөнхий чадавхын зарчим буюу төв Засгийн газарт олгогдсоноос бусад бүх эрх мэдлийг хэрэгжүүлэх эрх олгох зарчмын дор үйл ажиллагаагаа явуулдаг. Бодит амьдрал дээр нэгдмэл улсын орон нутгийн засаг захиргаанд хэзээ ч төв Засгийн газраасаа бүрэн хараат бус байж чаддаггүй. Засаг дарга, эсвэл мужийн дарга нь ихэвчлэн төв Засгийн газрын улс төрийн томилгоот албан тушаалтан бөгөөд мужийн захиргааны дарга болон төв Засгийн төлөөлөгчийн үүргийг давхар гүйцэтгэдэг. Зарим оронд төв засгийн газрын яамд, агентлагийн орон нутгийн салбарын ажилтнуудаас 26 бүрдсэн мужийн захиргаад нь зөвхөн төв Засгийн газрын хөрөнгийг дамжуулах, зарцуулалтад хяналт тавих үүрэг гүйцэтгэдэг. Улс орнууд улс төрийн (Индонези ба Их Британи зэрэг холбооны болон нэгдмэл тогтолцоотой орнууд зарим бүсэд бие даасан эрх олгосон) захиргааны (Франц, Япон) бүсчлэлийн бодлогын талаар эсрэг тэсрэг хандлагатай байна. Японы орон нутгийн засаг захиргаа төв Засгийн газраас илүү үүрэгтэй бол, Францын орон нутгийн коммуны зөвлөл төв захиргаанаас илүү үүрэгтэй байдаг ажээ. Италид бүсийн захиргаанд ихээхэн бие даасан эрх мэдэлтэй боловч хэл, угсаатны үндэслэлээр зарим бүсэд тусгай статус олгожээ. Япон, Их Британи зэрэг олон орон жижиг нэгжүүдийг нэгтгэсний үндсэн

дээр бие дааж амьдрах чадвартай хот суурин газрын бүтэц бий болгох зориудын арга хэмжээ авчээ.

Хотын даргыг сонгох болон томилох тогтолцооны онцлог

Япон, АНУ, Ази, Зүүн Европ, Латин Америкийн зарим оронд хотын даргыг иргэдээс шууд сонгодог. Гүйцэтгэх эрх мэдэл захиргаа хотын даргад төвлөрөх ба сонгогдсон зөвлөл зөвхөн төсөв батлах, шинэ албан тушаал бий болгох, дээд түвшний удирдах албан тушаалтнуудыг томилох, гол бодлогуудыг тодорхойлох зэргээр хяналт тавьдаг. Зөвлөлд хотын даргыг огцруулах эрхгүй байдаг. Британийн уламжлалтай төлөөлөгчдийн олонхоос шууд бус сонгогддог хотын даргын загварыг Ази, Африкийн зарим орон хэрэглэдэг. Тус загвар хотын дарга болон сонгогдсон зөвлөлийн хоорондох зөрчлийг багасгах давуу талтай боловч хотын дарга намын элдэв арга мэхэд илүү өртөмхий болж, эрх мэдэл нь эрх барьж буй улс төрийн намын шатлал дахь түүний байр сууриас хамааралтай байдаг. Улс төрийн намын босоо хяналт мужийн болон хотын захиргаанд давамгайлдаг тул хамтын хүчин чармайлтад санал зөрөлдөөн үүсэх эрсдэл багатай байдаг. Хотын даргыг сонгодоггүй, харин үндэсний Засгийн газрын гүйцэтгэх засаглалын тэргүүн томилдог Ази, Африкийн бусад орнуудад эрх мэдэл нь түүний бие даан үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоо, хотын захиргаанд хэр нөлөөтэй байхаас хамаардаг. Британийн орон нутгийн удирдлагын уламжлалыг баримталсан орнууд хотын захиргааг үйлчилгээ хүргэх агентлаг хэмээн үзэж тус үүрэгтэй нь холбогдуулан чиг үүрэг, санхүүжилт, хил хязгаар, төвийн хяналтыг тодорхойлдог байна. Харин Европын уламжлалыг баримталсан орнууд чиг үүргийг төв Засгийн газар болон орон нутгийн 27 захиргаадын хоорондхуваарилснаар хотын захиргаад хэмжээ болон үйлчилгээ үзүүлэх чадавхын хувьд харилцан адилгүй байж болох нөхцөлийг хүлээн зөвшөөрдөг ажээ. Британийн уламжлалтайгаас бусад эх газрын Европын орнууд (түүнчлэн Япон) хотын захиргаадад “ерөнхий бүрэн эрхийн” зарчмаар буюу төв Засгийн эрхлэх хүрээнээс бусад орон нутгийн иргэдэд ач тустай гэж үзсэн аль ч асуудлыг эрхлэх эрх мэдэл олгодог байна. Сонгуулиар байгуулагдсан хотын захиргааны гүйцэтгэх байгууллага дараах хэлбэрүүдтэй байна. Үүнд: Иргэдээс шууд сонгогдсон хотын дарга (төв ба Зүүн Европ, Япон, Хойд болон Өмнөд Америкийн ихэнх хот); Зөвлөл (Британийн тогтолцоотой Ази, Африкийн орон); Зөвлөл-захирагч нь Засгийн газар, эсвэл зөвлөлөөс томилогдсон (Өмнөд Ази); Иргэдээс сонгогдсон төлөөлөгчдийн сонгосон хотын дарга (баруун Европын зарим орон, Азийн зарим хот); Хотын дарга-зөвлөлд загвар нь зөвлөлийн тэргүүлэгчид, тэргүүлэгчдийн даргын хамт сонгогддог. Хотын дарга, эсвэл хотын дарга-зөвлөлд загвараар гүйцэтгэх захиргааны удирдлагыг томилох нь сүүлийн үед нийтлэг болжээ. Энэ нь хотын захиргаа доторх эрх мэдэл хуваагдаж задрахаас сэргийлэхийн тулд авч буй нэг арга хэмжээ юм

Дүгнэлт:

Нутгийн өөрийн удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлж чадсан улс орнууд, мөн дэлхийн сонгодог гэгдэх загваруудыг судлах нь өөрийн орны бодит байдалтай харьцуулах, үнэлэлт, дүгнэлт өгөхөд чухал ач холбогдолтой юм. Тэр дундаа төрийн байгууламжийн хувьд ижил төсөөтэй улс орны загварыг судлах, харьцуулах нь сайн туршлагыг нутагшуулах, цаг хугацаа хэмнэх зэрэг олон давуу талтай юм. Дэлхий нийтийн туршлагаас харвал улс орнууд нутгийн өөрийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход Нутгийн өөрийн

удирдлага ба төрийн удирдлагын харилцан хяналт, тэнцвэртэй байх, бие даасан хараат бус байх, шийдвэр гаргах эрх хэмжээтэй байх, хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудалд ач холбогдол өгч анхаарч, хууль эрх зүйн орчин бүрдүүлэхийг эрмэлзсээр байна.

Ашигласан ном зохиол

Хууль тогтоомж:

1. Монгол улсын Үндсэн хууль.1992
2. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 2006
3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль. 1996
4. Захиргааны ерөнхий хууль 2015
5. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль. 2006
6. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөл 2020

Ном, сурах бичиг, гарын авлага

1. Бямбасүрэн Д. Нутгийн өөрөө удирдлагыг шинжлэхүй, Уб.,2010
2. Бямбасүрэн Д. Орон нутгийн засаглалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь Уб.,2015
3. Болд-Эрдэнэ Д. Улс төрийн философи Уб.,2015

11.Доохүү,Т.Энхбаатар,Ч. Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй, УБ, 2006

4. Лүндэндорж Н. Төрийн онол Уб., 2008 13.Маналжав Г. Мандах М. Монгол улсын орон нутаг, түүний удирдлага Уб.,2004
5. Оюунтунгалаг О. Орон нутгийн удирдлага Уб.,2002
6. Төмөр С, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй” нутгийн өөрөө удирдах ёс, онол туршлага, хэтийн төлөв Уб.,2004
7. Сандаг-Очир М, Нутгийн удирдлага Уб.,2003 17.Сүхбаатар Ж. Монгол Улсын захиргааны эрх зүй Уб.,2000 18.Цогтоо Ш. Нийтийн захиргааны удирдлага Уб., 2011
8. Чимэд Б, Монгол улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал: нутгийн удирдлага уб.,2004
9. Чимэд Б, Багийн өнгөрсөн одоо ирээдүй-Монгол Улсын төрийн байгууламжийн язгуур нэгж, түүний удирдлага Уб.,2002